

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 10 (247)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *"Ник" хувьцаат компанийн төлбөр авах зарим арга хэмжээний тухай*
- *Газар тариалангийн үйлдвэрлэлийн төлбөр авах зарим арга хэмжээний тухай*
- *Хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны гуравдугаар сарын 15 №10 (247)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

108. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 26 497
109. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 27 498
110. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай Дугаар 28 498

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

111. Нэрэмжит болгох тухай Дугаар 1 498
112. "Ник" хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 2 499
113. Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 3 501
114. Орон сууц хувьчлах тухай Дугаар 4 502
115. Хөрөнгө, машин гаргах тухай Дугаар 6 502
116. Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын IX хуралдааны дүнгийн тухай Дугаар 7 502
117. Хөтөлбөр батлах тухай Дугаар 9 507

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 2 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 26** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгохнь:

1. Монгол Улсаас Лалын Бүгд Найрамдах Пакистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дагвын Цахилгааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Лалын Бүгд Найрамдах Пакистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандагвын Амарсанаагг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 2 дугаар сарын 28–ны өдөр | Дугаар 27 | Улаанбаатар хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дугаар заалтыг баримтлан Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Өөрөө хүсэлт гаргасан Дамдингийн Одонцэцэгийг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, өөр ажилд томилогдох болсон Дамдинсүрэнгийн Оюунхүүг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 2 дугаар сарын 28–ны өдөр | Дугаар 28 | Улаанбаатар хот

Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дамдинсүрэнгийн Оюунхүүг Архангай аймгийн шүүхийн шүүгчийн, Нацагдоржийн Төмөрбаатарыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 4–ний өдөр | Дугаар 1 | Улаанбаатар хот

Нэрэмжит болгох тухай

Булган аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид, Засаг даргын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Булган аймгийн нэгдсэн эмнэлгийг төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Их Хурлын дарга асан Лхамсүрэнгийн Энэбишийн нэрэмжит болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

2002 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр Дугаар 2 Улаанбаатар хот

"Ник" хувьцаат компанийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 2.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор "НИК" хувьцаат компанийн нийт хувьцааны төрийн эзэмшлийн хувийг хувьчлах бэлтгэлийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "НИК" хувьцаат компаниас 4 187 910 000 (дөрвөн тэрбум нэг зуун наян долоон сая есөн зуун арван мянган) төгрөгийн үнэ бүхий 7735 тонн нефтийн бүтээгдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор Улсын нөөцийн газарт шилжүүлсүгэй.

2. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгах нь:

а/энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан 34850 шоо метр багтаамж бүхий нефтийн бүтээгдэхүүний агуулах, сав, тоног төхөөрөмж, байгууламжийн зах зээлийн үнийг мэргэжлийн үнэлгээний байгууллагаар үнэлүүлэн Улсын нөөцийн газарт шилжүүлж, "НИК" хувьцаат компанийн тусламжийн барааны болон татварын өрөнд суутган тооцсугай;

б/улсын нөөцийн нефтийн бүтээгдэхүүний үнэ 4 187 910 000 (дөрвөн тэрбум нэг зуун наян долоон сая есөн зуун арван мянган) төгрөгийг "НИК" хувьцаат компаниас Санхүү, эдийн засгийн яаманд төлөх тусламжийн барааны дутуу төлөлтийн өглөгт суутгал хийх замаар хассугай.

3. Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгах нь:

а/Улсын нөөцийн газарт шилжүүлэх нефтийн агуулах, сав, тоног төхөөрөмж, байгууламжийн хэвийн ажиллах нөхцөлийг нь хангуулж, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулан комисст хүлээлгэн өгсүгэй;

б/энэ зүйлийн "а"-д заасан объектыг шилжүүлэх комиссыг Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам, Төрийн өмчийн хороо, Улсын нөөцийн газар болон "НИК" хувьцаат компанийн төлөөлөл оролцсон бүрэлдэхүүнтэйгээр байгуулж ажиллуулсугай;

в/энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан "НИК" хувьцаат компанийн илүүдэлтэй болон ашиглалтгүй байгаа хөрөнгийг худалдах, цаашид ашиглах бололцоогүй зүйлийг актлах, тэдгээрийг худалдсан орлогыг нефтийн бүтээгдэхүүний татан авалтыг нэмэгдүүлэхэд зарцуулах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу "НИК" хувьцаат компанитай Төлөөлөн удирдах зөвлөлд тавьж шийдвэрлүүлсүгэй.

4. "НИК" хувьцаат компанийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хувьчлагдахын өмнө хийлгэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийн асуудлыг Дэлхийн банкинд тавихыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
САЙД Ч.УЛААН

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ
САЙД Ч.ГАНЗОРИГ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

УЛСЫН НӨӨЦИЙН ГАЗАРТ ШИЛЖҮҮЛЭХ АГУУЛАХ, ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦУУДЫН БАЙРШИЛ, НЕФТИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ

Объектын нэр	Байршил	Ашиглалтад орсон он	Савны багтаамж (м.куб)	Шилжүүлэх нефтийн бүтээгдэхүүний төрөл	Шилжүүлэх хэмжээ (тонн)
Баруунхараагийн агуулах, ШТС	Сэлэнгэ аймгийн Баянгол сум	1976 1994	11700	АИ-93 А-76 Дизелийн түлш Тос Онгоцны түлш	100 50 1700 60 1500
Улаанбаатарын 7-р ШТС	Улаанбаатар хотын Баянгол дүүрэг	1984		Улсын нөөцийн нефтийн бүтээгдэхүүнийг сэлгэж, шинэчлэхэд ашиглана	
Дорнодын нөөцийн агуулах	Дорнод аймгийн төв	1978	1215	А-76 Дизелийн түлш Онгоцны түлш	200 300 100
Сонгинын агуулах	Завхан аймгийн Сонгино сум	1994	3570	А-76 Дизелийн түлш	50 200
Мөстийн агуулах, ШТС	Ховд аймгийн Мөст сум	1987 1994	2320	А-76 Дизелийн түлш	50 300
Цагаannуурын агуулах, ШТС	Баян-өлгий аймгийн Цагаannуурын дамжлага баз	1991 1995	5845	А-76 Дизелийн түлш	50 100
Айргийн агуулах, ШТС	Дорноговь аймгийн Айраг сум	1988 1982	1600	А-76 Дизелийн түлш	100 300
Дундговийн нөөцийн агуулах	Дундговь аймгийн төв	1986	8600	А-76 Дизелийн түлш	50 150
Дүн			34850		
Улсын нөөцийн газрын харьяа Дархан дахь агуулах	Дархан-Уул аймгийн Дархан сум	1996	2000	Дизелийн түлш Тос	2000 30
Улсын нөөцийн газрын харьяа Улаанбаатар хот дахь агуулах	Улаанбаатар хотын Баянзүрх дүүрэг	1999	650	АИ-93 Дизелийн түлш Тос	150 150 45
		Нийт дүн			7735

Засгийн газрын 2002 оны 2 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"НИК" ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУДАЛДАХ, АКТЛАХ ХӨРӨНГИЙН ТОВЧОО

№	Нефть хангамжийн газар, баазын нэр	Илүүдэлтэй, ашиглалтгүй хөрөнгө	
		Бүртгэлийн үнэ	Үлдэгдэл үнэ
1.	Архангай дахь НХБ	6655.8	2122.5
2.	Баянхонгор дахь НХБ	20531	10359.6
3.	Говь-Алтай дахь НХБ	7381.2	2112.5
4.	Дорноговь дахь НХГ	31448.9	11329.9
5.	Дундговь дахь НХБ	32537.7	27954
6.	Завхан дахь НХБ	19454.6	6288.7
7.	Өвөрхангай дахь НХБ	59524.7	10862.3
8.	Өмнөговь дахь НХБ	9156.6	3258.7
9.	Сүхбаатар дахь НХБ	30182.3	9072.5
10.	Ховд дахь НХБ	20126.5	10368.9
11.	Хөвсгөл дахь НХБ	33058.1	11198.8
12.	Хэнтий дахь НХБ	35814.6	12228.8
13.	Говьсүмбэр дахь НХГ	24106.2	6223.7
14.	Дархан дахь НХГ	494836.2	449787.5
15.	Дорнод дахь НХГ	232192.7	167665.7
16.	Орхон дахь НХГ	242826.6	203923.4
17.	Улаанбаатар дахь НХГ	224551.3	119866
18.	Увс дахь НХГ	21431.7	7694.2
19.	Цагаannуур дахь НХГ	5861	2002.3
20.	Агуулах (Улаанбаатар)	57285.8	55093.6
21.	"НИК" ХК (Улаанбаатар)	532039.7	440821.1
	Дүн	2141003.2	1570234.7

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр **Дугаар 3** **Улаанбаатар хот**

Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих талаар тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2001 онд бэлтгэсэн уриншийн талбайд тариалалт хийх бэлтгэл, зохион байгуулалтын арга хэмжээг одооноос авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлдэг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Аж ахуйн нэгжүүдийн бие даан үйлдвэрлэл явуулж тогтвортой урагц авах боломжийг бүрдүүлэхийн тулд 2002 онд "Уринш" төслийг үргэлжлүүлэх нь зүйтэй гэж үзсүгэй.

3. Төв аймгийн газар тариалангийн салбарыг гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөлд хамруулах, ялангуяа усалгаатай тариаланг хөгжүүлэх, ашиглалтын зардал хямдтай услалтын системийг сэргээн засарлахад дэмжлэг үзүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Төв аймгийн Засаг дарга М.Мэндбилэг нарт даалгасугай.

4. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хураан авсан урагц, өрхийн аж ахуйн газар тариалангийн үйлдвэрлэлийн мэдээг статистик мэдээнд хамруулах талаар 2002 оноос эхлэн бодлого гарган ажиллахыг Үндэсний статистикийн газар /Ч.ДАВААСҮРЭН/-т зөвлөж, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Газар тариалангийн үйлдвэрлэлийг байгалийн эрсдэлээс хамгаалах зорилгоор даатгалд хамруулах арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр Дугаар 4 Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах тухай

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газрын эзэмшилд байгаа Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 60 айлын 308 дугаар байр, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газрын эзэмшилд байгаа 27 айлын орон сууц, Газрын тосны хэрэг эрхлэх газрын эзэмшилд байгаа 14 айлын орон сууцыг тус тус дээрх газруудын саналыг үндэслэн одоо эзэмшиж байгаа оршин суугчдад нь зохих журмын дагуу хувьчлахыг Төрийн өмчийн хороо /Л.ПҮРЭВДОРЖ/-нд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Дугаар 6 Улаанбаатар хот

Хөрөнгө, машин гаргах тухай

Манай орны зарим аймгийн ихэнх сумдын нутгаар 2001 оны зун, намар гантай буюу гандуу байсны зэрэгцээ өвөл цас их орж хүйтэрсний улмаас мал өвөлжилтийн байдал хүндэрч байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Мал өвөлжилт ихээхэн хүндэрч байгааг харгалзан өвс, тэжээл нэмж бэлтгэх эргэлтийн хөрөнгийг нь нэмэгдүүлэхэд зориулан төсвөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр Баян-Өлгий, Ховд аймгийн Засаг даргын мэдэлд тус бүр 70.0 (далан) сая төгрөг олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Баян-Өлгий аймгийн Толбо, Говь-Алтай аймгийн Халиун сумын хүн эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээнд зориулан УАЗ-31512 маркийн суудлын автомашин тус бүр нэгийг улсын нөөцөөс олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд, эдгээр машиныг нөхөн бүрдүүлэхэд зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс 10200.0 (арван сая хоёр зуун мянга) мянган төгрөг гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Зарим аймгийн нутагт мал өвөлжилт хүндэрч байгаатай холбогдуулан өвс, тэжээлийн нөөцийг орон нутагт шуурхай шилжүүлэн байршуулж, тэдгээрийг малчдад хуваарилан хүргэх, нөхөн бүрдүүлэх асуудлыг тухайн аймгийн Засаг даргатай хамтран гэрээний үндсэн дээр зохицуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Дугаар 7 Улаанбаатар хот

Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын IX хуралдааны дүнгийн тухай

Худалдаа-эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын IX хуралдааны Протоколыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын IX хуралдааны шийдвэрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Төлөвлөгөөний биелэлтийн явцын талаар Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын Монголын хэсэгт мэдээлж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

ХУДАЛДАА-ЭДИЙН ЗАСАГ, ШИНЖЛЭХ УХААН-ТЕХНИКИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ МОНГОЛ-ОРОСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН КОМИССЫН IX ХУРАЛДААНЫ ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
	Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны талаар:		
1	Бүс нутаг, хил орчмын хамтын ажиллагааны дэд комиссын Ш хуралдааныг зохион байгуулах, энэ хүрээнд "Сибирийн хэлэлцээр" нийгэмлэгтэй хамтран ажиллах бүтэц, хэлбэрийг тохирох	2002 оны Ш улиралд	ҮХЯ, ГХЯ
2	Хил орчмын бүс дэх гэмт хэрэгтэй тэмцэх, хэвийн нөхцөлийг хангах талаар Монгол Улс болон ОХУ-ын орон нутгийн удирдлага, хууль хяналтын байгууллагуудын хамтран хэрэгжүүлэх буй ажлыг үргэлжлүүлэх	Жилдээ	ГХЯ, ХЗДХЯ, УПЕГ, холбогдох аймгуудын Засаг дарга нар
3	Хулгайлагдсан болон хил давсан малыг эрэн сурвалжлах, эргүүлэн өгөх хамтарсан комиссуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх	Жилдээ	ХЗДХЯ, ГХЯ, холбогдох аймгуудын Засаг дарга нар
4	Цагаannуур-Ташант, Боршоо-Хандгайт болон Арцсуурь-Цагаантолгойн хилийн боомтуудын тохижуулалтын ажил дуусмагц тэдгээрийн ажиллах журам, горимыг тохирох	Жилдээ	ХЗДХЯ,ГХЯ
5	Алтанбулаг-Хиагтын олон улсын боомтыг тохирсон журам ёсоор нь ажиллуулах, хил, гаалийн хяналтыг хөнгөвчлөх, Алтанбулагийн цоцолборыг ашиглалтад оруулсны дараа уг боомтыг 24 цагаар ажиллуулах бэлтгэлийг хангах асуудлаархи хамтарсан ажлын хэсэг байгуулах	2002 оны I улиралд	ХЗДХЯ,ГХЯ, ДБЯ, УПЕГ
	Худалдаанд харилцан либерал-члах талаар:		
6	Монгол Улс, ОХУ-ын хооронд худалдаанд харилцан либерал-члах асуудлаархи ажлын хэсгийн Ш хуралдааныг зохион байгуулах	2002 оны эхний хагас жилд	ҮХЯ, ДБЯ, ХХААЯ
	Дэд бүтцийн салбар дахь хамтын ажиллагааны талаар:		
7	Монгол Улсын Эрчим хүчний удирдах газар болон ОХУ-ын РАО "ЕЭС России" нэгдэл хооронд хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, энэ хүрээнд Адуунчулуун, Налайх болон бусад нүүрсний уурхай, орд газрыг хамтран ээмших, нүүрс экспортлох, Монголын нутаг дэвсгэр дээр өндөр хүчдэлийн шугам барих зэрэг чиглэлээр ажиллах	Жилдээ	ДБЯ
8	ОХУ-тай хил залгаа бөгөөд эрчим хүчний хүрэлцээ муу бүс нутагт нэмэгдэл эрчим хүч импортлох асуудлыг судлах	Жилдээ	ДБЯ
9	Монгол Улсын баруун бүсийн эрчим хүчний импортын үнийг бууруулах чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах	Жилдээ	ДБЯ
10	Монгол Улсын баруун бүсийн чиглэлээр нефть бүтээгдэхүүнээр найдвартай хангах талаар үргэлжлүүлэн хэлэлцээ хийх	Жилдээ	ҮХЯ, ДБЯ

11	"Төв Азийн хүдэржсэн бүсийн геологийн үнэлгээ" гэсэн олон улсын хөтөлбөр болон геоэкологийн зураглалыг гаргахад оролцох, геологийн салбарт бүс нуттийн хүрээнд хамтран ажиллах, монголын геологчдын мэргэжлийг ОХУ-ын эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн холбогдох байгууллага дээр дээшлүүлэх талаар арга хэмжээ авах	Жилдээ	ҮХЯ
12	Асгатын мөнгөний ордыг хамтран эзэмших чиглэлээр үргэлжлүүлэн ажиллах	Жилдээ	ҮХЯ
13	"Мянганы зам" төслийн хэрэгжилттэд ОХУ-ын холбогдох субъектуудын аж ахуйн нэгжүүдийг боломжийн хэлбэр, нөхцөлөөр татан оролцуулах	Жилдээ	ДБЯ
14	ОХУ-ын Барилпын улсын хороотой харилцаа холбоо тогтоох, хоёр орны байгаль цаг уурын адил нөхцөлийг харгалзан Оросын талаас гаргаж буй барилпын аргачлал, норм болон бусад баримт бичгийг шууд ашиглах замаар барилпын мэдээллийн сан байгуулах талаар арга хэмжээ авах	Жилдээ	ДБЯ
15	Улаанбаатар-Кызылийн агаарын хөдөлгөөний удирдах төвүүдийн хооронд сансрын холбооны шинэ суваг бий болгох талаар ажиллах	Жилдээ	ДБЯ
16	Монгол Улсын хил орчмын бүс нутагт хийгдсэн геологи хайгуулын ажлын тайлангуудын жагсаалт гарган Оросын талаас шилжүүлэн авах	Жилдээ	ҮХЯ
	Хөдөө аж ахуйн салбар дахь хамтын ажиллагааны талаар:		
17	Монгол Улсын мал эмнэлгийн серологийн лабораторидыг хамтран аттестатчилах	2002 оны ҮП сард	ХХААЯ
18	Мах экспортлох зорилгоор мал бэлтгэх схем, суряглэх бааз, тууварлах замын маршрутыг гаргаж баталгаажуулах	2002 оны П-Ш улиралд	ХХААЯ
19	Малын эмч, аймгуудын лабораторийн серологч нарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг хамтран зохион байгуулах	Жилдээ	ХХААЯ
20	Үхэр, бог малыг бруцеллёз өвчнөөс эрүүлжүүлэх хөтөлбөрийг хамтран боловсруулах	Жилдээ	ХХААЯ
	Шилжих рублиэр олгосон зээлийн өрийн талаар:		
21	ЗСБНХУ-аас /хуучин нэрээр/ шилжих рублиэр олгосон зээлийн өрийг зохицуулах асуудлаархи ажлын хэсгийн үүлзалтыг хийх	2002 оны I улиралд	СЗЗЯ
	Үл хөдлөх хөрөнгийн талаар:		
22	Үл хөдлөх хөрөнгийн асуудлаархи ажлын хэсгийн зэгжит хуралдааныг зохион байгуулах	2002 оны I улиралд	ГХЯ
	Хамтарсан үйлдвэрүүдийн үйл ажиллагааны талаар:		
23	Монгол-Оросын хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн газрын хэвлий болон эдэлбэр газар ашигласны төлбөрийг тооцож, үр дүнг Засгийн газарт танилцуулах	2002 оны I улиралд	СЗЗЯ, ТӨХ
24	Хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн үйл ажиллагааны тухай Засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээрийн 7 дугаар зүйл болон түүний хавсралт Протоколын 4, 5 дугаар зүйлүүдийн дагуу хоёр талын дүрмийн сан дахь хувь хөрөнгийг тооцох	2002 оны I улиралд	СЗЗЯ, ТӨХ

25	Эрдэнэтийн овооны зэс-молибдений орд газрыг үйлдвэрийн аргаар эзэмшсэний үр дүнд байгаль орчинд учруулсан хохирлыг үнэлэх, уг хохирлыг цаашид хэрэх талаар санал боловсруулах	2002 оны П улиралд	БОЯ, ТӨХ
26	Хамтарсан "Эрдэнэт" үйлдвэрийн үйл ажиллагааны тухай Засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээр дуусгавар болж буйтай холбогдуулан Оросын талтай хэлэлцээ хийх ажлын хэсгийг бүрдүүлэх	2002 оны I улиралд	Ерөнхий сайдын 2001 оны 110 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг
	Шинжлэх ухаан, хүмүүнлэгийн салбар дахь хамтын ажиллагааны талаар:		
27	Боловсрол, соёл болон шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах 2002-2006 оны хөтөлбөрийг тохиролцох	2002 оны эхний хагас жилд	БСШУЯ
28	Монголын дээд сургуулиудад улсын тэтгэлгээр сурах оросын иргэдийн тоог нэмэгдүүлэх боломжийг судлах	2002 оны эхний хагас жилд	БСШУЯ
29	ОХУ-ын соёл, урлагийн сургуулиудад Оросын талын тэтгэлгээр монголын иргэдийг суралцуулах талаар арга хэмжээ авах	2002 оны эхний хагас жилд	БСШУЯ
30	Техник мэргэжлийн боловсролын салбар дахь хамтын ажиллагааг хөгжүүлэх боломжийг судлах	Жилдээ	НХХЯ, БСШУЯ
31	Боловсролын үнэмлэх, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг тохиролцохыг түргэтгэх	2002 оны эхний хагас жилд	БСШУЯ
32	Сургалтын болон шинжлэх ухаан-техникийн ном, хэвлэх үйлдвэрийн бусад бүтээгдэхүүнийг импортлоход хөнгөлөлт үзүүлэх асуудлыг судалж үзэх	Жилдээ	БСШУЯ, СЭЗЯ
33	Хүмүүнлэгийн харилцааны хүрээнд Монгол Улс болон ОХУ-ын иргэд харилцан зорчиход визийн зохих хөнгөлөлтийг харилцан адил хэмжээгээр үзүүлж байх талаар арга хэмжээ авах	Жилдээ	ГХЯ
34	Монгол-Оросын хамтарсан Увс нуурын хотгорын дархан цаазтай газар байгуулах	Жилдээ	БОЯ

	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай 2002 оны Протоколын төслийн талаар:		
35	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын 2002 оны Протоколыг эцэслэн тохирч байгуулах	2002 оны I улиралд	ҮХЯ, СЭЗЯ
36	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны тухай БНМАУ-ын Засгийн газар, ЗСБНХОУ-ын Засгийн газар хоорондын 1991 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн хэлэлцээрийг шинэчлэх тухай Оросын талын саналыг судлан үзээд Монголын талын байр суурийг тодорхойлох	2002 оны эхний хагас жилд	ҮХЯ
	Бусад асуудлаар:		
37	ОХУ-ын геодезийн албаа "Роскартография"-тай дараахь чиглэлээр хамтран ажиллах боломжийг судлах: -Монгол-Байгалын газар чичирхийллийн идэвхтэй бүс нутагт геодезийн суглкээний нарийвчлал сайжруулах болон геодинамикийн судалгаа хийх зорилгоор хиймэл дагуулын геодезийн хамтран хийх хэмжилт хөтөлбөр боловсруулах; -Дэд бүтцийн эрчимтэй хөгжлийг бүс нутаг болон байгаль экологийн гамшигт өртөгдөж болзошгүй газрыг зураглах, ямад, агентлагуудын эрэлт хэрэгцээг сансраас авсан зургаар хангах үүднээс хиймэл дагуулаас дүрс мэдээллэл хүлээн авах, боловсруулах газрын станцыг Улаанбаатар хотод байгуулах; -Монгол Улсын дэд бүтцийн хөгжлийг мэдээллээр хангах зорилгоор геодези, зураг зүй болон тандан судалгааны өгөгдөлд үндэслэсэн олон зорилалттай газар зүйн мэдээллийн системийг бий болгох; -Монгол Улсын сансрын зургийн үндэсний сан байгуулах.	Жилдээ	Улсын геодези, зураг зүйн газар
38	Монгол, Оросын хилийн боомтуудаар гуравдагч орны жуулчдыг харилцан нэвтрүүлэх чиглэлээр тэдгээрийн ажиллах журмыг өөрчлөх боломжийг судлах	Жилдээ	ГХЯ, ХЗДХЯ, ДБЯ
39	Засгийн газар хоорондын дараахь хэлэлцээрийг байгуулах чиглэлээр ажиллах: -Хил орчмын бүсэд гал түймрээс урьдчилан сэргийлэх, хамтран ажиллах тухай -Аялал жуулчлалын салбарт хамтран ажиллах тухай -Монгол Улс болон ОХУ-ын иргэд харилцан хөдөлмөр эрхлэх тухай -Нийгмийн хамгаллын салбарт хамтран ажиллах тухай -Монгол, Оросын улсын хилийн дэглэмийн тухай	Жилдээ	БОЯ, ХЗДХЯ ДБЯ НХХЯ НХХЯ ХЗДХЯ, ГХЯ
40	Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын үндэсний хэсгүүдийн дарга нарын ажлын уулзалтыг зохион байгуулах	2002 оны Ш улиралд	Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг
41	Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын X хуралдааныг зохион байгуулах	2002 оны IУ улиралд	Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсэг

2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр Дугаар 9 **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 33 дугаар зүйл, "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 1.3-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1."Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор батлуулсугай.

2.Энэхүү хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомж, "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн дагуу холбогдох яамдтай хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хороо /Л.Түрэвдорж/-нд даалгасугай.

3.Төрийн өмчийн хороо /Л.Түрэвдорж/-нд зөвшөөрөх нь:

а/"Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 2 дугаар хавсралтад тусгасан аж ахуйн нэгжүүдээс өөрчлөн байгуулагдсан, хувьчлалын бэлтгэл хангагдсан аж ахуйн нэгжийг 2002 онд хувьчлах арга хэмжээ авсугай;

б/хувьчлах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн худалдагдах үнийн дүнгийн 10 хүртэл хувьд хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн баталгаажуулсан цэнхэр болон ягаан тасалбарыг төлбөрт тооцон авсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 9 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ 2002 ОНД ХУВЬЧЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Өмч хувьчлалын зорилго

Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д заасан зорилт, зарчмыг удирдлага болгон, үнэ цэнэтэй аж ахуйн нэгж болон бусад аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийг хувьчилж, эдийн засаг дахь хувийн хэвшлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өсөлтийг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү өмч хувьчлалын зорилго оршино.

Хоёр. Өмч хувьчлалын зарчим

Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д тусгагдсан зарчмыг баримтална.

Гурав. Хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалт

Дор дурдсан жагсаалтын дагуу аж ахуйн нэгжүүдэд өөрчлөн байгуулалт хийж хувьчлалын бэлтгэлийг ханган хувьчлах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ:

1. 2002 онд хувьчлах аж ахуйн нэгжийн жагсаалт /1 дүгээр хавсралт/

2. 2002 онд өөрчлөн байгуулалт хийх болон хувьчлалын бэлтгэлийг ханган аж ахуйн нэгжийн жагсаалт /2 дугаар хавсралт/

3. 2002 онд худалдах төрийн өмчийн үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалт /3 дугаар хавсралт/

Дөрөв. Хөтөлбөр, жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах

Хөтөлбөр, хувьчлах аж ахуйн нэгж, өөрчлөн байгуулалт хийж, хувьчлалын бэлтгэлийг ханган аж ахуйн нэгжийн болон худалдах үл хөдлөх эд хөрөнгө, дуусаагүй барилгын жагсаалтад дор дурдсан нөхцөлд

нэмэлт, өөрчлөлт оруулж болно:

4.1.Монгол Улсын иргэн, гадаадын иргэн болон дотоод, гадаадын аж ахуйн нэгжээс тодорхой аж ахуйн нэгжийг хувьчлан авах санал хүсэлт гаргасан тохиолдолд;

4.2.Хувьчлах шийдвэр гарсан боловч холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буулгах, өөрчлөн зохион байгуулах шаардлагатай болсон аж ахуйн нэгжийг жагсаалтаас хасна;

4.3.Тодорхой салбар, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хандивлагчдын зүгээс томоохон хэмжээний төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбогдсон тусгай шаардлага гарсан;

4.4.Тухайн аж ахуйн нэгжийг энэхүү хөтөлбөр, жагсаалтад зааснаас өөр аргаар хувьчлах болсон;

4.5.Жагсаалтад орсон аж ахуйн нэгж хуваагдах буюу тусгаарласны үндсэн дээр шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн компанийнхаа анхны нэрийг өөрлөн аваагүй тохиолдолд жагсаалтад орсон аж ахуйн нэгжийн нэрийг жагсаалтаас хасч шинээр бий болсон аж ахуйн нэгжүүдийн нэрийг холбогдох жагсаалтад оруулах, тухайн аж ахуйн нэгжийг салган хувьчлуулах санал гарч, түүнийг холбогдох яам болон Төрийн өмчийн хороо албан ёсоор зөвшөөрсөн, тухайн аж ахуйн нэгж өр зээлтэй бол томоохон зээлдүүлэгчийн зүгээс тодорхой санал гарсан тохиолдолд;

4.6.Компанийн хувь нийлүүлэгчдийн хүрлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр төрийн эзэмшлийн хувьцаанд өөрчлөлт орсон /үүнийг Үнэт цаасны хорооноос зөвшөөрсөн/ тохиолдолд энэхүү шинэчлэн тогтоосон хувийг хувьчлана.

Тав. Хөтөлберийн хэрэгжилтийг тайлагнах

Энэхүү хөтөлберийн биелэлтийг 2003 оны 1 дүгээр сарын 25-ны дотор Төрийн өмчийн хороо холбогдох яам, газартай хамтран гаргаж Засгийн газарт тайлагнана.

Засгийн газрын 2002 оны 9 дүгээр тогтоолын хавсралт

"Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралт

2002 ОНД ХУВЬЧЛАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил /аймаг, хот, сум, дүүрэг/	Үндсэн үйл ажиллагаа	Төрийн эзэмшлийн хувьцаа		Хувьчлах хугацаа /улиралаар/	Хувьчлах арга хэлбэр, нөхцөл					
				Нийт хувь	Үүнээс: хувьчлах хувь							
1. ҮНЭ ЦЭНЭТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ												
1.	"Говь" ХК	Улаанбаатар, Хан-уул	Нүүс, ноолуурын бүтээгдэхүүн үйлдвэрлэх	74.9	4.9	I-Ш	Төрийн эзэмшлийн нийт хувьцааны 4.9 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжих					

2.	"Нефть импорт концерн" ХК	Улаанбаатар /бүх аймаг, суманд салбартай/	Нефтийн бүтээгдэхүүний импорт, борлуулалт	80	80	П- IУ	1. Нефть бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах бизнес эрхэлдэг, олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий дотоод, гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдын дунд уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах. 2. Монгол Улсын алслагдсан аймаг, сум дахь шатахуун түгээх станцыг нефть бүтээгдэхүүнээр хангах нөхцөлөөр Засгийн газраас алтан хувьцаа гаргах
3.	"МИАТ" ХК	Улаанбаатар /бүх аймагт салбартай/	Агаарын зорчигч болон ачаа тээвэр	100	49	2002 оны Ш улирал-2003 оны I улирал	УИХ-аас "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д "МИАТ" ХК-ийн талаар өөрчлөлт оруулахаар танилцуулж, шийдвэр гаргах нөхцөлд нийт хувьцааны 49 хувийг компанийн менежментийг гэрээний үндсэн дээр гүйцэтгэх нөхцөлтэйгээр хөрөнгө оруулалт хийж үйл ажиллагаа, үйлчилгээг нь сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх санхүүгийн чадавхитай, олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий гадаадын авиакомпаниудын дунд уралдаант шалгаруулалтын аргаар
4.	"Монгол даатгал" ХХК	Улаанбаатар, Сүхбаатар	Даатгалын үйл ажиллагаа	100	100	2002 оны Ш улирал-2003 оны I улирал	Олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий, санхүүгийн чадавхитай, даатгалын үйл ажиллагаар амжилттай явуулж ирсэн туршлагатай дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдад уралдаант шалгаруулалтын аргаар
5.	"Түшиг даатгал" ТӨҮГ	Улаанбаатар, Баянзүрх	Даатгалын үйл ажиллагаа	100	100	П-IУ	Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хэлбэрт шилжүүлж, уралдаант шалгаруулалтын аргаар
			П. БУСАД АЖ АХУЙН НЭГЖ				
6.	"Хаш Орд" ХК	Улаанбаатар, Хан-Уул	Барилга үгсралт	34,67	34,67	П	Төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгож, Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжих
7.	"Багнуурын дулааны станц" ТӨХК	Улаанбаатар, Багануур	Дулаан үйлдвэрлэл	100	100	П-Ш	Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
8.	"Налайхын дулааны станц" ТӨХК	Улаанбаатар, Налайх	Дулаан үйлдвэрлэл	100	100	П-Ш	Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах
9.	"Алтай" ЭХБУТрест /ТӨҮГ/	Ховд, Жаргалант	Эрчим хүчний барилга үгсралт	100	100	I-П	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, нийтийн дуудлага худалдааны аргаар

10.	"Бэрх-Уул" ТӨХК	Хэнтий, Батноров	Жонш, алт, нүүрс олборлох	100	100	I-П	Нийт хувьцаааны 67 хувийг менежментийн үр дүнг харгалзан хувьчилж, 33 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан нийтэд арилжих
11.	"Уран" ТӨҮГ	Улаанбаатар, Чингэлтэй	Судалгаа шинжилгээ	100	100	I	Татан буулгаж, эд хөрөнгийг худалдах
12.	"Үндэсний үнэт цаас" ХХК	Улаанбаатар, Сүхбаатар	Үнэт цаасны үйлдвэрлэл	50	50	I-Ш	1. Төрийн эзэмшлийн хувийг нэг багц болгон үнэлэж, "Компанийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлд заасны дагуу бусад хувьцаа эзэмшигчдэд санал болгох. 2. Бусад хувьцаа эзэмшигч төрийн эзэмшлийн хувьцааг аваагүй тохиолдолд нийтийн дуудлагын худалдааны аргаар хувьчлах
13.	"Монгол шуудан" банк	Улаанбаатар, Сүхбаатар	Банкны үйлчилгээ	2,5	2,5	I	Төрийн эзэмшлийн хувийг нэг багц болгон нийтийн дуудлагын худалдааны аргаар
14.	"Шинэчлэл" банк	Улаанбаатар	Банкны үйлчилгээ	17.5	17.5	П	Төрийн эзэмшлийн хувийг нэг багц болгон нийтийн дуудлагын худалдааны аргаар
15.	"Монэнзим" ТӨҮГ	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Эм үйлдвэрлэл	100	100	П-Ш	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжих
16.	Шаргалжуут рашаан сувилал /ТӨҮГ/	Баянхонгор, Эрдэнэцогт	Амралт, сувилал	100	100	П-Ш	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, цаашид үйлчилгээний чиглэлийг өөрчлөхгүйгээр эд хөрөнгийг зориулалтаар нь ашиглах, үр ашгийг нь дээшлүүлэх, зайлшгүй шаардагдах хөрөнгө оруулалт хийж, технологийгн шаардлагыг хангах, мэргэжлийн үйлчилгээний чанарыг сайжруулах нөхцөлтэйгээр дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын дунд уралдаант шалгаруулалтын аргаар
17.	"Цайз" компани /ТӨҮГ/	Улаанбаатар, Баянзүрх	Түүхий эдийн зах, худалдаа	100	100	П	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан арилжих
18.	"Дар зам" ХК	Дархан-Уул, Дархан	Авто зам барих	50	50	П	Төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон, нийтийн дуудлагын худалдааны аргаар
19.	"Гал" компани /ТӨҮГ/	Улаанбаатар, Сонгинохайрхан	Галын машин, техникийн засвар	100	100	Ш-IУ	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, уралдаант шалгаруулалтын аргаар

2002 ОНД ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ ХИЙХ БОЛОН ХУВЬЧЛАЛЫН БЭЛТГЭЛИЙГ

ХАНГАХ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил /аймаг, хот, сум, дүүрэг/	Үндсэн үйл ажилагаа	Харьяалах яам	Төрийн өмчийн хувь	Өөрчлөн байгуулалт хийх, хувьчлалын бэлтгэл хангах арга хэмжээ
1. ҮНЭ ЦЭНЭТЭЙ АЖ АХУЙН НЭГЖ						
1	"Дулааны П цахилгаан станц" ТӨХЦ	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Цахилгаан, дулаан үйлдвэрлэл	ДБЯ	100	Эрчим хүчний салбарт олон улсын хэмжээнд нэр хүндтэй, эрчим хүчний техник, технологийн шинэчлэл хийх санхүүгийн чадавхитай дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын дунд уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах бэлтгэлийг хангах
2.	"Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ТӨХК	Улаанбаатар, Хан-Уул	Цахилгаан түгээх	ДБЯ	100	Эрчим хүчний салбарт олон улсын хэмжээнд нэр хүндтэй, эрчим хүчний техник, технологийн шинэчлэл хийх санхүүгийн чадавхитай дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын дунд уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах бэлтгэлийг хангах
3.	Монгол-Солонгосын хамтарсан "Монголын цахилгаан холбоо" ХК	Улаанбаатар, Чингэлтэй	Цахилгаан холбооны үйлчилгээ	ДБЯ	54.7	1. Шуудан, цахилгаан холбооны газрын цахилгаан холбооны суурь сүлжээний улс, хот хоорондын дамжуулах болон улс хоорондын холболтын байгууламжаас бусад хөрөнгийг дахин үнэлэж, Солонгосын талтай тохиролцсоны үндсэн дээр "Монголын цахилгаан холбоо" ХК-д шилжүүлж, Монголын талын төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг шинэчлэн тогтоох. 2. "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн Монголын талын төрийн эзэмшлийн хувьцаат хувьчлах бүтцийг тогтоож, хувьчлах саналыг Үндсэний ажлулгүй байдлын зөвлөлд танилцуулах. 3. Дээрх асуудлууд шийдвэрлэгдсэн нөхцөлд "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлах ажлыг 2002 оны Ш-IУ улиралд зохион байгуулах
4.	"Хөтөл цемент шохой" ХК	Сэлэнгэ, Сайхан	Цемент, шохой үйлдвэрлэл	ДБЯ	100	Дараахь чиглэлийг баримтлан хувьчлалын бэлтгэл хангах: 1. Цементийн үйлдвэрлэлийн техник, технологийн орчин үеийн түвшинд шинэчлэн сайжруулж, Монгол Улсын экспортод гаргах бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах чиглэлээр ажилах гадаадын хөрөнгө оруулагчид уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах. 2. Уралдаант шалгаруулалтын нөхцөлд үйлдвэрийн орчны экологи болон Хөтөл тосгоны нийгмийн асуудлаар тодорхой /хувьчлалд шууд саад болохгүй/ шаардлага тавих
5.	Монгол-Болгарын хамтарсан "Монгол-болгаргео" ХХК	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Алт олборлолт	УХЯ	50	1. Болгарын талтай тохиролцсоны үндсэн дээр Монголын талын оруулсан хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох. 2. Компанийг хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулах. 3. Компанийг хувьчлах тухай асуудлыг Болгарын талтай тохиролцож, Монголын талын эзэмшиж байгаа хувьцааг нэг багц болгон хувьчлах бэлтгэлийг хангах

6.	Монгол-Чехийн хамтарсан "Монгол-чехметалл" ХХК	Улаанбаатар, Баянзүрх	Алт олборлолт	ҮХЯ	50	1. Чехийн талтай тохиролцсоны үндсэн дээр Монголын талын оруулсан хөрөнгийн хэмжээг шинэчлэн тогтоох. 2. Компанийг хувьчлах тухай асуудлыг Чехийн талтай тохиролцож, хувьчлалын бэлтгэлийг хангах
7.	Монгол-Америкийн хамтарсан "Монгол амикал" ХХК	Улаанбаатар, Хан-уул	Ноос, ноолуур боловсруулах	ҮХЯ	45	1. Монголын талаас хөрөнгө оруулахтай холбогдон үүссэн өрийн асуудлыг шийдвэрлэх. 2. "Монгол тэмээний ноос" ТӨҮГ-ын хувьчлалын бэлтгэлийг хангахтай холбогдуулан тус ТӨҮГ-ын "Монгол амикал" ХХК-д эзэмшигдэх байгаа Монголын талын хувьцаа хэнаж тусгаарлах асуудлыг шийдвэрлэх. 3. Монголын талын төрийн эзэмшлийн хувьцааг нэг багц болгон, нийтийн дуудлагын худалдаагаар хувьчлах асуудлыг Америкийн талтай тохиролцож, бэлтгэлийг хангах
8.	Хөдөө аж ахуйн банк	Улаанбаатар, Баянзүрх	Банкны үйлчилгээ	СЭЗЯ	100	1. Тус банкны үйл ажиллагааны талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр хувьчлах стратегийн хөтөлбөрийг боловсруулах. 2. Урьд жилүүдээс хуримтлагдаж ирсэн тус банкны алдагдлыг шийдвэрлэх арга хэмжээ авах
9.	Монголын хөрөнгийн биржс	Улаанбаатар, Сүхбаатар	Үнэт цаасны арилжаа	СЭЗЯ	100	Тус биржийн үйл ажиллагааны талаар нарийвчилсан судалгаа, шинжилгээ хийсний үндсэн дээр хувьчлах стратегийн хөтөлбөрийг боловсруулах
			П. БУСАД АЖ АХУЙН НЭГЖ			
10.	"Монгол тэмээний ноос" ТӨҮГ	Улаанбаатар, Хан-Уул	Ноос боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх	ҮХЯ	100	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, үралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах чиглэл баримтлан бэлтгэлийг хангах
11.	"Хүнс трейд" ТӨҮГ	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Хүнсний бөөний худалдаа	ҮХЯ	100	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, хувьчлах бэлтгэлийг хангах
12.	"Булигаар" ХК	Улаанбаатар, Хан-Уул	Арьс, шир боловсруулах	ҮХЯ	70	Гадаад зээл, өр авлагыг шийдвэрлэх чиглэлээр өөрчлөн байгуулалт хийж, хувьчлалын бэлтгэлийг хангах
13.	"Монгол шуудан" компани ТӨҮГ	Улаанбаатар, Чингэлтэй	Шуудангийн үйлчилгээ	ДБЯ	100	Төрийн өмчит хувьцаат компаний хэлбэрт шийлжүүлэх
14.	"Автоимпэкс" ХК	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Автын сэлбэг хэрэгслийн худалдаа	ДБЯ	51	Өр, зээлийн асуудлыг шийдвэрлэх, гүйлгээгүй барааны үлдэгдлийг борлуулах арга хэмжээ авч, хувьчлалын бэлтгэлийг хангах
15.	"Зураг зүйн үйлдвэр" ТӨҮГ	Улаанбаатар, Чингэлтэй	Газрын зургийн үйлдвэрлэл	ДБЯ7	100	1. Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрлөн байгуулах. 2. Үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөхгүйгээр технологийг шинэчлэх нөхцөлөөр нэмэлт хөрөнгө оруулалт хийх эгээдэд үралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах чиглэл баримтлан бэлтгэлийг хангах

16.	Аэрогеодезийн үйлдвэр ТӨҮГ	Улаанбаатар, Чингэлтэй	Газрын зүргийн үйлдвэрлэл	ДБЯ	100	1. Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах. 2. Үүнд ажиллагаанд чиглэлийг өөрчлөхгүйгээр технологийг шинэчлэх нөхцөлөөр нэмэлт хөрөнгө оруулалт эзэмшүүлэх урадданат шаардлагатай аргаар хувьчлах чиглэл бариптлан баптгэлийг хангах
17	"Алтайн зам" ХК	Ховд, Жаргалант	Зам, гүүр барих, замын засвар, арчлалт	ДБЯ	51	1. Замын засвар арчлалтын хэгийг барууи бусийн зам засвар, арчлалтын бүрэлдэхүүнд оруулж, компанийн нийт хувьцаан дахь төрийн эзэмшлийн хувийг шинэчлэн тогтоох. 2. Замын засвар арчлалтаас бэрилгэ үгсралтыг салгаан хэгийн төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгож, хувьчлах баптгэлийг хангах 3. Өөрчлөн байгуулалт хийж, хувьчлалын бэлтгэл хангалан нөхцөлд төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 2002 онд хувьчлах ажлыг зохион байгуулах
18	"Завхан Улбаа" ХК	Завхан, Улиастай	Зам, гүүр барих, замын засвар, арчлалт	ДБЯ	67.2	1. Замын засвар арчлалтын хэгийг барууи бусийн зам засвар, арчлалтын бүрэлдэхүүнд оруулж, компанийн нийт хувьцаан дахь төрийн эзэмшлийн хувийг шинэчлэн тогтоох. 2. Замын засвар арчлалтаас бэрилгэ үгсралтыг салгаан хэгийн төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгож, хувьчлах баптгэлийг хангах 3. Өөрчлөн байгуулалт хийж, хувьчлалын бэлтгэл хангалан нөхцөлд төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 2002 онд хувьчлах ажлыг зохион байгуулах
19	"Хөвсгөл авто зам" ХК	Хөвсгөл, Мөрөн	Зам, гүүр барих, замын засвар, арчлалт	ДБЯ	70	1. Замын засвар арчлалтын хэгийг барууи бусийн зам засвар, арчлалтын бүрэлдэхүүнд оруулж, компанийн нийт хувьцаан дахь төрийн эзэмшлийн хувийг шинэчлэн тогтоох. 2. Замын засвар арчлалтаас бэрилгэ үгсралтыг салгаан хэгийн төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгож, хувьчлах баптгэлийг хангах 3. Өөрчлөн байгуулалт хийж, хувьчлалын бэлтгэл хангалан нөхцөлд төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 2002 онд хувьчлах ажлыг зохион байгуулах
20	"Архангай авто зам" ХК	Архангай, Эрдэнэбулган	Зам, гүүр барих, замын засвар, арчлалт	ДБЯ	56.8	1. Замын засвар арчлалтын хэгийг барууи бусийн зам засвар, арчлалтын бүрэлдэхүүнд оруулж, компанийн нийт хувьцаан дахь төрийн эзэмшлийн хувийг шинэчлэн тогтоох. 2. Замын засвар арчлалтаас бэрилгэ үгсралтыг салгаан хэгийн төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгож, хувьчлах баптгэлийг хангах 3. Өөрчлөн байгуулалт хийж, хувьчлалын бэлтгэл хангалан нөхцөлд төрийн эзэмшлийн хувьцаагаа нэг бүрд болгон Монголын хөрөнгийн биржээр дамжуулан 2002 онд хувьчлах ажлыг зохион байгуулах

21	"Шарын гол" ХК	Дархан-Уул, Шарын гол	Нүүрс олборлох, борлуулах	ДБЯ	80	Нүүрсний судлагдсан нөөцийн хэмжээ, уурхайн ирээдүйн чиглэл, тостоны нийлмийн асуудлаар үйлдвэлэн төрийн зээмшлийн хувьчлах бэлтгэлийн хангах
22	Гэр үйлдвэр ТӨҮГ	Сэлэнгэ, Сайхан	Гэр үйлдвэрлэл	ДБЯ	100	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, хувьчлах бэлтгэлийг хангах
23	"Монголэм-импэкс" концерн ТӨҮГ	Улаанбаатар, Сүхбаатар	Эмийн импорт, эм хангамжийн сүлжээ	ЭМЯ	100	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулж, хувьчлах бэлтгэлийг хангах
24	Эмийн үйлдвэр ТӨҮГ	Улаанбаатар, Сүхбаатар	Мансууруулах сэтгэц нөлөөт болон бусад эмийн үйлдвэрлэл	ЭМЯ	100	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн байгуулах
25	Барилгын цэргийн засвар механизмийн завод	Улаанбаатар, Сонгино-хайрхан	Машин, механизмын засвар	БХЯ	100	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэн өөрчлөн байгуулж, хувьчлах бэлтгэлийг хангах
26	"Дарханмах-экспо" ХК	Дархан-Уул, Дархан	Мах үйлдвэрлэл	ХХААЯ	51	1. Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар бий болсон хөрөнгийг хувьцаа зээмшигчийн хурлаар хэлэлцүүлсний үндэсн дээр төрийн зээмшлийн хувьцааны хэмжээг шинэчлэн тогтоох. 2. Японы талтай буцалтгүй тусламжийн асуудлыг тохиролцсоны үндэсн дээр хувьчлалын бэлтгэлийг хангах
27	"Гантэрэм" ХК	Өвөрхангай, Хархорин	Гурил үйлдвэрлэл	ХХААЯ	60	1. Японы Засгийн газрын буцалтгүй тусламжаар бий болсон хөрөнгийн асуудлыг сайжж шийдэрлэх. 2. Японы талтай буцалтгүй туслажжийн асуудлыг тохиролцсоны үндэсн дээр хувьчлалын бэлтгэлийг хангах

"Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 3 дугаар хавсралт

2002 ОНД ХУДАЛДАХ ТӨРИЙН ӨМЧИЙН УЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ БОЛОН ДУУСАГАУЙ БАРИЛГЫН ЖАГСААЛТ

№	Үл хөдлөх эд хөрөнгийн нэр	Байршил	Ашиглагдаж орсон болон барьж эхэлсэн он	Турэслэж буй болон зээмшиж буй байгууллагын нэр	Хувьчлагдах нийт талбай /м²/	Дуусаагүй барилгын гүйцэтгэлийн хувь /%/	Ашиглаж буй чиглэл	Худалдах арга, хэлбэр, нөхцөл

ТӨРИЙН ӨМЧИЙН ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ							
1	Халуун усны барилга	Улаанбаатар, Баянгол 18 дугаар хороо	1959	"Төгс эрдэм" сан	525	Сургалт, үйлчилгээ	Дуудлагын худалдааны аргаар
2	Төрийн өмчийн 25 дугаар байр /хуучнаар "Монгол такси" компанийн гараашийн мужаан цехтэй хэсэг/	Улаанбаатар, Баянзүрх	1935	Хувираа хөдөлмөр эрхлэгчдийн холбоо	84.7	Дулаан гараааш	Дуудлагын худалдааны аргаар
3	Төрийн өмчийн 24 дүгээр байр /хуучнаар Тээврийн удирдах газрын барилга/	Улаанбаатар, Чингэлтэй, /Улсын циркийн баруун талд/	1935	"Гурван эвтэн" ХХК	2081.7	Меркурий хүнсний зах	Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийг үндэслэн Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 24-ний өдрийн 33 дугаар тогтоолын дагуу түрээсийн давуу эрхээр худалдах
4	Батлан хамгаалах яамны Цэргийн эмнэлгийн хуучин амбулаторийн барилга	Улаанбаатар, Баянзүрх, 5 дугаар хороо	1905	Монгол эмнэлгийн "МонгЭм" ХХК	868	Эмнэлгийн зориулалтаар	Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийг үндэслэн түрээслэгчид эхний ээлжинд санал болгох, эс зөвшөөрвөл дуудлагын худалдааны аргаар худалдах
5	Хүүхдийн зуслангийн байр /21 байр/	Өвөрхангай, Хужирт	1964	"Цагаан залаат агвет" ХХК	3126	Хүүхдийн зуслан	Дуудлагын худалдааны аргаар
6	Төрийн өмчийн 21 дүгээр байр	Улаанбаатар, Баянгол	1956	"Монгол шуудан" банк	128	Банкны үйлчилгээ	Иргэний хуулийн 274 дүгээр зүйлийг үндэслэн түрээслэгчид эхний ээлжинд санал болгох, эс зөвшөөрвөл дуудлагын худалдааны аргаар худалдах
7	Төрийн өмчийн 5 дугаар байрны спорт заал	Улаанбаатар, Чингэлтэй, Барилгчдын талбай	1970	"Эм-Си-Эс" ХХК	540	Агуулах	Дуудлага худалдааны аргаар худадах
8	БХЯ-ны харьяа "Халамж" ТӨҮГ-ын харуулын байр	Улаанбаатар, Баянзүрх	1969	"Билэгт-Импекс" ХХК	118.9	Хиамны цех	Дуудлагын худалдааны аргаар худалдах

9	Спорт сургалтын төвийн "А" хэсэг	Улаанбаатар, Сухбаатар, 8 дугаар хороо	1979	"Монгол спорт" ХХК, Гимнастикчдын холбоо	1404	Биеийн тамир, спорт	Иргэний хуулийн 274, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28, 31 дүгээр зүйлийг үндэслэн зээмшин-үзэд нь хуваагдах
10	Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын усланган байруууд /118 байр/	Улаанбаатар, Жижид болон Нүхтийн ам	1953-1990	Төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газар	-	Усланган байр	
				ТӨРИЙН ӨМЧИЙН ДУУСААГҮЙ БАРИЛГА			
11	800 машины засварын газар	Дорнод, Хэрлэн	1988		24	Барилтын ажил зогссон тул ашиглалтгүй байгаа	Урапдаант шалгаруулалтын аргаар
12	Эсгий, эсгийн гутлын үйлдвэр	Орхон, Баян-өндөр	1988		85	Барилтын ажил зогссон тул ашиглалтгүй байгаа	Урапдаант шалгаруулалтын аргаар
13	190 хүүхдийн ясли, цэцэрлэгийн барилга	Улаанбаатар, Багануур	1989		20	Барилтын ажил зогссон тул ашиглалтгүй байгаа	Нийтийн дуулгалын худалдааны аргаар
14	Хөргүүлгэй агуулахын цогцолбор	Улаанбаатар, Хан-Уул	1990		40	Барилтын ажил зогссон тул ашиглалтгүй байгаа	Нийтийн дуулгалын худалдааны аргаар

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 11 (248)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Нийслэлийн замын хөдөлгөөний ажлыгүй байдал, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай*
- *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны гуравдугаар сарын 22 №11 (248)

Гарчиг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

118. Нийслэлийн замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай Дугаар 8 517

119. Журамд нэмэлт оруулах тухай Дугаар 10 518

120. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 11 519

121. Тогтоол хүчингүй болгох тухай Дугаар 12 524

122. Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө, Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай Дугаар 13 524

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр **Дугаар 8** **Улаанбаатар хот**

Нийслэлийн замын хөдөлгөөний аюулгүй байдал, нийтийн тээврийн үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт даалгах нь:

а/нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн хөдөлгөөний буртгэл, мэдээлэл, зохицуулалт, хяналтын автомат системийг нэвтрүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалтын арга хэмжээнд хамруулж шийдвэрлэсүгэй;

б/нийслэлийн авто замын уулзварын гэрлэн дохиог орчин үеийн загвараар сольж тоноглох, замын гол уулзвар, хэсэгт хөдөлгөөний хяналтын телекамерийн систем суурилуулахад шаардагдах хөрөнгийг 2003 оны төвлөрсөн төсөвт тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авсугай;

в/хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний төвийг нийслэлийн баруун, зүүн хэсэгт байрлуулж, түүнтэй холбогдон газар олгох, барилга, зам, талбай барихад шаардагдах хөрөнгийг шийдвэрлэх арга хэмжээ авсугай.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М. Энхболдод үүрэг болгох нь:

а/нийслэлийн Тээврийн газрыг авто тээвэр, авто замын бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Зам, тээврийн газар болгон өөрчлөн зохион байгуулсугай;

б/ нийтийн тээврийн үйлчилгээ

эрхлэж байгаа төрийн өмчит Автобус-2", "Автобус-3", "Цахилгаан тээвэр" компанийн одоогийн үндсэн үйл ажиллагаат хэвээр адгалж үйлчилгээний чанар, эдийн засгийн үр шгийг нь дээшлүүлэх зорилгоор удирдах үйл жиллагааны үр дүнг харгалзан хувьчлах чиглэл ариматлж 2002-2004 онд шийдвэрлүүлэх арга эмжээ авсугай;

в/замын хөдөлгөөний нягтрал охиомлоор үүсгэж байгаа аж ахуйн нэгж, йгууллагын байршлыг хот төлөвлөлтийн бодлого, рөнхий төлөвлөгөөтэй уялдуулан оновчтой болгох рга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлсүгэй;

г/олон улсын болон дамжин өнгөрөх авто тээвэрийн харилцааны эрх зүйн орчин бүрдэж байгаатай холбогдуулан нийслэлд олон улсын ачаа, орчигч тээвэрийн автовокзал, терминал аж ахуйг байгуулах байршлыг 2002 онд тогтоосугай;

д/хөрөнгийн асуудлыг олон улсын байгууллага, хандивлагч орнуудад тавьж шийдвэрлүүлэх замаар хотын өрөнхий төлөвлөгөө, авто замын сүлжээг хөгжүүлэх өрөнхий схемтэй уялдуулан нийслэлийн зорчигч тээвэрийн өрөнхий схемийг 2002–2003 онд багтаан боловсруулсугай;

е/нийслэлийн авто замын хөдөлгөөн, нийтийн тээвэрийн үйлчилгээний ачааллыг ажлын өдрийн оргил ачаалалтай уялдуулан зохицуулж байх арга хэмжээ авсугай;

ж/нийслэлийн авто тээвэрийн хэрэгслийн хөдөлгөөнийг оновчтой зохион байгуулах зорилгоор замын хөдөлгөөний зохицуулалтын дэвшилтэт арга хэлбэрийг судалж, нэвтрүүлэх арга хэмжээ авсугай;

з/авто замын зураг төслийг зохиох, зам барихдаа явган хүний гарцад тахир дутуу хүн, тэргэнцэр болон дугуйтай зорчигчдод зориулсан налуу гаргах, сургууль, цэцэрлэгийн орчимд автомашины хурдыг сааруулах замын байгууламж,замын ус зайлуулах системийг тусган хэрэгжүүлэх арга хэмжээг авч байсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 7 дугаар зүйлийн "г" заалтыг "Зам, тээвэрийн газар" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 16–ны өдөр **Дугаар 10** **Улаанбаатар хот**

Журамд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Зөвлөл шинэчлэн байгуулах тухай" Засгийн газрын 2000 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 152 дугаар тогтоолоор батлагдсан "Гадаадын зээл, тусламжийг зохицуулах зөвлөлийн ажиллах журам"-ын 4 дэх заалтын ". . . төрүүн дэд дарга" гэсний дараа "Монгол банкны төрүүн дэд өрөнхийлөгч, Улаанбаатар хотын өрөнхий менежер" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Их Хурлын 2001 оны 100 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлт, санхүү татварын мэдээ, тайлан гаргалтын чанарыг сайжруулах зорилгоор 2002 оныг улсын хэмжээнд "Бүртгэлийн ажлыг сайжруулах жил" болгон зохион байгуулсугай.

2. 2002 оныг "Бүртгэлийн ажлыг сайжруулах жил" болгож байгаатай холбогдуулан "2002-2004 онд бүртгэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг 1 дүгээр, "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг 2 дугаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

3. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:

а/бүртгэл эдийн засгийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх үндсэн дээр нягтлан бодогч, санхүү, эдийн засгийн тэргүүний ажилтны улсын 3 дугаар зөвлөлгөөнийг 2003 оны 2 дугаар улиралд багтаан зохион байгуулсугай;

б/нягтлан бодох бүртгэл, татварын бүртгэл, тайлангийн уялдаар сайжруулж, улсын статистик мэдээллийн үндэслэлийг дээшлүүлэх зорилгоор өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад заавал хөтлөх анхан шатны бүртгэлийн маягт, түүнийг хөтлөх аргачлалыг Үндэсний статистикийн газартай зөвшилцөн 2002 онд шинэчлэн боловсруулж мөрдүүлсүгэй;

в/нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг холбогдох дүрэм, журам, зааврын хамт 2002 оны эхний улиралд багтаан боловсруулж батлан 2002 онд нийт аж ахуйн нэгж, байгууллагын 50 хувьд, 2003 онд 70 хувьд, 2004 онд 90 хувьд хүргэж мөрдүүлсүгэй;

г/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн дотоод эх үүсвэрийг 2002-2004 онь төсвийн төвлөрсөн арга хэмжээний зардалд тусган санхүүжүүлсүгэй.

4. Монгол Улсын нягтлан бодох бүртгэл аудитын стандартыг боловсруулан хэрэгжүүлэх, энэ чиглэлээр сургалт явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг гадаад орон, олон улсын банк, санхүүгийн байгууллага, хандивлагч орнуудын тусламжаар санхүүжүүлэх боломжийг судалж холбогдох улс, байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун нарт даалгасугай.

5. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн бэлтгэдэг их сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийг орчин үеийн шаардлагад нийцүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, бүртгэлийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил явуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд тус тус даалгасугай.

6. Энэ тогтоол болон хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд зохиож байгаа ажил, мөн түүнчлэн байгууллага, аж ахуйн нэгж, ажилтны бүртгэл тооцооны ажлын туршлагыг радио, телевизээр өргөн сурталчлахыг Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

7. "2002-2004 онд бүртгэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх зорилгоор тодорхой төлөвлөгөө боловсруулж ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

2002-2004 ОНД БҮРТГЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улс зах зээлийн эдийн засагт шилжсэнээр бүртгэлийн тогтолцоо 1990-ээд оноос бүртгэлийн шинэ системд шилжсэн. Улсын Их Хурал 1993 онд "Нягтлан бодох бүртгэлийн тухай", 1996 онд "Аудитын тухай" хуулийг тус тус батalснаар Монгол Улсад нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн бүртгэл хөтлөх асуудлыг хуульчлан баталгаажуулсан болно. Өнгөрсөн хугацаанд дээрх хуулиудыг хэрэгжүүлэх, бүртгэл, аудитын шинэ тогтолцоог цаашид боловсронгуй болгож төлөвшүүлэх талаар нэлээд ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

Улсын Их Хурлаас 2001 оны 12 дугаар сард "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулийг шинэчлэн батalсантай холбогдуулан "Бүртгэлийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2001 оны 100 дугаар тогтоол гарч 2002 оныг улсын хэмжээнд "Бүртгэлийн ажлыг сайжруулах жил" болгон зарлаж, түүгий хөтөлбөр боловсруулж ажилласыг Засгийн газарт даалгасан.

"Бүртгэл бол бизнесийн хэл" гэж нэрлэдэг бөгөөд зах зээлийн нөхцөлд бүртгэл хөтлөхүйгээр аж ахуйн нэгж, байгууллага оршин тогтнох үндэсгүй, татвараг тосцож төвлөрүүлэх, хяналт, шалгалт хийх боломжгүй байдаг.

2001 онд улсын хэмжээнд явуулсан бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийн дүнгээс үзэхэд нийт аж ахуйн нэгж, байгууллагын 61 хувь нь бүюу 17678 нь үзлэгт хамрагдаж, 39 хувь нь үзлэгт бүрэн хамрагдаагүй байна. Эдгээр байгууллага улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч үйл ажиллагаа нь бүрэн зогссон, эсхүл үйл ажиллагаа явуулаагүй, хаяг, байршил нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, татварын албанд бүртгүүлж улсын бүртгэлийн гэрчилгээ авсан нийт аж ахуйн нэгж, байгууллагын 30 гаруй хувь нь үйл ажиллагаа явуулдаггүй, ямар нэгэн мэдээ тайлан гаргадаггүй гэсэн дүгнэлт гарч байна.

Үзлэгийн дүнгээр улсын хэмжээгээр анхан шатны бүртгэл хөтлөлт 70.9 хувьтай, нягтлан бодох бүртгэл хөтлөлт 70.3 хувьтай, нийт аж ахуйн нэгж, байгууллагын 66.5 хувь нь санхүүгийн тайлан, 72.4 хувь нь татварын тайлан гаргадаг бусад нь санхүү, татварын тайлан гаргадаггүй; нийт аж ахуйн нэгжийн 27.1 хувьд нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт бүрэн, 32.1 хувьд нь хагас дутуу, 40.8 хувьд нь сүг нэвтрээгүй, төсвийн байгууллагын бүртгэл шинэчлэгдээгүй байгаа нь тогтоогджээ. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүү, татварын тайлангийн гаргалт, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлсэн байдал төрийн емчийн болон төрийн емчийн оролцоотой аж ахуйн нэгжид зохих түвшинд байхад хувийн хэвшилд энэ асуудал хангалттүй байгаа нь үзлэгийн дүгнээс харагдаж байна.

Улсын хэмжээнд 15000 гаруй нягтлан бодогч ажиллаж байгаагийн 7.1 хувь нь мэргэжлийн бус, 70 гаруй хувь нь бүртгэлийн хуучин системээр төгссөн тул тэдгээрийн мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах зайлшгүй шаардлага гарч байна.

Бүртгэл сайн хөтөлдөг, орлого, татвараа үнэн зөв тодорхойлж бүрэн төлдөг бүртгэлийн ажилтныг ажлаас нь халах, нэр хүндийг нь унагаах, зарим аж ахуйн нэгжийн удирдлага бүртгэлийн ажилтантайгаа хуйвалдан орлого, татвараа нуун дарагдуулах, бүртгэл хөтлөхөөс зайлсхийх хандлага газар авч байгаа нь ажиглагдаж байна. Иймд Засгийн газрын зүгээс энэ ажилд өндөр ач холбогдол өгч, хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, үе шат, хамрах хүрээ

1. Хөтөлбөрийн зорилго:

Хөтөлбөрийн үндсэн зорилго нь емчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, санхүү, татварын тайлан, мэдээ гаргах ажлыг сайжруулах, нягтлан бодогчдын мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэдгээрийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэхэд оршино.

2. Хөтөлбөрийн үе шат:

Бүртгэл хөгжүүлэх хөтөлбөрийг 2002-2004 онд үе шаттайгаар хэрэгжүүлнэ.

1 дүгээр үе шат /2002 он/-Нягтлан бодох бүртгэлийн стандартыг боловсруулж нэвтрүүлнэ. Улсын хэмжээнд бүртгэлийн ажлыг сайжруулж нийт аж ахуйн нэгж, байгууллагын 50 хувийн санхүүгийн тайланг стандартын дагуу болгоно.

2 дугаар үе шат /2003 он/-Нягтлан бодогчдын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын талаархи мэдлэг, чадварыг дээшлүүлж нийт аж

ахуйн нэгж, байгууллагын 70 хувьд нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг нэвтрүүлнэ.

3 дугаар үе шат /2004 он/-Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг боловсруулан нэвтрүүлнэ.

3. Хөтөлберийн хамрах хүрээ:

Энэ хөтөлберийн хүрээнд нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүйг боловсруулах, түүнийг практикт нэвтрүүлэх, нягтлан бодогчдын мэдлэг, чадвар, хариуцлагыг дээшлүүлэх ажлыг бүх шатны төсвийн байгууллага, өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагад нэвтрүүлнэ.

Гурав. Хөтөлберийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлберийн хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий Хөтөлберийн зөвлөл ажиллана. Хөтөлберийг улсын хэмжээнд зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг Санхүү, эдийн засгийн яамны Нягтлан бодох бүртгэлийн хэлтэс хариуцан зохион байгуулна.

Хөтөлберийн хэрэгжилтийг хангах асуудлын хүрээнд аймаг, нийслэл, дүүрэгт тодорхой төлөвлөгөө боловсруулан тухайн шатны Засаг дарга батлан мөрдүүлнэ. Төлөвлөгөөний хэрэгжилтийг тухайн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс хариуцна.

Хөтөлберийн хэрэгжилтийн талаар Санхүү, эдийн засгийн яам болон аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтэс хагас жилд нэг удаа Хөтөлберийн зөвлөлд, Хөтөлберийн зөвлөл жилд нэг удаа Засгийн газарт тайлагнана.

Дөрөв. Хөтөлберийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

1. Нягтлан бодох бүртгэлийн стандарт

1. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /НББОУС/-ыг орчуулах, орчуулгыг хянан зөвшөөрөх, тэдгээрээс улсын хэмжээнд дагаж мөрдөх стандартыг эрх бүхий байгууллагын шийдвэрээр батлуулна.

2. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж дагаж мөрдөх анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн маягт, аргачлалыг батлан мөрдүүлнэ.

3. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг Монгол Улсад мөрдөх онцлогийн талаар тайлбар боловсруулж батлан мөрдүүлнэ.

Нягтлан бодох бүртгэлийн стандартыг 2002 онд нийт аж ахуйн нэгж, байгууллагын 50 хувьд, 2003 онд 70 хувьд, 2004 онд 90 хувьд нь нэвтрүүлсэн байхад чиглэгдсэн зохион байгуулалтын арга хэмжээ авна.

4. Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн улсын үзлэгийг төв, орон нутагт жил бүр явуулж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Улсын үзлэгээр амжилттай дүн үзүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагад "Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн төрүүний байгууллага" гэсэн гэрчилгээ олгох ажлыг зохион байгуулна.

2. Сургалт

Өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогчдын сургалтыг дараахь байдлаар зохион байгуулна:

1. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн, сургагч нарын сургалтыг 2002 оны 3 дугаар улиралд багтаан явуулах.

2. Нийслэлд байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогчдын сургалтыг 2002 оны 4 дүгээр улиралд багтаан явуулах.

3. Аймагт байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодогчдод зориулан сургагч нарын хүчээр 2002-2003 онуудад сургалт явуулна.

4. Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зарим ажилтныг гадаад орнуудад сургалтад хамруулах буюу туршлага судлуулна.

3. Бүх нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчилгаа

Нягтлан бодох бүртгэлийн бүх нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, сурталчилгаа явуулах талаар дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

1. Нягтлан бодох бүртгэлийн бүх нийтийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн теле хичээлийг долоо хоног бүр 10-15 минут, радио хичээлийг долоо хоногт 30 минутаар явуулна.

2. Нягтлан бодох бүртгэлийн стандартыг шинэчилсэн, бүртгэл нэвтэрсэн үр дүнгийн талаархи мэдээллийг сард 2-оос доошгүй удаа радио, телевизээр явуулж байна.

3. Бүртгэлийн стандарт нэвтрүүлсэн байгууллага, ажилтны туршлагыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж байна.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд гарах зардлын тооцоо

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 550.0 сая төгрөг зарцуулна.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлын тооцоо

/сая төгрөгөөр/

№	Үзүүлэлтүүд	2002 онд	2003 онд	2004 онд	Дүн
1	Төв орон нутгийн бүртгэлийн мэргэжилтэн, сургагч нарыг бэлтгэх	7.4			7.4
2	Орон нутгийн нягтлан бодогчдод сургалт зохион байгуулах	42.6	87.9	40.1	170.6
3	Улаанбаатар хотын нягтлан бодогчдод сургалт зохион байгуулах	52.8	105.0	53.7	211.5
4	Нягтлан бодох бүртгэлийн ажилтнуудыг гадаад сургалтад хамруулгах, туршлага судлах	40.9	22.8		63.7
5	Монгол Улсын онцлогт нийцсэн нягтлан бодох бүртгэл, аудитын стандартыг боловсруулж хэвлэн нийтлэх	48.4	48.4		96.8
	ДҮН	192.1	268.7	93.8	550.0

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

- Санхүү, эдийн засгийн яамны санхүүгийн төлөвлөсөн арга хэмжээний жил бүрийн төсөвт тусгасан хөрөнгө
- Олон улсын банк, санхүүгийн байгууллага, гадаадын бусад байгууллагаас үзүүлэх техникийн туслалцаа
- Аж ахуйн нэгж, байгууллагын өөрийн хөрөнгө

Зургаа. Гарах үр дүн

Дээр дурдсан арга хэмжээг хэрэгжүүлснээр бүртгэл, тайлангийн ажил дараахь үр дүнд хүрнэ:

- анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөлт, мэдээ, тайлан гаргалтын улсын дундаж түвшин эрс дээшилнэ.
- нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцсэн Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандарттай болж нягтлан бодогчдын мэдлэг мэргэшил дээшилнэ.
- аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэл хөтлөлт сайжирснаар татварын орлого нэмэгдэж, төсвийн орлогын бүрдүүлэлтэд эерэг нөлөө үзүүлнэ.
- нягтлан бодогчдын мэргэшлийн болон нийт хүмүүсийн бүртгэлийн талаархи мэдлэгийн түвшин дээшилнэ.
- улсын хэмжээнд бүртгэл, тайлан тооцоосны талаар арга зүй, зохион байгуулалтын удирдлагаар хангах эрх зүйн орчин бүрдэнэ.
- аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд бүртгэлээр тавих хяналт шалгалт нэмэгдэж, хариуцлага тооцох тогтолцоо бүрдэнэ.
- нягтлан бодох бүртгэл, мэдээллийг шинэ техник, технологиор боловсруулах нөхцөл бололцоо хангагдана.

Засгийн газрын 2002 оны 11 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ЗАСГИЙН ГАЗРЫН 2002-2004 ОНД БҮРТГЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Санхүү, эдийн засгийн дэд сайд

Гишүүд: -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;
-Үндэсний татварын ерөнхий газрын дарга;
-Үндэсний статистикийн газрын дэд дарга /тохиролцоноор/;
- Монгол банкны бүртгэл, тооцоо, мэдээллийн технологийн газрын дарга /тохиролцоноор/;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Эдийн засаг, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын дарга;
-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга;
-Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын дарга;

-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн сангийн удирдлага зохицуулалтын газрын дарга;
-Санхүү, эдийн засгийн сайдын дэргэдэх Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөлийн дарга.
Нарийн бичгийн дарга
-Санхүү, эдийн засгийн яамны нягтлан бодох бүртгэлийн хэлтсийн дарга.

Засгийн газрын 2002 оны 11 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах байгууллага
1. "Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм"-ийг шинээр боловсруулан батлаж мөрдүүлэх	2002 оны 1 дүгээр сард	Санхүү, эдийн засгийн яам
2. Бүртгэл, тайлан тооцооны талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах	2002-2004	Санхүү, эдийн засгийн яам
3. Салбарын хөгжлийн удирдлага зохицуулалтын газрын Нягтлан бодох бүртгэлийн хэлтсийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу өөрчлөн зохион байгуулж үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх	2002 оны 1 дүгээр сард	Санхүү, эдийн засгийн яам
4. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн стандартын хорооны (орон тооны бус) бүрэлдэхүүн, дүрмийг шинээр батлаж мөрдүүлэх	2002 оны 2 дугаар сард	Санхүү, эдийн засгийн яам
5. Зарим аж ахуйн нэгжид мөрдөх нягтлан бодох бүртгэлийн энгийн хэлбэрийн бүртгэлийн журам боловсруулж мөрдүүлэх	2002 оны 2 дугаар сард	Санхүү, эдийн засгийн яам
6. Төсвийн болон төрийн өмчийн үйлдвэрийн газрын нягтлан бодогчдыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын талаарх сургалтад хамруулах	2002-2004	Санхүү, эдийн засгийн яам
7. Монгол Улсын онцлогт нийцүүлэн нягтлан бодох бүртгэл, аудитын стандартыг боловсруулан хэвлэн нийтлэх	2002-2003	Санхүү, эдийн засгийн яам
8. Бүртгэл хөтлөлтийн улсын үзлэгийг жил бүр татвар төлөгчдийн тооллоготой хамт явуулах	2002-2004	Санхүү, эдийн засгийн яам, Үндэсний татварын ерөнхий газар
9. Аж ахуйн нэгж, байгууллага, Засгийн газар хоорондын гэрээний үндэсэн дээр хэрэгжиж байгаа төслүүдийн дансны тооллогыг жил бүрийн 12 дугаар сард явуулах	2002-2004	Санхүү, эдийн засгийн яам
10.Төсвийн байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн стандартыг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж мөрдүүлэх	2002-2003	Санхүү, эдийн засгийн яам
11. 2003 оны П улиралд хийх "Нягтлан бодох бүртгэл, санхүү, эдийн засгийн тэргүүний ажилтны 3 дугаар зэвлэлгөөн"-ий бэлтгэлийг хангуулж, бүртгэл, эдийн засгийн тулгамдсан асуудлыг хэлэлцэх	2003 оны П улирал	Санхүү, эдийн засгийн яам
12.Хөтөлбөрийг орон нутгийн түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох	2002-2004	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга
13.Хөтөлбөрийн хэрэгжилттэй холбогдсон мэдээлэл, суртапчил-гаа бэлтгэж, холбогдох байгуул-лагад хүргүүлэх, хөтөлбөрийг хэрэгжүүлэх асуудлаар сургалт явуулах	2002-2004	Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга
14.Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж мөрдөх	2002-2004	Аж ахуйн нэгж, байгууллагын дарга
15.Хөтөлбөрийг аж ахуйн нэгж, байгууллагын түвшинд хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах	2002-2004	Аж ахуйн нэгж, байгууллагын дарга

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

Тогтоол хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2000 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 16 дугаар тогтоол, "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1999 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 133 дугаар тогтоолын хавсралтын 15 дахь заалтыг тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 13 | Улаанбаатар хот

Хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө, Үндэсний хорооны бүрэлдэхүүн, дүрмийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ойн тухай үндэсний хөтөлбөрийн 1 дүгээр үе шатны зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 1 дүгээр хавсралт, Ойн тухай үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт, "Үндэсний хорооны дүрэм"-ийг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Орон нутагт Үндэсний хорооны салбарыг бий болгон "Ойн тухай үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулан ажлын явц, үр дүнг жил бүрийн 1 улиралд багтаан Засгийн газарт тайлагнаж байхыг Үндэсний хорооны дарга У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2002 оны 13 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"ОЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙН 1 ДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2002-2005 он)

Зорилт	Арга хэмжээ	Хугацаа /он/	Хариуцан гүйцэтгэх байгууллага
I.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах	1."Ойн тухай үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийн явц, үр дүнг сурталчилна	2002	Байгаль орчны яам, Радио, телевизийн хэрэг эрхлэх газар
	2.Аймаг, нийслэлд дэд хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна	2002	Байгаль орчны яам, Засаг дарга нар
II. Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл, ойн түймэр, хөнөөлт шавьж, өвчнөөс сэргийлэх, тэдгээртэй тэмцэх, хохирлыг арилгах арга хэмжээг	1.Ойн хайгуул төслийн төвийг ойн талбайн өөрчлөлтийг санспаас тандан судлах, газар зүйн мэдээллийн системийг ашиглан ойн зураг үйлдэх техник, тоног төхөөрөмжөөр хангана	2002-2004	Байгаль орчны яам
	2.Ойн том масштабын гэрэл зургийг 3.0 сая га талбайд онгоцоор авна	2003-2005	Байгаль орчны яам

шуурхай хэрэгжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх, ойг хамгаалах ажилд дэвшилтэт техник технологи нэвтрүүлэх	3.Ой зохион байгуулалтын ажлыг 0.8 сая га 1.0 сая га 1.2 сая га 1.4 сая га талбайд тус тус гүйцэтгэнэ	 2002 2003 2004 2005	Байгаль орчны яам.
	4. Ойн мэргэжлийн байгууллагуудын удирдлагын дор ажилгүй иргэдийг оролцуулах замаар арчилгаа, цэвэрлэгээний ажлыг жилд 3000 га-гаас доошгүй талбайд гүйцэтгэнэ	2002-2005	Байгаль орчны яам, Засаг дарга нар, аж ахуйн нэгж, байгууллагууд
	5.Ойн түймрээс сэргийлэх, түүнтэй тэмцэх төлөвлөгөөг аймаг, сумын хэмжээнд боловсруулан, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт жил бүр тусгаж, санхүжүүлнэ	Жил бүр	Аймгийн Засаг дарга
	6.Ой бүхий аймаг, Улаанбаатар хот дахь байгалийн гамшиг, гал түймэртэй тэмцэх нэгжийг холбооны болон түймэр унтраах техник, багаж хэрэгслээр хангана. Үүнд: -Улаанбаатар, Сэлэнгэ, Хөвсгөл; -Булган, Хэнтий, Дорнод, Архангай, Завхан, Төв	 2002 2003-2005	Байгаль орчны яам, Батлан хамгаалах яам, Хууль зүй, дотоод хэргийн яам
	7.Үүлэнд нөлөөлж тунадас оруулах 2000 ширхэг сум захиалж авна	2002-2005	Байгал орчны яам, Улсын байнгын онцгой комисс
	8.Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй тэмцэх хэсэг, судалгааны лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг шинэчилнэ	2002-2004	Байгаль орчны яам
	9. Ойн хөнөөлт шавьж, өвчний судалгаа, шинжилгээний ажлыг эрчимжүүлж, хөнөөлт шавьжийн олшролтын урт, богино хугацааны төлөвийг тогтоож урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээ авна. Үүнд: 7000 га 7000 га 6000 га 6500 га	 2002 2003 2004 2005	Байгаль орчны яам
	10.Хөнөөлт шавьж, өвчний тархалтын судалгааг 1.0 сая га талбайд гүйцэтгэнэ	2002-2005	Байгаль орчны яам
	11. Ойн хөнөөлт шавьж, өвчинтэй биологийн аргаар тэмцэх ажлыг өргөжүүлж, шаардлагатай 69000 литр био бэлдмэлийг дотооддоо үйлдвэрлэнэ	2002-2005	Биокомбинат
III. Орчин үеийн техник, технологи бүхий жижиг, дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх, ой модны ашиглалтын түвшинг дээшлүүлэх, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах, чанарыг сайжруулах, мод, модон бүтээгдэхүүний	1. Жилд бэлтгэх модны төрөл, тоо хэмжээг ойн даацтай нь уялдуулан аймаг, сум тус бүрээр тогтооно	2002-2003	Байгаль орчны яам
	2.Улсын хэмжээнд 20.0-30.0 мянган га мод бэлтгэлийн талбайг тусгаарлан мод бэлтгэх технологийн горимыг тогтоож мөрдүүлнэ	2002-2005	Мэргэжлийн байгууллагууд
	3.Ойг нөхөн сэргээх үйл ажиллагааг үр дүнтэй явуулж чадах техник технологи, мэргэжлийн боловсон хүчин бүхий аж ахуйн нэгжид ойн санг гэрээгээр эзэмшиж хамгаалах,	2002-2003	Байгаль орчны яам

дотоодын хэрэгцээг хангахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	мод бэлтгэх эрх олгох журам боловсруулж мөрдүүлнэ		
	4.Ашиглалтын насанд хүрээгүй мод огтлож, жижиг дүгуй хөрөөгөөр дүнз хийж байгаа үйл ажиллагааг таслан зогсоох хууль эрх зүйн актыг боловсруулж мөрдүүлнэ	2002-2003	Байгаль орчныг хамгаалах алба
	5. Говь, цөлийн бүсийн зарим аймаг, сумдын түлшний хэрэгцээг хангах зорилгоор хангайн бүсээс мод тээвэрлэх зардлыг улсын төвлөрсөн төсөвт тусгаж санхүүжүүлэх зардлын тооцоо, судалгаа хийж, санал боловсруулж шийдвэрлүүлнэ	2002-2003	Санхүү, эдийн засгийн яам, Байгаль орчны яам
	6. Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Хэнтий, Архангай гэх мэт ой бухий аймгуудын ойн нөөцөд ой зохион байгуулалт хийх, ойн арчилгаа, цэвэрлэгээний огтолтыг ой зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу хийлгэх асуудлыг олон улсын болон дотоодын хөрөнгө оруулагчдын дунд тендер зарлах замаар шийдвэрлэх	2002-2004	Байгаль орчны яам, Санхүү, эдийн засгийн яам
	7.Мод, модон түүхий эдийн импортыг дэмжих эдийн засгийн хөшүүрэг, эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээ авна	2002-2003	Үйлдвэр, худалдааны яам, Үндэсний татварын ерөнхий газар, Улсын гаалийн ерөнхий газар
	8.Төмөр замын дэр модыг импортлох буюу өөр материалаар орлуулах арга хэмжээ авна	2002-2004	Дэд бүтцийн яам, Улсын гаалийн ерөнхий газар, Үндэсний татварын ерөнхий газар
	9. Модны шилмүүс, үзүүр мөчир, гишүүг, үртэс, холтос, зах, тайрдас, тавааралг чанар муутай модыг механик болон химийн аргаар гүнзгий боловсруулж ашиглах судалгаа хийж хэрэгжүүлж эхэлнэ	2002-2005	Үйлдвэр, худалдааны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
	10. Модны шилмүүснээс эфирийн тос, витамин нунтаг, эмчилгээний хэнд болон шинэс, нарс модноос давирхай олборлон канифол, скипидар, хус модноос нүүрс гарган авах төсөл шалгаруулж, гадаадын хөрөнгө оруулагч нарт суртачилж хэрэгжүүлнэ	2002-2004	Үйлдвэр, худалдааны яам
	11.Хус модыг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, хусан зүймэл шал, барилгын модон хийц, эдлэлийг үйлдвэрлэх техник технологийг нэвтрүүлэх санаачилгыг дэмжинэ	2002-2005	Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам
	12. Мебель, модон эдлэлийн үйлдвэрлэлийг шинэчлэх, шинээр байгуулах замаар зах зээлд өрсөлдөх чадвартай жижиг, дунд үйлдвэр байгуулахыг татвар, тарифийн бодлогоор дэмжиж, экспортын модон бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ	2002-2005	Үйлдвэр, худалдааны яам, Байгаль орчны яам
	13. Наамал болон шахмал хавтан, фанер, мебелийн хуулга үйлдвэрлэх дэвшилтэт технологи бухий үйлдвэр шинээр байгуулагдад хөнгөлөлт, дэмжлэг үзүүлнэ	2002-2005	Үйлдвэр, худалдааны яам, Үндэсний татварын ерөнхий газар

	14. Хөдөөгийн малчид, иргэдийн өргөн хэрэглүүэний модон эдлэл, гэрийн мод үйлдвэрлэх уламжлалт аргыг орчин үеийн технологитой хослуулан, төв, орон нутагт жижиг, дунд үйлдвэр байгуулж байгаа аж ахуйн нэгжийг жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамруулах арга хэмжээ авна	2002-2005	Үйлдвэр, худалдааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
	15. Ойн дагалт баялгийн ашиглах боломжтой нэр төрөл, нөөцийг тогтоох судалгаа хийнэ	2003-2005	Байгаль орчны яам
	16. Самар, жимс, мөөг, эмийн ургамал зэрэг ойн дагалт баялгийг бэлтгэж ашиглах заавар, зөвлөмж, гарын авлага боловсруулж хэвлүүлнэ	2002-2003	Байгаль орчны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
	17. Ойн дагалт баялгийг бэлтгэж, боловсруулах ажлыг өргөжүүлэх, нэр төрлийг олшруулах замаар орлогоо нэмэгдүүлэх ерхийг төсөлд хамруулж дэмжлэг үзүүлнэ	2002-2005	Байгаль орчны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
IV. Мод сөөгний үр бэлтгэх, тарьц суулгац үржүүлэх ажлыг эрчимжүүлж, гол мөрний эх, мод бэлтгэсэн, түймэр, хөнөөлт шавьж, өвчинд нэрвэгдсэн ойн талбайг эхний ээлжинд ойжуулж, тал хээр, говь, цөлд хамгаалалтын ойн зурвас, төгөл, ногоон хаалт байгуулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлэх	1. Ой ургамалжилтын муж бүрт модны үр бэлтгэх байгуйн хэсгийг 400 га талбайд туслаарлаж сор шилмэл модыг сонгон тогтооно	2002-2005	Байгаль орчны яам, мэргэжлийн байгууллагууд
	2.Жил бүр 500 кг-аас доошгүй үрийг улсын үрийн санд нөөцлөнө	2002-2005	Байгаль орчны яам
	3.Үрийн чанарын шинжилгээний лабораторийн багаж хэрэгслийг шинэчилнэ	2003-2005	Байгаль орчны яам
	4.Ойг нөхөн сэргээх ажлыг 7600 га 8000 га 9000 га 10000 га талбайд гүйцэтгэнэ	2002 2003 2004 2005	Байгаль орчны яам, аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	5. Ойжуулах, бэлчээр, тариалангийн талбайн хөрсний элэгдэл, эвдрэл, цөлжилтөөс хамгаалах ойн зурвас байгуулах, хот цэцэрлэгжүүлэлтэд шаардагдах тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрууд байгуулж байгаа иргэн, аж ахуйн нэгжид хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан болон банкнаас хөнгөлөлттэй зээл олгох замаар дэмжлэг үзүүлнэ	2002-2005	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Байгаль орчны яам
	6.Нутгийн иргэд,сурагч, залуучуудад модны үр, боргоцой бэлтгэх, тарьц, суулгац бойжуулах, ойг тарьж ургуулах талаар сургалт явуулж, гарын авлага хэвлүүлэн хангана	2002-2004	Байгаль орчны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
	7. Үр, боргоцой бэлтгэх, тарьц, суулгац бойжуулах ажлыг механикжуулах, энгийн гар багаж, техник хэрэгслийн загвар зохион бүтээж туршилт хийнэ	2002-2003	Үйлдвэр, худалдааны яам, Байгаль орчны яам, Шинжлэх ухаан технологийн сан

	8. Мод үржүүлэг, ойжуулалтын ажлын техник, технологийг боловсронгуй болгож, энгийн, бага оворын техник хэрэгслээр хангах тендер зарлаж хэрэгжүүлнэ	2003-2005	Байгаль орчны яам, Шинжлэх ухаан технологийн сан
	9. Ой ургамалжилтын муж, бүс нутгуудад ойг байгалийн аясаар болон зориудаар нөхөн сэргээх хялбар, егөөжтэй арга технологийн судалгаа явуулна	2003-2004	Байгаль орчны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
	10. Ойг нөхөн сэргээх ажлыг зураг төслийн дагуу хийж, ойжуулалтын ажил явуулах, түүний үр дүнг тооцох, хүлээн авах, улсын ойн санд шилжүүлэх, санхүүжүүлэх журмыг шинэчлэн баталж мөрдүүлнэ	2002-2003	Байгаль орчны яам, Санхүү,эдийн засгийн яам
	11. Ойжуулалт, ойн аж ахуйн арга хэмжээний ажлын норм, үнэлгээ, зардлыг шинэчлэн тогтооно	2002-2003	Байгаль орчны яам, Санхүү, эдийн засгийн яам
	12. Жил бүр Дэлхийн байгаль хамгаалах өдрийг угтаж бүх нийтээр мод тарих 10 хоногийн хөдөлгөөнийг аймаг, сум бүрээр зохион байгуулна	Жил бүр	Байгаль орчны яам, аймгийн Засаг дарга нар
	13. Иргэн, аж ахуйн нэгж бүр өөрийн ойжуулсан талбайг ойн санд шилжүүлэх хүртэл байнга арчилж, улсын ойн санд шилжүүлэхэд урамшуулах механизмыг бүрдүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, иргэн, аж ахуйн нэгжүүдэд ойжуулалтын ажлын буртгэл тооцоог сайжруулна	2002-2003	Байгаль орчны яам, аймгийн Засаг дарга нар
	14.Цөлжилттэй тэмцэх, тариалангийн талбайн хөрс, бэлчээрийг хамгаалах зорилгоор ойн зурвас, төгөл байгуулах ажлын зардлын нормативыг шинээр боловсруулна	2002-2003	Байгаль орчны яам
Ү.Ой, модны салбарын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох	1. Ой модны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүтэц, орон тоог баталж, үйл ажиллагааг эхлүүлнэ	2002-2003	Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам, Засаг дарга нар
	2. Ойн нөөц бүхий аймгуудад ойн асуудал эрхэлсэн бүтэц зохион байгуулалтын нэгж бий болгож, ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг удирдан зохион байгуулах	2002	Байгаль орчны яам, Засаг дарга нар
	3. Төрийн бус байгууллагатай гэрээ байгуулах замаар төрийн захиргааны зарим үүргийг гүйцэтгүүлэх арга хэмжээ авна	2002-2005	Байгаль орчны яам

VI. Ойн салбарт шинжлэх ухаан, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх, олон улсын хамтын ажиллагааг өргөжүүлэх, мэргэжлийн боловсон хүчний чадавхийг дээшлүүлэх	1. Ойн холбогдолтой хууль тогтоомжуудын хоорондын уялдаа холбоог сайжруулах, бусад хууль тогтоомжтой нийцүүлэх судалгаа хийж төсөл боловсруулна	2002-2004	Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам
	2.Жил бүрийн бүх нийтээр мод тарих өдрөөр ойн тухай хууль тогтоомжийг сурталчлах арга хэмжээг зохион байгуулна	2002-2005	Байгаль орчны яам, аймгийн Засаг дарга нар, мэргэжлийн байгууллагууд
	3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт зориулан ойн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ойн нөөцийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээх ажлын талаар гарын авлага боловсруулж, сургалт зохион байгуулна	2002-2004	Байгаль орчны яам
	4.Ойн санг аж ахуйн нэгж, байгууллагад гэрээгээр, нутгийн иргэдэд хамтын эзэмшлийн журмаар эзэмшүүлэх журмыг шинэчлэн боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авна	2002-2003	Байгаль орчны яам
	5.Ойг хамгаалах, зохистой ашиглах,нөхөн сэргээх технологи боловсруулах судалгаа хийнэ	2002-2005	Байгаль орчны яам, Шинжлэх ухааны академи
	6. Баруун хойд Хэнтийн ойн экосистемийн өөрчлөлтийн судалгаа хийнэ	2002-2005	Байгаль орчны яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
	7. Тусгай хамгаалалттай газар нутаг (ТХГН)-ийн ой зохион байгуулалтын ажлыг хилийн заагаар хийж ойн аж ахуйн арга хэмжээг ТХГН-ийн менежментийн төлөвлөгөөнд тусгаж хэрэгжүүлнэ	2003-2005	Байгаль орчны яам
	8. ТХГН-ийн ойд ойн аж ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэх журмыг боловсруулж мөрдүүлнэ	2002	Байгаль орчны яам
	9.ТХГН-ийн Хамгаалалтын захиргаа бүрт мод үржүүлгийн газар байгуулж, ойг нөхөн сэргээх ажлыг бие даан гүйцэтгэх материаллаг баазтай болгоно	2002-2005	Байгаль орчны яам

	10.Мод боловсруулах үйлдвэрлэлээс гарах хаягдал, өөдсийг ашиглах, түүхий эдийг гүнзгий боловсруулах, өргөн хэрэглээний мебель, модон эдлэл үйлдвэрлэх технологи боловсруулах, ойн химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн туршилт судалгаа явуулна	2002-2005	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Үйлдвэр, худалдааны яам
	11.Ойн аж ахуй, мод бэлтгэх, боловсруулах үйлдвэрлэлийн шинжлэх ухааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авна	2002-2003	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Үйлдвэр, худалдааны яам, Байгаль орчны яам
	12.Ойн сангийн мэдээ, мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгож, чадавхийг дээшлүүлнэ	2002-2005	Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам
	13. Ойн сангийн ажиллагаа мэргэжлийн боловсон хүчний мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах арга хэмжээ авна	2002-2005	Байгаль орчны яам, Боловсрол, соёл шинжлэх ухааны яам.
	14. Хил дамжсан түймрээс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар ОХУ-тай Засгийн газар хооронд гэрээ байгуулах, БНХАУ, ОХУ-тай байгуулсан гэрээг хэрэгжүүлэх арга хэмжээ авна	2002-2005	Байгаль орчны яам, Батлан хамгаалах яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам
	15. Улаанбаатар хотод байгаль орчны болон ойн мэргэжилтнүүдийн нэрэмжит цэцэрлэг байгуулна	2002-2005	Байгаль орчны яам.
	16.Ойн сангийн гадаад улс орнуудтай хамтран ажиллах хамтын ажиллагааг өргөжүүлнэ	2002-2005	Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам, Гадаад хэргийн яам

Засгийн газрын 2002 оны 13 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Байгаль орчны сайд

Орлогч дарга -Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга

Гишүүд:

-Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Байгаль орчны яамны Стратегийн төлөвлөлт, удирдлагын газрын дарга;

-Байгаль орчныг хамгаалах албаны дарга;

-Байгалийн нөөцийн газрын дарга;

-Санхүү,эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Үйлдвэр, худалдааны яамны Үйлдвэрийн бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;

-Хөдөлмөр эрхлэлтийн газрын дарга;

-Гал түймэртэй тэмцэх газрын дарга;

-Улсын иргэний хамгаалалтын газрын дарга;

-Радио,телевизийн хэрэг эрхлэх газрын дарга;

-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;

-Үндэсний татварын ерөнхий газрын дэд дарга;

-Замын цагдаагийн газрын дэд дарга;

-Монголын ойчдын нэгдсэн холбооны ерөнхийлөгч (тохиролцоноор).

Нарийн бичгийн дарга Орон тооны

Засгийн газрын 2002 оны 13 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ОЙН ТУХАЙ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Үндэсний хороо /цаашид "Хороо" гэх/ нь Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд нь хяналт тавих, ойн салбар дундын асуудлыг зохицуулах үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

2. Хороо нь үйл ажиллагаандаа Ойн тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ дүрмийг удирдлага болгоно.

3. Хороо нь тогтоол, албан бичгийн хэвлэмэл хуудастай байх бөгөөд Байгаль орчны яамны тамга, тэмдгийг хэрэглэнэ.

Хоёр. Хорооны удирдлага, бүтэц зохион байгуулалт

4. Хорооны бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

5. Хорооны үйл ажиллагааны хэлбэр нь хурал байна. Хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурна. Хороо нь ойн асуудлаар тэмдэглэл, зөвлөмж гаргаж болно. Хорооноос гаргасан тогтоол, зөвлөмжийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан хэрэгжүүлэх арга хэмжээ авч түүний явц, үр дүнгийн тухай тогтоосон хугацаанд нь Хороонд мэдээлэх үүрэгтэй.

6. Хорооны хурлыг жилд хоёроос доошгүй удаа хуралдуулж Ойн тухай үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, зохиож байгаа ажлын явц, үр дүнг хэлэлцэнэ.

7. Хурлын дэгийг Хорооны хурлаар хэлэлцэн батална. Хурлыг Үндэсний хорооны дарга, түүнийг эзгүйд орлогч дарга удирдана.

8. Хорооны нарийн бичгийн дарга нь Хорооны хурлын бэлтгэлийг ханган, хурлаас гарсан

шийдвэрийг яам, холбогдох газруудад хүргүүлэх, биелэлтэд нь хяналт тавих болон ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх салбар дундын зохицуулалтын едөр тутмын ажлыг эрхэлнэ. Нарийн бичгийн дарга нь орон тооны байна.

9. Хорооны гишүүд нь тухайн салбарын чиглэлээр хөтөлбөрт тусгагдсан асуудлын зохицуулалтыг хариуна.

10. Хороо нь холбогдох яам, агентлаг, газар, хэлтсийн дарга, мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөллийг оролцуулан тодорхой асуудлаар түр/ш байгууллагаас гаргасан санал, санаачилга, хүсэлтийг судлан, түүний мөрөөр асуудал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

д/ойг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглах талаар иргэд, төрийн бус байгууллагын үүсгэн санаачилгыг дэмжин, тэдгээрийг энэ ажилд өргөнөөр оролцуулан үйл ажиллагаанд туслалцаа үзүүлэх;

е/ойн асуудлаар хууль сахиулах байгууллагуудтай хамтран ажиллах;

ж/ойн талаар гарч байгаа зөрчил, түүний шалтгаан нөхцөлийн талаар судалгаа хийх, мэдээ, мэдээлэл солилцох;

з/ойн чиглэлээр тодорхой зорилт хэрэгжүүлэх зорилгоор холбогдох эрдэм шинжилгээний байгууллага болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажлын хэсэг байгуулж ажиллуулах;

и/Хорооноос зохиож буй ажлын явц, үр дүн болон хэрэглэгчдэд экологийн боловсрол ээмшүүлэх талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулах.

Дөрөв. Бусад зүйл

15. Хорооны үйл ажиллагааны зардлыг Хороо хүрлаараа хэлэлцэн батлах бөгөөд санхүүжилтийг нь харилцан тохиролцсоны үндэсэн дээр холбогдох яам гаргана.

16. Хорооны хуралдаж хэлэлцүүлэх асуудлын материалыг боловсруулсан яам, агентлаг нь Хорооны гишүүдийн тоогоор олшруулж Хорооны нарийн бичгийн даргад өгч, гишүүдэд хүргүүлнэ.

17. Хороо нь ажлаа бүтэн жилээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

18. Хороо нь хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт тайлагнана.

13. Хороо дараахь эрхтэй байна:

а/яам, агентлагийн удирдлага, аймаг, нийслэлийн Засаг даргаас хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохиосон болон ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх яам, санхүүжилтийн явц, зарцуулсан хөрөнгийн тайланг холбогдох байгууллагаас жил, хагас жилээр гаргуулан авах, нэгтгэн дүгнэлт хийх;

б/хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд эрх бүхий байгууллагаас гарсан шийдвэрийн биелэлтийг яам, агентлаг, аймаг, нийслэлд шалгаж үнэлэлт, дүгнэлт өгөх, тэдгээрийн удирдах ажилтны илтгэл, сонсголыг Хорооны хурлаар хэлэлцэн чиглэл өгөх, шаардлагатай мэдээ материалыг гаргуулах;

в/холбогдох эрдэмтэн, мэргэжилтэн, шинжээчийг хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон тодорхой ажилд татан оролцуулах;

г/эрх хэмжээнийхээ хүрээний асуудлаар улс, орон нутгийн чанартай хурал, зөвлөлгөөн, семинар, ярилцлага зохион байгуулах;

д/хорооны шийдвэр, зөвлөмжийг биелүүлээгүй албан тушаалтны талаар удирдлагад нь албан ёсоор мэдэгдэх.

14.Хороо дараахь үүрэгтэй байна:

а/ Ойн тухай үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд нэгдмэл удирдлагаар хангаж, салбар хоорондын асуудлыг уялдуулан зохицуулах;

б/хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, тайлагнах;

в/орон нутгийн салбарыг удирдлага, зөвлөлгөөгөөр хангаж тэдний ажлыг шалгаж дүгнэх;

г/ойн талаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гаргасан санал, санаачилга, хүсэлтийг судлан, түүний мөрөөр асуудал боловсруулж зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;

Гурав. Хорооны эрх, үүрэг

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 12 (249)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Зайны сургалтын үндэсний хөтөлбөр батлах тухай*
- *Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулах, дүрэм батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны гуравдугаар сарын 29 №12 (249)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

123. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 31 533
124. Тунгатбайн Баатарханд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай Дугаар 32 534
125. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 33 534
126. Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах тухай Дугаар 35 536

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

127. Зайны сургалтын үндэсний хөтөлбөр батлах тухай Дугаар 14 536
128. Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулах, дүрэм батлах тухай Дугаар 15 543
129. Хөрөнгө гаргах тухай Дугаар 16 546
130. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариалан хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах тухай Дугаар 17 547
131. Улсын эталон батлах тухай Дугаар 19 548
132. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 20 548

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 31 Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Финланд Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Цэрэндашийн Цолмонг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Финланд Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар Санжаагийн Баярыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 18–ны өдөр Дугаар 32 Улаанбаатар хот

Тунгатбайн Баатарханд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээх тухай

Мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил, үр бүтээлтэй ажиллаж малын тоо толгойг төлөөрнь өсгөх, ашиг шимийг бүрэн ашиглаж хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх, малгүй болон цөөн малтай иргэдийг малжуулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын 3 дугаар багийн малчин ТТТТунгатбайн Баатарханд Монгол Улсын гавьяат малчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАМГАБА**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 18–ны өдөр Дугаар 33 Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Үйлдвэрлэл үйлчилгээ, хөдөө аж ахуй, эрүүл мэнд, боловсрол, төр захиргааны болон төрийн бус байгууллагад олон жил, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон медалиар шагнасугай.

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

Хурманханы Шамед - Баян-Өлгий аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн лабораторийн ахлах эмч

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Исайн Акей - Ховд аймгийн Буянт сумын ногоочин
2. Цэрэнбатын Баасанжав - Нийслэлийн "Атар-Өргөө" ХК-ийн токарьчин
3. Бүткэйн Байболат - Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын Засаг даргын Тамгын газрын дарга
4. Ойдовын Бат-Очир - Увс аймгийн Малчин сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчийн дарга
5. Лувсанцэрэнгийн Баяраа - Дэд бүтцийн улсын хяналтын албаны харилцаа холбооны хяналтын улсын ерөнхий байцаагч
6. Мухиягийн Бригад - Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч
7. Содномбалжирын Бямбаа - Дундговь аймгийн Сайнцагаан сумын "Эрдмийн далай" цогцолбор сургуулийн орос хэлний багш
8. Лувсандоржийн Ваанжил - Дархан-Уул аймгийн Дархан сумын 4 дүгээр дунд сургуулийн сургалтын технологич
9. Бэгзийн Ванчинсүрэн - Орхон аймгийн Баян-Өндөр сумын "Царс импекс" ХХК-ийн ахлах захирал
10. Хандын Дарь - Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн түргэн тусламжийн станцын эрхлэгч, их эмч
11. Лувсан-Ишийн Дашдаваа - Улаанбаатар төмөр замын Суудлын вагон депогийн инженер
12. Батменхийн Зинамидэр - Монголын тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны гүйцэтгэх захирал
13. Ханатбайн Көнбай - Баян-Өлгий аймгийн Холбооны газрын эзэлжийн техничк
14. Лувсандашийн Нямаа - Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын мастер
15. Дашлхамын Пүрэвдорж - Дархан-Уул аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвийн дарга
16. Баярын Сүхтэй - Ховд аймгийн Булган сумын Нэгдсэн эмнэлгийн эмэгтэйчүүдийн их эмч

17. Хужигийн Тогоо - Баянхонгор аймгийн Өлзийт сумын малчин
18. Цээрэвийн Уган - Ховд аймгийн Мөнххайрхан сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан
19. Анхайн Хуан-Иш - Нийслэлийн "Улаанбаатарын цахилгаан түгээх сүлжээ" ХК-ийн инженер
20. Дамдингүржавын Цэвэлмаа - Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын эсгүүрчин
21. Гимпэлийн Цэдэвдорж - Дорноговь аймгийн Иххэт сумын Зүлэгтийн дунд сургуулийн захирал
22. Оролбайн Шолтай - Ховд аймгийн Жаргалант сумын "Эрчлүүр" ХХК-ийн гүйцэтгэх захирал

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

Баасанхүүгийн Лхагвацэрэн - Хорих 407 дугаар ангийн аж ахуйн дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Бооройн Батбаасан - Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын оёдолчин
2. Цэрэннадмидын Доржготов - Завхан аймгийн Улиастай сумын "Ёст тохой" ХХК-ийн механикч
3. Цэрэндоржийн Думаа - Баянхонгор аймгийн Баянхонгор сумын барилга угсралт, засварын "Хаш өргөө" ХХК-ийн мастер
4. Зайкений Күлзия - Баян-Өлгий аймгийн Өлгий сум дахь нисэх онгоцны буудлын нягтлан бодогч
5. Улагбаны Мамбар - Баян-Өлгий аймгийн Толбо сумын Засаг дарга
6. Тавхайн Намжил - Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын 2 дугаар багийн Засаг дарга
7. Гомбодоржийн Нэргүй - Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын оёдолчин
8. Кадений Онашыбай - Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Засаг даргын Тамгын газрын дарга
9. Банзарын Отгон - Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийн багш
10. Ходройн Оюун - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн 68 дугаар цэцэрлэгийн багш
11. Даваагийн Оюунбилэг - Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын эсгүүрчин
12. Цэдэндоржийн Пүрэвдоо - Монголын дүлий иргэдийн нийгэмлэгийн тэргүүн
13. Самданжамцын Сайнбаяр - Монголын тахир дутуу иргэдийн байгууллагуудын үндэсний холбооны албаны дарга
14. Хапийн Самархан - Баян-Өлгий аймгийн Алтай сумын 1 дүгээр багийн Засаг дарга
15. Хажийн Серижан - Баян-Өлгий аймгийн Нэгдсэн эмнэлгийн чих, хамар, хоолойн тасгийн эрхлэгч, их эмч
16. Энэбишийн Туяа - Дархан-Уул аймгийн Дархан сумын "Од" цогцолбор сургуулийн химийн багш
17. Санийн Хадис - Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл
18. Төкейн Хуан - Монголбанкны Баян-Өлгий аймаг дахь салбарын хянан шалгагч-эдийн засагч
19. Сономцэвээний Хүрэлбаатар - "Цагаан шөнө" хамтлагийн ахлагч
20. Дуламсүрэнгийн Чүлтэм - Говь-Алтай аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн дарга

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

21. Дававаанямын Даваа-Очир - Нийслэлийн шүүхийн шийдвэр биелүүлэх албаны дарга

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 20–ны өдөр Дугаар 35 Улаанбаатар хот

Үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах тухай

Монгол Улс нийгмийн шинэчлэл, ардчилсан өөрчлөлтийг өрнүүлэн дэлхийн улс орны хамт шинэ мянганы босгыг алхаж, шинэ зуунтай учраад нэгэн жилийг үдлээ.

Шинэ зуунд даяарших үйл явц ихээхэн өргөжих төлөвтэй байна. Монгол Улсын хувьд даяаршилд зохицох, түүнтэй хөл нийлүүлэх нийгмийн шаардлага, бас өөрийгөө хадгалан хөгжүүлэх, ерөнхийдөө чадавхиа есгэх үндэсний хэрэгцээ, сонирхол хослон тулгарч байна.

Өнгөрсөн хугацаанд Монгол Улсын Их Хурал үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын болон хөгжлийн үзэл баримтлал зэрэг бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэж батаслан билээ. Түүнчлэн эдгээрийн хүрээнд багтах олон хөтөлбөр, бодлого, чиглэлийг УИХ, Засгийн газар батлан гаргаж мөрдөж ирэв.

Гэвч шинэ зуун улс орон бүрт шинэ боломж, сонголтыг олгож, шинэ асуудал, шийдлийг дэвшүүлж, шинэ сорилт, шалгалтыг тулгаж буй төдийгүй хөгжлийн чиг баримжаа, хэтийн зорилтоо шинээр харахыг шаардах болгоо.

Хөгжлийг үзэх үзэл, нийгмийн дэвшлийн шалгуурын тухай ойлголт ч өөрчлөгдөж, хүний хөгжлийн үзүүлэлтийг баримжаалах нийтлэг жишиг тогтож байна.

Арчилал, шинэчлэл гүнзийрэх тусам улс төрийн хүчнүүд, ард олныхоо санал бодлыг шингээн тусгасан, улс орны хөгжлийн тогтвортой чиглэл, удирдамж болох үндэсний зөвшилцлийн шинжтэй хөтөлбөр боловсруулан баталж, түүнийгээ туушталй хэрэгжүүлэх бодит хэрэгцээ бий боллоо.

ашигт нийцсэн, хэтийг харсан, тэгэхдээ хүрч болох зорилтуудыг дэвшүүлсэн, тэдгээрийг хэрэгжүүлэх арга замыг тодорхой тусгасан байвал зохино.

Хөтөлбөр нь товч тодорхой, ойлгомжтой, хялбар дөхөм байх тусам олон түмэнд хүрч, төрийн бодлого, үйл ажиллагааны удирдлага болж чадна.

Энэ бүхнийг иш үндэс болгож, улс төрийн намуудын удирдлагатай хийж буй ярилцлагын явцад удаа дараа хөндөгдсөн асуудлыг анхааралдаа авч, эрдэмтэд, мэргэжилтнүүд, ард иргэдээс дэвшүүлж буй санал, бодлыг тунгаан үзэж, "Зууны илгээлт"-дээ дурьдсан үндсэн зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал болон одоо мөрдөгдөж буй бусад хөтөлбөр, үзэл баримтлалыг шинэчлэн баяжуулах, тодотгох үндэсэн дээр 2021 он хүртэлх Монгол Улсын үндэсний хөгжлийн хөтөлбөрийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

2. Хөтөлбөрийн төсөл боловсруулах, хэлэлцэн зөвшилцөхөд улс төрийн намууд, шинжлэх ухааны болон төрийн бус байгуулагад, олон нийтийн төлөөллийг идэвхтэй оролцуулж, тэдний санал, бодлыг судалж тусгахыг Монгол Улсын Засгийн газарт зөвлөсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Н. БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
Н. ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 25–ны өдөр Дугаар 14 Улаанбаатар хот

Зайны сургалтын үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын 2000 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын мэдээлэл, харилцаа, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт зайны сургалтын талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Зайны сургалтын үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр, Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагдсугай.

2. "Зайны сургалтын үндэсний хөтөлбөр"-т дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаагаар хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх явц бүрийн үндэсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж байхын хамт зарим төслийг олон улсын байгууллага, хандивлагч орнуудын техникийн бүцалтгүй тусламжаар санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт үүрэг болгосугай.

3. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаанд Монгол Улсын мэдээлэл, харилцаа, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлалтай нягт уялдуулан зохицуулах арга хэмжээ авч байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

4. Монголын радио, телевизийн нэвтрүүлгийн программд зайнаас сургалт зохион байгуулах цаг гаргаж байх арга хэмжээ авахыг Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод үүрэг болгосугай.

5. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Албан бус боловсролын төвийн материаллаг баазын ашиглалтыг сайжруулах зорилгоор тус төвийг Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв болгон өргөтгөн зохион байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

6. Эрхэлсэн ажлынхаа хүрээнд боловсон хүчнийг дахин бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэхдээ зайны сургалтын арга, хэлбэрийг өргөнөөр нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг сайд нарт үүрэг болгосугай.

7. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаат эрхэлсэн ажлын хүрээ, нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, гүйцэтгэлийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд жил бүрийн 1 дүгээр сард тайлагнаж байхыг холбогдох сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2002 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ЗАЙНЫ СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл

1. Шинэ зууны боловсролын нэг гол шинж бол нээлттэй сургалт, зайны сургалтын арга хэлбэр өргөжиж байгаа явдал мөн. Боловсролын тухай хуульд хөгжлийн шинэ нөхцөл байдлыг харгалзан боловсролын зорилгыг иргэдийнхээ бие даан сурч, амьдрах чадвартай болгоход нь үйлчлэх чиглэлээр шинэчлэн тодорхойлсон билээ. Боловсролын хэрэгцээг орон зай, цаг хугацаанаас тэдийлэн шалгаалахгүйгээр уян хатан, олон хувилбартай, нээлттэй, хүртээмжтэй, чанартай, үр ашигтайгаар хангах тогтолцоо бий болгох нь чухал байна.

2. Сургуулийн өмнөх боловсрол, бага, суурь, бүрэн дунд боловсрол, техник, технологи, мэргэжлийн боловсрол, дээд боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэх, хүүхдийн суралцах, хөгжих эрхийг тэгш боломжоор хангах, иргэдийн насан туршдаа суралцаж, мэргэжил боловсролоо дээшлүүлэх, амьдрах чадвараа хөгжүүлэхэд зайны сургалт чухал ач холбогдолтой гэдгийг иш үндэс болгож, зайны сургалтын нөөц, шинээр бий болж байгаа боломжийг тогтвортой бүтээ болгон өргөжүүлж үр өгөөжийг нь нэмэгдүүлэхийн тулд Засгийн газраас Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг гаргаж байна. Зайны сургалтын үндэсний хөтөлбөр нь Бүх нийтийн боловсролын үйл ажиллагааны хүрээг баталсан Дакарийн тунхаглалыг хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Засгийн газраас явуулах үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг байх болно.

Хоёр. Зорилго

3. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь албан болон албан бус боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлж, хүн амд насан туршдаа суралцах боломж олгоход нь дэмжлэг үзүүлэх зайны сургалтын үндэсний тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэхэд оршиж байна.

Гурав. Зорилт

4. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтуудаар хэрэгжүүлнэ:

4.1. Зайны сургалтын бодлогын зохицуулалт, менежментийн тогтолцоог бий болгох;

4.2. Зайны сургалтын үйлчилгээ, үйл ажиллагааны механизм бүрдүүлэх;

4.3. Зайны сургалтын мэргэжилтэн бэлтгэх,

хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх;

4.4. Зайны сургалтын хүртээмжтэй, чанартай, үр ашигтай мэдээлэл, техникийн орчин бий болгох;

4.5. Зайны сургалтын оновчтой хэлбэрийг сонгон ашуулга, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх.

Дөрөв. Зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5. Зайны сургалтын бодлогын зохицуулалт, менежментийн тогтолцоог бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

5.1. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх бодлого, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх, түүнтэй нийцүүлсэн шийдвэр гаргаж, дэд хөтөлбөр хэрэгжүүлэх;

5.2. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг холбогдох яамтай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх;

5.3. Зайны сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур, үзүүлэлтийг мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, үе шаттайгаар хэрэгжүүлэх;

5.4. Хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг улсын төсөрсөн болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, хандивлагч орны тусламж, хувийн хөрөнгө оруулалт, хандив, дотоодын эх үүсвэр, нөөц боломжийг ашиглан дэмжлэг үзүүлэх;

5.5. Зайны сургалтын мэдээллийн сан бий болгон ашиглах;

5.6. Хөтөлбөрийн хэрэгжилтийн үе шатны явц, үр дүнг харгалзан хөтөлберт зохих тодотгол хийж, цаашдын бодлого, чиглэлийг тодорхойлох;

5.7. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжүүлэхэд төрийн захиргааны бүх шатны байгууллага, олон улсын мэргэжлийн төрөлжсөн байгууллага, хандивлагч орон, төрийн бус байгууллага, сонирхлын бүлэг, иргэдийн өргөн түншлэлийг бий болгож оролцоог нэмэгдүүлэх.

6. Зайны сургалтын үйлчилгээ, үйл ажиллагааны механизм бүрдүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

6.1. Зайны сургалтыг стратегийн удирдлага, төлөвлөлтөөр хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах, хянах, үнэлэх, Засгийн газарт тайлагнах үүргийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам хэрэгжүүлэх. Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайдаар ахлуулсан төрийн болон мэргэжлийн, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, иргэд, хандивлагчдын төлөөллөөс бүрдсэн зөвлөх үүрэгтэй зайны сургалтын зөвлөлийг ажиллуулах;

6.2. Үндэсний түвшинд зайны сургалтын хэрэгцээ, хүртээмжийн судалгаа хийх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө, удирдлагаар хангах, үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах, боловсон хүчин бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын ашуулга, арга зүйг боловсруулах чиг үүргийг мэргэжил, арга зүйн байгууллага, төслийн багийн оролцоотойгоор хэрэгжүүлэх;

6.3. Үндэсний түвшинд зайны сургалтын мэдээллийг нэгтгэж сан бүрдүүлэх, мэргэжлийн болон арга зүйн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, үр дүнг тайлагнах үүргийг Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв хариуцан гүйцэтгэх; Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвийг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны харьяа Албан бус боловсролын төвийг ерөнхий замаар байгуулж, үйл ажиллагааг нь төсвөөс санхүүжүүлэх;

6.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг орон нутгийн түвшинд удирдлагаар хангах үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргаар удирдуулсан Зайны сургалтын зөвлөл хариуцах. Орон нутгийн түвшинд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйлчилгээ үзүүлэх, сургалт зохион байгуулах чиг үүргийг мэргэжил, арга зүйн байгууллагын оролцоотойгоор аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төв гүйцэтгэх;

6.5. Нутаг дэвсгэрийн түвшинд зайны сургалтын үйлчилгээг бүх шатны боловсролын байгууллага хариуцан зохион байгуулах.

7. Зайны сургалтын мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

7.1. Зайны сургалтын чиглэлээр ажиллаж байгаа боловсон хүчний өнөөгийн байдалд үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;

7.2. Зайны сургалтын мэргэжилтэн бэлтгэх олон хувилбартай сургалтын төлөвлөгөө, агуулга, стандарт боловсруулан хэрэгжүүлэх;

7.3. Мэргэжлийн байгууллага, төслийн багийн нөөц бололцооны тулгуурлан мэргэжилтэн бэлтгэх, тэдний мэргэшлийг дээшлүүлэх, давтан бэлтгэх түр болон богино хугацааны сургалтыг зохион байгуулах;

7.4. Зайны сургалтын чиглэлээр зохиогдож байгаа олон улсын хурал, сургалт, семинарт зайны

сургалтын мэргэжилтэн, арга зүйчдийг оролцуулах;

7.5. Зайны сургалтын чиглэлээр олон улсын, үндэсний түвшний сургалт, семинар зохион байгуулах;

7.6. Өндөр хөгжилтэй оронд зайны сургалтын үндэсний боловсон хүчин бэлтгэх бодлогыг дэмжин хэрэгжүүлэх.

8. Зайны сургалтын хүртээмжтэй, чанартай, үр ашигтай мэдээлэл, техникийн орчин бий болгох зорилтын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

8.1. Монгол Улсад бий болсон зайны сургалтын мэдээлэл, техникийн орчин, түүний ашиглалтад үнэлгээ өгч, дүгнэлт гаргах;

8.2. Радио, телевизийн нэвтрүүлгийн программ сургалтын цаг гаргаж, зардлыг төрөөс санхүүжүүлэх, цаашид боловсролын бие даасан суваг бий болох асуудлыг судалж шийдвэрлэх;

8.3. Төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагын зайны сургалтын хэвлэмэл болон аудио, видео материал бэлтгэх, теле хичээл явуулах, бэб сайт нээх техникийн чадавхийг үе шаттайгаар сайжруулах;

8.4. Бүх түвшний боловсролын байгууллагыг үндэсний мэдээлэл харилцааны тоготолцоо, интернетийн суүлжээнд холбогдох техникийн боломжийг өргөжүүлэх;

8.5. Зайны сургалтын хэрэглэгдэхүүнийг сонирхогч хүнд хүргэх, ашиглах боломж бүхий тоготолцоо бүрдүүлэх;

8.6. Зайны сургалтын мэдээлэл, техникийн орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах, бэлтгэхэд хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, сонирхлыг бүлгүүдийн дэмжлэг, оролцоог нэмэгдүүлэх үйл ажиллагаа хэрэгжүүлэх.

9. Зайны сургалтын оновчтой хэлбэрийг сонгон агуулга, арга зүйг боловсруулж, хэрэгжүүлэх зорилтын хүрээнийй үйл ажиллагаа:

9.1. Цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдийг гэр бүлд түшиглэж хөгжүүлэн сургуульд бэлтгэх зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх;

9.2. Сургуульд сурагч боломжгүй, бичиг үсэг үл мэдэх хүүхдийг бичиг үсэгт тайлах, боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулах сургагч багш нарт зориулсан зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан ерөнхий боловсролын сургууль, албан бус боловсролын байгууллагын оролцоотойгоор хэрэгжүүлэх;

9.3. Мэргэжлийн байгууллагатай хамтран ерөнхий боловсролын сургуулийн сурагч, бүх шатны сурагчагч, ирэгдэзд зориулсан Англи хэлний зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх;

9.4. Багш болон боловсролын удирдах ажилтныг давтан бэлтгэх, мэргэшлийг дээшлүүлэх зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулж хэрэгжүүлэх үйл ажиллагаат хүртээмжтэй, тасралтгүй, тогтвортой болгох;

9.5. Албан бус боловсрол, хүүхэд, залуучуудыг ажилд сургах, амьдралд бэлтгэх болон техник, мэргэжлийн сургалтыг зайны сургалтаар явуулах хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх;

9.6. Дээд боловсролын сургалтад зайны сургалтын арга, технологийг нэвтрүүлэх, зайны сургалтын оновчтой хэлбэрийг хөгжүүлэх;

9.7. Хувийн хэвшлийн эрэлт, хэрэгцээнд тулгуурласан зайны сургалтын агуулга, арга зүйг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж, хэрэгжүүлэх замаар мэргэжилтэн, ажилчдын мэдлэг, чадавхийг бэхжүүлэх;

9.8. Албан бус, тасралтгүй боловсролын хүрээнд эрүүл мэнд, экологи, эрх зүй, эдийн засаг, гэр бүл зэрэг бүх нийтийн боловсролын ерөнхий түвшинг дээшлүүлэх зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх;

9.9. Компьютер, интернат, интернет ашиглан явуулах сургалтын агуулга, арга хэлбэрийг тогтоох, программ хангамжийн нэгдсэн тоготолцоо, сүлжээ бий болгох.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зам

10. Хөтөлбөрийн зорилго, үйл ажиллагаат хэрэгжүүлэхдээ дараахь зарчим, арга замыг ашиглана:

10.1. Хөтөлбөр хэрэгжүүлэх үйл ажиллагаат эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулан зохицуулах;

10.2. Төрийн болон төрийн бус байгуллага, аж ахуйн нэгж, иргэд, хандивлагчдыг зайны сургалтыг хөгжүүлэхэд оролцох боломжоор хангах, хөрөнгө, хүчийг зохистой хуваарилах, түншлэлийг бэхжүүлэх;

10.3. Зайны сургалтын хүрсэн түвшинг хадгалж олон хувилбартай,уян хатан, нээлттэй, онцлог байдлаа харгалзах;

10.4. Зайны сургалтын агуулга, стандартын

түвшинг тухайн боловсролын стандарт түвшингээс бууруулахгүй байх;

10.5. Зайны сургалтыг зохион байгуулахдаа иргэдийн хэрэгцээ, сонирхлыг харгалзан, чөлөөт байдлыг ханган, сурах чадварыг нь хөгжүүлэхэд чиглүүлэх;

10.6. Албан болон албан бус боловсролын нэгдлийг ханган, хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх;

10.7. Зайны сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсруулах олон эх үүсвэрийг бий болгох;

10.8. Зайны сургалтад мэдээлэл, харилцааны дэвшилтэт технологи ашиглах.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

11. Энэхүү хөтөлбөрийг 2002-2010 онд дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Эхний үе шат: 2002-2003 он

Дунд үе шат: 2004-2007 он

Төгсгөлийн үе шат: 2008-2010 он

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт

12. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүгийн дор дурдсан эх үүсвэрийг ашиглана:

12.1. Улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв;

12.2. Олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, буцалтгүй тусламж;

12.3. Мэргэжил дээшлүүлэх суралцагчийн сургалтын төлбөр;

12.4. Үйлчилгээний төлбөр;

12.5. Аж ахуйн нэгж болон төрийн бус байгуулага, иргэдийн хандив, тусламж.

Найм. Хөтөлбөрийн шалгуур, үзүүлэлт

13. Хөтөлбөрийн үр дүнг үнэлэхдээ дараахь шалгуурыг ашиглана:

13.1. Үндэсний түвшинд зайны сургалтын тогтолцоо бүрдэж, боловсон хүчний нөөцтэй болсон байдал;

13.2. Мэдээлэл, харилцаа, холбооны шинэ технологийг боловсролын байгууллагуудад нэвтрүүлсэн байдал;

13.3. Багш болон бусад боловсон хүчний мэргэшил дээшлүүлэх, давтан бэлтгэх зайны сургалтын тогтолцоо бүрдсэн байдал;

13.4. Ерөнхий боловсролын сургуульд зориулсан зайны сургалтын нэмэлт хөтөлбөр боловсруулсан байдал;

13.5. Ерөнхий боловсрол, их сургууль, коллежийн оюутан, сурагчдад зориулсан Англи хэлний болон тэдгээрийн сонирхол, хэрэгцээ, зах зээлийн шаардлагад нийцсэн зайны сургалтын сүлжээ бүрдүүлсэн байдал;

13.6. Албан болон албан бус боловсролын хүртээмж, чанар, үр ашгийг нэмэгдүүлэхэд үзүүлсэн нөлөө, зайны сургалтын үйл ажиллагааны үр дүн;

13.7. Зайны сургалтад хувийн хэвшил болон мэргэжлийн байгууллагын сонирхол, оролцоог нэмэгдүүлсэн байдал.

14. Хөтөлбөрийн үр дүнг хэмжих үзүүлэлт:

14.1. Багш нарын 60 хувийн мэргэжлийг зайны сургалтаар дээшлүүлдэг болсон байх;

14.2. Сургуулийн өмнөх насны хөдөөгийн хүүхдийн 35-аас доошгүй хувийг гэр бүлд түшиглэсэн зайны сургалтаар сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж сургуульд бэлтгэдэг болсон байх;

14.3. Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвийн үйл ажиллагааг тогтмолжуулсан байх;

14.4. Аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төвийг 2004 он гэхэд зайны сургалтын техник, тоног төхөөрөмжөөр хангаж, орон нутагт зайны сургалт явуулах боломж бүрдүүлсэн байх;

14.5. Ерөнхий боловсролын сургуульд зориулсан Англи хэлний зайны сургалтын нэмэлт хөтөлбөрийг боловсруулж мөрдсөн байх.

Ес. Бусад

15.1. Зайны сургалтын хөтөлбөрийн зорилт, үйл ажиллагаа бүрт үр дүнг үнэлэх шалгуур, хүрэх түвшинг жил бүрийн эхэнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам боловсруулж мөрдөнө.

15.2. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан Засгийн газарт тайлагнана.

ЗАЙНЫ СУРГАЛТЫН ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ
(2002-2003)

№	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцан гүйцэтгэх байгууллага
1	Зайны сургалтын бодлогын зохицуулалт, менежментийн тогтолцоог бий болгох	1.1. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат бусад яам, агентлаг, хувийн хэвшил, төрийн бус байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран хэрэгжүүлэх чиглэл, төлөвлөгөөг жил бүр гаргаж, үр дүнг тооцож ажиллах	2002-2003	БСШУЯ, холбогдох яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
		1.2. Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төвийг байгуулж ажиллуулах	2002 I улирал	БСШУЯ
		1.3. Зайны сургалтын салбарт хөрөнгө оруулах чиглэлээр туршлага хуримтлуулсан хандивлагч орон, олон улсын байгууллагыг судалж, төсөл боловсруулж, санал тавих	2002-2003	БСШУЯ, СЭЗЯ
		1.4. Зайны сургалтын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шалгуур, үзүүлэлтийг боловсруулан хэрэгжүүлэх	оны эхэнд	БСШУЯ
		1.5. Зайны сургалтын мэдээллийн сан бүрдүүлж, мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх	2002-2003	БСШУЯ
2	Зайны сургалтын үйлчилгээ, үйл ажиллагааны механизм бүрдүүлэх	2.1. Зайны сургалтын бодлогын болон орон нутгийн зөвлөлийг байгуулж ажиллуулах	2002 I-Ш улирал	БСШУЯ,аймаг, нийслэлийн Засаг дарга
		2.2. Эрүүл мэнд, экологи, эрх зүй, эдийн засаг, гэр бүлийн боловсрол болон хүүхэд, залуучуудыг ажилд сургах, амьдралд бэлтгэх зайны сургалтын хэрэгцээг үе шаттайгаар судлах	2002-2003	БСШУЯ, ЭМЯ, БОЯ, ХЗДХЯ, СЭЗЯ, холбогдох яамд
		2.3. Бүх нийтийн боловсролын төрөл, чиглэл бүрээр төслийн баг байгуулах санаачилгыг дэмжин үйл ажиллагаат тогтмолжуулах	2002-2003	БСШУЯ, ЭМЯ, БОЯ, ХЗДХЯ, СЭЗЯ, холбогдох яамд
		2.4. Бүх нийтийн боловсролын асуудлаар зайны сургалтыг зохион байгуулах, зөвлөлгөө өгөх арга зүйг мэргэжлийн байгууллага, төслийн багийн оролцоотойгоор боловсруулж хэрэгжүүлэх	2002-2003	БСШУЯ,ЭМЯ, холбогдох яамд
		2.5. Нутаг дэвсгэрийн түвшинд зайны сургалтын үйлчилгээг бүх шатны боловсролын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх	2002-2003	БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга нар
		2.6. Зайны сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, түгээх тогтолцоо бий болгох	2003	БСШУЯ, холбогдох яамд
3	Зайны сургалтын мэргэжилтэн бэлтгэх, хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх	3.1. Зайны сургалт явуулах байгууллагуудын хүний нөөцийн чадавхийг сайжруулах төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх	2002-2003	БСШУЯ, холбогдох яам, агентлаг
		3.2. Өндөр хөгжилтэй оронд зайны сургалтын үндэсний	2002-2003	БСШУЯ, холбогдох яамд

ТЕРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он, №15 (249)

		боловсон хүчин бэлтгэх асуудлыг судалж, хэрэгжүүлж эхлэх		
		3.3. Зайны сургалтыг хөнгжүүлэх чиглэлээр олон улсын тусламж авах, төсөл хэрэгжүүлэх, тэдгээртэй хамтран ажиллах үйл ажиллагаат дэмжин өргөжүүлэх	2002-2003	БСШУЯ, холбогдох яам, агентлаг
		3.4. Зайны сургалтын мэргэжилтэн бэлтгэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх богино хугацааны сургалтыг зохион байгуулах	2002-2003	БСШУЯ, мэргэжлийн байгууллагууд
		3.5. Зайны сургалтын чиглэлээр үндэсний түвшний сургалт семинар зохион байгуулах	2002-2003	БСШУЯ, холбогдох яам, агентлаг
		3.6. Зайны сургалтын чиглэлээр зохиогдох олон улсын хурал, сургалт, семинарт зайн сургалтын багш нарыг оролцуулах	2002-2003	БСШУЯ, холбогдох яам, агентлаг
4	Зайны сургалтын хүртээмжтэй, чанартай, үр ашигтай мэдээлэл, техникийн орчин бий болгох	4.1. Албан бус боловсрол, зайны сургалтын өнөөгийн байдалд судалгаа хийж, дүгнэлт гарган, гарсан үр дүнг цаашдын үйл ажиллагаанд төлөвлөгөөнд тусган ажиллах	2002-2003	БСШУЯ, холбогдох яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
		4.2. Радио, телевизийн нэвтрүүлгийн программд албан бус боловсрол, зайны сургалтын тусгай цагтай болох	2002	БСШУЯ, РТХЭГ
		4.3. Зайны сургалтын хэвлэмэл болон аудио, видео материал, телевизийн хичээл бэлтгэн нэвтрүүлэх	2002-2003	БСШУЯ, мэргэжлийн байгууллагууд, сонирхлын бүлгүүд
		4.4. Зайны сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилт, шаардагдах хөрөнгийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгах	2002-2003	БСШУЯ, СЭЗЯ
5	Зайны сургалтын оновчтой хэлбэрийг сонгон, агуулга, арга зүйг боловсруулж, хэрэгжүүлэх	5.1. Хүн амын боловсролын хэрэгцээг судалж, зайнаас явуулах сургалтын агуулга, арга зүйг тогтоох	2002	БСШУЯ, холбогдох яамд, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар
		5.2. Зайны сургалтад орчин үеийн мэдээлэл, харилцааны технологи нэвтрүүлэх, сургалтын аудио, видео мэдээллийн хэрэгслийн тохиромжтой хослол бий болгох бэлтгэл хангах	2002-2003	ЗГХЭГ, БСШУЯ, РТХЭГ, холбогдох яам, агентлаг, сонирхлын бүлгүүд
		5.3. Цэцэрлэгт хамрагдах боломжгүй хүүхдийг гэр бүлд түшиглэн хөгжүүлэх, сургуульд бэлтгэх зорилгоор тэдний эцэг, эхэд зориулан явуулах зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх	2002-2003	БСШУЯ
		5.4. Бүх шатны боловсролын байгууллагын суралцагч болон иргэдэд зориулсан Англи хэлний зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх	2002-2003	БСШУЯ, мэргэжлийн байгууллагууд
		5.5. Багш болон боловсролын удирдах ажилтныг давтан бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх зайны сургалтын агуулга, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх	2002-2003	БСШУЯ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 15 | Улаанбаатар хот

Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулах, дүрэм батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 5.1.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хороог байгуулж, дүрмийг хавсралт ёсоор батлсугай.

2. Харилцаа холбооны зохицуулах хорооны болон ажлын албаны орон тоо, цалингийн сан, төсвийг батлаж, харилцаа холбооны байгууллагуудын бүтцийг Харилцаа холбооны тухай хуулийн дагуу шинэчлэн зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид,Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт тус тус даалгасугай.

3. Дэд бүтцийн улсын хяналтын албаны Долгион хүлээн авах, хянах станцын барилга байгууламж, тоног төхөөрөмж, эд хөрөнгийг ажиллагсдын хамт Харилцаа холбооны зохицуулах хороонд шилжүүлсүгэй.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1996 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 99 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2002 оны 15 дугаар тогтоолын хавсралт

ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид "Хороо" гэнэ/ нь өмчийн бүх төрлийн аж ахуйн нэгж, иргэн харилцаа холбооны зах зээлд үр ашигтай, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, тусгай зөвшөөрөл олгох, мэргэжлийн дүгнэлт, зөвлөмж, шийдвэр гаргах үүрэг бүхий байгууллага мөн.

2. Харилцаа холбооны зохицуулах хорооны үндсэн зорилго нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, харилцаа холбооны талаар төрөөс бариматлж байгаа бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, түүнийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, радио давтамжийн зурвасыг хуваарилах, дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, үйлчлэгч, хэрэглэгчийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах, үйлчлэгчийн шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

3. Хороо нь үйл ажиллагаандаа Харилцаа холбооны болон Радио долгионы тухай хууль, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

4. Хороо нь зохих журмын дагуу хийгдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

5. Хороо нь нийслэлд байрлах бөгөөд орон нутагт салбар зөвлөлтэй байж болно.

Хоёр. Хорооны удирдлага, зохион байгуулалт

6. Хороог Харилцаа холбооны тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгуулна.

7. Хорооны өдөр тутмын үйл ажиллагаог Хорооны даргаар удирдуулсан Зохицуулалтын; Радио давтамж зохицуулалт, хяналтын; Зах зээл, үнэ тарифын; Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба гүйцэтгэнэ.

8. Хорооны дарга дараахь бүрэн эрхтэй байна:

1/хорооны үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр гаргах, хэрэгжүүлэх;

2/хорооны хуралдааныг товлох, хэлэлцэх асуудлыг тогтоож хуралдааныг даргалах;

3/хороог итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

4/ажлын албаны ажилтныг томилох, чөлөөлөх, тэдгээрт хариуцлага хүлээлгэх, цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоож хөдөлмөрийн гэрээ байгуулах;

5/хорооны дотоод асуудлыг дангаар шийдвэрлэж тушаал гаргах;

6/шаардлагатай бол дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ хийлгэх зорилгоор гадаад, дотоодын шинжлэх ухааны байгууллага, эрдэм шинжилгээний ажилтан, мэргэжилтнийг гэрээний үндсэн дээр татан оролцуулах, тэдгээрт цалин, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

7/хорооны ажилтнуудын мэргэшлийг дээшлүүлж, давтан сургах, тэдгээрийн ниигмийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ авах;

8/бүрэн эрхээ хорооны аль нэг гишүүнд шилжүүлэх;

9/тусгай зөвшөөрөлд гарын үсэг зурж баталгаажуулах;

10/батлагдсан төсвийг захиран зарцуулах;

11/хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрх.

Гурав. Хорооны хуралдаан

9. Хорооны үйл ажиллагаа явуулах үндсэн хэлбэр нь хорооны хуралдаан байна. Хорооны гишүүдийн дийлэнх олонхи оролцсоноор хуралдаан хүчин төгөлдөр болно.

10. Хорооны хуралдааныг дараахь асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

1/харилцаа холбооны талаар боловсруулж байгаа бодлогын асуудалд өгөх санал;

2/харилцаа холбооны талаар баримталж байгаа бодлогын хүрээнд тусгай зөвшөөрөл олгох, түтгэлзүүлэх, хүчингүй болгох, сэргээх асуудал;

3/харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөөнийг дэмжих, дангаар нөёрхолыг хязгаарлахтай холбоотой асуудал;

4/харилцаа холбооны салбарын зохицуулалтын асуудлаар баримтлах хөтөлбөр, холбогдох дүрэм, журмын төсөл;

5/хорооны төсвийн төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайлан;

6/хөрөнгө шилжүүлэх, худалдан авах, данснаас хасах асуудал;

7/ажлын албад болон салбар зөвлөлийн ажилтах журам, албадын даргыг томилох, чөлөөлөх, тэдгээрийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх.

11. Хороо нь өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар дүрэм, журам болон хорооны хуралдааны дэгийг батлах, биелэлтэд нь хяналт тавьж ажиллана.

12. Хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд хуралдааны явцад тэмдэглэл хөтөлнө.

13. Хорооны тогтоолд хорооны дарга, гишүүд, хуралдааны тэмдэглэлд хорооны дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

14. Хорооноос гарсан шийдвэрийг холбогдох байгууллага, хуулийн этгээд дагаж мөрдөнө.

15. Хуралдааныг хэлэлцсэн асуудлыг хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ. Санал тэнцсэн тохиолдолд асуудлыг хуралдаан даргалагчийн саналаар шийдвэрлэнэ.

16. Хороо нь сард нэгээс доошгүй удаа хуралдана. Шаардлагатай тохиолдолд хорооны дарга ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

17. Хорооны дарга, гишүүдийг дараахь тохиолдолд үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

1/томилогдсон хугацаа дууссан;

2/өөрөө хүсэлт гаргасан;

3/эрүүл мэндийн хувьд цаашид ажиллах боломжгүй болсон нь эрүүл мэндийн байгууллагаар тогтоогдсон;

4/хорооны тухайн жилийн хуралдааны 50-иас илүү хувийг тасалсан;

5/хууль тогтоомж зөрчсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон.

18. Хугацаа дуусахаас өмнө үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн хорооны дарга, гишүүдийн оронд шинээр гишүүн томилохдоо өмнөх дарга, гишүүний үлдсэн хугацаагаар томилно.

19. Шийдвэр гаргахдаа хорооны дарга, гишүүд аль нэг талын болон хувийн ашиг сонирхолын үүднээс хандахгүй байх зарчмыг баримтална.

20. Хорооны хуралдааныг асуудал хэлэлцүүлэхэд холбогдох албан тушаалтнаас гадна шаардлагатай бол төрийн бус байгууллагын төлөөлөгч, иргэдийг байлцуулж болно.

Дөрөв. Хорооны ажлын алба

21. Хорооны ажлын албадын дарга нь тухайн чиглэлээр мэргэшсэн, харилцаа холбооны салбарт 5-аас доошгүй жил ажилласан байна.

22. Албадын дарга нь хариуцсан ажлаа Хорооны даргад үлирал тутам тайлагнана.

23. Зохицуулалтын алба дараахь эрх, үүрэгтэй байна:

1/зах зээлийг либерапчлах талаар баримталж байгаа бодлогын хүрээнд үйлчилгээ эрхлэхийг хүссэн үйлчлэгчид тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох талаар санал дүгнэлт гаргах, тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагыг биелүүлэх гэрээ байгуулах;

2/тусгай зөвшөөрөл үзэмшигчийн үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх, тэдний үйл ажиллагааны талаархи баримт материалыг хадгалах, баяжуулах;

3/сүлжээ хоорондын харилцан холболт хийх гэрээний ерөнхий нөхцөл, шаардлага, заагласан цэгийг тогтоох, гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавих;

4/харилцаа холбооны салбарт шинээр гарсан олон улсын стандарт, зөвлөмжийг судлан үндэсний стандарт, зөвлөмж боловсруулж эрх бүхий байгууллагаар батлуулан, хэрэгжилтэд хяналт тавих;

5/олон улсын байгууллагын стандарт боловсруулах судалгааны хэсэгт өөрийн мэргэжилтнийг оролцуулах, ажлын болон судалгааны хэсэг ажиллуулах;

6/дэлхийн улс орнуудын болон өөрийн орны дугаарлалтын төлөв байдалд судалгаа хийж үндэсний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулан хэрэжүүлэх;

7/тусгай зөвшөөрөл үзэмшигч үндэсний дугаарлалтын нэгдсэн төлөвлөгөөг хэрэзн мердэж байгааг хянан зохицуулах;

8/харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжийн техникийн нөхцөл, шаардлагыг тогтоох, баталгаажуулах;

9/шаардлагатай тохиолдолд харилцаа холбооны сүлжээний болон хэрэглэгчийн тоног төхөөрөмжид дотоод, гадаадын байгууллагаар баталгаажуулалт хийлгэх.

24. Радио давтамж зохицуулалт, хяналтын алба нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл үзэмшихэд тавих шаардлагыг тогтоож хэрэгжилтийг хянах;

2/радио төхөөрөмжийн баталгаажуулалтын техникийн нөхцөлийг тогтоох, судалгаа шинжилгээ хийх;

3/радио давтамжийн хуваарилалтын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх;

4/тусгай хэрэглээний ангиланд ашиглагдах радио давтамжийн зурвасын хэрэгцээ, шаардлагыг холбогдох байгууллагатай хамтран судалж тодорхойлох;

5/радио төхөөрөмж, радио давтамжийн ашиглалтын эрэлт хэрэгцээний судалгаа хийх, радио долгионы тархалт, цахилгаан соронзон зохицолдоо, түүнийг тооцоолох аргачлал, судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулах;

6/радио давтамжийн зурвасыг Үндэсний радио давтамжийн хуваарийн хүснэгтийн дагуу хуваарилах;

7/Харилцаа холбооны тухай хуулийн 9.1.10-т, Радио долгионы тухай хуулийн 20 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх зорилгоор дор дурдсан хяналт шалгалтыг явуулна:

а/радио хэрэгслийн давтамжийн тархац, цацралт, байршлыг тодорхойлох, шинжилгээ хийх, техникийн болон ашиглалтын стандарт, нормын шаардлагад нийцэж байгаа хянах, тогтоох;

б/олон улсын радио долгионы хяналтад оролцох;

в/радио долгион ашиглагчдын эрх ашгийг хамгаалах зорилгоор хууль бус хэрэглэгчдийг илрүүлэх, үйл ажиллагааг нь зогсоох санал тавих, импортоор оруулж байгаа радио төхөөрөмж олон улсын болон үндэсний стандартад нийцэж байгаа эсэхэд хэмжилт шалгалт хийх;

г/радио долгионы тархалт нь хууль тогтоомж, эрх бүхий байгууллагын шийдвэрийг зөрчиж, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй болон зөвшөөрөлтэй зөрчиж байгаа нөхцөл зорилгоор радио төхөөрөмжийн эх үүсвэрээс гарч буй чимээ шуугианы бичлэг хийж, судалгаа, шинжилгээ, үнэлэлт, дүгнэлт гаргах;

д/хэрэглэгчийн гомдлын дагуу хэмжилт хийж зохицуулах.

25. Зах зээл, үнэ тарифын алба нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/харилцаа холбооны зах зээл дэх өрсөлдөөний байдал, хандлагад судалгаа шинжилгээ хийх;

2/зах зээлийн эрэлт хэрэгцээг тодорхойлох, шинээр гарч байгаа техник, технологийг судалж мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

3/харилцан холболтын хөлс тогтоох аргачлал, орлого хуваарилах журам боловсруулах;

4/харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа компануудын харилцан холболтын хөлс, орлогын хэмжээнд судалгаа шинжилгээ хийж үнэлэлт өгөх, дүгнэлт гаргах;

5/тусгай зөвшөөрөл үзэмшигчээс шаардлагатай мэдээллийг гаргуулах;

6/харилцаа холбооны үйлчилгээний тариф тогтоох аргачлал боловсруулж, зах зээлд давамгайлж байгаа үйлчилгээний тарифыг хянаж, зохицуулах санал боловсруулах;

7/харилцаа холбооны үйлчилгээ эрхэлж байгаа үйлчлэгчийн үйлчилгээний үнэ тарифын хэмжээнд судалгаа шинжилгээ хийх;

8/тусгай зөвшөөрөл үзэмшигчээс

олон улсын жишиг нийцсэн аргачлал, журмын дагуу үйл ажиллагааныхаа зардлыг тодорхойлох, бүртгэх шаардлага тавих;

9/бүх нийтийн үйлчилгээний үүргийн хэрэгжилтийг хангуулах арга хэмжээ авах.

26. Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/хорооноос гарах шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлж эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

2/тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын биелэлт, техникийн ашиглалт үйлчилгээ, технологийн горимын мөрдөлтөд хяналт тавих;

3/тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд үүссэн маргаан болон хэрэглэгчийн эрх ашгийг хөндсөн маргаантай асуудлыг судлан шийдвэрлэх, санал боловсруулж хорооны хуралд оруулах;

4/тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний чанарт шалгалт, хэмжилт хийх, холбогдох арга хэмжээ авах;

5/харилцаа холбооны асуудлаар хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах болон төрийн бус бусад байгууллагатай хамтран ажиллах;

6/хорооны шийдвэр, харилцаа холбооны салбарын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, салбарын хөгжлийн талаар тогтмол сурталчлах;

7/тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар дотоод мэдээллийн сан бий болгох, холбогдох байгууллагыг мэдээллээр хангах;

8/хорооны жилийн төсвийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулах, төсвийг бүрдүүлж хяналт тавих, гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг хорооны хуралдаанд оруулах;

9/нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан тэнцэл гарган аудитаар баталгаажуулж нийтлэх;

10/хорооны ажилтнуудыг сургалтад хамруулан мэргэшүүлэх, тэдний нийгмийн асуудлын талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх;

11/олон улсын болон бүс нутгийн цахилгаан холбоо, шуудан холбооны байгууллага, гадаад улсын ижил төрлийн байгууллагатай хамтран ажиллах санал боловсруулж, тэдгээрийн туршлагыг судлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэх;

12/хорооны ажилтнуудыг олон улсын болон бүс нутгийн цахилгаан холбоо, шуудан холбооны байгууллагаас зохион байгуулж байгаа хурал зөвлөлгөөнд оролцуулах ажлыг зохион байгуулах;

13/хорооны хэмжээнд архив, бичиг хэргийг зохих дүрэм, журмын дагуу хөтлөх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 25–ны өдөр Дугаар 16 **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөвсгөл аймгийн Цагаан-Уул сумын 10 жилийн дунд сургуулийн хичээлийн болон дотуур байрны халаалтын шугам сүлжээг засварлах, шинээр тавих, Төмөрбулаг сумын сургуулийн дотуур байранд халаалт тавих, Шинэ-Идэр сумын сургуулийн уурын халаалтын асуудлыг шийдвэрлэх, Цэцэрлэг сумын төвийн иргэдийн үндны усны зөөвөрт ашиглах "ЗИЛ-130" маркийн автомашин худалдаж авах хөрөнгийн төсвийг хянаж батлан Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Их-Уул, Эрдэнэбулган, Тосонцэнгэл сумдын өвөлжилтийн байдалтай холбогдуулан тус сумдын иргэд, малчдад эмнэлгийн болон бусад тусламж, үйлчилгээ үзүүлэхэд зориулж "УАЗ-фургон" машин тус бүр нэгийг улсын нөөцөөс гаргаж, энэ оны П улиралд багтаан нөхөн бүрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Дугаар 17 Улаанбаатар хот

"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", "Улсын тэргүүний тариаланч" шалгаруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын шаардлага хангаж өндөр амжилт гаргасан:

-Төв аймгийн Эрдэнэсант сумын 4 дүгээр багийн малчин Дамбадаржаагийн Гомбодаш;

-Дундговь аймгийн Сайнцагаан сумын 2 дугаар багийн малчин Шаравжамцын Нармандах;

-Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Рашаант багийн малчин Гомбодоржийн Сампил;

-Хөвсгөл аймгийн Их-Уул сумын Их-Уул багийн малчин Нааванбазарын Жүгдэр;

-Өвөрхангай аймгийн Бүрд сумын 1 дүгээр багийн малчин Лувсанчүлтэмийн Чимиддорж;

-Ховд аймгийн Чандмань сумын Баянхайрхан багийн малчин Базардарамын Содномжанцан;

-Ховд аймгийн Булган сумын Баянсудал багийн малчин Хумаарын Таутек;

-Говь-Алтай аймгийн Жаргалан сумын Бүрэн багийн малчин Даржаагийн Дорждэрэм;

-Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын Гуулин багийн малчин Сумьяагийн Рагчаа;

-Завхан аймгийн Сантмаргац сумын Баяндавс багийн малчин Идэрийн Дүүрэн;

-Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 2 дугаар багийн малчин Дакейний Аххаз;

-Баян-Өлгий аймгийн Буянт сумын Хөх-Эрэг багийн малчин Оожооны Галдан;

-Архангай аймгийн Хайрхан сумын Асгат багийн малчин Отгоны Дорж;

-Архангай аймгийн Батцэнгэл сумын Баян-Уул багийн малчин Түндэвийн Бальдиржанцан;

-Булган аймгийн Орхон сумын 2 дугаар багийн малчин Лхагваагийн Гүндсамбуу;

-Баянхонгор аймгийн Баянлиг сумын 3 дугаар багийн малчин Чимбэгийн Сугар-Очир;

-Булган аймгийн Гурванбулаг сумын Хөгнө багийн малчин Жүгдэрдэмидийн Бат-Эрдэнэ;

-Дархан-Уул аймгийн Орхон сумын 2 дугаар багийн малчин Дүнгэгийн Пунцаг;

-Увс аймгийн Ховд сумын Шивэр багийн малчин Дашцэрэнгийн Балжинням;

-Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Баян багийн малчин Ламжавын Бат-Өлзий нарыг "Улсын сайн малчин"-аар.

2. Булган аймгийн Орхон сумын "Халиун тариа" ХХК, Сэлэнгэ аймгийн Сайхан сумын "Ургацын ундраа" ХХК, Булган аймгийн Орхон сумын "Орхонмандал" ХХК, Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын "Энхбулган" ХХК, Дархан-Уул аймгийн Үргамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн төмсний бригадыг "Улсын тэргүүний тариаланч хамт олон"-оор.

3. Дорноговь аймгийн Мандах сумын ногоочин Ёндонгийн Эрдэнээ, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын ногоочин Апахайн Рахадыл, Дархан-Уул аймгийн Орхон сумын ногоочин Очирын Бадарч, Сэлэнгэ аймгийн Шаамар сумын ногоочин Дамаагийн Гантөмөр нарыг "Улсын тэргүүний тариаланч"-аар тус тус шалгаруулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр | Дугаар 19 | Улаанбаатар хот

Улсын эталон батлах тухай

Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв дэх тогтмол гүйдлийн эталон эсэргүүцлийн ороомгийг тогтмол гүйдлийн эсэргүүцлийн хэмжлийн нэгжийн, эталон ачаат бүлүүрт манометрийг даралтын хэмжлийн нэгжийн улсын эталоноор тус тус баталсугай.

2. Улсын эталоныг олон улсын болон гадаад орны холбогдох эталонтой харьцуулан дүйлгэж баталгаажуулж байхыг Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга Ж.Хүрэлсүхэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр | Дугаар 20 | Улаанбаатар хот

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Олон улсын байгууллагуудын татвар, хандивын тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "49.Дэлхийн хөрөнгө оруулалтыг дэмжих агентлагуудын холбоо" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 13 (250)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Хөтөлбөр батлах тухай*
- *Дүрэм шинэчлэн батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *2002 оныг "Хөрөнгө оруулалтыг дэмжих жил" болгох тухай*
- *2002 оныг Оюутны жил болгох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны дөрөвдүгээр сарын 5 №13 (250)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

133. Хөтөлбөр батлах тухай Дугаар 34 549
134. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 38 558
135. Дүрэм шинэчлэн батлах тухай Дугаар 39 558

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

136. 2002 оныг "Хөрөнгө оруулалтыг дэмжих жил" болгох тухай Дугаар 21 561
137. Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын дүнгийн тухай Дугаар 22 565
138. Орон сууц хувьчлах тухай Дугаар 23 566
139. 2002 оныг Оюутны жил болгох тухай Дугаар 24 566
140. 2002 оны улсын төсвийн орлого хуваарилалтын хувийг тогтоох тухай Дугаар 25 571
141. Эрүүл мэндийн даатгалын 2002 оны хураамжийн хэмжээ, даатгалтай иргэний эмчилгээний зардлын дээд хязгаарыг тогтоох тухай Дугаар 26 572

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 34 Улаанбаатар хот

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн 2001 оны 12 дугаар зөвлөмжийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. "Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг хавсралтын ёсоор батлаж, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулж, явц, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.

2. "Цэргийн байгуулалтыг 2005 оны хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг "Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль"-д нийцүүлэн нийтлэхийг ҮАБЗ-ийн нарийн бичгийн дарга (Р. Болд)-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2002 оны 34 дүгээр зарлигийн хавсралт

ЦЭРГИЙН БАЙГУУЛАЛТЫГ 2005 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР

Нэг.Хөтөлбөрийн үндэслэл

Цэргийн шинэчлэлийн үндэсн зорилго нь цомхон, чадварлаг, мэргэжлийн чиг баримжаатай эзвэсэгт хүчинтэй болох явдал мөн.

Цэргийн шинэчлэл нь цэргийн байгуулагдуудыг улс төрийн шинэ тогтолцоонд нийцсэн өөрийгөө хамгаалах эзвсэгт хүчин болгон өөрчлөх, цаашид түүнийг мэргэжлийн чиг хандлагаар хөгжүүлэх цогц арга хэмжээг агуулж байна. Батлан хамгаалах бодлогын нэгдмэл, залгамж чанарыг хадгалж, хэрэгжүүлэх нь цэргийн шинэчлэлийн тогтвортой байдлыг хангах нөхцөл юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 1997 онд батлагдсан «Цэргийн шинэчлэлийн бодлого» баримт бичигт дэвшүүлсэн зорилтын нэлээд хэсэг биелж, цомхон эзвсэгт хүчин болгон шинэчлэх нөхцөл бүрдүүлэх чиглэлд зарим практик алхам хийгдсэн.

«Төрийн цэргийн бодлогын үндэс»-т дэвшүүлсэн цэргийн шинэчлэлийг анги, салбарт хүргэж, эзвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг бэхжүүлэн, чадварлаг эзвсэгт хүчинтэй болох үндэсн нөхцлийг хангах тулгамдсан зорилтыг шийдвэрлэх «Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр»-ийг боловсруулах чиглэлийг Монгол Улсын Ерөнхийлөгч өгсөн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн өгсөн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн «Батлан хамгаалах тогтолцоо, цэргийн шинэчлэлийн бодлогыг Төрийн цэргийн бодлогын дагуу туушгай хэрэгжүүлж... Цэргийн байгуулалтыг бодисронгуй болгож, шинэчлэлийг гүнзгийрүүлж, цэргийн чадавхийг дээшлүүлнэ» гэсэн зорилтын хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2000 оны 157 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг;

-Батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгуллагууд, аж ахуйн нэгж, тэдгээрийн удирдлагаас хуулиар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх механизм бүрдээгүй,

-орон нутгийн хамгаалалтын эрх зүйн үндсийг тодорхойлох, бүрдүүлж хэрэгжүүлэх үйл явц удаашралтай, иргэдийг үндэсний эх оронч, цэргийн үүргээ хүндэтгэн биелүүлэх үзлээр хүмүүжүүлэхэд чиглэгдсэн сурталчилгаа, хүмүүжлийн ажлын тогтолцоо бий болоогүй, цэргийн насны залуучуудын боловсрол, эрүүл мэндийн байдал доройтож байгаа,

-Эзвсэгт хүчний бие бүрэлдэхүүн 1989 онтой харьцуулахад 2.5 дахин, нэгтгэл, ангиудын тоо 20 гаруй хувиар багассан боловч батлан хамгаалах төсвийг оновчтой ашиглах асуудал шийдвэрлэгдээгүй, цэргийн албан хаагчдын нийгмийн зарим асуудлууд өнөөгийн шаардлагаас хоцорсон хэвээр байгаа,

-тайван цагийн орон тоо, зохион байгуулалтаараа олон талт үүрэг гүйцэтгэх чадвартай мэргэжлийн өндөр бэлтгэл бүхий бие бүрэлдэхүүний эзлэх хувийн жин Эзвсэгт хүчинд харьцангуй бага,

-Эзвсэгт хүчин, Хилийн цэргийн эзвсэглэл, техникийн зарим хэсгийнх нь эдэлгээний хугацаа дууссан, хөрөнгө санхүүгийн хязгаарлагдмал боломжоос шалтгаалан тэдгээрийн инженхэдэ технологийн горимын дагуу техникийн үйлчилгээ, сэргээн сайжруулалт хийгээгүй,

-иргэний хамгаалалтын хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх, суурийн жилүүдэд улс оронд тохиолдсон байгалийн гамшиг, ган, зуд, үер, түймрийн аюул болон хүн, малын халдварт өвчин тархсан сургамжаас үүдэн байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх бэлэн байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх, ялангуяа гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор хөнөөл, үр дагаварт тэмцэх менежментийг боловсронгуй болгох шаардлага хурцаар тавигдаж байгаа,

-бусад улсаас батлан хамгаалах салбарт үзүүлэх бүцалтгүй туслэмжийн ашиглалтыг тодорхой зорилго, чиглэлтэй болгон, Эзвсэгт хүчний анги, салбарыг энхийг сахиулах үйл ажиллагаанд бэлтгэх, цэргийн албан хаагчдын ахуй нөхцөл, орон сууцны хангамжийг дээшлүүлэх, хил хамгаалалтын холбоог шинэчлэхэд ашиглаж, туслэмжийн үр ашгийг дээшлүүлэх нь чухал байгаад дүгнэлт хийж, боловсруулсан «Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр (цаашид «Хөтөлбөр» гэх)»-ийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн сайшааж, Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлд өргөн мэдүүлсэн юм.

Үндэсний аюулгүй байдлын Зөвлөлийн хуралдаанаас эзвсэгт хүчнийг чадваржуулах, мэргэжлийн чиг баримжаатай болгох тулгамдсан зорилтыг шийдвэрлэх эдийн засгийн боломж, нөхцлийг бүрдүүлэхийн чухлыг тэмдэглэж, гаргасан санал, өгсөн чиглэлийг Хөтөлбөрт тусгав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилтууд

Цэргийн байгуулалтыг 2005 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөрийн зорилго нь цэргийн шинэчлэлийг анги, салбарт хүргэж, эзвсэгт хүчинд тавих иргэний хяналтыг бэхжүүлэн, чадварлаг эзвсэгт хүчинтэй болох үндэсн нөхцлийг хангахад оршино.

Энэхүү зорилгын хүрээнд дараахь үндэсн зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлнэ. Үүнд:

1.Зэвсэгт хүчин, бусад цэргийн байгууламтыг боловсронгуй болгох;

2.Зэвсэгт хүчин, хилийн цэргийн зэвсэглэл, техникийг хэсэгчлэн сэргээн сайжруулах, шинэчлэх;

3.Цэргийн албан хаагчдын нийгмийн нөхцлийг сайжруулах;

4.Орон нутгийн хамгаалалтын эрх зүйн үндсийг тодорхойлон бүрдүүлэх;

5.Иргэний хамгаалалтын тогтолцоо, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, байгалийн гамшиг, осолтой төмцэх хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх;

6.Зах зээлийн эдийн засгийн харилцаанд зохицон нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог бий болгох;

7. Батлан хамгаалахын шинжилгээ, судалгааны чадавхийг нэмэгдүүлэх;

8. Иргэдийн эх орноо батлан хамгаалах бэлтгэл, эрүүл мэндийг дээшлүүлэх, тэдэнд үндэсний эх оронч хүмүүжил олгох тогтолцоог төлөвшүүлэх;

9.Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэх;

10.Цэргийн байгуулалтын цаашдын тогвортой хөгжлийг хангах.

Гурав. Хөтөлбөрийн үндсэн зорилтыг хэрэгжүүлэх хугацаа, хангах нийтлэг арга хэмжээний чиглэл, гарах үр дүн

Хөтөлбөрийг 2002 оноос эхлэн 2005 оныг дуусталх хугацаанд хоёр үе шаттай хэрэгжүүлнэ.

Нэгдүгээр үе шат 2002 оныг хамарна. Энэ үе шатанд:

3.1.Зэвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалтыг боловсронгуй болгох.

3.1.1.Зэвсэгт хүчний нэгттэл, ангиудын тайван цагийн бүтэц, зохион байгуулалтыг цаашид цомхон, боловсронгуй болгох зорилгоор:

а/Зэвсэгт хүчний бүх нэгттэлийн зэрэглэлийг шинэчлэн тогтоож, ангийн зэрэглэлд шилжүүлэх бэлтгэлийг хангана.

б/Зэвсэгт хүчний дараах анги, байгууллагыг зориулалт, чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалтын ижил, төстэй байдлаар нь нэгттэж, ангийн зэрэглэлд шилжүүлнэ

д/Гүйцэтгэж буй чиг үүргийнх нь дагуу Зэвсэгт хүчний 247 дугаар ангийг төсвийн хамт Гал түймэртэй төмцөх газарт шилжүүлэх,

3.1.2. Мэргэжлийн анги, салбарыг шинээр бий болгох зорилт

б/НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох бэлтгэлтэй салбарын тоог нэгээр нэмэгдүүлнэ.

Гарах үр дүн

- Ангиудын тоо 16-аар хорогдож, нэгттэл, ангиудын орон тоо дунджаар 35.2 хувиар хямдарна, чиг үүргийн давхардал багасч, гүйцэтгэх чиг үүрэг нь нягтарна.

- Офицер, ахлагч, албан хаагчдын тоо 830, хугацаат цэргийн албан хаагчид 1100-аар тус тус багасаж, 2-3 цэргийн хотхон, 100 гаруй барилга, байгууламж суларч, аж ахүйн болон барилга байгууламжийн ашиглалтанд зарцуулж байгаа төсөв, хөрөнгийн хэмнэлт гарна.

-2003 оноос эхлэн Зэвсэгт хүчний төсөв 1,8 тэрбум орчим төгрөгөөр буурах боломж бүрдэнэ.

-Мэргэжлийн бэлтгэл, гүйцэтгэх чиг үүргийн хүрээнд нь алан хядах ажиллагаа, хорлон сүйтгэх бүлэгтэй тэмцэх асуудал хамаарах мэргэжлийн анги бий болно.

- Энхийг сахиулах хүчинд оролцох Зэвсэгт хүчний боломж нэмэгдэнэ

- Улсын агаарын хил, орон зайд тавих хяналт нягтарна.

3.1.3.Зэвсэгт хүчин, бусад цэргийг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах жүрмыг шинэчлэх зорилт

а/Офицерын албан тушаал бүрт мэдлэг-боловсролын, мэргэшил-ур чадварын, сэтгэл зүйбие бялдрын шалгуур үзүүлэлт тогтоон мөрдүүлж, офицерын бүрэлдэхүүнд тавих шаардлагыг мэргэжлийн цэргийн жишигт ойртуулан тэдгээрийг бэлтгэх, давтан бэлтгэх, мэдлэг мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтын тогтолцоог төгөлдөржүүлнэ.

б/Цэргийн мэргэжлийн дипломын, иргэний мэргэжлийн бакалавраас доошгүй боловсролтой хүмүүсээр офицерын бүрэлдэхүүнийг бүрдүүлэх чиг бодлогыг хэрэгжүүлнэ.

в/Ахлагчийн болон энгийн орон тоонд шилжүүлэх замаар офицеруудын албан тушаалын орон тоог цөөрүүлэх, ахлах, дунд офицерын албан тушаалын болон цолны зохистой харьцааг хянан үзэж, албан тушаалын ангилалыг шинэчлэн тогтооно.

г/Ахлагчийн цолны зэрэглэл, албан тушаалын ангилалыг шинэчлэн тогтоож, даргалах болон гүйцэтгэх албан тушаалыг зааглан мөрдүүлнэ.

д/Зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүний бүтцэд мэргэжлийн ахлагч, гэрээт цэргийн албан хаагчын эзлэх хувийг нэмэгдүүлэх үндэсэн дээр цэргийн анги, салбаруудыг мэргэжлийн цэргийн анги, байгууллагын жишигт ойртуулах бодлого боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

е/Хугацаат цэргийн албанд тэнцүүлэх шалгуур үзүүлэлтийг шинэчлэн тогтооно.

ө/Цэргийн мэргэжил зайлшгүй шаардахгүй албан тушаалуудад энгийн иргэд ажиллуулах нөхцөл, боломжийг бүрдүүлнэ.

Гарах үр дүн

-Зэвсэгт хүчнийг мэргэжлийн цэргийн чиг баримжаатай болгох зорилтод нийцсэн бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах журам бий болно.

-Зэвсэгт хүчинд байлдагч, түрүүчийн албыг иргэн сайн дураар гэрээгээр хаах албыг төлөвшүүлж, гэрээт цэргийн албан хаагчийн тоог 2005 он гэхэд хугацаат цэргийн албан хаагчдын 10 хүртэл хувьд хүргэх зорилт хэрэгжих үндэс тавигдана.

-Ахлах, дунд офицерийн цолны зохистой харьцаа бий болно.

3.1.4 Зэвсэгт хүчний тайван цагт гүйцэтгэх үүрэгтэй уялдуулан цэргийн сургалт бэлтгэлийг шинэчлэх хүрээн дэх зорилт

а/Зэвсэгт хүчин хуулиар хүлээсэн үүрэгээ биелүүлэхэд бэлэн байхад чиглүүлэн цэргийн сургалт бэлтгэлийн агуулгыг өргөтгөнө.

б/Цэргийн сургалт бэлтгэлийн нэг үндсэн чиглэлийг цэргийн албан хаагчдад байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын үед ажиллах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх дадлага, чадвар олгоход хандуулан өөрчлөнө.

в/Цэргийн сургалтын материаллаг баазыг гадаадын бүцаатгүй тусламжинд тулгуурлан дараахь чиглэлээр өргөтгөнө:

-Энхийг сахиулах хүчний сургалтын төвийг олон улсын стандартын шаардлагад хүргэнэ.

-Зарим төрлийн дууриалган үзүүлэх дадлагын хэрэгсэл/тренажёр/ ашиглан сургалт явуулах нөхцлийг анги, салбаруудад бүрдүүлнэ.

- Гурван ангийг гадаад хэлний компьютержсэн танхимтай болгоно.

г/Мэргэжлийн бэлтгэлээр бүх шатны нэгж, цэргийн албан хаагч нэг бүрийг тайван болон дайны үед ноогдсон үүргээ бүрэн гүйцэтгэх чадвар, дадлагатай болгох сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдөнө.

д/Энхийг сахиулагчдад тавигдаг шаардлагыг нийт цэргийн албан хаагчид хангасан байхад чиглэсэн сургалтын хөтөлбөр боловсруулж мөрдөнө.

е/Сургуулийн салбаруудыг хугацаат цэргийн албан хаагчид богино хугацаанды эрчимжсэн сургалтаар цэргийн мэргэжил эзэмших, эх оронч үзэл, бие бялдар-сэтгэл зүйн бэлтгэл олгох үндсэн төв болгон бэхжүүлнэ.

ё/Салбарын байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх чадавхийг байлдааны жигдрэлт, тусгай үүрэг гүйцэтгэх бэлтгэлийн түвшингээр нь үнэлж дүгнэдэг журамд шилжинэ.

ж/Цэргийн албан хаагчдыг үндэсний эх оронч үзэлтэй, сэтгэл зүй, бие бялдрын хатуужилтай, сахилга зохион байгуулалттай болгон төлөвшүүлэхэд соёл, сурталчилгаа, хүмүүжлийн ажлыг чиглүүлнэ.

Гарах үр дүн

-Сургалтын агуулгад анги, салбарыг тайван цагт гүйцэтгэх үүрэгт нь бэлтгэхэд чиглэсэн өөрчлөлт орж, хэрэгжиж эхэлнэ.

-Цэргийн сургалтын материаллаг бааз сайжирч, шинэ технологи нэвтэрч эхэлнэ.

-Цэргийн албан хаагч бүр мэргэшсэн байх шаардлагад үндэслэсэн сургалтын тогтолцоо бүрдүүлэх үндэс тавигдана.

3.1.5 Зэвсэгт хүчин, анги, салбарын байлдааны бэлэн байдлыг хангах зорилт

а/Зэвсэгт хүчний ангиудыг гамшиг, осолтой тэмцэх, авран хамгаалахад туслах, улсын хил, онц чухал объектыг хамгаалах үүрэгт томилгоожуулан байнгын бэлтгэлтэй болгох хөтөлбөр боловсруулан мөрдөж эхэлнэ.

Гарах үр дүн

Анги, салбаруудын гүйцэтгэх чиг үүрэг тухайн ангийн онцлогтой уялдан тодорхой болж, чиг үүргээ гүйцэтгэх зохион байгуулалтыг бие даан хийх боломж бүрдэнэ.

3.1.6. Цэргийн удирдлагыг боловсронгуй болгох, мэдээллийн технологийг нэвтрүүлэх

а/Цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааны стратегийг боловсронгуй болгож, ЗХЕШ-ын орон тоог хямдруулна.

б/ Тайван цагт болон болзошгүй гамшиг ослын үед анги, салбарынхаа үйл ажиллагааг удирдах, дайны үед зэвсэгт тэмцлийг төлөвлөх, зохион байгуулах, удирдан явуулах арга зүйг зэвэшүүлэхийг сургалтын нэг зорилт болгон Зэвсэгт хүчний бүх шатны штабуудыг цэргийн удирдлагын мэргэшсэн байгуулага болгон төлөвшүүлнэ.

в/Цэргийн мэргэжлийн удирдлагын компьютержсан мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах бэлтгэл ажлыг дуусгана.

г/Орон нутгийн холбоо, мэдээллийн системд Зэвсэгт хүчний холбоог холбох техник-эдийн засгийн судалгааг хийнэ.

д/Мэдээллийн аюулгүй байдлыг хангах техник-зохион байгуулалтын цогцолбор арга хэмжээг боловсруулж дуусгана.

е/Агаарын довтолгооноос хамгаалах хэрэгсэл, агаарын цагийн байдал, зарлан мэдээлэлт, удирдлагын автоматчлагдсан систем байгуулах ажлыг дуусгана.

ё/Сансрын холбоог цэргийн удирдлагад нэвтрүүлэх техник-эдийн засгийн судалгаа хийнэ.

ж/Зэвсэгт хүчин, бусад цэргийн салбар/суман/ бүрийг ажлын болон сургалтын компьютерээр бүрэн хангах ажлыг хэрэгжүүлж эхэлнэ.

Гарах үр дүн

-Цэргийн мэргэжлийн удирдлага чадваржих урьдчилсан нөхцөл бүрдэнэ.

-Цэргийн мэргэжлийн удирдах төв байгуулагын үйл ажиллагааны стратеги оновчтой тодорхойлогдон бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэнэ.

3.2.Зэвсэгт хүчин, хилийн цэргийн зэвсэглэл, техникийг хэсэгчлэн сэргээн сайжруулах, шинэчлэх.

а/Цэргийн зэвсэглэл, байлдааны техникийн хадгалалт, ашиглалтыг сайжруулах, шинэчлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

б/Хилийн цэргийн зэвсэглэлд дэвшилтэт технологи бүхий холбоо, мэдээллийн хэрэгслийг бусад улсаас батлан хамгаалах салбарт үзүүлэх буцалтгүй тусламжаар нэвтрүүлж эхэлнэ.

д/Илүүдэл болон зэвсэгглэлээс хасагдсан зэвсэгэл, техникийг борлуулах замаар хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэн:

-цэргийн албан хаагчдын хувцас, туслах тоног, хэрэгслэлийн үйлдвэр байгуулах техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулж дуусгана,

-Туулц сайтай, шинэ загварын тээврийн хэрэгсэл худалдан авч зэвсэглэлд нийлүүлж эхэлнэ,

-Авто, хуягт, танкийн болон тусгай зориулалтын техникт хэсэгчлэн сэргээн сайжруулах үйлчилгээ хийнэ,

е/Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын үед ашиглах боломж бүхий хүчин чадалтай холбоо, мэдээллийн хэрэгсэл, туулц сайтай техник бусад шаардлагатай хэрэгслүүдээр иргэний хамгаалалтын байгуулагыг хангаж эхэлнэ.

Гарах үр дүн

- Илүүдэл болон зэвсэглэлээс хасагдсан зэвсэг техникийн борлуулалтаас олох хөрөнгийг төвлөрүүлж, зэвсэглэл техникийн шинэчлэлийн зарим чиглэл, мэргэжлийн шинэ анги, салбарт зориулах боломж бүрдэнэ.

-Зарим төрлийн шинэ зэвсэглэл, техник Зэвсэгт хүчин , бусад цэргийн зэвсэглэлд нэвтэрснээр цэргийн зарим анги, салбарын тайван болон дайны цагийн үүргээ биелүүлэх чадавхи нэмэгдэнэ.

3.3. Цэргийн албан хаагчдын нийгмийн нөхцлийг сайжруулах

3.3.1. Цэргийн албан хаагчдын нийгмийн хангамжийг дээшлүүлэх

а/Радиотехник, радиолокаторын анги, салбарт ажиллаж буй офицер, ахлагч нарт тогтвор, суурьшилтай ажилласны нэмэгдэл холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох асуудлыг 2002 оны 1 дүгээр улиралаас эхлэн хэрэгжүүлнэ.

б/Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу офицер, ахлагч нарт албан ажлын онцгой нөхцлийн нэмэгдлийг олгож эхлэх асуудлыг 2002 оны эхний хагаст багтаан шийдвэрлүүлнэ.

в/Цэргийн байгууллагад ажиллагсдыг хөдөлмөрийн үр дүнгээр нь цалинжуулдаг журмыг нэвтрүүлэх арга хэмжээг авна.

г/Холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар алслагдсан орон нутагт ажиллаж буй офицер, ахлагч нарыг хүнсний ханган нормтой болгох асуудлыг шийдвэрлэнэ.

д/Цэргээс тэтгэвэрт гарч буй офицер, ахлагч нарыг иргэний мэргэжилд сургах сургалтын төгтолцоог бүрдүүлэн, 2002 оны 3 дугаар улиралаас эхлэн хэрэгжүүлнэ.

3.3.2.Орон сууцны хангамжийг дээшлүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэх

а/Цэргийн албан хаагчдыг орон сууцаар ханган бодлого боловсруулан, юуны өмнө алба хааж буй офицер, ахлагчийг албаны орон сууцаар ханган ажлын эхний ээлжийг хэрэгжүүлнэ.

б/Офицер, ахлагч нарыг амины орон сууцаар ханган хадгалах дэмжлэг үзүүлэн, хөнгөлттэй зээл тусламж олгох асуудлыг шийдвэрлэнэ.

в/Бусад улсаас батлан хамгаалах салбарт үзүүлэх буцалтгүй тусламжийг цэргийн анги, салбарын ахуй нөхцөл, орон сууцны хангалтыг дээшлүүлэхэд ашиглана. «Цэргийн орон сууц» хөтөлбөрийг шинэчлэн мөрдөнө.

3.3.3. Эрүүл мэнд, эмнэлгийн үйлчилгээг сайжруулах, нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх талаар бодлого боловсруулан хэрэгжүүлэх

а/Офицер, ахлагч нарын эрүүл мэнд, чийрэгжилтийн байдалд жилд 2 удаа, нийслэл, аймгийн төвөөс алслагдсан анги, салбарын офицер, ахлагч, тэдний гэр бүлд жилд 1 удаа үнэ, төлбөргүй эмнэлгийн үзлэг явуулж, эмчилгээ, сувилгаанд хамруулдаг жүрмыг тогтоон мөрдөнө.

б/ «Эрүүл мэнд, чийрэгжүүлэлтийн төв»–ийг анги, байгууллага бүрт өөрсдийн дотоод нөөц болоолцоонд тулгуурлан байгуулж, ажиллуулах боломжийг бүрдүүлнэ.

в/Албан үүргээ гүйцэтгэж байгаад осолд орж гэмтэсгэд, ажлын нөхцөл, мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөгсдийг эмчлүүлэх, рашаан сувилалд явах зардлыг анги, байгууллага нь хариуцах нөхцлийг бүрдүүлнэ.

г/Нийтийн биеийн тамирыг бие бүрэлдэхүүнийг чийрэгжүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах үндсэн хэрэгсэл болгоход чиглүүлэн «Биеийн тамир-спорт» хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ.

д/Офицер, ахлагч, тэдний гэр бүлийнхэнд зориулсан амралт, сувиллын газрын боломжийг нэмэгдүүлэх, шинээр нээн ажиллуулах арга хэмжээг авна.

Гарах үр дүн

-Цэргийн албан хаагчдын нийгмийн хамгаалал сайжирна.

-Цэргийн байгууллагад ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, чийрэгжүүлэх, амралт, чөлөөт цагаа үр ашигтай өнгөрүүлэх материаллаг нөхцөл дээшлэнэ.

3.4. Орон нутгийн хамгаалалтын эрх зүйн үндсийг тодорхойлон бүрдүүлэх

а/Монгол Улсын тогтвортой хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсыг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалтай уялдуулан орон нутгийн хамгаалалтын онол, үзэл баримтлалын үндсийг тодорхойлох судалгаог хийж дуусгана.

б/Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалтын эрх зүйн үндсийг бүрдүүлж, хэрэгжүүлэх арга хэмжээг дээ дараатай авна.

в/ «Агаарын орон зайг нисэхэд ашиглах хууль»-ийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

г/Цэргийн анги, байгууллагын ар талын хангалтыг бүсчилсэн тогтолцоонд шилжүүлэх арга замыг судалж шийдвэрлэнэ.

д/Цэргийн анги, байгууллага, хотхоны ахуйн хангалтын зарим үйл ажиллагааг гэрээ, турэсэийн хэлбэрээр гүйцэтгүүлэх замаар аж ахуй, захиргааны зардлыг хямдруулах арга хэмжээ авна.

Гарах үр дүн

Орон нутгийн хамгаалалтын онолын үндэс, ерөнхий загвар тодорхойлогдон, орон нутгийн хамгаалалтад тулгуурласан батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлэх үндэс тавигдаж, аж ахуйн зардал хямдрах нөхцөл бий болно.

3.5.Иргэний хамгаалалтын тогтолцоо, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, байгалийн гамшиг, осолтой тэмцэх хүч хэрэгслийн чадавхийг нэмэгдүүлэх.

а/Гамшгийн менежментийг боловсронгуй болгох хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг хангах, байгалийн гамшиг, осолтой тэмцэх менежментийг гамшиг осол, биологийн хордуулалт, хүн, малын өвчний тархалтаас урьдчилан сэргийлэх, үйл явцын өрнөлтөд шуурхай, мэдрэмжтэй, үр дүнтэй ажиллах, хор уршгийг багино хугацааны арилгахад чиглүүлэн боловсронгуй болгоно.

б/ Иргэний хамгаалалтын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тогтолцоог бүрдүүлэн, удирдах ажилтан, багш мэргэжилтэн сургах, давтан бэлтгэх байнгын дамжааг зохион байгуулж, хэрэгжүүлнэ.

в/ Иргэний хамгаалалтын сургалтын агуулгыг цаг үеийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн шинэчилж, иргэд, албан тушаалтан, оюутан сурагчдын сургалтыг гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, түүнээс хамгаалах арга ажиллагааг сургаж, дадлагажуулахад чиглүүлнэ.

г/ Гамшиг, осол, хөнөөлийн хор хохиролтой тэмцэх үйл ажиллагаанд бие даан зохион байгуулах иргэний хамгаалалтын удирдлага, штабын бүрэлдэхүүний дадлага чадварыг нэмэгдүүлнэ.

д/ Гамшиг, осолтой тэмцэхэд шаардагдах иргэний хамгаалалтын нөөцийг бүрдүүлэх, байршуулах ажлыг дэс дараатай хэрэгжүүлж, түүний хадгалалт, хамгаалалт, нөхөн сэлбэх ажлыг тасралтгүй зохион байгуулах механизмыг бүрдүүлнэ.

е/ Иргэний хамгаалалтын зарлан мэдээлэх системийг шинэчлэнэ.

ё/ Иргэний хамгаалалтын хүч хэрэгслийг бэхжүүлэх зохистой хувилбарыг боловсруулан, хэрэгжүүлж эхэлнэ.

Гарах үр дүн

-Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн осол, хөнөөх хэрэгслийн хөнөөл, биологийн хордуулалт, хүн, малын өвчний халдварын тархалтын хор

хохиролтой тэмцэх иргэний хамгаалалтын хүч хэрэгслийн чадавхи нэмэгдэнэ.

-Иргэний хамгаалалтын сургалтын тогтолцоо бүрдэж, материаллаг баазыг бэхжүүлэх эхлэл тавигдана.

3.6.Зах зээлийн эдийн засгийн харилцааны зохицсон нэгдмэл удирдлага, төлөвлөлт бүхий дайчилгааны тогтолцоог бий болгох

а/Улсын дайчилгааны тогтолцоог улс орны хөгжлийг чиг хандлагад нийцүүлэн, эдийн засаг, хүний нөөцийн чадавхи, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоонд тулгуурлан бүрдүүлнэ.

б/Улсын дайчилгааны төлөвлөлтийн эдийн засгийн үндэслэлийг гаргах, холбогдох тооцоо, судалгааны дүгнэлт хийх үндсэн дээр Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлагаажуулж мөрдөнө.

в/Хямралын үед хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний төслийг боловсруулан батлагаажуулна.

г/Цэргийн дайчилгааны бэлтгэл нөөцийг орон нутгийн зарчмаар бэлтгэх тогтолцоог бүрдүүлнэ.

Гарах үр дүн

Улс орны эдийн засгийн чадавхид нийцсэн, зах зээлийн эдийн засгийн харилцааны зохицсон, шаардлагатай үед хүн ам, эзэмшэл хүчний болон иргэний хамгаалалтын хойшлуулшгүй хэрэгцээг хангаж чадахуйц дайчилгааны тогтолцоог бүрдүүлэх үндэс тавигдана.

3.7. Батлан хамгаалахын шинжилгээ, судалгааны чадавхийг нэмэгдүүлэх

3.7.1.Батлан хамгаалах салбарын шинжлэх ухаан, технологийн чадавхийг нэмэгдүүлэх

а/Батлан хамгаалах салбарын шинжлэх ухаан, технологийн бодлого, стратегийн зорилт, тэргүүлэх чиглэлийг шинэчлэн тодорхойлж мөрдөх, Батлан хамгаалах салбарт шинжлэх ухаан, технологийг 2010 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж эхэлнэ.

б/Батлан хамгаалахын их сургуулийг шинжлэх ухаан, боловсрол, туршилт үйлдвэрлэлийн зохистой хослол бүхий цогцолбор болгох асуудлыг боловсруулж шийдвэрлэнэ.

в/Салбарын шинжлэх ухааны боловсон хүчний хөгжлийг хангах тогтолцоог бий болгон, эрдэмтдийн тоо, чанарын үзүүлэлтэд зарчмын ахиц өөрчлөлт гарах нөхцлийг бүрдүүлж, магистрантур, докторантурт суралцуулах замаар батлан хамгаалах болгогын тэргүүлэх чиглэлээр шинжлэх ухааны боловсон хүчин бэлтгэнэ.

г/Эрдэм шинжилгээний байгууллагуудын судалгаа, туршилтын материаллаг баазыг бэхжүүлж, мэдээллийн хангалт, үйлчилгээг боловсронгуй болгож эрдэм шинжилгээ, туршилт, зохион бүтээх ажил гүйцэтгэх таатай орчинг бүрдүүлнэ.

е/Батлан хамгаалах салбарт мэдээллийн шинэ технологийг нэвтрүүлж, түүний хүрээг өргөтгөх, салбарын мэдээллийн нэгдсэн сүлжээ байгуулах, цэргийн анги, салбаруудыг компьютер, мэдээллийн техник, хэрэгслээр хангах ажлыг хэрэгжүүлнэ.

Гарах үр дүн

-Салбарын эрдэм шинжилгээ, судалгааны байгууллагын чадавхи дээшлэнэ.

-Эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэд, судлаачдын судалгаа, шинжилгээний ажил батлан хамгаалах зорилтын тулгамдсан асуудлуудад хариу өгөхөд чиглэгдэнэ.

3.8.Иргэдийн эх орноо батлан хамгаалах бэлтгэл, эрүүл мэндийг дээшлүүлэх, тэдэнд үндэсний эх оронч хүмүүжил олгох тогтолцоог төлөвшүүлэх.

3.8.1.Эх орондоо үнэнч, ард түмний уламжлал, эв нэгдлийг хүндэтгэн үзэх хүмүүжлийг иргэдэд олгох тогтолцоог бүрдүүлэх

а/Бие бүрэлдэхүүнтэй зохиох мэдээлэл, сурталчилгаа, соёл хүмүүжлийн ажлын тогтолцоо, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

б/Эх оронч хүмүүжлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж дуусгана.

в/Иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх асуудалд төр засаг, олон нийтийн байгууллагуудын анхаарлыг хандуулж, үндэсний эх оронч үзлийг төлөвшүүлэх ажлын нэгдсэн тогтолцоог бий болгоно.

3.8.2.Залуучуудын бие бялдрын зөв өсөлт, хөгжилтийг хангах, эрүүл чийрэг болгох бодлогыг тодорхойлон хэрэгжүүлэх

а/Хүн амын эрүүл мэнд, бие бялдрын зөв өсөлтийг дээшлүүлэхэд чиглэсэн төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, улс төрийн нам, төрийн бус байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн байгууллагуудын ажлыг уялдуулан зохицуулж, эрчимжүүлнэ.

б/Ард иргэд, ялангуяа хүүхэд, залуучуудыг суурь өвчнөөс ангижруулах, тэдний эрүүлжүүлэх бодлого боловсруулан, хэрэгжүүлж эхэлнэ.

Цэргийн байгуулалтыг хөгжүүлэх чөтөлбөрийн эхний шатны үйл ажиллагаа, хэрэгжилт, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит үзлэгийн бэлтгэлд үнэлгээ, дүгнэлт өгч, шаардлагатай бол хөтөлбөрт тодотгол хийнэ.

Хоёрдугаар үе шат 2003-2005 оныг хамарна. Энэ үе шатанд:

3.9. Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэх

а/Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалтын зохистой бүтцийг бий болгоно.

б/Зэвсэгт хүчний ангиудын бүтцийг орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалттай уялдуулан хямдруулж, хөнгөн бүтцэд шилжүүлэн, чадваржуулах арга хэмжээ авна.

в/Цэргийн анги, салбарын байршил, бүтэц, үүрэг зориулалтыг орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалттай уялдуулах арга хэмжээ авна.

д/Цэргийн болон «цэрэгжүүлсэн» байгуулагын заагаа ялгаат тодотгож шийдвэрлэнэ.

е/Дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүнийг бэлтгэх, давтан бэлтгэх эрх зүй, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлнэ.

ж/Орон нутгийн цэргийн дайчилгааны нөөцийг бүрдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж дуусгана.

з/Аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг боловсруулан мөрдүүлэх арга хэмжээ авна.

и/Улсын дайчилгааны нөөцийн бүрдүүлэлт, байршлыг улс оронд тохиолдож болзошгүй хүндрэл, бэрхшээлийг даван туулахад чиглүүлэн тогтоож түүнийг нөхөн сэлбэх, шинэчлэх, өргөжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

й/Зэвсэгт хүчний дайчилгааны нөөцийн материал хэрэгслийг улсын нөөцийн хүрээнд бүрдүүлэх тогтолцоог бий болгоно.

к/Байгалийн гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх, түүний хор уршигтай тэмцэх менежментийг боловсронгуй болгох чиглэлээр Иргэний хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, Аварга нарын эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулан Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

л/Иргэний хамгаалалтын сургалтын бүсийн төв байгуулж, материаллаг баазыг бэхжүүлнэ.

м/НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох бэлтгэлтэй салбарын тоог нэгээр нэмэгдүүлнэ.

н/Зэвсэгт хүчний анги, байгуулагын тохижилт, цэргийн дүрмийн хэрэгжилтэд Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит үзлэгийн 2003 онд явуулна.

Гарах үр дүн

-Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай уялдсан орон нутгийн хамгаалалтын зохион байгуулалт, хангалтын зохистой бүтэц бий болж, батлан хамгаалах нэгдмэл тогтолцоо бүрдэх, цэргийн байгуулалтын хөгжих эрх зүй, эдийн засгийн үндэс бүрдэнэ.

-Монгол Улсын орон нутгийн хамгаалалтын болон улсын дайчилгааны тогтолцооны материаллаг үндэс бүрдэнэ.

-Иргэний хамгаалалтын тогтолцоо төлөвшиж, удирдлагын шуурхай ажиллагаа хангагдана.

3.10. Цэргийн байгуулалтын цаашдын тогтвортой хөгжлийг хангах

а/Монгол Улсын түүхэн уламжлал, ард түмний эв нэгдэлд үнэнч, эх оронч үзэл төлөвшүүлэх, Үндэсэн хууль, бусад хуулийг хүндэтгэн сахин биелүүлдэг, эрх зүйт төрийг дээдлэн үздэг хүмүүжил, сэтгэл зүйн бэлтгэл олгохүүлэх чиглэгдсэн сургалтын тогтолцоог бүх шатны сургуулиудад 2003 оны хичээлийн жилээс нэвтрүүлнэ.

б/Шинжлэх ухаан, боловсрол, туршилт, үйлдвэрлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн дунд, богино хугацааны хөтөлбөр, төслүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.

в/Зэвсэгслэл техникийн зарим жижиг эд анги, цэргийн эд хэрэгслийг туршилтын жүрмаар үйлдвэрлэж эхэлнэ.

е/Шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаанд зарцуулах зардлын хэмжээг дэс дараатайгаар нэмэгдүүлэн 2003-2005 онд батлан хамгаалах арга хэмжээний төсвийн 0,6-1,5 хувьд хүргэж, шинжлэх ухаан технологийн үйл ажиллагааны эдийн засгийн бааз суурийг бэхжүүлнэ.

Гарах үр дүн

-Хөтөлбөрийн хэрэгжилтийн төгсгөлд батлан хамгаалах зардал дотоодын нийт бүтээгдэхүүний 2 хувиас хэтрэхгүй байх хэмжээнд хүрч буурна.

-Төрүүлэх чиглэлийн зэвсэглэл, техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах үйл явц хэрэгжинэ.

-Цэргийн дэд бүтцийг улс орны эдийн засгийн бүсчилсэн хөгжилтэй уялдуулан хөгжүүлэх, эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, техникийн ололтыг батлан хамгаалах чадавхийг нэмэгдүүлэхэд ашиглах боломж бүрдэж эхэлнэ.

-Цэргийн анги, салбар/суман/ бүр ажлын болон сургалтын компьютерээр бүрэн хангагдана.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

а.Хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах, хэрэгжилтэнд хяналт тавих үүрэгтэй Засгийн газрын ажлын хэсэг ажиллана. Ажлын хэсгийг Ерөнхий сайд удирдана.

б.Ажлын хэсэг нь орон тооны бус байгууллага байх бөгөөд Засгийн газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, төрийн захиргааны төв болон бусад байгууллагын төлөөлөөс бүрдэнэ.

в.Ажлын хэсэг нь улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн бодлого, үндэсний аюулгүй байдлыг хангах үзэл баримтлалыг хэрэгжүүлэхтэй уялдаатайгаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үйл ажиллагаат зохицуулна.

Засгийн газрын ажлын хэсэг нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

-Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг жил бүр төлөвлөн, зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тооцох;

-Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, олон улс, гадаад, дотоодын байгууллагын хандив, тусламжийг нэгтгэн хуваарилах, зохицуулах асуудлыг Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэх, түүнийг хэрэгжүүлэхтэй холбоо бүхий ажлыг төрийн захиргааны төв байгууллагууд, Засгийн газрын агентлагуудын хүрээнд уялдуулан зохицуулах, хэрэгжилтийн байдалд хяналт тавих;

-Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар аймаг, нийслэлийн удирдлагыг чиглэл, удирдамжаар хангах;

Ажлын хэсэг нь хөтөлбөрийн хэрэгжилтийг жил бүр Засгийн газарт тайлагнаж байна.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэр нь:

- улсын төвлөрсөн төсвөөс батлан хамгаалах арга хэмжээнд зориулан төсөвлөсөн хөрөнгө;
- батлан хамгаалах салбарын хөрөнгө оруулалтын зардал;
- цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хааснаас орох орлого;
- Илүүдэл болон орон тооноос хасагдсан зэвсэгслэл, техник, ашиглалтаас чөлөөлөгдсөн барилга, байшин, бусад объектыг зарж борлуулснаас орох орлого;
- Засгийн газрын томоохон хөтөлбөр хэрэгжүүлэхэд цэргийн анги, салбарыг оролцуулснаас олох орлого;
- гадаад, дотоодын болон олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс батлан хамгаалах үйл ажиллагаанд зориулан олгосон хөрөнгө, хандив, тусламж;
- агаарын навигацын төлбөрийн тодорхой хэсэг;
- салбарын хүрээнд хийгдэх бүтээц, зохион байгуулалтын өөрчлөлтөөс гарах төсвийн хэмнэлт болон салбарын дотоод зохицуулалтаас олж болох бусад орлого.

Зургаа. Хүлээгдэж буй үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрэх болно.Үүнд:

-Батлан хамгаалах тогтолцоо, цэргийн байгуулалт нь цэргийн хэргийн хөгжлийн чиг хандлагад нийцэн, иргэний ардчилсан нийгэм, эрх зүйт төрийн тогтолцооны нэг хэсэг байж, эдийн засгийн боломж, батлан хамгаалах хэрэгцээ, шаардлагатай уялдан шинжлэх ухааны үндэстэй хөгжих нөхцөл бүрдэнэ.

-Батлан хамгаалах тогтолцоо, цэргийн байгуулалтын удирдлага, эрх зүй, эдийн засгийн оновчтой тогтолцоо бий болж, цэргийн болон «цэрэгжүүлсэн» байгууллагуудын зааг ялгаа нарийвчлан тогтоогдож, тайван цагийн болон дайны үеийн чиг үүрэг тодорхой болно.

-Иргэдэд эх оронч үзлийг төлөвшүүлэх сургалтын нэгдсэн тогтолцоо бий болж, залуу үеийн эрүүл мэнд, бие бялдар, мэдлэг оюуны чадавхи дээшлэх нөхцөл бүрдэнэ.

-Зэвсэгт хүчин нь хүнийг хөгжүүлэх орчин болж, зэвсэглэл, техникийн өндөр чадавхи бүхий, хуулиар хүлээсэн үүргээ ямар ч нөхцөлд биелүүлэх чадвартай, цомхон, чадварлаг, мэрэгжлийн чиг баримжаатай болох эхний шатны зорилтоо хангах боломжтой болно.

-НҮБ-ын энхийг сахиулах хүчний бүрэлдэхүүнд үүрэг гүйцэтгэх бэлтгэл бүхий гурван салбар бий болно.

-Улс орны батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх чиглэлээр төр, засгийн бүх шатны байгууллагын гүйцэтгэх үүрэг, оролцоо тодорхой болно.

-Зэвсэгт хүчнийг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах журам оновчтой болж, цэргийн анги бүр тайван цагийн бүтээц, зохион байгуулалтаараа байлдааны болон гамшиг, ослын үед ард иргэдэд хүмүүнлэгийн туслалцаа үзүүлэх, тусгай үүрэг

гүйцэтгэх чадвартай, харьцангуй богино хугацаанд дайчилгаагаар өргөтгөн, зохион байгуулагдан байдааны бэлэн байдалд шилжих боломжтой болно.

-Цэргийн албан хаагчдын нийгмийн баталгаа сайжирна.

-Иргэний хамгаалалтын оновчтой тогтолцоо бий болж, түүний удирдлагын шуурхай байдал хангагдахын дээр хүч хэрэгслийн чадавхи нэмэгдэж, гамшиг ослын хохирлыг бууруулахад ахиц гарна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Тайлбар.

«Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль»-д нийцүүлэн хэвлэлд нийтлэхийн тулд Хөтөлбөрийн «Гурав» дугаар бүлгээс нууцын зэрэглэлд хамаарах

3.1.1.б-заалтыг тодруулсан хэсэг, в, г, е-заалт,

3.1.2.а, в, г- заалт,

3.1.5.б, в, г- заалт,

3.2..в, г-заалт, д-заалтыг тодруулсан зарим хэсэг,

3.6.д-заалт,

3.7.1.д заалт,

3.9.г, е-заалт,

3.10.г, д-заалтыг хасаж,

3.1.1.а,б; 3.1.6.а-заалт; 3.2-ын «Гарах үр дүн»-гийн нэг дэх өгүүлбэр дэх холбогдох нэр, тоо баримтыг тус тус хасаж найруулав.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 28–ны өдөр Дугаар 38 Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гүчин гуравдугаар зүйлийн 1дэх хэсгийн 5,Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Данийн Вант Улс, Люксембургийн Их Вант Улс, Нидерландын Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Шүхэрийн Алтангэрэлийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Данийн Вант Улс, Люксембургийн Их Вант Улс, Нидерландын Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Содовын Ононг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 3 дугаар сарын 28–ны өдөр Дугаар 39 Улаанбаатар хот

Дүрэм шинэчлэн батлах тухай

"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" Монгол Улсын хуулийн 24 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын шинэчлэн найруулсан дүрмийг хавсралтын ёсоор батлуулсугай.

2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1998 оны 132 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 39 дүгээр зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комисс /цаашид Улсын комисс гэх/ нь ядгуур үгсаа,гарал үүсэл,үзэл бодол, шашин шүтлэг, хөрөнгө чинээ,нийгмийн байдлын үлмаас улс төрийн хэрэгт хилсэрэ шийтгэгдсэн, нам, захиргааны байгуулагаас арга хэмжээ

авагдсан, хэлмэгдсэн иргэдийн асуудлыг судалж шалгах, хянаж зохион байгуулах үүрэг бүхий цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах төрийн орон тооны бус байгууллага мөн.

2.Улсын комиссын зорилт нь төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн,нам, төрийн бодлого, шийдвэрт шүүмжлэлтэй хандсан гэх шалтгаанаар хилсээр шийтгүүлсэн, нам,захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдсан иргэдийн хэргийг шалгаж, шийдвэрлүүлэх хэлмэгдсэн иргэнд хууль тогтоомжийн дагуу тэтгэмж, тусламж, нөхөх олговор олгуулах, хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээн сурталчлахад холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдийг татан оролцуулах ажлыг зохион байгуулахад оршино.

3.Улсын комисс нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Үндсэн хууль,"Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

4.Улсын комисс төрийн болон төрийн бус байгууллага, иргэдээс улс төрийн цагаатгалын асуудлаар тавьж буй санал, хүсэлтийг судлан шийдвэрлэж байна.

5. Улсын комисс Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн эрх хэмжээнийхээ хүрээнд тогтоол гаргана.

6. Улсын комисс нь тогтоосон жүрмаар хийсэн тамга, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

7. Улсын комиис нь үйл ажиллагаагаа Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөлд тайлагнана.

8. Улсын комиссын бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.Улсын комисс дарга, нарийн бичгийн дарга, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга,Санхүү,эдийн засгийн сайд,Улсын ерөнхий прокурор, Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгч, Тагнуулын ерөнхий газрын дарга, Тагнуулын ерөнхий газрын цагаатгалын тасгийн дарга,комиссын дэргэдэх улс төрийн хэлмэгдэгсдийн судалгааны төвийн захирал бөгөөд ажлын албаны дарга гэсэн албан тушаалтнуудаас бүрдэнэ.

9. Улсын комиссын харьяанд аймаг, нийслэлийн Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбар комисс, судалгааны төв, ажлын алба тус тус ажиллана. Ажлын албаны үүргийг Судалгааны төвд давхар хариуцуулан гүйцэтгүүлж болно.

Хоёр. Улсын комиссын үүрэг, эрх

10. Улсын комисс нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ. Үүнд:

а/ "Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдүдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай" хуулийг сурталчлах, хэрэгжүүлэхэд хяналт тавьж, зохион байгуулж ажиллана.

б/ Төрийн эсрэг гэмт хэрэгт шийтгүүлсэн болон нам, төрийн удирдлагын бодлого, шийдвэрийг шүүмжилж эсэргүүцэн, энэ тухай санал бодлоо илэрхийлсний улмаас нам, захиргааны байгууллагаас хилсээр арга хэмжээ авагдаж, шийтгүүлсэн иргэдийн асуудлыг шалгаж, шийдвэрлэхэд Тагнуулын ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Улсын дээд шүүх зэрэг газруудтай ажил төрлийн нягт уялдаатайгаар хамтарч ажиллана.

в/ Хэлмэгдсэн иргэдийн алдар цол, одон медаль, цэргийн дээд цолыг сэргээх асуудлыг өөрсдийн нь болон өв залгамжлагчдын санал, хүсэлтийг үндэслэн холбогдох газруудад тавьж шийдвэрлүүлнэ.

г/ Хэлмэгдэгсдэд нөхөх олговор олгохтой холбоотой санал, хүсэлтийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж байгаа эсэхэд хяналт тавина.

д/ Орон нутгийн төр, захиргааны байгууллагууд хэлмэгдсэн иргэдийг орон байраар хэрэхэн ханган байгаад хяналт тавина.

е/ Улс төрийн хэлмэгсдийн дурсгалыг мөнхжүүлэх талаар иргэд, байгууллагаас гаргасан санал, санаачлагыг судалж, шийдвэр гаргуулахаар эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

ё/ Аймаг, нийслэлийн салбар комиссууд хэлмэгдэгсдийн асуудлаар иргэдээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг хэрхэн шийдвэрлэж байгаад хяналт тавьж, чиглэл удирдамж өгнө.

ж/ Байгууллага, иргэдээс Улсын комисст гаргасан өргөдөл, гомдол, санал, хүсэлтийг хүлээн авч барагдуулах ажлыг зохион байгуулна.

з/ Улс төрийн цагаатгалын ажлын явц, үр дүнгийн талаар нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг зохион байгуулна.

Улсын комиссын дэргэд хэвлэл, мэдээллийн орон тооны бус төлөөлөгч ажиллуулж, түүнд урамшуулал олгоно.

11. Улсын комисс нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/ Цагаатгагдсан иргэд, тэдний өв залгамжлагчдад нөхөх олговор, мөн хэлмэгдэгчдэд орон сууц олгуулах, тэдгээрт шаардагдах хөрөнгийн

хэмжээг хэлбэгдох байгууллагаар тодорхойлуулж, улсын төсөвт жил бүр тусгуулна.

б/ Улсын комисс, аймаг, нийслэлийн салбар комисс, улс төрийн хэлмэгдэгсдийн Судалгааны төв, комиссын ажлын албаны төсөв, зардлыг улсын төсөвт жил бүр тусгуулна.

в/ Улс төрийн хэлмэгдүүлэлтийн шалтгаан, нөхцлийг тодорхойлох, хэлмэгдэгсдийн нэр төрийг сэргээхэд шаардлагатай архивын баримт бичиг, тодорхойлолт, мэдээ судалгаа бусад материалыг Монгол Улсын бүх архив, төр засаг, нам, олон нийтийн байгууллага, албан тушаалтнаас гаргуулж авна.

г/ Гадаад улсын хуулиар Монголын иргэдийг улс төрийн хэрэгт шийтгэсэн тухай баримт материал, мэдээг тухайн улсад нь санал тавьж авах, ЗХУ /хуучин нэрээр/-ын нутаг дэвсгэрт улс төрийн шалтгаанаар шийтгүүлж, амь насаа алдсан, целегдсэн, нутаг заагдсан, сураггүй болсон, Монголд байрлаж байсан Зөвлөлтийн цэргийн болон тусгай албадад дайчлагдан баривчлагдсан монгол иргэдийн тухай баримт материалыг Оросын Холбооны улсаас шилжүүлэн авах ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулна. Гадаадын улсуудад хэлмэгдсэн монголын иргэдийг цагаатгуулах, нөхөх олговрын асуудлаар санал тавьж шийдвэрлүүлнэ.

д/ Улс төрийн хэлмэгдүүлэлтийн шалтгаан, нөхцөл, хор уршгийг судлан тогтоох, төр, нийгмийн зүтгэлтнүүдийн улс төрийн үйл ажиллагааны түүх, намтрыг бичиж, нийтлэх, судалгаа шинжилгээ хийж, зөвлөмж боловсруулах үүрэг, зорилт бүхий судалгааны төвийг ажилуулна.

е/ Улсын комиссын ажилтнууд болон Судалгааны төвийн захирал, ажлын албаны дарга ажилд томилох бөгөөд ажлаас чөлөөлнө.

ё/ Цагаатгалын асуудлаар холбогдох байгууллага, албан тушаалтны сонсгол, мэдээллийг хэлэлцэх, чиглэл, удирдамж, заалт өгч, биелэлтийг хянуулах ажлыг зохион байгуулна.

ж/ Хүний эрх, эрх чөлөө, нэр төртэй холбоотойгоор гарч байгаа хууль эрхийн баримт бичгүүдийн төсөлтэй танилцаж, санал өгнө.

з/ Улс төрийн хилс хэрэгт шийтгүүлээд цагаатгагдсан иргэдэд үнэмлэх олгоно.

Гурав. Улсын хөмиссын хуралдааны ерөнхий дэг

12 Хуралдааныг Улсын комиссын дарга даргална.

13. Комиссын даргын эзгүйд хуралдааныг Улсын комиссын нарийн бичгийн дарга даргална.

14. Улсын комиссын хуралдаанд хэлэлцэх асуудлын талаар хоёр сарын өмнө холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдэгдэж, сонсгол, мэдээллийг бэлтгүүлнэ. Сонсгол, мэдээллийг / Улсын комиссын жилийн ажлын тайлан орохгүй/ 3-4 хуудсанд багтаж, хуралдаан товлосон хугацаанаас 15 хоногийн өмнө Улсын комисст ирүүлсэн байна.

15. Комиссын хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, сонсгол, мэдээллэл, хуралдаанаас гаргах шийдвэрийн төсөл зэргийг хуралдаан хийхээс 7 хоногийн өмнө Улсын комиссын гишүүдэд тараана.

16. Хуралдаанд комиссын гишүүд таслах эрхтэй оролцоно.

17. Хуралдаанд хэлэлцсэн асуудлаар шаардлагатай бол тогтоол гаргана.

Дөрөв. Улсын комиссын дарга, гишүүдийн эрх хэмжээ

18. Улсын комиссын дарга нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн зургадугаар зүйлийн 1-ийн 4-т заасан төрийн улс төрийн албан тушаалтан байх бөгөөд комиссын өдөр тутмын ажлыг удирдах, захирамж гаргана.

19. Улсын комиссын нарийн бичгийн дарга нь Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн долдугаар зүйлийн гурвын 1-ийн 4-т заасны дагуу төрийн захиргааны албан хаагчийн тэргүүн түшмэлийн эрх хэмжээтэй байх бөгөөд комиссын өдөр тутмын ажлыг зохион байгуулна.

20. Улсын комиссын гишүүд нь хамтын шийдвэр гаргахад санал дүгнэлтээ илэрхийлэх, Улсын комиссын хуралдаанд бие даан асуудал, санал оруулах эрхтэйгээр ажиллана. Улсын комиссын гишүүдэд жилд хоёроос доошгүй удаа тэдний үндсэн ажлын цалингийн 40.0 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал комиссоос олгож болно.

21. Аймаг, нийслэлийн салбар комиссын дарга нь төрийн нутгийн захиргааны албан тушаалтан байх бөгөөд тухайн орон нутгийн хэмжээнд цагаатгалын ажлыг зохион байгуулж, ажлаа Улсын комиссын өмнө хариуцна.

Салбар комиссын дарга, нарийн бичгийн дарга нарыг ажлын үр дүнгээр нь Улсын комиссоос урамшуулж болно.

2002 оны 2 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот

2002 оныг "Хөрөнгө оруулалтыг дэмжих жил" болгох тухай

Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтыг дэмжих үүднээс Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2002 оныг "Хөрөнгө оруулалтыг дэмжих жил" болгон зарласугай.

2. Хөрөнгө оруулалтыг дэмжих жилийн ажлыг зохион байгуулах, зохицуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт, Хөрөнгө оруулалтыг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлагдсугай.

3. Хөрөнгө оруулалтын эдийн засаг, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтыг татах, сурталчлах арга хэмжээ авахыг Үндэсний зөвлөлийн дарга Ч.Улаанд даалгасугай.

4. Хөрөнгө оруулалтыг дэмжих жилийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2002 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ЖИЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Санхүү, эдийн засгийн сайд
Орлогч дарга	-Үйлдвэр, худалдааны сайд
Гишүүд:	-Хүнс, хөдөө аж ахуйн сайд; -Дэд бүтцийн сайд; -Байгаль орчны дэд сайд; -Гадаад хэргийн дэд сайд; -Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга; -Хууль зүй,дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Төрийн өмчийн хорооны дарга; -Үндэсний татварын ерөнхий газрын дарга; -Улсын гаалийн ерөнхий газрын дарга; -Улаанбаатар хотын ерөнхий менежер; -Үнэт цаасны хорооны дарга (тохиролцоноор); -Үндэсний статистикийн газрын дарга (тохиролцоноор); -Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгч (тохиролцоноор); -Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцоноор); -Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч (тохиролцоноор); -Монголын үндэсний үйлдвэрлэгчдийн холбооны ерөнхийлөгч (тохиролцоноор); -Аймгуудын Засаг дарга нар.
Нарийн бичгийн дарга	-Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ ЖИЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийх ажил	Хугацаа	Хариуцах эзэн
	1. Хөрөнгө оруулалтын эдийн засаг, эрх зүйн орчинг боловсронгуй болгох		
1.1	Хөрөнгө оруулалтын тааламжтай нөхцөлийг эн тэргүүнд бүрдүүлэх, зах зээлийг идэвхжүүлэхэд чиглэсэн дараахь арга хэмжээ авах:		
	- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг батлуулж мөрдүүлэх	I- П улирал	Ч.Ганзориг
	- Газрын тухай болон газрын төлбөрийн тухай хуулийг батлуулах	жилдээ	У.Барсболд
	- Гадаадын зээл, тусламжийг зохицуулах тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах	I-П улирал	Ч.Улаан
	- Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн найруулга болон үүнтэй холбогдуулан бусад холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах	жилдээ	Ч.Улаан, С.Гүндэнбал
	- Газар тариалангийн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах	жилдээ	Д.Насанжаргал
	- Малчин өрх болон фермерийн аж ахуйн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах	VП сар	Д.Насанжаргал
	- Амьтан, ургамал тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр оруулах, гаргах хорио цээрийн хяналт шалгалтын тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах	VI сар	Д.Насанжаргал
	- Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах	VI сар	Д.Насанжаргал
	- Ашигт малтмалын тухай хуулийн 63 дугаар зүйлийн заалтууд (алдагдлыг орлогоос хасч тооцох, бэлтгэл ажлын зардлыг үйлдвэрлэлийн зардалд тооцох зэрэг)-ыг татварын холбогдох хуульд тусгуулах тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах	I улирал	Ч.Ганзориг, Ч.Улаан
	- Экспортыг дэмжих хуулийн төсөл боловсруулж батлуулах	Ш улирал	Ч.Ганзориг
	- Экспортын болон импорт орлох чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжих үүднээс Татварын багц хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах, батлуулах	П улирал	Ч.Улаан, Ч.Ганзориг
	- Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах	I улирал	Д.Насанжаргал
	- Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж батлуулах	IY улирал	Д.Насанжаргал

1.2	Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, бүсийн үйл ажиллагааны талаар хөрш орнуудтай уулзалт зохион байгуулах, Алтанбулаг, Замын-Үудийн хуралдааны чөлөөт бүсийн талаар төсөл хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах	I-Ш улирал	Ч.Улаан, Ч.Ганзориг
1.3	"Аж үйлдвэрийн парк" байгуулах боломжийг судлах, эрх зүйн үндсийг бүрдүүлэх чиглэлээр ажиллах	I-Ш улирал	Ч.Ганзориг, Т.Бадамжунай
1.4	Хөрөнгө оруулалт, ялангуяа хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжих хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийх, боловсронгуй болгох санал боловсруулах	жилдээ	Ч.Ганзориг, Ч.Улаан, Ц.Нямдорж, холбогдох албад
1.5	Гадаадын хөрөнгө оруулаттай компаниудын үйл ажиллагаатай танилцах, тэдгээрийн зүгээс гаргасан саналыг шийдвэрлэх арга хэмжээ авах	жилдээ	Ч.Ганзориг, Үндэсний зөвлөл, ГХГХОГ, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
1.6	Хөрөнгө оруулалтын холбогдолтой хууль тогтоомжийг сурталчлах, тусгай товхимол болгон хэвлэх	жилдээ	Ч.Ганзориг, Ч.Улаан, Ц.Нямдорж
1.7	Хөрөнгө оруулалтын статистик мэдээг боловсронгуй болгох	Ш улирал	Ч.Улаан, Ч.Даваасүрэн
1.8	Хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих, харилцан хамгаалах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрүүдийг байгуулах арга хэмжээ авах	жилдээ	Ч.Ганзориг, Л.Эрдэнэчулуун
1.9	Бизнесийн үйл ажиллагааг дэмжих гадаад, дотоодын хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	жилдээ	О.Чулуунбат, Ч.Улаан
	2. Хөрөнгө оруулалтыг татах, сурталчлах арга хэмжээ		
2.1	Хөрөнгө оруулалтын техник эдийн засгийн үндэслэл, төсөл боловсруулах аргачлалын асуудлаар семинар зохион байгуулах, энэ талаар бизнес эрхлэгчдэд зориулан гарын авлага бэлтгэх, зөвлөлгөө өгөх	жилдээ	Ч.Улаан, Ч.Ганзориг, Үндэсний зөвлөл
2.2	Үнэ цэнтэй аж ахуйн нэгжийн хувьчлалд гадаад, дотоодын бодит хөрөнгө оруулагчдыг татан оруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх	жилдээ	Л.Пүрэвдорж, Үндэсний зөвлөл, ГХГХОГ
2.3	Засгийн газраас батлсан хөтөлбөр, төслүүдийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг татах арга хэмжээ авах	жилдээ	Ч.Улаан, Ч.Ганзориг, Д.Насанжаргал, Үндэсний зөвлөл
2.4	Өндөр хэмжээнд хийх албан ёсны айлчлалын хүрээнд хөрөнгө оруулалтын төсөл, эрх зүйн орчинг өргөн сурталчлах, ажил хэрэгч хүмүүсийн дугуй ширээний уулзалт, ярилцлага зохион байгуулах арга хэмжээ авах	Тухай бүр	Үндэсний зөвлөл, ГХГХОГ, МХАҮТ
2.5	Уул уурхайн болон металлургийн томоохон төслүүдийг бэлтгэж, гадаадын хөрөнгө оруулагчдад сурталчлах	жилдээ	Ч.Ганзориг, АМХЭГ, ГХГХОГ
2.6	"Мянганы зам" хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хөрөнгө оруулалтыг татах, эрчимжүүлэх арга хэмжээ авах	жилдээ	Б.Жигжид
2.7	Цагаан Сувргын зэс-молибдены орд, Дорноговь аймгийн Мандах сум хүртэл 110 квт өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам татах санхүүжилт олох чиглэлээр ажиллах	жилдээ	Ч.Ганзориг, АМХЭГ

2.8	Тавтын алт, Цагаан Суваргын зэс, Асгатын мөнгөний ордуудыг ашиглахад шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийн урьдчилсан тооцоог хийж, ашиглах талаар сонирхогч оруулдад санал тавих	жилдээ	Ч.Ганзориг, АМХЭГ
2.9	Газрын тосны тендер зарласан нээлттэй байгаа 16 талбайн судалгаа, хайгуулын ажилд хөрөнгө оруулалтыг татах сурталчилгааны ажлыг зохион байгуулах	жилдээ	Ч.Ганзориг, ГТХЭГ
2.10	Үр тариа, төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх арга хэмжээ авах	жилдээ	Д.Насанжаргал
2.11	Сүү, цагаан идээний үйлдвэрлэлд шинэ технологи нэвтрүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх	жилдээ	Д.Насанжаргал
	3. Хөрөнгө оруулалтад дэмжлэг үзүүлэх талаар зохион байгуулах арга хэмжээ		
3.1	Улаанбаатар хотноо зохион байгуулах Монголд хандивлагчдын зөвлөлгөөнд хөрөнгө оруулалтын төслүүдийг бэлтгэж санал болгох	II улирал	Ч.Улаан, Л.Эрдэнэчулуун
3.2	Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын бэлтгэлийг ханган, зохион байгуулах	Ш улирал	Ч.Ганзориг, Чуулга уулзалтын бэлтгэлийг ханган, зохион байгуулах Засгийн газрын комисс
3.3	Дэд бүтцийн салбараар хандивлагчдын сэдэвчилсэн уулзалт зохион байгуулах, эрчим хүчний салбарт бүтцийн өөрчлөлт хийх, хөрөнгө оруулалтыг эрчимжүүлэх санал тавих	I улирал	Б.Жигжид, Ч.Улаан
3.4	Авто зам, усан цахилгаан станц зэрэг дэд бүтцийн томоохон төслүүдийг санхүүжүүлэх талаар гадаад орон, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай хийж байгаа хэлэлцээг эрчимжүүлэх, шийдвэрлэхэд чиглэсэн арга хэмжээ авах	I-П улирал	Ч.Улаан, Б.Жигжид
3.5	Хандивлагчдын уулзалт, зөвлөлгөөний үеэр амласан зээл, тусламжийг ашиглах гэрээ, хэлэлцээр байгуулах, хөрөнгө оруулалтын төслүүдийн хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авах	жилдээ	Ч.Улаан, Үндэсний зөвлөл
3.6	Улсын төвөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа бөгөөд хугацаандаа ашиглалтад ороогүй объектуудад шалгалт хийж, дүгнэлт гаргах	жилдээ	Ч.Улаан, Аймгийн Засаг дарга нар
3.7	Жижиг, дунд үйлдвэрт оруулсан зээл, тусламжийн хөрөнгийн ашиглалт, үр дүнд дүгнэлт хийх, энэ үйл ажиллагаат дэмжихэд чиглэсэн сангуудын хөрөнгийн эргэлтийг сайжруулах арга хэмжээ авах	жилдээ	Ч.Улаан, Ч.Ганзориг, Д.Насанжаргал, Үндэсний зөвлөл
3.8	Хүчин чадлаа бүрэн ашиглаагүй буюу хадгалалтад байгаа үйлдвэрийг сэргээх, ашиглалтыг сайжруулах үүднээс эзэн компани, байгууллагын саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах	жилдээ	Ч.Ганзориг, Ч.Улаан, Аймгийн Засаг дарга, Үндэсний зөвлөл
3.9	Засгийн газрын бонд, компанийн үнэт цаас, вексель гаргах хэлбэрээр хөрөнгө оруулалтын санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах	жилдээ	Ч.Улаан, С.Гүндэнбал, Үндэсний зөвлөл

4. Бусад асуудал			
4.1	Хөрөнгө оруулалтыг татахад чиглэсэн үзэсгэлэн гаргах, дугуй ширээний уулзалт, ярилцлага зохион байгуулах	жилдээ	Үндэсний зөвлөл, ГХГХОГ
4.2	2002 оны шилдэг хөрөнгө оруулагчийг шалгаруулах	IV улирал	Ч.Улаан, Ч.Ганзориг, МХАҮТ, ГХГХОГ, Үндэсний зөвлөл
4.3	"Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн үйл ажиллагааг сайжруулах, бизнесийн үйл ажиллагааг зохицуулахтай холбогдсон эрх зүйн актуудын лавламжийн санг бүрдүүлэх, түүгээр үйлчлэх	жилдээ	Ч.Ганзориг, Үндэсний зөвлөл, ГХГХОГ
4.4	"Хөрөнгө оруулалтыг дэмжих жил"-ийн хүрээнд хийж гүйцэтгэсэн ажлын үр дүнг сурталчлах	жилдээ	Үндэсний зөвлөл
4.5	Үндэсний зөвлөлийн хурлыг улиралд нэгээс доошгүй удаа хийж төлөвлөгөөний биелэлтэд дүгнэлт хийж цаашид авах арга хэмжээг тодотгон ажиллах	Улиралд нэгээс доошгүй удаа	Үндэсний зөвлөл
4.6	Хөрөнгө оруулалтыг дэмжих жилийн хүрээнд хийсэн ажлын үр дүнгийн уулзалтыг зохион байгуулах	2002 оны 12 дугаар сар	Үндэсний зөвлөл
4.7	Ажлын дүнг Засгийн газарт тайлагнах	2003 оны 1 дүгээр сар	Үндэсний зөвлөл

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 22 Улаанбаатар хот

Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн ажлын дүнгийн тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тахир дутуу иргэдийг дэмжих жилийн хүрээнд тэдний сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, урлаг, спортын арга хэмжээнд оролцох үүсгэл санаачилгыг дэмжих, туслалцаа үзүүлэх чиглэлээр өргөн хүрээтэй ажил зохион байгуулсан төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн идэвхи санаачилга тодорхой үр дүнд хүрснийг сайшаан тэмдэглэж, цаашид ажлын эхлэл, ололтоо эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг холбогдох сайд, аймаг, нийслэлийнх Засаг дарга нарт даалгасугай.

2. Тахир дутуу иргэдийн амьдрах орчин, ажлын байрны зохистой нөхцөлийг бүрдүүлэх, ажлын байраар хангах замаар тэдний нийгмийн амьдралд татан оролцуулах, төрийн зарим чиг үүргийг тахир дутуу иргэдийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх асуудлыг судлан шийдвэрлэх зорилгоор үйл ажиллагаанд нь бодитой дэмжлэг үзүүлж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

3. Хөдөө орон нутгаас тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвд суралцагчдын дотуур байрны зардлыг тус төвийн жилийн төсөвт тусган өгч байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт үүрэг болгосугай.

4. Тахир дутуу иргэдийн мэргэжлийн сургалт, сэргээн засалтын үндэсний төвийг Олон улсын сэргээн засалтын холбоонд гишүүнээр элсэхийг дэмжиж, гишүүний татварыг нь төсөөс төлж байсугай.

5. Нийслэлд тахир дутуу иргэдийн сэргээн засалтын иж бүрэн цогцолбор, 5 аймагт түүний салбар байгуулах асуудлыг Япон Улсын Засгийн газарт тавьж шийдвэрлүүлэхийг Санхүү, эдийн

засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

6. Хараагүй хүмүүсийн хөдөлмөр, сургалтын үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2003 оноос эхлэн тус үйлдвэрийн цахилгаан, дулаан, уур ус, холбоо, захиргааны ажилтны зардлыг Нийслэлийн төсвөөс бүрэн санхүүжүүлэх, тэнд хараагүй иргэдийн зэрэгцээ тахир дутуу болон бусад хүмүүсийг ажиллуулах зохион байгуулалтын оновчтой арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Нийслэлийн Засаг дарга М.Энхболд нарт үүрэг болгосугай.

7. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Олон улсын байгууллагуудын татвар хандивын тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "50. Олон улсын сэргээн засалтын холбоо" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 23 Улаанбаатар хот

Орон сууц хувьчлах тухай

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын үйлдвэрийн харьяа 48 айлын орон сууцыг хууль ёсоор эзэмшиж байгаа суугч эзэмшигчдэд нь хувьчлах ажлыг зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Дугаар 24 Улаанбаатар хот

2002 оныг Оюутны жил болгох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2002 оныг Оюутны жил болгон зарласугай.

2. Оюутны жилд хийх ажлыг зохион байгуулах Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор батлуулсугай.

3. Оюутны жилд хийх ажлын төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор батлуулсугай.

4. Оюутны жилийн ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж дүнг нь 2002 оны 12 дугаар сард Засгийн газарт танилцуулахыг Үндэсний хорооны дарга А.Цанжидад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,ХӨДӨЛМӨРИЙН САЙД БӨГӨӨД БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **Ш.БАТБАЯР**

ОЮУТНЫ ЖИЛД ХИЙХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
Гишүүд:	-Байгаль орчны дэд сайд; -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч; -Дархан-Уул аймгийн Засаг дарга; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд; -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд; -Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга; -Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга; -Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны залуучуудын хөгжлийн бодлого, зохицуулалтын асуудал хариуцсан мэргэжилтэн; -Батлан хамгаалахын дээд сургуулийн захирал; -Монголын оюутны холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор); -Монголын их, дээд сургуулиудын консорциумын ерөнхийлөгч (тохиролцсоноор); -"Оюутан төсөл" үндэсний төвийн тэргүүн (тохиролцсоноор); -Монголын соёл, урлагийн оюутны холбооны тэргүүн (тохиролцсоноор); -MCS группийн дэд захирал (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Боловсрол,соёл,шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газрын оюутны нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн.

Засгийн газрын 2002 оны 24 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ОЮУТНЫ ЖИЛД ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцан хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Төсөв /сая.төг/ /45.0/
1	Оюутны жилийн ажлын зохион байгуулалтын арга хэмжээ (нээлт, хаалт, сурталчилгаа, урамшуулал, "Шинэ зууны эзэд" цомыг их сургууль, коллежууд, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, бусад байгууллагаар аялуулах гэх мэт)-г авч хэрэгжүүлэх	Жилдээ	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын оюутны холбоо	8.0
2	Оюутанд үзүүлэх үндэсний нийтлэг хөнгөлөлтийн эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	Жилдээ	Үндэсний хороо	Дэд бүтцийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэр, худалдааны яам	
3	Оюутны хөнгөлөлтийн картын хэрэглээг үндэсний хэмжээнд нэвтрүүлэн олон улсын хөнгөлөлтийн жишиг нийцүүлэх ажлыг зохион байгуулах	2002 оны I улирал	Үндэсний хороо	Монголын оюутны холбоо	
4	Оюутанд хөнгөлөлттэй үнээр үйлчлэх асуудлыг судлан үзэж, хамтран ажиллах санал гаргасан аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулах	Жилдээ	Үндэсний хороо, Монголын оюутны холбоо	Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим	
5	Оюутны дотуур байрын менежмент, ашиглалт, хуваарилалт, ахуй нөхцөлийг сайжруулах талаар судалгаа хийж санал боловсруулан холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх	2002 оны II-Ш улирал	Үндэсний хороо	Төрийн өмчийн их сургууль, коллеж	1.5
6	"Эрүүл аж төрөх ёс" зөвлөлгөө өгөх оюутны төвийг Анагаах ухааны их сургуулийг түшиглэн байгуулж ажиллуулах	2002 оны Ш улирал	Үндэсний хороо	Анагаах ухааны их сургууль	
7	Эрүүл мэндийн даатгалын болон түүнд хамрагдах ач холбогдлыг сурталчлах арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах	Жилдээ	Үндэсний хороо	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	
8	Оюутнуудын эрүүл мэндийн даатгалын хураамжийг сургалтын төлбөртэй хамт авах асуудлын эрх зүйн зохицуулалтыг шийдвэрлэх замаар тэднийг ерхийн эмнэлгийн үйлчилгээнд хамруулах	Жилдээ	Үндэсний хороо	Эрүүл мэндийн яам	

9	Оюутны хүүхэд олноор хамрагддаг зарим цэцэрлэгийн ажиллах цагийн хуваарьт зохицуулалт хийх, амралтын өдрүүдэд ажиллах "Хүүхэд саатуулах анги" нээх замаар оюутнуудын сурч, хөдөлмөрлөх боломжийг нэмэгдүүлэх	2002 оны Ш улирал	Үндэсний хороо	Аймаг, нийслэлийн Засаг дарга	
10	МҮҮИС-ийн хичээлийн 2 дугаар байрны өмнөх талбайг "Оюутны талбай" болгох, Улаанбаатар хотод оюутнуудын хүчээр "Оюутны гудамж" тохижуулах асуудлыг шийдвэрлэх	2002 оны П-Ш улирал	Үндэсний хороо	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	2.0
11	Оюутнуудын идэвх санаачилгад тулгуурлан амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх ногоон бүсийг Улаанбаатар хотод байгуулж, тохижуулах	2002 оны П-IҮ улирал	Үндэсний хороо, Монголын оюутны холбоо	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	2.0
12	Урлаг, спорт, эрдэм шинжилгээний олон улсын арга хэмжээнд монголын оюутнууд болон оюутны байгууллагуудын төлөөллийг оролцоход дэмжлэг үзүүлэх	Жилдээ	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Гадаад хэргийн яам	5.0
13	Оюутны их семинарыг зохион байгуулж нэрт эрдэмтэн, улс төр болон нийгмийн зүтгэлтэн, бизнесмэн, уран бүтээлчдээр лекц уншуулж, зөвлөлгөө өгүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Үндэсний хороо	Монголын оюутны холбоо	0.5
14	Гадаад орнуудад хувийн шугамаар суралцаж байгаа монгол оюутнуудын талаар судалгаа хийж, мэдээллийн сан бүрдүүлэх	Жилдээ	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, гадаадад суралцагч монгол оюутны холбоо	
15	Гадаадад суралцаж байгаа оюутнуудыг эх орныхоо хөгжил дэвшилд татан оролцуулах, тэдгээрийн санал санаачилгыг нь дэмжин хамтарч ажиллах	Жилдээ	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Гадаад хэргийн яам	0.5
16	Оюутны "Мэдээллийн төв" ажиллуулж, интернэтээр дамжуулан гадаадад сурах боломж нөхцөлийн талаар судалгаа хийж, мэдээлэл түгээх, зөвлөлгөө өгөх	Жилдээ	Үндэсний хороо	Гадаадад суралцагч монгол оюутны холбоо	
17	Оюутны амьдрал ахуй, сурах орчин, нөхцөл, хүйсийн тэнцвэр зэрэг сургалтын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн талаар оюутнуудын дунд социологийн судалгаа явуулж, санал боловсруулж холбогдох газарт уламжлах	Жилдээ	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын оюутны холбоо	1.5
18	Олон улсын оюутны байгууллагуудын туршлагыг судалж, хамтын ажиллагааг өргөжүүлэх	2002 оны П-Ш улирал	Үндэсний хороо	Гадаад хэргийн яам	1.0

19	"Ургац хураалт", "Хот тохижуулалт", "Мянганы зам" зэрэг хөдөлмөрийн багтаамж ихтэй болон байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажилд оюутан залуучуудыг өргөнөөр оролцуулах арга хэмжээ авах	Жилдээ	Үндэсний хороо	Монголын оюутны холбоо	2.0
20	Оюутны эрдэм-шинжилгээ, судалгааны ажлыг дэмжих, улсын хэмжээний уралдаан зохион байгуулах, холбогдох журмыг боловсруулж хэрэгжүүлэх	2002 оны II-IV улирал	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2.0
21	"Эрдэм шинжилгээний шилдэг бүтээл"-ийн шагналыг бий болгож оюутны эрдэм шинжилгээний шилдэг бүтээлийг урамшуулдаг уламжлалтай болгох	2002 оны IV улирал	Үндэсний хороо	Монголын оюутны холбоо	2.5
22	Оюутнуудын оролцоотойгоор нийгмийн эмзэг бүлгийн болон ажил эрхлээгүй, төлбөрийн чадваргүй, тэнэмэл хүүхэд, залуучуудын дунд төрөл бүрийн албан бус сургалт явуулж, зөвлөгөө өгөх төвийг байгуулан үйл ажиллагаат нь тогтмолжуулах	2002 оны II улирал	Үндэсний хороо	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	1.0
23	Оюутан, залуучуудын дунд ДОХ, бэлгийн замын халдварт өвчин, биеэ үнэлэх, мансуурулах бодис, архи, тамхи хэрэглэх явдлаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх	Жилдээ	Үндэсний хороо	Эрүүл мэндийн яам	
24	Монгол Улсад оюутны байгууллага үүсэж, хөгжсөний 60 жилийн ойг "Чанартай боловсрол-амьдралын баталгаа" уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх	2002 оны IV улирал	Үндэсний хороо	Монголын оюутны холбоо	1.0
25	Дэлхийн Монгол туургатан оюутан, залуучуудын чуулга уулзалт, урлаг, спортын наадмыг Улаанбаатар хотод зохион байгуулах	2002 оны IV улирал	Үндэсний хороо	Гадаадад суралцагч монгол оюутны холбоо	7.0
26	Оюутны жилийн арга хэмжээ болон оюутны байгууллагын тухай баримтат кино бүтээх	2002 оны IV улирал	Үндэсний хороо	Монгол кино нэгтгэл	5.0
27	Оюутны жилийн үйл ажиллагаат сурталчилах хэвлэл, мэдээллийн алба /орон тооны бус/ байгуулан ажиллуулах	2002 оны IV улирал	Үндэсний хороо		
28	Их сургууль, коллежиудын дунд оюутны сурах орчныг сайжруулах, сургалтын чанарыг дээшлүүлэх, оюутны байгууллагын үйл ажиллагаат дэмжиж бодит туслалцаа үзүүлэх ажлыг өрнүүлэх	Жилдээ	Үндэсний хороо	Их сургууль, коллежиуд	
29	Монгол улсаас гадаадын их сургууль, коллежид суралцах оюутан, магистрант, докторантын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авах	Жилдээ	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, их сургууль, коллежиуд	

30	Оюутнуудыг суралцаж байгаа мэргэжлээр нь гадаад оронд дадлага хийлгэх боломжийг судалж, санал боловсруулах	Жилдээ	Үндэсний хороо	Гадаад хэргийн яам	
31	Гадаадын зарим орнуудтай дээд, дунд, мэргэжлийн боловсролын салбарын баримт бичгийг хүлээн зөвшөөрөлцөх талаар гэрээ, хэлэлцээр байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх	Жилдээ	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	
32	Оюутнууд чөлөөт цагаараа хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор "Оюутны хөдөлмөрийн бирж", "Хөдөлмөр зуучлалын алба"-ыг байгуулан ажиллуулах	2002 оны II улирал	Үндэсний хороо	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Монголын оюутны холбоо	1.5
33	Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу "Оюутны хотхон" (кампус) байгуулах асуудлыг судалж санал боловсруулах	2002 онд	Үндэсний хороо	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын оюутны холбоо, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч	
34	Оюутны түүхэн замналаар ном хэвлүүлэх	2002 оны IY улирал	Үндэсний хороо	МҮҮИС-ийн түүхийн тэнхим	1.0
35	Оюутны орлогыг нь нэмэгдүүлэн тэдгээрийг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжин урамшуулах	2002 оны II улирал	Үндэсний хороо	Монголын оюутны холбоо	
	Нийт дүн				45.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 25** **Улаанбаатар хот**

2002 оны улсын төсвийн орлого хуваарилалтын хувийг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2002 оны улсын төвлөрсөн төсвийн тухай хуулийн дагуу төсөвт төвлөрөх татварын орлогыг төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан бодит гүйцэтгэлд үндэслэн дараахь байдлаар төв, орон нутгийн төсөвт хуваарилахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай:

а/улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 80 хувийг Монгол Улсын хүн амд тухайн аймаг, нийслэлийн хүн амын эзлэх хувийн жингээр тооцон хавсралт ёсоор орон нутагт хуваарилан шилжүүлэг хийж байх;

б/тухайн аймаг, нийслэлээс улсын төвлөрсөн төсөвт төвлөрүүлсэн дотоодод үйлдвэрлэсэн архины онцгой албан татварын орлогын 50 хувийг аймаг, нийслэлийн төсөвт буцаан хуваарилж байх.

2. Улсын төвлөрсөн төсөвт татварын орлого төвлөрүүлэх тухай хууль тогтоомж зөрчсөн аймаг, орон нутагт тухайн зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд орлогын буцаан хуваарилалтыг хойшлуулж байсугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн байдал, үр дүнг 2002 оны 4 дүгээр сард Засгийн газарт танилцуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 25 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ДОТООДЫН БАРААНЫ НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ОРЛОГООС 2002 ОНД АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ХУВААРИЛАХ ХУВЬ

№	Аймаг, нийслэл	Хуваарилах хувь
1.	Архангай	4.0
2.	Баян-Өлгий	3.9
3.	Баянхонгор	3.5
4.	Булган	2.6
5.	Говь-Алтай	2.6
6.	Дорноговь	2.1
7.	Дорнод	3.1
8.	Дундговь	2.1
9.	Завхан	3.6
10.	Өвөрхангай	4.7
11.	Өмнөговь	2.0
12.	Сүхбаатар	2.3
13.	Сэлэнгэ	4.2
14.	Төв	4.1
15.	Увс	3.6
16.	Ховд	3.6
17.	Хөвсгөл	5.0
18.	Хэнтий	3.0
19.	Дархан-Уул	3.5
20.	Улаанбаатар	32.7
21.	Орхон	3.2
22.	Говьсүмбэр	0.6
Дүн		100

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 26 **Улаанбаатар хот**

Эрүүл мэндийн даатгалын 2002 оны хураамжийн хэмжээ, даатгалтай иргэний эмчилгээний зардлын дээд хязгаарыг тогтоох тухай

Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-т заасан даатгуулагчийн 2002 онд төлөх эрүүл мэндийн даатгалын сар тутмын хураамжийн хэмжээг тэдний цалин, хөдөлмөрийн хөлстэй адилтгах орлогын 6 хувиар, мөн зүйлийн 1 дэх хэсгийн 3-10-т заасан даатгуулагч болон хоригдлын эрүүл мэндийн даатгалын сар тутмын хураамжийн хэмжээг 300 төгрөгөөр, даатгалтай иргэний эмчилгээний зардлын дээд хязгаарыг 400000 төгрөгөөр тус тус тогтоож, 2002 оны 2 дугаар сарын 1-нээс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл мэндийн даатгалын 1997 оны хураамжийн хэмжээ, даатгалтай иргэдийн эмчилгээний зардлын дээд хязгаарыг тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 67 дугаар тогтоолын 4 дүгээр зүйл, "Эрүүл мэндийн даатгалын 1999 оны хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД БӨГӨӨД ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ш.БАТБАЯР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эрхлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 14 (251)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Дүрэм батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлах тухай*
- *Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2002 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны дөрөвдүгээр сарын 12 №14 (251)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

142. Дүрэм батлах тухай Дугаар 40 573
143. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай Дугаар 41 576

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

144. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлах тухай Дугаар 28 576
145. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2002 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай Дугаар 29 578
146. Зарим тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 30 584
147. Журам батлах тухай Дугаар 31 586

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Дугаар 40 Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх заалтыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1."Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм"-йг хавсралт ёсоор шинэчлэн батлуулсугай.

2.Дүрмийг шинэчлэн батлуулсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 08 дугаар зарлигаар батлагдсан "Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм"-йг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 40 дүгээр зарлигаар шинэчлэн батлав.

МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН ШАГНАЛЫН ТУХАЙ ДҮРЭМ

Нэг.**Нийтлэг үндэслэл**

1.Монгол Улсын иргэдийн авьяас билэг, оюуны бүтээлийг төрөөс шалгаруулан үнэлж Монгол Улсын төрийн шагнал олгож байна.

2.Төрийн шагналыг шинжлэх ухаан, танин мэдэхүйн шинэ онцгой туурвил, анхдагч шинэ техник, технологи, урлаг, утга зохиолын гоц содон нэгэн цогц, дан бүтээлд олгоно.

3.Төрийн шагналд хамтын бүтээл нэр дэвшиж байгаа бол нэр дэвшигчдийн бүрэлдэхүүн нь уг бүтээлийг туурвихад голлох үүрэгтэй оролцсон 3 хүртэл хүнтэй байхыг зөвшөөрнө.

4.Нэр дэвшиж буй бүтээлийн эрх зохих журмын дагуу баталгаажсан байхаас гадна, уг бүтээл нь мэргэжилтнүүд болон олон нийтийн хүртээл болж, дотоод гадаадад үнэлэгдсэн, Монгол улсын хөгжилд тодорхой хувь нэмэр оруулсан байвал зохино.

5.Төрийн шагналд нэр дэвшиж буй бүтээл нь урьд өмнө зохиогчийн хөдөлмөрийг үнэлж төрөөс олгосон шагналд хамаргдаагүй шинэ, эсвэл шинэчилсэн бүтээл байна.

6.Тухайн хүнд улсын цол хүртээсэн хөдөлмөрийн үнэлгээнд орсон бүтээлийг дахин төрийн шагналд нэр дэвшүүлж болохгүй.

7.Төрийн шагналыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар хүртээнэ.

8.Монгол Улсын төрийн шагналыг нэг жилд 5 хүртэл бүтээлд хүртээж болно.

Хоёр.**Бүтээлийг төрийн шагналд нэр дэвшүүлэх**

1.Шинжлэх ухаан, техник, технологийн бүтээлүүдийг их, дээд сургууль, мэргэжлийн хүрээлэнгүүдийн эрдмийн зөвлөлийн хурлаар хэлэлцэж, ШУА-ийн холбогдох салбарын Бага чуулганаас; урлагийн бүтээлүүдийг уран бүтээлийн эвлэл холбоодын хамтын удирдлагын хурлаар хэлэлцэж Соёл урлагийн их сургуулийн эрдмийн зөвлөлийн хурлаас; утга зохиолын бүтээлийг утга зохиолын холбогдох үндэсний төвийн хурлаар хэлэлцэж зохиолчдын эвлэлүүд болон мэргэжлийн холбоодын удирдах зөвлөлүүдийн хамтарсан хурлаас тус тус нэр дэвшүүлнэ.

2.Нэр дэвшүүлэх хуралдааны хугацааг урьдчилан нээлттэй зарлаж, зохих бэлтгэл хангасны үндэсэн дээр нэг л удаа хийх бөгөөд нэг салбар чиглэлийн хэд хэдэн бүтээлээс нэгийг л шалгаруулан тодорхойлно.

3.Нэр дэвшүүлэх хуралдаан ирвэл зохих гишүүдийн тавны дөрөөс доошгүй нь хүрэлцэн ирвэл хүчинтэйд тооцно. Нэр дэвшүүлэх хуралдаанд Ерөнхийлөгчийн Тамгын газрын төлөөллийг заавал оролцуулна.

4.Нэр дэвшсэн бүтээл нь шат шатны хуралдаанд оролцогсдын дөрөвний гурваас доошгүй хувийн саналаар дэмжигдсэн байвал зохино. Саналыг нууцаар хураана.

5.Саналын хуудсыг битүүмжлэн, тэмдэг дарж, тооллогын комиссын тогтоолын хамт шат шатны хуралдааны албан тэмдэглэлд хавсарган дагалдуулна.

6.Нэр дэвшүүлэх хурлаас дэмжигдсэн бүтээлүүдэд тухайн салбар хариуцсан сайдын зөвлөлийн хуралдаанаас санал дүгнэлт гаргасан байна.

7.Монгол Улсын Ерөнхийлөгч Төрийн шагналд нэр дэвшүүлж болно. Иймд бүтээлийг мөн эл дүрмийн дагуу судлан шинжилж шийдвэрлэнэ.

8.Төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлийг энэ дүрмийн хавсралтад заасан бүрдүүлбэл зохих баримт бичгүүдийн хамт тухайн оны 4 дүгээр сарын 20-ны дотор Оюуны өмчийн газарт хүргүүлнэ. Оюуны өмчийн газар баримт бичгийн бүрдлийг бүртгэн үзээд, бүтээлд тодорхойлолт гаргаж ажлын 10 хоногийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ.

9.Тамгын газар баримт бичгүүдийг нарийвчлан хянаж нягтлаад энэ дүрмийн шаардлагад бүрэн нийцсэн бүтээлүүдийг ажлын хэсгүүдэд хүлээлгэн өгнө.

10.Баримт бичгийн бүрдэл дутуу, зөрчилтэй, дүрмийн заалтад тохироогүй бүтээлийг Тамгын газраас тухайн жилийн шалгаруулалтад оруулахгүйгээр нэр дэвшүүлсэн газарт буюу зохиогчид буцаах эрхтэй.

11.Зохиогч бүтээлээ аль ч шатанд хэлэлцүүлэг, шийдвэр гаргахаас өмнө зүгүлэн татах эрхтэй.

12.Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэд байгуулагдах ажлын хэсгүүдийн хуралдааныг хэлэлцэгдээд зохих саналын дэмжлэг авч чадаагүй бүтээлийг 2 жилийн дараагаас дахин нэг удаа дэвшүүлж болно. Ингэхдээ эл дүрмийн заалтыг баримтална.

Гурав.**Нэр дэвшсэн бүтээлд сонгон шалгаруулалт, хянан магадлагаа хийх**

1.Төрийн шагнал хүртээх бүтээлийг судлан шалгаруулах үүднээс Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэргэд:

-Төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлээс сонгон тодруулах ажлын хэсэг;

-Сонгон тодруулсан бүтээлд хянан магадлагаа хийх шинжээчийн ажлын хэсгийг тус тус

жил бүр томилон ажиллуулна.

2.Ажлын хэсгүүдийг байгуулахдаа:

а/ажлын хэсгүүдэд өмнөх жилийн бүрэлдэхүүнээс гуравны нэг хүртэл хувийг нь оруулж болно;

б/төрийн шагнал хүртээх бүтээлийг сонгон тодруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан хүнийг шинжээчийн ажлын хэсэгт оруулж болно;

в/төрийн шагналд бүтээл нь нэр дэвшсэн хүнийг ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүнд оруулахгүй.

3.Ажлын хэсэг тус бүр 15-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд нарийн бичгийн дарга нь Ерөнхийлөгчийн Тамгын газрын төлөөлөл байна.

4.Бүтээлийг сонгон тодруулах ажлын хэсгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын захиramжаар байгуулна.

5.Ажлын хэсэг нь шинжлэх ухаан, технологи, урлаг, утга зохиолын тэргүүлэх эрдэмтэд, мэргэжилтэн, төрийн шагналтан, нэр хүнд бүхий хүмүүсээс бүрдэнэ.

6.Сонгон тодруулах ажлын хэсэг төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлүүдийг Ерөнхийлөгчийн Тамгын газраас хүлээн авч шалгаруулалтад оруулна.

7.Ажлын хэсэг төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлд судалгаа хийсэн дүн, сонгон тодруулсан бүтээлийн тухай танилцуулгыг тухайн оны 6 дугаар сарын 15-ны дотор Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ.

8.Жүрмын дагуу явагдсан эхний шатны шалгаруулалтын дүнд үндэслэн ажлын хэсгийн сонгон тодруулсан бүтээлийг Ерөнхийлөгчийн Тамгын газраас олон нийтэд зарлана.

9.Төрийн шагнал хүртээхээр сонгон тодруулсан бүтээлд хянан магадлагаа хийх шинжээчийн ажлын хэсгийг Ерөнхийлөгчийн захиramжаар томилно. Шинжээчийн ажлын хэсэгт тухайн салбарын тэргүүлэх эрдэмтэн, мэргэжилтнүүдийг оруулна.

10.Шинжээчийн ажлын хэсэг нь сонгон тодруулах ажлын хэсгээс ирүүлсэн бүтээлүүдэд хянан магадлагаа хийж хоёр дахь шатны шалгаруулалтад оруулан тухайн бүтээлд төрийн шагнал олгохыг дэмжих эсэх тухай хэлэлцэж, шийдвэрлэнэ. Төрийн шагнал олгохыг дэмжсэн бүтээлийн тухай үндэслэл, дүгнэлт, саналаа шагнал гардуулах хугацаанаас 14-өөс доошгүй хоногийн өмнө ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга нар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

11.Ажлын хэсгүүд төрийн шагнал хүртээх бүтээлтэй танилцан шалгаруулахдаа мэргэжлийн байгууллага, хүмүүс, олон нийтийн санаа бодол, бүтээлийн талаар гарсан санал, шүүмжийг сайтар харгалзвал зохино.

12.Төрийн шагналд нэр дэвшиж олон нийтэд зарлагдсан бүтээлийн талаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд саналаа Ерөнхийлөгчийн Тамгын газарт ирүүлнэ. Саналыг 9 дүгээр сарын 1-ний дотор бүртгэж авна.

13.Ажлын хэсгүүд Ерөнхийлөгчийн захиramжаар батална "Монгол Улсын төрийн шагналд нэр дэвшсэн бүтээлээс сонгон тодруулах болон сонгон тодруулсан бүтээлд хянан магадлагаа хийх шинжээчийн ажлын хэсгүүдийн ажиллах журам"-ыг мөрдөнө.

14.Төрийн шагнал хүртээх бүтээлийг сонгон тодруулах болон хянан магадлагаа хийхээр томилогдсон хүмүүст ажлын хөлс олгоно.

Дөрөв.**Төрийн шагнал олгох шийдвэр гаргах, шагналыг гардуулах**

1.Монгол Улсын Ерөнхийлөгч шинжээчийн хэсгийн үндэслэл, саналыг судалж, зөвшөөрвөл Монгол Улсын төрийн шагнал хүртээх тухай зарлиг гаргана.

2.Төрийн шагнал хүртээхээр шинжээчийн ажлын хэсгээс санал болгосон бүтээлүүдийн талаар Засгийн газарт Ерөнхийлөгчийн Тамгын газраас танилцуулна.

3.Төрийн шагналыг тухайн жилийн намрын дунд сарын шинийн 17-ны билэг дэмбэрэлт едер Төрийн хүндэтгэлийн өргөөнд Монгол Улсын Ерөнхийлөгч ёс төгөлдөр гардуулна.

4.Төрийн шагнал хүртэгчдэд энгэрийн тусгай тэмдэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн гарын үсэг бүхий төрийн шагналтны үнэмлэхийг дагалдах мөнгөний хамт олгоно. Шагналыг дагалдах мөнгөний хэмжээ дан бүтээлд 20 цэн, хамтын зохиогчтой бүтээлд 30 цэн алтны үнэтэй тэнцэхүйц байна.

5.Төрийн шагнал хүртсэн бүтээлүүдийн тодорхойлолт, холбогдох бусад баримт бичгийг Ерөнхийлөгчийн Тамгын газрын архивт хадгална.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 40 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын Төрийн шагналын тухай дүрэм"-ийн хавсралт

ТӨРИЙН ШАГНАЛД НЭР ДЭВШСЭН БҮТЭЭЛИЙГ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗАР ИРҮҮЛЭХДЭЭ БҮРДҮҮЛБЭЛ ЗОХИХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

1.Материал хүргүүлэх тухай нэр дэвшигчийн ажилладаг байгууллага, газрын албан тоот;

2.Нэр дэвшигчийн анкет /маягт № 1/;

3.Нэр дэвшигчийн ажил байдлын тодорхойлолт;

4.Нэр дэвшсэн бүтээл, бүтээлийн тодорхойлолт, танилцуулга /оюуны үнэ цэнэ, шинэлэг санаа, сэдэв ойролцоо бусад бүтээлээс ялгаарах давуу, ач холбогдол, практик үр өгөөж, эдийн засгийн тооцоо, хамрах хүрээ, чанар, хүртэц, нөлөө гэх мэт/;

5.Нэр дэвшсэн бүтээл гадаад, дотоодод үнэлэгдсэн байдал;

6.Нэр дэвшүүлсэн газрын тогтоол;

7.Бүтээлийг шат шатанд хэлэлцсэн хуралдааны бүрэн тэмдэглэл, саналын хуудсыг битүүмжлэн дагалдуулсан тооллогын комиссын тогтоол;

8.Тухайн салбар хариуцсан сайдын зөвлөлийн хуралдаанаас гаргасан санал, дүгнэлт (хуралдааны тэмдэглэл, үндэслэл, үр ашгийн тооцоо зэргийг хавсаргаж болно);

9.Нэр дэвшигчийн бусад бүтээлийн жагсаалт;

10.Хэрэглэгч, сонирхогч байгууллага, хүмүүсийн санал, шүүмж;

11.Холбогдох бусад баримт бичиг /шинэ бүтээлийн гэрчилгээ, эрдмийн зэрэг, цолны үнэмлэхийн хуулбар гэх мэт/;

12.Оюуны өмчийн газрын тодорхойлолт.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 4 дүгээр сарын 3–ны өдөр Дугаар 41 **Улаанбаатар хот**

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 63 дугаар зүйлийн 4, 5 дахь заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дорноговь аймгийн шүүхийн шүүгч Дашдэлгэгийн Улааныг эрүүгийн хэрэгт сэжигтнээр татаж шалгах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг нь түдгэлзүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н. БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 26–ны өдөр Дугаар 28 **Улаанбаатар хот**

Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын 4 дүгээр зүйлийн 7 дахь хэсгийн 5 болон Хот байгуулалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө"-г хавсралтаар заасан бүрдэлтэйгээр батлагдсугай.

2. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболдод даалгасугай.

а/ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалд тусгагдсан хотжилт эрчимтэй хөгжих, хотжилт эрчимтэй бус буюу аж ахуйг хязгаарлагдмал чиглэлтэй хөгжүүлэх, хөдөө аж ахуйг тэргүүлэх чиглэлтэй хөгжүүлэх бүс гэсэн хот байгуулалтын гурван бүсчлэлээр горимлож нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалтын тасралтгүй үйл ажиллагаа явуулсугай;

б/чиг үүрэг, зориулалт, барилгажилтын өндөр, ландшафтын зохион байгуулалт гэсэн гурван ангиллаар Улаанбаатар хотын барилгажсан газар нутгийн судалгааны П үе шатны төсөл, газар ашиглалтын төлөвлөгөөг боловсруулж барилгажилтын орон зайн төлөвлөлтийг сайжруулах арга хэмжээ авч ажилласугай;

в/нийслэлийн алслагдсан дүүрэг, дагуул хот, тосгоныг эрчимтэй хөгжүүлэн хүн амын хэт төвлөрлийг үе шаттайгаар сааруулах чиглэл баримтлан ажилласугай.

3. Нийслэлийн хүн амын ундны усны эх үүсвэрийн нөөцийг нарийвчлан тогтоож хамгаалах, усан хангамжийн инженерийн барилга байгууламж барих бэлтгэл ажлыг эхлүүлэх, инженерийн дэд бүтэц, зам, тээврийн асуудлыг боловсронгуй болгох талаар арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Байгаль орчны сайд У.Барсболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт тус тус даалгасугай.

4. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд холбогдох норм, дүрмийг шинэчлэн боловсруулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт үүрэг болгосугай.

5. Хот байгуулалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтын дагуу Улаанбаатарын бүс нутгийн хөгжлийн төсөл, ерөнхий төлөвлөгөөний үе шатны төсөл боловсруулж, тэдгээрийн хэрэгжилтэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон нийслэлийн төсвөт тусгах, гадаад, дотоодын байгууллага, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах замаар санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд нарт даалгасугай.

6.Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрэм, журмыг салбарын бодлоготой уялдуулан боловсруулж мөрдүүлэхэд мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2002 оны 28 дугаар тогтоолын хавсралт

"УЛААНБААТАР ХОТЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ"-НИЙ БҮРДЭЛ

1. ЗУРАГЛАЛЫН МАТЕРИАЛ:

А. Нийслэлийн хилийн цэс болон хот орчмын хөгжлийн хандлага.

1. АБ-1. Нийслэлийн ба хот орчмын бүсийн хот байгуулалтын хөгжлийн одоогийн байдал, хот орчмын экологи, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. М1: 100 000
2. АБ-2. Нийслэл хот орчмын бүсийн хот байгуулалтын хөгжлийн одоогийн байдал, нутаг дэвсгэрийн иж бүрэн үнэлгээ. М1: 100 000
3. АБ-3. Нийслэл хот орчмын бүсийн хүрээлэн буй орчин, байгаль хамгаалал. М1: 100 000
4. АБ- 4. Нийслэл хот орчмын бүсийн хөгжлийн тойм. М 1: 50 000
5. АБ- 5. Нийслэлийн хот байгуулалт, газар ашиглалтын хөгжлийн тойм. М1: 100 000
6. АБ- 6. Нийслэл хот байгуулалтын хөгжлийн чиг хандлага. М1: 100 000
7. АБ- 7. Нийслэлийн бүлэг суурингийн тоглолцоо, ангилал. М1: 100 000
8. АБ- 8. Хотын гадна тээврийн сүлжээ. М1: 100 000
9. АБ- 9. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, дулаан хангамж. М1: 100 000
10. АБ-10. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, цахилгаан хангамж. М1: 100 000
11. АБ-11. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, усан хангамж, ариутгах татуурга. М1: 100 000
12. АБ-12. Нийслэлийн инженерийн дэд бүтэц, холбоожуулалт. М1: 100 000
13. АБ-13. Нийслэлийн тусгай хамгаалалттай газар нутаг.
14. АБ-14. Нийслэлийн түүх, соёлын дурсгалын зүйлийн хадгалалт. М1: 100 000
15. АБ-15. Нийслэл хот орчмын аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт. М1: 100 000

Б. Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө.

1. В-1. Хотын хөгжлийн одоогийн байдал, хот орчмын экологи, хот байгуулалтын иж бүрэн

үнэлгээ. М1: 100 000
2. В-2. Хотын хөгжлийн одоогийн байдал, хот орчмын экологи, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. М1: 100 000
3. В-2.1. Хүрээлэн байгаа байгаль орчны бохиндын үнэлгээ. М1: 100 000
4. В-2.2. Газар нутгийн ашиглалтын байдал. М 1:25 000
5. В-2.3. Хүн амын орон суучны хангамжийн түвшинд өгөх үнэлгээ. М 1: 25 000
6. В-2.4. Ландшафтын шинж байдалд өгөх үнэлгээ. М 1: 25 000
7. В-2.5. Улаанбаатар хотын барилгажсан газар нутгийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. М 1: 25 000
8. В-2.6. Газар нутгийн үүрэг зориулалт, бүсчлэлийн төрөл. М 1: 25 000
9. В-3. Улаанбаатар хот /тойм/. М 1: 25 000
10. В-4. Улаанбаатар хот 2020 ерөнхий төлөвлөгөө. М 1:5000
11. В-5. Дэвсгэр нутаг газар эдэлбэрийн хуваарилалт. М 1: 10 000
12. В-6. Хүрээлэн байгаа байгаль хамгаалал. М 1: 25 000
13. В-7. Хотын гудамж сүлжээ. М 1: 25 000
14. В-8. Зам тээврийн сүлжээ. М 1: 10 000
15. В-9. Цэцэрлэгжилт, ногоон байгууламж. М 1:10 000
16. В-10. Улаанбаатар хотын дулааны хангамж. М 1: 25 000
17. В- 11. Улаанбаатар хотын дулааны хангамж. М 1: 50 000
18. В-12. Улаанбаатар хотын цахилгаан хангамж. М 1: 25 000
19. В-13. Улаанбаатар хотын цахилгаан хангамж. М 1: 50 000
20. В-14. Улаанбаатар хотын усан хангамж. М 1: 25 000
21. В-15. Улаанбаатар хотын ариутгах татуургa. М 1: 25 000
22. В-16. Улаанбаатар хотын холбоожуулалт. М 1: 25 000
23. В-17. Улаанбаатар хотын инженерийн бэлтгэл арга хэмжээ. М 1: 25 000
24. В-18. Түүх, соёлын дурсгалт барилга, цогцолборын зэрэглэл байршил. М 1: 25 000

В. Нийслэлийн бүс нутгийн үзэл баримтлал.

1. Тулгуур төв бүлэг суурингийн тогтолцоо /Улаанбаатар дэд бүс/. М 1: 500 000
2. Дэд бүтцийн хөгжлийн хандлага /Улаанбаатар дэд бүс/. М 1: 500 000
3. Ашигт малтмалын ордын мужлал. М 1: 500 000
4. ХАА-н хөгжлийн хандлага /Мал аж ахуй/. М 1: 500 000
5. ХАА-н хөгжлийн хандлага /Газар тариалан/. М 1: 500 000
6. Амралт, аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлт. М 1: 500 000
7. Эрчим хүчний одоогийн байдал /1998 он/. М 1: 500 000
8. Хүн амын нутагшилт, хот суурингийн үүргийн ялгаа /1998 он/. М 1: 500 000
9. Нийслэл, нийслэлийн ногоон бүсийн нутаг дэвсгэр /1998 оны байдлаар/. М 1: 100 000
10. Багануур, Багахангай дүүрэг. М 1: 100 000

2. БИЧИГЛЭЛИЙН МАТЕРИАЛ:

1. I боть. Улаанбаатар хотын хөгжлийн одоогийн байдал. 2000 он. /294 хуудас/
2. II боть. Улаанбаатар хотын барилгажсан газар нутгийн хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ. 2000 он. /419 хуудас/
3. III боть. Улаанбаатар хотын хөгжлийн хэтийн төлөв. /2000 он/ /359 хуудас/
4. IY боть. Нийслэлийн хилийн цэс болон хот орчмын бүсийн хөгжлийн хэтийн төлөв. 2000 он. / 209 хуудас/
5. Y боть. Нийслэл хот орчмын бүсийн хөгжлийн үзэл баримтлал. 2000 он. /167 хуудас/
6. YI боть. Улаанбаатар хотын хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээ. 2001 он. /171 хуудас/

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 27–ны өдөр **Дугаар 29** **Улаанбаатар хот**

Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2002 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2002 онд хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр, улсын төсвийн болон замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зам, гүүрийн барилга байгууламж, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батална гай.

2. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц, ашиглалтад оруулах хугацаа, санхүүжилтийн байдалд хяналт тавьж, энэ тогтоолоор батлагдсан хөрөнгийн дунд багтаан шаардлагатай зохицуулалт хийж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2002 оны 29 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2002 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

№	Төсөл, арга хэмжээний нэр, хуч чадал, байршил	Эхлэх, дуусах хугацаа	Төсөвт өртөг	Үүнээс: 2002 онд санхүүжих	Ерөнхий захиалагч
	А	1	2	3	4
I	**Эрчим хүчний салбарын дүн**		**26982.2**	**6075.7**	
I.1	**Дулааны цахилгаан станц, төвлөрсөн зуух**		**10271.6**	**838.0**	
1	Дулааны цахилгаан станцын 2 дахь шатны шинэчлэлтийн дотоод эх үүсвэр. Чойбалсан, Дорнод	1998-2003	1085	210	ДБЯ
2	ХБНГУ-ын бүцалтгүй тусламжаар хэрэгжиж буй "Цахилгаан станцын ажилтнуудын сургалт" төслийн дотоод эх үүсвэр. Улаанбаатар	2001-2005	93.6	23	ДБЯ
3	АХБ-ны зээлээр хэрэгжиж буй "Улаанбаатар хотын дулааны үр ашиг" төслийн дотоод эх үүсвэр. Улаанбаатар	2002-2003	5300	40	ДБЯ
4	Дулааны 7а, 10б гол шугамын өргөтгөл /ф1000мм, 6.1 км/ Улаанбаатар	2002-2006	3400	330	НЗДТГ
5	Дулааны станцын КЕ 25-14 с маркийн гурван зуухны экран хоолойн системийг шинэчлэх. Сайншанд, Дорноговь	2002-2002	75	75	ДГ ЗДТГ
6	Спорт, сургалтын комплексийн гадна дулааны шугам. Мөрөн, Хөвсгөл	2002-2002	60	60	ХӨ ЗДТГ
7	Сумын төвийн гадна инженерийн дулааны шугамын шинэчлэл. Түмэнцогт, Сүхбаатар	2002-2003	150	50	СҮ ЗДТГ
8	Бага оврын халааltын зуух барих. Тосонцэнгэл, Завхан	2002-2003	108	50	ЗА ЗДТГ
I.2	**6,15, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөв**		**5182.1**	**3231.1**	
1	Ховд аймаг-Дуут сум, 61.1 км, 35 кВ, 1х0.4мВа. Ховд	2001-2002	709	509	ДБЯ
2	Алтанбулаг-Баян-Өнжүүл сум, 83.3км, 35 кВ, 1х0.4 мВа.Төв	2001-2002	831.4	581.4	ДБЯ
3	Батноров-Баян-Овоо сум, 48 км, 35 кВ, 1х1 мВа. Хэнтий	2002-2002	362	362	ДБЯ
4	Баруун-Урт-Уулбаян сум, 80 км, 35 кВ, 1х1 мВа. Сүхбаатар	2002-2003	1040	100	ДБЯ
5	Өндөр-Улаан-Чулуут сум, 99 км, 35 кВ, 1х1 мВа. Архангай	2002-2003	718	257	ДБЯ
6	Хүрмэн-Баяндалай сум, 48 км, 35 кВ, 1х0.4 мВа. Өмнөговь	2002-2002	350	350	ДБЯ
7	Хулд-Дэлгэрхангай сум, 59 км, 15 кВ, 1х0.25 мВа. Дундговь	2002-2002	450	450	ДБЯ
8	Өлгий-Наранбулаг сум, 61 км, 35 кВ, 1х0.16, 1х0.1 мВа. Увс	2002-2002	410	410	ДБЯ
9	Өлгий-Алтанцөгц сум, 6.7 км, 35 кВ, 1х 0,4 мВа. Баян-Өлгий	2002-2002	90	90	ДБЯ
10	Баянхонгор-Эрдэнэцогт сум, 24 км, 6 кВ, 1х0.16мВа. Баянхонгор	2002-2003	162	62	ДБЯ
11	НӨАТ-ын өөрчлөлтийн зөрүү (Хэнтийн Өмнөдэлгэр, Өвөрхангайн Баянгол, Дундговийн Луус, Дорноговийн Алтанширээ)	2002-2002	59.7	59.7	ДБЯ
I.3	**110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд өртөв**		**5553.2**	**1422.8**	

	А	1	2	3	4
1	Сайншанд-Замын-Үүд сум, 196.3 км, 110 кВ, 1х10 мВа. Дорноговь	2001-2003	3233.2	1272.6	ДБЯ
2	Дергөнийн УЦС-Мянгад сум, 76 км, 110 кВ, 2х10 мВа. Ховд	2002-2003	2320	150.2	ДБЯ
I.4	**Сэргээгдэх эрчим хүч**		**5975.3**	**583.8**	
	а/ Нар, салхины эрчим хүч		**1300**	**100**	
1	Нарны эх үүсвэр ашиглан малчин өрхийг эрчим хүчээр хангах	2001-2005	1300	100	ДБЯ
	б/ Усан цахилгаан станц		**4675.3**	**483.8**	
1	Усан цахилгаан станц, 150 кВт, 10 кВ-ын 5 км шугам. Мөнххайрхан, Ховд.	2001-2002	374.8	274.8	ДБЯ
2	Тайширшын усан цахилгаан станц, 8 мВт. Хүвөйтийн сангийн зээлийн дотоод эх үүсвэр. Говь-Алтай.	2001-2004	513.5	100	ДБЯ
3	Усан цахилгаан станц, 1.2 мВт. Үенч, Ховд.	2002-2005	1070	70	ДБЯ
4	Чаргайтын УЦС-ын бэлтгэл ажил, Хөвсгөл.	2002-2005	2700	32	ДБЯ
5	Данийн Засгийн газрын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх Эрдэнэт-Булганы УЦС-ын дотоод эх үүсвэр, Хөвсгөл.	2002-2003	17	7	ДБЯ
II	**Түлш**		**110**	**60**	
1	Олонбулагийн нүүрсний уурхай, (10-15 мянган тн, жилд) Үенч, Ховд.	2001-2002	110	60	ДБЯ
III	**Барилга, хот байгуулалт, нийтийн аж ахуй**		**6426.8**	**901.5**	
1	Аймгийн төвийн үерийн усны далангийн байгуулалж, Дархан-Уул.	2002-2003	100	50	ДА ЗДТГ
2	Аймгийн төв, сумдын нийтийн халуун ус шинээр барих, шинэчлэлт хийх	2001-2004	1875	380	ДБЯ
3	Хятадын Засгийн газрын буцалтгүй тусламжаар барих (ахмадууд болон төрийн ажилтны) орон сууцны барилгын гадна инженерийн шугам сүлжээ, Улаанбаатар	2002-2003	150	80	ДБЯ
4	"Орон нутгийн НААУ-г сэргээн хөгжүүлэх" төслийн Монголын талын хөрөнгө	1998-2002	1533.1	70	ДБЯ
5	Бохир усны шугамын дуусгал. 3,1 км Улаанбаатар	2000-2002	867.2	20	ДБЯ
6	Хэлмэгдсэн иргэдэд олгох орон сууц	2001-2004	400	100	ДБЯ
7	Бохир усны шугам, 3.5 км , Зайсан, Улаанбаатар	2002-2003	171.5	71.5	ДБЯ
8	ЗДТГ-ын барилга, Сэвсэг, Баян-Өлгий	2002-2002	30	30	БӨ ЗДТГ
9	Парламентын нэгдсэн байрны зураг төсөл боловсруулах, УИХ -ын гишүүдэд орон сууц худалдан авах	2001-2004	1300	100	УИХ
IY	**Аялал жуулчлал**		**95**	**60**	
1	УБ хотод жуулчдад зориулсан гудамж, талбай байгуулах /мэдээллийн төв, техник хэрэгсэл, зам талбай байгуулах, зураг төсөл боловсруулах/	2002-2003	75	40	ДБЯ
2	"Монголын соёлын парк"-ийн зураг төсөл	2002-2002	20	20	ДБЯ
Y	**Тээвэр**		**924**	**300**	
1	Нисэх буудлын барилга, Баян-Өлгий аймаг	2001-2004	924	300	ДБЯ
YI	**Холбоо**		**61**	**61**	
1	Засгийн газрын ордны холбооны сүлжээний дотоод монтажийг шинэчлэх төсөл	2002-2002	50	50	ТЗҮААЭГ
2	ХХААЯ-ыг нэгдсэн сүлжээнд холбох.	2002-2002	11	11	ХХААЯ
YII	**Аж үйлдвэр**		**759**	**559**	
	Цементийн үйлдвэрийн барилгын дуусгал, (жилд 15000 тн) Жаргалант, Ховд	2001-2002	759	559	ДБЯ

	А	1	2	3	4
YIII	**Боловсрол, соёл, шинжлэх ухаан**		**4998**	**1681.4**	
1	Сургуулийн барилгын дуусгал, 560 суудал. Өлгий, Баян-Өлгий	2000-2003	476.6	150	БСШУЯ
2	Сургуулийн барилгын дуусгал, 240 суудал. Цэзл, Төв	2001-2002	175.2	75.2	ТӨ ЗДТГ
3	Сургуулийн барилгын дуусгал, 320 суудал. Гурванбулаг, Баянхонгор	2001-2003	303.5	180	БСШУЯ
4	Сургуулийн барилга, 640 суудал. Есөнбулаг, Говь-Алтай	2002-2003	750	200	БСШУЯ
5	Сургуулийн өргөтгөл, 240 суудал. Булган, Булган.	2002-2003	350	100	БСШУЯ
6	Сургуулийн дуусгал, 640 суудал. Баруун-Урт, Сухбаатар	2002-2003	450	100	БСШУЯ
7	Сургуулийн дуусгал, 160 суудал. Цэцэрлэг сум, Могой баг, Хөвсгөл	2002-2003	285	50	БСШУЯ
8	II-10 жилийн сургуулийн барилгын өргөтгөл, 928 суудал, Сайншанд, Дорноговь	2002-2003	620	220	БСШУЯ
9	Сургуулийн барилга, 320 суудал. Уянга, Өвөрхангай	2002-2003	250	50	БСШУЯ
10	Сургуулийн спорт заал, Нөмрөг, Завхан	2002-2003	75	58.5	БСШУЯ
11	АХБ-ны "Боловсролын салбарын хөгжил хөтөлбөр-2"-ийн Монголын талын хөрөнгө.	2002-2004	480	160	БСШУЯ
12	"Жайка"-гийн шугамаар хэрэгжих жижиг засварын ажлын Монголын талын хөрөнгө (15%)	2002-2004	99	33	БСШУЯ
13	Сургуулийн барилга,320 суудал. Цагаанхайрхан, Увс	2001-2002	189.7	29.7	БСШУЯ
14	Сургуулийн барилгын өргөтгөл. Цагааннуур, Сэлэнгэ	2002-2003	85	60	БСШУЯ
15	Сургуулийн спорт заалын дуусгал. Цагаандэлгэр, Дундговь	2002-2002	20	20	БСШУЯ
16	Сургуулийн спорт заалын дуусгал. Яруу, Завхан	2002-2003	88	40	БСШУЯ
17	Сургуулийн дотуур байрны дуусгал. Эрдэнэдалай, Дундговь	2002-2003	100	50	БСШУЯ
18	Сургуулийн дотуур байрны дуусгал. Сэлэнгэ, Булган	2002-2003	70	40	БСШУЯ
19	Соёлын төвийн барилгын дуусгал. Эрдэнэбулган, Хөвсгөл	2002-2003	60	30	БСШУЯ
20	Соёлын төвийн барилгын дуусгал. Архуст, Төв	2002-2003	71	35	БСШУЯ
IX	**Эрүүл мэнд**		**3021.1**	**1290**	
1	Сумын хүн эмэлгийн барилга, 10 ор. Цахир, Архангай	2002-2002	90	90	ЭМЯ
2	Сумын хүн эмэлгийн барилга, 15 ор. Улаанхус, Баян-Өлгий	2002- 2002	100	100	ЭМЯ
3	Сумын хүн эмэлгийн барилгын засвар шинэчлэлт, 15 ор. Баянцагаан. Баянхонгор	2002-2002	50	50	ЭМЯ
4	Сумын хүн эмэлгийн барилгын засвар шинэчлэлт, 15 ор. Богд, Баянхонгор,	2002-2002	40	40	ЭМЯ
5	Сумын хүн эмэлгийн барилга, 10 ор. Бугат, Говь-Алтай	2002-2002	90	90	ЭМЯ
6	Сумын хүн эмэлгийн барилга, 15 ор. Тэлмэн, Завхан	2002-2002	100	100	ЭМЯ
7	Сумын хүн эмэлгийн барилга, 15 ор. Уянга, Өвөрхангай	2002-2002	90	90	ЭМЯ
8	Сумын хүн эмэлгийн барилга, 15 ор. Зүүнхангай, Увс	2002- 2002	120	120	ЭМЯ
9	Сумын хүн эмэлгийн барилга, 15 ор. Зэрэг, Ховд	2002-2002	100	100	ЭМЯ

	А	1	2	3	4
10	Сумын хүн эмнэлгийн барилга, 10 ор. Хөлөнбуйр, Дорнод	2002-2002	90	90	ЭМЯ
11	Сумын хүн эмнэлгийн барилга, 15 ор. Гурвантэс, Өмнөговь	2002-2003	100	70	ЭМЯ
12	Сумын хүн эмнэлгийн барилга, 15 ор. Батширээт, Хэнтий	2002-2002	100	100	ЭМЯ
13	Сумын хүн эмнэлгийн барилга, 15 ор. Эрдэнэцагаан, Сүхбаатар	2002-2002	110	110	ЭМЯ
14	"Эрүүл мэндийн салбарын хөгжил" хөтөлбөрийн Монголын талын хөрөнгө	1998-2002	1774.1	100	ЭМЯ
15	Сумын хүн эмнэлгийн барилга, 10 ор. Өргөн, Дорноговь	2002-2003	67	40	ДГ ЗДТГ
X	**Батлан хамгаалах**		**352**	**170**	
1	015-р ангийн цэргийн байр, штаб, гал зуухны барилга, Хужирбулан. Улаанбаатар	2002-2003	192	90	БХЯ
2	Цэргийн төв эмнэлгийн өргөтгөл. Улаанбаатар	2002-2003	160	80	БХЯ
XI	**Нийгмийн хамгаалал**		**2049.3**	**149**	
1	"Найрамдал" төвийн халаалтын зуухны шинэчлэл. Улаанбаатар	2002-2002	49.3	49	НХХЯ
2	" Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийн дотоод эх үүсвэр	2002-2005	2000	100	НХХЯ
XII	**Гал түүмэртэй тэмцэх арга хэмжээ**		**450**	**100**	
1	Галын депо,5 машины гараж,8 айлын сууц. Сүхбаатар	2002-2003	450	100	ХЗДХЯ
XIII	**Нийгмийн хэв журам, аюулгүй байдал**		**559**	**354.5**	
1	Цагдаагийн хэлтэс, урьдчилан хорих байрны дуусгал. Улаангом, Увс	2000-2002	459	254.5	ХЗДХЯ
2	Авто баазын засварын газрын өргөтгөл. Хан-Уул, Улаанбаатар	2002-2002	100	100	ХЗДХЯ
XIY	**Хил хамгаалал**		**1729**	**300**	
1	Хилийн 27-р хороо. Мэнэн, Дорнод	1999-2004	735	100	ХЗДХЯ
2	Хилийн 0129-р ангийн штаб, цэргийн байр. Дорноговь	2002-2005	735	80	ХЗДХЯ
3	0245-р ангийн Тээлийн суман. Давст, Увс	2002-2003	106	50	ХЗДХЯ
4	Булган аймгийн 0286-р ангийн, Төмөрөнгийн суманд хил руу нүүлгэх	2002-2003	56	20	ХЗДХЯ
5	0132-р ангийн Зоргоны суман, Дорнод	2002-2003	97	50	ХЗДХЯ
XY	**Шүүхийн ерөнхий зөвлөл**		**330**	**180**	
1	Шүүхийн барилга. Жаргалант, Ховд	2002-2002	80	80	ШЕЗ
2	Шүүхийн барилга. Баруун-Урт, Сүхбаатар	2002-2003	250	100	ШЕЗ
XYI	**Шүүхийн шийдвэр гүйцэтгэл**		**135**	**100**	
1	Ажлын байр бий болгох төсөл, арга хэмжээ.	2002-2003	135	100	ХЗДХЯ
XYII	**ТЭЗҮ, хайгуул, зураг төсвийн бэлтгэл ажил**	2002-2002	**100**	**100**	СЭЗЯ
XYIII	**Тоног төхөөрөмжийн дүн**		**1520**	**1520**	СЭЗЯ
XIX	**Их засварын дүн**		**3066.9**	**3066.9**	СЭЗЯ
XX	**Гадаад харилцаа**		**400.0**	**100**	
1	Ерөнхий консулын барилга. Эрээн хот	2002-2003	400.0	100	ГХЯ
XXI	**Гаалийн хөгжлийн сан**		**4900**	**1800**	
1	Алтанбулагийн ШНЦ-ын дуусгал, Сэлэнгэ	2001-2002	4500	1500	УГЕГ
2	Цагаannуурын ШНЦ--ын дуусгал, Баян-Өлгий	2001-2002	400	300	УГЕГ
XXII	**Төслийн бус бүцалтгүй тусламжийн санд бүцаан суутгах төлбөр**	2002-2002	**106.0**	**106**	СЭЗЯ
XXIII	**Замын сан**		**43830.5**	**12000**	ДБЯ
	ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БҮГД		**103304.8**	**31035.0**	

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН БОЛОН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖИХ ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төгрөг)

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хэрэгжүүлэх хугацаа	Хүч чадал	Төсөвт өртөг	2002			Ашиглалтад оруулах	
					Төсөл	Үүнээс			
						Улсын төсөв	Замын сан	Хугацаа	Хүч чадал
	А	1	2	3	4	5	6	7	8
	Нэг. Мянганы зам			**4342.3**	**1711.3**	**1265.7**	**445.6**		
1	Багануур чиглэлийн зам	2001-2003	37.3 км	4000.0	1479.0	1263.4	215.6		
2	Ховдын Булган-Яарантайн зам	2002-2003	70 км	210	100.0		100.0	IУ	15 км
3	Өндөрхааны төвийн зам	2002-2002	1.2 км	130.0	130.0		130.0	Ш	1,2 км
4	Багануур-Өндөрхааны авто замын /228 км/ ТЭЗҮ-ийг боловсруулах	2001-2002		2.3	2.3	2.3		Ш	
	Хоёр. Төмөр бетон гүүр			**2956.0**	**550.0**	**0.0**	**550.0**		
1	Буянтын гол, Завхан	2002-2004	180,5 у/м	850.0	100.0		100.0		
2	Хөмүүлтийн гол, Хэнтий	2002-2005	250 у/м	1000.0	200.0		200.0		
3	Идэрийн гол, Хөвсгөл	2002-2004	162.9 у/м	900.0	100.0		100.0		
4	Хануйн гол, Булган	2002-2004	73 у/м	206.0	150.0		150.0		
	"Мянганы зам" төслийн гүүрүүд:			**4093.0**	**1794.0**	**0.0**	**1794.0**		
5	Завхан голын Сар-Хайрхан, Завхан	2001-2003	126,9 у/м	1700.0	900.0		900.0		
6	Орхон гол, Архангай	2001-2003	210 у/м	1000.0	400.0		400.0		
7	Хонгион гол, Ховд	2001-2002	45,8 у/м	213.0	125.0		125.0	IУ	45,8 у/м
8	Шургийн гол, Ховд	2002-2003	145,1 у/м	750.0	169.0		169.0		
9	Тогосын хоолой, Төв	2002-2003	75,7 у/м	430.0	200.0		200.0		
	Гурав. Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төслүүдийн дотоод эх үүсвэр			**16074.5**	**3236.7**	**3236.7**	**0.0**		
1	АХБ-ны зээлээр хэрэгжих Налайх-Чойрын зам	2000-2005	200 км	9316.0	1942.7	1942.7			
2	Кувейтийн сангийн зээлээр хэрэгжих Дархан-Эрдэнэтийн зам	1997-2003	184 км	6758.5	1294	1294		Ш	184 км
3	**"Тээврийг хөгжүүлэх төсөл" /ДБ/**			**6693.9**	**2658**	**2658**			
а	Эрдэнэсант-Аравайхээрийн зам	2001-2004	215 км	1711.3	767.9	767.9			
б	Аравайхээр-Ховдын зам	2002-2005	93 км	1305.4	460.4	460.4			
в	Цэцэрлэг-Тосонцэнгэлийн зам	2001-2004	87.2 км	1086.0	691.1	691.1			
г	Хархорин-Цэцэрлэгийн зам	1999-2002	44.1 км	1197.9	36.5	36.5		IУ	44,1 км
д	Тээврийг хөгжүүлэх төслийн бэлтгэл хяналт, сургалт, тоног төхөөрөмж	2001-2005		1393.3	702.1	702.1			
	Дөрөв.Улсын чанартай авто замын засвар арчлалт, "Авто замын хууль"-ийн хэрэгжилттэй холбоотой ажлууд	2001-2004		**9670.8**	**2050**		**2050**		
	НИЙТ ДҮН			**43830.5**	**12000.0**	**7160.4**	**4839.6**		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 30 Улаанбаатар хот

Зарим тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Сайд нарын Зөвлөл (хуучин нэрээр), Засгийн газрын ач холбогдлоо алдсан, хууль тогтоомжтой давхардсан, зөрчилдсөн зарим тогтоол, тогтоолын заалтыг хавсралт ёсоор хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2002 оны 30 дугаар тогтоолын хавсралт

САЙД НАРЫН ЗӨВЛӨЛ /ХУУЧИН НЭРЭЭР/, ЗАСГИЙН ГАЗРЫН ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ЗАРИМ ТОГТООЛ, ТОГТООЛЫН ЗААЛТЫН ЖАГСААЛТ

1. "Батлан хамгаалах яам, Нийгмийг аюулаас хамгаалах яамны цэргийн албаа хаагчдыг амралт, сувилалд явахад нь үзүүлэх хөнгөлөлтийн тухай" Сайд нарын Зөвлөлийн 1968 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 332 дугаар тогтоол

2. "Засан хүмүүжүүлэх байгууллагын ажлыг сайжруулах зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 252 дугаар тогтоол

3. "Дээд сургуулийн эчнээ, оройн сургалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1975 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 619 дүгээр тогтоол

4. "Эрчим хүчний зарим үйлдвэр, шугам сүлжээний газрын зэрэглэл, албан тушаалын цалингийн схемд өөрчлөлт оруулах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1980 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 383 дугаар тогтоол

5. "Санхүүгийн хяналт шалгалтыг хүчтэй болгох зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1984 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 294 дүгээр тогтоол

6. "Журам батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 10 дугаар тогтоол

7. "Орон нутгийн авто замын ажилд оролцох үүргийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1987 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн 221 дүгээр тогтоол

8. "Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын зохион байгуулалтын тухай" Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоол

9. "Мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх ажлын талаар авах зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 112 дугаар тогтоол

10. "Боловсон хүчин бэлтгэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 314 дүгээр тогтоол

11. "Худалдаа, үйлдвэрийн яамны цалингийн санг батлах тухай" Засгийн газрын 1990 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 36 дугаар тогтоол

12. "Улсын ашигт малтмалын нөөцийн сан байгуулах тухай" Засгийн газрын 1990 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 60 дугаар тогтоол

13. "Налайхын нүүрсний уурхайд гарсан ослын улмаас амь үрэгдсэн хүмүүсийн ар гэрт болон осолд орсон хүмүүст тусламж үзүүлэх тухай"

Засгийн газрын 1990 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 210 дугаар тогтоол

14. "Сум, хороо, дүүрэг, орон нутгийн хотын Ардын Хурлын гүйцэтгэх захиргааны үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх тухай" Засгийн газрын 1991 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 58 дугаар тогтоол

15. "Зарим ажилтны нэмэгдэл амралтын хугацаог тогтоох тухай" Засгийн газрын 1991 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн 161 дүгээр тогтоол

16. "Улсын хянан байцаах газрын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 175 дугаар тогтоол

17. "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тогтоох тухай" Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 199 дүгээр тогтоол

18. "Зөвлөмж батлах тухай" Засгийн газар, МҮЭ-ийн Холбооны Төв Зөвлөлийн 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 200/50 дугаар тогтоол

19. "Журам батлах тухай" Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 201 дүгээр тогтоол

20. "Ажилгүйдлийн тэтгэмжийн хэмжээ тогтоох тухай" Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 202 дугаар тогтоол

21. "Чойр хотын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 207 дугаар тогтоол

22. "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1991 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 208 дугаар тогтоол

23. "Нөхөр Ц.Сүхбаатарыг ажилд томилж, аймаас чөлөөлөх тухай" Засгийн газрын 1991 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 214 дүгээр тогтоол

24. "БНМАУ-ын нийгэм, эдийн засгийг 1992 онд хөгжүүлэх чиглэлийн тухай" Засгийн газрын 1991 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 355 дугаар тогтоол

25. "Дархлалын олдмол дутлын хам шинж өвчинтэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1992 оны 9 дүгээр сарын 4-ний өдрийн 18 дугаар тогтоол

26. "Хүн амын нийгмийн баталгааг хангах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1992 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 69 дүгээр тогтоол

27. "Улсын эрдсийн баялгийн эзөвлөлийн дүрмийг батлах тухай" Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 72 дугаар тогтоол

28. "Цалингийн сангийн тухай" Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 75 дугаар тогтоол

29. "Хүн амын нийгмийн баталгааг хангах зэлжит арга хэмжээний тухай" Засгийн газрын 1993 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 184 дүгээр тогтоол

30. "Нийгмийн халамж, хүнсний хангамжийн үйлчилгээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн 72 дугаар тогтоол

31. "Улсын эрдсийн баялгийн эзөвлөлийн дүрэмд зарим нэмэлт, өөрчлөлт оруулах, эзөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1994 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 103 дугаар тогтоол

32. "Газрын тосны үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1996 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн 101 дүгээр тогтоол

33. "Улс төрийн зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 158 дугаар тогтоол

34. "Шуудангийн шинэ нэр төрлийн үйлчилгээ нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 99 дүгээр тогтоолын 2, 3 дугаар зүйл.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 31 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Нийтийг хамарсан ажил зохион байгуулах журам"-ыг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Нийтийг хамарсан ажлыг дээрх журмын дагуу зохион байгуулж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Яам, агентлаг, холбогдох бусад байгууллагын чиглэлээр хэрэгжиж байгаа төсөл, хөтөлберийн хүрээнд хийгдэх нийтийг хамарсан ажлыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамтай уялдуулан зохион байгуулж байхыг холбогдох сайд, дарга нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 3-ны өдрийн 87 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Засгийн газрын 2002 оны 31 дүгээр тогтоолын хавсралт

НИЙТИЙГ ХАМАРСАН АЖИЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах, түүнд иргэдийг оролцуулахад энэхүү журмыг баримтална.

2. Нийтийг хамарсан ажил нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хэлбэр бөгөөд хөдөлмөр зарцуулалт ихтэй, мэргэжил шаардахгүй ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг зохион байгуулж оролцуулах замаар хэрэгжүүлнэ.

3. Нийтийг хамарсан ажил нь дараахь зорилтыг хангахад чиглэнэ:

-түр хугацааны болон улирлын чанартай ажил гүйцэтгүүлж улс, орон нутгийн болон тухайн байгууллагын хэрэгцээг хангах, нийгэм-эдийн засгийн хөгжлийн бүсийн болон зорилтот хөтөлберийг хэрэгжүүлэх;

-хөдөлмөрийн хөлс (орлого)-ний хэлбэрээр иргэдэд дэмжлэг үзүүлэх;

-удаан хугацаагаар ажилгүй байгаа болон мэргэжилгүй, эсхүл ажлын дадлага, туршлага багатай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, тэдний хөдөлмөрлөх идэвхийг өрнүүлэх.

4. Нийтийг хамарсан ажлыг дараахь чиглэлээр зохион байгуулна:

-мод суулгах, зүлэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон усжуулалтын ажил, байгалийн гамшиг, цөлжилттэй тэмцэх;

-малын тэжээл, хадлан бэлтгэх, төл хүлээн авах, хашаа, хороо барих, хаврын тариалалт, ургац хураах;

-хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн бэлтгэх, дахин боловсруулах;

-зам, гүүр барих, засварлах, ус дамжуулах, холбооны болон бусад шугам сүлжээ тавих бэлтгэл хангах;

-хот, төв суурин газрын нийтийн эзэмшлийн гудамж, талбайг засч тохижуулах, хог, хаягдал цаас арилгах, зайлуулах, үерийн далан цэвэрлэх;

-байгалийн өгөөж, хоёрдогч түүхий эд, хаягдал цуглуулах, дахин боловсруулах;

-энгийн аргаар буюу ой цэвэрлэн түлш бэлтгэх;

-амралт, жуулчлал, соёлын зориулалттай барилга байгууламжийг тохижуулах;

-хөдөлмөрийн бусад боломжтой хэлбэрүүд.

Хоёр. Нийтийг хамарсан ажилд тавих шаардлага

5. Нийтийг хамарсан ажил нь дараахь шаардлагыг хангасан байна:

-их хэмжээний хөрөнгө оруулалт шаардахгүй (үндсэн хөрөнгө, тоног төхөөрөмжид хөрөнгө зарцуулахгүй);

-хөрөнгийн 50-иас доошгүй хувийг хөдөлмөрийн хөлсөнд зарцуулах.

6. Орон нутгийн Засаг даргын Тамгын газар нь шаардлагатай тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн албатай тохиролцон нийтийг хамарсан ажилд нэмэлт шаардлага тавьж болно. Эдгээр нэмэлт шаардлагад тухайн ажлын онцлогоос шалтгаалан ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл, ажлын багаж, шагнал урамшуулал, унаа, хоол, байрны зардал, эмнэлгийн үйлчилгээ зэрэг асуудлууд багтана.

Гурав. Нийтийг хамарсан ажлын санхүүжилт, зохион байгуулалт

7. Нийтийг хамарсан ажлыг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

-хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нийтийг хамарсан ажилд хуваарилсан хөрөнгө;

-тусгай хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зориулсан дотоод, гадаадын хөрөнгийн эх үүсвэр, хандив тусламж;

-төвлөрсөн болон орон нутгийн төсөв;

-тусгай зориулалтын сангуудын хөрөнгө;

-аж ахуйн нэгж, байгууллагаас нийтийг хамарсан ажилд зарцуулсан хөрөнгө;

-бусад.

8. Орон нутгийн Засаг даргын Тамгын газар нийтийг хамарсан ажлыг хөдөлмөр эрхлэлтийн алба, аж ахуйн нэгж, байгууллагын оролцоотойгоор тодорхой төсөл, гэрээний үндсэн дээр зохион байгуулна.

9. Тухайн жил хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх нийтийг хамарсан ажлын төслүүдийг орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба боловсруулан тогтоосон хугацаанд хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагад ирүүлсний үндсэн дээр шаардагдах хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангийн төсөөт тусгуулна.

10. Бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн болон нийтийн хурал нь орон нутгийн хэрэгцээ, шаардлага, цаг үеийн онцлог, хөдөлмөр эрхлээгүй хүн амын тоо, бүтцийг харгалзан тухайн жил зохион байгуулах нийтийг хамарсан ажлын төсвийг жил бүр батална. Засаг дарга үүнийг үндэслэн нийтийг хамарсан ажил зохион байгуулах тухай шийдвэр гаргана.

11. Шаардлагатай тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллага хөдөлмөр эрхлэлтийн албатай гэрээ байгуулсны үндсэн дээр нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж болно. Гэрээний загварыг хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага батална.

12. Хөдөлмөр эрхлэлтийн алба болон нийтийг хамарсан ажлыг зохион байгуулах аж ахуйн нэгж, байгууллагын хооронд байгуулах гэрээнд нийтийг хамарсан ажил явуулах нөхцөл, шинээр бий болгох ажлын байр буюу ажиллуулах нийт хүний тоо, гүйцэтгэх ажлын шинж чанар, уг ажлыг явуулах газар, ажил эхлэх, дуусах хугацаа, ажилтны хөдөлмөрийн хөлсний хэлбэр, хэмжээ,

түүнийг олгох хугацаа, нийтийг хамарсан ажилд шаардагдах зардал тэдгээрийг санхүүжүүлэх журам, хөдөлмөрийн ашуулгын ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөл зэргийг тодорхой тусгана.

13. Нийтийг хамарсан ажил зохион байгуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага уг ажилд оролцох иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулна.

Дөрөв. Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэдийн цалин хөлс, нийгмийн даатгал

14. Нийтийг хамарсан ажилд оролцох хүсэлтэй иргэдийг хөдөлмөр эрхлэлтийн алба бүртгэж, зохион байгуулалттайгаар оролцуулна.

15. Ажилгүйдлийн тэтгэмж авдаггүй, 6 сараас дээш хугацаагаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй байгаа хөдөлмөр эрхлээгүй иргэнийг нийтийг хамарсан ажилд эхний ээлжинд оролцуулна.

16. Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэнд ажлын гүйцэтгэлээр нь хөдөлмөрийн хөлс олгоно. Хөдөлмөрийн хөлс нь Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.

Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэнд хөдөлмөрийн хөлсийг өдөрт нь тооцон олгож болно.

17. Нийтийг хамарсан ажилд оролцож байгаа иргэн болон зохион байгуулагч аж ахуйн нэгж, байгууллага Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын шимтгэл төлнө. Шимтгэл төлсөн тухай баримтыг үндэслэн орон нутгийн нийгмийн даатгалын байгууллага нийтийг хамарсан ажилд эролцсон иргэний нийгмийн даатгалын дэвтэртбичилт хийж байна.

18. Нийтийг хамарсан ажилд оролцсон иргэний хөдөлмөрийн аюулгүй ажиллагаатай холбоотой асуудлыг уг ажлыг зохион байгуулж байгаа байгууллага бүрэн хариуцаж хөдөлмөр эрхлэлтийн албатай хамтран нийтийг хамарсан ажилд оролцох иргэнд хөдөлмөр зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны талаархи заавryг зохих журмын дагуу өгнө.

19. Ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа ажилгүй иргэн нийтийг хамарсан ажилд оролцох тохиолдолд түүний авч байсан тэтгэмжийг түр зогсоон, нийтийг хамарсан ажил дууссаны дараа ажилгүйдлийн тэтгэмжийг өмнө тогтоосон хэмжээгээр тэтгэмж авбал зохих үлдсэн хугацаанд үргэлжлүүлэн олгоно.

20. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулагчаас иргэнийг ажилд авсан тухай хөдөлмөр эрхлэлтийн албанд бичгээр өгсөн мэдэгдэл нь түүний ажилгүйдлийн тэтгэмжийг түр зогсоох үндэслэл болно.

Тав. Нийтийг хамарсан ажлын мэдээ, тайлан, хяналт

21. Хөдөлмөр эрхлэлтийн алба нийтийг хамарсан ажилд оролцсон иргэний бүртгэлийг хөтөлж, нийтийг хамарсан ажлын мэдээ, тайланг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл, тайлангийн маягт"-ын дагуу тогтоосон хугацаанд гаргана.

22. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж байгаа байдал, гүйцэтгэсэн ажлын үр дүн, мөн түүнчлэн төвлөрсөн болон орон нутгийн төсөв, гадаад, дотоодын хандив тусламж, сангуудын хөрөнгөөр зохион байгуулсан нийтийг хамарсан ажилд зарцуулсан хөрөнгө, түүний зориулалтад орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн алба холбогдох мэргэжлийн хяналтын албадтай хамтран хяналт тавина.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 2 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (252)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Ромын дүрмийг соёрхон батлах тухай*
- *Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *Шүүхийн шийдвэр түйцэлтэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны дөрөвдүгээр сарын 19 №15 (252)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

148. Ромын дүрмийг соёрхон батлах тухай (2002-4-5-ны хууль) 590
149. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-4-11-ний хууль) 590
150. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн зарим зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох тухай (2002-4-12-ны хууль) 590

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

151. Ерөнхийлөгчийн хоригийн тухай Дугаар 08 590

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

152. Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай Дугаар 34 591
153. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 35 591
154. Татвар төлөх хугацааг хойшлуулах тухай Дугаар 36 592
155. Зарим аймгийн талаар авах арга хэмжээний тухай Дугаар 39 593
156. Журам батлах тухай Дугаар 40 596
157. Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай Дугаар 41 597

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

158. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2; 184 дүгээр зүйлийн 5; 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн Хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 01 598

159. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай. Дугаар 02 601

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр — **Улаанбаатар хот**

РОМЫН ДҮРМИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс 2000 оны 12 дугаар сарын 29-ний өдөр гарын үсэг зурсан Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын Дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж. БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр — **Улаанбаатар хот**

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд дор дурдсан агуулгатай 26 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

"10. Гадаадын иргэнийг бүртгэх, гадаадын иргэн Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин суух, байнга оршин суух, цагаачлах журмыг Засгийн газар батална."

2/ 30 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах журмыг Засгийн газар тогтооно."

2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын "дипломат" гэсний дараа "албан" гэх нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр — **Улаанбаатар хот**

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалтаас "үг мэдүүлгийг албадан өгүүлэх зорилгоор түр саатуулахаар шүүхэд хандах," гэсний хасч, мөн хуулийн 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.5.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр — **Дугаар 08** — **Улаанбаатар хот**

Ерөнхийлөгчийн хоригийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 14.3-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.2 дахь заалт, 41 дүгээр зүйл, 42 дугаар зүйлийн 42.5.2 дахь заалтад тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 34 | Улаанбаатар хот

Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай

Төмөр замын тээврийн аюулгүй байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газрын орлогч дарга бөгөөд Хяналтын албаны дарга Ч.Цогтбаярт төмөр замын тээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн эрх олгосугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай" Засгийн газрын 1995 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 237 дугаар тогтоолын "Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газрын орлогч дарга Ц.Сандуузад төмөр замын тээврийн хяналтын улсын ерөнхий байцаагчийн" гэсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 6-ны өдөр | Дугаар 35 | Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийг хэрэгжүүлэх, аж ахуй эрхлэгчдэд олгож буй олон төрлийн зөвшөөрөл, лиценз, шат дамжлагыг багасгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.Яам, агентлагийн удирдлага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгах нь:

а/өөрсдийн эрхлэх үйл ажиллагааны чиглэлээр өмнө батлан гаргасан журам, зааврууд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай Монгол Улсын хуульд нийцүүлэн 2002 оны 4 дүгээр сарын 1-ний дотор хүчингүй болгож, дэлгэрэнгүй танилцуулга, жагсаалтыг Засгийн газарт ирүүлсүгэй;

б/аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгчдэд зөвшөөрөл, лиценз олгох, буртгэх ажиллагааны шат дамжлагыг цөөрүүлэх зорилгоор 2002 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс "Нэг цэгийн үйлчилгээний төв"-ийн зарчмыг хэрэгжүүлэх арга хэмжээ авсугай.

2.Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд даалгах нь:

а/мэргэжлийн чиглэлийн хяналт, шалгалт эрхэлдэг төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын тогтолцоог судлан үзэж бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх арга хэмжээ авсугай;

б/энэхүү тогтоол болон цаашид авах арга хэмжээний талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулсугай.

3. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нийцүүлэн салбарын чиглэлийн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж Засгийн газарт оруулахыг Засгийн газрын гишүүн, сайд нарт даалгасугай.

4. Яам, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын шийдвэр Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхийг 2002 оны П улиралд багтаан шалгахыг

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин нарт үүрэг болгосугай.

5. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх талаар гаргасан шийдвэрүүдээ хуульд нийцүүлэн хянан үзэхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд зөвлөсүгэй.

6. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 58 дугаар тогтоол, "Жагсаалтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 1994 оны 5 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 1994 оны 11 дүгээр сарын 2-ны өдрийн 184 дүгээр тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1995 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн 76 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 118 дугаар тогтоол, "Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 198 дугаар тогтоол, "Жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1996 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн 3 дугаар тогтоол, "Журам батлах тухай" Засгийн газрын 1996 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 62 дугаар тогтоол, "Журмын хавсралтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 1996 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 164 дүгээр тогтоол, "Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 1997 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 34 дүгээр тогтоол, "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 1997 оны 10 дугаар сарын 8-ны өдрийн 203 дугаар тогтоол, "Нийтийн аж ахуйн үйлчилгээний салбарыг хувьчлах хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн 159 дүгээр тогтоол, "Жагсаалтад нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2000 оны 10 дугаар сарын 4-ний өдрийн 154 дүгээр тогтоол, "Тогтоолд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 44 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 36 Улаанбаатар хот

Татвар төлөх хугацааг хойшлуулах тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 20 дугаар зүйл, Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Төрийн холбоог өргөтгөн шинэчлэх" МОН-3, "Хөдөөгийн цахилгаан холбоо" МОН-4 төслүүдийн хүрээнд нийлүүлэгдэх тоног төхөөрөмжид ногдсон гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын төлөх хугацаат татвар ногдуулсан едрөөс хойш 2 сарын хугацаагаар хойшлуулахыг Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар, Үндэсний татварын ерөнхий газрын дарга Л.Зориг нарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 39 | Улаанбаатар хот

Зарим аймгийн талаар авах арга хэмжээний тухай

Ерөнхий сайд Н.Энхбаяр орон нутагт ажилласан дүнг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Малчдын хэрэгцээнд зориулан Говь-Алтай, Ховд, Увс аймагт тусламж болгон улсын нөөцөөс олгох хүнс, өргөн хэрэглээний барааны хуваарийг 1 дүгээр хавсралт ёсоор, Говь-Алтай, Баянхонгор аймгийн малчдад эргэн төлөгдөх нөхцөлөөр улсын нөөцөөс олгох өвс, тэжээлийн хуваарийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан хүнс, өргөн хэрэглээний барааны үнэ 215.8 (хоёр зуун арван таван сая найман зуун мянга) сая төгрөг, 1, 2 дугаар хавсралтад заасан хүнс, өргөн хэрэглээний бараа, өвс, тэжээлийн тээврийн зардал 442.1 (дөрвөн зуун дөчин хоёр сая нэг зуун мянга) сая төгрөг, улсын нөөцийн орон нутаг дахь салбаруудад 3 дугаар хавсралтын дагуу нэмж байршуулах өвс, тэжээлийн тээврийн зардал 239.6 (хоёр зуун гучин есөн сая зургаан зуун мянга) сая төгрөг, бүгд 897.5 (найман зуун ерэн долоон сая таван зуун мянга) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрч улсын нөөцөөс гаргасан хүнс, өргөн хэрэглээний бараа, өвс, тэжээлийг 2002 оны Ш улиралд багтаан нөхөн бүрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

3. Говь-Алтай, Ховд, Увс аймагт олгосон цагаан будаа (БНСВУ-ын тусламжийн)-ны үнийг Улсын нөөцийн газраас Санхүү, эдийн засгийн яаманд төвлөрүүлэх борлуулалтын орлогын дүнгээс суутган тооцохоор тогтоосугай.

4. Говь-Алтай аймгийн Дэлгэр сумын хүний эмчийн салбарт улсын нөөцөөс УАЗ-31512 маркийн суудлын автомашин нэгийг олгохыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд зөвшөөрч уг машиныг эрүүл мэндийн салбарт 2002 онд хөрөнгө оруулалтаар олгох түргэн тусламжийн автомашинаас энэ оны II улиралд багтаан улсын нөөцөд нөхөн бүрдүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

5. Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад заасны дагуу эргэн төлөгдөх нөхцөлөөр улсын нөөцөөс олгосон өвс, тэжээлийн үнэ 176.0 (нэг зуун далан зургаан) сая төгрөгийг 2002 оны 8 дугаар сард багтаан Улсын нөөцийн газарт төлж дуусгахыг холбогдох аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Мал хаваржилтыг зохион байгуулах, зарим тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд зориулж 100.0 (нэг зуун) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж Баянхонгор аймагт олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МАЛЧДЫН ХЭРЭГЦЭЭНД ЗОРИУЛАН ГОВЬ-АЛТАЙ, ХОВД, УВС АЙМАГТ ТУСЛАМЖ БОЛГОН УЛСЫН НӨӨЦӨӨС ОЛГОХ ХҮНС, ӨРГӨН ХЭРЭГЛЭЭНИЙ БАРААНЫ ХУВААРЬ

№	Хүргэх газар	Хаанаас тээвэрлэх	Нэр төрөл	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1.	Говь-Алтай аймаг	Улаанбаатар	Гурил	тн	270
			Хуурай сүү	тн	20
			Цагаан будаа (Вьетнам)	тн	50
			"Илч" аяны тогоо	ком	150
2.	Ховд аймаг	Ховд	Гурил	тн	60
		Улаанбаатар	Цагаан будаа (Вьетнам)	тн	50
			Хуурай сүү	тн	5
3.	Увс аймаг	Ховд	Гурил	тн	40
		Улаанбаатар	Цагаан будаа (Вьетнам)	тн	45
			Хуурай сүү	тн	5

ГОВЬ-АЛТАЙ, БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛЧДАД ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛӨӨР УЛСЫН НӨӨЦӨӨС ОЛГОХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Хүргэх газар	Хаанаас тээвэрлэх	Өвс		Тэжээл (тонн)	
			боодол	тонн	нэр төрөл	тоо хэмжээ
1.	Говь-Алтай аймаг	Булган аймаг Баяннуур сум	8696	200	-	-
		Завхан аймгийн төв	4328	100	-	-
		Улаанбаатар	43478	1000	-	-
			-	-	хивэг	250
			-	-	тэжээл	250
2.	Баянхонгор аймаг	Улаанбаатар	-	-	хивэг	42.1
			-	-	хорголжин	150.0
			-	-	багсармал	56.7
			-	-	няцалсан будаа	51.2
			43478	1000	-	-

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он №15 (252)

УЛСЫН НӨӨЦИЙН ОРОН НУТАГ ДАХЬ САЛБАРУУДАД НЭМЖ БАЙРШУУЛАХ ӨВС, ТЭЖЭЭЛИЙН ХУВААРЬ

№	Байршуулах салбарын нэр	Хаанаас тээвэрлэх	Өвс		Тэжээл тонноор
			боодлоор	тонноор	
1.	Баянхонгор аймаг дахь улсын нөөцийн салбарт	Булган аймаг Баяннуур сум	66813	1536.7	
		Булган аймаг Баяннуур сум	20100	462.3	
		Улаанбаатар			200
2.	Ховд аймаг дахь улсын нөөцийн салбарт	Улаанбаатар			200
3.	Өвөрхангай аймгийн Сант сум дахь улсын нөөцийн салбарт	Булган аймаг Баяннуур сум	21739	500	
		Улаанбаатар			200
4.	Говь-Алтай аймаг дахь улсын нөөцийн салбарт	Булган аймаг Баяннуур сум	21739	500	
		Улаанбаатар			200
5.	Увс аймгийн төвийн улсын нөөцийн салбарт	Улаанбаатар			200
6.	Архангай аймгийн Түвшрүүлэх сум дахь улсын нөөцийн салбарт	Булган аймаг Баяннуур сум	21739	500	
7.	Булган аймаг дахь улсын нөөцийн салбарт	Булган аймаг Баяннуур сум	21739	500	

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ 2002 он, №15 (252)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 40 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Усан замын тээврийн асуудлыг түсгай хуулиар зохицуулах хүртэл "Усан замын тээврийн хэрэгсэлд хяналт тавьж бүртгэх түр журам"-ыг хавсралт ёсоор батална.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2002 оны 40 дүгээр тогтоолын хавсралт

УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ХЯНАЛТ ТАВЬЖ, БҮРТГЭХ ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын дотоодын усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдал, тээвэрлэлтийн болон техник ашиглалтын шаардлагыг хангуулж, хүн ам, хүрээлэн байгаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх нөхцөл бүрдүүлэхэд төрийн хяналт зохицуулалтын үр нөлөөг дээшлүүлж, усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийж, бүртгэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийж, дугнэлт гаргах үйл ажиллагааг техникийн комисс (цаашид "техникийн комисс" гэнэ) гүйцэтгэнэ. Техникийн комисс нь үйл ажиллагаандаа мэргэжлийн байгууллага, шинжээчдийг татан оролцуулж болно.

3. Усан замын тээврийн хэрэгслийн ашиглалт, ажил, үйлчилгээнд тавих захиргааны хяналт, шалгалтыг усан замын тээврийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлнэ.

4. Техникийн комиссын гишүүд болон усан замын тээврийн хяналтын улсын байцаагчийг авто тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

5. Техникийн комиссын гишүүд болон улсын байцаагч нь авто буюу усан замын тээврийн инженер, эсхүл эдийн засагч мэргэжилтэй, энэ чиглэлээр мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, мэргэжлээрээ 3-аас доошгүй жил ажилласан, дадлага туршлагатай, хууль зүйн зохих мэдлэгтэй байна.

6. Улсын байцаагч нь ачаа, зорчигч тээвэрлэх усан замын тээврийн хэрэгсэлд тавигдах нөхцөл, шаардлага болон энэхүү дүрмийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээ авч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 16, 21 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7. Усан замын тээврийн хэрэгсэл гэдэгт хүн болон ачаа тээвэрлэхээд зориулсан бүх төрлийн онгоц, чиргүүл, гатлага онгоц, моторт завийг багтаана.

Хоёр. Техникийн хяналтын үзлэг хийх зарчим

8. Техникийн комисс нь усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэгийг 2 жил тутамд хийж, үр дүнг комиссын хурлаар хэлэлцэн дүгнэлт гаргана.

9. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн өмчлөл, эзэмшилдээ байгаа усан замын тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулахдаа дараахь шаардлагыг хангасан байна:

1/ техникийн болон галын аюулгүй байдал, хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага хангасан байх;

2/ багийн гишүүд болон жолоодогч нь тухайн мэргэжлээр суралцсан, эсхүл мэргэшүүлэх сургалтад хамрагдсан байх;

3/ болзошгүй аюулын үед хэрэглэх аврах бэлхэс, техник хэрэгсэл, тусгай хувцсаар хангаж, ашиглалтын бэлэн байдалд байлгах;

4/ хүрээлэн байгаа байгаль орчин, хүн амд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх;

5/ хөвөлтийн үеийн хөвийн үйл ажиллагаа хангахад шаардлагатай сэлбэг материал, багаж хэрэгсэлтэй байх.

10. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийлгэж, бүртгэлийн гэрчилгээ авахдаа дараахь бичиг баримтыг бүрдүүлсэн байна:

1/ техникийн хяналтын үзлэг хийлгэж, бүртгүүлэхийг хүссэн өргөдөл (үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл, хугацаа тодорхой дурдах);

2/ өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол нотариатаар баталгаажуулсан улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэн-иргэний үнэмлэхийн хуулбар;

3/ тээврийн хэрэгслийн техникийн паспорт;

4/ тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн он, сар, өдөр, үйлдвэрийн нэр болон их засвар хийсэн

тухай акт;

5/ урьд нь техникийн хяналтын үзлэгт орсон дугнэлт;

6/ өмчлөгч солигдсон (худалдсан, шилжүүлсэн, өв залгамжилсан) бол энэ тухай баримт бичиг.

11. Усан замын тээврийн хэрэгслийг өмчлөгч, эзэмшигч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн 2 жил тутам тэдгээрт техникийн хяналтын үзлэг хийлгэж, дүгнэлт гаргуулан бүртгүүлэх үүрэгтэй.

12. Усан замын тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийж, дүгнэлт гаргахтай холбогдон гарах зардлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хариуцна.

13. Дараахь тохиолдолд усан замын тээврийн хэрэгслийг ашиглахыг хориглоно:

1/ техникийн хяналтын үзлэгт ороогүй буюу хангалттүй дүн үзүүлсэн;

2/ хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа байгаль орчинд сөргөөр нөлөөлөх, мөн түүнчлэн аюулгүй байдлыг хангаагүй.

Гурав. Бүртгэлийн гэрчилгээ

14. Техникийн комисс нь усан замын тээврийн хэрэгсэл эзэмшигчийн хүсэлт, өргөдлийг үндэслэн техникийн хяналтын үзлэг хийж, дүгнэлт гаргана. Уг дүгнэлтийг үндэслэн авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бүртгэлийн гэрчилгээг олгох, эсэх талаар шийдвэр гаргана. Уг шийдвэрийг үндэслэн авто тээврийн асуудал эрхэлсэн төв байгууллага бүртгэлийн гэрчилгээ олгоно.

15. Бүртгэлийн гэрчилгээнд дор дурдсан зүйлийг тусгана:

1/ олгосон байгууллагын нэр;

2/ техникийн үзүүлэлт, загвар, нэр, таних тэмдэг, даац, багтаамж;

3/ техникийн хяналтын үзлэг хийсэн дүгнэлт;

4/ өмчлөгч, эзэмшигчийн нэр, хаяг;

5/ бүртгэлийн гэрчилгээний хугацаа;

6/ гэрчилгээний дугаар, олгосон он, сар, өдөр;

7/ олгосон эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, тамга /тэмдэг/.

16. Бүртгэлийн гэрчилгээг 2-оос доошгүй жилийн хугацаагаар олгоно.

17. Бүртгэлийн гэрчилгээ эзэмшигч гэрчилгээний хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах хүсэлтээ гаргана.

18. Бүртгэлийн гэрчилгээ олгох, түүний хугацааг сунгах асуудлыг өргөдөл хүлээн авснаас хойш ажлын 21 хоногийн дотор шийдвэрлэнэ. Хэрэв бүртгэх буюу хугацааг сунгахаас татгалзсан бол татгалзсан үндэслэлийг зааж бичгээр хариу өгнө.

19. Техникийн комисс нь шаардлагатай гэж үзвэл өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох мэргэжлийн байгууллага болон шинжээчээр нягтлан шалгуулж, магадлан шинжилгээ хийлгэж болно.

20. Бүртгэлийн гэрчилгээг дараахь тохиолдолд хүчингүй болгоно:

1/ усан замын тээврийн хэрэгсэл өмчлөгч, эзэмшигч хүсэлт гаргасан;

2/ хуулийн этгээд татан буугдсан;

3/ зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй.

21. Бүртгэлийн гэрчилгээг хүчингүй болгосон тухай авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрийг шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор гэрчилгээ эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

22. Бүртгэлийн гэрчилгээ олгохтой холбогдсон маргааныг авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 41 Улаанбаатар хот

Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

2002 онд зохих жүрмын дагуу цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх мөнгөн төлбөрийн хэмжээг 750878 (долоон зуун тавин мянга нийман зуун далан нийман) төгрөг байхаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

2002 оны 4 дүгээр сарын 03-ны өдөр | Дугаар 01 | Улаанбаатар хот

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2; 184 дүгээр зүйлийн 5; 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн Хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн 207 дугаар өрөв

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд Ж.Амарсанаа, Ч.Дашням, В.Удвал /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяа, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сугар, Д.Дэмбэрэлцэрэн нарыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд хийв.

Нэг. Иргэн Н.Даваадорж 2002 оны 1 дүгээр сарын 23-нд Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдлөөс: "1994 оны 5 дугаар сарын 9-нд батлагдсан ИХШХШ тухай болон 1995 оны 7 дугаар сарын 04-нд ҮИХШХШ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдөж буйг дараах үндэслэлээр гаргасан юм. Үүнд:

1.Уг хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: "Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцон шүүгч уг хэрэгийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй" гэж хориглон заасны дараа 1995 оны 7 дугаар сарын 4-ны өдрийн ИХШХШ тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар "Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж нэмсэн нь анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцсон Улсын дээд шүүхийн шүүгч Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хэргийг хэлэлцэхэд оролцуулсон өмнөх саналаа дэмжин үндэслэж байх болзолгоог олгож зөвшөөрсөн нь.

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2-т буй "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг зөрчин шүүхэд иргэний журмаар хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагаат шүүхийн дээд, дээд шатны хуралдаанаар нь болон шүүгчээр нь ялгаварлан зүйлчилж хуульчилсан;

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14-т: "Хэргэз шударга шүүхээр шүүгдэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах" гэсэн иргэний эрхийн байдлыг алдагдуулж, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд уг хэргийг өмнө нь шийдвэрлэхэд оролцож байсан Улсын дээд шүүхийн хувийн сонирхол сэдэлттэй шүүгчийг татгалзах, түүний өмнө нь гаргаж байсан үндэслэлгүй саналаар шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах эрхгүйгээр эцэслэгдэж байгаа;

в/ Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн 1-д: "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалттай зөрчилдөж Улсын дээд шүүхэд өмнө нь Улсын дээд шүүхийн шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнээр хянан хэлэлцэхэд шийдэхээс хойш түүний эрэгч санал гаргаж хууль зүйн дагуу шийдвэрлэх гэдэг байхын хэрэггүй гэсэн хараат байдалд бусад шүүгчдийг оруулахад хүргэсэн;

г/ Монгол Улсын Үндсэн хуулийн тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т: "Давж заалдах болон хяналтын шатны журмаар дээд шатны шүүхийн шийдвэрлэсэн шийдвэрийг хянаж үзэх" гэсэн заалтын агуулгыг алдагдуулсан зөрчлүүд байгаа болно.

2.Мөн хуулийн 184 дүгээр зүйлийн 5-д: "Хүрэлдаанаас тогтоол гаргах ба түүнд хуралдаан даргалагч, хуралдаанд оролцсон бүх шүүгч гарын үсэг зурна" гэж заасныг "хяналтын шүүх хуралдаанаас тогтоол гаргана. Аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын шүүх хуралдаанаа тогтоолд шүүх бүрэлдэхүүн, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан даргалагч, хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна" гэж өөрчилсөн нь мөн л дээр дурьдагдсан Үндсэн хуулийн заалтуудын зөрэг өөрчлөлт болсны зөрэгцэз:

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1-д: "...дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно" гэж хориглосныг;

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн тавин

хоёрдугаар зүйлийн 1-д "Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэж тогтоосныг үгүйсгэж Монгол Улсын нэрийн өмнөөс шүүхийн гаргаж буй тогтоолыг хуралдаан даргалагч, бүх бүрэлдэхүүн бус зөвхөн Улсын дээд шүүхийн хуралдаан даргалагч, хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурснаар хүчинжүүлж байгаа нь тухайн шүүгч хяналтын шүүх хуралдааныг хувийн хэрэгцээгээ хэрэгжүүлэхэд ашиглахад хүргэж байна.

3. Дээрх хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: "Улсын Ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн шүүхийн магадлал, тогтоолд доод шатны прокурорын саналыг үндэслэн хяналтын эсэргүүцэл бичих эрхтэй" гэж заасныг: "Улсын Ерөнхий прокурор давж заалдах, хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал, тогтоолд, давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналаар эсэргүүцэл бичих эрхтэй" гэж өөрчилсэн нь:

а/ Монгол Улсын Үндэсэн Хуулийн тавин зургадугаар зүйлийн 1-д "Прокурор ...шүүх хуралдааны төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэж заасныг зөрчиж, Улсын Ерөнхий прокурор Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны оролцох буюу түүнээс гарсан тогтоолд эсэргүүцэл бичих эрхгүй болгосон;

б/ Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанаас хуульд харшлан гаргасан тогтоолд прокурор эсэргүүцэл бичих эрхгүй болсон тул ИХШХШ тухай хуулийн 187 дугаар зүйлийн 2-т заасныг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нэг удаа эсэргүүцэл бичиж хэлэлцүүлэх эрхтэй гэснээр прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдааны тавих хяналтгүй болж хэрэв Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч хувийн үзэмжээрээ эсэргүүцэл бичихгүй л гэх юм бол тэр нь эцсийн шийдвэр буюу хуулиас дээгүүр хүчинтэй болж байгаа нь Монгол Улсын Үндэсэн хуулийн дечин наймдугаар зүйлийн 2-т: "Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно" гэсэн заалттай харшилж байна.Энэ бүхнийг шударга үнэнээр магадлан дүгнэлт гаргаж өгнө үү" гэжээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын даргын 2002 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 50 дугаар захирамжаар томилогдсон Улсын Их Хурлын илтгэмжлэгдсэн төлөвлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сугар, Д.Дэмбэрэлцэрэн нар гаргасан тайлбартаа:

"Нэг.Улсын Их Хурлаар 2002 оны 1 дүгээр сарын 10-нд хэлэлцэн батална Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар Улсын дээд шүүх зөвхөн хяналтын шатаар л хэрэг шийдэхээр тогтоож, уг хуулийн 84 дүгээр зүйлд "Иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцох шүүгч уг хэргийг давж заалдах, хяналтын шат болон дахин анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэж заасан, прокурор иргэний хэрэгт зөвхөн зохигчийн хувиар оролцох ба Улсын дээд шүүхийн хяналтын журмаар шийдвэрлэсэн хэрэгт хяналтын эсэргүүцэл бичих эрхгүй байхаар хуульчилсан бөгөөд энэ хууль нь 2002 оны 9 дүгээр сарын 01-нээс хүчин төгөлдөр үйлчлэх юм.

Иймээс иргэн Н.Даваадоржийн өргөдөлд дурдсан эхний хоёр асуудлыг Улсын Их Хурал өөрийн эрх хэмжээний хүрээнд нэгэнт шийдвэрлэжээ. Мөн түүний Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан даргалагч хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна гэж заасан нь Үндэсэн хууль зөрчсөн байна гэсэн гомдол нь хэрэг хянан шийдвэрлэх үйл явц, шийдвэрийг албан ёсны болгох үе шат хоёрын заагт ялгааг ойлгоогүйтэй холбоотой гарсан байж болзошгүй байна. Улсын Их хурлын шийдвэрт түүний 76 гишүүн гарын үсэг зурдаггүй юм.

Дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж уг гомдлоор үүссэн хэргийг хэрэгсэхгүй болгохыг Үндсэн хуулийн цэцийн эрхэм гишүүдээс хүсье.

Хоёр. Дээрх хууль 5 сарын дараа үйлчилж эхлэх учир энэ хооронд үүсч болох зарим асуудлыг авч үзвэл:

а/ 5 сарын дараа хүчингүй болох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах нь нийгэмд болон иргэн Н.Даваадоржид ямар ч ашиггүйн дээр тийм хууль зүйн шаардлага байхгүй байна.

б/ Монгол Улсын Үндэсэн хуулийн дечин наймдугаар зүйлд "Шүүхийн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх сум буюу сум дундын дүүргийн шүүхээс бүрдэнэ гэзд энэ 3 шатны шүүх зэрэг үйл ажиллагаа явуулах нь ойлгодож байна. Энэ тохиолдолд анхан шатны болон давж заалдах журмаар хэрэг шийдэхэд оролцсон Улсын дээд шүүхийн 17 гишүүнээс хасаад байхад Улсын дээд шүүх хяналтын журмаар хэрэг шийдэхэд 4 шүүгч оролцох тооцоо гарч байна. Иймээс Үндэсэн хуулийн өөрийнх нь заалтыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагаар оруулсан

нэмэлт юм. Иргэний хэргийг шүүхэд хянан шийдвэрлэх хуулийн 81 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Улсын дээд шүүх нийт шүүгчийн олонхийн /9-ээс доошгүй/ бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэнэ гэсэн заалтыг ингэж хэрэгжүүлнэ.

в/ Үндэсэн хуулийн дөчин есдүгээр зүйлд "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэж заасны дагуу Улсын дээд шүүх хяналтын хурмаар шийдвэрлэсэн хэрэг шүүхийн эцсийн шийдэр, түүнд ерөнхий прокурор болон Үндэсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн 2-т заасан ямар ч албан тушаалтан хөндлөнгөөс оролцож болохгүй.

Харин прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх хуралдаанд оролцоно гэсэн заалт одоо ч шүүх хуралдааны мэтгэлцэх зарчимд нийцэн хэлбэрэзрэзэ хэрэгжих байна" гэжээ.

ХЯНАВАЛ:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Улсын Ерөнхий прокурор давж заалдах болон хяналтын журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн аймаг, нийслэлийн шүүхийн магадлал гаргаж давж заалдах журмаар хэрэг хянан шийдвэрлэсэн Улсын дээд шүүхийн магадлалд доод шатны прокурорын саналаар эсэргүүцэл бичих эрхтэй" гэсэн нь Монгол Улсын Үндэсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэг ба тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн гэж үзэх үндэслэл тогтоогдохгүй байна.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 184 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан "Хуралдаанаас тогтоол гаргах ба түүнд хуралдаан дарагалагч, хуралдаанд оролцон бүх шүүгч гарын үсэг зурна" гэж заасныг "Хяналтын шүүх хуралдаанаас тогтоол гарна. Аймаг, нийслэлийн шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд шүүх бүрэлдэхүүн, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдааны тогтоолд хуралдаан дарагалагч хэрэг илтгэсэн шүүгч гарын үсэг зурна" гэж өөрчилсэн нь Үндэсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1-д заасан "...Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно", Үндэсэн хуулийн тавин хоёрдугаар зүйлийн 1-д заасан "Бүх шатны шүүх хэрэг маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ" гэсэн заалтыг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй "Анхан болон дээж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй" гэсэн заалтын дараа 1995 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар "Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж нэмсэнийг шүүгчийг шүүх хуралдаанаас татгалзан гаргах олон улсын жишиг, эрх зүйн нийтлэг зарчмыг үндэслэн авч үзвэл Монгол Улсын Үндэсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", Үндэсэн хуулийн дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "Шүүгч хараат бус байх..." заалтыг тус тус зөрчиж байна гэсэн нь үндэслэлтэй байна.

Монгол Улсын Үндэсэн хуулийн жаран зургадугаар зүйл, Үндэсэн хуулийн цөцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй "Анхан шатны болон дээж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа "Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндэсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", дөчин есдүгээр зүйлийн 1-д заасан "шүүгч хараат бус байх" заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2, 184 дүгээр зүйлийн 5 дахь заалтууд, Монгол Улсын Үндэсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1, 2; тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг зөрчөөгүй байх тул иргэн Н.Давааджамийн энэ талаар гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

3. Үндэсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА	Н.ЖАНЦАН
ГИШҮҮД	Ж.АМАРСАНАА
	Ч.ДАШНЯМ
	Ц.САРАНТУЯА
	В.УДВАЛ

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2002 оны 4 дүгээр сарын 10–ны өдөр Дугаар 02 Улаанбаатар хот

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан хэлэлцсэн тухай.

Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Цэцийн дарга Н. Жанцан даргалж, гишүүдэд Д. Чилхаажав, Н. Чинбат, Ч. Дашням, Ц. Сарантуяа / илтгэгч/ хуралдааны нарийн бичгийн даргаар Д. Нарантуяа, өргөдөл гаргагч иргэн П. Баттогтох, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр УИХ- ын гишүүн Д. Мөрөн нарыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд хийв.

1. Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн оршин суугч, Монгол Улсын иргэн П.Баттогтох Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцэд 2002 оны 03 дугаар сарын 01-ний өдөр хандаж гаргасан өргөдлөөс:

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт: " ... Хуульд заасан үндэслэл жүрмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалт бий. Гэтэл 1994 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчинтөгөлдөр үйлчилж эхэлсэн Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: " Олон нийтийн газар соггуугаар хэвийн бус яваа хүнийг тусгай байранд эрүүлжүүлэх, эсхүл хамгаалах хүнд хүлээлгэн өгнө", мөн зүйлийн 2 дахь хэсэгт: "Эрүүлжүүлэх жүрмыг Улсын ерөнхий прокуроротой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэж түс түс заасныг дурьдажээ.

Эрүүлжүүлнэ гэдэг бол тухайн этгээдийн эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээгээр хязгаарлаж буй үйл ажиллагаа билээ. Тодруулбал эрүүлжүүлэх ажиллагаа нь процессийн эрх зүйн ажиллагаануудын 2 хэсгээс бүрддэг бөгөөд үүнд:

1. Тухайн соггуу этгээдийг баривчлах буюу цагдаагийн албан хаагч хяналтандаа оруулж, барьж авч эрүүлжүүлэх байранд хүргэх үйл ажиллагаа
2. Тухайн соггуу этгээдийг албадан саатуулах буюу эрүүлжүүлэх байранд тодорхой хугацаагаар хорих үйл ажиллагааныудаас бүрддэг онцлогтой гэжээ.

Иймхүү соггуу этгээдийг эрүүлжүүлэх буюу баривчлах, эрх чөлөөг нь хязгаарлах үйл ажиллагаа хуульд заасан үндэслэл жүрмаар хийгдэх ёстой билээ. Эрүүлжүүлэх үндэслэлийг Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт: Олон нийтийн газар соггуугаар хэвийн бус явааҳҳҳхэмээн заасан байна.

Харин эрүүлжүүлэх жүрмыг түс хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт: "Цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэж заажээ.

Энэ нь хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагаа буюу эрүүлжүүлэх ажиллагаа явуулах үндэслэлийг хуулиар тогтоож тодорхойлсон боловч эрүүлжүүлэх жүрмыг тодорхой нэг албан тушаалтны эрх зүйн хэмжээний актаар зохицуулж байгаа нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчиж байна гэсэн байна.

Үндсэн хуулийн түс заалт нь хүний эрх чөлөөг хязгаарлах аливаа үйл ажиллагаа, жүрмыг гагцхүү хуулиар тогтоож хэлбэршүүлэх гэсэн агуулгыг илэрхийлж байгаа явдал хэмээн өргөдөл гаргагч үзсэн байна.

Дээрхи заалтыг үндэслэн хүний эрх чөлөөг хязгаарлах жүрмыг хуульчилж хэрэжүүлж байгаа бөгөөд тухайлбал, Захиргааны хариуцлагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Соггуурах, мансуурах донтой өвчтэй этгээдийг захиргааны жүрмаар албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх тухай хууль, Сэжигтэн яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хууль зэргийг нэрлэж болно хэмээжээ.

Иргэн П.Баттогтох өргөдлийнхөө шаардлагад Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчиж буй Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон уг заалт дээр үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 1994 онд батлагдсан нийтээр дагаж мөрдөгдөж байгаа Эрүүлжүүлэх жүрмыг хүчингүй болгож , Эрүүлжүүлэх жүрмыг хуульчлан хэлбэршүүлэхийг УИХ-д үүрэг болгосон шийдвэр гаргаж өгнө үү хэмээн хүсчээ.

Өргөдлийн шаардлага Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан Цэцийн харъяалан шийдвэрлэх асуудалд хамаарах учир Цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн 2002 оны 3 дугаар сарын 20-ны өдөр Маргаан хянан шалгах ажиллагаа үүсгэх тухай 06 тоот тогтоол гаргасан. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2002 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн 34 тоот албан бичгээр Их хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч томилуулж маргаантай холбогдсон тайлбар ирүүлэхийг УИХ-аас хүссэн юм.

2. Монгол Улсын Их Хурлын даргын 2002 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 05 тоот захирамжаар Үндсэн хуулийн Цэцийн өнөөдрийн хуралдаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгчээр томилогдсон УИХ-ын гишүүн Д.Мөрөн Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан тайлбартаа:

а/ Эрүүлжүүлэх арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13-т заасан: "... баривчлах,хорих, ... эрх чөлөөг нь хязгаарлах" албадлагын арга хэмжээнээс агуулгын хувьд өөр юм.

б/ "Эрүүлжүүлэх" үндэслэлийг Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Олон нийтийн газар согтуурваар хэвийн бус явдал..." гэж заасан иргэн П.Баттогтохын тайлбартай санал нэг байна. Харин мөн хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "эрүүлжүүлэх журмыг Цагдаагийн төв байгууллагын дарга Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн батлах"-аар заасныг Үндсэн хуулийн зөрчил гэж үзэх үндэслэлгүй гэж үзэж байна.

в/ "Эрүүлжүүлэх" гэдэг нь согтууруулах үндаас хэтрүүлэн хэрэглэсний улмаас хэвийн бус яваа этгээдийн амь насыг хамгаалах, түүнийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэхээс, өөрөөр хэлбэл согтуурлын улмаас өөрийгөө жолоодох чадвараа ямар нэг хэмжээгээр алдсан этгээд гэмтэж бэртэх, осолдох, хүйтний улиралд осгох, бусдын хууль бус үйлдэлд өртөж хохирох, бусдад гэмтэл учруулах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулан танхайрахаас сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллага, албан тушаалтны зүгээс авч байгаа урьдчилан сэргийлэх арга хэмжээ юм. Өөрөөр хэлбэл эрүүлжүүлэх ажиллагаа нь хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон үйл ажиллагаа биш, харин ч хүний эрхийг хамгаалах чиглэлээр хийж байгаа ажиллагаа юм.

г/ Эрүүлжүүлэх арга хэмжээ нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон хүний амьд явах эрхийг баталгаажуулж байгаагийн зэрэгцүүх нэг хүний эрх, негөө хүний эрхээр хязгаарлагдаг ардчилсан нийгмийн зарчимд бүрнээ нийцэж байгаа гэж үзэж байна.

д/ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 74 дүгээр тушаалаар "Эрүүлжүүлэх журам"-ыг батална да уг журмаар эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах шаардлага, эрүүлжүүлэх байранд хүлээн авах, түүнээс гаргах, эрүүлжүүлэх үйл ажиллагаанд тавих хяналт зэрэг зөвхөн процедурыг зааж өгсөн байна. Иймд Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, түүнийг үндэслэн гаргасан Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүлжүүлэх журам" нь Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэж үзэж байна гэжээ.

3. Иргэн П.Баттогтох Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн нэмэлт тайлбартаа:

а/ Үндэслэл гэдэг бол тухайн үйл ажиллагаат явуулах шалтгаан, нөхцөл байдал, ,

б/ Журам гэдэг бол тухайн үйл ажиллагаа болон түүнд оролцогчдын баримтлах дэг горимыг тогтоож, уг ажиллагааны дэс дарааллыг зохицуулж буй процессийн шинжтэй үйл ажиллагаа байдаг.

Журам нь эрх зүйн онолын үүднээс аваад үзвэл үйлчлэх хүчин чадлынхаа хувьд:

А/ Хууль

Б/ Хуульчилсан актын хэлбэрээр илэрч хэлбэрждэг.

Хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагаа буюу үндэслэл,журам нь гагцхүү хуулиар илэрч хэлбэржсэн байх ёстой гэсэн агуулга, утга санаат Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсэгт заасан: " ... Хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалт нь өөрөө агуулж байгаа юм. Өөрөөр хэлбэл хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагаа явуулах үндэслэл, журмыг хуульчилсан актаар биш, гагцхүү хуулиар хэлбэршүүлэхийн зорилго нь хүний эрх чөлөөг хязгаарлах ажиллагааны их нарийн бөгөөд төвөгтэй үйл ажиллагаа үчир үүнийг дан ганц албан тушаалтан болон түүнийг тойрсон хэсэг эвлөхүүдийн хүрээнд баталж

шийдвэрлэх биш, харин Улсын Их хурлын 76 гишүүн хамтаар хянан хэлэлцэж батална бүй нь хүний эрх, эрх чөлөөг төрөөс хэтрүүлэн зөрчихээс хамгаалж, сэргийдлэх ач холбогдолтой. Үүнийг ч Үндсэн хуулийн өмнө нь дурьдсан заалт хангаж, үйлчилж байгаа юм.

Тийнхүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үйл ажиллагаа болох " Эрүүлжүүлэх журам"-ыг УИХ-аас биш харин Цагдаагийн ерөнхий газрын дарга батлаж , мөрдүүлж бүй нь Үндсэн хууль зөрчиж бүй хэрэг мөн. Тодруулбал: Улсын ерөнхий прокуроротой зөвшилцөн Цагдаагийн ерөнхий газрын даргын гаргасан тушаалыг үндэслэн 1994 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн нийтээр дагаж мөрдөж буй " Эрүүлжүүлэх журам" нэртэй хуульчилсан актын агуулга нь Үндсэн хууль зөрчиж байгаагаас үл хамааран харин түүний хэлбэржсэн байдал болон батлах субъектэд тавигдах шаардлагыг хангаагүй байдал нь Үндсэн хуулийг зөрчиж байгаа болно.

Энэхүү зөрчлийг арилгахын тулд эрүүлжүүлэх ажиллагаа явуулах жүрмыг хуулийн хэлбэрт оруулах ёстой бөгөөд жишээ нь: эрүүлжүүлэх ажиллагаа явуулах жүрмыг Цагдаагийн байгууллагын тухай хууль, эсхүл Захиргааны хариуцлагын тухай хуульд тусгай нэг бүлэг болгон хуульчлах, эсхүл тусдаа бие даасан нэг хууль болгон хэлбэршүүлж болох юм.

Тиймээс Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийг зөрчиж бүй Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг болон үг заалтанд үндэслэн батлагдсан 1994 оны "Эрүүлжүүлэх журам", үг жүрмыг баталсан Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалыг тус тус хүчингүй болгож эрүүлжүүлэх ажиллагаа явуулах жүрмыг хуульчлахыг Улсын Их Хуралд тодорхой хугацаа заажүргэр болгосон шийдвэр гаргаж өгнө үү гэсэн саналаа дэмжиж байна гэжээ.

4. Өдрийн сонины 2002 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн дугааралс иргэн П.Баттогтохын эргэдлөөр Цэцэд маргаан хянан шалгах ажиллагаа үүсгэсэн тухай мэдээг хүлээн аваад Монголын Эмэгтэйчүүдийн холбоо Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн мөн өдрийн № 1/30 албан тоотдоо: Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан "Олон нийтийн газар сэгтуугаар хэвийн бус явах хүнийг тусгай байранд эрүүлжүүлэх" гэсэн заалт нь монгол улсын эгэл хирийн олон иргэдийн эрхэнд халдах нөхцөлийг бүрдүүлж байгаа нь үнэн юм. Тухайлбал: Цагдаа нар олгогдсон эрхээ давруулан, ямар ч хэв журам зөрчилгүйгээр бага зэрэг халамцуу явваа иргэдийг албаар баривчилж сүрдүүлэн хэдэн төгрөг салгах, нэгжлэг хийж юутай явааг нь мэдсэний дараа негөө хүнийг гудамжны буланд үл таних хүмүүс зодож мөнгө, эд зүйлсийг нь булаасан бодит тохиолдол олон байдаг бөгөөд эгэл жирийн иргэд цагдаагийн байгууллага, цагдаа нарт үл итгэж дүргүй байдгийн гол шалтгаан болдог юм. Мөн түүнчлэн бага зэрэг согтуу явсан настайвтар хүнийг өөр буудалд андуурч буусан байхад нь залуухан цагдаа сүрдүүлж түүнд байсан 2000 төгрөгийг нь авсан байсантай нь миний бие таарч бүв. Зарим цагдаа нар баар үушийн газарт хүмүүсийг ажиглаж , гарахыг нь отож байгаад албаар баривчилж мөнгө олдог нь нууц биш. Архаг архичин, жинхэнэ танхайрагчидтай ажиллахгүй хирнээ жирийн иргэдийн архи уусан байдлыг далимдуулан хүч хэрэглэж сүрдүүлдэг , албаар сөргөлдөх үүр амьсгал үүсгэж зодож нүддэг, тэгээд өршөөсөн дүр үзүүлж суллаад өөрсдөө мөнгө авдаг, цаагуураа хулгайчид, гар утасны наймаачидтай суйбээтэй байдаг зэрэг нь манай доод тушаалын цагдаа нарын хийдэг бизнес болсныг анхаарах цаг болсон. Өөрөө хэлбэл дээрхи заалт нь манай цагдаагийн байгууллага, цагдаа нарын ёс зүй төлөвшөөгүй байгаа өнөө үед иргэний эрх, эрх чөлөөнд бүдүүлгээр халдах бодит боломж олгож байгаа заалт мөн. Иймд хэрэв иймэрхүү заалт байх шаардлага байдаг бол "хэвийн бус" гэдгийг тодруулах, согтуугаар танхайрсан ямар нэгэн үйлдлийн үед баривчилж эрүүлжүүлэх ёстойг нарийвчлан зааж өгөх нь зүйтэй болов уу гэжээ.

5. Иргэн П.Баттогтох Үндсэн хуулийн Цэцийн хуралдааны оролцож гаргасан тайлбартаа:

Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокуроргой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батлаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчихөөс гадна мөн зүйлд заасан чөлөөтэй зорчих үндсэн эрхийг нэгэн адил зөрчиж байна. Дээр дурьдсан эрхүүд нь Үндсэн хуулинд заасан үндсэн эрхүүд учраас эдгээрийг гагцхүү хуулиар хязгаарлах боломжтой юм. Эрүүлжүүлэх журам, түүний агуулга өөрөө Үндсэн хуулийг зөрчсөн эсэхээс үл хамааран үндсэн эрхийг хязгаарлах асуудал хуульчилсан актаар бус, харин Улсын Их Хурлаас батлсан хуулиар хэлбэржсэн байх ёстой юм гэжээ.

6. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Мөрөн Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож гаргасан тайлбартаа:

а/ Иргэн П.Баттогтох өргөдөлдөө

эрүүлжүүлэх үйл ажиллагааг тайлбарлахдаа албадан саатуулах болон хорих гэсэн 2 үе шатаас бүрддэг хэмээн ойлгосон нь эрүүгийн процессийн үйл ажиллагаатай хольж, ялгаа заагийг анзаараагүй хэрэг болсон байна гэжээ. Албадан саатуулах болон хорих үйл ажиллагааны аль аль нь эрх бүхий байгууллагын тогтоолоор, гэмт хэрэгт сэжиглэгдсэн хүний хувьд холбогдох байгууллагаас зөвшөөрөл авах журмаар хэрэгждэг үйл ажиллагааныүү юм

б/ Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална гэсэн нь өөрөө хуулинд заасан журам болж байна.

в/ Дэлхийн улс орнуудын жишгийг ажиллахад эрүүлжүүлэх үйл ажиллагааг хүчний байгууллагагүйцэтгэдэг бус, харин Эрүүл мэндийн байгууллага гүйцэтгэдэг болсон нь хүний эрхийг хамгаалах талаасаа илүү зөв зүйтэй хэмээн үздэг. Энэ саналыг би өөрөө бас дэмждэг юм. Энэ ажлыг гүйцэтгэхэд Эрүүл мэндийн байгууллага, Цагдаагийн байгууллага хамтарч ажиллаж , үүнд Цагдаагийн байгууллага хэв журам хамгаалах талаас нь оролцвол илүү зүйтэй юм гэжээ.

ХЯНАВАЛ:

1.Эрүүлжүүлэх нь соггуугийн улмаас өөрийгөө хлоодох чадвараа ямар нэг хэмжээгээр алдсан хүнийг юуны өмнө өөрийг нь хамгаалахад чиглэсэн арга хэмжээ. Нөгөөтэйгүүр хамгаалах зорилгыг хэрэгжүүлэхийн тулд захиргааны байгууллагаас авч хэрэгжүүлж буй хуулиар зөвшөөрсөн захиргааны албадлагын арга хэмжээний нэгэн төрөл учир хүний эрхийг тодорхой хэмжээнд зайлшгүй хөндөж шинж чанартай байна.

2.Эрүүлжүүлэх нь соггуугаар явааа хүнийг цагдаагийн албан хаагчийн хяналтанд албадан авах, зориулалтын байранд хүлээн авах арга хэмжээ бөгөөд хэдийгээр хүнийг өөрийг нь элдэв ослоос хамгаалах зорилготой боловч хүний халдашгүй, чөлөөтэй байх тухай Үндсэн хуулинд заасан үндсэн эрхийн хүрээг хөндөж, хязгаарлаж байдаг. Дээр дурдсан үндэслэлүүдэд тулгуурлан Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр "Эрүүлжүүлэх журам"-ыг Улсын ерөнхий прокуроотой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батлах тогтоож эрхийг шилжүүлсэн явдал Үндсэн хуулийг зөрчсөн байна гэх үндэслэл тогтоогдож байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсэг мөн зүйлийн бусад хэсэгтэй харьцуулахад "Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн давхар хамгаалалттай байгаа учир Цагдаагийн байгууллагын тухай хуулийн дээрх заалт Үндсэн хуулийг зөрчиж байна гэх үндэслэл тогтоогдож байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйл, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийг удирдлага болгон

ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокуроотой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарга батална гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн... "...Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах,... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээж авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж хариу мэдэгдэхийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон УИХ- д уламжилъя.

ДАРГА Н.ЖАНЦАН

ГИШҮҮД Д. ЧИЛХААЖАВ

Н. ЧИНБАТ

Ч. ДАШНЯМ

Ц. САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 2 ☎ 329487

Эрдэм ахлах сургуулийн
номын сан

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 16 (253)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Гуйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай*
- *Монгол Улсын хилийг шалгасан баримт бичиг батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Тооны дээд хязгаар тогтоох тухай*
- *"Тогтвортой байдлын гэрээ"-ний загвар батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны дөрөвдүгээр сарын 30 №16 (253)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

160. Хууль, дүрэм соёрхон батлах тухай (2002-4-12-ны хууль) 605

161. Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 606

162. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 606

163. Монгол Улсын хилийг шалгасан баримт бичиг батлах тухай (2002-4-19-ний хууль) 606

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

164. Тооны дээд хязгаар тогтоох тухай Дугаар 42 607

165. Журам батлах тухай Дугаар 43 608

166. "Тогтвортой байдлын гэрээ"-ний загвар батлах тухай Дугаар 46 609

167. Журамд хамааруулах тухай Дугаар 47 612

168. "Ник" ХК-ийн төв лабораторийг олон улсын хаалттай уралдаант шалгаруулалтын аргаар худалдах тухай Дугаар 48 612

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛЬ , ДҮРЭМ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2000 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Иран Улсын Тегеран хотноо гарын үсэг зурсан "Ази, Номхон далайн бүсийн шуудан холбооны Үндсэн хууль, дүрэм"-ийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж. БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр — **Улаанбаатар хот**

ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 8 дугаар зүйлд "8.6. Хуулиар эрх олгогуй хувь хүн, байгууллага, албан тушаалтан гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно." гэсэн 6 дахь хэсэг нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр — **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "ахлах ахлагч" гэсний дараа "сургагч ахлагч, тэргүүн ахлагч" гэж, 28 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн "хүнсний болон эдийн хангамж" гэсний дараа "түүнчлэн аймгийн төв, нийслэлээс бусад сум, суурин газарт байрлаж буй радиотехник, радиолокаторын анги, салбарын офицер, ахлагч нар албан үүргээ гүйцэтгэж байгаа эсэхийг үл харгалзан хүнсний хангамж тус тус" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6.2. Зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүнийг нөхөн хангах жүрмыг батлан хамгаалах болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална."

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж. БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр — **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙГ ШАЛГАСАН БАРИМТ БИЧИГ БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийг 1987-2001 онд хийсэн шалгалтаар хоёр улсын хилийн шугамыг тодорхойлсон дор дурдсан баримт бичгийг баталсугай:

1/ Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийн шугамын тодорхойлолт – протокол;

2/ Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийн газрын зургийн альбом;

3/ Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийг шалгах үед үйлдсэн хилийн тэмдгийн протокол;

4/ Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хил дээр босгосон хилийн тэмдгүүдийн болон геодезийн эхлэл цэгүүдийн солбицлын жагсаалт.

2 дугаар зүйл. Монгол Улс, Оросын Холбооны Улсын хоорондын улсын хилийг хамтран шалгах явцад Монгол Улсын хилийн шугамд орсон өөрчлөлтийг баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 42 | Улаанбаатар хот

Тооны дээд хязгаар тогтоох тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. 2002 оноос "Цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаар"-ыг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Цэргийн албыг зохих журмын дагуу дүйцүүлэн хаалгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

Засгийн газрын 2002 оны 42 дугаар тогтоолын хавсралт

2002 оноос цэргийн албыг дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаар

	Аймаг, нийслэлийн нэр	Тооны дээд хязгаар
1.	Архангай	140
2.	Баян-Өлгий	-
3.	Баянхонгор	50
4.	Булган	45
5.	Говь-Алтай	50
6.	Говьсүмбэр	-
7.	Дархан-Уул	25
8.	Дорноговь	38
9.	Дорнод	100
10.	Дундговь	116
11.	Завхан	120
12.	Орхон	14
13.	Өвөрхангай	80
14.	Өмнөговь	30
15.	Сүхбаатар	105
16.	Сэлэнгэ	30
17.	Төв	80
18.	Увс	134
19.	Ховд	100
20.	Хөвсгөл	37
21.	Хэнтий	-
22.	Улаанбаатар	80
Дүн		1374

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 43 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

батлэсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журам"-ыг хавсралт ёсоор

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Засгийн газрын 2002 оны 43 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГААС ЖИЖИГ ЗЭЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан иргэн, аж ахуйн нэгжид Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл (цаашид "зээл" гэнэ) олгоход энэхүү журмыг баримтална.

2. Зээл нь ажлын байр нэмэгдүүлэх, иргэдэд хувираа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийг банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан олгоно.

Хоёр. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх банк болон банк бус санхүүгийн байгууллага

4. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх банк болон банк бус санхүүгийн байгууллага нь дор дурдсан нөхцөлийг хангасан байна:

-Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг нэг жилийн турш хангасан тухай хөндлөнгийн байгууллагын дүгнэлт гаргуулсан байх;

-зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг сангийн өмнө бүрэн хариуцахаа илэрхийлсэн баталгаа гаргаж нотариатаар баталгаажуулсан байх;

-зээлийн үйл ажиллагааг орон нутагт явуулах боломжтой байх.

5. Хөдөлмөр эрхлэлтийн сангаас жижиг зээл олгох үйл ажиллагааг гүйцэтгэх банк, банк бус санхүүгийн байгууллагыг сонгох тендерийг хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зарлан явуулж энэ журмын 4 дүгээр зүйлд заасан нөхцөлийг хангасан банк, банк бус санхүүгийн байгууллагыг сонгон шалгаруулна.

6. Тендерт шалгарсан банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгууллах гэрээнийг загварыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Гурав. Банк, банк бус санхүүгийн байгууллагатай байгуулах гэрээ

7. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага тендерт шалгарсан банк, банк бус санхүүгийн байгууллагатай зээлийн үйл ажиллагаа эрхлүүлэх гэрээ байгуулан ажиллана.

8. Гэрээнд дараахь асуудлыг тусгасан байна:

-талуудын эрх, үүрэг, хариуцах албан тушаалтан;

-банк, банк бус санхүүгийн байгууллагад байршуулсан зээлийн санд уг банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгох хүүгийн хэмжээ;

-эцсийн зээлдэгчдэд олгох зээлийн хэмжээ, хүү, хугацаа;

-зээлийн санд тавих хяналт;

-зээлийн көрөнгийг эргүүлэн татах нөхцөл;

-хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагатай

хамтран ажиллах нөхцөл;

-гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа;

-гэрээг цуцлах нөхцөл.

9. Гэрээг нотариатаар баталгаажуулна.

Дөрөв. Банк, банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан зээл олгох, зээлийн дээд хэмжээ, хүү, хугацаа

10. Хөдөлмөр эрхлэлтийн алба зээл авахыг хүссэн иргэн, аж ахуйн нэгжтэй ажлын байр бий болгох, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байраар хангах талаар гэрээ байгуулан банк, банк бус санхүүгийн байгууллагад тодорхойлолт гаргана. Энэхүү тодорхойлолт нь зээл олгоход шаардагдах баримт бичгийн бүрдэл хэсэг болно. Банк, банк бус санхүүгийн байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийн албаны тодорхойлолтгүйгээр зээл олгохгүй.

11. Банк, банк бус санхүүгийн байгууллага иргэн, аж ахуйн нэгжид зээл олгох эсэх асуудлыг дангаараа шийдвэрлэнэ.

12. Банк, банк бус санхүүгийн байгууллага нь зээлийн үйл ажилгааг зээлийн эрсдэлийг сангийн өмнө бүрэн хариуцна.

13. Эцсийн зээлдэгчид зээлийг нэг жил хүртэл хугацаагаар олгох бөгөөд түүний дээд хэмжээ нь 10,0 (арван) сая төгрөг хүртэл, хүү нь тухайн банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгож байгаа зээлийн хүүгээс илүүгүй байна.

Тав. Гэрээний биелэлтэд тавих хяналт, тайлан

14. Ажлын байр нэмэгдүүлэх талаар зээлдэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтэд Хөдөлмөр эрхлэлтийн алба хяналт тавина.

15. Аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн алба нь банк, банк бус санхүүгийн байгууллагаас олгосон зээлийн мэдээг дараа сарын 5-ны дотор авч нэгтгэн мөн сарын 10-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагад ирүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 24-өөр өдөр **Дугаар 46** **Улаанбаатар хот**

"Тогтвортой байдлын гэрээ"-ний загвар батлах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 20 дугаар зүйлийг үндэслэн Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Тогтвортой байдлын гэрээ"-ний загварыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тогтвортой байдлын гэрээний загвар батлах тухай" Засгийн газрын 1997 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 226 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Л.ЭРДЭНЭЧУЛУУН

Засгийн газрын 2002 оны 46 дугаар тогтоолын хавсралт

ТОГТВОРТОЙ БАЙДЛЫН ГЭРЭЭ

Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, ...хуулийн ... зүйлийн .... хэсэг заалт)-ийг үндэслэн нэг талаас Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж Монгол Улсын Санхүү, эдийн засгийн сайд /цаашид "Сайд" гэнэ/, нөгөө талаас тогтвортой байдлын гэрээ байгуулахаар хүсэлт гаргасан ..... улсад үүсгэн байгуулагдсан, аж ахуйн нэгжийн ..... тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрсөн ..... дугаартай гэрчилгээтэй, ашигт малтмалын орд ашиглах ..... дугаарын лиценз эзэмшигч .....үйл ажиллагаа явуулах ..... компани буюу ....

улсын иргэн ..... /цаашид хөрөнгө оруулагч гэнэ/-тай хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаа явуулах татварын орчныг тодорхой хугацаанд тогтвортой байлгах баталгаа болгож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Гэрээгээр зохицуулах зүйл

1.1. Энэхүү Гэрээ нь хөрөнгө оруулагч Монгол Улсын ..... аймаг /хот/-ийн ..... сум /дүүрэг/-ын нутаг дэвсгэрт ..... үйл ажиллагаа явуулахад нь татварын тогтвортой нөхцөлөөр хангах, тухайн хөрөнгө оруулалтын зорилго, хэмжээ, гэрээг цуцлах үндэслэл, хэрэгжүүлэх хугацаа, гэрээ байгуулагч талуудын эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Үндсэн нөхцөл

2.1. ..... хуулийн ..... зүйлийн ..... хэсэгт заасны дагуу хөрөнгө оруулагчийн анхны хөрөнгө оруулалтын хэмжээ нь ..... сая ам.доллар буюу түүнтэй тэнцэх төгрөгөөс багагүй байх тул ..... жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулав.

2.2. Хөрөнгө оруулагчийн төлбөл зохих аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ..... хувь, импортын барааны гаалийн албан татвар .... хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар ..... хувь, онцгой албан татвар ..... хувь, авто бензин, дизелийн түлшний албан татвар .... хувь буюу энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед үйлчилж байгаа хууль тогтоомжид заасан хувь, хэмжээнд байна.

2.3. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болох үед үйлчилж байгаа Засгийн газраас батлагдсан тэргүүлэх ач холбогдол бүхий салбарт болон экспортын бүтээгдэхүүний үйлдвэрлэлд хөрөнгө оруулж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэл явуулахдаа технологийн зориулалтаар ашиглах, үгсарч суурилуулах тоног төхөөрөмж, хүнд механизмыг импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө.

2.4. Хөрөнгө оруулагчийн экспортод гаргасан бараа, ажил, үйлчилгээнд ногдуулах нэмэгдсэн өртгийн албан татварын хувь хэмжээ "О"-тэй тэнцүү байна.

2.5. Хөрөнгө оруулагч төлбөл зохих ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг гэрээ хүчин төгөлдөр болох үед мөрдөгдөж байгаа ашигт малтмалын холбогдолтой харилцааг зохицуулж байгаа хуульд заасан хэмжээгээр тооцно.

2.6. Хөрөнгө оруулагч үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ экспортод гаргаж, олон улсын зах зээлийн үнээр борлуулах, үүнээс олсон төгрөгийн болон валютын орлогоо захиран зарцуулахад нь энэ талаар Монгол Улсын иргэн, хуулийн этгээдэд олгодогтой адил эрх, нөхцөлөөр хангана.

Гурав. Гэрээний хугацаа

3.1. Гэрээг 20.. оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн 20.. оны ... дүгээр сарын ...-ны өдрийг хүртэл ... жилийн хугацаатайгаар байгуулав.

Дөрөв. Хөрөнгө оруулагчийн үүрэг, эрх

4.1. Хөрөнгө оруулагч Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж, Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

4.2. Хөрөнгө оруулагч гэрээний хугацаанд үйл ажиллагаагаа тогтмол, хэвийн явуулах үүрэгтэй.

4.3. Хөрөнгө оруулагч Монгол Улсын нутаг дэвсгэр дээр энэхүү гэрээнд гарын үсэг зурснаас хойш ... жилийн хугацаанд нийт ..... сая ам.долларын хөрөнгө оруулалтыг дараахь хуваарийн дагуу хийнэ:

Хөрөнгө оруулалтын жил	Хугацаа	Хөрөнгө оруулалтын хэмжээ /сая ам.доллар/	Үүнээс	
			Мөнгөн хэлбэрээр	Бусад хэлбэрээр
1	20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс 20.. оны ... дугаар сарын ...-ны өдрийг хүртэл			
2	20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс 20.. оны ... дугаар сарын...-ны өдрийг хүртэл			
3	20.. оны ... дугаар сарын ...-ны өдрөөс 20.. оны ... дугаар сарын...-ны өдрийг хүртэл			

4.4. Энэхүү гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дараагийн жилийн мөн өдрийг хүртэлх хугацаанд энэхүү гэрээний хувьд "Хөрөнгө оруулалтын жил" гэж үзнэ.

4.5. Хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтын жилд оруулсан хөрөнгө оруулалтын тайлангаа дараагийн хөрөнгө оруулалтын жилийн эхний сард багтаан Санхүү, эдийн засгийн яамнаас баталсан маягтын дагуу гаргаж, тухайн салбарыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан Сайдад хүргүүлнэ.

4.6. Хөрөнгө оруулагч бүтээгдэхүүнээ борлуулснаас олсон орлогоо Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аль нэг арилжааны банкинд нээсэн дансанд эхлэн байршуулна.

4.7. Хөрөнгө оруулагч нь тухайн хөрөнгө оруулалтын жилд төлөвлөснөөс илүү хөрөнгө оруулалт хийсэн нөхцөлд давсан хэсгийг дараагийн жилийн хөрөнгө оруулалтад оруулж тооцох эрхтэй.

4.8. Хөрөнгө оруулалтыг бэлэн мөнгө, техник, тоног төхөөрөмж, түүхий эд, бараа материал, оюуны өмч болон хуулиар зөвшөөрөгдсөн бусад байдлаар хийх эрхтэй.

4.9. Сайд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас Тогтвортой байдлын гэрээний баталгаа алдагдсан тохиолдолд Хөрөнгө оруулагч баталгаат сэргээлгэх, үчирсан хохирлоо нөхөн төлүүлэхээр хуульд заасан журмын дагуу нэхэмжлэх эрхтэй.

Тав. Сайдын үүрэг, эрх*

5.1. Хөрөнгө оруулагчийн үйл ажиллагаагаа явуулах орчныг гэрээний хугацаанд тогтвортой байлгах талаар энэхүү Гэрээнд заасан баталгаа, нөхцөлөөр хангах үүргийг хүлээнэ.

5.2. Тогтвортой байдлын гэрээнд гарын үсэг зурсны дараа уг гэрээний нөхцөлийн тухай мэдэгдлийг холбогдох газруудад хүргүүлнэ.

5.3. Хөрөнгө оруулагч 4.3-т заасан хуваарийн дагуу хөрөнгө оруулалтаа хийж байгаа эсэхэд Сайд тухайн салбарыг хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хяналт тавина.

5.4. Хөрөнгө оруулагч энэхүү гэрээний 4.3-т заасан хэмжээ, хугацаанд хөрөнгө оруулахаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй 6 сар өнгөрвөл Сайд энэ тухай хөрөнгө оруулагчид бичгээр мэдэгдэл өгнө.

5.5. Мэдэгдэл өгснөөс хойш аажлын 30 хоногийн дотор Хөрөнгө оруулагч уг мэдэгдэлд заасан үүргийг биелүүлэх талаар зохих арга хэмжээ авааагүй тохиолдолд Сайд дангаар гэрээг цуцлах эрхтэй.

Зургаа. Гэрээ дуусгавар болох

6.1. Дараахь тохиолдолд гэрээ дуусгавар болно:

6.1.1. Гэрээний хугацаа дууссан тохиолдолд;

6.1.2. Хөрөнгө оруулагч гэрээг цуцлах тухай хүсэлт гаргасны дагуу хоёр тал харилцан тохиролцсон тохиолдолд;

6.1.3. Аж ахуйн нэгж дампуурсан, хууль тогтоомж зөрчсөний үчир эрх бүхий байгууллагаас үйл ажиллагаг нь бүрэн зогсоосон тохиолдолд.

Долоо. Бусад зүйл

7.1. Энэхүү Гэрээний үүргийн биелэлттэй холбогдон аливаа маргаантай асуудал үүсвэл Талууд хэлэлцэн тохиролцох замаар шийдвэрлэнэ. Нэгдсэн шийдэлд хүрээгүй тохиолдолд маргааныг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

**Сайд тухайн хөрөнгө оруулагчийн үйл ажиллагааны онцлог, тэдгээрийн саналыг харгалзан уг гэрээнд нэмэлт заалт, тодруулгыг хууль тогтоомжийн хүрээнд оруулж болно.*

7.2. Гэрээг 20.. оны ... дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод монгол, ... хэл дээр тус бүр 2 хувь үйлдэж баталгаажуулав.

7.3. Хувиуд нь адил хүчинтэй бөгөөд хэрэв гэрээг хэрэгжүүлэх, тайлбарлахад маргаан гарвал монгол хэл дээрх эх бичвэрийг баримтална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж, ...

компанийг төлөөлж, Санхүү,эдийн засгийн сайд .....

/...../ /...../

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 47** **Улаанбаатар хот**

Журамд хамааруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын зүгээс гүйцэтгэж байгаа тодорхой төрлийн ажил, үйлчилгээг хувийн болон төрийн бус байгууллагын хөрөнгөөр гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа Засгийн газрын 2000 оны 101 дүгээр тогтоолоор батлагдсан "Бараа, ажлын гүйцэтгэгчийг сонгоход баримтлах тусгай журам" болон "Зөвлөхийг сонгоход баримтлах тусгай журам"-уудыг мөрдөж ажилласугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 48** **Улаанбаатар хот**

"НИК" ХК-ийн төв лабораторийг олон улсын хаалттай уралдаант шалгаруулалтын аргаар худалдах тухай

Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 2.1.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"НИК" хувьцаат компанийн нефтийн бүтээгдэхүүний чанарын итгэмжлэгдсэн төв лабораторийг олон улсын хаалттай уралдаант шалгаруулалтын аргаар худалдахыг Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 1 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 17 (254)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*
- *Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны тавдугаар сарын 10 №17 (254

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

169. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 614
170. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 614
171. Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 615
172. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 617
173. Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 618
174. Гаалийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-4-19-ний хууль) 619
175. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-4-25-ны хууль) 619
176. Ан агнуурын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-4-25-ны хууль) 619
177. Ойн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-4-25-ны хууль) 620
178. Гэрээ соёрхон батлах тухай (2002-4-25-ны хууль) 620
179. Гэрээ соёрхон батлах тухай (2002-4-26-ны хууль) 621
180. Гэрээ соёрхон батлах тухай (2002-4-26-ны хууль) 621

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

181. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай Дугаар 09 621
182. Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Дугаар 10 621
183. Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай Дугаар 11 621

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

184. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 42 622
185. Далрайн Даваасамбууг Элчин сайдаар томилох тухай Дугаар 43 622
186. Ким Ён Хи, Хо Сук Тэ нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 44 622
187. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 47 623

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

188. Хөрөнгө гаргах тухай Дугаар 49 623
189. Тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 50 623
190. Тужийн нарсны ойг нөхөн сэргээх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 51 624
191. Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай Дугаар 52 624

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "эхний 6 өдрийн" гэснийг "ажлын эхний 5 өдрийн"; " 7 дахь өдрөөс" гэснийг "6 дахь өдрөөс"; мөн зүйлийн 2 дахь хэсгийн "эхний 6 хоногийг оролцуулан ажлын 78 хоногоос" гэснийг "ажлын эхний 5 өдрийг оролцуулан ажлын 66 өдрөөс"; "156 хоногийн хугацаанд" гэснийг "ажлын 132 өдрийн хугацаанд"; мөн зүйлийн 3 дахь хэсгийн "нийтдээ 156 хоногоос" гэснийг "нийтдээ ажлын 132 өдрөөс" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Улаанбаатар хот**

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС ОЛГОХ АЖИЛГҮЙДЛИЙН ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ "12 дугаар зүйл. Мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах

12.1.Хөдөлмөр эрхлэлтийн алба нь ажилгүйдлийн тэтгэмж авах болзол хангасан даатгуулагчийн хүсэлтээр түүнийг ажилгүй болсноос нь хойших 6 сарын дотор мэргэжил олгох болон давтан сургалтад хамруулж, сургалтын зардлыг ажилгүйдлийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасны дагуу сургалтад хамрагдсан даатгуулагч мэргэжил олгох болон давтан сургалтад хамрагдсанаас хойш хөдөлмөр эрхлээгүй бол 2 жилийн дараа сургалтад дахин хамрагдаж болно.

12.3. Ажилгүйдлийн даатгалын сангаас сургалтад хамрагдах нэг даатгуулагчид олгох зардлын дээд хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно."

2 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "олгохтой" гэсний дараа "мэргэжлийн сургалтад хамруулахтай"; 2 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн гарчиг болон 1 дэх хэсгийн "авах" гэсний дараа ",мэргэжлийн сургалтад хамрагдах"; 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "олгох" гэсний дараа ",мэргэжлийн сургалтад хамруулах"; 10 дугаар зүйлийн гарчиг болон 1 дэх хэсгийн "ажилгүйдлийн" гэсний өмнө "мэргэжлийн сургалтад хамрагдах" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн 5,6,7,9 дүгээр зүйлүүдийн "хөдөлмөрийн бирж" гэснийг "хөдөлмөр эрхлэлтийн алба"; 1 дүгээр зүйлийн "олгохтой" гэснийг "олгох" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 28^1 дугаар зүйл:

"28^1 дугаар зүйл. Эмнэлгийн төлбөргүй тусламж, үйлчилгээ

28^1.1. Монгол Улсын иргэнд түүний эрүүл мэндийн даатгалд даатгуулсан эсэхээс үл хамааран эмнэлгийн дараахь тусламж, үйлчилгээг төлбөргүй үзүүлнэ:

28^1.1.1. эмнэлгийн яаралтай болон түргэн тусламжийн үйлчилгээ;

28^1.1.2. сүрьеэ, хорт хавдар, сэтгэцийн болон удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах зарим эмгэгийн эмчилгээ, халдвар судлалын үйлчилгээ, төлөвлөгөөт урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл;

28^1.1.3.жирэмсэн, төрөх, төрсний дараахь үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар/;

28^1.1.4.байгалийн гамшиг, гэнэтийн аюул, осол болон нийтийг хамарсан аюул бүхий халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ;

28^1.1.5.аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар, эсхүл их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн, өвчилсөн хүний эмчилгээ.

28^1.2. Энэ хуулийн 28^1.1-д заасан төлбөргүй тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар, 28^1.1.2-т заасан өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

2/ 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"8.2. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд орон тооны бус мэргэжлийн зөвлөл байгуулан ажиллуулна. Мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

3/ 11 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг:

"11.2. Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэд нийгмийн эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг улсын хэмжээнд зохицуулах үүрэг бүхий орон тооны бус Үндэсний зөвлөл байгуулан ажиллуулж болно. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Засгийн газар батална.

11. 3. Бүс нутгийн хүн амд эрүүл мэндийн төрөлжсөн, нарийн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сургалт, сурталчилгаа хийх, эрүүл мэндийн лавлагаа, тусламж, үйлчилгээ эрхлэх бүсийн оношлогоо, эмчилгээний төв ажиллуулж болно. Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн үлгэрчилсэн дүрмийг Засгийн газар батална."

4/ 16 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"16.3.Барилга байгууламж, тоног төхөөрөмж, мэргэжлийн боловсон хүчний бэлтгэл, ур чадвар, ёс зүйн түвшинг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ явуулах технологи, чанар, стандартын шаардлага хангасан эрүүл мэндийн байгууллагад 5 хүртэл жилийн хугацаагаар магадлан итгэмжлэл олгоно.

16.4.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь магадлан итгэмжлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ орон тооны бус шинжээчийг сонгон шалгаруулж ажиллуулна. Шинжээч сонгон шалгаруулах, ажиллуулах журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

5/ 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"21.2. Энэ хуулийн 28^1 дугаар зүйлд заасан эмнэлгийн төлбөргүй тусламж, үйлчилгээний зардал болон төрийн өмчийн эмнэлгийн байгууллага,

өрхийн эмнэлгийн тогтмол зардлыг төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ."

6/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 18 дахь заалт:

"3.1.18."эмнэлгийн багаж, тоног төхөөрөмж, хэрэгсэл" гэж хүний бие махбодийн үйл ажиллагаа, согогийг орлуулах, нөхөх, эмчлэх, сувилах зориулалтаар бүтээгдсэн зүйлийг."

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн "бодлого" гэсний дараа "үндсэн"; "хамгаалуулах" гэсний дараа "нийгмийн эрүүл мэндийн болон"; "тусламж" гэсний дараа "үйлчилгээ"; "иргэн" гэсний дараа "албан тушаалтны"; 12.3-ын "тусгай зөвшөөрөл авахад" гэсний дараа "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1-д зааснаас гадна"; 22.1, 22.2, 22.3, 24.1-ийн "эзэмшүүлэх" гэсний дараа "тусгай"; 27.1-ийн "газраас" гэсний дараа "голомт цомхотгосноос хойш 1 сарын дотор"; 47.1.1, 47.1.2-ын "тусламж" гэсний дараа "үйлчилгээ"; 51.1.5-д "зөрчсөн бол" гэсний дараа "иргэнийг 20000-30000,"гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 13 дугаар зүйл:

"**13 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

13.1. Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлд заасан үндэслэлээр уг тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хүчингүй болгоно."

2/ 17 дугаар зүйл:

"**17дугаар зүйл. Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрөл олгох**

17.1.Эмнэлгийн мэргэжилтэнд олгох эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл нь ерөнхий мэргэжлийн болон нарийн мэргэшлийн гэсэн төрөлтэй байна.

17.2.Анагаах ухааны болон эм зүйн, сувилахуйн боловсрол эзэмшүүлэх тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгсөж, мэргэжлийн шалгалтад тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд ерөнхий мэргэжлийн зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгоно.

17.3.Ерөнхий мэргэжлээр 2-оос доошгүй жил ажилласны дараа төгсөлтийн дараахь сургалтад хамрагдаж, эмнэлгийн нарийн мэргэшлийн шалгалт өгч тэнцсэн эмнэлгийн мэргэжилтэнд тухайн мэргэшлийн зөвшөөрлийг 5 жилийн хугацаагаар олгоно.

17.4.Мэргэжлийн бүюу эрдмийн зэрэг хамгаалсан, эсхүл мэргэжлэзрэз 20-оос доошгүй жил ажилласан эмч, сувилагч, эм зүйчид эмчлэх, сувилах, эм барих зөвшөөрлийг хугацаагүйгээр олгоно.

17.5.Анагаах ухааны болон эм зүй, сувилахуйн боловсрол эзэмшсэн, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эмчлэх, эм барих, сувилах үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг 5 хүртэл жилийн хугацаагаар олгож болно.

17.6.Эмнэлгийн мэргэжилтэнд эмчлэх, сувилах, эм барих үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно."

3/ 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"23.3. Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд Ёс зүйн хороо байгуулан ажиллуулна. Ёс зүйн хорооны дүрэм болон эмнэлгийн мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

4/ 44 дүгээр зүйл:

"**44 дүгээр зүйл. Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, худалдах, импортлох**

44.1. Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, худалдах, импортлох үйл ажиллагааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд эрхэлнэ.

44.2. Эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, худалдах, импортлохоод түүнийг бүтээсэн материалын бүтэц, чанар, тухайн хэрэгслийн техникийн болон чанарын баталгаажуулалтын баримт бичгийг хавсаргасан байна."

5/ 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"37.1. Эхийн хэвлий дэхураг удамшлын болон бие эрхтний гаж хөгжилтэй болох нь тогтоогдсон, эсхүл тухайн жирэмсэлт нь эхийн амь насанд ноцтой аюул учруулж болох онцгой нөхцөлд жирэмсэн эх, шаардлагатай гэж үзвэл түүний нөхөөс бичгээр зөвшөөрөл авч, жирэмсэлтийг эмнэлгийн аргаар тасалж болно."

7/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалт:

"3.1.11 "дархлаажуулалт" гэж халдварт өвчнөөс сэргийлэх, түүний тархалтыг хязгаарлах, өвчнийг устгах зорилгоор дархлаажуулах бэлдмэл хэрэглэх арга хэмжээний тогтолцоог;"

8/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12 дахь заалт:

"3.1.12. "донор" гэж бусдын эрүүл мэнд, амь насыг аврахад зориулан өөрийн биеийн эд эрхтэн, цусыг сайн дураараа өгөгч болон зарим эд эрхтэнг нь шилжүүлэн суулгах зорилгоор авч болох цогцсыг;"

9/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалт:

"3.1.13."олон улсын хөл хориот өвчин" гэж олон улсын эмнэлэг, ариун цэврийн дүрэмд заасан өвчнийг;"

10/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16 дахь заалт:

"3.1.16. "сувилах" гэж өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг иларшуулах болон өвчтнийг сэргээн засахад чиглэгдсэн сувилагчийн мэргэжлийн цогц үйл ажиллагаа;"

11/ 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 11 дэх заалт:

"51.1.11. энэ хуулийн 28'.1, 49.1.1, 49.1.4-ийг зөрчсөн албан тушаалтныг 30000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 150000-250000 төгрөгөөр торгох."

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 3.1.7-ын "эрүүл ахуйч" гэснийг "нийгмийн эрүүл мэндийн ажилтан"; 4.2.2-ын "урьдчилан сэргийлэлтийг" гэснийг "нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг"; 10.1.5, 27.1, 27.2, 27.3-ын "гоц аюулт халдварт" гэснийг "олон улсын хөл хориот"; 24.1-ийн "төгсөж" гэснийг "төгссөн"; 24.2-ын "Тангараг өргөсөн Хүний их эмч Төрийн далбаанаас адис авч хүндэтгэл үйлдэнэ" гэснийг "Тангараг өргөх, хүндэтгэл үйлдэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."; 29.2 дахь хэсгийн "гоц аюулт" гэснийг "олон улсын хөл хориот"; 51.1.4-ийн "100000" гэснийг "150000" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 24.1-ээс "эмчлэх үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан" гэснийг хассугай.

6 дугаар зүйл. Эрүүл мэндийн тухай хуулийн 4.1.5, 22.4-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Улаанбаатар хот**

АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12.7 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ЭМИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эмийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/16¹ дүгээр зүйл:

"16¹ дүгээр зүйл. Мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн хяналт

16¹.1.Монгол Улсад хэрэглэгдэх мансууруулах, сэтгэц нөлөөт эмийн жагсаалт, худалдаж жүрмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

16¹.2.Мансууруулах, сэтгэц нөлөөт эм, тэдгээрийн уутвар бодисыг үйлдвэрлэх, худалдах тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

16¹.3.Энэ хуулийн 16¹.2-т заасан тусгай зөвшөөрлийг олгох, тудгэлзүүлэх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна."

2/8 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:

"8.7.Ховор тохиолддог өвчнийг эмчлэхэд харьцангуй бага хэмжээгээр хэрэглэдэг эм /өнчин эм/-ийг улсын бүртгэлд бүртгүүлэхгүйгээр импортлоно. Эдгээр эмийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

3/13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"13.5.Эмийн сан, түүний салбар нь эмнэлгийн багаж, хэрэгсэл, ариутгалын бодис, хувийн ариун цэврийн хэрэгсэл, эмчилгээний, хүүхдийн, дэглэм сахиулах хоол, гоо сайхны бүтээгдэхүүн худалдаж болно."

2 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 7.2.2-ын "эмийн" гэсний дараа "үйлдвэрлэл"; 14.1.3-ын "хороор олгох эмийг жоргүйгээр" гэсний дараа ", эсхүл хүчингүй хороор" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 1 дүгээр зүйл:

"1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүний болон мал эмнэлгийн зориулалттай эм, биобэлдмэл /цаашид "эм" гэх/-ийг үйлдвэрлэх, импортлох, хадгалах, худалдах, түгээх, хэрэглэх, хянах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино."

2/8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"8.5.Эм импортлох тусгай зөвшөөрөл ээзэмшигч нь гадаадын эм нийлүүлэгч байгууллагатай гэрээ байгуулсан байна."

3/12 дугаар зүйл:

"12 дугаар зүйл. Эм барих үйл ажиллагаа явуулах

12.1.Эрүүл мэндийн тухай хуулийн 22.3-т заасан зөвшөөрөл бүхий хүн эм барих үйл ажиллагаа эрхэлнэ.

12.2.Эм барих эрх бүхий эм зүйч, эм найруулагч, малын эмчээс бусад этгээд жороор олгох эм найруулах, бэлтгэх, шалгах, олгох, худалдахыг хоригломо.

12.3.Мал эмнэлгийн боловсрол ээзэмшүүлэх тусгай зөвшөөрөл бүхий сургууль тегсөж, мэргэжлээрээ ажиллах итгэмжлэл авсан малын эмч малын эм барих үйл ажиллагаа эрхэлнэ."

4/9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"9.3.Зорчигчийн хувийн хэрэглээнийэмийг улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг Гаалийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн дагуу зохицуулна."

5/10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"10.1.Малын эмийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, хүний эмийн үйлдвэрлэл эрхлэх тусгай зөвшөөрлийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тус тус олгоно."

6/14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"14.1.6.зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэхээр заасан болон үнэ төлбөргүй олгох зориулалттай буцалтгүй тусламжийн эмийг худалдах."

7/18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"18.1.Монгол Улсад шинээр бүтээгдсэн эм, эмийн түүхий эдийг бүртгэх, үнэлэмж өгөх, чанарыг баталгаажуулах жүрмыг хууль тогтоомжид нийцүүлэн төрийн захиргааны холбогдох байгууллага тогтоож мөрдүүлнэ."

4 дүгээр зүйл. Эмийн тухай хуулийн 3.1.7, 4.3, 5.3.2, 5.3.5, 7.2.3, 10 дугаар зүйлийн нэр, 10.2, 11 дүгээр зүйлийн нэр, 11.1, гуравдугаар бүлгийн нэр, 16 дугаар зүйлийн нэр, 6.1.1, 16.1, 16.2-ын "эм, эмнэлгийн хэрэгслийн" гэснийг "эмийн"; 4.2, 7.1, 13.1,13.3, 14.1.1, 14.1.4-ын "эм, эмнэлгийн хэрэгслээр" гэснийг "эмээр"; 18.4-ын "эм, эмнэлгийн хэрэгслийг" гэснийг "эм, эмийн түүхий эдийг"; 8.6-ын "бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн" гэснийг "бэлдмэлийн"; 6.3-ын "эм, эмнэлгийн хэрэгсэлд" гэснийг "эмэнд"; 5.3.3, 6.2, 6.3, 7.3, 7.4, 8 дугаар зүйлийн нэрийн "эм, эмнэлгийн хэрэгслийг" гэснийг "эмийг"; 10.2.3-ын "үйлдвэрлэх бүтээгдэхүүн" гэснийг "түүхий эд"; 18.3-ын "эм, эмнэлгийн хэрэгслийн" гэснийг "эм, эмийн түүхий эдийн"; 18 дугаар зүйлийн нэрийн "эмнэлгийн хэрэгсэл" гэснийг "эмийн түүхий эд"; 19.1-ийн "импортлох, экспортлохтой" гэснийг "импортлохтой" гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 5.3.3,

16.3-ын "экспортлох"; 13.4, 16.3-ын "эмнэлгийн хэрэгсэл"; 8.4-ын "мэргэжлийн бус"; 11.1.1-ийн "болон эрх бүхий байгууллагаар чанарын баталгаажуулалт хийгдээгүй эмнэлгийн хэрэгсэл" гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Эмийн тухай хуулийн 3.1.4, 7.2.1, 10.2.8, 10.2.9, 15.3-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Улаанбаатар хот**

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 32 дугаар зүйлд "2. Зорчигчийн хувийн хэрэглээний эмийн тоо хэмжээ, улсын хилээр нэвтрүүлэх журмыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн гаалийн төв байгууллага батална." гэсэн 2 дахь хэсэг нэмсүгэй.

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн гарчигт "эд зүйлс" гэсний дараа ",эм" гэсэн үг нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр **Улаанбаатар хот**

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 9, 10, 11 дүгээр заалт нэмсүгэй:

"9/нөөтэй зөрчил гаргах үед ашигласан тээврийн хэрэгслийг хураах. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага уг шийдвэрийг үл зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана;

10/хууль тогтоомж, технологийн зөрчил гаргаж байгаль орчинд хохирол учруулсан аж ахуйн нэгж, байгууллагын лицензи, зөвшөөрөл, байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулах эрхийг хүчингүй болгуулах саналаа тухайн эрх олгосон байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

11/байгаль орчны тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан байгууллага, албан тушаалтны шийдвэрийг хүчингүй болгохыг шаардах, эсхүл дээд шатны байгууллагад гомдол гаргаж, шийдвэрлүүлэх."

2 дугаар зүйл.Байгаль орчны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"6/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах явцдаа тухайн иргэний болон тээврийн хэрэгслийн баримт бичгийг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд баримт бичиг, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн, олборлосон байгалийн баялаг, ашигласан техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг хураах;"

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр **Улаанбаатар хот**

АН АГНУУРЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ан агнуурын тухай хуулд дараахь зүйл, хэсэг нэмсүгэй:

1/"15[1] дүгээр зүйл. Ан амьтны гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглох

15[1].1.Энэ хуулийн 7.3-т заасан тодорхойлолт аваагүй ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах, худалдан авахыг хоригломо."

2/7 дугаар зүйлийн 3, 4 дэх хэсэг:

"7.3.Ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдах иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад

тухайн сум дахь байгаль орчны улсын байцаагч гарал үүслийн тодорхойлолт /цаашид "тодорхойлолт" гэх/ олгоно.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан тодорхойлолтын загвар, олгох журам, тодорхойлолт олгогдвол зохих ан амьтан, тэдгээрийн түүхий эдийн жагсаалтыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална."

2 дугаар зүйл. Ан агнуурын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.1.Тусгай зориулалтаар ангуурын ховор ан амьтан агнах, барих болон тусгай төлбөр төлсөн гадаадын иргэнд ан амьтан агнуулах, бариулах зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, бусад агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно."

2/16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалт:

"16.1.6.зохих эрхийн бичиг, тусгай зөвшөөрөлгүйгээр ахуйн болон тусгай зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан, энэ хуулийн 7.3-д заасан жагсаалтад орсон ан амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол хураах, иргэнийг 10000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгох;"

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хот

ОЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Ойн тухай хуулийн 27 дугаар зүйлд 4, 5 дахь хэсэг, 28 дугаар зүйлд 7 дахь заалт нэмсүгэй:

1/27 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:

"4.Зохих журмын дагуу бэлтгэсэн гуалин, дүнз, зүсмэл материал, нойтон шургаагийг бэлтгэсэн газраас нь өөр аймаг, сум, хот, суурингийн хооронд тээвэрлэх, худалдах тохиолдолд мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ олгоно.

5.Мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээний загвар, олгох журмыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална."

2/28 дугаар зүйлийн 7 дахь заалт:

"7/зохих журмын дагуу бэлтгэсэн гуалин, дүнз, зүсмэл материал, нойтон шургаагийг өөр аймаг, сум, хот суурингийн хооронд тээвэрлэх, худалдахдаа мод, модон түүхий эдийн гарал үүслийн гэрчилгээ авна."

2 дугаар зүйл. Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтын "зохих" гэсний дараа "гарал үүслийн гэрчилгээ," гэж; "...түлээ бэлтгэсэн" гэсний дараа "тээвэрлэсэн, худалдсан," гэж; "... хууль бусаар бэлтгэсэн" гэсний дараа ",тээвэрлэсэн" гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Ойн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"2.Нөхөн төлбөрийн хэмжээг тогтоохдоо бэлтгэж ашигласан модыг экологи-эдийн засгийн үнэлгээгээр нь, ойн дагалт баялгийн нөхөн төлбөрийг түүнийг мөнгөн үнэлгээгээр тогтооно."

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Орон сууцны санхүүжилтийн төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2002 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан Зээлийн Гэрээг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Шүүх, эрх зүйн шинэчлэлт төсөл"-ийг хэрэгжүүлэхээр Монгол Улс, Олон улсын Хөгжлийн Ассоциацийн хооронд 2002 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр байгуулсан Хөгжлийн Зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хөдөө орон нутгийн санхүүжилтийн төслийг хэрэгжүүлэхээр Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2002 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр байгуулсан Зээлийн Гэрээг Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Дугаар 09** **Улаанбаатар хот**

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг даатгуулагчийн шимтгэл төлөх, тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох цалин хөлс, олговрын бүрэлдэхүүнийг хуульчлан тогтоох шаардлагатай эсэх, хуульчлах шаардлагатай бол орлогын бүрэлдэхүүн ямар байх, мөн нийгмийн даатгалын үзэл баримтлалыг боловсронгуй болгох, нийгмийн даатгалын хуульд тогтоомжийг иж бүрнээр нь боловсруулан оруулах нь зүйтэй байгаа зэрэг үндэслэлээр хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Дугаар 10** **Улаанбаатар хот**

Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн арван тавын 15.1.6 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Эрүүлжүүлэх журмыг Улсын ерөнхий прокуроротой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална." гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13-ын "... Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... баривчлах, ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно." гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Дугаар 11** **Улаанбаатар хот**

Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн арван тавын 15.1.5, 15.1.6 дахь заалтуудыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Анхан шатны болон давж заалдах, хяналтын

журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй" гэсний дараа "Энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "шүүгч хараат бус байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 184 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин наймдугаар зүйлийн 1, 2, тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Дугаар 42 Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Румын Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Булгаагийн Алтангэрэлийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Румын Улсад хавсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Бүдрагчаагийн Даш-Ёндонг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Дугаар 43 Улаанбаатар хот

Далрайн Даваасамбууг Элчин сайдаар томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Далрайн Даваасамбууг Монгол Улсаас Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр Дугаар 44 Улаанбаатар хот

Ким Ён Хи, Хо Сук Тэ нарыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, БНСУ-ын харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БНСУ-ын Намянжу хотын дарга Ким Ён Хи, мөн хотын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга Хо Сук Тэ нарыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Дугаар 47** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, "Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дагвын Цахилгааныг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандагвын Амарсанаат тохоон томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 49** **Улаанбаатар хот**

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Лалын Бүгд Найрамдах Афганистан Улсад хүмүүнлэгийн тусламж болгон 150 мянган тун панкипсин эмийг нийлүүлэхэд 52.0 (тавин хоёр) сая, түүнийг тээвэрлэх зардалд зориулан 19.8 (арван есөн сая найман зуун мянга) сая, нийт 71.8 (далан нэгэн сая найман зуун мянга) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөрөнгө гаргах тухай" Засгийн газрын 2001 оны 9 дүгээр сарын 19-ний өдрийн 207 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ГАДААД ХЭРГИЙН САЙД **Л.ЭРДЭНЭЧУЛУУН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 27-ны өдөр **Дугаар 50** **Улаанбаатар хот**

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 75 дугаар тогтоолын 2 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай "ж" заалт нэмсүгэй:

"ж/Нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй, хяналтын газар;

-Засгийн газрын байгууллагын бүртгэлийн бодлого, арга зүйн хэлтэс;"

2. Тогтоолын 2 дугаар зүйлийн "ж" гэснийг "з" гэж, "з" гэснийг "и" гэж тус тус өөрчилж, мөн зүйлийн "е" заалтын "-нягтлан бодох бүртгэл, магадлагааны хэлтэс" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 51** | **Улаанбаатар хот**

Тужийн нарсны ойг нөхөн сэргээх талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Байгаль орчны сайд У.Барсболдод даалгах нь:

а/Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Шаамар, Сүхбаатар сумын хил залгаа нутаг дэвсгэрийн зарим хэсгийг хамарсан Тужийн нарсны ойг нөхөн сэргээх ажлыг 2002 оноос эхлэн эрчимтэй зохион байгуулж, энэ ажилд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг өргөнөөр татан оролцуулах арга хэмжээ авч ажилласугай;

б/Тужийн нарсны ойг нөхөн сэргээх төсөл хэрэгжүүлж хандив, тусламжаар хөрөнгө оруулах талаар гадаад орон, олон улсын байгууллагатай идэвхтэй хамтран ажиллаж, хамтын ажиллагаог өргөжүүлэх арга хэмжээ авсугай.

2. Тужийн нарсны ойг нөхөн сэргээх, таримал ойг түймэр, хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэхэд гадаад орон, олон улсын байгууллагаас олгож байгаа хандив, тусламж, төслийн нөхцөл, болзолтой уялдуулан Монголын талаас гаргах хөрөнгийн эх үүсвэрийг тухай бүр шийдвэрлэж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгасугай.

3. Тужийн нарсны ойг нөхөн сэргээх, уг ойд арчилгаа, цэвэрлэгээ явуулж түлшний модны хэрэгцээг хангах, мод боловсруулах жижиг үйлдвэрлэл эрхлэх зэрэг ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг татан оролцуулж, ажлын байр шинээр бий болгох арга хэмжээг төв, орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгасугай.

4. Тужийн нарсны ойг нөхөн сэргээх ажилд өөрсдийн санаачилгаар оролцож байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг шаардагдах үр, тарьц, суулгацаар хангах, талбайг хуваарилан хөрсийг боловсруулах, хаягжуулах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, ойжуулалт хийсэн талбайн хамгаалалт, арчилгааг нь тодорхой аж ахуйн нэгж, иргэдэд хариуцуулан явцыг хянаж үр дүнг тооцох, энэ талаар нийтэд сурталчлах зэрэг арга хэмжээ авч байхыг Байгаль орчны сайд У.Барсболд, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Р.Нямсүрэн нарт үүрэг болгосугай.

5. Тужийн нарсны ойг нөхөн сэргээх арга хэмжээний хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж шаардагдах хөрөнгийг гарган Тужийн нарсны ойг нөхөн сэргээхэд зориулсан мод үржүүлгийн газруудыг өргөжүүлэх, шинээр байгуулах замаар сайн чанарын үр, тарьцны нөөцтэй болох арга хэмжээ авахыг Сэлэнгэ аймгийн Засаг дарга Р.Нямсүрэнд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 27-ны өдөр | **Дугаар 52** | **Улаанбаатар хот**

Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Улсын ерөнхий байцаагчийн эрх олгох тухай" Засгийн газрын 1999 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн 41 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 1.2 ☎ 329487



Улсын Их Хурлын Тамгын газар
Номын сан



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (255)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай*
- *Гэрээнд нэгдэн орох тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны тавдугаар сарын 17 №18 (255)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

192. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай (2002-4-25-ны хууль) 625
193. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-4-25-ны хууль) 630
194. Гэрээнд нэгдэн орох тухай (2002-5-2-ны хууль) 630
195. Гэрээнд нэгдэн орох тухай (2002-5-2-ны хууль) 630

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

196. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 12 630

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

197. Монгол Улсын гэр бүлийн тухай хуулийн заримзүйл, заалтыг тайлбарлах тухай Дугаар 71 631
198. Дээд шүүхийн 1998 оны 62 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 123 636

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь эрүүл мэндийн даатгалын хэлбэр, хамрах хүрээг тогтоож, эрүүл мэндийн даатгалд даатгуулж шимтгэл төлөх, эрүүл мэндийн даатгалын санг бүрдүүлэх, хуваарилах, зарцуулахтай холбогдсон даатгалын болон эрүүл мэндийн байгууллага, төр, иргэн, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж

2.1. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай

хууль тогтоомж нь Үндсэн хууль[1], Нийгмийн даатгалын тухай[2], Нийгмийн халамжийн тухай[3], Эрүүл мэндийн тухай хууль[4], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "даатгалын гэрээ" гэж даатгагчаас даатгуулагч болон эрүүл мэндийн байгууллагатай байгуулсан гэрээг;

3.1.2. "даатгагч" гэж Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль тогтоомжийн дагуу эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийг;

3.1.3. "даатгуулагч" гэж хууль болон гэрээний үндсэн дээр даатгагчид шимтгэл тогтмол төлж, эрүүл мэндээ хамгаалах, учирч болох эрсдэлийн зардлыг нөхөн төлүүлэхээр даатгуулсан иргэнийг;

3.1.4. "эрүүл мэндийн даатгалын сан" гэж даатгуулагч нь даатгагчид эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авах, даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг;

3.1.5."эрүүл мэндийн даатгалын шимтгэл" гэж даатгуулагч эрүүл мэндийн даатгалд даатгуулах зорилгоор иргэний болон түүний нэрийн өмнөөс даатгагчид тогтмол хугацаанд заавал төлөх урьдчилсан төлбөрийг;

3.1.6. "давхар даатгал" гэж даатгуулагч сайн дураар хоёр буюу хэд хэдэн даатгалд зэрэг даатгуулахыг;

3.1.7."даатгалын хугацаа" гэж энэ хуульд заасан болон даатгалын гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа;

3.1.8."төлбөрийн арга" гэж даатгагчаас эрүүл мэндийн байгууллагад санхүүжилт олгохад баримтлах тооцооны хэлбэрийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эрүүл мэндийн даатгал

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгал, түүний хэлбэр

4.1. Иргэний эрүүл мэндийн даатгал / цаашид "даатгал" гэх/ нь төр, иргэн, хуулийн этгээдээс хуульд заасан жүрмын дагуу даатгалын шимтгэл төлж, даатгалын сан үрьдчилан бүрдүүлэх, даатгуулагчийн амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг үг сангаас төлөх нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн.

4.2. Даатгалын шимтгэлийн тодорхой хэсгийг төр, хуулийн этгээд энэ хууль болон бусад хуульд заасан үндэслэл, жүрмын дагуу хариуцна.

4.3. Даатгал нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна.

4.4.Иргэн эрүүл мэндээ учирч болзошгүй хохирлын зардлыг нөхөн төлүүлэх зорилгоор давхар даатгалд даатгуулж болно.

4.5. Эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалыг нийгмийн даатгалын байгууллага / цаашид "даатгалын байгууллага" гэх/ эрхэлнэ.

4.6. Сайн дураар даатгуулах болон давхар даатгалын үйл ажиллагааг өмчийн бух хэлбэрийн даатгалын байгууллага эрхэлж болно.

5 дугаар зүйл. Даатгалын зөвлөл

5.1. Эрүүл мэндийн даатгалын орон тооны бус салбар зөвлөл /цаашид "даатгалын зөвлөл" гэх/ -ийг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэд ажиллуулна.

5.2 Даатгалын зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1. эрүүл мэндийн даатгалын сангийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих;

5.2.2.зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад орсон, даатгалын сангаас үнийн хөнгөлөлт үзүүлэх эмийн үнийн дээд хязгаарыг тогтоох;

5.2.3.эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж, даатгалын үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар санал боловсруулж, холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх,

5.2.4.эрүүл мэндийн даатгалтай холбогдсон асуудлаар ажлын хэсэг байгуулах, тогтоол, зөвлөмж гаргах;

5.2.5.эрүүл мэндийн даатгалын гэрээний болон гэрчилгээний загварыг батлах.

5.3.Даатгалын зөвлөл нь Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг төнцүү тоогоор төлөөлсөн дараахь бүрэндэхүүнтэй байна:

5.3.1 Засгийн газрыг төлөөлж эрүүл мэндийн, санхүү, эдийн засгийн, нийгмийн хамгаллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр 1 хүн;

5.3.2 даатгуулагчийг төлөөлсөн 3 хүн;

5.3.3.ажил олгогчийг төлөөлсөн 3 хүн.

---

[1] Монгол Улсын Үндсэн хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

[2] Нийгмийн даатгалын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

[3] Нийгмийн халамжийн тухай хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

[4] Эрүүл мэндийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

5.4. Даатгалын зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг талуудын саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

5.5. Даатгалын зөвлөл нь аймаг, нийслэлд орон тооны бус салбар зөвлөлтэй байна. Салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг даатгалын зөвлөл батална.

6 дугаар зүйл. Даатгалд хамрагдах хүрээ

6.1. Монгол Улсын дор дурдсан иргэн эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна:

6.1.1. аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан;

6.1.2. аж ахуйн нэгжийн өөрт, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн;

6.1.3. 16 /ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18/ хүртэлх насны хүүхэд;

6.1.4. их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн өдрийн ангийн суралцагч;

6.1.5. тэтгэвэрээс өөр мөнгөн орлогогүй иргэн;

6.1.6. хүүхдээ 2 /ихэр бол 3 / нас хүртэл нь өсгөн бойжуулж байгаа эх /эцэг/;

6.1.7. хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;

6.1.8. малчин;

6.1.9. Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан иргэн;

6.1.10. ял эдэлж байгаа хоригдол;

6.1.11. энэ хуулийн 6.1.1 – 6.1.10-т зааснаас бусад иргэн.

6.2. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн эрүүл мэндийн даатгалд сайн дураар даатгуулж болно.

6.3. Энэ хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.8, 6.1.11-д заасан даатгуулагчийн өрхийн даатгалд 16 /ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18/ хүртэлх насны хүүхдийг хамруулан даатгаж болно.

6.4. Энэ хуулийн 6.3-т заасан даатгуулагчийн даатгалд өрхийн гишүүнийг хамруулах жүрмыг эрүүл мэнд болон нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, даатгалын зөвлөлийн саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл батална.

7 дугаар зүйл. Даатгуулагчид үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ

7.1. Даатгуулагчид амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

7.2.Даатгуулагчид үзүүлэх амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээг хуульд заасны дагуу тухайн үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгд хамрагдсан өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага үзүүлнэ.

7.3. Энэ хуулийн 7.1, 7.2-т заасан тусламж, үйлчилгээний жагсаалт, тэдгээрийг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагыг даатгалын зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

8 дугаар зүйл. Даатгалын шимтгэлийн хувь хэмжээ, төлөх журам

8.1. Даатгуулагчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээг дараахь байдлаар тогтооно:

8.1.1.энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн төлөх даатгалын шимтгэлийн хувь хэмжээг түүний хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувиас хэтрүүлэхгүйгээр Засгийн газраас жил бүр;

8.1.2.энэ хуулийн 6.1.2-т заасан даатгуулагчийн даатгалын шимтгэл төлбөл зохих орлогын хэмжээг татварын албанд гаргасан орлогын мэдүүлгийг үндэслэн даатгалын байгуллага тухай бүр;

8.1.3. энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т зааснаас бусад даатгуулагчийн төлөх даатгалын шимтгэлийн хувь хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдуулан даатгалын зөвлөлийн саналыг үндэслэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс жил бүр.

8.2. Даатгуулагч даатгалын шимтгэлээ дараахь жүрмаар даатгалын санд төлнө:

8.2.1. энэ хуулийн 6.1.1-д заасан даатгуулагчийн төлөх даатгалын шимтгэлийн 50-иас доошгүй хувийг аж ахуйн нэгж, байгууллага, үндэх хэсгийг даатгуулагч өөрөө;

8.2.2. энэ хуулийн 6.1.4-т заасан даатгуулагчийн даатгалын шимтгэлийг сургуулийн захиргаа хариуцаж, даатгагчтай байгуулсан гэрээний дагуу;

8.2.3. энэ хуулийн 6.1.8-д заасан 6.1.1, 6.1.2-т хамаарахаас бусад даатгуулагчийн даатгалын шимтгэлийг баг, хорооны Засаг дарга хариуцаж, даатгагчтай байгуулсан гэрээний дагуу;

8.2.4.энэ хуулийн 6.1.3, 6.1.5, 6.1.6, 6.1.7, 6.1.9-д заасан даатгуулагчийн даатгалын шимтгэлийг төвлөрсөн төсвөөс;

Даатгалын шимтгэлийг төсвөөс тухайн шатны төсвийн эрх захирагч сард нь багтаан даатгагчид шилжүүлнэ.

8.2.5. ял эдэлж байгаа ялтны даатгалын шимтгэлийг хорих байгууллага.

8.3. Энэ хуулийн 6.1.11, 6.2-т заасан даатгуулагчийн төлөх шимтгэлийн хэмжээг даатгалын гэрээгээр зохицуулна.

8.4. Энэ хуулийн 6.1.4, 6.1.8, 6.1.11-д заасан даатгуулагч даатгалын гэрээнд өөрөөр заагаагүй бол жил бүр, 6.1.1, 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.6, 6.1.7, 6.1.9, 6.1.10-д заасан даатгуулагч сар бүр даатгалын шимтгэл төлнө.

8.5. Энэ хуулийн 6.1.4, 6.1.8, 6.1.11-д заасан даатгуулагч дараалсан 12 сараас доошгүй хугацааны даатгалын шимтгэл төлсний дараа даатгалын сангаас эмчилгээ, үйлчилгээний төлбөр хийлгэх эрхтэй.

9 дүгээр зүйл. Даатгалын сан

9.1. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

9.1.1. даатгуулагчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл;

9.1.2. ажил олгогчийн төлсөн эрүүл мэндийн даатгалын шимтгэл;

9.1.3.тэр даатгалыг нь хариуцах иргэдэд төвөрсөн төсвөөс төлсөн шимтгэл;

9.1.4. сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

9.1.5. эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлөх хугацааг хэтрүүлсэнд оногдуулсан алданги;

9.1.6. бусад эх үүсвэр.

9.2. Эрүүл мэндийн даатгалын сангаас дор дурдсан зардлыг санхүүжүүлнэ:

9.2.1. даатгуулагчид үзүүлэх амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний зардал;

9.2.2. энэ хуулийн 12.9-д заасан эмийн үнийн хөнгөлөлт үзүүлэх зардал;

9.2.3. эрүүл мэндийн даатгалын үйл ажиллагааны зардал.

10 дугаар зүйл. Даатгалын гэрээ

10.1. Даатгалын гэрээнд даатгалын шимтгэл, түүнийг төлөх хугацаа, даатгуулагчид тусламж, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, үр дүнгийн үзүүлэлт даатгалын сангаас төлөх эмчилгээний төлбөрийн дээд хязгаар болон талуудын хүлээх үүрэг, хариуцлага, гэрээний нөхцөл зэргийг тодорхой тусгасан байна.

10.2. Даатгалын гэрээг аймаг, нийслэлийн орон тооны бус салбар эвлэл хянаж, баталгаажуулна.

11 дүгээр зүйл. Даатгалын гэрчилгээ

11.1. Даатгалын гэрээ байгуулсан даатгуулагчид даатгалын гэрчилгээ олгоно.

11.2. Даатгалын гэрчилгээ нь нэг талаас даатгуулагч эрүүл мэндээ даатгуулсныг, нөгөө талаас даатгагч тухайн даатгуулагчийг даатгалд авсныг гэрчлэх албан ёсны баримт бичиг болно.

11.3. Даатгалын гэрчилгээ нь даатгалын гэрээнд заасны дагуу хураамж төлсөн тэмдэглэлийг тухай бүр хийлгэсэн тохиолдолд хүчинтэй байна.

12 дугаар зүйл. Даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөр

12.1. Даатгуулагчид үзүүлэх амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлын даатгалын сангаас олгох хэмжээг Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн, санхүү, эдийн засгийн, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага хамтран тогтооно.

12.2. Даатгуулагчийн амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний хувьсах зардлыг эмнэлгийн байгууллагад сарын хуваарийг үндэслэн урьдчилан төлж, гүйцэтгэлээр тооцон олгоно.

12.3. Өрхийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг нэг даатгуулагчид ногдох зардлын хэмжээгээр тооцон санхүүжүүлнэ.

12.4. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний нэг шатлалаас нөгөөд болон хувийн эмнэлгээс төрийн, төрийн өмчийн оролцоотой эмнэлэгт даатгуулагч эмнэлгийн заалтаар шилжин эмчлүүлэх тохиолдолд ялгавартай төлбөрийн тарифыг эмнэлэг хоорондын тооцоонд хэрэглэнэ.

12.5. Энэ хуулийн 6.1.3, 6.1.5, 6.1.6, 6.1.7, 6.1.9 -д зааснаас бусад заавал даатгуулагч болон сайн дурын даатгуулагч энэ хуулийн 12.1-д заасан зардлын 5 хувийг анхан шатны эмнэлэгт, 10 хувийг аймаг, дүүргийн эмнэлэг, бусийн оношлогоо, эмчилгээний төвд, 15 хувийг улсын хэмжээний үйлчилгээтэй клиникийн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн тохиолдолд өөрөө хариуцна.

12.6. Даатгуулагч дараахь тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг өөрөө хариуцна:

12.6.1.гоо сайхны үйлчилгээ, засал;

12.6.2.өөрийн хүсэлтээр хийлгэсэн нэмэлт тусламж, үйлчилгээ;

12.6.3.өөрийн хүсэлтээр эрүүл мэндийн дүгнэлт гаргуулахад шаардагдах шинжилгээ, үйлчилгээ;

12.6.4. аялал жуулчлал, хувийн болон албан ажлаар гадаад улсад зорчих иргэдэд хийх урьдчилан сэргийлэх тарилга;

12.6.5. зарим төрлийн протезийн үнэ;

12.6.6. яаралтай тусламж зайлшгүй үзүүлэх шаардлагатай болон амь насанд аюул учруулж болзошгүй тохиолдлоос бусад үед эмнэлгийн тусламж, үйлчилгээний шатлалыг алгасан улсын хэмжээний үйлчилгээтэй эмнэлгийг иргэн өөрөө сонгон хэвтэж эмчлүүлэхэд;

12.6.7. даатгуулагчийн хүсэлтээр нийслэл хот болон аймгийн төвийн онгоц, галт тэрэгний буудал, ар гэрт нь хүргэх эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ.

12.7. Энэ хуулийн 12.6.5-д заасан протез, 12.6.6-д заасан яаралтай тусламж зайлшгүй үзүүлэх шаардлагатай болон амь насанд аюул учруулж мэдэгдэхүйц өвчин эмгэгийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас батална.

12.8. Даатгуулагч хариуцсан өрх /сум, баг/-ийн эмчийн жороор эмийн сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан үнийн хөнгөлөлт олгох эм авсан бол уг эмийн үнийн зохих хувийг даатгалын сангаас олгоно.

12.9.Энэ хуулийн 12.8-д заасан эмийн жагсаалт, уг эмийн үнийн даатгалын сангаас олгох хувь, хэмжээг даатгалын зөвлөл баталж, ниитэд мэдээлнэ.

12.10. Энэ хуулийн 6.1.1, 6.1.2-т заасан даатгуулагч ажилгүй болсон тохиолдолд даатгалын шимтгэл төлсөн нийт хугацааных нь 25 хувьтай тэнцэх хугацаанд түүний тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг даатгагч төлнө.

12.11.Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчид эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх тусламж, үйлчилгээний зардлын даатгалын сангаас санхүүжүүлэх дээд хязгаарыг даатгалын зөвлөл жил бүр тогтооно.

12.12. Энэ хуулийн 12.5, 12.6-д заасан өөрөө хариуцах төлбөрийг нөхөн төлүүлэхээр даатгуулагч давхар даатгалд хамрагдаж болно.

12.13.Даатгуулагч Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагаас тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд зардлыг даатгалын сангаас төлнө.

13 дугаар зүйл. Даатгалын сангаас гарсан зардлыг нөхөн төлүүлэх

13.1. Даатгалын сангаас гарсан дараахь зардлыг дор дурдсан этгээдээр нөхөн төлүүлнэ:

13.1.1. гэмт хэрэг, зөрчилгүй улмаас эрүүл мэндэд нь гэм хор учирсан даатгуулагчийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг гэм хор учруулсан буруутай этгээдээр;

13.1.2. эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын бруутай үйл ажиллагааны улмаас эмчилгээний болон тарилгын дараахь хүндрэл гарсан нь тогтоогдсон тохиолдолд түхайн эрүүл мэндийн байгууллагаар.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

14 дүгээр зүйл. Даатгалын үйл ажиллагаанд тавих мэргэжлийн хяналт

14.1.Энэ хуулийн хэрэгжилт, даатгалаас санхүүжих байгаа эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чанар, үр дүн, даатгалын үйл ажиллагаанд даатгалын улсын байцаагч хяналт тавина.

14.2. Даатгалын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч хяналт тавина.

14.3. Эрүүл мэндийн даатгалын хяналтын дүрмийг Засгийн газар батална.

15 дугаар зүйл. Даатгалын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

15.1. Аж ахуйн нэгж, байгууллага, төсвийн захирагч даатгалын шимтгэлийг энэ хууль болон даатгалын гэрээнд заасан хугацаанд шилжүүлээгүй бол уг шимтгэлийг нөхөн төлүүлж, хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих хүрээмжийн 0.3 хувьтай тэнцэх алданги даатгагчид төлнө. Хэрэв хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлогыг нуусан буюу хэмжээг нь санаатайгаар бууруулсан нь тогтоогдсон бол гэм буруутай этгээдээр нуусан, бууруулсан орлогод ногдох шимтгэлийг нөхөн төлүүлж, мөн орлоготой тэнцэх хэмжээний алданги ногдуулна.

15.2. Сайн дурын даатгуулагч нь даатгалын гэрээнд заасан хугацаанд даатгалын шимтгэлийг төлөөгүй бол уг гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

15.3. Гэм буруутай этгээд энэ хуулийн 13 дугаар зүйлд заасан тусламж, үйлчилгээний зардлын төлбөр, нөхөн төлбөр төлөхөөс зайлсхийсэн бол учирсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд гомдлоо гаргана.

15.4.Даатгагч нь эрүүл мэндийн байгууллагад төлөх төлбөрийг хугацаа хожимдуулсан бол уг төлбөрийг нөхөн төлүүлж, хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих төлбөрийн 0,1 хувьтай тэнцэх алданги түхайн эрүүл мэндийн байгууллагад төлнө.

15.5.Энэ хуулийн 15.1, 15.2, 15.4-т заасан заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан гомдол, маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

16 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

16.1. Энэ хуулийг 2003 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1993 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

мэндийн даатгалын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 4 дүгээр сарын 25-нд батлагдсан Иргэний эрүүл

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

ГЭРЭЭНД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас 1996 онд баталсан Зохиогчийн эрхийн гэрээнд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хот

ГЭРЭЭНД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дэлхийн Оюуны Өмчийн Байгууллагаас 1996 онд баталсан Тогтолт ба дуу авианы бичлэгийн тухай гэрээнд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Дугаар 12 Улаанбаатар хот

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн 23.13-ыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дараахь ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуультай холбогдсон журам, заавар болон даатгалын гэрээ, гэрчилгээний загварыг 2002 оны 3 дугаар улиралд багтаан Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлтэй хамтран боловсруулж батлан, бэлэн болгох;

2/ Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль нь иргэдийг хамарч үйлчлэх хүрээ өргөжиж, арга хэлбэр өөрчлөгдсөнтэй холбогдуулан уг хуулийг сурталчлах, даатгалын байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах ажлыг зохион байгуулах.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2002 оны 3 дугаар сарын 18-ны өдөр Дугаар 71 Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛ, ЗААЛТЫГ ТАЙЛБАРЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгох, зөв хэрэглэх явдлыг ханган зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт, Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6 дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1.Хуулийн 9.1.1-д заасан "Өмнөх гэрлэлт хүчинтэй байгаа бол" гэдэгт гэрлэгчдийн аль нэг нь өмнө нь өөр бусадтай гэрлэсэд захиргааны журмаар болон шүүхээр үг гэрлэлтээ цуцлуулаагүй байхыг ойлгох бөгөөд харин гэрлэгчдээс хэн нэг нь шүүхийн шийдвэрээр сураггүй болсноор тооцогдсон эсхүл нас барсныг зарласан бол энэ ойлголтод хамаарахгүй болохыг заасугай.

2.Хуулийн 9.1.3-т заасан "Төрөл, садангийн хүмүүс хоорондоо гэрлэх" гэдгийг гэрлэгчдийн төрөл, садангийн хүмүүсийн хоорондын холбоо бус зөвхөн гэрлэгч хоёр этгээдийн төрөл, садан эсэхэд хамааралтай болохыг ойлгож заасугай.

3.Хуулийн 9.1.4-т заасан "Харгалзан дэмжигч, дэмжүүлэгч хоёр гэрлэх" бол гэдэгт тэдгээр нь оршин суугаа сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр харгалзан дэмжигчээр тогтоогдсон байх бөгөөд, харин дээрх эрх бүхий этгээдийн шийдвэр дуусгавар болсон тохиолдолд хамаарахгүй болно.

4.Хуулийн 9.1.6-д заасан "гэрлэгчдийн хэн нэг нь, эсхүл хоёулаа удамших хандлагатай сэтгэцийн архаг өвчтэй" эсэх талаар маргаантай тохиолдолд Иргэний бүртгэлийн байгууллага болон сонирхогч этгээдийн хүсэлтээр шүүх тухайн этгээдийн сэтгэцийн өвчтэй эсэх, үүл сэтгэцийн өвчин нь удамших хандлагатай эсэхийг тогтоолгохоор мэргэжлийн шинжээч нарыг томилж, дүгнэлт гаргуулж байвал зохино.

5.Хуулийн 10.2 дахь хэсгийн "материалын болон сэтгэл санааны хохирлоо бууруулах этгээдээс гаргуулах тэрш эрхтэй" гэдгийг гэрлэгчдийн хэн аль нь нэгнийгээ эд хөрөнгийн хавчигдмал болон сэтгэл санааны дарамттай байдалд байлгах, хүчирхийлэх, нэр төр, алдар хүндийг гутаах, нэгнийхээ хуваарьт болон дундаа хэсгээр өмчлөх эд хөрөнгийг дур мэдэн захиран зарцуулах, устгах, гэмтээх, эрүүл мэндийг сарниулах зэргээр хохирол учруулбал Иргэний /1994 оны/ хуулийн 377 дугаар зүйлийн 1 дүгээр заалтын /Иргэний 2002 оны хуулийн 497 дугаар зүйлийн 1 дүгээр заалт/ дагуу уг гэм хорыг бүрэн хариуцаж, арилгах үүрэгтэй тул хохирлыг арилгуулахыг шаардах эрхтэй гэж ойлгоно.

6.Хуулийн 10.3, 10.4 дэх хэсэгт заасан "угийн бичгийг" Монгол Улсын Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан "Угийн бичиг хөтлөх" журмын дагуу хөтөлнө. Угийн бичигт тухайн хүний мэдэх өвөг дээдсээсээ эхлэн өөрийн хүүхэд хүртэлх ясан болон цусан төрлийн ураг садан хүмүүсийг тус бүрээр нь тодорхой бичнэ. Гэр бүл бологчид өөр өөрсдийн угийн бичгийг бүрнээр нь хуулан авч цаашид нэгтгэн өөрийн өрхийн угийн бичгийг бүрдүүлэн хөтөлж, үр хүүхдүүддээ уламжлуулан дамжуулж өгнө.

7.Хуулийн 11.1 дэх хэсгийн "гэрлэгч нас барсан" гэдгийг тухайн этгээдийн нас барсны гэрчилгээгээр тодорхойлно. "Нас барсан гэж зарласан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс" гэдгийг сураггүй алга болсонд тооцогдсоноос хойш, эсхүл амь үрэгдэж болох аюултай нөхцөл байдалд алга болсноос хойш нэг жилийн турш амьд байгаа эсэх нь мэдэгдэхгүй байгаа иргэнийг сонирхогч этгээдийн хүсэлтээр "нас барсан" гэж зарласан шүүхийн шийдвэр Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 124 дүгээр зүйл /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуулийн 120 дугаар зүйл/-ийн дагуу хүчин төгөлдөр болсныг хэлнэ.

Оршин суугаа газраасаа алга болсноос хойш 2 жилийн хугацаанд хаана байгаа нь мэдэгдэхгүй, сураг чимээгүй болсон иргэнийг сонирхогч этгээдийн хүсэлтээр "сураггүй алга болсонд тооцсон" шүүхийн шийдвэрийг энэ хэсэгт нэгэн адил хамаарууллан ойлговол зохино.

Дээрх үндэслэлээр гэрлэлтийг дуусгавар

болсонд тооцуулах өргөдлөө сонирхогч этгээд Иргэний бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу оршин суугаа газрынхаа сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт гаргана.

8.Хуулийн 12.2 дахь хэсгийн "Эхнэр нь жирэмсэн буюу хүүхэд нь нэг нас хүрээгүй, эсхүл хариуцагч хүндээр өвчилсөн тохиолдолд гэрлэлтийг цуцлахыг хориглоно" гэсэн заалт нь гэрлэлт цуцлах үед өөрийн эрхийг бүрэн хамгаалж чадахгүй, эрүүл мэндийн болон санхүү, ахуй амьдралын хувьд зайлшгүй эхнэр буюу нөхрийн тусламж дэмжлэг шаардлагатай байгаа гэрлэгчийн болон хүүхдийн эрх ашгийг хамгаалсан заалт тул энэ хэсэгт заагдсан нөхцөл байгаа тохиолдолд гэрлэлтийг цуцалж болохгүй.

Тухайн тохиолдолд шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасsnaар гэрлэлт цуцлахыг татгалзсан шийдвэр гаргана. /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуулийн 132 дугаар зүйлийн дагуу нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгоно/. Гэрлэлт цуцлахыг хориглосон шалтгаан арилсны дараа гэрлэлт цуцлуулах талаар шүүхэд дахин нэхэмжлэл гаргаж болно.

"Хариуцагч хүндээр өвчилсөн" гэдэг ойлголтонд гэрлэлт цуцлуулах тухай хэрэг хянан шийдвэрлэх үед хариуцагч хөдөлмөрийн чадвараа алдах, эмнэлэгт хэвтэх, хэвтрийн дэглэм зайлшгүй сахих шаардлагатай байх, мэс засалд орох, эмчийн хяналтан доор туушгай эмчилгээ хийлгэх зэргээр шүүхэд гэрлэлт цуцлах асуудлыг хэлэлцэхэд өөрийн эрхийг хамгаалах боломж муутай байгаа үеийг эмнэлгийн байгууллагын тодорхойлолтыг үндэслэж ойлгоно.

Өвчний хувьд здэгэршгүй, хугацаагүй тахир дутуугийн группэд орсон хэдий ч гэрлэлт цуцлах үед өвчин хүндэрсэн шатандаа биш ердийн явцтай байгаа нөхцлийг үүнд хамааруулахгүй. Харин энэ тохиолдолд шүүх Гэр бүлийн тухай хуулийн 36, 37 дугаар зүйлүүдийн дагуу гэрлэгчдийн тэжээн тэтгүүлэх асуудлыг нэг мөр шийдвэрлэж байвал зохино.

Хүндээр өвчилсөн гэрлэгч нь хэзээ ч гэрлэлтээ цуцлуулахыг өөрөө шаардах эрхтэй болно.

9.Хуулийн 13.1 дэх хэсгийн Захиргааны журмаар гэрлэлтээ цуцлуулах тухай хүсэлтээ "Иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллагад гаргана" гэдэг нь Иргэний бүртгэлийн тухай хуулийн 14.3 дахь хэсэгт зааснаар гэрлэгчид оршин суугаа газрынхаа сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүсэлт хамтран гаргахыг хэлнэ.

10.Хуулийн 14.1 дэх хэсгийн "иргэний эрх зүйн эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдсон этгээд" гэдэгт Иргэний хуулийн 15 дугаар зүйлийн / Иргэний 2002 оны хуулийн 18 дугаар зүйл/ дагуу сэтгэцийн өвчний улмаас өөрийн үйлдлийн учир холбогдлыг ойлгохгүй, өөрийгөө зөв удирдаж чадахгүй болсны улмаас шүүхийн шийдвэрээр эрхийн бүрэн чадамжгүй гэж тооцогдож, асран хамгаалалт тогтоолгосон этгээдийг хамаарууллна.

11.Мөн зүйлийн 14.2 дахь хэсгийн "шүүх шаардлагатай гэж үзвэл" гэдгийг тухайн хэрэг бүрийн онцлогоос шалтгаалан гэрлэлтийг зайлшгүй цуцлах ноцтой шаардлага байхгүй, гэрлэгчдийг эвлэрүүлэх бололцоотой, тэдний болон хүүхдийн эрх ашгийн үүднээс гэрлэлтийг цуцлахгүй байх нь илүү ач холбогдолтой байх нөхцлүүдийг хэлнэ.

Гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэхэд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 74 дүгээр зүйлд / Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуулийн 80 дугаар зүйл/ зааснаар шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

"Гэрлэгчдийг эвлэрүүлэх бүх талын арга хэмжээ авна" гэдэгт гэрлэгч тус бүртэй ганцаарчилан уулзах, эвлэлгөө өгөх, гэрлэлтийг цуцлуулах болсон шалтгаануудыг нарийвчлан судалж, үндэслэлтэй эсэхийг нь тайлбарлах, шаардлагатай тохиолдолд сэтгэл судлаач, сурган хүмүүжүүлэгчдийг татан оролцуулах зэргээ гэрлэгчдийг эвлэрүүлэхэд ач холбогдолтой бүхий л үйл ажиллагаог хэлнэ.

Мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн "шүүхийн шийдвэрт" гэснийг "шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжинд" гэж ойлговол зохино.

"Гэрлэгчид эвлэрэх боломжгүй бол шүүхийн шийдвэрт заасан хугацаа дуусмагц шүүх гэрлэлтийг цуцлана" гэсэн заалтыг хэрэгжүүлэхдээ шүүх доорхи арга хэмжээг авна:

а/.Шүүх гэрлэгчдийг эвлэрүүлэх хугацаа өгч түдгэлзүүлсэн тохиолдолд энэ хугацааг дуустал хавтаст хэргийг архивт шилжүүлэхгүй байна.

б/Хугацаа дууссаны дараа зохигчид шүүхэд дахин хүсэлт гаргасан эсэхээс үл хамааран шүүх саналчилгаараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг шинэчлэн явуулж:

-зохигчид эвлэрсэн бол Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 134 дүгээр зүйлийн 2 дугаар хэсгийн /Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуулийн 132.3 дугаар зүйл/ дагуу шүүх эвлэрлийг батална гэсэн тогтоол буюу шүүгч захирамж гарган хэргийг хэрэгсэхгүй болгож, шийдвэрийн дугаар авна.

-зохигчид эвлэрэх боломжгүй бол гэрлэлтийг цуцлах тухай шийдвэр гаргана.

-зохигчид эвлэрээгүй хэдий ч гэрлэлт цуцлах нөхцөй шалтгаан үндэслэл тогтоогдохгүй бол гэрлэлт цуцлахаас татгалзсан шийдвэр гаргана / зөвхөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1994 оны хуулийн дагуу/.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхэд шийдвэрийн нэгэн адил уйлчилдэг бус харин ердийн захирамж, тогтоол гардаг тул энэ эрхийн актаар хэргийг хааж орхидог буруу практикийг зогсоохыг шүүхүүдэд анхааруулсугай.

- в/Гэрлэгчид эвлэрч, шүүхээс хэргийг хэрэгсэхгүй болгосон захирамж, тогтоол хүчин төгөлдөр байхад гэрлэлт цуцлуулах тухай дахин нэхэмжлэл гарвал шинэ нэхэмжлэл гэж үзэж, шинээр хэрэг үүсгэн шийдвэрлэнэ.

Хэргийг хэрэгсэхгүй болгосон хүчин төгөлдөр эрхийн акт байгаа тул нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах эсэх нь зөвхөн нэхэмжлэлийн үндэслэл, шалтгаан, шаардлагаас хамаарна.

Энэ хэсгийн "гэрлэгчид эвлэрэх боломжгүй" гэдэгт эхнэр, нөхрийн хэн нэг нь согтууруулах ундаа байнга хэрэглэдэг, гэр бүл, ур хүүхдийн амьдрал хүмүүжилд муугаар нөлөөлдөг, гэр бүлийн гишүүдийг хүндэтгэн үзэхгүй, хэрцгий догшин авирладаг, бэлгийн харьцаа тохирдоггүй, ур хүүхэдтэй болоогүй, гэрлэгчид гэр бүлээ үргэлжлүүлэх санаачлагагүй, удаан хугацаагаар тусдаа амьдарсан зэргийг хамааруулж болно.

Мөн зүйлийн 14.4 дэх хэсгийн "байнгын хүчирхийлэл, дарамт" гэдэгт гэрлэгчдийн хэн аль нь нэгнийхээ болон гэр бүлийн гишүүдийн эрх чөлөөнд халдах, эрүүл мэндийг сарниулах, бие махбодид гэмтэл учруулах, хардах, сэтгэл санааны хувьд түгшүүр, айдас төрүүлэх зэргээр тайван орчинд амьдрах эрхийг байнга хязгаарласан нөхцлүүдийг хамааруулан ойлгоно.

Мөн зүйлийн 14.5 дахь хэсэгт "гэрлэгчид ... тохиролцож болно" гэдгийг сайн дурын үндэсэн дээр хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлж чадсан, бусдын эрхийг хохироогоогүй тохиролцоо гэж ойлгоно. Хэн нэгний дарамт шахалтаас болж өөрт хохиролтойгоор хийсэн, эсвэл бага насны ба насанд хүрээгүй хүүхдүүд болон гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй бусад гишүүдийн эрх ашгийг хохироосон тохиролцоог шүүх хүлээн авах боломжгүй юм.

Мөн зүйлийн 14.6 дахь хэсэгт заасан хүүхдийн асрамжийн асуудлыг шийдвэрлэхдээ "хүүхдийн нас" буюу бага насны эсвэл насанд хүрээгүй байдал, цэцэрлэгт хүмүүжиж эсвэл сургуульд сурч байгаа зэргээс шалтгаалан тухайн насны хүүхдийн онцлогийг шүүх харгалзана.

Мөн "эцэг, эхийн халамж" буюу хүүхдийн хүмүүжил, эрүүл мэндэд тавих анхаарал, "ахуйн нөхцөл, бололцоо" буюу хүүхдийн өсөж бойжих орчин, орон сууц, эд хөрөнгийн байдал, "ёс суртахууны байдал" буюу эцэг, эхийн өөрсдийн хүмүүжил, боловсрол, аливаа муу зуршилтай эсэх, хүүхдийг болон гэр бүлийн бусад гишүүдийг эд хөрөнгийн болон сэтгэл санааны дарамтанд байлгадаг эсэх, эрх чөлөөнд халдаж, эрүүл мэндэд гэм хор учруулж байсан эсэхийг шүүх анхаарч хүүхдийн асрамжийг тогтооно.

Дээрх асуудлыг шийдвэрлэхэд шүүх сурган хүмүүжүүлэгч, сэтгэл судлаач болон өөр нарийн мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулж, дүгнэлт гаргуулж болно.

Эдгээр байдлууд нь хүүхдийг эцэг, эхийн хэнийх нь асрамжинд үлдээх, хэнээс нь тэтгэлэг гаргуулахыг шийдвэрлэхэд нөлөөлөх бө харин тэтгэлэгийг хуулинд заасан хэмжээнээс өөрөөр тогтоох үндэслэл болохгүй юм. Энэ хэсэгт заасан хамтран өмчлөх дундын эд хөрөнгийг хуваах асуудлыг шүүх шийдвэрлэхдээ гэрлэгчдийн хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгө, түүнээс гэр бүлийн гишүүнд оногдох хэсгийг тодорхойлох Иргэний хуулийн 96-99 дүгээр зүйлийн зохицуулалтыг хэрэглэнэ /Иргэний 2002 оны хуулийн 125-133 дугаар зүйл/.

Гэрлэгчдийн дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийг хуваахдаа шүүх хүүхдийн болон хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг харгалзан үзнэ.

Мөн зүйлийн 14.7 дахь хэсэгт зааснаар "долоо ба түүнээс дээш настай хүүхдийн саналыг авахдаа" сурган хүмүүжүүлэгч, эсвэл сэтгэл зүйчийг байлцуулан, түүний гаргаж буй санал нь жинхэнэ хүсэл зоригийнх нь илэрхийлэл байж чадаж байгаа эсэхийг анхаарвал зохино. Энэхүү саналыг

шүүх харгалзан үзэх ёстой боловч тэр нь хүүхдийн асрамжийг тогтоох асуудлыг шийдвэрлэх цорын ганц үндэслэл болохгүй.

Мөн зүйлийн 14.8 дахь хэсгийн "дундын эд хөрөнгө зүй бусаар ашигласан" гэдэгт гэрлэгчдийн хэн аль нь нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр дундын өмчлөлийн эд хөрөнгийг бусдад худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан гэх мэт, мөн санаатайгаар устгаж, гэмтээх зэргээр үүгй болгож, захиран зарцуулахыг ойлгоно. Дундын эд хөрөнгөнд орох орлого, эд хөрөнгөө хамтран өмчлөхүүй байх зорилгоор нэгэндээ мэдэгдэхүйгээр өөрийн болон бусдын нэр дээр эзэмшиж, ашигласан нөхцлийг "нуусан" гэдэг ойлголтонд хамруулна.

Мөн зүйлийн 14.9 дэх хэсгийн "гэрлэлтийг бүртгэсэн иргэний үүр бүлийн бүртгэлийн байгууллагад явуулна" гэдгийг Иргэний бүртгэлийн тухай хуулийн 14.2 дахь хэсэгт заасны дагуу гэрлэгчдийн оршин суугаа газрын, эсхүл гэрлэлтийг бүртгэсэн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлнэ гэж ойлгоно. Энэ хуулийн дагуу гэрлэлт цуцалсны бүртгэлийг гэрлэлтээ цуцлуулсан иргэд өөрсдөө өргөдөл гаргаж, шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос хойш дээрх байгууллагаар хийлгүүлэх үүрэгтэй болно.

12.Хуулийн 15.2 дахь хэсэгт заасан "гэрлэлтийг сэргээх" тухай асуудал сураггүй алга болсонд тооцогдсон ба нас барсан гэж зарлагдаад сүүлд эргэж ирсэн хүний эхнэр буюу нөхөр өөр хүнтэй гэрлээгүй тохиолдолд хамаарна. Сураггүй алга болсонд тооцсон ба нас барсан гэж зарласан тухай шүүхийн шийдвэр хүчингүй болсноор өмнөх гэрлэлтийг цуцалсан шийдвэр ба шинээр бүртгүүлсэн гэрлэлт хүчингүйд тооцогдохүй. Тухайн хүний нөхөр буюу эхнэр шинэ гэрлэлтээ цуцлуулж, хуучин гэрлэлтээ сэргээх хүсэлтэй бол энэ зүйлд заасан журам үйлчилнэ.

13.Хуулийн 16.1 дэх хэсгийн "гэр бүл болох зорилгогүйгээр гэрлэлт бүртүүлсэн" гэдгийг элдэв тэтгэвэр авах, орон сууцны талбай эзэмших, гадаадад зорчих ба оршин суух зөвшөөрөл авах зэргээр гэрлэгчдийн хэн аль нь гэрлэлтийн баталгаат эдлэх ёсгүй эрхийг эдлэх, эсхүл хүлээх ёстой үүргээс зайлсхийхийн тулд ашиглах зорилгоор гэрлэлтээ бүртүүлснийг ойлгоно.

Мөн зүйлийн 16.2 дахь хэсгийг 18 насанд хүрээгүй хэдий ч шүүхийн шийдвэрээр эрхийн бүрэн чадамжтай гэж зарлагдсан иргэний гэрлэлтийг энэ хуулийн 9.1.2 дахь хэсэгт заасан үндэслэлээр хүчин төгөлдөр бус гэж тооцохгүй гэж ойлговол зохино.

14.Хуулийн 17.2 дахь хэсгийн "гэрлэгчдийн эд хөрөнгийн гэрээ" гэдгийг гэрлэгчид гэр бүл болохдоо хуваарьт болон дундаа хамтран өмчлөх эд хөрөнгийн эзэмшил, ашиглалт, захиран зарцуулалтын талаар хоорондоо байгуулсан гэрээг хэлнэ.

Гэрлэгчид эд хөрөнгийн гэрээг Иргэний хуулийн холбогдох зохицуулалтын дагуу байгуулна. /Иргэний хуулийн 168¹ дүгээр зүйл, Иргэний 2002 оны хуулийн 132-133 дугаар зүйл/.

15.Хуулийн 22.1 дэх хэсгийн "иргэний гэр бүлийн бүртгэлийн байгууллага" гэдгийг Иргэний бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн дагуу эцэг, эхийн оршин суугаа эсхүл хүүхдийн төрсөн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газрын иргэний бүртгэл хариуцсан алба гэж ойлгоно.

16.Хуулийн 23.2 дахь хэсгийн "эцэг, эхийг тогтооход хариуцагч хүүхдийн эцэг, эхтэй эр, эмийн харилцаатай байсныг нотлох баримт, эмнэлгийн шинжилгээ, бусад баримтыг үндэслэнэ" гэснийг шүүх хэрэгслэхдээ хүүхдийн биологийн эцэг, эх нь хэн болохыг тогтоох ажиллагаанд хийнэ гэдгийг анхаарах шаардлагатай юм. Хүүхдийн эцэг, эх нь хамтын амьдралтай, цаашид гэр бүл болох зорилготой байсан эсэх нь эцэг, эхийг тогтооход зайлшгүй шаардлагатай нотлох баримт биш бөгөөд здгээр байдал нь хариуцагч хүүхдийн эцэг, эхтэй эр, эмийн харьцаатай байсныг нотлох баримтуудын нэгэн хэсэг байж болно.

17.Хуулийн 24 дүгээр зүйлийн "нэр" гэдэгт хүүхдийн өөрийн нэр, "эцгийн буюу эхийн нэр" гэдэгт эцгийн буюу эхийн нэр харъяалахын тийн ялгалд, "овог" гэдэгт эцгийн буюу ясан төрлийг бариматлсан ба Засгийн газрын 1997 оны 1 дүгээр сарын 8-ны өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан "Үгийн бичиг хөтлөх" журмын дагуу тогтоосон овгийг хэлнэ. Жишээлбэл: Боржигон Дашдоржийн Нацагдорж, Хатгин Цэндийн Дамдинсүрэн.

Хүүхдэд нэр, овог өгөх, хүүхэд, эцэг, эхийн нэр овогтой холбогдсон маргааныг шүүх онцгой ажиллагааны журмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

18.Хуулийн 26.5 дахь хэсэгт заасан "эцэг, эх үүргээ хэрэгжүүлэх журмыг" тогтоохдоо шүүх эцэг, эхийн зүгээс хүүхдийн асран хамгаалалт, хүмүүжилд тавих анхаарал, болломж, хүсэлт зэргийг харгалзан эцэг, эх тус бүрт ноогдох үүргүүдийг нэг бүрчлэн тодорхой зааж болно. Энэ нь эвлэхэн хүүхдийн тэтгэлэгийг тогтоосноор хязгаарлагдахгүй.

Тухайлбал, хүүхдийг сургуульд, цэцэрлэгт хүргэж өгөх, авах, гэрийн даалгаврыг хийлгэх, хувцас авах, амралт чөлөөт цагийг өнгөрүүлэх, эмчилгээ, сургалт, амралтын зардлыг хариуцах, секц, дугуйланд хичээлүүлэх гэх мэт маргаан тус бүрийн онцлогоос шалтгаалан дээрх үүргүүдийг шүүх хуваарилан журамлаж болно.

19.Мөн зүйлийн 26.6 дахь хэсгийн "хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхэд нь саад учруулахыг хориглоно" гэдгийг мөн эцэг, эхийн хүүхдээ хүмүүжүүлэхэд эдлэх хэн алиний тэгш эрхийг хязгаарлаж болохгүй гэж ойлговол зохино.

20.Хуулийн 27, 29, 30, 32 дугаар зүйлүүдэд заасан эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хязгаарласныг хүчингүй болгох, хасах, сэргээх асуудлыг шүүх онцгой ажиллагааны журмаар хянан хэлэлцэнэ.

21.Хуулийн 28.5 дахь хэсэгт зааснаар хүүхдийг хүүхэд асран хүмүүжүүлэх байгууллагад шилжүүлсэнтэй холбогдон гарсан хохирлыг шүүх Иргэний хуулийн гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцааны зохицуулалтыг баримтлаж шийдвэрлэнэ.

22.Хуулийн 38.7 дахь хэсэгт зааснаар төтгэлэгийн хэмжээг багасгахдаа төтгэлэг авагч уг хүсэлтийг зөвшөөрсөн эсэхийг харгалзахүйгээр хоёр талын амьдралын бололлоо болон төтгэлэг авагчаас бага орлоготой, түүнчлэн хүүль ёсоор асрамжлах хүний тоо нэмэгдсэн эзргийг нотлохдоо баг, хорооны болон цалин, төтгэврийн тодорхойлолтууд, мөн бусад бичгийн нотолгоонуудыг үндэслэх бөгөөд, харин хөдөлмөрийн чадвараа алдсаныг эмнэлэг хөдөлмөрийн магадлах товчооны дүгнэлтийг баримтална. Гэвч энэ үндэслэлээр төтгэлэг төлөчийг хүүхдийн төтгэлэгээс бүрэн чөлөөлж болохгүйг тайлбарласугай.

23.Хуулийн 40.1.1, 40.1.2-т заасан "амьжиргааны доод түвшингийн 50 хувь буюу амьжиргааны доод түвшингийн хэмжээ" гэдгийг шүүхээс эвөхөн нэг хүүхдэд олгох төтгэлэгийн хэмжээ гэж ойлговол зохихыг тайлбарласугай. Харин хуулийн 40.2 дахь хэсэгт заасан "цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй" гэснийг шүүхээс төтгэлэг тогтоох хэмжээнд хамааралгүй, шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага болон ажил олгогч төтгэчийн цалин хөлс түүнтэй адилтгах орлогоос шилжүүлэхдээ баримтлах заалт болохыг заасугай.

Түүнчлэн хуулийн 40.2 дахь хэсэгт заасан "цалин хөлс түүнтэй адилтгах орлогын 50 хувиас хэтэрч болохгүй" гэдгийг энэ хуулийн 40.1.1, 40.1.2-т зааснаар тогтоосон хүүхдийн төтгэлэгийн хэмжээнь төтгэчийн цалин хөлсний 50 хувиас хэтэрч болохгүй гэж ойлгох бөгөөд энэ тухай Шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллага болон ажил олгогчид үүрэг болгосон заалтыг шүүхийн шийдвэртээ оруулж байх нь зүйтэй.

Хуулийн 40.1.2-т заасан "хөдөлмөрийн чадваргүй хүүхэд" гэдэгт насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй гэдгийг тогтоосон эмнэлэг хөдөлмөрийн магадлах товчооны дүгнэлтийг шүүх үндэслэвэл зохино.

Дээрх зүйлүүдэд заасан "бүс нутаг" гэдгийг шүүхийн шийдвэрт тухайн "төтгэлэг авагч хүүхдийн оршин суугаа газрын бүс нутгийн" гэдгээр ерөнхийлөн бичих бөгөөд, мөн төтгэлэгийн хэмжээг мөнгөн дүнгээр бус харин амьжиргааны доод түвшингийн хувиар бичиж байвал зохино.

24.Төтгэлэг төлөгч, төтгэлэг авагч нарын хооронд төжээн төтгэх гэрээ байгуулаагүй боловч шүүх хуралдааны бэлтгэл шатанд болон хуралдааны үед энэ хуулийн 41 дүгээр зүйлд зааснаар төтгэлэгийг мөнгөн болон эд хөрөнгөөр мөн тодорхой хугацаагаар авахаар тохирч болно. Ингэхдээ тодорхой хугацаанд төлөх мөнгөний болон эд хөрөнгийн хэмжээг шүүхийн шийдвэрт тодорхой зааж, төлбөр төлөгч, авагч нар төтгэлэгийн хэлбэр, хугацаат хоорондоо тохиролцоогүй тохиолдолд ялангуяа төтгэлэгийг эд хөрөнгөөр тогтооход шүүх тэдгээрийн амьдралын бололлоо, хөрөнгийн байдал, эрхэлж байгаа ажил эзргийг харгалзан тогтоох бөгөөд нийт төтгэлэгийн хэмжээ хуульд заасан хэмжээнээс хэтрэхгүй болохыг заасугай.

Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шүүхээс тогтоосон хүүхдийн төтгэлэгийн хэмжээг ихэсгэх, багасгах тухай нэхэмжлэлийг шүүх хүлээн авч, дараахь байдлаар шийдвэрлэвэл зохино:

а/Шүүхийн нэг шийдвэрээр хэд хэдэн төжээн төтгүүлэгчид төтгэлэг тогтоосон буюу шүүхийн хэд хэдэн шийдвэрээр төтгэгч хэдэн хэдэн төтгүүлэгчид төтгэлэг төлөх явцад төтгүүлэгч нас барсан, бусдад үрчлэгдсэн, насанд хүрсэн зэрэг шалтгаанаар төтгэлэгийг хасах тохиолдолд 1973 оны Гэр бүлийн хуулийн зохих зүйл, заалтуудыг баримтлан шийдвэрлэвэл зохино.

б/Өмнө үйлчилж байсан /1973 оны / хуулийн 61 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар шүүх

тэтгэлэгийг биет төгрөгөөр тогтоосон нь хүүхдийн хоол хүнс, асаргаанд илтэд хүрэлцэхгүй буюу амьжиргааны доод түвшингээс хэт бага байгаа тухай тэтгэлэг авагчийн гомдлыг шүүх шинээр гаргасан нэхэмжлэл гэж үзэн, энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасан журмаар шийдвэрлэнэ.

в/Өмнө үйлчилж байсан хуулиар хүүхдийн тэтгэвэр тогтоосон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа бусад нөхцөлд энэхүү хуулиар хүүхдийн тэтгэлэгийг шинэчлэн тогтоолгохыг хүссэн тэтгэвэр авагчийн нэхэмжлэлийг /хууль бүдаан хэрэглэхгүй тухай зарчмыг үндэслэн/ шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 63 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзана.

25.Хуулийн 45.1 дэх хэсэгт зааснаар тэтгэлэг төлөгч, авагч нар тэжээн тэтгэх тухай гэрээг хийх бөгөөд энэ талаар хуульд заасан журам зөрчигдсөн тохиолдолд шүүх Иргэний хуулийн гуравдугаар бүлэгт зааснаар хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцон, тэдний хэн нэгний хүсэлтээр ердийн журмаар тэтгэлэг тогтоож болохыг заасугай.

26.Хуулийн 48.1 дэх хэсэгт заасан "тэжээн тэтгүүлэгчид" гэдэгт энэ хуулийн 40, 44 дүгээр зүйлүүдийн хүрээнд багтсан тэтгэлэг авагч эттэздүүдийг хамаарууллна.

Харин энэ зүйлийн "Онцгой нөхцөл байдал тохиолдсон" гэдэгт тэжээн тэтгүүлэгч нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүнд нөхцөлд байгаа болон Хүүхдийн болон насанд хүрэгсдийн асрах байгууллага, мөн Халамжийн газруудын асрамжинд байгаа, түүнчлэн нэн ядуу эсхүл өрхийн нэг хүнд оногдох орлого нь тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингээс бага байгаа зэрэг бусдын санхүүгийн дэмжлэг зайлшгүй хэрэгтэй байгаа байдлыг ойлгоход зохино.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч.ГАНБАТ

ШҮҮГЧ Ц.АМАРСАЙХАН

Д.ТУНГАЛАГ

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 123 Улаанбаатар хот

ДЭЭД ШҮҮХИЙН 1998 ОНЫ 62 ДУГААР ТОГТООЛД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн 6 дахь заалтыг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1."Улс төрийн хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, хэсэг, заалтыг тайлбарлах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 1998 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 62 дугаар тогтоолын 9 дэх заалтыг дор дурьдсанаар шинэчлэн найруулсугай.

9.Хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4 дэх заалтын "...ах, эгч, дүү" гэдэгт хэлмэгдэгчийн төрсөн буюу үрчилж авсан ах, эгч, дүү; мөн заалтын "ач, зээ" гэдэгт хэлмэгдэгчийн төрсөн буюу үрчилж авсан хүү, охины төрсөн буюу үрчилж авсан хүүхэд; түүнчлэн хэлмэгдэгчийн төрсөн буюу үрчилж авсан ах, эрэгтэй дүүгээс гарсан ба үрчилж авсан хүүхэд /ач/, эсхүл төрсөн буюу үрчилж авсан эгч, эмэгтэй дүүгээс гарсан ба үрчилж авсан хүүхэд /зээ/-ийг тус тус хамааруулан ойлгоно.

2."Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Монгол Улсын Дээд шүүхийн 1998 оны 6 дугаар сарын 23-ны өдрийн 242 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ШҮҮГЧ Ч.ГАНБАТ

ШҮҮГЧ А.ДОРЖГОТОВ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 1.2 ☎ 329487

ОЮУНЫ ДЭЛХИЙН ХУРЛЫН ЧУУЛГА
ЭЛЧИЙН ЗОХИЛ



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 19 (256)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай*
- *Боловсролын тухай*
- *Багa, дунд боловсролын тухай*
- *Дээд боловсролын тухай*
- *Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны тавдугаар сарын 23 №19 (256)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

199. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай (2002-5-2-ны хууль) 637
200. Хууль хүчингүй болсонд тооцох тухай (2002-5-2-ны хууль) 649
201. Банкны тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-5-2-ны хууль) 649
202. Боловсролын тухай (2002-5-3-ны хууль) 649
203. Бага, дунд боловсролын тухай (2002-5-3-ны хууль) 663
204. Бага, дунд боловсролын тухай хуулийг дагаж мөрдөх тухай (2002-5-3-ны хууль) 668
205. Дээд боловсролын тухай (2002-5-3-ны хууль) 669
206. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай (2002-5-3-ны хууль) 674
207. Хуулиуд хүчингүй болсонд тооцох тухай (2002-5-3-ны хууль) 679
208. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-5-3-ны хууль) 679

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

209. Хөдөө аж ахуйн ажилтны өдөр бий болгох тухай Дугаар 13 680
210. Байгаль орчныг хамгаалах өдрүүд бий болгох тухай Дугаар 14 680
211. Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 15 680

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

ТАТВАР НОГДУУЛАЛТ, ТӨЛӨЛТӨД ХЯНАЛТ ТАВИХ, ТАТВАР ХУРААХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж

2.1. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Татварын ерөнхий хууль болон татварын бусад хуулиуд, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Татварын алба, татварын улсын байцаагчийн хууль дээдлэх, бусдын нөлөөнд үл автах зарчмыг хангах

3.1. Үндэсний татварын алба /цаашид "татварын алба" гэх/, татварын улсын байцаагч /цаашид "татварын байцаагч" гэх/ бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ бусдын нөлөөнд үл автан гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн бусад актыг удирдлага болгоно.

3.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан нь татварын алба, татварын байцаагчаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлэхийг хориглоно. Татварын алба, татварын байцаагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь хөндлөнгөөс оролцож дарамт, шахалт үзүүлж байгаа этгээдийн талаар холбогдох байгууллагад гомдлоо гаргаж шийдвэрлүүлнэ.

3.3. Татварын алба, татварын байцаагчийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар хууль тогтоомжоор эрх олгосноос бусад этгээд шийдвэр гаргахыг хориглоно.

3.4. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол аливаа этгээд татвар ногдуулах, хөнгөлөх, чөлөөлөхтэй холбогдсон асуудлаар бусдын өмнө үүрэг хүлээж болохгүй.

3.5. Татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан татварын албаны удирдах дээд байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, заавар, арга члалыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дагаж мөрдөнө.

4 дүгээр зүйл. Татвар төлөгчийн эрх, хууль бусын ашиг сонирхлыг хүндэтгэх зарчмыг хангах

4.1. Татварын алба, татварын байцаагч нь бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ татвар төлөгчийн эрх, хууль бусын ашиг сонирхлыг хүндэтгэж, тэдэнд итгэл үзүүлэн ажиллана.

4.2. Татварын алба, татварын байцаагч хуульд заасны дагуу татварын нөгцлыг тодорхойлох, татвар төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбоотойгоос бусад асуудлаар татвар төлөгчийн үйл ажиллагаанд үл оролцоно.

4.3. Татварын алба, татварын байцаагч, татварын албаны бусад албан тушаалтан нь албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн Хувь хүний нууцын тухай хууль болон Байгууллагын нууцын тухай хуулиар тодорхойлсон татвар төлөгчийн нууцыг хадгалах үүрэгтэй бөгөөд зөвхөн терийн байгууллагын дор дурдсан албан тушаалтанд татварын албаны даргын шийдвэрээр танилцуулж болно:

4.3.1. татварын хууль тогтоомжийн дагуу албан үүргээ гүйцэтгэж байгаа татварын байцаагч, татварын албаны бусад албан тушаалтан;

4.3.2. татварын хууль тогтоомжийг зөрчсөнтэй холбогдуулан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаа явуулж байгаа болон прокурорын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд уг зөрчилд нь холбогдох асуудлаар;

4.3.3. Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу бусад орны татварын байгууллагын эрх бүхий албан тушаалтан.

4.4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд татвар төлөгчийн зөвхөн бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн хуулиар хориглоогүй мэдээ, баримтуудыг нийтэд танилцуулж болно.

4.5. Татварын хууль тогтоомжийг зөрчсөн нь нотлогдсон, эсхүл татвар төлөхөөс зайлсхийсэн хаяг байршлаас оргон зайлсны улмаас эрх сурвалжлагдаж байгаа татвар төлөгчийн талаар татварын алба энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөвшөөрөлгүйгээр нийтэд мэдээлж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Татварын албанаас татвар төлөгчтэй харилцах

5 дугаар зүйл. Татвар төлөгчийн бүртгэл

5.1. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол шинээр байгуулагдсан аж ахуйн нэгж, байгуулага нь бүртгэх байгуулагаас гэрчилгээ авснаас хойш ажлын 3 хоногийн дотор харьяалагдах татварын албанд хувийн хэрэг нээлгэн бүртгүүлнэ.

5.2. Орлогоос бусад татвар ногдох зүйлийг өмчлөгч буюу эзэмшигч нь хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол уг зүйлийг өмчилж буюу эзэмшиж эхэлснээс хойш нэг сарын дотор харьяалагдах татварын албанд хувийн хэрэг нээлгэн бүртгүүлнэ.

5.3. Татварын албаны нь татвар төлөгч, татвар суутган авагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн бүрт регистрийн дугаараар нь хувийн хэрэг бүрдүүлж, түүнд дараахь баримт, мэдээллийг хадгална:

5.3.1. татвар төлөгч иргэний овог

нэр, регистрийн дугаар, гэрчилгээ буюу дэвтрийн дугаар, гэрийн хаяг, харилцах утасны дугаар;

5.3.2. татвар төлөгч аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, хаяг, ажилчдын тоо, удирдлагын гишүүдийн товч анкет, зураг, иргэний үнэмлэхний дугаар;

5.3.3. аж ахуйн нэгж, байгууллагын татвар төлөгчөөр бүртгүүлсэн он, сар, өдөр, эрхлэх үйл ажиллагааны чиглэл;

5.3.4. үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, газар эзэмшлийн байдал, үндсэн хөрөнгийн хэмжээ, эргэлтийн хөрөнгө зэргийг тусгасан, баталгаажуулсан тайлангийн хуулбар;

5.3.5. хөрөнгө оруулагчид болон харьяа салбар нэгжийн нэр, тоо, тэдгээрийн байршил, хаяг, харилцах утасны дугаар;

5.3.6. татвар төлөгчийн төлөх татварын нэр төрөл, банк дахь харилцах дансны дугаар;

5.3.7. тайлан тэнцэл, акт, мэдэгдэх хуудасны хувь.

5.4. Татвар төлөгч үл хөдлөх эд хөрөнгийг худалдах, бэлэглэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн өдрөөс хойш жилын 14 хоногийн дотор харьяалагдах татварын албанд мэдэгдэнэ.

5.5. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол татвар төлөгч нь улсын бүртгэлийн гэрчилгээ, хувийн хэрэгт тусгагдсан зүйл өөрчлөгдөх тухай бүр өөрчлөлт орсноос хойш 14 хоногийн дотор татварын албанд мэдэгдэж, бүртгэл, хувийн хэрэгтээ өөрчлөлт хийлгэнэ.

5.6. Аж ахуйн нэгж, байгууллагад олгосон регистрийн дугаарыг татвар төлөгч, суутган авагч аливаа байгууллага татварын хууль тогтоомжийн дагуу гаргаж байгаа тайлан, мэдээ, гаалийн мэдүүлэг, төлбөрийн болон бусад шаардлагатай баримтуудад бичнэ.

6 дугаар зүйл. Татвар төлөгчид үйлчлэх

6.1. Татварын албаа, татварын байцаагч хууль тогтоомжоор тодорхойлсон татвар төлөх үүргээ биелүүлэхэд нь татвар төлөгчид туслах зорилгоор дараахь үйлчилгээг үзүүлнэ:

6.1.1. татварын хууль тогтоомжийг тайлбарлан таниулах;

6.1.2. татварын хууль тогтоомжийг нэг мөр дагаж мөрдөх, татварын үүргийг тодорхойлох, тайлан, мэдээ гаргахтай холбогдсон заавар, аргачлал, гарын авлага, маягтаар хангах;

6.1.3. татварын үүргээ биелүүлэхтэй холбогдсон асуудлаар татвар төлөгч хэсгээрээ буюу ганцаарчлан зөвлөгөө авах боломжийг бүрдүүлж, зөвлөгөө өгөх.

7 дугаар зүйл. Татварын алба, татварын байцаагчаас татвар төлөгчтэй харилцахад үйлдэх баримт бичиг

7.1. Татварын алба, татварын байцаагчаас татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураахтай холбогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудас, дүгнэлт, гэрээ, үйл ажиллагааны тэмдэглэл /цаашид "тэмдэглэл" гэх/ үйлдэнэ.

7.2. Татварын алба, татварын байцаагч нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичгийг дараахь үндэслэл, журмын дагуу үйлдэх бөгөөд тэдгээрт тавигдсан шаардлагыг татвар төлөгч биелүүлэх үүрэгтэй:

7.2.1. татварын алба, татварын байцаагч нь Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд татвар төлөгч болон бусад этгээдийг дуудан ирүүлэхэд мэдэгдэл бичнэ. Мэдэгдэлд түүнийг бичсэн он, сар, өдөр, татварын албаны даргын, эсхүл татварын байцаагчийн овог, нэр, гарын үсэг, шаардлага биелүүлэх хугацаа, гардуулсан он, сар, өдрийг тусгана;

7.2.2. татварын алба, татварын байцаагч нь татвар төлөгчид татварын хууль тогтоомжийн дагуу ногдох татварыг тодорхойлох, эд хөрөнгө битүүмжлэх, Татварын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэхэд акт үйлдэнэ. Актад түүнийг бичсэн он, сар, өдөр, татварын албаны даргын болон татварын байцаагчийн овог, нэр, зөрчлийн тухай тэмдэглэл, шийдвэрлэсэн үндэслэл, гардуулсан он, сар, өдрийг тусгана;

7.2.3. татварын алба, татварын байцаагч татварын хууль тогтоомжийг зөрчихөд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилгуулах зорилгоор шаардлага бичнэ. Шаардлагад түүнийг бичсэн он, сар, өдөр, татварын албаны даргын, эсхүл татварын байцаагчийн овог, нэр, гарын үсэг, зөрчлийн тухай тэмдэглэл, шийдвэрлэсэн нөхцөл, шалтгааныг арилгах, хариу өгөх хугацаа, гардуулсан он, сар, өдрийг тусгана;

7.2.4. татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй болон шууд бус аргаар ногдуулсан татварын ногдлыг төлүүлэхээр мэдэгдэх хуудас бичнэ. Мэдэгдэх хуудсыг татвар төлөгчид гардуулах бол энэ хуулийн 18.1 дэх хэсэг, татвар төлөгчийн

харилцагч банкинд өгөх бол энэ хуулийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу үг хуудсыг үйлдэнэ;

7.2.5. цалин хөлс, бусад орлогоос татварын ер гаргуулах бол татвар төлөгчид орлого олгож буй аж ахуйн нэгж, байгууллагад төлбөрийн хуудас бичнэ. Төлбөрийн хуудсанд татварын өрийг хүлээн авах газрын нэр, хаяг, бичсэн он, сар, өдөр, татварын албаны даргын болон татварын байцаагчийн овог, нэр, гарын үсэг, татвар төлөгчийн хаяг, гаргуулах татварын өрийн хэмжээ, гардуулсан он, сар, өдөр, хариу мэдэгдэх хугацаа тусгана;

7.2.6. татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татварногдох орлого нуусан, татвар төлөхээс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичнэ. Дүгнэлтэд түүнийг бичсэн он, сар, өдөр, эрүүгийн хэрэг үүсгүүлэх болсон зөрчлийн тухай тэмдэглэл, холбогдох баримтууд, татварын албаны даргын болон татварын байцаагчийн овог, нэр, тухайн зөрчилд холбогдох этгээдийн тайлбар, түүнд үг дүгнэлтийг танилцуулсан он, сар, өдрийг тусгана;

7.2.7. татварын алба, татварын байцаагч татварын өрийг барагдуулах зорилгоор татвар төлөгчийн өмчлөлд байгаа эд хөрөнгийг барьцаалахдаа Иргэний хуульд заасны дагуу гэрээ байгуулна;

7.2.8. татварын байцаагч бүрэн эрхийнхээ хүрээнд татвар төлөгчийн байр, агуулахад үзлэг хийх, тооллого явуулах, ажлын зураг авалт хийх, эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах болон татвар төлөгчөөс тайлбар, лавлагаа авах зэргээр асуулга, ярилцлага хийхдээ тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд татварын албаны даргын, эсхүл татварын байцаагчийн овог, нэр, татвар төлөгчийн хаяг, он, сар, өдрийг тодорхой тусгаж, тэмдэглэл үйлдэхэд байлцсан хүмүүс гарын үсэг зурна.

7.3. Татварын алба, татварын байцаагчийн мэдэгдэл, акт, шаардлага, мэдэгдэх хуудас, төлбөрийн хуудас, дүгнэлт, гэрээ, тэмдэглэлийг татвар төлөгчид биечлэн гардуулсан буюу тэдгээрийн оршин байгаа, эсхүл ажиллаж байгаа газрын хаягаар баталгаат шуудангаар хүргүүлснээр дээрх баримт бичгийг татвар төлөгчид гардуулсанд тооцно. Татвар төлөгчийн хаяг нь холбогдох бүртгэл хөтлөх байгууллагад хамгийн сүүлд бүртгүүлсэн хаяг байна.

8 дугаар зүйл. Татвартай холбогдсон баримт бүрдүүлэх, бүртгэл хөтлөх, хадгалах

8.1. Татвар төлөгч нь хууль тогтоомжийн дагуу татвар ногдох зүйл, төлөх татварын хэмжээг тодорхойлохтой холбогдсон баримтыг бүрдүүлж, аж ахуйн нэгж, байгууллагын тухайд нягтлан бодох бүртгэл, иргэний тухайд энгийн бүртгэл хөтлөнө.

8.2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримтыг гадаад хэл дээр үйлдсэн бол татвар төлөгч түүнийг монгол хэл дээр орчуулж өгөх үүрэг хүлээнэ. Иймхүү орчуулахтай холбогдсон зардлыг татвар төлөгч хариуцна.

8.3. Татвар төлөгч болон түүний баримтыг бүрдүүлэх, бүртгэл хөтлөх үүрэг хүлээсэн этгээд нь үг баримт, бүртгэлийг татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал Монгол Улсын нутаг дэвсгэрт хадгална.

9 дүгээр зүйл. Татварын тайлан, орлого, татвар тодорхойлох хуудсыг бөглөх, тушаах

9.1. Татвар төлөгч татварын тайлан, орлого, татвар тодорхойлох хуудас /цаашид "татварын тайлан" гэх/-ыг хуулиар тогтоосон хугацаанд, батлагдсан загвар, зааврын дагуу бөглөж, харьяалсан татварын албанд тушаана.

9.2. Хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамрагдах татвар төлөгч нь татварын тайлан тушаах үүрэгээс чөлөөлөгдөхгүй бөгөөд түүнд татварын хөнгөлөлт үзүүлэх, татвараас чөлөөлөх эсэхийг татварын тайланг үндэслэн шийдвэрлэнэ.

9.3. Татварын албанд бүртгүүлж, шалгалт өгсөн татварын итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь хэд хэдэн аж ахуйн нэгж, байгууллагын татварын тооцоог хийхэд оролцож болно.

9.4. Татварын тайланд аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий албан тушаалтан болон татвар төлөгч иргэн, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч гарын үсэг зурна.

9.5. Татвар төлөгчийн татварын тайланг гаргасан буюу гаргахад оролцсон этгээд татварын тайланд гарын үсэг зурна. Хариуцсан үүргийнхээ дагуу татварын тайланг гаргахад хэд хэдэн албан тушаалтан оролцдог бол татварын тайланд ерөнхий нягтлан бодогч гарын үсэг зурна .

9.6. Татвар ногдох зүйлийг бусдад шилжүүлсэн аливаа этгээд нь энэ тухай баримтыг шилжүүлэн авсан этгээдэд тухай бүр, татварын албанд шаардсан үед гаргаж өгөх үүрэг хүлээнэ .

10 дугаар зүйл. Мэдээ, баримт цуглуулах

10.1. Татварын алба, татварын байцаагч нь Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлд заасан үйл ажиллагаагаа явуулж, татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураахтай холбогдсон

мэдээ, баримт цуглуулах, хяналт шалгалт хийхдээ дараахь журмыг баримтална:

10.1.1. татварын байцаагчийн үнэмлэхээ үзүүлж, үйл ажиллагааныхаа зорилгыг тайлбарлах;

10.1.2. холбогдох баримт, материалыг түр хугацаагаар хураан авах, хуулбарлахдаа хөндлөнгийн гэрчийг, эсхүл итгэмжлэгдсэн нягтлан бодогч байлцуулан тэмдэглэл үйлдэж, гарын үсгийг зуруулах;

10.1.3. нотолгооны чанартай баримтын гэрэл зургийг авах, дүрс бичлэг хийх;

10.1.4. тайлбар, лавлагааг бичгээр гаргуулах, эсхүл асуулга, ярилцлагад тэмдэглэл үйлдэж, холбогдох этгээдээр гарын үсэг зуруулах;

10.1.5. татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураах, хянан шалгахтай холбогдсон мэдээ, баримтыг татвар төлөгч болон холбогдох этгээдээс шаардах.

10.2. Татварын байцаагч шаардлагатай мэдээ, баримтыг хуулбарлан авахдаа бусдын техник хэрэгслийг ашиглаж болно ашиглаасы хөлсийг зах зээлийн үнээр, эсхүл харилцан тохиролцсон үнээр төлнө.

11 дүгээр зүйл. Байр, агуулахад нэвтрэн орох журам

11.1. Татварын байцаагч Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасны дагуу татвар төлөгчийн орлого олох зориулалтаар ашиглаж байгаа, эсхүл татвар ногдох зүйл болон татварын үйл ажиллагаа явуулахад шаардлагатай мэдэц, судалгаа, бусад холбогдох баримтыг хадгалж байгаа, нэвтрэн орохыг хуулиар хориглоогүй аливаа үйлдвэрлэл, үйлчилгээний болон албан байр, агуулах, зооринд нэвтрэн орж хяналт шалгалт явуулна.

Уг хяналт шалгалтыг явуулахдаа тухайн байгуллага, аж ахуйн нэгж, иргэний эзэмшилд байгаа ямар обьектод хяналт шалгалт хийх тухай харьяалах татварын албаны даргын батлсан албан томилолт, удирдамжийг үндэслэн болгоно.

Хяналт шалгалт хийх тухай албан томилолт, татварын байцаагчийн үнэмлэхээ татвар төлөгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчид үзүүлсний үндсэн дээр байр, агуулахад нэвтрэн орно.

11.2. Энэ зүйлийн 1 дэх хэсэг нь гадаад орны дипломат болон консулын газар, олон улсын байгуллагын төлөөлөгчийн газрын дипломат эрх бүхий албан тушаалтны ажлын байр, агуулахад хамаарахгүй.

12 дугаар зүйл. Үзлэг хийх журам

12.1. Татварын байцаагч нь татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох, татвар хураах зорилгоор Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасны дагуу үзлэг хийхдээ дараахь журмыг баримтална:

12.1.1. үзлэг хийхэд итгэмжлэгдсэн нягтлан бодогч, эсхүл хөндлөнгийн гэрчийг байлцуулна. Хөндлөнгийн гэрч нь 18 насанд хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, тухайн ажиллагааанд хувийн сонирхолгүй, түүнчлэн өөр хоорондоо захирах, захирагдах ёсны холбоогүй хүн байна;

12.1.2. үзлэг хийх ажиллагааанд үзлэгт хамрагдаж байгаа байр, агуулах болон хадгалах, тээвэрлэх, зөөвөрлөх сав, хэрэгсэл эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, хэрэв боломжгүй бол зохих нутгийн захирагааны байгуллагын төлөөлөгчийг байлцуулна;

12.1.3. үзлэг явуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ. Үзлэг хийхэд оролцон болон байлцсан бүх хүмүүс тэмдэглэлд гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргана.

12.2. Үзлэгт хамрагдах зүйл нь хэний эзэмшилд байгаагаас үл хамаарч үзлэгийг хийнэ.

13 дугаар зүйл. Тооллого явуулах журам

13.1. Татварын байцаагч татвар төлөгчийн татварын үүргийг тодорхойлох зорилгоор Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасны дагуу тооллого хийхдээ дараахь журмыг баримтална:

13.1.1. бараа, эд хөрөнгө, бэлэн мөнгөний тооллогыг татвар төлөгч бүюу түүний хууль ёсны төлөөлөгч, итгэмжлэгдсэн нягтлан бодогч, эсхүл хуулийн нутгийн захирагааны байгуллагын төлөөлөгчийг байлцуулан хийж, тооллогын бүртгэл, тэмдэглэл үйлдэнэ;

13.1.2. тооллогын бүртгэл, тэмдэглэлд тооллого явуулсан татварын байцаагч болон тооллого явуулахад байлцсан бусад хүмүүс гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргана.

14 дүгээр зүйл. Ажлын зураг авалт хийх журам

14.1. Татварын байцаагч Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4-д заасны дагуу ажлын зураг авалт хийхдээ дараахь журмыг баримтална:

14.1.1. татвар төлөгчийн төлбөл зохих татварын хэмжээг тодорхойлох, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, зардлыг тогтоох зорилгоор ажлын зураг авалт хийнэ;

14.1.2. ажлын зураг авалтыг татвар төлөгчид урьдчилан мэдэгдэх буюу мэдэгдэхгүйгээр хийж болно. Ажлын зураг авалт хийх тухай урьдчилан мэдэгдсэн тохиолдолд уг үйл ажиллагаанд татвар төлөгчийг, урьдчилан мэдэгдээгүй тохиолдолд хөндлөнгийн гэрчийг, эсхүл итгэмжлэгдсэн нягтлан бодогчийг оролцуулна;

14.1.3. ажлын зураг авалтад төрөл бүрийн хэмжих хэрэгсэл ашиглаж, холбогдох мэргэжилтэнг оролцуулж болно;

14.1.4. татварын байцаагч ажлын зураг авалтын зохих тооцоог хийж, тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд уг ажиллагаа явуулахад байлцсан хүмүүс гарын үсэг зурах бөгөөд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төлбөл зохих татварын ногдлыг тодорхойлох, бүртгэх, барагдуулах

15 дугаар зүйл. Татварын ногдлыг тодорхойлох, хянан шалгах

15.1. Татвар төлөгч холбогдох баримт, бүртгэлд үндэслэн татварын ногдлоо өөрөө тодорхойлон татварын тайланд тусгана. Татвар төлөгч татварын ногдлыг буруу тодорхойлсон гэж үзвэл татварын алба, татварын байцаагч шалган тогтооно.

15.2. Татвар төлөгч хуульд заасан хугацаанд татварын тайланг тушаагаагүй буюу тушаасан боловч түүнд татварын ногдлыг тусгаагүй бол татварын алба, татварын байцаагч өөрт байгаа мэдээ, баримтад тулгуурлан тодорхойлох, шалгах болон шууд бус аргаар ногдуулах үндэсэн дээр татварын ногдлыг тодорхойлно.

15.3. Татварын алба, татварын байцаагчийн татварын ногдлыг тодорхойлох, хянан шалгах бүрэн эрх нь татвар төлөх хөөн хэлэлцэх хугацаа дуустал хүчин төгөлдөр байна.

16 дугаар зүйл. Татварын ногдлыг бүртгэх

16.1. Татварын алба татварын ногдол, төлөлтийн бүртгэлийг хууль тогтоомжид нийцүүлэн татвар төлөгч бүрээр хөтөлнө.

17 дугаар зүйл. Татварын ногдлыг шууд бус аргаар тодорхойлох

17.1. Үйл ажиллагаа эрхэлж байгаа болон эрхэлж байсан нь нотлогдсон боловч үйл ажиллагаандаа бодит бус үнэ хэрэглэсэн, тайлан, бүртгэл хөтлөөгүй буюу дутуу хөтөлсөн, эсхүл бүртгэл, татварын тайланг гаргаж өгөөгүй тохиолдолд тухайн татвар төлөгчийн татварын ногдлыг татварын алба дор дурдсан шууд бус аргаар тодорхойлно:

17.1.1. бодит үнийн арга;

17.1.2. жишгээр тодорхойлох арга.

17.2. "Бодит үнийн арга" гэж харилцан хамаарал бүхий этгээдийн хооронд хийгдсэн үйлдвэрлэл, худалдаа, санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэсэн үнэ нь иймэрхүү харилцан хамааралгүй этгээдийн хооронд хэрэглэсэн үнээс ялгаатай байвал зах зээлийн ердийн нөхцөлд хэрэглэж болох үнийг харьцуулалт, тооцооллын аргыг ашиглан тогтоохыг хэлнэ. "Харилцан хамаарал бүхий этгээд" гэж Монгол Улсын болон гадаад улсын аливаа аж ахуйн нэгжийн удирдлага, хяналт болон эд хөрөнгийн эрхэд нь шууд ба шуудбусаар оролцох эрхтэй этгээдийг хэлнэ.

17.3. Татвар төлөгч нь Монгол Улсын болон гадаад улсад байгаа харилцан хамаарал бүхий этгээдтэй хийсэн борлуулалт, худалдан авалт, боловсон хүчин илгээх, техникийн үйлчилгээ үзүүлэх, хоршсон үйлдвэрлэл явуулах зэрэг үйл ажиллагаанд хэрэглэсэн үнэ, төлбөр, хураамж нь / цаашид "үнэ" гэх/ бодит үнээс их буюу бага байвал татварын ногдлыг тодорхойлходоо бодит үнийн аргыг хэрэглэнэ.

17.4. "Жишгээр тодорхойлох арга" гэж татвар төлөгчтэй ойролцоо хүчин чадал, нөхцөл бүхий адилтгах үйл ажиллагаат тухайн орон нутагт эрхэлж буй татвар төлөгч байгаа бол түүний, байхгүй бол ойролцоо орон нутагт орших хэд хэдэн татвар төлөгчийн үйл ажиллагаа, орлого, зарлагын буюу бусад бодит тооцоонд үндэслэн татварын ногдлыг тодорхойлохыг хэлнэ.

17.5. Татварын ногдлыг шууд бус аргаар тодорхойлох аргачлалыг санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.6. Шууд бус аргаар татварын ногдлыг тодорхойлж байгаа тохиолдолд татвар төлөгч татварын албанд шаардлагатай материалыг гаргаж өгөх үүрэгтэй.

17.7. Татварын ногдлыг шууд бус аргаар тодорхойлох ажлыг тухайн аж ахуйн нэгжийг хариуцан ногдуулалт хийсэн татварын байцаагч, хяналт шалгалт хариуцсан татварын байцаагчтай хамтран акт үйлдэж гүйцэтгэнэ. Шууд бус аргаар ногдуулсан татварын актыг тухайн татварын албаны дарга хянаж батална.

18 дугаар зүйл. Мэдэгдэх хуудас гардуулах

18.1. Татвар төлөгчийн хугацаандаа төлөөгүй татвар болон энэ хуулийн 15.1, 15.2 дахь хэсэгт заасан журмаар татварын албанаас тодорхойлон тогтоосон татварыг төлүүлэхээр мэдэгдэх хуудсыг татвар төлөгчид гардуулна. Түүнд дараахь зүйлийг тусгана:

18.1.1. татвар төлөгчийн овог, нэр;

18.1.2. татвар төлөгчийн бүртгэлийн дугаар;

18.1.3. мэдэгдэх хуудас бичсэн он, сар, өдөр;

18.1.4. татвар ногдох зүйл;

18.1.5. төлбөл зохих татварын хэмжээ;

18.1.6. мэдэгдэх хуудас гардуулснаас хойш ажлын 10 хоногт багтаан татварыг төлөх шаардлага;

18.1.7. татвар төлөх газар;

18.1.8. татварын ногдлыг тооцсон үндэслэл;

18.1.9. татварын албанаас зайлшгүй гэж үзсэн бусад шаардлага.

18.2. Татварын ногдлыг төлөхгүйд хүрч болзошгүй тохиолдолд татварын албаны дарга энэ хуулийн 18.1.6-д зааснаас богино хугацаанд татварыг төлүүлэхээр шийдэж болно.

19 дүгээр зүйл. Татварын өрийг барагдуулах дараалал

19.1. Хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд төлөөгүй татвар, хүү, торгуулийн өр / цаашид "татварын өр" гэх/-ийг дор дурдсан дараалалаар барагдуулна:

19.1.1. тухайн татварт ногдох хүү;

19.1.2. торгууль;

19.1.3. татварын үндсэн өр.

19.2. Хэрэв татвар төлөгч тухайн татварын өрийг аль хугацааны, ямар татварт хамаарахыг заагаагүй бол татварын өрийн дараалалыг татварын алба тусгайлан тогтооно.

20 дугаар зүйл. Татварын өр төлөх хугацаа, түүнийг сунгах

20.1. Татварын алба, татварын байцаагч татварын өр төлөх хугацааг дор дурдсанаар тогтооно:

20.1.1. татвар төлөгчид татварын ногдуулалтаар гарсан өр буюу дутуу төлөлтийг ногдол хийсэн акт гардуулсан өдрөөс хойш ажлын 15 хүртэл хоног;

20.1.2. хяналт шалгалтаар илэрсэн нөхөн татвар, хүү, торгуулийг акт гардуулсан өдрөөс хойш ажлын 10 хүртэл хоног.

20.2. Бодит шалтгааны улмаас энэ хуулийн 18.1.6, 18.2, 20.1-д заасан хугацаанд татвараа төлж чадаагүй бол татвар төлөгчийн бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн тухайн татварын албаны дарын тушаалаар татвар төлөх хугацааг 60 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

21 дүгээр зүйл. Татварыг суутган тооцох, буцаан олгох

21.1. Татварын өрөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 5-д заасны дагуу татварын алба татвар төлөгчийн илүү төлсөн татварыг дараахь журмаар шийдвэрлэнэ:

21.1.1. тухайн шатны төлбөл зохих бусад татварт суутган тооцох;

21.1.2. татвар төлөгч эвшөөрвөл дараагийн хугацаанд төлөх татварт суутган тооцох;

21.1.3. буцаан олгох.

21.2. Илүү төлсөн татварыг суутган тооцох бол энэ тухай татварын алба татвар төлөгчид мэдэгдэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Татвар хураах

22 дугаар зүйл. Төлөөгүй татварыг хураах

22.1. Хууль тогтоомжид заасан хугацаанд татвар төлөгч татвараа төлөөгүй бол татварын алба түүнийг төлүүлэх талаар дараахь ажиллагаа явуулна:

22.1.1. үл маргах журмаар гаргуулах;

22.1.2. эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах;

22.1.3. шүүхэд нэхэмжлэл гаргах.

22.2. Татвар төлөгчийн төлөх ёстой татварын өрийг бүрэн гаргуулах зорилгоор энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагааг давхардуулан явуулж болно.

23 дугаар зүйл. Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах

23.1. Энэ хуулийн 18.1.6, 18.2, 20 дугаар зүйлд заасан хугацаанд татварын өрийг барагдуулаагүй тохиолдолд татвар төлөгчийн харилцагч банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгөнөөс татварын өрийг үл маргах журмаар гаргуулна. Хэрэв татвар төлөгчийн харилцагч банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгө нь татварын өрийг төлөхэд хүрэлцэхгүй бол уг данснаас төлөх шүүхийн шийдвэртэйгээс бусад зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоож, дансны орлогоос татварын өрийг барагдуулна.

23.2. Татварын өрийг үл маргах журмаар гаргуулах тухай татварын байцаагчийн мэдэгдэх хуудсыг тухайн татварын албаны дарга баталж, банкны байгууллагад хүргүүлнэ. Мэдэгдэх хуудсанд татварын өр гаргуулах үндэслэл, түүний хэмжээ, зарлагын гүйлгээг бүрэн буюу хэсэгчлэн зогсоох хугацааны тухай заасан байна.

24 дүгээр зүйл. Татварын өрийг татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос гаргуулах

24.1. Татвар төлөгч энэ хуулийн 18.1.6, 18.2, 20 дугаар зүйлд заасан хугацаанд татварын өрийг барагдуулаагүй, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасны дагуу татварын өрийг үл маргах журмаар гаргуулах боломжгүй тохиолдолд татварын алба татвар төлөгчийн эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос татвар төлөгчтэй тохиролцож гаргуулна.

24.2. Татварын өрийг эд хөрөнгө, цалин, хөлс, бусад орлогоос төлөх тухай татвар төлөгчийн бичгээр өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр татварын алба холбогдох шийдвэр гаргана.

Татварын өрийг татвар төлөгчийн эд хөрөнгөнөөс гаргуулахдаа энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу барьцаанд гэрээ байгуулж, татвар төлөгчийн тодорхой эд хөрөнгийг барьцаалах буюу татвар төлөгчтэй тохиролцсоны үндсэн дээр татварын өрийг төлөхөд нөхцөл, болзолтойгоор нийтэд зарлан худалдаж, үнийг төсвийн орлогод оруулж болно.

25 дугаар зүйл. Татвар төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос татварын өр гаргуулах журам

25.1. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчийн цалин хөлс, бусад орлогоос татварын өр гаргуулахдаа дараахь журмыг баримтална:

25.1.1. цалин хөлс, бусад орлогоос татварын өрд суутгал хийлгүүлэхээр татвар төлөгчид орлого олгож байгаа буюу түүний ажиллаж байгаа үндсэн аж ахуйн нэгж, байгууллагад төлбөрийн хуудас хүргүүлнэ;

25.1.2. аж ахуйн нэгж, байгууллага төлбөрийн хуудсыг хүлээн авмагц татвар төлөгчийн орлогоос зохих суутгалыг сар тутам хийж, суутгал хийснээс хойш 3 хоногийн дотор уг мөнгийг төлбөрийн хуудсанд заасан дансанд шилжүүлнэ;

25.1.3. татварын өрийг шүүхийн шийдвэрийн дагуу цалин хөлс, бусад орлогоос нь суутгал хийж байгаагаас бусад ер, төлбөрийн өмнө суутгана;

25.1.4. татвар төлөгч ажлаас гарвал аж ахуйн нэгж, байгууллага нь түүний гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор татварын өрд суутгасан мөнгөний хэмжээ, хаана шилжсэнийг тэмдэглэж, төлбөрийн хуудсыг татварын албанд буцаана.

26 дугаар зүйл. Татвар төлөгчийн эд хөрөнгөөс татварын өр гаргуулах

26.1. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу татвар төлөгчийн эд хөрөнгөөс татварын өр гаргуулахдаа татварын албаны даргын шийдвэрээр комисс томилно.

26.2. Эд хөрөнгөөс татварын өр гаргуулах комисс дараахь үйл ажиллагаа явуулна:

26.2.1. татварын өрд өгөх эд хөрөнгийн чанар, хэрэгцээ, элэгдсэн байдал, татвар төлөгчийн санал, орон нутгийн тухайн үеийн ханшийг харгалзан дуудлагын худалдааны оруулах анхны үнийг тогтоож, тэмдэглэл үйлдэнэ. Хөрөнгийн бүртгэлийг тэмдэглэлд хавсаргана;

26.2.2. татварын өрд өгсөн эд хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдана. Татвар төлөгч хүсвэл түүнийг буюу түүний хууль ёсны төлөөлөгчийг дуудлагын худалдааны байлцуулна;

26.2.3. дуудлагын худалдаагаар борлогдоогүй эд хөрөнгийг татвар төлөгчид буцаан олгоно;

26.2.4. дуудлагын худалдаагаар борлуулсан эд хөрөнгийн үнэ нь татварын өр, дуудлагын худалдааны зардлаас давбал энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэрлэж, тэмдэглэл үйлдэнэ;

26.2.5. дуудлагын худалдаагаар борлуулсан эд хөрөнгийн үнэ нь татварын өрд хүрэлцэхгүй бол татвар төлөгч уг татварын өрийн үлдсэн хэсгийг барагдуулах үүргээс чөлөөлөгдөхгүй.

26.3. Эд хөрөнгийн дуудлагын худалдааны оруулах анхны үнийг тогтооход мэргэжлийн байгууллага, хүмүүсийн туслалцаа авч болно.

27 дугаар зүйл. Татварын өрийг гаргуулах тухай шүүхэд нэхэмжлэл гаргах

27.1. Энэ хуулийн 18.1.6, 18.2, 20 дугаар зүйлд заасан хугацаанд татвар төлөгч татварын өрийг барагдуулаагүй, уг өрийг энэ хуулийн 23, 24, 25, 26 дугаар зүйлд заасан журмын дагуу барагдуулах боломжгүй тохиолдолд татварын алба татварын өр гаргуулах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргана.

27.2. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасан журмын дагуу тохиролцсон боловч эд хөрөнгө, цалин хөлс, бусад орлогоос татварын өр гаргуулах ажиллагааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр саатуулсан, татгалзсан бол энэ хуулийн 39 дүгээр зүйлд заасан журмын дагуу холбогдох эд хөрөнгийг битүүмжилж, шүүхэд нэхэмжлэл гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ

Татварын байцаагчийн акт, дүгнэлт

28 дугаар зүйл. Татварын байцаагчийн акт, дүгнэлт бичих үндэслэл

28.1. Татварын байцаагч нь энэ хуулийн 7.2.2, 17.7, 39.3 дахь хэсэгт заасан үндэслэлээр акт, 7.2.6-д заасан үндэслэлээр дүгнэлт бичих бөгөөд акт, дүгнэлт нь тэмдэглэх болон тогтоох хэсгээс бүрдэнэ.

28.2. Татварын байцаагчийн акт, дүгнэлт нь түүнийг татвар төлөгчид гардуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. Татварын байцаагч татвар төлөгчид акт, дүгнэлтийг гардуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ. Акт, дүгнэлттэй татварын албаны хяналт шалгалт хариуцсан хэлтэс, тасгийн дарга танилцан, гарын үсэг зурж баталгаажуулна. Акт, дүгнэлт нь нэгдсэн бүртэл, дугаартай байна.

28.3. Татварын байцаагч акт, дүгнэлтийг 3 хувь үйлдэж 1 дэх хувийг хяналт шалгалтын баримтад үлдээж, 2 дахь хувийг татвар төлөгчид өгч, 3 дахь хувийг татвар төлөгчийн хувийн хэрэгт хадгална.

29 дүгээр зүйл. Татварын байцаагчийн акт, дүгнэлтийн биелэлтийг хангах

29.1. Татварын алба, татварын байцаагч биелэлт нь хангагдахгүй байгаа акт, дүгнэлтийн талаар хууль тогтоомжийн дагуу шүүхэд нэхэмжлэл гаргана.

29.2. Татварын байцаагчийн акт, дүгнэлтийн биелэлтэд уг татварын байцаагчийн харьяалах хэлтэс, тасгийн дарга, татварын ахлах байцаагч болон тухайн татварын албаны дарга хяналт тавина

30 дугаар зүйл. Татварын байцаагчийн акт, дүгнэлтийг өөрчлөх, хүчингүй болгох

30.1. Татварын байцаагчийн акт, дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзвэл тухайн татварын албаны даргын тушаалаар уг акт, дүгнэлтийг өөрчлөх буюу хүчингүй болгоно.

30.2. Татварын байцаагчийн акт, дүгнэлтийн үндэслэлтэй эсэхийг татварын албаны даргын тушаалаар томилогдсон комисс тогтооно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад этгээдийн үүрэг

31 дүгээр зүйл. Татварын үйл ажиллагааны талаар банк, санхүүгийн байгууллагын хүлээх үүрэг

31.1. Банк, санхүүгийн байгууллага татварын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар дараахь үүрэг хүлээнэ:

31.1.1. татвар төлөгчийн тооцооны болон бусад данс /цашшд "данс" гэх/-ыг Монгон хадгаламж, төлбер тооцоо, банкны эзэлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу шинээр нээсэн болон дансны дугаарын өөрчлөлт, хөдөлгөөний тухай мэдээллийг ажлын 10 хоногийн дотор татварын албанд мэдэгдэх;

31.1.2. дансан дахь мөнгөн хөрөнгөөсөө татвар төлөх тухай татвар төлөгчийн, үл маргах журмаар татварын өр гаргуулах тухай татварын албаны шийдвэрийг хуульд заасны дагуу эхний ээлжинд шилжүүлэх ёстой өр, төлбөрөөс бусад тохиолдолд банк, санхүүгийн байгууллага, бусад эзэлдэгч, нэхэмжлэгчид төлөх ёр, төлбөрөөс өмнө биелүүлэх. /Энэ заалтад Монгон хадгаламж, төлбер тооцоо, банкны эзэлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг хамаарахгүй/;

31.1.3. энэ хуулийн 18.1.6, 18.2, 20 дугаар зүйлд заасан хугацаанд татварын өрөө барагдуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагын банк дахь харилцах дансны зарлагын гүйлгээг татвараа төлж дуустал түр зогсоох тухай татварын албаны шийдвэрийг хэрэгжүүлэх.

32 дугаар зүйл. Хөрөнгийн биржийн хүлээх үүрэг

32.1. Хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн тархалтын тухай мэдээллийг татварын албанд улирал тутам гаргаж өгнө.

33 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын үүрэг

33.1. Татварын алба, татварын байцаагчаас татвар төлөгчийн байр, агуулахад нэвтрэн орох болон шалгалт, тооллого, үзлэг явуулах үйл ажиллагааг хүч хэрэглэх буюу зохион байгуулалттайгаар саатуулсан, эсэргүүцсэн тохиолдолд цагдаагийн байгуллага шаардлагатай туслалцаа үзүүлж, уг үйл ажиллагааг явуулах бололцоог хангана.

33.2. Цагдаагийн байгууллага нь Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг татвар төлөгчөөр бүртгэх, хаягийг нь тодруулахтай холбогдсон хувь хүний нууцад үл хамаарах өөрт байгаа мэдээ, судалгаат татварын албаны хүсэлтээр гаргаж өгнө.

33.3. Цагдаагийн байгууллага нь татвар төлөхөөс зайлсхийж, оргон зайлсан татвар төлөгчийг эрэн сурвалжлах ажилд туслалцаа үзүүлж, хамтран ажиллана.

34 дүгээр зүйл. Бусад этгээдийн үүрэг

34.1. Хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон бусад төрийн байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаанихаа явцад илрүүлсэн татварын хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг татварын албанд шилжүүлж өгөх үүрэгтэй.

34.2. Гаалийн байгууллага нь гаалийн мэдүүлэгт татвар төлөгч регистрийн дугаараа тусгаж байгаа эсэхийг хянаж, татвар төлөгчийн экспорт, импортын үйл ажиллагаатай холбогдсон мэдээллийг татварын албаны хүсэлтээр гаргаж өгнө.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

35 дугаар зүйл. Хүү, торгууль ногдуулах, төлүүлэх журам

35.1. Татварыг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд хуульд заасан татвар төлөх өдрөөс татвар төлсөн өдрийг хүртэлх хугацаанд хүү ногдуулна.

35.2. Татварын албаны буруугаар илүү төлөгдсөн татварыг буцаан олгох бол татварыг төсөвт төлсөн өдрөөс буцаан олгосон өдрийг хүртэлх хугацаанд буцаасан татварын дүнгээс бодож хоног тутам 0.3 хувийн хүү төлнө. Энэ хүүг холбогдох шатны төсөөс гаргана.

36 дугаар зүйл. Гомдлыг захиргааны журмаар шийдвэрлэх

36.1. Татварын үйл ажиллагаатай холбоотой татвар төлөгчийн гомдлыг захиргааны журмаар шийдвэрлэхэзд энэ хууль болон татварын хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийг дагаж мөрдөнө.

36.2. Татварын үйл ажиллагаатай холбоотой татварын байцаагчийн болон татварын албаны шийдвэрийн талаарх татвар төлөгчийн гомдлыг дараахь харьяаллаар хүлээн авч шийдвэрлэнэ:

36.2.1. татварын байцаагчийн шийдвэртэй холбоотой гомдлыг тухайн байцаагчийн ажилладаг буюу шууд харьяалдаг татварын алба;

36.2.2. татварын албаны

шийдвэрийн талаархи гомдлыг түүний дээд шатны татварын алба.

37 дугаар зүйл. Шүүхэд гомдол гаргах

37.1. Татвар төлөгч татварын албанаас гаргасан аливаа шийдвэрийн талаархи гомдлоо шүүхэд гаргах эрхтэй.

38 дугаар зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх үндэслэл

38.1. Татварын албаны даргын шийдвэрээр татварын байцаагч нь татварын ертэй татвар төлөгчийн эд хөрөнгө, мөнгө, баримт, байр, агуулах /цаашид "эд хөрөнгө" гэх/-ыг дараахь үндэслэл, хугацаагаар битүүмжилж болно:

38.1.1. татварын хяналт шалгалт, тооллого, үзлэг, ажлын зураг авалт явуулахтай холбогдуулан эдгээр ажиллагаат хийж, дүгнэлт, шийдвэр гаргах хүртэл;

38.1.2. эд хөрөнгийг нуух, бусдад шилжүүлж болзошгүй тухай мэдээлэл байгаа бол түүнийг магадлан шалгаж дуусах хүртэл;

38.1.3. Татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалтын а,б,в,г,е-д заасны дагуу шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах үед баримт, бүртгэл, хуурамч буюу хүчингүй гэрээ, хэлцэл, мөнгө, эд хөрөнгийг хамгаалах шаардлагатай бол нэхэмжлэлийг шүүхэд хүргүүлэх хүртэл.

38.2. Энэ хуулийн 38.1.1, 38.1.2-т заасан хугацаа дуусвал битүүмжилсэн эд хөрөнгийг татварын алба эзэнд нь буцаан олгоно.

39 дүгээр зүйл. Эд хөрөнгө битүүмжлэх журам

39.1. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаог тооллого, үзлэг, шалгалт хийхээр томилогдсон болон шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргаж байгаа татварын байцаагч гүйцэтгэнэ.

39.2. Эд хөрөнгө битүүмжлэх ажиллагаог явуулахад татвар төлөгч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, итгэмжлэгдсэн нягтлан бодогч, эсхүл тухайн нутгийн захиргааны байгууллагын төлөөлөгч болон хөндлөнгийн гэрчийг байлцуулна.

39.3. Эд хөрөнгийг битүүмжилсэн тухай татварын байцаагч акт, тэмдэглэл үйлдэнэ. Тэмдэглэлд эд хөрөнгийн хэлбэр, хэмжээ, чанар, тоо, өнгө, шинж тэмдгийг тусгана. Актад эд хөрөнгийн битүүмжилсэн үндэслэл, хугацаог заана.

39.4. Эд хөрөнгийг битүүмжлэхэд байлцсан хөндлөнгийн гэрч болон итгэмжлэгдсэн нягтлан бодогч нь эд хөрөнгө битүүмжлэх ажиллагааны бүх үйл явцыг нотлох үүрэг хүлээх бөгөөд уг ажиллагаанд түүнийг оролцуулсан тухай тэмдэглэлд гарын үсэг зурна. Тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзвал энэ тухай шалтгааныг тайлбарлах бололцоо олгож, тайлбарыг тэмдэглэлд хавсаргана.

39.5. Битүүмжилсэн эд хөрөнгийг лацдах буюу ломбодож эзэмшигчид нь хариуцуулан өгнө.

39.6. Эзэмшигч нь түүнд хариуцуулан өгсөн эд хөрөнгийг бүрэн бүтэн байлгах, татварын албаны зөвшөөрөлгүйгээр лац, ломбо, түгжээг хөдөлгөх, битүүмжилсэн эд хөрөнгийг үрэгдүүлэх, бусдад худалдах, шилжүүлэхгүй байх үүрэг хүлээнэ. Эзэмшигч үүргээ биелүүлээгүй тохиолдолд зохих хууль тогтоомжийн дагуу хүлээлгэх хариуцлагын талаар татварын байцаагч түүнд тайлбарлаж, энэ тухай тэмдэглэлд тусган эзэмшигчээр гарын үсэг зуруулна.

40 дүгээр зүйл. Эд хөрөнгө барьцаалах үндэслэл, журам

40.1. Энэ хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу татварын өрийг татвар төлөгчийн эд хөрөнгийг барьцаалан гаргуулах бол дараахь журмыг баримтлана:

40.1.1. татварын өрийн барьцаанд авсан эд хөрөнгө нь тухайн татвар төлөгчийн өрийн өмч байна;

40.1.2. эд хөрөнгийг барьцаанд авахдаа татвар төлөгчтэй гэрээ хийж, уг эд хөрөнгийн чанар, үнэ, хэлбэр, хэмжээ, байршил, хэний эзэмшилд хаана байхыг тодорхой заана.

Хэрэв үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан бол Үл хөдлөх эд хөрөнгийн газарт бүртгүүлнэ;

40.1.3. барьцааны гэрээний хугацаанаас гэрээнд оролцогч талууд тохиролцож тогтоно;

40.1.4. татвар төлөгч гэрээнд заасан хугацааны дотор татварын өрийг барагдуулж, барьцаанд тавьсан эд хөрөнгөө буцааж авах эрхтэй. Татвар төлөгч барьцаалсан эд хөрөнгийг ашиглах, захиран зарцуулах, гэмтээх, үрэгдүүлэх эрхгүй. Хэрэв барьцаалсан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, гэмтээсэн, чанарыг нь өөрчилсэн зэргээр хохирол учруулбал зээмшилдээ байлгаж байгаа этгээд хариуцлага хүлээнэ;

40.1.5. татвар төлөгчийн дараахь эд хөрөнгийг битүүмжилж, барьцаалж болохгүй:

1/ татвар төлөгч, түүний гэр бүлийн гишүүдийн өдөр тутамд хэрэглэх /улирлын/ хувцас, хэрэглэл;

2/ удаан хадгалах боломжгүй, түргэн муудах хүнсний бүтээгдэхүүн;

3/ хүүчирч элэгдсэн, хэрэгцээ хангахгүй болсон эд зүйлүүд;

4/ татвар төлөгчийн байнга амьдран суугаа гэр, орон сууц, хүйтний улиралд түлээ, нүүрс.

40.2. Барьцааны эд хөрөнгийг худалдахдаа энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.

41 дүгээр зүйл. Эрхэлж байгаа үйл ажиллагааг түр зогсоох

41.1. Татварын нөгдлыг тодорхойлох хяналт шалгалтын явцад холбогдох хууль тогтоомж ноцтой зөрчсөн нь тогтоогдвол татвар төлөгчийн эрхэлж буй үйл ажиллагаагаа татварын алба уг зөрчил болон түүнд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг арилган шийдвэрлэх хүртэл хугацаанд түр зогсоож болно.

42 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

42.1. Татвар ногдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль тогтоомж зөрчсөн татвар төлөгч болон холбогдох бусад этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын байцаагч дор дурдсан захиргааны шийтгэл ногдуулна:

42.1.1. энэ хуулийн 5.1, 5.2, 5.4, 5.5, 5.6 дахь хэсэгт заасан журмыг зөрчсөн иргэнийг 10000-20000, албан тушаалтныг 30000-60000 төгрөгөөр торгох;

42.1.2. татварын хууль тогтоомжид заасан татварын тайланг хуулиар тогтоосон хугацаанд татварын албанд гаргаж өгөөгүй татвар төлөгч иргэнийг 500-10000, холбогдох албан тушаалтныг 5000-30000 төгрөгөөр торгох;

42.1.3. татварын байцаагчаас битүүмжилсэн, барьцаалсан эд хөрөнгийг үрэгдүүлсэн, бусдад дуран мэдэн шилжүүлсэн, гэмтээсэн, зөвшөөрөлгүйгээр худалдсан бол иргэнийг 30000-50000, албан тушаалтныг 40000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

42.1.4. татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхээр өгсөн мэдэгдэл, акт, мэдэгдэх хуудас, төлөөрийн хуудас, шаардлагыг хугацаанд нь биелүүлээгүй, тэдэнд шаардлагатай мэдээ, баримтуудыг гаргаж өгөөгүй бол иргэнийг 500-10000, албан тушаалтныг 5000-30000, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр торгох;

42.1.5. байр агуулахад орж, үзлэг хийх, эд хөрөнгө, бэлэн мөнгө тоолох, ажлын зураг авалт хийх, эд хөрөнгө битүүмжлэх, барьцаалах үйл ажиллагаанд саад учруулсан бол иргэнийг 30000-50000, албан тушаалтныг 40000-60000 төгрөгөөр торгох;

42.1.6. энэ хуулийн 31, 32, 34 дүгээр зүйл, 3.5, 33.2 дахь хэсэг, 25.1.2, 25.1.4 дэх заалтад заасан журмыг зөрчсөн холбогдох албан тушаалтныг 20000-60000 төгрөгөөр торгох;

42.1.7. энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан журмыг зөрчсөн бол иргэнийг 10000-25000, албан тушаалтныг 30000-50000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1996 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр батална Татвар нөгдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр батална Татвар нөгдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 2-ны өдөр

Улаанбаатар хот

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтад "Энэ заалт нь хууль тогтоомжид заасан хугацаанд татварын өрөө барагдуулаагүй татвар төлөгчийн харилцагч банк дахь дансанд байгаа мөнгөн хөрөнгөнөөс татварын өрийг үл маргах журмаар гаргуулахад хамаарахгүй." гэсэн 2 дахь өгүүлбэр нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Татвар нөгдуулалт, төлөлтөд хяналт тавих, татвар хураах тухай хууль /шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь боловсролын үндсэн зарчим, тогтолцоо, агуулга, удирдлага, зохион байгуулалт, боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлх, иргэний сурч боловсрох эрхийг хангахтай холбогдсон нийтлэг харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Боловсролын тухай хууль тогтоомж

2.1. Боловсролын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."бүх нийтийн ерөнхий боловсрол" гэж 11 жилийн сургалтын агуулгын түвшинг;

3.1.2."суурь боловсрол" гэж 9 жилийн сургалтын агуулгын түвшинг;

3.1.3."боловсролын агуулга" гэж боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадал, төлөвшлийн цогцыг;

3.1.4."боловсролын түвшин" гэж тухайн шатанд эзэмшвэл зохих сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын агуулгын стандартаар тогтоосон мэдлэгийн хэмжээг;

3.1.5."сургалтын байгууллага" гэж боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын агуулгыг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг;

3.1.6."албан боловсрол" гэж боловсролын албан ёсны байгууллагаар дамжуулж, суралцагчийн ерөнхий болон мэргэжлийн зохих түвшний боловсрол эзэмших хэрэгцээг хангадаг боловсролын зохион байгуулагдсан үйл ажиллагаа;

3.1.7."албан бус боловсрол" гэж боловсролын албан ёсны тогтолцооноос гадуур иргэнд боловсролын үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалттай үйл ажиллагаа;

3.1.8. "багц цаг" гэж дээд болон мэргэжлийн боловсролын агуулгын багтаамжийг хэмжих нэгжийг.

4 дүгээр зүйл. Боловсролын зорилго

4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг сөюн ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.

5 дугаар зүйл. Боловсролын үндсэн зарчим

5.1.Боловсролын үндсэн зарчим нь:

5.1.1.боловсролыг тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгана;

5.1.2.Монгол Улсад боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй, бүх ниітэд хүртээмжтэй байх бөгөөд үндэсний болон хүн төрөлхтөний соёл иргэншлийн үнэт зүйлс, дэвшилт өв уламжлал, шинжлэх ухаанд тулгуурлана;

5.1.3.боловсрол эзэмшүүлэх арга, хэлбэр олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй байна;

5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох нөхцөлөөр хангана;

5.1.5.нийгэм, иргэний эрх аших, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө бүхий сургалт зохион байгуулахыг хориглоно;

5.1.6.өмчийн төрөл, хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил тэгш хандана.

6 дугаар зүйл. Иргэний сурч боловсрох үндсэн эрх, үүрэг

6.1.Монгол Улсын иргэн бүх шатны боловсролыг хуульд заасан нөхцөл, журмын дагуу төлбөргүй буюу төлбертэйгээр сурч эзэмших, ажил эрхлэхийн зэрэгцээ суралцах эрхтэй.

6.2.Үндсэн хуульд заасны дагуу төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно.

6.3.Монгол Улсын иргэн суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэй.

7 дугаар зүйл. Боловсролын тогтолцоо

7.1.Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ.

7.2.Албан боловсролын агуулга, стандартыг хуульд заасан журмын дагуу тогтооно. Албан бус боловсролын агуулга чөлөөтэй байна.

8 дугаар зүйл. Боловсрол эзэмших арга, хэлбэр

8.1.Иргэн нь боловсролыг албан болон албан бус сургалтаар эзэмшиж болно. Албан сургалт нь өдөр, орой, зочээ, экстернат зэрэг хэлбэртэй байж болно.

9 дүгээр зүйл. Боловсролын баримт бичиг

9.1.Боловсролын баримт бичиг нь тухайн иргэний эзэмшсэн боловсролын агуулгын түвшин, мэргэжлийг гэрчилсэн албан ёсны баталгаа мөн.

9.2.Боловсролын баримт бичиг /гэрчилгээ, үнэмлэх, диплом/-ийг бүрдүүлэх, олгох журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Боловсролын агуулга, стандарт

10 дугаар зүйл. Боловсролын агуулга

10.1.Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас, сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ.

11 дүгээр зүйл. Боловсролын агуулгын түвшин, стандарт

11.1. Боловсролын агуулгыг түвшингээр нь сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд гэж ангилна. Боловсролын агуулгыг Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасны дагуу тус тус тодорхойлж, боловсролын улсын стандартаар нарийвчлан тогтооно.

11.2. Боловсролын стандарт нь суралцагчийн зайлшгүй эзэмшсэн байвал зохих түвшин /сургуулийн өмнөх, бага, дунд, дээд/-ий боловсролын агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно.

11.3.Боловсролын улсын стандартыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага боловсруулж, Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай[1] хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу батална, улсын бүртгэлд бүртгэнэ. Боловсролын стандартыг боловсруулахдаа мэргэжлийн байгууллага, шинжээч нарыг оролцуулна. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр боловсролын улсын стандартыг өөрчлөхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Боловсролын байгууллага

12 дугаар зүйл. Боловсролын байгууллага

12.1.Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг боловсролын байгууллага гэнэ.

12.2.Боловсролын байгууллага нь ашгийн төлөө бус байна.

13 дугаар зүйл. Боловсролын байгууллагын тогтолцоо

13.1.Боловсролын байгууллагын тогтолцоо нь сургалтын, эрдэм шинжилгээ, арга зүйн болон бусад байгууллагаас бүрдэнэ.

14 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллага

14.1.Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.

15 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллага

15.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна. Их сургууль нь эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын, дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний, коллеж нь сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжтэй байна.

16 дугаар зүйл. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага

16.1.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын хөгжлийн асуудлаар суурь болон хавсарга судалгаа явуулах, бүх шатны сургуульд, цэцэрлэг, иргэдэд судалгаа, шинжилгээний мэдээллээр үйлчлэх, сургалт-арга зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаа эрхэлнэ.

16.2. Аймаг, нийслэлийн боловсролын төв нь тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуульд мэргэжлийн туслалцаа үзүүлэх, боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш, иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд нь туслах үүрэг бүхий эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага мөн.

16.3. Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага болон аймаг, нийслэлийн боловсролын төв нь түшиц цэцэрлэг, сургуультай байж болно.

16.4. Боловсролын эрдэм шинжилгээ, арга

[1] Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 3 дугаарт нийтлэгдсэн

зүйн байгууллагын дүрэм болон аймаг, нийслэлийн боловсролын төвийн үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

17 дугаар зүйл. Албан бус боловсролын байгууллага

17.1.Албан бус боловсролын судалгаа, арга зүйн байгууллага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд ажиллана.

17.2.Аймаг, нийслэл, сум, дүүрэгт албан бус сургалтыг зохион байгуулах, бие даан суралцагчид туслах үүрэг бүхий албан бус боловсролын төвийг бие даасан хэлбэрээр, эсхүл сургалтын байгууллагыг түшиглүүлэн ажиллуулна.

17.3.Албан бус боловсролын судалгаа, арга зүйн байгууллагын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

18 дугаар зүйл. Сургалтын бусад байгууллага

18.1.Сургуулиас гадуурх сургалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн еөрийн үйл ажиллагааны чиглэлээр нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, хууль зүй, байгаль орчин, гоо зүй, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, гэр бүлийн болон ахуйн хүрээний асуудлаар тусгай хөтөлберийн дагуу хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол эзэмшүүлэх, боловсрол, мэргэшлээ дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлж болно.

18.2.Иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зайлшгүй шаардагдах мэргэжил эзэмшүүлэх, мэргэшил дээшлүүлэх сургалтыг бух шатны сургууль, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэн эрхэлж болно.

18.3.Аж ахуйн нэгж, байгууллага боловсролын үйл ажиллагаа тогтвортой эрхлэх бие даасан нэгжийг хууль тогтоомжид заасан журмын дагуу байгуулан ажиллуулж болно.

18.4.Шашны сургуульд суралцагчид суурь боловсрол эзэмшүүлэх харилцаат энэ хууль болон Төр, сум хийдийн харилцаанн тухай[2] хуулиар зохицуулна.

19 дүгээр зүйл. Боловсролын сургалтын байгууллага байгуулах

19.1.Боловсролын сургалтын байгууллагыг зориулалтын барилга, байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг, багшлах боловсон хүчнээр хангагдсан нөхцөлд ємчийн аль ч хэлбэрт үндэслэн байгуулж болно.

19.2.Боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авсан өдрөөс эхлэн байгуулагдсанд тооцно.

20 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох байгууллага

20.1.Боловсролын сургалтын байгууллагыг байгуулах тусгай зөвшөөрлийг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг тухай[3] хуулийн 15.7.1, 15.7.2, 15.7.4, 16.2.4, 16.3.3-д заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, еөнхий боловсролын сургуульд аймаг, нийслэлийн Засаг дарга, цэцэрлэгт сум, дүүргийн Засаг дарга тус тус олгоно.

21 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулагч нь тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд зааснаас гадна дараахь баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс зургаагаас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ:

21.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр, ерөедөл, үүсгэн байгуулах тухай гэрээний аль нэг;

21.1.2.боловсролын сургалтын байгууллага байгуулах үндэслэл, тооцоо бүхий танилцуулга;

21.1.3.сургалтын төлөвлөгөө;

21.1.4.багшлах боловсон хүчний хангамж, бүрэлдэхүүн, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа;

21.1.5.сургалт явуулах барилга байгууламж, техник хэрэгсэл, ном, сурах бичиг зэрэг сургалтын хэрэгслэгдэхүүний баталгаа;

21.1.6.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, түүний баталгаа;

21.1.7.үүсгэн байгуулагчаас

[2] Төр, сум хийдийн харилцаанн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1993 оны 6-7 дугаарт нийтлэгдсэн

[3] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн

сургалтын байгууллагын мэдэлд шилжүүлэх хөрөнгө /биетболон мөнгөн/-ийн жагсаалт, хэмжээ, баталгаа;

21.1.8. байгууллагын эзэмшилд газрын эвшөөрөл.

21.2.Боловсролын сургалтын байгууллага шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахдаа Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 21.1.3 - 21.1.7-д дурдсан баримт бичиг, сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, сургалт явуулах үндэслэл, төсөөрх сургалтын үйл ажиллагаа эхлэхээс таваас доошгүй сарын өмнө тусгай зөвшөөрөл олгох байгууллагад ирүүлнэ.

21.3.Шинэ мэргэжлээр сургалт явуулах, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай шийдвэр гарснаас хойш долоо хоногт багтаан тухайн сургалтын байгууллагын тусгай зөвшөөрлийн баримт бичигт нэмэлт тэмдэглэл хийнэ.

22 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх

22.1. Боловсролын сургалтын байгууллага байгууллахад тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх асуудлыг дараахь журмаар шийдвэрлэнэ:

22.1.1.тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага энэ хуулийн 21.1-д заасан баримт бичгийг үүсгэн байгуулагчаас хүлээн авснаас хойш ажлын 21 өдрийн дотор боловсролын сургалтын байгууллага бүрдүүлах урьдчилсан зөвшөөрөл олгох эсэхийг шийдвэрлэх;

22.1.2.урьдчилсан зөвшөөрөл олгох тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан өдрөөс үүсгэн байгуулагч тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангах талаар санал болгосон нөхцөлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

22.1.3.үүсгэн байгуулагч тусгай зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа холбогдох бүрикт бичгийг өргөдлийн хамт эрх бүхий байгууллагад ирүүлэх;

22.1.4.тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдлэ хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор эрх бүхий байгууллага төрийн захиргааны болон боловсролын байгууллага, холбогдох мэргэжлийн байгууллагын төлөөлөл бүхий шинжээчийн хэсэг томилж, магадлан шинжилгээ хийлгэнэ. Магадлан шинжилгээ хийлгэхтэй холбогдсон зардлыг үүсгэн байгуулагч хариуцах;

22.1.5. шинжээчийн хэсэг томилогдсонооос хойш 30 хоногт багтаан баримт бичигт магадлан шинжилгээ хийж, газар дээр нь танилцан дүгнэлт гаргах;

22.1.6.энэ хуулийн 20 дугаар зүйлд заасан байгууллага шинжээчийн хэсгийн дүгнэлтийг үндэслэн тусгай зөвшөөрөл олгох, эсэх тухай шийдвэр гаргаж, үүсгэн байгуулагчид мэдэгдэх;

22.1.7.тусгай зөвшөөрөл олгох мэдэгдэл өгснөөс хойш 15 хоногийн дотор боловсролын сургалтын байгууллагыг бүртгэж, улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийг үүсгэн байгуулагчид олгох.

22.2.Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалттай ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг хамтарсан бүюу дангасан хэлбэрээр байгуулах тусгай зөвшөөрлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага олгоно.

22.3.Боловсролын сургалтын байгууллага нь үүсгэн байгуулах гэрээ, дүрэмдээ өөрчлөлт оруулсан, дүрмийн сан, оршин байгаа газраа өөрчилсөн бол энэ тухайгаа бүртгэх байгууллагад 14 хоногийн дотор бичгээр мэдэгдэж, улсын бүртгэлд өөрчлөлт оруулна.

23 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах

23.1.Тусгай зөвшөөрлийн хугацааг сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд, дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын хугацаатай уялдуулан тогтоно.

23.2.Тусгай зөвшөөрлийн хугацааг он, сар, өдрөөр тодорхойлох бөгөөд тухайн сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн тоолно.

23.3.Хугацаа сунгуулах тухай өргөдлийг тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас гурван сарын өмнө гаргана.

23.4.Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 13.1-д заасан нөхцөл байдал илрээгүй бол тусгай зөвшөөрөл эзэмшигчийн өргөдлийг үндэслэн 14 хоногийн дотор тусгай зөвшөөрлийн хугацаа сунгана.

24 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

24.1.Тусгай зөвшөөрөл олгосон байгууллага нь Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 14.1-д зааснаас гадна дараахь үндэслэлээр түүнийг хүчингүй болгоно:

24.1.1. боловсролын стандарт зөрчсөн;

24.1.2.нийгэм, иргэний эрх ашиг, эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй сургалт зохион байгуулсан нь холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоогдсон;

24.1.3.улсын бүртгэлд бүртгүүлсэн буюу тусгай зөвшөөрөл авснаас хойш зургаан сарын дотор үйл ажиллагаагаа явуулж эхлээгүй;

24.1.4.хуульд заасан бусад үндэслэл.

25 дугаар зүйл. Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

25.1. Боловсролын сургалтын байгууллагыг дараахь тохиолдолд татан буулгана:

25.1.1.үүсгэн байгуулагчийн буюу үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу эрх олгогдсон этгээдийн шийдвэрээр;

25.1.2.тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон;

25.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

25.1.4.хуульд заасан бусад үндэслэл.

25.2.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хуулийн 25.1.1, 25.1.3-т заасны дагуу татан буулгасан бол энэ тухай шийдвэр гарснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн сургалтын байгууллагын удирдлага бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

25.3.Тухайн боловсролын сургалтын байгууллагыг бүртгэх байгууллага улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

25.4.Боловсролын сургалтын байгууллага татан буугдсан болон суралцагчид учирсан хохирлыг арилгуулахтай холбоотойгоор үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл. Боловсролын магадлан итгэмжлэл

26.1.Боловсролын магадлан итгэмжлэл нь дээд боловсролын сургалтын байгууллага, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны түвшин, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ хийж, дүгнэлт гаргах ажиллагаа мөн.

26.2.Боловсролын магадлан итгэмжлэлийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон байгууллага, шинжээч хэрэгжүүлнэ.

26.3. Магадлан итгэмжлэх байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

26.4. Магадлан итгэмжлэх байгууллага магадлан шинжилгээ хийх ажлыг гэрээний үндсэн дээр явуулах бөгөөд гэрээнд өөрөөр заагаагүй бол буруу дүгнэлт гаргаснаас учирсан хохирлыг өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Боловсролын удирдлага

27 дугаар зүйл. Боловсролын удирдлагын тогтолцоо

27.1. Боловсролын удирдлага нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, боловсролын байгууллагын болон түүний өөрийн удирдлагаас бүрдэнэ.

27.2. Боловсролын арга зүйн удирдлагыг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан чиг үүрэг бүхий эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын төв хэрэгжүүлнэ.

28 дугаар зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

28.1. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах;

28.1.2.боловсролыг хөгжүүлэх ойрын болон хэтийн төлөвлөгөө, дүрэм, журам, үзэл баримтлал, үндсэн чиглэл, хөтөлбөр, төсөл боловсруулах, хэрэгжүүлэх;

28.1.3.мэргэжлийн анхан, дунд, дээд боловсролын мэргэжлийн чиглэлийг тогтоох;

28.1.4.бүх шатны боловсролын стандарт, норм, норматив боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

28.1.5.иргэнд албан болон албан бус сургалтаар боловсрол эзэмшүүлэх, мэргэжил

олгох, түүний боловсрол, мэргэшлийг дээшлүүлэх талаар бусад байгууллагаас зохиож байгаа ажлыг төрийн захиргааны болон мэргэжлийн удирдлагаар хангах, зохицуулах;

28.1.6.удирдах ажилтан, багшийг нэгдсэн бодлого, тодорхой чиглэлээр бэлтгэх, давтан сургах, тэдний нийгмийн баталгааг хангах асуудлыг холбогдох дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, энэ талаар гарсан шийдвэрийн биелэлтийг хангах;

28.1.7.цэцэрлэг, бүх шатны сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, мэргэжил, арга зүйн байгууллагыг зориулалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүн, ном, сурах бичгээр хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах;

28.1.8.цэцэрлэг, бүх шатны сургуулийг аттестатчилах;

28.1.9.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

28.1.10.боловсролын асуудлаар гадаадын болон олон улсын байгууллагатай хамтран ажиллах, үр өгөөжийг дээшлүүлэх;

28.1.11.гадаадын их сургууль, дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллагад хувийн болон байгууллагын зардлаар суралцах хүнд зуучлах, мэдээллийн нэгдсэн бүртгэлд хамруулах;

28.1.12.төрийн өмчийн их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн захирлыг томилох, чөлөөлөх;

28.1.13.аймаг, нийслэлийн боловсролын төвийг мэргэжлийн удирдлагаар хангах;

28.1.14. энэ хууль болон бусад хуульд заасан бүрэн эрх.

29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

29.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.1.1.боловсролын асуудлаар тухайн шатны ба доод шатны Засаг даргын тайлан хэлэлцэж, чиглэл өгөх;

29.1.2.орон нутгийн харьяаллын боловсролын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих;

29.1.3.зохих нормативыг үндэслэн боловсролын байгууллагын төсвийг баталж, түүний гүйцэтгэл, зарцуулалтад хяналт тавих;

29.1.4. хууль заасан бусад бүрэн эрх.

30 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

30.1.Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах;

30.1.2.иргэнд суурь боловсрол эзэмшүүлэх, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, давтан сургах, мэргэжил эзэмшүүлэх арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;

30.1.3. орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг шийдвэрлэх,

30.1.4.батлагдсан төсвийг хуваарилан олгох, өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд нь боловсролын байгууллагад дэмжлэг үзүүлэх, тэдгээрийг хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангах ажлыг зохион байгуулах;

30.1.5.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

30.1.6.энэ хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу өрөнхий боловсролын сургууль байгуулахад тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх;

30.1.7. багш, суралцагчийн нийгмийн баталгааг сайжруулах, тэдний хөдөлмөрийг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, бусад дэмжлэг үзүүлэх;

30.1.8.боловсролын байгууллагын үйл ажиллагаанд захиргааны хяналт тавих;

30.1.9. боловсролын тайлан, мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж өгөх;

30.1.10. орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилох, чөлөөлөх;

30.1.11.боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын боловсролын асуудал эрхэлсэн нэгжийн болон боловсролын төвийн даргыг томилох, чөлөөлөх;

30.1.12. хуульд заасан бусад бүрэн эрх.

31 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

31.1.Сум, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртэх боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

31.1.1.боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэжилтийг зохион байгуулах;

31.1.2.хүүхдэд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх, иргэнд суурь боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг захиргааны удирдлагаар хангах;

31.1.3. орон нутгийн өмчийн боловсролын байгууллага байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

31.1.4.энэ хууль болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд заасан журмын дагуу цэцэрлэг байгуулах тусгай зөвшөөрөл, гэрчилгээ олгох, улсын бүртгэлд бүртгэх;

31.1.5.цэцэрлэгийн эрхлэгчийг томилох, чөлөөлөх;

31.1.6.орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хамран сургах тойрог тогтоох;

31.1.7.батлагдсан төсвийг боловсролын байгууллагад хуваарилан хуульд заасан хугацаанд нь олгох, өөрийн орлогоо нэмэгдүүлэхэд боловсрөлын байгууллагад дэмжлэг үзүүлэх;

31.1.8.цэцэрлэгийг зориулалтын барилга байгууламжаар, ерөнхий боловсролын сургуулийг хичээлийн болон дотуур байраар хангах, дотуур байрны хүүхдийн хоол хүнсний хангамжийг зохих журмын дагуу шийдвэрлэх;

31.1.9.төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

31.1.10.багш, суралцагчийн нийгмийн баталгаат сайжруулах, тэдний хөдөлмөрийн үр дүнг бодитой үнэлж, шагнаж урамшуулах, бусад дэмжлэг үзүүлэх;

31.1.11. боловсролын мэдээ, мэдээллийг хууль тогтоомжид заасан журмын дагуу холбогдох байгууллагад гаргаж байх;

31.1.12. хуульд заасан бусад бүрэн эрх.

32 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

32.1.Баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.1.1. сургуулийн өмнөх болон суурь боловсрол эзэмшүүлэх сургалтад харьяа айл өрхийн хүүхдийг хамруулах;

32.1.2. иргэдийн боловсрол эзэмшсэн байдалд судалгаа хийж, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

32.1.3. суурь боловсрол эзэмшээгүй иргэнд нөхөн эзэмшүүлэх ажил зохион байгуулах.

33 дугаар зүйл. Боловсролын сургалтын байгууллагын удирдлага

33.1.Өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагыг сургууль, цэцэрлэгийн эвлөлийн болон удирдах эвлөлийн саналыг харгалзан түүний үүсгэн байгуулагчийн томилсон захирал, эрхлэгч удирдана.

33.2.Захирал, эрхлэгч нь Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай болон Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд заасан эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

33.3.Боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч нь орон тооны байна.

34 дүгээр зүйл. Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлага

34.1.Боловсролын сургалтын байгууллагын өөрийн удирдлагыг ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт сургуулийн болон цэцэрлэгийн эвлөл, их сургууль, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд удирдах эвлөлөл тус тус хэрэгжүүлнэ.

34.2.Цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагад энэ хуулийн 34.1-д заасан заалт хамаарахгүй.

35 дугаар зүйл. Сургууль, цэцэрлэгийн зөвлөл

35.1.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь багш, ажилтан, сурагч, эцэг, эх, бусад байгуулагын төлөөлөлтэй байна. 9-11 гишүүнтэй сургууль, цэцэрлэгийн зөвлөлийг 3 жилийн хугацаагаар сонгоно.

35.2.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлд орох багш, ажилтан, сурагч, эцэг, эхийн төлөөллийг тэдгээрийн хамт олны хурлаас тус тус сонгоно.

35.3.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлд орох бусад байгуллагын төлөөллийг үүсгэн байгуулагчийн саналыг үндэслэн сургууль, цэцэрлэгийн нийт ажилтны хурлаас сонгоно.

35.4.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

35.4.1.сургууль, цэцэрлэгийн хөгжлийн бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санал өгөх;

35.4.2.сургууль, цэцэрлэгийн дэг журам, дотоод зохион байгуулалтын хэлбэрийг тодорхойлох;

35.4.3.сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

35.4.4.сургалтын ажлын чанар, түвшинг сайжруулах талаар сургууль, цэцэрлэгийн удирдлага болон үүсгэн байгуулагчид санал тавих;

35.4.5.захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, дэмжлэг үзүүлэх;

35.4.6.багш, сурагч, ажилтны эрх ашгийг хамгаалах;

35.4.7.сурагчийн дүрэмт хувцасны загварыг тогтоох.

35.5.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь захирал, эрхлэгчийг томилох, чөлөөлөх асуудлаар үүсгэн байгуулагчид санал тавьж болно.

35.6.Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь гишүүний бүрэн эрхийг зөвшөөрөх, зөвлөлийн даргыг сонгох, чөлөөлөх, үйл ажиллагаа явуулах журмыг хурлараа баталж мөрдөнө.

36 дугаар зүйл. Удирдах зөвлөл

36.1.Удирдах зөвлөл нь үүсгэн байгуулагч, багш, суралцагч, төгсөгчийн төлөөлөлтэй байна. Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн удирдах зөвлөлийн төлөөллийг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна.

36.2.Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 51-60 хувь нь үүсгэн байгуулагчийн төлөөлөл байна. Удирдах зөвлөлд орох үүсгэн байгуулагчийн төлөөллийг түүний шийдвэрээр томилно.

36.3.Удирдах зөвлөлд орох багш, суралцагчийн төлөөллийг хамт олны хурлаас сонгоно.

36.4.Удирдах зөвлөлийн гишүүнийг 3 жилийн хугацаагаар томилох буюу сонгоно. Жил бүр удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний гуравны нэгийг өөрчилж болно.

36.5.Удирдах зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Удирдах зөвлөл бүрэн эрхийн хугацаанд жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, ээлжит бус хурлыг үүсгэн байгуулагч, зөвлөлийн дарга буюу гишүүдийн 1/3-ээс доошгүй саналаар хуралдуулна. Захирал тодорхой асуудлаар удирдах зөвлөлийг хуралдуулах саналаа зөвлөлийн даргад тавьж болно.

36.6.Удирдах зөвлөл олонхийн саналаар шийдвэр гаргана. Зөвлөлийн даргыг удирдах зөвлөлөөс сонгоно.

36.7.Удирдах зөвлөл үйл ажиллагаандаа туслах үүрэг бүхий комисс, ажлын хэсэг байгуулан ажиллуулж болно.

36.8.Удирдах зөвлөлд орсон үүсгэн байгуулагчийн төлөөлөл нь түүний бодлого, чиг үүргийг хэрэгжүүлнэ.

36.9.Удирдах зөвлөлийн даргыг үүргээ хангалтгүй биелүүлсэн, хууль тогтоомж зөрчсөн нь нотлогдсон, өөрөө чөлөөлөгдөхийг хүссэн үндэслэлээр хугацаанаас өмнө өөрчилж болно.

36.10. Үүсгэн байгуулагч удирдах зөвлөл, түүний гишүүнийг хангалтгүй ажилласан гэж үзвэл өөрийн төлөөллөө зүүлэн татах, бусад гишүүний талаар сонгосон хамт олонд нь мэдэгдэх эрхтэй.

36.11. Удирдах зөвлөл дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

36.11.1.холбогдох хууль тогтоомжийн дагуу боловсролын байгууллагыг хөгжүүлэх бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, дүрмийг батлах, өөрчлөх;

36.11.2. сургуулийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн нийт хэмжээг тогтоох;

36.11.3. хөрөнгө оруулалт, жилийн төсвийн хуваарилалтыг баталж, зарцуулалтад хяналт тавих;

36.11.4. сургалтын төлбөр, дотуур байрны үйлчилгээний төлбөрийн хэмжээг зохих журмын дагуу тогтоох;

36.11.5. сургуулийн үйл ажиллагааны тайлан хэлэлцэх, үнэлэлт, дүгнэлт өгөх;

36.11.6.удирдах зөвлөлийн үйл ажиллагааны жилийн тайлан гаргаж үүсгэн байгуулагчид өгөх.

36.12. Удирдах зөвлөл нь захирлыг томилох, чөлөөлөх саналыг үүсгэн байгуулагчид тавьж болно.

37 дугаар зүйл. Боловсролын мэргэжлийн хяналт

37.1.Боловсролын мэргэжлийн хяналтыг боловсролын улсын хяналтын байгууллага, улсын байцаагч хэрэгжүүлнэ.

37.2.Боловсролын улсын хяналтын байгууллага нь боловсролын тухай хууль тогтоомж, бага, дунд болон мэргэжлийн боловсролын стандарт, сургалтын байгууллагын ажлын түвшин, түүнтэй холбогдсон норм, норматив, дүрэм, журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавина.

37.3.Боловсролын улсын хяналтын албаны дүрмийг Засгийн газар батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

Боловсролын эдийн засаг

38 дугаар зүйл. Боловсролын төлөвлөлт, мэдээлэл

38.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага орон нутгийн захиргааны болон холбогдох бусад байгууллагын оролцоотойгоор боловсролын хөгжлийн ойрын болон хэтийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлнэ.

38.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын боловсруулсан төлөвлөгөө, арга зүйг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүрэг боловсролын ойрын болон хэтийн төлөвлөгөөтэй байна.

38.3.Цэцэрлэг, сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага тогтоосон норм, нормативыг үндэслэн зорилтот төлөвлөгөөтэй ажиллана.

38.4.Өмчийн аль ч хэлбэрийн боловсролын байгууллага хууль тогтоомжид заасан мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж боловсролын дээд шатны байгууллагад тайлагнана.

39 дүгээр зүйл. Боловсролын санхүүжилт

39.1.Боловсролын үйл ажиллагаат хэвийн явуулахад шаардагдах хэмжээний төсвийг Улсын Их Хурал, аймаг, нийслэл, сум, дүүргийн ирэгдийн Төлөөлөгчдийн Хурал батална. Боловсролын санхүүжилтэд улсын төсвийн жилийн орлогын 20-иос доошгүй хувийг зарцуулна.

39.2.Боловсролын байгууллага нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, хөрөнгө оруулалт, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс оруулах сургалтын төлбөр, хандив, хөнгөлөлттэй зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг санхүүгийн эх үүсвэртэй байна.

39.3.Боловсролын сургалтын байгууллага санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлэх, багш, ажилтан, суралцагчийн нийгмийн баталгаат дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжид нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагаа явуулж болох бөгөөд түүнээс олсон орлогоо энэ хуульд заасан зориулалтын дагуу захиран зарцуулах эрхийг боловсролын сургалтын байгууллагын захирал, эрхлэгч эдэлнэ.

39.4.Боловсролын байгууллагын өөрийн орлогын хэмжээтэй холбоотойгоор улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх хөрөнгийн хэмжээг багасгахыг хориглоно.

39.5.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын төв нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, судалгааны ажлын төслийн зардлаар санхүүжнэ.

39.6. Орой, эчнээ, түр, албан бус арга, хэлбэрээр сургалт явуулах зардлыг тухайн орон нутгийн төсөөс гаргана.

39.7.Суралцагчид хөнгөлөлттэй зээл олгох, буцалтгүй тусламж үзүүлэх зорилгоор сургалтын төрийн сан байгуулж ажиллуулна. Сангийн хөрөнгийг зарцуулах журмыг Засгийн газар тогтооно.

39.8.Олон нийтийн үүсгэл саналчилгаар аймаг, нийслэл, сум, дүүрэгт боловсрол хөгжүүлэх сан байгуулж болно.

39.9.Боловсролд зориулсан төсвийн болон сангийн хөрөнгийг өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

39.10. Боловсролын сургалтын байгууллага үүсгэн байгуулагчаас өөрт нь нийлүүлсэн болон тухайн сургалтын байгууллагын үйл ажиллагааныхнь явцад бий болсон хөрөнгийг өөрийн үндсэн үйл ажиллагааны зорилго, дүрэм, үүсгэн байгуулагчтай байгуулсан гэрээнд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах үүрэгтэй.

40 дүгээр зүйл. Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт

40.1.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг тогтмол болон норматив зардлаар санхүүжүүлнэ.

40.2.Их сургууль, дээд сургууль, коллежийн тогтмол зардлыг улсын төвлөрсөн төсвөөс, ерөнхий боловсролын сургуулийн тогтмол болон дотуур байрны нийт зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг суралцагчид ногдох норматив зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

40.3.Бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын норматив, дээд боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох зардлын жишгийг сургуулийн байршил, хэв шинж болон мэргэжлийн төрлөөр Засгийн газар жил бүр тогтооно.

40.4.Төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

40.4.1. цэцэрлэгт орон нутгийн төсөв, эцэг, эх, асран хамгаалагчаас өгөх төлбөр, өөрийн үйл ажиллагааны орлого;

40.4.2. ерөнхий боловсролын сургуульд орон нутгийн төсөв, өөрийн үйл ажиллагааны орлого;

40.4.3.мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв. өөрийн үйл ажиллагааны орлого;

40.4.4.их сургууль, дээд сургууль, коллежид улсын төвлөрсөн төсөв, сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний төсөлт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлого;

40.4.5.Цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбоотой зардлыг төр хариуцна.

40.5.Энэ хуулийн 40.4-т заасан төрийн өмчийн боловсролын байгуллагын санхүүжилтийн эх үүсвэрт улсын төвлөрсөн бүюу орон нутгийн төсвийн хөрөнгө болон бусад орлогын зохистой харьцаог боловсролын болон санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар жил бүр тогтооно.

41 дүгээр зүйл. Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилт

41.1.Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь үүсгэн байгуулагчийн хөрөнгө, нэг сурагчид ногдох хувьсах зардлын төсөөс санхүүжүүлэх хэсэг, сургалтын төлбөр, хандив, хөнгөлөлттэй зээл, өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.

41.2.Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчинг сайжруулах, тэдгээрийг багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газар тогтоосон журмын дагуу дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

42 дугаар зүйл.Боловсролын байгууллагын сургалтын орчин

42.1. Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, сурагчийн хөдөлмөрийн онцлогт тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

42.2.Боловсролын сургалтын байгууллага өөрийн харьяа хэвлэл, мэдээлэл, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно.

42.3.Цэцэрлэг, сургуулийн барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хоол хүнсний зүйлийн норм, нормативыг холбогдох хууль тогтоомж, боловсролын стандартыг үндэслэн боловсролын, эрүүл мэндийн, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь холбогдох бусад байгууллагатай хамтран батлаж мөрдүүлнэ.

42.4.Боловсролын сургалтын байгууллагыг хэвийн үйл ажиллагаа явуулахад хүрэлцэхүйц

зориулалтын барилга байгууламж, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, сурах бичиг, дотуур байраар хангах ажлыг үүсгэн байгуулагч хариуцна.

42.5.Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламжийг зориулалтын дагуу ашиглана.

43 дугаар зүйл. Боловсролын харилцаанд оролцогчдын нийгмийн баталгаа

43.1. Багш нийгмийн дараахь баталгаагаар хангагдана:

43.1.1.хөдөлмөрийн шинж чанар, мэргэжлийн онцлогт тохирсон цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, нөхөх олговор, шагнал урамшуулал авах, хуульд заасан бусад хөнгөлөлт эдлэх;

43.1.2.багш, ажиллагчдын зөлжийн үндсэн амралтын хугацаанг Хөдөлмөрийн тухай[4] хуулиар зохицуулна. Хөдөлмөрийн онцлогийг харгалзан багшид ажлын 33, захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрны багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт тус тус олгоно. Хөдөлмөрийн тухай хуулийн 79.5, 79.6-д заасан ажилласан хугацаа, хөдөлмөрийн нөхцөлийг харгалзсан бусад нэмэгдэл амралт дээрх албан тушаалтанд хамаарахгүй;

43.1.3.орон сууц барих буюу худалдан авахад зориулж хөнгөлөлттэй зээл, тусламж авах;

43.1.4.бүх шатны сургууль, цэцэрлэгт 25 ба түүнээс дээш жил ажилласан, энэ хуулийн 43.1.2-т заасан албан тушаалтанд тэтгэвэрт гарахад нь нэг хичээлийн жилийн үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгох;

43.1.5.тухайн нутаг дэвсгэрийн онцлогийг харгалзан нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэд багшид нэмэгдэл цалин, урамшил, бусад дэмжлэг үзүүлэх;

43.1.6. хуульд заасан бусад баталгаа.

43.2. Суралцагч нийгмийн дараахь баталгаагаагаар хангагдана:

43.2.1. оршин суудаг газараасаа сургуульд тогтмол явах боломжгүй, өнчин буюу амьжиргааны түвшин доогуур суралцагчийг дотуур байраар хангах;

43.2.2.ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв /анхан шатны/-ийн дотуур байранд төлбөргүй суух;

43.2.3.сурагчийг хичээлийн жил эхлэх, дуусах болон улирлын амралтаар сургуульдаа ирэх, гэртээ буцахад эцэг, эх, асран хамгаалагчийн зардал, хүсэлтээр унаагаар үйлчлэх арга хэмжээг сургуулийн захиргаа, нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулах;

43.2.4. оршин суудаг газараасаа өөр аймаг, хотод суралцаж байгаа оюутны жилд 2 удаа орон нутагтаа ирж, очих зардлыг Засгийн газраас тогтоосон журмын дагуу хөнгөлөх;

43.2.5.нийтийн тээврийн хэрэгслээр хичээлдээ явах зайлшгүй шаардлагатай сурагч, оюутны нийтийн тээврийн хэрэгслээр зорчих зардлыг тухайн нутгийн захиргааны байгууллагаас тогтоосон журмын дагуу хөнгөлөх;

43.2.6.Засгийн газраас тогтоосон журмын дагуу эмнэлэг, нийтийн хоол, соёл, урлагийн болон ахуйн үйлчилгээгээр үйлчлэх зардлыг хөнгөлөх;

43.2.7.суралцагчийн онцгой авьяас, чадварыг нээн илрүүлж хөгжүүлэх, урамшуулан дэмжих, өнчин, амьжиргааны түвшин доогуур, бие эрхтний согогтой, оюуны хомсдолтой суралцагчийг сурах нөхцөл бололцоогоор төрөөс хангах;

43.2.8.хөдөөгийн сумдын захиалгагаар сургууль, мэргэжлээр суралцаж байгаа оюутан, магистрантад сургалтын төрийн сангаас хөнгөлттэй нөхцөлөөр зээл, тэтгэлэг олгох;

43.2.9. хуульд заасан бусад баталгаа.

43.3.Багш, суралцагчид үзүүлэх хөнгөлөлт, нөхөх олговор, тэтгэлэг, тэтгэмж, шагнал урамшил нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна.

[4] Хөдөлмөрийн тухай хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Боловсролын харилцаанд оролцогчдын нийтлэг эрх, үүрэг

44 дүгээр зүйл. Багшийн эрх, үүрэг

44.1. Багш дараахь эрхтэй:

44.1.1.сургалтын үйл ажиллагаанд хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангуулах;

44.1.2.сургалтад шинжлэх ухааны дэвшилт арга барил, боловсролын стандартад нийцсэн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэх;

44.1.3.суралцагч болон түүний эцэг, эх, асран хамгаалагчид шаардлага тавих, зөвлөгөө өгөх;

44.1.4.суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, тэдний авьяас, бие сэтгэцийн хөгжилтэд тодорхойлолт өгөх;

44.1.5.суралцагчийг сонгон суралцуулах, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах;

44.1.6. судалгаа шинжилгээний ажил хийх, багшийн мэргэжлийн болон боловсролын зэрэг хамгаалах, мэргэжлийн цол хүртэх;

44.1.7. хүүхдийн эрүүл мэнд, эрх ашгийг хохироосон эцэг, эх, асран хамгаалагчийн талаар насанд хүрээгүй суралцагчаа төлөөлөн зохих байгууллагад гомдол гаргаж шийдвэрлүүлэх;

44.1.8. үндсэн ажлын чөлөө цагаар мэргэжил, сонирхлын дагуу бусад байгууллагад гэрээгээр ажиллах.

44. 2. Багш дараахь үүрэгтэй:

44.2.1. багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн сахих;

44.2.2.сургалтын ажлыг амьдрал, үйлдвэрлэлтэй уялдуулан шинжлэх ухааны үндэстэй явуулах;

44.2.3. онолын мэдлэг, заах арга, ур чадвараа дээшлүүлэх;

44.2.4.суралцагчид бие даан боловсрол, мэргэжил эзэмших чадвар олгох, амьдрах арга ухаанд сургах;

44.2.5.хариуцсан ангийн суралцагчийн эрүүл мэндэд анхаарал тавих.

45 дугаар зүйл. Суралцагчийн эрх, үүрэг

45.1. Суралцагч дараахь эрхтэй:

45.1.1. суралцах нөхцөл бололцоогоор хангуулах;

45.1.2. сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгаагүй хичээлээс сонгон судлах;

45.1.3. сургууль, багшийн үйл ажиллагаатай холбогдох асуудлаар санал гаргах, шүүмжлэх, шаардлага тавих;

45.1.4. суралцах хугацаа, хэлбэрийн талаар санал тавьж шийдвэрлүүлэх;

45.1.5. хууль тогтоомжид заасны дагуу тусламж авах, хөнгөлөлт эдлэх;

45.1.6. гэрээнд өөрөөр заагаагүй бол сургууль төгсөгч эзэмшсэн буюу сонирхсон мэргэжлийн дагуу эрхлэх ажлаа хөдөлмөрийн зах зээл дээр чөлөөтэй сонгох;

45.1.7.сургалтын төлбөр, хандивын зарцуулалт, ашиглалтын талаар мэдээлэл авах, хяналт тавих.

45.2. Суралцагч дараахь үүрэгтэй:

45.2.1. сургалтын хөтөлбөрийн агуулгыг хугацаанд нь бүрэн эзэмших;

45.2.2.багшаас тавьсан шаардлага, өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх;

45.2.3. бие дааж суралцах арга барилыг эзэмших;

45.2.4. багш, шавийн харилцааг хүндэтгэн дээдлэх;

45.2.5. сургуулийн дотоод журмыг хүндэтгэн сахих;

45.2.6. сургалтын төлбөрийг гэрээний дагуу хугацаанд нь төлөх.

46 дугаар зүйл. Эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүрэг

46.1. Эцэг, эх, асран хамгаалагч дараахь эрхтэй:

46.1.1.хүүхдээ аль сургуульд, ямар хэлбэрээр суралцуулахыг зохих журмын дагуу сонгох;

46.1.2.боловсролын сургалтын байгууллага, багшийн үйл ажиллагаатай холбогдсон санал, хүсэлт гаргах;

46.1.3.хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авьяас, бие, сэтгэцийн талаар сургууль, багшаас гаргасан тодорхойлолттой танилцах.

46.2. Эцэг, эх, асран хамгаалагч дараахь үүрэгтэй:

46.2.1.хүүхдийн авьяас, чадварыг бага наснаас нь дэмжин хөгжүүлэх, боловсрол эзэмшихэд нь шаардагдах нөхцөлийг бүрдүүлэх, багштай хамтран ажиллах, мэргэжлээ сонгоход нь хүүхэддээ туслах;

46.2.2.сургалтын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдуулан сургууль, багшаас тавьсан шаардлагыг биелүүлэх;

46.2.3.хүүхэддээ 16 хүртэл насанд нь суурь боловсрол заавал эзэмшүүлэх, суралцах хүсэл, сонирхлыг нь хааж боогдуулахгүй байх;

46.2.4. хүүхдийг гэр бүлийн орчинд сургах арга барил эзэмших.

47 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

47.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараахь эрхтэй:

47.1.1.мэргэжилтэн бэлтгүүлэх, ажиллагчын мэргэшлийг дээшлүүлэх захиалгыг холбогдох боловсролын сургалтын байгууллагад өгөх, гэрээ байгуулах;

47.1.2.гэрээ, захиалгаар суралцагчийн талаар санал гаргах, шаардлага тавих;

47.1.3.ажилтандаа боловсрол олгох, түүний мэргэшил дээшлүүлэх сургалт зохион байгуулах;

47.1.4.боловсролын байгууллагыг бэхжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх, ивээн тэтгэсний төлөө хууль тогтоомжид заасан зохих хөнгөлөлт эдлэх.

47.2. Аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэгтэй:

47.2.1.гэрээний дагуу суралцагчийг хүлээн авч үйлдвэрлэлийн дадлага хийлгэх нөхцөл, болопцоогоор хангах;

47.2.2. гэрээ, захиалгаар суралцагчийн сургалтын зардлыг төлөх;

47.2.3.ажилтан бие дааж сурч боловсрох, хүүхдээ сургахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

48 дугаар зүйл. Боловсролын хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

48.1.Суурь боловсрол олгох ажлыг хангалттүй зохион байгуулсан, зохих арга хэмжээ аваагүй төрийн захиргааны болон боловсролын байгууллагын гэм буруутай албан тушаалтанд хууль тогтоомжийн дагуу сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

48.2. Боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

48.2.1. энэ хуулийн 9 дүгээр зүйлийг зөрчиж боловсролын баримт бичгийг хууль бусаар олгосон, хуурамчаар үйлдсэн, авч ашигласан иргэнийг 20000-30000, албан тушаалтныг 40000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-200000 төгрөгөөр торгож, хуурамч баримт бичгийг хураах;

48.2.2. энэ хуулийн 47 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан үүргийг биелүүлэхээс зайлсхийсэн бол 50000-75000 төгрөгөөр торгох;

48.2.3.ажил үүргээ гүйцэтгэхэд нь багшид санаатайгаар саад учруулсан, багшийн нэр хүндийг гутаан доромжилсон этгээдийг 10000-30000 төгрөгөөр торгох;

48.2.4.энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан тусгай зөвшөөрөл аваагүй, боловсролын сургалтын байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй сургалтын ажил эрхэлсэн бол сургалтын төлбөрийг суралцагчид буцаан олгож, иргэнийг 30000-50000, албан тушаалтныг 40000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгож, олсон орлогыг хурааж, сургалтын үйл ажиллагааг зогсоох;

48.2.5.энэ хуулийн 46.2.3-т заасан үүргийг хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол 10000-30000 төгрөгөөр торгох.

48.3. Энэ хуулийн 48. 2-т заасан шийтгэлийг шүүгч, сум, дүүргийн Засаг дарга, боловсролын хяналтын улсын байцаагч ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэнд сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Бага, дунд боловсролын зорилго

2.1.Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчид ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Бага, дунд боловсролын агуулга

3 дугаар зүйл. Сургуулийн өмнөх боловсролын агуулга

3.1.Сургуулийн өмнөх боловсролын агуулга нь хүүхдэд дараахь мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, хүмүүжүүлэхэд чиглэнэ:

3.1.1.бие бялдрын хувьд эрүүл чийрэг, хэл яриа, хараа, сонсгол хэвийн, үндсэн хөдөлгөөнийг зөв гүйцэтгэдэг, ариун цэвэр, эрүүл ахуйн анхны хэвшилтэй болгох;

3.1.2.сэтгэн бодох чадварыг хөгжүүлэх, хүмүүнлэг ёс, байгалийн юмс, үзэгдлийн талаар анхдагч ойлголт эзэмшүүлэх;

3.1.3.хүрээлэн байгаа орчин, эд юмс, үйл явдлыг дүрслэн зурах, урлан бүтээх, дуулах, хөгжимдөх, бүжиглэх анхны төсөөлөлтэй болгох;

3.1.4.эцэг, эх, ах, эгч, дүү, бусад хүнийг хүндэлж, эелдэг харьцаж сургах;

3.1.5.бие даасан, эвсэг нийтэч чанарыг хөгжүүлэх;

3.1.6. бага боловсрол эзэмшихэд бэлтгэж, саная бодлоо зөв илэрхийлэх, бусдыг ойлгох, өөртөө үйлчлэх дадал, чадвартай болгох;

3.1.7. сурч мэдэх эрмэлзлэл төлөвшүүлэх

4 дүгээр зүйл. Бага боловсролын агуулга

4.1.Бага боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

4.1.1.эх хэлээрээ зөв ярьж, бодол санаагаа ойлгомжтой илэрхийлэх, уншиж, бичиж сургах;

4.1.2. тоо бодох, түүнийг амьдрал ахуйдаа хэрэглэж сурах;

4.1.3.хүрээлэн байгаа орчны үзэгдэл, юмсын талаар зохих шатны мэдлэг эзэмшүүлэх;

4.1.4.гоо зүй, хүмүүнлэг, үндэсний дэвшилт, ёс заншил, соёлын өв уламжлал, эрүүл ахуйн зохих шатны мэдлэг, чадвар эзэмшүүлэх;

4.1.6.өөрийн болон бусдын хөдөлмөрийг хүндэтгэх, үнэнч шударга, хамтач байдлыг эрхэмлэх үзэл төлөвшүүлэх;

4.1.7.бие дааж сурах арга барил эзэмшүүлэх.

4.2.Бага боловсролын агуулгын хүрээнд гадаад хэл, мэдээлэл зүйн анхны мэдлэг олгож болно.

5 дугаар зүйл. Суурь боловсролын агуулга

5.1.Суурь боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

5.1.1.эх хэл болон гадаад хэл, математик, мэдээлэл зүй, шинжлэх ухаан, эрх зүйн зохих шатны мэдлэг, өөрийн авьяас, чадварт тулгуурлан бие даан амьдрахад шаардлагатай чадвар, дадал эзэмшүүлэх;

5.1.2.гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэх;

5.1.3. эрүүл аж төрөх ёс, гэр бүлийн амьдралын анхан шатны ойлголт, соёлын төсөөлөл эзэмшүүлэх;

5.1.4. бие даан бүтээлчээр суралцах арга барил төлөвшүүлэх.

6 дугаар зүйл. Бүрэн дунд боловсролын агуулга

6.1.Бүрэн дунд боловсролын агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

6.1.1.эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;

6.1.2.байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;

6.1.3.мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;

6.1.4.бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

7 дугаар зүйл. Бага, дунд боловсрол эзэмшүүлэх хугацаа

7.1. Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдэд ерөнхий боловсролын сургууль орох хүртэлх хугацаанд эзэмшүүлнэ.

7.2. Бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 11 жилд тус тус эзэмшүүлнэ.

7.3. Ерөнхий боловсролын сургууль нь мөрдөх сургалтын төлөвлөгөөг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж, батална.

7.4. Суралцагч эзэмшвэл зохих боловсролыг тогтоосон хугацаанаас өмнө эзэмшсэн бол дараагийн анги дэвшүүлэх буюу анги алгасуулан суралцуулж болно.

8 дугаар зүйл. Бага, дунд боловсролын сурах бичиг

8.1.Бага, дунд боловсролын агуулгын стандарт, арга зүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна.

9 дүгээр зүйл. Бага, дунд боловсролын чанарын үнэлгээ

9.1.Боловсролын стандартаар суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг сургалтын явцад болон анги дэвших, сургууль төгсөхөд нь үнэлж, боловсролын чанарыг дүгнэнэ.

9.2. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадал, боловсролын чанарыг үнэлж, дүгнэх үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

9.3. Боловсролын тухай хуулийн 9.1-д заасны дагуу суурь, бүрэн дунд, мэргэжлийн боловсрол эзэмшин төгсөгчид гэрчилгээ, үнэмлэх, мэргэжлийн боловсролын үнэмлэх олгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бага, дунд боловсролын байгууллага

10 дугаар зүйл. Бага, дунд боловсролын байгууллагын тогтолцоо

10.1.Бага, дунд боловсролын байгууллага нь цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагаас бүрдэнэ.

10.2.Мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвтэй холбогдсон харилцааг Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулиар зохицуулна.

11 дүгээр зүйл. Цэцэрлэг

11.1.Цэцэрлэг нь хоёроос дээш наснаас сургуульд орох хүртэлх хугацаанд хүүхдийг бие бялдар, оюун санаар хөгжүүлж, төлөвшүүлэх сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага мөн.

11.2.Цэцэрлэг нь сургалтын стандартын дагуу хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын агуулгыг эзэмшүүлнэ.

11.3.Цэцэрлэг нь ердийн, асрамжийн, сувиллын гэсэн хэв шинжтэй байна.

11.4. Аж ахуйн нэгж, байгууллага нь цэцэрлэгтэй байж болно.

11.5.Цэцэрлэг нь боловсролын эрдэм

шинжилгээ, арга зүйн байгууллагаас зөвшөөрөл авч нэмэлт сургалт явуулж болно.

11.6.Цэцэрлэг нь хамран сургах тойргийнхоо цэцэрлэгт хамрагдаагүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх тур сургалт зохион байгуулах, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид мэргэжлийн туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

11.7 Асрамжийн болон сувиллын цэцэрлэгт мөрдөх журмыг боловсролын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

11.8.Цэцэрлэг нь эрхлэгч, багш, туслах багш болон үйлчилгээний бусад ажилтантай байна.

11.9.Цэцэрлэгийн эмээг бүлгийн болон эрхтэн согоотой, ою ухааны хөгжил дутмаг хүүхдийн бүлэгт зөлжийн багш ажиллуулж болно.

11.10. Асрамжийн болон сувиллын цэцэрлэгт эмч ажиллана.

12 дугаар зүйл. Ерөнхий боловсролын сургууль

12.1.Ерөнхий боловсролын сургууль нь улсын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.

12.2.Эзэмшүүлэх боловсролын түвшинг харгалзан ерөнхий боловсролын сургуулийг бага, дунд, ахлах сургууль гэж ангилна. Бага, дунд, ахлах сургууль нь цогцолбор хэлбэрээр хоршин ажиллаж болно.

12.3.Ерөнхий боловсролын сургууль нь ердийн, мэргэжлийн, гүнзгийрүүлсэн, тусгай сургалттай гэсэн хэв шинжтэй байна.

12.4.Ерөнхий боловсролын сургууль 7 настай хүүхдийг элсүүлнэ. Зохих бололцоо, нөхцөл бүрдсэн ерөнхий боловсролын сургууль 6 настай хүүхдийг элсүүлэн суралцуулж болно.

12.5.Ерөнхий боловсролын сургууль нь сургууль завсардсан хүүхэд, насанд хүрэгчдэд орой, эчнээ хэлбэрээр бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалт явуулж болно.

12.6. Ерөнхий боловсролын сургууль захирал, хичээлийн эрхлэгч /сургалтын менежер/, багш, нийгмийн ажилтан, бусад ажилтан ажиллана.

12.7.Сургуулийн онцлогийг харгалзан захиргааны удирдлагын орон тооны улгэрчилсэн нормативыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

13 дугаар зүйл. Ерөнхий боловсролын тусгай сургууль

13.1.Ерөнхий боловсролын тусгай сургууль нь тусгай хэрэгцээт боловсрол эзэмших хүүхдэд хөнгөрүүлсэн хөтөлбөр, арга, хэлбэрээр бага, суурь, бүрэн дунд боловсрол, мэргэжил эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн. Оюун ухааны хөгжил дутуу, хэл, хараа, сонсголын эрхтний согоотой хүүхдэд олгох боловсролыг тусгай хэрэгцээт боловсрол гэнэ.

13.2.Ерөнхий боловсролын тусгай сургууль нь хамран сургах тойрог тогтоох, аймаг, нийслэл, сум, дүүрэгт салбар бүлэг ажиллуулах, элсэлтийг зохион байгуулах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

13.3.Ерөнхий боловсролын сургууль нь тусгай хэрэгцээт боловсрол эзэмших хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол тусгайлан олгох бүлэг нээн хичээллүүлж болно.

13.4.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд тусгай сургуулиудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий төв сургууль ажиллаж болно.

13.5.Төв сургууль орон тооны арга зүйч, нийгмийн болон эрдэм шинжилгээний ажилтан тус тус ажиллана.

13.6.Ерөнхий боловсролын тусгай сургууль нь 12.6-д заасан ажилтнаас гадна эмч ажиллана.

13.7.Ерөнхий боловсролын тусгай сургууль нь сургалт-үйлдвэрлэлийн дадлагын газартай байж болно.

14 дүгээр зүйл. Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль

14.1.Суралцагчид бага, суурь, бүрэн дунд болон мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтыг хослон явуулдаг сургалтын байгууллагыг мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургууль гэнэ.

14.2.Мэргэжлийн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь хөгжим, бүжиг, дурслэх урлаг, биеийн тамир, техник, технологи зэрэг чиглэлээр суралцагчийн авьяас, чадварыг багаас нь хөгжүүлэх тусгай хөтөлбөрийн дагуу сургалт явуулах, эсхүл суралцагчийн чөлөөт сонголтоор тодорхой мэргэжлийн анхан шатны боловсролыг эзэмшүүлэх хэлбэртэй байж болно.

14.3.Шинжлэх ухааны нэг буюу хэд хэдэн чиглэлээр бүх нийтийн ерөнхий боловсролын стандартаас давсан агуулгаар сургалт явуулдаг сургуулийг гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль гэнэ.

14.4.Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургууль нь суралцагчид бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартын агуулгыг заавал эзэмшүүлнэ.

14.5.Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үлгэрчилсэн жүрмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

14.6.Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг тухайн сургуулийн саналыг үндэслэн аймаг, нийслэлийн боловсролын төв батална.

14.7.Ерөнхий боловсролын сургууль нь мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалт зохион байгуулах арга, технологийн талаар судалгаа, шинжилгээний ажил эрхэлж болно.

14.8.Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн элсэлтийн жүрмыг тухайн сургуулийн зөвлөл тогтооно.

14.9.Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалттай сургуульд бүх нийтийн ерөнхий боловсролын стандартаас давсан агуулгаар явуулсан сургалтын нэмэгдэл зардлын хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын батална жишгийг үндэслэн сургуулийн зөвлөл тогтоно. Сургалтын нэмэгдэл зардлыг эцэг, эх, асран хамгаалагчаас гаргуулж болно.

14.10.Мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтыг мэргэжлийн зэрэгтэй багш удирдана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бага, дунд боловсролын сургалтын ажлын зохион байгуулалт

15 дугаар зүйл. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаа

15.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлнэ.

15.2.Хичээлийн жилийн үргэлжлэх, дуусах болон улсын шалгалт авах хугацаог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

15.3.Нутаг дэвсгэрийн байгаль, цаг уур, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, байгалийн болон нийтийг хамарсан гамшигтай холбогдуулан онцгой дэглэм, хорио цээр тогтоосон нөхцөлийг харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах хугацаог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөөний дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийнхийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн үед нь өөрчилж болно.

15.4.Хичээлийн жилийн эхлэх, үргэлжлэх, дуусах болон суралцагчдын амралтын хугацааг энэ хуулийн 15.3-т зааснаас бусад нөхцөлд өөрчлөх, хичээлийг түр хугацаагаар хаахыг хориглоно.

16 дугаар зүйл. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын ажлын зохион байгуулалт

16.1.Цэцэрлэгийн сургалтын ажлыг бага, дунд, ахлах, бэлтгэл бүлгээр зохион байгуулна. Хүүхдийн тоо хүрэлцэхгүй тохиолдолд холимог бүлэг зохион байгуулж болно.

16.2.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг анги, бүлгээр зохион байгуулна. Гадаад хэл, мэргэжлийн сургалтын дадлага, мэргэжлийн болон гүнзгийрүүлсэн сургалтыг дэд бүлэг, хэсгээр зохион байгуулж болно.

16.3.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэгт байх хүүхдийн болон долоо хоногт хичээллэх цагийн тоо, нэг хичээлийн үргэлжлэх хугацаа, завсарлагаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

17 дугаар зүйл. Ерөнхий боловсролын сургуулийн дэг

17.1.Ерөнхий боловсролын сургууль нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн дотоод журамтай байна.

17.2.Ерөнхий боловсролын сургууль суралцагчийн дүрэмтэй байна. Суралцагчийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

17.3. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагч дүрэмт хувцастай байна.

18 дугаар зүйл. Хичээллээс гадуурх сургалтын ажил

18.1. Хичээллээс гадуурх сургалтын ажил нь суралцагчийн танхимд эзэмшсэн мэдлэг, чадварыг бататгах, баяжуулах, тэдний авъяас, сонирхлыг гүнзгийрүүлэн хөгжүүлэхэд чиглэнэ.

18.2.Хичээллээс гадуурх сургалтын ажлын үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран тогтооно.

18.3.Сургуулийн захиргаа нь хичээллээс гадуурх сургалтын ажлыг дугуйлан, түр сургалт, соёл, урлаг, спортын арга хэмжээ зэрэг хэлбэрээр үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох

байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдтэй хамтран зохион байгуулна.

18.4. Сургууль хүндэтгэлийн тэнхим, булантай байж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бага, дунд боловсролын сургалтын байгууллагын удирдлага

19 дүгээр зүйл. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлага

19.1.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн өөрийн удирдлага нь сургууль, цэцэрлэгийн зөвлөл байна. Сургууль, цэцэрлэгийн зөвлөл Боловсролын тухай хуулийн 35 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдан үйл ажиллагаагаа явуулна.

19.2.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг үүсгэн байгуулагчийн томилсон захирал /эрхлэгч/ удирдана.

19.3.Гадаад үлстай хамтарсан хэлбэрээр байгуулсан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь удирдах зөвлөлтэй байна. Удирдах зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлд зааснаар зохицуулна.

19.4.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжил, арга зүйн удирдлагыг багш нарын зөвлөл, заах аргын нэгдэл /тэнхим/ эрхэлнэ.

19.5.Сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн болон багш нарын зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

19.6. Заах аргын нэгдэл /тэнхим/-ийн ажиллах журмыг багш нарын зөвлөлийн саналыг үндэслэн захирал батална, мөрдүүлнэ.

19.7.Цэцэрлэг, сургуульд эцэг, эх, асран хамгаалагчийн болон суралцагчдын байгууллага ажиллаж болно.

20 дугаар зүйл. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн захирал /эрхлэгч/-ын нийтлэг эрх, үүрэг

20.1. Захирал /эрхлэгч/ нь дараахь эрхтэй:

20.1.1.холбогдох хуульт тогтоомжид нийцүүлэн зохих шийдвэр гаргаж хэрэгжүүлэх;

20.1.2. багш, ажилтныг сонгон авч ажиллуулах, өөрчлөх, чөлөөлөх;

20.1.3. багш нарын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн суралцагчийг анги дэвшүүлэх болон алгасуулан суралцуулах, улируулах, сургууль төгсгөх, сургуулиас хасах, чөлөөлөх;

20.1.4. сургалтын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч болон зохих байгууллагад шаардлага тавьж шийдвэрлүүлэх;

20.1.5. дотоод, гадаадын цэцэрлэг, сургууль, аж ахуйн нэгж, байгууллагатай хууль тогтоомжийн дагуу гэрээ, хэлцэл хийж, хамтран ажиллах;

20.1.6. сургалтын үйл ажиллагааны дэвшилтэт арга, хэлбэрийг турших, нэвтрүүлэх.

20.2. Захирал /эрхлэгч/ нь дараахь үүрэгтэй:

20.2.1.боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, биелэлтийг дүгнэх, тайлагнах;

20.2.2.цэцэрлэг, сургуулийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

20.2.3.цэцэрлэг, сургуулийг багш, ажилтнаар хангах, хамт олныг төлөвшүүлэх, тэдний хөдөлмөр, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, мэргэшлийг дээшүүлэх;

20.2.4.цэцэрлэг, сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах;

20.2.5.цэцэрлэг, сургуулийн санхүү, нягтлан бодох бүртгэл, статистикийн мэдээ, тайланг хугацааанд нь үнэн зөв гаргах ажлыг зохион байгуулах;

20.2.6.суралцагчийн авьяас, чадварыг хөгжүүлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх;

20.2.7.багш, ажилтны хөдөлмөрийн үр дүнг үнэлэх, урамшуулах, дэмжих, хариуцлага тооцох;

20.2.8.хамран сургах тойргийн хүүхдийг сургуульд бүрэн хамруулж, тэдэнд суурь боловсрол заавал эзэмшүүлэх, иргэдэд нийтийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулах;

20.2.9.багш, суралцагч, ажилтны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш

21 дүгээр зүйл. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг бэлтгэх, давтан бэлтгэх

21.1. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийг багш бэлтгэдэг их сургууль, дээд сургууль, коллежид бэлтгэнэ.

21.2. Багш нь багшлах эрхтэй байна.

21.3. Багш бус мэргэжлийн хүн заах арга зүйн сургалтад хамрагдсаны дараа багшлах эрх авна.

21.4. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшид зааx аргач багш, тэргүүлэх багш, зөвлөх багш гэсэн мэргэжлийн зэрэг олгоно.

21.5.Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

21.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн зааx арга, мэргэжлийн ур чадвар, мэргэшил дээшлүүлэх сургалтыг төвлөрсөн, бүсчилсэн болон зайны хэлбэрээр зохион байгуулахад Боловсролын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан байгууллага мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

22 дугаар зүйл. Багшийн эрх, үүрэг

22.1.Багш нь Боловсролын тухай хуулийн 44.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

22.1.1. багшийн ёс зүйн хэм хэмжээг хүндэтгэн сахиж биелүүлэх;

22.1.2.холбогдох хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журам, сургууль, цэцэрлэгийн зөвлөлийн шийдвэрийг мөрдөх, тэдгээрийг сурталцагч, эцэг, эх, асран хамгаалагч, иргэдэзд сурталчлах, суралцагчаа хуулийг хүндлэн дээдэлж, сахин биелүүлдэг болгох;

22.1.3.бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартыг мөрдөж, зааx арга, мэргэжлийн ур чадвараа байнга дээшлүүлэх;

22.1.4.сургалтын ажлын баримт бичгийг зохих журмын дагуу хөтлөх, хичээлийн хуваарь, үргэжлэх хугацааг мөрдөх;

22.1.5.хичээлийг багш, суралцагчийн хамтын бүтээлч уйл ажиллагаа болгон зохион байгуулах, суралцагчийг сэтгэн бодох, бие даан ажиллах чадвар, дадалд сургах, сурах явцад тохиолдох бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэхэд нь эцэг, эх, асран хамгаалагчид зөвлөх, туслах, суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг зөв үнэлэх;

22.1.6.хүүхдийн авьяас, чадвар, сонирхлыг нээн илрүүлж, чиг зорилготой хөгжүүлэх, хүүхдийн эрх ашгиг хамгаалахад эцэг, эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах, тэдэнд мэргэжлийн зөвлөгөө, туслалцаа үзүүлэх;

22.1.7. сургалтын ажлын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын шаардлагыг хангах;

22.1.8. бага насны хүүхдийн эрүүл мэнд, бие бялдрын хөгжлийн асуудлаар сургуулийн эмч болон эцэг, эх, асран хамгаалагчид мэдээлэл өгөх.

22.2. Багш нь Боловсролын тухай хуулийн 44.1-д зааснаас гадна сургууль болон багш, суралцагчийн сургалтын ажил, эрүүл мэнд, аюулгүй байдал, эрх ашигт сөрөг нөлөө үзүүлэх аливаа уйл ажиллагаа таслан зогсоох, хориглоход биечлэн оролцох эрх эдэлнэ.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

23 дугаар зүйл. Бага, дунд боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1.Бага, дунд боловсролын тухай хууль зөрчигчид Боловсролын тухай хуулийн 48.2-т заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улаанбаатар хот

БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг 2005-2006 оны хичээлийн жилээс эхлэн мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр

Улаанбаатар хот

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь иргэнд дээд боловсрол олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2.1.Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндэсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино.

2 дугаар зүйл. Дээд боловсролын зорилго

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын агуулга

3 дугаар зүйл. Дээд боловсролын агуулга

3.1.Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

3.2.Дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрийн агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

3.2.1.ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;

3.2.2.мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол- арга зүйн мэдлэг эзэмшүүлэх;

3.2.3.мэргэших хэсгийн агуулга нь суралцагчид нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тухайн мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх.

3.3.Дээд боловсролын зэрэг нь багц цагаар хэмжигдэх дипломын, бакалаврын, магистрын, докторын шатлалтай байна.

3.4.Багц цагийн хэмжээг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон мэргэжлийн байгууллага тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын сургалтын байгууллага

4 дүгээр зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллага

4.1.Дээд боловсролын сургалтын байгууллага нь Боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу их сургууль, дээд сургууль, коллеж гэсэн ангилалтай байна.

4.2.Их сургууль нь шинжлэх ухааны хэд хэдэн чиглэлээр суурь ба хавсарга судалгаа явуулдаг, бакалавр, магистр, докторын сургалт эрхэлдэг, үйлдвэр, үйлчилгээний бааз лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын байгууллага байна.

4.3.Дээд сургууль нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулдаг, дипломын болон бакалавр, магистрын сургалт эрхэлдэг, сургалт-эрдэм шинжилгээний байгууллага байна.

4.4.Коллеж нь дипломын болон бакалаврын сургалт эрхэлдэг сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

4.5.Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг сургуулийн хүчин чадал, үндсэн багш нарын дотор докторын зэрэгтэй багш нарын эзлэх хувь хэмжээг харгалзан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

5 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

5.1.Дээд боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын үндсэн нэгж нь тэнхим, лаборатори байна. Их сургууль нь профессорын багт тулгуурласан зохион байгуулалтын нэгжтэй байж болно.

5.2.Их сургууль харьяалалдаа дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээний хүрээлэн, гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуультай байж болно.

5.3.Дээд сургууль харьяалалдаа коллеж, сургалт-эрдэм шинжилгээний болон мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуультай байж болно.

5.4.Коллеж харьяалалдаа мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвтэй байж болно. Коллеж нь зарим мэргэжлээр шаталсан сургалт зохион байгуулж болно.

5.5.Их сургууль, дээд сургууль, коллежийн харьяаллын сургууль нь бие даасан хуулийн этгээд байна. Дээр дурдсан сургууль бие дааж магадлан итгэмжлэлд орно.

5.6.Дээд боловсролын сургалтын байгууллага нь хамтарсан болон дагнасан сургалт-эрдэм шинжилгээний зориулалт бүхий үйлдвэрлэл, үйлчилгээний түшиц байгууллага, лаборатори, эмнэлэг, дадлагын бааз, туслах аж ахуйтай байж болно.

5.7.Боловролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр тодорхой аж ахуйн нэгж, байгууллагыг сургалт-эрдэм шинжилгээ, дадлагын бааз болгож болно.

5.8.Дээд боловсролын сургалтын байгууллагын бүрэлдэхүүний нэгжийн эрх, үүрэг, хариуцлагыг их сургууль, дээд сургууль, коллежийн дүрмээр тогтооно.

6 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагыг байгуулах, өөрчлөх, зарим үйл ажиллагааг зогсоох, татан буулгах

6.1.Дээд боловсролын байгууллагыг Боловсролын тухай хуулийн 19, 20 дугаар зүйл, болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[1] хуулийн 15.7.1,15.7.2,15.7.4-т заасны дагуу үүсгэн байгуулна.

6.2.Цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэх байгууллагыг байгуулах, өөрчлөх, зарим үйл ажиллагааг зогсоох, татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

6.3.Төрийн өмчийн их сургууль, дээд сургууль, коллежийг өөрчлөх, зарим үйл ажиллагааг зогсоох, татан буулгах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага шийдвэрлэнэ.

6.4.Төрийн бус өмчийн их сургууль, дээд сургууль, коллежийг татан буулгах асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр суралцагчийн эрх ашгийг хохироохгүйгээр үүсгэн байгуулагч буюу түүний эрх олгосон этгээд шийдвэрлэнэ.

6.5.Дээд боловсролын сургалтын байгууллага татан буугдсан нөхцөлд оюутны мэдлэг, чадварыг шалган тогтоож, ижил мэргэжлийн сургууль шилжүүлэн суралцуулах, холбогдох зардлын асуудлыг татан буугдсан сургууль нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, дээд боловсролын сургалтын бусад байгууллагатай харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

6.6.Улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ болон түүнд зөвшөөрөл авааруй нөхцөлд оюутан элсүүлэх, сургалтын үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Дээд боловсролын сургалтын зохион байгуулалт

7 дугаар зүйл. Их сургууль, дээд сургууль, коллежийн элсэлт

7.1.Их сургууль, дээд сургууль, коллежид зохих болзол хангасан бүрэн дунд буюу түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ.

7.2.Мэргэжилтний хэрэгцээ, захиалга, сургуулийн хүчин чадлыг харгалзан элсэгчдийн тоог боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно. Сургуулийн хүчин чадлыг тодорхойлох үндэслэл нь багшлах боловсон хүчин, хичээлийн байр, лаборатори, номын сан, дүрмийн сангийн хэмжээ байна.

7.3.Оюутан, магистрант, докторант

[1] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн

элсүүлэх үлгэрчилсэн журмыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

8 дугаар зүйл. Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалтын зохион байгуулалт

8.1.Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалт нь өдөр, орой, эчнээ болон экстернат хэлбэртэй байж болно.

8.2.Их сургууль, дээд сургууль, коллежийн өдөр, оройн сургалтын хичээлийн жил 9 дүгээр сарын 1-ний өдөр эхэлнэ.

8.3.Нутаг дэвсгэрийн байгаль, цаг уур, үйлдвэрлэл, үйлчилгээний онцлог, байгалийн болон нийтийг хамарсан гамшигтай холбогдуулан онцгой дэглэм, хорио цээр тогтоосон нөхцөлийг харгалзан хичээлийн жилийн эхлэх хугацааг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тухайн үед нь өөрчилж болно.

8.4.Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалт мэргэжил бүрээр боловсруулсан сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн дагуу явагдана. Сургалтын төлөвлөгөөг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр сургуулийн захирал батална.

8.5.Их сургууль, дээд сургууль, коллежийн сургалтын зохион байгуулалт, дадлагын хөтөлбөр, дүрмийг сургуулийн эрдмийн болон сургалт-арга зүйн зөвлөлийн саналыг үндэслэн захирал батална.

8.6.Магистр, докторын сургалтын судалгаа, туршилтын ажлын зарим хэсгийг эрдэм шинжилгээний хүрээлэн, үйлдвэрийн газрын лаборатори, баазыг түшиглэн тухайн байгууллагын эрдэмтдийн удирдлагын дор явуулж болно.

8.7.Дээд боловсрол эзэмшүүлэх дипломын сургалт 9О багц цагаас доошгүй байх бөгөөд өмнөх түвшний сургалтын багц цагийг оролцуулан бакалаврын сургалт 12О-оос, магистрын сургалт 15О-аас, докторын сургалт 21О багц цагаас тус тус доошгүй байна.

8.8.Магистр, докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж, хэрэгжилтэд хяналт тавина.

8.9.Хичээлийн жилийн үргэлжлэх, дуусах болон шалгалтын хугацааг сургалтын төлөвлөгөөгөөр зохицуулна.

9 дүгээр зүйл. Их сургууль, дээд сургууль, коллежид суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлж, дүгнэх

9.1.Их сургууль, дээд сургууль, коллежид суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу үнэлж, дүгнэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын удирдлага сургалтын байгууллагын удирдлага

10 дугаар зүйл. Дээд боловсролын удирдлага

10.1.Дээд боловсролын удирдлагыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хэрэгжүүлнэ.

10.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дээд боловсролын асуудлаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1.дээд боловсролын байгууллагын үйл ажиллагаат төрийн бодлогын хүрээнд уялдуулан зохицуулж дэмжих, тэдгийг мэргэжлийн арга зүйн удирдлагаар хангах;

10.2.2.төрийн захиргааны бусад төв байгууллагатай тухайн салбарт мэргэжилтэн бэлтгэх асуудлаар хамтран ажиллах.

11 дүгээр зүйл. Дээд боловсролын

11.1.Их сургууль, дээд сургууль, коллежийн өөрийн удирдлагыг сургуулийн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

11.2.Их сургууль, дээд сургууль, коллежийн удирдах зөвлөл нь Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу байгуулагдан үйл ажиллагаагаа хэрэгжүүлнэ.

11.3.Захирал нь энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, сургуулийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, томилсон байгууллагын өмнө ажлаа тайлагнана.

11.4.Сургалт-эрдэм шинжилгээний ажлын чиглэлийг тогтоож, түүний онол, арга зүйн түвшин, ач холбогдол, үр дүнг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зорилгоор их сургууль, дээд сургуульд эрдмийн зөвлөл, коллежид сургалт-арга зүйн

зөвлөл ажиллана. Эрдмийн болон сургалт-арга зүйн зөвлөлийн дарга нь тухайн сургуулийн захирал байна.

11.5.Захирал нь харьяаллын сургууль, тэнхим, лаборатори, эрдэм шинжилгээний нэгжийн саналыг үндэслэн эрдмийн болон сургалт-арга зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, түүний ажиллах жүрмыг батална.

11.6. Захирлын дэргэд захиргааны зөвлөл ажиллаж болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын сургалтын байгууллагын бүрэн эрх

12 дугаар зүйл. Дээд боловсролын сургалтын байгууллагын эрх, үүрэг

12.1.Дээд боловсролын сургалтын байгууллага дараахь эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

12.1.1.дээд боловсрол, шинжлэх ухаан, технологи хөгжүүлэх төрийн бодлогод нийцүүлэн сургуулиа хөгжүүлэх чиглэл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;

12.1.2. сургалтын агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг сонгож хэрэгжүүлэх;

12.1.3. эрдэм шинжилгээ, судалгааны төсөлд оролцох;

12.1.4.боловсролын байгууллагын багш, ажилтны цалин хөлсний хэмжээг тогтоох, байгууллагын дотоод журам боловсруулж, мөрдүүлэх;

12.1.5.тогтоосон журмын дагуу сургуулийн бүтэц, зохион байгуулалтыг тогтоох, харьяа нэгж, байгууллагыг байгуулах, өөрчлөх, татан буулгах, тэдгээрийн тайлан сонсож үйл ажиллагаанд нь үнэлэлт, дүгнэлт өгөх;

12.1.6.суралцагч элсүүлэх, төгсгөх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх;

12.1.7.багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, тэдний болон төгсөгчийн мэргэшлийг дээшлүүлэх;

12.1.8.багшид боловсролын зэрэг, цол олгох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон журмын дагуу шийдвэрлэх;

12.1.9.бүс нутгийн болон олон улсын чанартай уулзалт, хурал, семинар зохион байгуулах;

12.1.10.үйл ажиллагаандаа нийцүүлэн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх;

12.1.11.гадаадын болон дотоодын боловсрол, шинжлэх ухааны байгууллага, бусад этгээдтэй өөрийн эрх хэмжээний асуудлаар гэрээ, хэлэлцээр хийх;

12.1.12.шаардлагатай гэж үзвэл шинээр элсэгчид зориулан бэлтгэл сургалт зохион байгуулах;

12.1.13.иргэдийн боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх болон нийгмийн халамж, хүмүүнлэгийн чиглэлийн үйлчилгээ үзүүлэх.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Багш, суралцагч

13 дугаар зүйл. Багш

13.1. Их сургууль, дээд сургууль, коллежид үндсэн мэргэжлийн хичээлийг магистр, түүнээс дээш зэрэгтэй багш заана.

13.2.Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн мэргэжил хэмжээгүй орон тооны багш заах арга зүй хэмжилсэн байна.

13.3.Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаал нь профессор, дэд профессор, ахлах багш, багш, дадлагажигч багш байна.

13.4.Дээд боловсролын сургалтын байгууллагад багшилсан хугацаа, сургалтын ажлын дадлага, туршлага, эрдэм шинжилгээний бүтээл, туурвилыг харгалзан докторын зэрэгтэй хүнд дээд профессор, профессор цолыг их сургууль, дээд сургууль олгоно.

13.5.Их сургууль, дээд сургууль, коллежийн багшийн албан тушаал, дэд профессор, профессор цолын тодорхойлолт, нийтлэг шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

14 дүгээр зүйл. Багшийн эрх, үүрэг

14.1.Багш Боловсролын тухай хуулийн 44.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

14.1.1.төрийн захиргааны болон үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн дагуу зөвлөхөөр ажиллах;

14.1.2.бүтээлийн чөлөө авах;

14.1.3.хөдөлмөрөө бодитой үнэлүүлэх, боловсролын зэрэг, цолын нэмэгдэл авах, нийгмийн зохих хангамж, хөнгөлөлт эдлэх.

14.2.Багш Боловсролын тухай хуулийн 44.2-т зааснаас гадна дараахь үүрэгтэй:

14.2.1.эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эрхлэн явуулах;

14.2.2.мэргэжлийн дагуу аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд соёл, боловсролыг түгээн дэлгэрүүлэх, сурталчлах ажилд туслах.

15 дугаар зүйл. Суралцагч

15.1.Их сургууль, дээд сургууль, коллежийн дипломын болон бакалаврын шатлалд суралцагчийг оюутан, магистрын шатлалд суралцагчийг магистрант, докторын шатлалд суралцагчийг докторант гэнэ.

16 дугаар зүйл. Суралцагчийн эрх, үүрэг

16.1.Суралцагч Боловсролын тухай хуулийн 45.1-д зааснаас гадна дараахь эрхтэй:

16.1.1.их сургууль, дээд сургууль, коллеж, түүний харьяаллын нэгжийн хичээлийн байр, номын сан, сургалт-эрдэм шинжилгээний лаборатори болон сургалтын бусад хэрэгслийг зохих журмын дагуу ашиглах;

16.1.2.зарим хичээлийг бие даан судалж, дүгнүүлэх;

16.1.3.эрдэм шинжилгээний ажил, бага хуралд оролцох;

16.1.4.бүтээлээ хэвлүүлэхээр дэвшүүлэх;

16.1.5.сургалтын үйл ажиллагаатай холбоотой асуудлыг хэлэлцэх, шийдвэрлэхэд шууд буюу төлөөлөн оролцох;

16.1.6.магистрант нь оюутанд мэргэжлийн зөвлөгөө өгөх, түүний судалгааны болон дадлагын ажлыг удирдах;

16.1.7.докторант нь хичээл заах, оюутан, магистрантын эрдэм шинжилгээний ажил удирдах.

16.2.Суралцагч Боловсролын тухай хуулийн 45.2-т заасан үүрэг хүлээнэ.

НАЙМДУГААР БҮЛЭГ

Дээд боловсролын эдийн засаг, нийгмийн баталгаа

17 дугаар зүйл. Дээд боловсролын төлөвлөлт, мэдээлэл

17.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь дээд боловсролыг хөгжүүлэх, их сургууль, дээд сургууль, коллеж нь сургуулиа хөгжүүлэх ойрын болон хэтийн бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

17.2.Их сургууль, дээд сургууль, коллеж нь статистикийн болон бусад шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох байгууллагад өгнө.

17.3.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллежийг холбогдох мэдээллээр хангана.

18 дугаар зүйл. Дээд боловсролын санхүүжилт

18.1.Төрийн өмчийн их сургууль, дээд сургууль, коллежийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

18.1.1.улсын төсвийн хөрөнгө;

18.1.2.эрдэм шинжилгээ, судалгааны ажлын төслийн санхүүжилт;

18.1.3.сургалтын төлбөр;

18.1.4.аж ахуйн үйл ажиллагааны орлого;

18.1.5.аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив;

18.1.6.зээл, тусламж;

18.1.7.бусад эх үүсвэр.

18.2.Төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын сургалтын орчныг сайжруулах, багшлах боловсон хүчнээр хангахад Засгийн газраас тогтоосон журмын дагуу төрөөс зохих дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

18.3.Боловсролын байгууллагад хандивласан хөрөнгийг тайланд тусгаж, зориулалтын дагуу ашиглана.

18.4.Зайлшгүй шаардлагатай зарим мэргэжлээр гадаадад мэргэжилтэн бэлтгэх сургалтын зардлыг жил бүрийн улсын төсвөөс санхүүжүүлж болох бөгөөд боловсролын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мэргэжлийн хэрэгцээг үндэслэн төрөөс суралцагчид үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг хуваарилан зохицуулна.

18.5.Өмчийн аль ч хэлбэрийн дээд боловсролын сургалтын байгууллага нь хоёр жил тутамд санхүүгийн үйл ажиллагаандаа аудитын хяналт хийлгэж, дүнг нийтэд ил тод байлгана.

19 дүгээр зүйл. Суралцагчийн нийгмийн баталгаа

19.1.Оршин суугаа газраасаа сургуульдаа тогтмол явах боломжгүй суралцагчид Боловсролын тухай хуулийн 43.2.1-д заасны дагуу дотуур байраар үйлчилнэ.

19.2.Өнчин, тахир дутуу болон амьжиргааны баталгаат түвшингээс доогуур орлоготой өрхийн болон бусад шаардлагатай суралцагчид тэтгэлэг, буцалтгүй тусламж, сургалтын төлбөрт зориулан хөнгөлөлттэй зээл олгоно.

19.3.Сургалт, эрдэм шинжилгээний ажилд амжилт гаргасан суралцагчид нэрэмжит тэтгэлэг олгох, сургалтын төлбөрийн зарим хэсгийг хөнгөлөх буюу бусад хэлбэрээр хөхиүлэн дэмжинэ.

19.4.Суралцагчид тэтгэлэг, буцалтгүй тусламж, хөнгөлөлттэй зээл олгох журмыг Засгийн газар тогтооно.

19.5.Дээд боловсролын сургалтын байгууллагад эчнээ, оройн хэлбэрээр суралцагчид ажлын газар нь улирлын болон төгсөлтийн шалгалт өгөх, дипломын ажил бичих хамгаалахад зориулж цалинтай чөлөө олгоно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

20 дугаар зүйл. Дээд боловсролын тухай хуууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

20.1.Дээд боловсролын тухай хууль тогтоомж зөрчигчид эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол боловсролын хяналтын улсын байцаагч Боловсролын тухай хуулийн 48.2-т зааснаас гадна дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

20.1.1.энэ хуулийн 8 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн бол бүрүүтай этгээдийг 30000-60000 төгрөгөөр торгох;

20.1.2.энэ хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн бол дээд боловсролын сургалтын байгууллагын захирлыг 30000-60000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр Улаанбаатар хот

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго, агуулга, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжил олгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцаог зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуууль тогтоомж

2.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Хөдөлмөрийн тухай[1], Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай[2] хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

[1] Хөдөлмөрийн тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1999 оны 25 дугаарт нийтлэгдсэн.
[2] Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2001 оны 19 дүгээрт нийтлэгдсэн

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулиар дээд боловсролын сургалтын байгууллагаас бусад байгууллагад мэргэжил эзэмшүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо

4.1.Энэ хуульд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1."мэргэжил" гэж тодорхой ажил, хөдөлмөрийг эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг;

4.1.2."мэргэжлийн боловсрол" гэж иргэний авьяас, сонирхол, хэрэгцээнд нийцүүлж албан ба албан бус хэлбэрээр эзэмшүүлсэн мэргэжлийн ур чадварын түвшин, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг;

4.1.3."мэргэжлийн сургалт" гэж иргэнд тодорхой мэргэжил эзэмшүүлэх үйл ажиллагаа;

4.1.4."мэргэшил" гэж тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадварын түвшинг.

5 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын зорилго

5.1.Мэргэжлийн боловсролын зорилго нь иргэний авьяас, сонирхол, нийгмийн хэрэгцээнд тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн мэргэжлийн боловсрол эзэмшүүлэхэд оршино.

5.2.Мэргэжлийн сургалтын зорилго нь мэргэжилтэй ажилтан бэлтгэх, давтан сургах замаар хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд оршино.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага

6 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлагын тогтолцоо

6.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын удирдлага нь төрийн захиргааны, түхайн байгууллагын болон сургуулийн өөрийн удирдлагаас бүрдэнэ.

6.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын төрийн захиргааны удирдлагыг боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн Засаг дарга хэрэгжүүлнэ.

6.3.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын болон түүний өөрийн удирдлагатай холбогдсон харилцааг Боловсролын тухай хуулийн 33, 36 дугаар зүйл, Бага, дунд боловсролын тухай хуулийн 20.1, 20.2-т заасны дагуу зохицуулна.

6.4.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийг үүсгэн байгуулагч, ажил олгогч, хөдөлмөр эрхлэлтийн алба, багш, суралцагч, төсөгчдийн төлөөлөлтэй байгуулж ажиллуулна.

6.5.Энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан байгууллага болон аймаг, нийслэлийн боловсролын төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг мэргэжил-арга зүйн удирдлагаар хангана.

7 дугаар зүйл. Боловсролын болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

7.1.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлд зааснаас гадна мэргэжлийн боловсрол, сургалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.1.1.мэргэжлийн боловсрол, сургалтын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

7.1.2.мэргэжлийн боловсролын болон хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх.

7.2.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэргэжлийн боловсрол, сургалтын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1.хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг судлах, энэ тухай мэдээллээр байгууллага, иргэнийг хангах;

7.2.2.мэргэжлийн сургалтын мэдээллийн сан бүрдүүлэх, түүнд дүн шинжилгээ хийх;

7.2.3.мэргэжлийн сургалт эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох;

7.2.4.мэргэжлийн түр сургалтын байгууллагын үйл ажиллагааанд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх, нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.

8 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл

8.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын үндэсний зөвлөл /цаашид "зөвлөл" гэх/ нь мэргэжлийн боловсрол, сургалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хамтын ажиллагааг дэмжих чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

8.2.Зөвлөл нь Засгийн газар, түүний байгууллага, ажил олгогч, ажилтны эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй байна.

8.3.Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална.

8.4.Зөвлөл нь ажлын албатай байж болно. Зөвлөлийн ажлын албаны ажиллах журмыг энэ хуулийн 8.1-д заасан зөвлөл батална.

9 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил-арга зүйн төв

9.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил-арга зүйн төв нь мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар судалгаа, шинжилгээ хийх, зөвлөлгөө өгөх, мэргэжил-арга зүйн үйлдирлагаар хангах үүрэгтэй албан мөн.

9.2.Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэжил-арга зүйн төвийн дүрмийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Мэргэжлийн боловсрол

10 дугаар зүйл. Мэргэжлийн боловсролын агуулга

10.1.Мэргэжлийн боловсролын агуулга нь суралцагчид ажил, мэргэжлийн үндэсний ангилал, мэргэжлийн стандартаар тодорхойлсон мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэхэд чиглэнэ.

10.2.Мэргэжлийн боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгээс бүрдэх бөгөөд хэсэг тус бүрийн агуулга нь дараахь зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ:

10.2.1.ерөнхий суурь хэсгийн агуулга нь Бага, дунд боловсролын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан зорилтыг хэрэгжүүлэх;

10.2.2.мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид үйлдвэрлэл, үйлчилгээ, техник, технологийн чиглэлээр тодорхой мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай мэдлэг олгох;

10.2.3.мэргэшүүлэх хэсгийн агуулга нь мэргэжлийн чадвар, дадал эзэмшүүлэх, тухайн мэргэжлээр сонгон мэргэшүүлэх.

10.3.Мэргэжлийн боловсрол нь шатлалтай байна.

10.4.Мэргэжлийн боловсролын агуулгыг багц цагаар хэмжинэ.

11 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсролын стандарт

11.1.Мэргэжлийн боловсролын стандарт нь суралцагчид зайлшгүй эзэмшсэн байвал зохих мэргэжлийн боловсролын агуулга, түүний үнэлгээ, багшийн мэргэжлийн түвшин, сургалтын байгууллагад тавигдах үндсэн шаардлагыг тодорхойлно.

11.2.Мэргэжлийн боловсролын улсын стандартыг боловсролын болон холбогдох төрийн захиргааны төв байгууллага, мэргэжлийн боловсролын сургалтын болон мэргэжил-арга зүйн байгууллага, ажил олгогч, мэргэжлийн холбоо хамтран боловсруулж, Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай[1] хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу батлуулж, улсын бүртгэлд бүртгэнэ.

12 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын ажлын зохион байгуулалтын хэлбэр

12.1.Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын ажлын зохион байгуулалтын үндсэн хэлбэр нь онолын хичээл, үйлдвэрлэлийн сургалт, дадлагын ажил байна.

12.2.Үйлдвэрлэлийн сургалт, дадлагыг сургууль дээрх, ажлын байран дахь, тегсөлтийн өмнөх гэсэн хэлбэрээр зохион байгуулна.

12.3.Мэргэжлийн боловсролыг өдөр, орой, эчнээ сургалтын хэлбэрээр эзэмшүүлнэ.

[1] Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1995 оны 3 дугаарт нийтлэгдсэн

13 дугаар зүйл. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага

13.1.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь иргэний сонирхол, авъяас, чадварыг харгалзан нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн мэргэжил эзэмшүүлэх үүрэг бүхий байгууллага мөн.

13.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, салбар, үйлдвэрлэлийн харъяалалтай сургалтын төв, мэргэжил-арга зүйн төв, тусгай хэрэгцээт сургалтын байгууллагаас бүрдэнэ.

13.3.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь зохих түвшний боловсролтой мэргэжилтэй ажилтан бэлтгэнэ.

14 дүгээр зүйл. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц

14.1.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь сургалтын орчны стандартын шаардлага хангасан хичээлийн танхим, лаборатори, дадлагын газар, сургалтын талбай, туршилт-үйлдвэрлэлийн цех, сургалтын аж ахуй, соёл-спортын төв, номын сан, мэдээллийн төвтэй байна.

14.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага нь бүрэлдэхүүн болон харьяалалдаа мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлдвэрлэл-үйлчилгээ эрхлэх нэгж, туслах аж ахуйтай байж болно.

14.3.Төрийн захиргааны төв болон холбогдох бусад байгууллагын хамтарсан шийдвэрээр тодорхой үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагыг мэргэжлийн боловсролын байгууллагын сургалт-үйлдвэрлэл, дадлагын бааз болгон ажиллуулж болно.

15 дугаар зүйл.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, тусгай зөвшөөрөл олгох, улсын бүртгэлд бүртгэх, татан буулгах

15.1.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагыг үүсгэн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг Боловсролын тухай хуулийн 19, 25 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

15.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага байгуулах тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдсон харилцааг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11-14 дүгээр зүйл, Боловсролын тухай хуулийн 19- 24 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

16 дугаар зүйл. Суралцагч элсүүлэх

16.1.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад суурь, түүнээс дээш боловсролтой иргэнийг элсүүлнэ. Энэ нь түр сургалтад элсэгчдэд үл хамаарна.

16.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад элсэгчдийн хяналтын тоо, суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журмыг энэ хуулийн 8.1-д заасан зөвлөлийн саналыг харгалзан боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

17 дугаар зүйл. Мэргэжлийн боловсролын чанарын үнэлгээ

17.1.Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлж, дүгнэх асуудлыг Бага, дунд боловсролын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

17.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага төгсөгчид мэргэжлийн боловсролын үнэмлэх олгоно. Суурь боловсрол эзэмшсэний дараа хоёроос доошгүй жил суралцан төгсөчид олгох мэргэжлийн боловсролын үнэмлэх нь бүрэн дунд боловсрол эзэмшсэнийг давхар гэрчилнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Мэргэжлийн түр сургалт

18 дугаар зүйл. Мэргэжлийн түр сургалтын агуулга

18.1.Мэргэжлийн түр сургалтын агуулга нь суралцагчид нэгж буюу бүлэг ажилбарыг гүйцэтгэхэд шаардагдах техник, технологийн анхан шатны мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.

19 дүгээр зүйл. Мэргэжлийн түр сургалт

19.1.Иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зайлшгүй шаардагдах мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх түр сургалтыг бүх шатны сургууль, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн эрхлэн явуулж болно.

20 дугаар зүйл.Мэргэжлийн түр сургалт төгсөчийг үнэлж, дүгнэх

20.1.Мэргэжлийн түр сургалтад суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлж, дүгнэх үлгэрчилсэн журмыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

20.2.Мэргэжлийн түр сургалтын хөтөлбөрийг хангасан төгсөгч болон үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад ажиллаж тухайн мэргэжлийн шаардлагыг хангасан гэж ажил олгогчийн тодорхойлсон ажилтан мэргэжлийн ур чадварын шалгалтад орох эрхтэй.

20.3. Онол, дадлагын хэсгээс бүрдэх мэргэжлийн ур чадварын шалгалтыг хөдөлмөрийн

асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага улсын хэмжээнд зохион байгуулна.

20.4.Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага энэ хуулийн 20.3-т заасан шалгалтын заримхэсгийг болон бүхэлд нь аж ахуйн нэгж, байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж болно.

20.5.Энэ хуулийн 20.3-т заасан шалгалтад тэнцсэн иргэнд гэрчилгээ олгоно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Мэргэжлийн боловсролын сургалтын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг

21 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын сурагчийн эрх, үүрэг

21.1.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад сурагчаар Боловсролын тухай хуулийн 45.1-д заасанаас гадна дараахь эрхтэй:

21.1.1.сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг үнэ төлбөргүй ашиглах;

21.1.2.үйлдвэрлэл, үйлчилгээний дадлага хийхэд үндсэн болон багалданчийн орон тоонд ажиллаасан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх;

21.1.3.мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг дээд үнэлгээтэй төгсөгч нь шаталсан сургалттай мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын дараагийн шатны сургалтад тухайн жилдээ мэргэжлээрээ шалгалтгүй элсэх.

21.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагад сурагчаар Боловсролын тухай хуулийн 45.2-т заасанаас гадна үйлдвэрлэлийн дадлагын үед аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журам, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрмийг сахин биелүүлэх үүрэгтэй.

22 дугаар зүйл. Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш

22.1.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын мэргэжлийн онолын багш нь бакалавр, түүнээс дээш, дадлагын багш нь дипломын боловсролоос доошгүй болон үйлдвэрлэлийн зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй байна.

22.2.Багшийн мэргэжил эзэмшээгүй орон тооны багш нь сурган-заах арга зүй эзэмшсэн байна.

22.3.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын онолын болон дадлагын багшид Бага, дунд боловсролын тухай хуулийн 21.4-т заасны дагуу мэргэжлийн зэрэг олгоно.

23 дугаар зүйл.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багшийн эрх, үүрэг

23.1.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш Боловсролын тухай хуулийн 44.1-д заасанаас гадна дараахь эрхтэй:

23.1.1.үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад мэргэжлийн дагуу гэрээгээр ажиллах, мэргэшил дээшлүүлэх;

23.1.2. шинэ техник, технологи судлах, дадлага хийх.

23.2.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын багш Боловсролын тухай хуулийн 44.2-т заасанаас гадна дараахь үүргэтэй:

23.2.1.сургалтын явцад эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангаж ажиллах;

23.2.2.аж ахуйн нэгж, байгууллагад мэргэжлийн зөвлөгөө өгөх, туслалцаа үзүүлэх;

23.2.3.шинэ техник, технологи, стандарт, норматив, хөдөлмөр зохион байгуулалтын дэвшилтэт арга барил судлах, сургалтад хэрэглэх.

24 дүгээр зүйл. Нийгмийн түншлэл

24.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын асуудлаар хамтран ажиллах ажил олгогч, ажилтан, үйлдвэрчний эвлэл, мэргэжлийн холбоод, аж ахуйн нэгж, байгууллага зэрэг сонирхогч этгээд нэгдэн нийгмийн түншлэлийг бүрдүүлнэ.

24.2.Нийгмийн түншлэл нь дараахь чиглэлээр хамтран ажиллана:

24.2.1.мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи төрийн бодлого боловсруулахад оролцох;

24.2.2.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сургалтын орчин, нөхцөлийг сайжруулах;

24.2.3.мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг санхүүгийн талаар дэмжих;

24.2.4.сургалтын агуулга, стандарт боловсруулахад оролцох;

24.2.5.үйлдвэрлэлийн сургалт, дадлагыг хамтран зохион байгуулах;

24.2.6.багш нарын мэргэшил дээшлүүлэх;

24.2.7. мэргэжлийн шалгалт хамтран авах;

24.2.8.төгсөгчийг ажлын байраар хангах;

24.2.9. хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагаа.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

25 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын санхүүжилт

25.1.Төрийн өмчийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын тогтмол зардал болон анхан шатны ангид сурч байгаа суралцагчийн дотуур байрны нийт зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр нэг сурагчид ногдох хувьсах зардлыг төсвөөс санхүүжүүлнэ.

25.2.Төрийн бус өмчийн мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь үүгээр байгууллагчийн хөрөнгө, нэг сурагчид ногдох хувьсах зардлын төсвөөс санхүүжүүлсэн хэсэг, сургалтын төлбөр, хандив, хөнгөлөлттэй зээл, өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ.

25.3.Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын сурәлцагчийн үйлдвәрлэлийн сургалт, даалгын зардлыг сургалтын байгууллага, аж ахуйн нэгжийн хооронд байгуулсан гэрээгээр зохицуулна.

25.4.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 9.1-д заасан иргэний мэргэжлийн түр сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

26 дугаар зүйл. Мэргэжлийн боловсрол, сургалтын хяналт

26.1.Мэргэжлийн боловсролын төрийн захиргааны хяналтыг боловсролын улсын хяналтын алба, улсын байцаагч хэрэгжүүлнэ

26.2.Мэргэжлийн түр сургалтын төрийн захиргааны хяналтыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн улсын хяналтын алба, улсын байцаагч хэрэгжүүлнэ.

27 дугаар зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

27.1.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Боловсролын тухай хуулийн 48 дугаар зүйлд зааснаас гадна энэ хуулийн 21.1.2-т заасныг зөрчсөн албан тушаалтныг 50000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-200000 төгрөгөөр торгох шийтгэлийг боловсролын хяналтын улсын байцаагч ногдуулна.

27.2.Энэ хуулийн 7.2.3-т заасан шаардлагыг биелүүлээгүй байгууллага, аж ахуйн нэгжийг 150000-250000, албан тушаалтныг 50000-60000, иргэнийг 30000-50000 төгрөгөөр тус тус торгох шийтгэлийг хөдөлмөрийн улсын байцаагч ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр **Улаанбаатар хот**

ХУУЛИУД ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Боловсролын тухай 1995 оны 6 дугаар сарын 13-ны өдрийн, Дээд боловсролын тухай 1995 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн, Бага, дунд боловсролын тухай 1996 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн хуулийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр **Улаанбаатар хот**

ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7, 16 дугаар зүйлд дараахь агуулгатай заалт тус тус нэмсүгэй:

1/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"7.1.8. шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах, олгох журмыг батлах;"

2/ 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 8 дахь заалт:

"16.1.8. шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалах."

2 дугаар зүйл. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.8-ын дугаарыг "7.1.9." болгон өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 13 | Улаанбаатар хот

Хөдөө аж ахуйн ажилтны өдөр бий болгох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: тэмдэглэж байхаар тогтоосугай.

Жил бүрийн 11 дүгээр сарын хоёр дахь ням гарагийг Хөдөө аж ахуйн ажилтны өдөр болгон

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 14 | Улаанбаатар хот

Байгаль орчныг хамгаалах өдрүүд бий болгох тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах өдрүүд бий болгож, үг өдрүүдийг жил бүрийн 9 дүгээр сарын дөрөв дэх долоо хоногт зохион байгуулж байхаар тогтоосугай.

2. Байгаль орчны өдрүүдийн үеэр байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх ажлыг бүх нийтийг хамарсан хөдөлгөөн болгон өрнүүлэх, байгаль орчны талаархи мэдээллийг нийтийн хүртээл болгох, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг өргөнөөр зохион байгуулах арга хэмжээ авч байхыг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 15 | Улаанбаатар хот

Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Бага, дунд боловсролын тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ Нь:

1. Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг мөрдөх, бэлтгэлийг хангах зорилгоор дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ 2002-2003 оны хичээлийн жилээс 8 настай хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд элсүүлэн суралцуулж одоогийн мөрдөж байгаа бага, дунд боловсролын улсын стандарт, сургалтын хөтөлбөрийн дагуу суурь болон бүрэн дунд боловсрол олгож байх;

2/ зохих нөхцөл, бололцоо бүрдсэн ерөнхий боловсролын сургуульд 7 настай хүүхдийг элсүүлэн сургах арга хэмжээг бүх талаар дэмжих;

3/ 11 жилийн сургалттай ерөнхий боловсролын сургуульд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын стандарт, төлөвлөгөөг 2004 онд багтаан шинэчлэн боловсруулж, тэдгээрт нийцүүлэн сурах бичгүүдийг шинэчлэх, хэвлүүлэх, хуваарилах ажлыг эзлэх дараатай зохион байгуулах;

4/ ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх бэлтгэлийг хангах.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын байнгын хороо /Т.Ганди/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 5.5 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (257)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Конвенцид нэгдэн орох тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *"Эрдэнэт" хамтарсан үйлдвэрт хийсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай*
- *Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 02 дугаар дүгнэлтийн тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны тавдугаар сарын 30 №20 (257)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

212. Конвенцид нэгдэн орох тухай (2002-5-16-ны хуулль) 681

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

213. "Эрдэнэт" хамтарсан үйлдвэрт хийсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай Дугаар 16 682

214. Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхарлыг зогсоох тухай тогтоолын төсөл буцаах тухай Дугаар 17 683

215. Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Дугаар 18 683

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

216. Супонг Лимтанакулыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 48 684

217. Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай Дугаар 66 684

218. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 67 685

219. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 68 685

220. Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 69 685

221. Зарим хүмүүсийг шүүгчээр томилох тухай Дугаар 70 686

222. Кенжи Мияхараг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 72 686

223. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 77 686

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

КОНВЕНЦИД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1946 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Вашингтон хотноо баталсан Халимны менежментийн тухай олон улсын Конвенцид Монгол Улс нэгдэн орсныг соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

2002 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 16 **Улаанбаатар хот**

"Эрдэнэт" хамтарсан үйлдвэрт хийсэн шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Монгол-Оросын Уулын баяжуулах "Эрдэнэт" хамтарсан үйлдвэрт Төрийн хянан шалгах хорооноос хийсэн шалгалтын мөрөөр дахин судалж танилцах, зарим асуудлыг гүнзгийрүүлэн шалгах зорилгоор Улсын Их Хурлын даргын 2001 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 136 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсгийн шалгалтын дүнг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцээд ТЭМДЭГЛЭХ нь:

Улсын Их Хурлын ажлын хэсэг Уулын баяжуулах "Эрдэнэт" хамтарсан үйлдвэрийн тухай Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Хэлэлцээр, Дүрэм, нэмэлт Протоколын зарим заалтын биелэлт, үйлдвэрийн дүрмийн сангийн бүрдүүлэлт, нөгдөл ашгийн хуваарилалт, экспорт, импортын гэрээнүүд, тэдгээрийг байгуулах үйл ажиллагаанд оролцож байсан албан тушаалтнуудын хариуцлага, "Эрдэнэт" хамтарсан үйлдвэрийн ёр, авлага их хэмжээгээр үүссэн шалтгаан нөхцөл, бусад аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулсан болон валютын арилжаа хийсний үр дагавар, татвар төлөлтийн байдал, үйлдвэрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, Монгол Улсын хууль тогтоомжийн биелэлт, сахилга хариуцлагатай холбоотой асуудлуудыг хамруулан шалгав.

"Эрдэнэт" үйлдвэрийн 1999-2000 оны санхүүгийн баримтад хэсэгчилсэн байдлаар шалгалт хийхэд аж ахуйн гэрээг үйлдвэрийн эрх ашиг, ашиг ажиллагааны төлөө гэхээсээ илүү аж ахуйн нэгж, хувь хүмүүст ашигтай байхаар хийх, мөнгийг илүү шилжүүлэх, "Гэрээт ажил", "Гэрээт ажлын урьдчилгаа" нэрийн дор мөнгөн хөрөнгийг завшуулах боломж олгох, үйлдвэрийн хөрөнгийг бусдад шилжүүлэх зэргээр ашиглан шамшигдуулах, ажлын хөлс, ур дүн гэдэг нэрээр их хэмжээний мөнгөөр өөрсдийгөө шагнах шийдвэр гаргах зэрэг албан тушаалын болон бусад гэмт хэргийн шинжтэй үйлдэл илэрсэн байна.

Төрийн хянан шалгах хороо шалгалтынхаа мөрөөр тодорхой асуудлуудыг хуулийн байгууллагад шалгуулахаар шилжүүлсэн боловч эцэслэн шийдвэрлэгдэхгүй удааширч байна.

Монгол Улсын эдийн засагт стратегийн ач холбогдолтой Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, эдийн засаг, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, техник, технологийн түвшинг сайжруулах, менежментийг боловсронгуй болгох, хамтарсан үйлдвэрийн Зөвлөлийн Монголын талын оролцогчдын бүрэлдэхүүнийг тухайн салбарын мэргэжлийн чиглэлээр бэхжүүлэх нь чухал байна.

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын шалгалтын явцад илэрсэн гэмт хэргийн шинж бүхий асуудлыг хуулийн байгууллагад шилжүүлэхээр тогтсугай.

2.Уулын баяжуулах "Эрдэнэт" хамтарсан үйлдвэрийн талаар дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/үйлдвэрийн эдийн засгийн үр ашиг, санхүүгийн чадавхид хохирол учруулах гэрээ, хэлцэл хийх, үйл ажиллагаа явуулах боломж олгож буй нөхцөл байдлыг таслан зогсоох талаар үйлдвэрийн одоогийн удирдлагаас хийж буй ажлыг эрчимжүүлэх, Монгол Улсын хуульд нийцүүлэн аж ахуйн үйл ажиллагааны оновчтой хэлбэрийг сонгох;

2/зэсийн зах зээлийн өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн үйлдвэрийн хөгжлийн үзэл баримтлалыг тодотгох, техник, технологийн түвшинг сайжруулах, менежментийг боловсронгуй болгох, санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх;

3/хамтарсан үйлдвэрийн Зөвлөлд Монголын талын оролцогчдын бүрэлдэхүүнийг тухайн салбарын мэргэжлийн чиглэлээр чадваржуулах;

4/үйлдвэрийн үйл ажиллагаанаас хүрээлэн байгаа орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг тогтоох, бууруулах, хохирлыг арилгуулах арга хэмжээ авах;

5/Хэлэлцээр, нэмэлт Протоколд Уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийг барьж байгуулах үед Монголын талын авсан үндсэн зээл, түүний хүүгийн өрийг ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон бусад орлогоос тооцох болон Монголын талын дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлж байхаар заасны дагуу уг заалтын биелэлтийг гаргаж, дүгнэлт хийх;

6/Монгол Улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын 1991 оны хэлэлцээрийн хугацаа дуусгавар болох гэж байгаатай холбогдуулан, мөн түүнчлэн "Эрдэнэт" үйлдвэрийн Оросын талын хувь оролцогчийн эрх зүйн байдал өөрчлөгдсөн, уулын баяжуулах "Эрдэнэт" үйлдвэр нь эдийн засгийн шинэ нөхцөл байдалд ажиллаж байгааг харгалзан түс үйлдвэрийн талаархи Хэлэлцээр, нэмэлт Протоколын заалтуудыг нэг бүрчлэн дүгнэж, хамтарсан үйлдвэрийн цаашдын үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох;

7/энэ тогтоолын биелэлтийг 2003 оны эхний хагас жилд багтаан Улсын Их Хуралд танилцуулах.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хороо /Т.Очирхүү/, Хууль зүйн байнгын хороо /Ц.Шаравдорж/ -нд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 17 Улаанбаатар хот

Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхарлыг зогсоох тухай тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

2000 оны Улсын Их Хурлын сонгуулиас хойш улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхрал гарсан гэж үзэх үндэслэл байхгүй тул Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалай, Ж.Наранцацралт нарын өргөн мэдүүлсэн "Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхарлыг зогсоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг төсөл санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 18 Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 02 дугаар дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36.1, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 15.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Захиргааны хариуцлагын тухай, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуулийн "баривчлах" гэсэн ойлолт нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 13-д байгаа "...хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно..." гэсэн заалтыг зөрчөөгүй байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2001 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 48 | Улаанбаатар хот

Супонг Лимтанакулыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс,Тайландын Нэгдсэн Вант Улсын харилцаа,хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Тайландын Нэгдсэн Вант Улсад Монгол Улсыг төлөөлөн Өргөмжит консулаар ажиллаж байсан Супонг Лимтанакулыг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 66 | Улаанбаатар хот

Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв олгосугай.

2. Энэ зарлигийг 2002 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2002 оны 66 дугаар зарлигийн хавсралт

ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧИД

Д/д	Овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Олгох зэрэг дэв
1.	Бэгзийн Очирбат	Монгол Улсын ЕрөнхийлөгчийнТамгын газрын дэд дарга	АА-1	Дэд зэрэг
2.	Далантайн Халиун	Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга	АА-3	Дөтгөөр зэрэг
3.	Самдангийн Цэдэндамба	Ерөнхийлөгчийн Тамгын газрын албаны дарга	АА-3	Гүтгаар зэрэг
4.	Цэрэндоржийн Содномпил	Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Дэд зэрэг
5.	Бөөрөнхийн Мишигжав	Боловсрол,соёл,шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Гүтгаар зэрэг
6.	Намжилын Түмэндэмбэрэл	Санхүү,эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг
7.	Дашзэвэгийн Эрдэнэчулуун	Улсын дээд шүүхийн Тамгын хэлтсийн дарга	АА-1	Дөтгөөр зэрэг
8.	Балчингийн Цэрэндорж	Хууль зүй,дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Дэд зэрэг
9.	Равдангийн Жадамбаа	Нийгмийн хамгаалал,хөдөлмөрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Дэд зэрэг
10.	Пунцагдоржийн Дамдиндорж	Хүнс,хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг
11.	Цэдэнгийн Ёндон	Үйлдвэр,худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Дэд зэрэг
12.	Цэгмидийн Цэнгэл	Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга	ТЗ-13	Гүтгаар зэрэг

13.	Чойжинжавын Сумаахүү	Нийслэлийн Засаг даргын орлогч	ТЗ-13	Дэд зэрэг
14.	Түнжингийн Бадамжунай	Улаанбаатар хотын Ерөнхий менежер,Захирагчийн албаны дарга	ТЗ-13	Дөтгөөр зэрэг
15.	Мөнхдалайн Ринчин	Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын ажлын албаны дарга	ТЗ-12	Дөтгөөр зэрэг
16.	Лувсандандарын Хангай	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга	АА-1	Гутгаар зэрэг
17.	Балдангийн Шатар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга	АА-1	Гутгаар зэрэг
18.	Лувсангийн Ишдорж	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	АА-3	Гутгаар зэрэг
19.	Шилагарьдын Солонго	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	АА-3	Гутгаар зэрэг
20.	Шаравжамцын Бүүвээбаатар	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хэлтсийн дарга	АА-3	Гутгаар зэрэг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 67 **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5,Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1.Монгол Улсаас Малайзын Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чимиддоржийн Агваандамдинг эгүүлэн татсугай.

2.Монгол Улсаас Малайзын Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лувсандоржийн Даваагивийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 10-ны өдөр Дугаар 68 **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5,Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3,Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бруней Даруссалам Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Бадам-Очирын Должинцэрэнг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бруней Даруссалам Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямсүрэнгийн Алиасүрэнг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 69 **Улаанбаатар хот**

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай"хуулийн 51 дүгээр зүйлийн 1дэх хэсгийн 2дугаар заалтыг баримтлан,Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Зарлиг болгох нь:

Түдэвийн Эрдэнэбаатарыг Өвөрхангай аймгийн шүүхийн шүүгчийн,Рэнцэндоржийн Хадчулууныг Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Чойжилсүрэнгийн Чулуунбаатарыг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр Дугаар 70 Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчээр томилох тухай

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль"-ийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай"хуулийн 6дугаар зүйлийн 2,4 дэх заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1.Рэнцэндоржийн Хадчулууныг Өмнөговь аймгийн шүүхийн шүүгчийн,Чойжилсүрэнгийн Чулуунбаатарыг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгчийн,Тудэвийн Эрдэнэбаатарыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1дүгээр шүүхийн шүүгчийн,Дувжирийн Наранцэцэгийг Дундговь аймаг дахь сум дундын 1дүгээр шүүхийн шүүгчийн,Довдонгийн Очмандахыг Дорнод аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн,Хөхөөгийн Санжидмаа Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн,Очирбатын Чулуунцэцэгийг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2.Түдэвийн Эрдэнэбаатарыг Өвөрхангай аймаг дахь сум дундын 1дүгээр шүүхийн ерөнхий шүүгчийн албан тушаалд томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 72 Улаанбаатар хот

Кенжи Мияахараг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс,Япон Улсын эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх,манай улсад холбооны дэвшилтэт технологийг нэвтрүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Япон Улсын иргэн,"Сүмитомо"корпорацийн ерөнхийлөгч Кенжи Мияахараг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 77 Улаанбаатар хот

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1дэх хэсгийн 5,Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3,Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Словак Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Пэрэнлэйн Нямааг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Словак Улсад хавсран суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Шижээхүүгийн Одонбаатарыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас0.75 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 21 (258)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Зэвсэгт хүчний тухай*
- *Өмгөөллийн тухай*
- *Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай*
- *Гэрээнд нэгдэн орох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны зургадугаар сарын 6 №21 (258)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

224. Зэвсэгт хүчний тухай (2002-5-16-ны хууль) 688

225. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 692

226. Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 692

227. Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 693

228. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 693

229. Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 693

230. Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 693

231. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 694

232. Цагдаагийн байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 694

233. Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-5-16-ны хууль) 694

234. Өмгөөллийн тухай (2002-5-16-ны хууль) 696

235. Өмгөөллийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай (2002-5-16-ны хууль) 701

236. Цэрэг, цагдаагийн албан хаагчийг нэгдсэн үндэстний байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай (2002-5-17-ны хууль) 701

237. Галт зэвсгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-5-17-ны хууль) 703

238. Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-5-17-ны хууль) 704

239. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-5-17-ны хууль) 704

240. Гэрээнд нэгдэн орох тухай (2002-5-17-ны хууль) 704

241. Цагдаагийн байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-5-23-ны хууль) 704

242. Нотариатын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2002-5-23-ны хууль) 705

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

243. Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай УИХ-ын 1998 оны 56 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 19 707

244. Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг батлах тухай	Дугаар 20	708
245. "Чингис хаан" одон бий болгох тухай	Дугаар 21	710

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

246. Сумдыг төрийн захиргааны мэрэгшсэн албан хаагчдаар хангах талаар авах зарим арга хэмжээний тухай	Дугаар 32	712
247. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 53	713
248. Ой тэмдэглэх тухай	Дугаар 55	713
249. "Монголд зочлох жил"-ийн бэлтгэл ажлыг хангах тухай	Дугаар 56	713
250. Ёкохамагийн Туннагалалыг хүлээн зөвшөөрөх тухай	Дугаар 57	714

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗӨВСӨГТ ХҮЧНИЙ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын зөвсөгт хүчин, түүний чиг үүрэг, байгуулалтын үндэс, бүтэц, зохион байгуулалт, зөвсөгт хүчинд тавих иргэний хяналт, зөвсөгт хүчний талаархи төрийн байгууллага, албан тушаалтны болон цэргийн мэргэжлийн удирдлагын байгууллагын бүрэн эрхийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Зөвсөгт хүчний тухай хууль тогтоомж

2.1. Зөвсөгт хүчний тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Батлан хамгаалах тухай хууль, Төрийн цэргийн бодлого, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Монгол Улсын зөвсөгт хүчин

3.1. Монгол Улсын зөвсөгт хүчин нь улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоо мөн.

3.2. Зөвсөгт хүчнийг Үндсэн хуулиар тогтоосон төр, нийгмийн байгууллын үндэс, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно.

4 дүгээр зүйл. Зөвсөгт хүчний чиг үүрэг

4.1. Зөвсөгт хүчний үндсэн чиг үүрэг нь эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гадны зөвсөгт халдлага, түрэмгийллээс хамгаалах явдал мөн.

4.2. Зөвсөгт хүчин энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөвсөгт хүчний үндсэн чиг үүргээс гадна тайван цагт дараахь үүрэг хүлээнэ:

4.2.1. эх орноо гадны зөвсөгт халдлага, түрэмгийллээс хамгаалах бэлтгэлийг хангах;

4.2.2. улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх, агаарын хилийн халдашгүй дархан байдалд хяналт тавих;

4.2.3. байгалийн болон нийтийг хамарсан гамшиг, үйлдвэрийн ослын аюул, хөнөөх хэрэгслийн хөнөөлийн голомтод байгаа хүн ам, эд баялагийг авран хамгаалахад болон тогтоосон хорио цээрийн дэглэмийг сахиулахад туслах;

4.2.4. дайчилгааны нөөцийг бүрдүүлэх, хадгалах, сольж шинэчлэх;

4.2.5. дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний сургалтад дэмжлэг үзүүлэх;

4.2.6. улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх;

4.2.7. хүмүүнлэгийн үйл ажиллагаанд туслалцаа, дэмжлэг үзүүлэх;

4.2.8. энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагаанд оролцох;

4.2.9. хуулиар тогтоосон бусад үүрэг гүйцэтгэх.

4.3. Зөвсөгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрөл, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн дагуу зөвсөгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр цэргийн

зарим анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно.

5 дугаар зүйл. Зэвсэгт хүчний байгуулалтын үндэс, зарчим

5.1. Зэсвэгт хүчний байгуулалтын үндэс нь төрийн хууль тогтоомж, Төрийн цэргийн бодлогоор тодорхойлогдоно.

5.2. Зэвсэгт хүчний байгуулалт нь дараахь зарчимд тулгуурлана:

5.2.1. зэвсэгт хүчин нь иргэний хяналтад байх;

5.2.2. зэвсэгт хүчнийг төрөөс удирдах;

5.2.3. зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл нь түүний тайван цагт болон дайны байдлын үед гүйцэтгэх үүрэгт зохицсон байх;

5.2.4. зэвсэгт хүчин үүргээ биелүүлэхэд байнга бэлэн байх;

5.2.5. зэвсэгт хүчний бүх төрлийн хангалтыг төрөөс баталгаажуулах;

5.2.6. зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар болон гэрээгээр сайн дурын үндсэн дээр нөхөн хангах;

5.2.7. цэргийн албан хаагч бүр цэргийн мэргэжилд заавал сурах;

5.2.8. хууль дээдлэх, чанд сахилга, өндөр зохион байгуулалттай байх;

5.2.9. төвлөрүүлэн удирдах, нэгтгэн захирах;

5.2.10. зэвсэгт хүчин нэгдмэл байх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалт, бие бүрэлдэхүүн

6 дугаар зүйл. Зэвсэгт хүчний бүтэц

6.1. Зэвсэгт хүчний бүтцэд тайван цагт ерөнхий зориулалтын цэрэг, дайны байдлын үед ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэрэг багтана. Дайны байдлын үед иргэний ба цэрэгжсэн зарим байгууллагыг бүрэн ба хэсэгчилсэн хэмжээгээр зэвсэгт хүчний бүтцэд оруулж болно.

(Энэ заалтад Монгол Улсын Ерөнхийлөгч 2002 оны 5 дугаар сарын 31-ний өдөр хориг тавьсан тул уг хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж шийдвэрлэтэл хүчин төгөлдөр дагаж мөрдөхгүй болно.)

6.2. Тайван цагт ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэрэг мэргэжлийн бие даасан үйл ажиллагаа явуулна.

6.3. Монгол Улсын нутаг дэвсгэрт цэргийн болон цэрэгжүүлсэн байгууллага хууль бусаар байгуулахыг хориглоно.

7 дугаар зүйл. Зэвсэгт хүчний зохион байгуулалт

7.1. Зэвсэгт хүчин нь зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн цэргийн штабууд, төрөл, мэргэжлийн цэргийн болон ар тал, техникийн нэгттэл, анги, цэргийн сургууль, сургалт-эрдэм шинжилгээ, соёл, урлаг, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, аж ахуй, үйлчилгээний байгууллагатай байна.

7.2. Зэвсэгт хүчний нэгттэл, ангиуд нь тайван цагт бүрэн, хураангуй, нэн хураангуй зохион байгуулалттай байж болно.

7.3. Зэвсэгт хүчний нэгттэл, анги, байгууллагуудын тайван цагийн болон дайны байдлын үеийн орон тоо, зохион байгуулалтыг зэвсэгт хүчний Жанжин штаб тогтооно.

8 дугаар зүйл. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн

8.1. Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн нь цэргийн албан хаагч болон цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагсадаас бүрдэнэ.

8.2. Цэргийн алба хаахтай холбогдсон харилцаа, цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар зохицуулна.

8.3. Цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллагчийн эрх зүйн байдал, хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулна.

9 дүгээр зүйл. Зэвсэгт хүчний нэгттэл, ангийн байршил

9.1. Зэвсэгт хүчний нэгттэл, ангийн байршлыг Засгийн газар тогтооно.

9.2. Зэвсэгт хүчний нэгттэл, анги байгууллагад тэдний хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардагдах газрыг тусгай зориулалтаар олгоно.

9.3. Зэвсэгт хүчний тусгай хэрэгцээний газрыг бусад зориулалтаар ашиглахыг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зэвсэгт хүчний удирдлага

10 дугаар зүйл. Зэвсэгт хүчний удирдлага

10.1. Зэвсэгт хүчний удирдлага нь ерөнхий болон цэргийн мэргэжлийн удирдлагаас бүрдэнэ.

11 дүгээр зүйл. Зэвсэгт хүчний ерөнхий удирдлага

11.1. Зэвсэгт хүчний ерөнхий

удирдлагыг Улсын Их Хурал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Засгийн газар, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж, иргэний хяналт тавина.

11.2. Зэвсэгт хүчинд тавих иргэний хяналт нь төрийн хууль тогтоомжийн биелэлт, зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн удирдлагын үйл ажиллагаа болон төсвийн санхүүжилт, зарцуулалтыг нээлттэй, ил тод хяналт үйл ажиллагаа мөн.

12 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

12.1. Монгол Улсын Их Хурал Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1. зэвсэгт хүчний үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

12.1.2. зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн албан хаагчийн тооны дээд хязгаарыг Засгийн газрын саналыг үндэслэн тогтоох;

12.1.3.онц байдлын үеийн зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлох;

12.1.4. зэвсэгт хүчний анги, салбарыг энхийг сахиулах олон улсын хамтын ажиллагааны оролцуулах шийдвэр гаргах;

12.1.5. цэргийн тангарагийг батлах;

12.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

13 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

13.1. Монгол Улсын Ерөнхийлөгч зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

13.1.1. зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг батлах;

13.1.2. зэвсэгт хүчнийг дайнд ашиглах төлөвлөгөөг баталж, цэргийг байлдааны бэлэн байдлын дээд зэргүүдэд шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргах;

13.1.3. зэвсэгт хүчнийг дайны байдлын үеийн бүтэц, зохион байгуулалтад шилжүүлэх шийдвэр гаргах;

13.1.4. зэвсэгт хүчнийг ашиглах номлолыг батлах;

13.1.5. зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах;

13.1.6. зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох;

13.1.7. улсын хил, онц чухал обьектын хамгаалалтад ерөнхий зориулалтын цэргээр дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах;

13.1.8. зэвсэгт хүчний анги, байгууллагыг аж ахуй, бүтээн байгуулалтын ажилд оролцуулах жүрмыг тогтоох;

13.1.9. хуульд заасан бусад бүрэн эрх.

14 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

14.1. Монгол Улсын Засгийн газар Үндсэн хууль, Засгийн газрын тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

14.1.1. зэвсэгт хүчинд тайван цагт алба хаах цэргийн албан хаагчийн тооны дээд хязгаарыг тогтоох саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

14.1.2. жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, дайчилгааны сургууль, цугларалтад оролцуулах хүний тоо, цэрэг татлага явуулах хугацаат зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн тогтоох;

14.1.3. цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар бүрэн эрхийнхээ хүрээнд бусад улсын Засгийн газартай гэрээ байгуулах;

14.1.4. зэвсэгт хүчнийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах арга хэмжээ авах;

14.1.5. гадаад улсаас авах цэргийн зэвсэг, байдаааны техникийн төрөл, тоог тогтоох, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр санхүүжүүлэх;

14.1.6. хуульд заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

15.1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Батлан хамгаалах тухай хуульд зааснаас гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

15.1.1. зэвсэгт хүчний байгуулалтын нийгэм, эдийн засаг, эрх зүйн үндсийг хангах бодлого боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах;

15.1.2. зэвсэгт хүчнийг бэхжүүлэх саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

15.1.3. ерөнхий зориулалтын цэргийн зэвсэг, техник, материал хэрэгслээр нөхөн хангах ажлыг зохион байгуулах;

15.1.4. ерөнхий зориулалтын цэргийн зэвсэг, техникийг шинэчлэн сайжруулах саналыг Засгийн газарт өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэх;

15.1.5. ерөнхий зориулалтын цэргийн батлагдсан төсвийн ангилал хооронд зохицуулалт хийх;

15.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

16 дугаар зүйл. Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн удирдлага

16.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь улс орныг цэргийн хүчээр батлан хамгаалах зорилго бүхий төрийн цэргийн байгууллагуудыг цэргийн мэргэжлийн нэгдмэл удирдлагаар хангах дээд байгууллага мөн.

16.2. Зэвсэгт хүчний цэргийн мэргэжлийн удирдлагыг зэвсэгт хүчний Жанжин штаб, төрлийн болон төрөл мэргэжлийн цэргийн дарга, штабууд, нэгттэл, ангийн захирагч, штаб, аймаг, нийслэл, сум, дүүргийн цэргийн штабууд тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлнэ.

16.3. Тэйван цагт ерөнхий зориулалтын, хилийн, дотоодын цэргийн харилцан ажиллагааг зэвсэгт хүчний Жанжин штаб, хилийн болон дотоодын цэргийн штабууд хамтран шийдвэрлэж хэрэгжүүлнэ.

17 дугаар зүйл. Зэвсэгт хүчний Жанжин штабын чиг үүрэг

17.1. Зэвсэгт хүчний Жанжин штаб нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.1. цэргийн бодлогыг боловсруулахад оролцож, хэрэгжүүлэх, зэвсэгт хүчнийг цэргийн мэргэжлийн удирдлагаар хангах;

17.1.2. зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах, тэдгээрийг дайнд ашиглах, улсын хил халхлах болон орон нутгийн хамгаалалтын ерөнхий төлөвлөгөөнүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх бэлтгэлийг нь хангах;

17.1.3. цэргийн тагнуулыг зохион байгуулж, төрийн дээд болон зэвсэгт хүчний удирдлагыг олон улсын цэрэг-улс төр, цэрэг-стратегийн мэдээллээр хангах;

17.1.4. ерөнхий зориулалтын цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх;

17.1.5. цэргийн алба, сургалт бэлтгэлийг зохион байгуулж, ерөнхий зориулалтын цэргийн нэгттэл, ангиудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдал, байлдах чадварыг хангах;

17.1.6. ерөнхий зориулалтын цэргийн бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, түүнийг бэхжүүлэх болон тэдгээрийг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах талаар санал боловсруулах;

17.1.7. орон нутгийн хамгаалалтын төлөвлөлт, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх, цэргийн мэргэжлийн удирдлагаар хангах;

17.1.8. ерөнхий зориулалтын цэргийн анги, салбарыг хил хамгаалах болон иргэний хамгаалалтын чиглэлээр томилон сургаж, ашиглах;

17.1.9. хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх журам тогтоож, биелэлтийг хянах;

17.1.10. цэрэг татах, халах ажлыг зохион байгуулах;

17.1.11. хууль тогтоомжийн хүрээнд төрийн ба байгууллагын нууцын хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах;

17.1.12. цэргийн шинжлэх ухааны судалгаа, шинжилгээний ажлыг зохион байгуулах, цэргийн урлагийг хөгжүүлэх;

17.1.13. цэргийн дайчилгааны даалгаврыг боловсруулж, биелэлтийг нь хангуулах арга хэмжээг зохион байгуулах;

17.1.14. ерөнхий зориулалтын цэргийн зэвсэг, техник, бусад материал хэрэгслээр хангах асуудлыг боловсруулж, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад оруулах, гаргасан шийдвэрийн хэрэжилтийг зохион байгуулах;

17.1.15. цэргийн төлөвлөгөөт сургууль, дайчилгааны цугларалтайн үед Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу өмчийн хэлбэр харгалзахгүйгээр тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийг нөхөх олговортойгоор дайчлах ажлыг зохион байгуулах;

17.1.16. зэвсэгт хүчний бэлэн байдал, байлдах чадварт хамаарах асуудлаар Монгол Улсын хууль, бусад эрх зүйн актын төсөлд санал өгөх.

17.2. Зэвсэгт хүчний Жанжин штабын бусад эрх, зэвсэгт хүчний бүтцэд байгаа төрөл, мэргэжлийн цэргийн удирдлагатай харилцах хэм хэмжээг зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмээр тогтооно.

18 дугаар зүйл. Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын бүрэн эрх

18.1. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нь цэргийн мэргэжлийн удирдлагын дээд байгууллагыг удирдаж, зэвсэгт хүчний ерөнхий командлагч, батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлага дор ажиллана.

18.2. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.2.1. батлан хамгаалах бодлогыг боловсруулахад оролцон, цэргийн бодлогын хэрэжилтийг зохион байгуулах;

18.2.2. зэвсэгт хүчнийг ашиглах номлолыг батлуулахаар зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

18.2.3. ерөнхий зориулалтын цэргэтэй холбоотой асуудлаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд илтгэл оруулах, зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

18.2.4. цэргийн тагнуулын байгууллагын дүрмийг Тагнуулын ерөнхий газрын даргатай хамтарсан тушаалаар батлах;

18.2.5. ерөнхий зориулалтын цэргийн боловсон хүчнийг томилох, чөлөөлөх;

18.2.6. цэргийн бэлтгэл албаны офицер, ахлагч нарыг цэргийн жинхэнэ албанд татах;

18.2.7. ерөнхий зориулалтын цэргийн бие бүрэлдэхүүн, зэвсэг, техник, материал хэрэгслээр нөхөн хангах ажлыг удирдан зохион байгуулах;

18.2.8. зэвсэгт хүчний Жанжин штабын чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар цэргийн удирдах байгууллагууд, төрөл, мэргэжлийн цэргийн дарга, аймаг, нийслэлийн цэргийн штабуудад тушаал, үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

18.2.9. албаа үлгэр жишээчээр хааж, цэргийн зохих мэргэжил эзэмшсэн байлдагч, түрүүчийг цэргийн албаны хугацаа дуусахаас гурав хүртэл сарын өмнө халах;

18.2.10. ерөнхий зориулалтын цэргийн төсөв, хөрөнгийг захиран зарцуулах.

18.3. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

18.4. Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нь төрийн тусгай албан хаагч байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

19 дүгээр зүйл. Зэвсэгт хүчний санхүүжилт

19.1. Зэвсэгт хүчнийг улсын төсөөс санхүүжүүлнэ.

20.1. Зэвсэгт хүчний тухай хууль тогтоомж зөрчигчид Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

20 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 4, 5, 6 дахь хэсгийн дугаарыг 3, 4, 5 гэж, 21 дүгээр зүйлийн 4, 7 дахь хэсгийн "Ерөнхий штаб" гэснийг "Жанжин штаб" гэж, 25 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "зориулалт" гэснийг "чиг үүрэг" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын "Ерөнхий штабын" гэснийг "Жанжин штабын" гэж, 33 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Аюулгүй байдлыг хангах", 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв" гэснийг "Тагнуулын" гэж, 38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтын "улсын" гэснийг "үндэсний" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн албаны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6 дахь заалтыг "6/ дэд сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Ерөнхий сайдын зөвлөх, хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газрын тохируулагч агентлагийн дарга;" гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвсөгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "улсын аюулгүй байдлыг хангах байгууллагын" гэснийг "Тагнуулын байгууллагын" гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн "Цэргийн номлол" гэснийг "Төрийн цэргийн бодлогын үндэс" гэж, мөн зүйлийн 8 дахь хэсгийн "ерөнхий штабын" гэснийг "Жанжин штабын" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвсөгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дайчилгааны тухай хуулийн 7.1, 8.3, 9.4 дэх хэсэг, 12.1.1, 12.2.2, 18.1.1 дэх заалт, 31.1, 32.1, 32.4, 32.6, 32.7 дахь хэсгийн "ерөнхий штаб" гэснийг тохиолдол бүрт нийцүүлэн "Жанжин штаб" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвсөгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дайны байдлын тухай хуулийн 9.1, 19.4 дэх хэсэг, 11 дүгээр зүйл, 20 дугаар зүйлийн гарчиг, 20.1, 20.2, 24.2, 24.3, 24.6 дахь хэсгийн "ерөнхий штаб" гэснийг тохиолдол бүрт нийцүүлэн "Жанжин штаб" гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зөвсөгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "ерөнхий штабын" гэснийг "Жанжин штабын" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн "ерөнхий штаб" гэснийг "Жанжин штаб" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Зэвсэгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот

БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Батлан хамгаалах тухай хуулийн 3, 9, 12 дугаар зүйлд дор дурдсан хэсэг, заалт нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Батлан хамгаалах цэргийн хүч хэрэгсэл нь зэвсэгт хүчин байна. Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна."

2/ 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн - улс төрийн албан тушаалтан нь цэргийн жинхэнэ албанаас ангид байна."

3/ 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Засаг дарга дараахь үүрэг хүлээнэ:"

4/ 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7/ орон нутгийн хамгаалалтын төлөвлөлт, түүний хэрэгжилтийн үйл ажиллагааг зэвсэгт хүчний Жанжин штабын оролцоотойгоор зохион байгуулах."

2 дугаар зүйл. Батлан хамгаалах тухай хуулийн 1 дүгээр зүйл, 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4; 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 7, 8; 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг; 10 дугаар зүйл; 11 дүгээр зүйлийн 2; 12 дугаар зүйлийн 2, 6 дахь заалтыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 1 дүгээр зүйл:

"1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог тогтоож, төрийн байгуллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгуллага, иргэдийн эх орноо батлан хамгаалах талаар хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино."

2/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Батлан хамгаалах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс

төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн нэгдмэл арга хэмжээ мөн. Батлан хамгаалах нэгдмэл тогтолцооны үндэс нь орон нутгийн хамгаалалт мөн."

3/ 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Монгол Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоох;

2/ дайны аюулыг сэрэмжлэх, бусад улс оронтой маргаантай асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх;

3/ Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын үндсийг тодорхойлох;

4/ цэргийн албан хаагчийн нийгмийн хамгаалалт, эрх зүйн баталгааны үндсийг тодорхойлох;

5/ батлан хамгаалах хамтын ажиллагааны талаархи Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах;

6/ улс орныг батлан хамгаалах арга хэмжээний төсвийг батлах, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох;

7/ цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг албаны онцлогт нь тохируулж тогтоох;

8/ цэргийн дээд цол бий болгох;

9/ гадаадын цэргийн хүчинийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх болон өөрийн цэргийн анги, салбарыг олон улсын энхийг сахиулах болон хүмүүнлэгийн ажиллагаанд оролцуулах асуудлыг шийдвэрлэх."

4/ 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 3, 4 дэх заалт:

"1/ Монгол Улсын Төрийн цэргийн бодлогын хэрэгжилт, улс орныг батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих;

3/ цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах;

4/ цэргийн албан хаагчид цэргийн цол олгох журмыг тогтоох;"

5/ 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 7, 8 дахь заалт:

"1/ улс орныг батлан хамгаалах болон орон нутгийн хамгаалалтын асуудлаар төрийн захиргааны байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;"

7/ иргэдийг эх оронч үзлээр хүмүүжүүлэхэд төрийн бүх шатны болон төрийн бус байгууллагын үйл ажиллагааг нэгтгэн чиглүүлэх, цэрэг иргэний харилцаат төлөвшүүлэх;

8/ иргэдээс цэргийн үүргээ биелүүлэх хүсэл сонирхол, эрмэлзлийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх."

6/ 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ батлан хамгаалах бодлогыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2/ батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

3/ цэргийн нийтлэг дүрмүүдийг батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барих;

4/ шинжлэх ухаан, технологийн дэвшлийг хангах, зэвсэгт хүчнийг зэвсэг, техникээр нөхөн хангах, шинэчлэн сайжруулах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, здгээртэй холбогдсон төсвийг захиран зарцуулах;

5/ батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах;

6/ батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Засгийн газарт оруулах, батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавих;

7/ батлан хамгаалах улсын байцаагчийг томилох, чөлөөлөх;

8/ батлан хамгаалах хууль тогтоомж, батлан хамгаалах асуудлаарх Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, биелэлтийг хангах талаар үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлэх;

9/ батлан хамгаалах салбарын төрийн өмчит хуулийн этгээдийн үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийг данснаас хасах, устгах, шилжүүлэх, шинээр авах асуудлыг шийдвэрлэх, захиалгыг хянаж батлах;

10/ батлан хамгаалах салбарын төрийн өмчит хуулийн этгээд, эд хөрөнгийг хувьчлах саналаа Засгийн газарт оруулах.

7/ 10 дугаар зүйл:

"10 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ батлан хамгаалах бодлого, улсын дайчилгааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2/ зэвсэгт хүчнийг зэвсэг, техник, материал хэрэгслээр хангах санал боловсруулах, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх;

3/ батлан хамгаалах салбарын боловсон хүчнийг сургаж бэлтгэх, цэргийн албан хаагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

4/ батлан хамгаалах салбарт техник, технологийн дэвшлийг хангаж, зэвсэг, техникийг шинэчлэн сайжруулах бодлого боловсруулах, энэ талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

5/ батлан хамгаалах салбарт судалгаа шинжилгээний ажил явуулах бодлогыг тодорхойлж, хэрэгжилтийг зохион байгуулах;

6/улсыг батлан хамгаалах арга хэмжээний төлөвлөлтөд шаардагдах мэдээ, судалгааны нэр төрлийг тогтоож, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас гаргуулж авах;

7/ хугацаат цэргийн албаа хаах иргэний тоо, цэрэг татлага явуулах ээлж, хугацаат тогтоох санал бэлтгэж Засгийн газарт оруулах;

8/ гэрээт цэргийн албаа хаах мэргэжил, тооны дээд хязгаарыг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран жил бүр тогтоох."

8/ 11 дүгээр зүйлийн 2 дахь заалт:

"2/ зэвсэгт хүчний дайчилгааны болон иргэний хамгаалалтын даалгаврыг биелүүлэх."

9/ 12 дугаар зүйлийн 2, 6 дахь заалт:

"2/ цэргийн тоо бүртгэлийг хөтлөх, цэрэг татах, цэргийн албанд гэрээгээр элсүүлэх, дүйцүүлэн хаалгах, дайчилгааны бэлтгэл нөөцийг бэлтгэх, давтан бэлтгэх ажлыг зохион байгуулах;

6/ нутаг дэвсгэртээ байрлаж байгаа цэргийн анги, байгууллага, бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцлийг хангах асуудлаар харилцан ажиллах, байгаль орчныг хамгаалах болон холбогдох бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;"

3 дугаар зүйл. Батлан хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дугаарыг "5" гэж, тавдугаар бүлгийн дугаарыг "дөрөвдүгээр" гэж, 25 дугаар зүйлийн дугаарыг "15" гэж, 26 дугаар зүйлийн дугаарыг "16" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Батлан хамгаалах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах," гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Батлан хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9, 10, 11, 4 дүгээр бүлгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлийн байгууллагын бүтэц, чиг үүргийг тогтоох, өмгөөлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх баталгаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Өмгөөллийн тухай хууль тогтоомж

2.1. Өмгөөллийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль, өмгөөлүүлэх эрхийг хангахтай холбогдсон хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагааны зарчим

3.1. Өмгөөллийн үйл ажиллагааг дараахь зарчим баримтална:

3.1.1. хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах, хууль дээдлэх;

3.1.2. өмгөөлөгчөө чөлөөтэй сонгох;

3.1.3. өмгөөллийн үйл ажиллагаа төрийн ивээлд байх, аливаа байгууллага, албан тушаалтан өмгөөлөгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс үл оролцох;

[1] Монгол Улсын Үндсэн хууль – "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн.

3.1.4. өмгөөлөгч нь хуулийн хүрээнд өмгөөлүүлэгчийнхээ эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн, туушатай хамгаалах.

4 дүгээр зүйл.Өмгөөллийн үйл ажиллагааны төрөл

4.1. Өмгөөлөгч нь өмгөөллийн үйл ажиллагаог дараахь хэлбэрээр явуулна:

4.1.1. эрх зүйн асуудлаар амаар болон бичгээр лавлагаа, зөвлөгөө өгөх;

4.1.2. эрх зүйн ач холбогдол бүхий баримт бичгийн эх зохиож туслах;

4.1.3. иргэний хэрэг, захиргааны зөрчлийн хэргийг эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэхэд үйлчлүүлэгч эттэздийг төлөөлөх;

4.1.4. хэрэг бүртээх, мөрдөн байцаах ажиллагаа болон эрүүгийн хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд өмгөөлөгчөөр оролцох;

4.1.5. иргэд, байгууллагын хүсэлтээр хууль тогтоомжид заасан хууль зүйн туслалцаа үзүүлэх;

4.1.6. хууль тогтоомжоор хориглоогүй эрх зүйн бусад туслалцаа үзүүлэх.

4.2.Өмгөөлөгч нь олон улсын шүүхийн байгууллага, бусад байгууллагад үйлчлүүлэгчийн сонирхлыг төлөөлж болно.

5 дугаар зүйл. Өмгөөлөгч

5.1. Хууль зүйн дээд боловсролтой, ял шийтгэлгүй, тогтоосон журмын дагуу мэргэшлийн шалгаруулалтад орж, өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан иргэнийг өмгөөлөгч гэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Өмгөөллийн байгууллагын удирдлага, зохион байгуулалт

6 дугаар зүйл. Монголын өмгөөлөгчдийн холбоо

6.1.Монголын өмгөөлөгчдийн холбоо / цаашид "Холбоо" гэх/ нь өмгөөлөгчдийг эгнээндээ нэгтгэсэн, тэдний эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус, мэргэжлийн байгууллага байна.

7 дугаар зүйл.Холбооны удирдлага, зохион байгуулалтын бүтэц

7.1. Холбооны эрх барих дээд байгууллага нь Холбооны Их хурал /цаашид "Их хурал" гэх/ байна.

7.2. Их хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

7.2.1. Холбооны дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

7.2.2. Холбооны Ерөнхийлөгч /цаашид "Ерөнхийлөгч" гэх/-ийг сонгох, чөлөөлөх;

7.2.3. Холбооны Удирдах зөвлөл /цаашид "Удирдах зөвлөл" гэх/-ийн гишүүнийг сонгох, чөлөөлөх;

7.2.4.Холбооны Хянан шалгагчдын зөвлөл /цаашид "Хянан шалгагчдын зөвлөл" гэх/ -ийн бүрэлдэхүүн, дүрмийг батлах;

7.2.5.өмгөөлөгчийн ёс зүйн дүрмийг батлах;

7.2.6.өмгөөлөгчийн Сахилгын хороо /цаашид "Сахилгын хороо" гэх/ -г байгуулж, дүрмийг батлах;

7.2.7. Холбооны төсөв, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах;

7.2.8. Ерөнхийлөгч, түүний ажлын албаны орон тоо, цалингийн хэмжээг тогтоох.

7.3. Их хурлыг гурван жилд нэг удаа Удирдах зөвлөл зарлан хуралдуулна.

7.4. Их хурал нийт өмгөөлөгчдийн төлөөлөгчдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болно.

7.5.Их хурал асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, хэлэлцсэн асуудлаараа тогтоол гаргана.

7.6. Их хурлын хуралдааны дэгийг Их хурал тогтооно.

7.7. Их хурлын чөлөөт цагт Холбооны удирдах байгууллага нь есөн гишүүнээс бүрдсэн Удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөлийн эрх хэмжээг Холбооны дүрмээр тогтооно.

7.8. Холбооны өдөр тутмын үйл ажиллагаог Ерөнхийлөгч удирдан зохион байгуулна.

7.9. Ерөнхийлөгчийн эрх хэмжээг Холбооны дүрмээр зохицуулна.

8 дугаар зүйл. Сахилгын хороо

8.1. Өмгөөлөгчийн сахилга, ёс зүйн байдалд дүгнэлт өгөх, сахилгын шийтгэл ногдуулах эрх бүхий Сахилгын хороо Холбооны дэргэд ажиллана.

8.2. Сахилгын хороо таван гишүүнтэй байна.

9 дүгээр зүйл. Хянан шалгагчдын зөвлөл

9.1. Хянан шалгагчдын зөвлөл нь Холбооны зөрөнгийн хуримтлал, зарцуулалт, санхүүгийн үйл ажиллагаа болон Холбоонд ирсэн албан бичиг, өргөдөл, санал, гомдлын шийдвэрлэлтийн байдалд хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлнэ.

9.2. Хянан шалгагчдын зөвлөл нь гурван гишүүнтэй байна.

9.3. Холбооны санхүүгийн асуудал хариуцсан ажилтан Хянан шалгагчдын зөвлөлд орж болохгүй.

10 дугаар зүйл. Холбооны аймаг, нийслэлийн салбар зөвлөл

10.1. Холбооны аймаг, нийслэлийн салбар зөвлөл өмгөөлөгчийн бие даасан, хараат бус байдлын хүрээнд өмгөөллийн үйл ажиллагаат нутаг дэвсгэртээ зохион байгуулах ажлыг эрхлэнэ.

10.2.Энэ хуулийн 10.1 дэх хэсгийн заалт өмгөөлөгчид хамтран өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх бие даасан хуулийн этгээд байгуулан ажиллахад үл хамаарна.

11 дүгээр зүйл. Өмгөөллийн байгууллагын бэлгэ тэмдэг

11.1. Холбоо өөрийн бэлгэ тэмдэгтэй байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Өмгөөллийн үйл ажиллагаа

12 дугаар зүйл. Өмгөөлөгчийн бүрэн эрх

12.1. Эрүү, иргэн, захиргааны хэрэг, зөрчлийг эрх бүхий байгууллага хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийг холбогдох хуулиар тогтооно.

12.2. Өмгөөлөгч нь өмгөөлөл, төлөөллийн үйл ажиллагаа гүйцэтгэхдээ дараахь эрх эдэлнэ:

12.2.1. хууль зүйн туслалцаа хүсэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг аль ч байгууллагад төлөөлөх;

12.2.2. өмгөөлж байгаа сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хориглолтой тэдгээрийн байгаа газарт чөлөөтэй нэвтрэн орж, ганцаарчлан уулзах;

12.2.3. эрүү, иргэний хэргийн нотлох бариманттай танилцах, тэмдэглэл хийх, шаардлагатай материалыг өөрийн зардлаар хувилж хуулбарлан авах;

12.2.4. нотлох баримт гаргаж өгөх, шинэ нотлох баримт шаардах буюу хэрэгт ач холбогдол бүхий бусад байдлыг шалгуулах, шинжээчийн дүгнэлт гаргуулах санал хүсэлт тавих;

12.2.5. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, орчуулагч, хэлмэрч, шинжээч, шүүгч, иргэдийн төлөөлөгч, шүүх хурлын нарийн бичгийн даргыг хуульд заасан үндэслэл байвал татгалзан гаргах тухай хүсэлт гаргах;

12.2.6. хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүхийн үйл ажиллагаа, шийдвэрт гомдол гаргах;

12.2.7. хууль зүйн туслалцаа үзүүлэхэд шаардлагатай баримт бичгийг байгуулагаа, аж ахуйн нэгжээс гаргуулан авахаар хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгчид хүсэлт гаргах, баримт сэлтийг бэхжүүлэх зорилгоор дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглах;

12.2.8. тусгай мэдлэг шаардагдах асуудлаар мэргэжлийн байгууллага, хүмүүсээс зөвлөгөө авах;

12.2.9. хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд байлцаж, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, түүнчлэн нэхэмжлэгч, харицуагч болон бусад оролцогчид асуулт тавих, үйлчлүүлэгчийнхээ гаргаж байгаа мэдүүлэг, тодорхойлолтод тайлбар хийх;

12.2.10. өөрийн байлцсан хэрэг бүртгэх, мөрдөн байцаах болон хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлтэй танилцаж санал хүсэлтээ бичгээр гаргах;

12.2.11. давж заалдах болон хяналтын шатны шүүх хуралдаанд өөрийн санаачилгаар буюу шүүгдэгчийн хүсэлтээр оролцож санал, дүгнэлт гаргах;

12.2.12. хууль тогтоомжид заасан бусад эрх.

12.3. Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ дараахь үүрэг хүлээнэ:

12.3.1. Үндэсэн хууль, бусад хууль тогтоомж болон өмгөөлөгч, хуульчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахих;

12.3.2. үйлчлүүлж байгаа этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хуульд үл харшлах бүх арга, хэрэгслийг ашиглан бүрэн, туушгай хамгаалах;

12.3.3. өмгөөллийн үүрэг гүйцэтгэх явцад олж мэдсэн төр, байгуллага, хувь хүн болон үйлчлүүлэгчийн нууцыг задруулахгүй байх;

12.3.4. эрүүгийн хэрэгт өмгөөллийн үүрэг гүйцэтгэх явцад үйлчлүүлэгчээс дахин гэмт хэрэг үйлдэх тухай мэдсэн тохиолдолд энэ тухай цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

12.3.5. үйлчлүүлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх;

12.3.6. үйлчлүүлэгчийн гэм буруу нотлогдсон, эсхүл нотлогдохгүй байгаа талаар нийтэд мэдээлэхгүй байх;

12.3.7. Холбоо, харьяалагдах аймаг, нийслэлийн салбар зөвлөлийн гишүүн байх;

12.3.8. өмгөөлөгч жилд хоёр удаа төлбөрийн чадваргүй иргэнийг өмгөөлөх;

12.3.9. өмгөөлөх байгууллагаас өгсөн томилолтыг биелүүлэх.

12.4. Өмгөөлөгч нь үйлчлүүлэгчийн эд хөрөнгө буюу эрхийг өөрийн болон бусад этгээдийн нэрээр худалдан авах, эсхүл өөр бусад аргаар олж авах, иззэмшихийг хоригдоно.

12.5. Өмгөөлөгч нь аливаа зүйлийг үйлчлүүлэгч болон бусдад дамжуулан өгөх, зуучлахыг хоригдоно.

13 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх

13.1. Хууль зүйн туслалцаа хүсэгч нь өмгөөлөгчид шууд хандаж хэлцэл хийх буюу Холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөлд хүсэлт гаргана. Холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөл нь мэргэжлийн өмгөөлөгчдийн нэр, хаягийн лавлагаа өгөх үүрэгтэй.

13.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэхэд туслахыг хүссэн тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон шүүх, прокурорын байгууллага нь мэргэжлийн өмгөөлөгчдийн болон өмгөөлөл эрхэлдэг байгууллагын нэр, хаягийн лавлагаа өгөх үүрэгтэй.

13.3. Хууль зүйн туслалцаа хүсэгч нь эрүүл мэнд, төлбөрийн чадвар болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөлүүлэх эрхээ өөрөө хэрэгжүүлэх боломжгүй, түүнчлэн өмгөөлөгчөө сонгон авч чадаагүй тохиолдолд хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах болон шүүх, прокурорын байгууллага энэ тухай Холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөлд мэдэгдэн өмгөөлөгч томилуулах арга хэмжээ авах үүрэгтэй.

13.4.Энэ хуулийн 13.3-д заасан тохиолдолд томилогдох өмгөөлөгчийн ажиллах хуваарийг Холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөл гаргасан байх үүрэгтэй.

13.5.Энэ хуулийн 13.2, 13.3-д заасан тохиолдолд өмгөөлөгчөө сонгохоо нь тодорхой хүний нэр зааж, тулгаж болохгүй.

14 дүгээр зүйл. Өмгөөллийн нууц

14.1. Өмгөөлөгчөөс өөрийн үйлчлүүлэгчид үзүүлж байгаа эрх зүйн туслалцаатай холбоотой бүхий л мэдээлэл өмгөөллийн нууцад хамаарна.

14.2. Аливаа этгээдээс өмгөөлөгчид эрх зүйн туслалцаа хүсч хандсан болон үйлчлүүлэгчид эрх зүйн туслалцаа үзүүлэх явцад олж мэдсэн зүйлтэй нь холбогдуулан өмгөөлөгчийг гэрчээр болон бусад байдлаар байцаах, нэхцэл байдлыг тодруулах зорилгоор асуухыг хоригдоно.

14.3. Өмгөөлөгч өмгөөллийн нууцыг задлах, эсхүл амин хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд ашиглахыг хоригдоно.

14.4. Өмгөөллийн нууцыг хугацаагүй хадгална.

14.5. Хуульд зааснаас бусад тохиолдолд өмгөөлөгчийн яриаг чагнах, албан байранд өмгөөллийн үйл ажиллагаатай нь холбогдуулан үзэлгэ, нэгжлэг хийх, өмгөөллийн үйл ажиллагаатай холбоотой материал, баримт бичгийг гаргуулан авахыг хоригдоно.

14.6. Өмгөөллийн нууцыг мэдэх болсон өмгөөллийн байгууллагын бусад ажилтан уг нууцыг хадгалах үүргийг мөн хүлээнэ.

14.7. Өмгөөллийн нууцыг хуулиар хамгаална.

15 дугаар зүйл. Өмгөөлөгчийн үйл ажиллагааны баталгаа

15.1. Өмгөөлөгч мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулахад нь түүнд хэн ч шахалт, дарамт үзүүлэх буюу хөндлөнгөөс оролцох, саад учруулах, ямар нэг баталгаа шаардах, заналхийлэхийг хоригдоно.

15.2. Өмгөөлөгч мэргэжлийн үүргээ биелүүлэхэд зайлшгүй шаардлагатай баримт бичиг, мэдээ сэлтийг гаргуулан авахын тулд шүүх, прокурор, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах байгууллага, бусад байгууллага, түүний холбогдох албан тушаалтанд хүсэлт гаргах эрхтэй.

15.3. Энэ хуулийн 15.2–т заасны дагуу хүсэлт гаргасан тохиолдолд эдгээр байгууллага, түүний албан тушаалтан өмгөөлөгчийн хүсэлтийг биелүүлэх арга хэмжээ авах үүрэгтэй.

15.4. Өмгөөлөгчийн давтан сургалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

15.5. Төр, захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллага Холбоо, түүний аймаг, нийслэлийн салбар зөвлөлөөс үйл ажиллагаага явуулахад нь шаардлагатай дэмжлэг туслалцаа үзүүлнэ.

15.6. Өмгөөлөгч Холбоогоор уламжлуулан хүсэлт гаргасан тохиолдолд шаардлагатай гэж үзвэл цагдаагийн байгууллага өмгөөлөгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эд хөрөнгөд хамгаалалтын арга хэмжээ авч болно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, түүнийг хүчингүй болгох

16 дугаар зүйл. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

16.1. Өмгөөллийн үйл ажиллагааг эмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ - ийн үндсэн дээр эрхэлнэ.

16.2. Хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад орж тэнцсэн хуульч тусгай зөвшөөрөл авахаар мэргэшлийн шалгалт өгөх эрхтэй.

16.3. Шүүгч, прокурор, мөрдөн байцаагч, хэрэг бүртгэгч ажлаасаа чөлөөлөгдсөнөөс хойш гурван жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хоригдоно.

16.4. Монгол хэл мэддэг харьяалалгүй хүн, гадаадын иргэн хуульч Монгол Улсын нутаг дэвсгэрт өмгөөллийн үйл ажиллагаа явуулахыг хүсвэл мэргэшлийн шалгалт өгсний үндэсэн дээр тусгай зөвшөөрөл авна.

16.5. Өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хугацаагүй олгоно.

17 дугаар зүйл. Мэргэшлийн хороо

17.1. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон мэргэшлийн шалгаруулалт явуулах Мэргэшлийн хороо /цаашид "Мэргэшлийн хороо" гэх/ хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байна.

17.2. Мэргэшлийн хороо есөн гишүүнтэй байна.

17.3. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнийг шүүх, прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг, Холбооноос зургаан хүний төлөөлөлтэйгөөр, тэдгээр байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Мэргэшлийн хорооны гишүүн нь эрдмийн зэрэг, цолтой байна.

17.4. Мэргэшлийн хорооны даргыг уг хорооны гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

17.5. Мэргэшлийн шалгаруулалтад тэнцсэн хуульчид тусгай зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

17.6. Мэргэшлийн шалгаруулалт явуулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

18 дугаар зүйл. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

18.1. Энэ хуулийн 12.3-т заасан өмгөөлөгчийн үүрэг, тусгай зөвшөөрлийн шаардлага, нөхцөлийг зөрчсөн тохиолдолд Сахилгын хорооны саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болно.

18.2. Өмгөөлөгч эрүүгийн хариуцлагад татагдсан тохиолдолд эрх бүхий байгууллага эцсийн шийдвэр гаргах хүртэл эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

18.3. Өмгөөлөгч эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүй болсон тохиолдолд өөрийнх нь хүсэлт болон Холбооны санаачилгаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

18.4.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн нөхцөл арилсан тохиолдолд уул зөвшөөрлийг сэргээнэ.

19 дүгээр зүйл. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох

19.1. Дараахь тохиолдолд тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

19.1.1. тусгай зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;

19.1.2. тусгай зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн;

19.1.3. өмгөөлөгчийн үүрэг, ёс зүй, тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа зөрчсөн;

19.1.4. тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

19.1.5. өмгөөлөгч гэмт хэрэг үйлдсэн тухай шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

19.2. Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох асуудлыг Сахилгын хорооны саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

20 дугаар зүйл. Өмгөөллийн үйлчилгээний хөлс

20.1. Өмгөөлөгч өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхдээ үйлчлүүлэгчээс өмгөөллийн үйлчилгээний хөлс авна.

20.2. Өмгөөллийн үйлчилгээний хөлсний хэмжээг өмгөөлөгч, үйлчлүүлэгч гэрээгээр харилцан тохиролцож тогтоно.

20.3. Өмгөөлөгч үйлчлүүлэгчийн эд хөрөнгийн болон бусад байдлыг нь харгалзан үзэж түүнийг өмгөөллийн үйлчилгээний хөлс төлөхөөс чөлөөлж болно.

21 дүгээр зүйл. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардал

21.1. Төлбөрийн чадваргүй иргэний өмгөөллийн зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ. Энэхүү санхүүжилтийг Холбоонд олгох бөгөөд уг зардлыг санхүүжүүлэх, тайлан тооцоо гаргах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлэж, хэрэгжилтэд нь хяналт тавина.

22 дугаар зүйл. Өмгөөлөгчийн хариуцлагын даатгал

22.1. Мэргэжлийн мэдлэг, ур чадвар дутсаны улмаас өмгөөллийн үйл ажиллагаанд алдаа гаргаж үйлчлүүлэгчид хохирол учруулсан тохиолдолд түүнийг нөхөн төлөх зорилгоор өмгөөлөгч харуулцлын даатгалд даатгуулна.

22.2. Өмгөөлөгч нь хариуцлагын даатгалд даатгуулах даатгалын байгууллагаа өөрөө сонгоно.

22.3. Хариуцлагын даатгалын хураамжийн хэмжээг өмгөөлөгч, даатгалын байгууллага харилцан тохиролцож тогтооно.

22.4. Өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын доод хэмжээг Холбоо тогтооно.

22.5. Өмгөөллийн үйл ажиллагаа явуулах мэргэшлийн шалгаруулалтад тэнцсэн хуульч нь өмгөөлөгчийн хариуцлагын даатгалын гэрчилгээний хүвийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгсөний үндсэн дээр тусгай зөвшөөрөл авна.

23 дугаар зүйл. Өмгөөлөгчийн хариуцлага

23.1. Хууль тогтоомж, өмгөөлөгчийн болон хуульчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн өмгөөлөгчид сахилгын дараахь шийтгэл ногдуулна:

23.1.1. сануулах;

23.1.2. тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах тухай асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд тавих.

23.2. Өмгөөлөгч Сахилгын хорооны шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд гаргаж болно.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

24.1. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Улаанбаатар хот**

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 12 дугаар сарын 9-ний өдөр батлагдсан Өмгөөллийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр батална.

тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр **Улаанбаатар хот**

ЦЭРЭГ, ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧИЙГ НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭНХИЙГ САХИУЛАХ БОЛОН ОЛОН УЛСЫН БУСАД АЖИЛЛАГААНД ОРОЛЦУУЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын цэрэг, цагдаагийн албан хаагч, цэрэг, цагдаагийн багийг Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид "НҮБ" гэх/-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулахтай холбогдсон харилцаог зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль тогтоомж

2.1. Цэрэг, цагдаагийн албан хаагчийг НҮБ-ын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

[1] Монгол Улсын Үндсэн хууль-"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 1 дүгээрт нийтлэгдсэн

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг баримтална.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1.Энэ хуульд хэрэглэсэн нэр томъёог дараахь утгаар ойлгоно:

3.1.1."НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаа" гэж НҮБ-ын мандатын дор олон улсын энх тайван, тогтвортой байдлыг сахин хамгаалах, бэхжүүлэх зорилгоор энхийг сахиулах байгууллагын бие бүрэлдэхүүнийг;

3.1.2. "олон улсын бусад ажиллагаа" гэж олон улсын холбогдох байгууллага, аливаа улсын санаачлагаар зохион байгуулж байгаа энхийг сахиулах төрөл бүрийн сургалт, дадлага, цэргийн хээрийн сургууль; гамшиг, ослын хор уршгийг арилгах, авран хамгаалах болон хүмүүнлэгийн олон улсын үйл ажиллагаа;

3.1.3. "НҮБ-ын энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцох" гэж цэрэг, цагдаагийн албан хаагч сайн дурын үндсэн дээр томилогдон хилийн чанадад үүрэг гүйцэтгэхийг;

3.1.4. "цэрэг, цагдаагийн баг" гэж энхийг сахиулах болон олон улсын тухайн ажиллагаанд оролцохоор томилогдсон, зохих агсамж, нормт хангалтын зүйлс, техник хэрэгсэл бүхий цэрэг, цагдаагийн байгууллагын бие бүрэлдэхүүнийг;

3.1.5. "энхийг сахиулагч" гэж энхийг сахиулах ажиллагаанд оролцож байгаа Монгол Улсын цэрэг, цагдаагийн албан хаагчийг;

3.1.6. "агсамж" гэж цэрэг, цагдаагийн албан хаагчийн нэг бүрийн иж бүрэн хувцас, хэрэглэл, эвэсэгглэлийг;

3.1.7. "нормт хангалтын зүйлс" гэж цэрэг, цагдаагийн албан хаагч нэг бүрд тогтоосон хүнс, эм, ороох, боох материал, бусад зүйлийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Удирдлага, зохион байгуулалт

4 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

4.1.Монгол Улсын Засгийн газар нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн цэрэг, цагдаагийн багийг энхийг сахиулах ажиллагаанд оролцуулах, эгүүлэн татах шийдвэр гаргах;

4.1.2. энхийг сахиулах ажиллагаанд оролцох асуудлаар НҮБ-тай холбогдох гэрээ, хэлэлцээр байгуулах;

4.1.3. цэргийн багийг олон улсын тухайн ажиллагаанд оролцуулах, эгүүлэн татах асуудлыг Монгол Улсын эзвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх;

4.1.4. энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагааны хээрийн сургууль, дадлагыг өөрийн оронд зохион байгуулах;

4.1.5. Монгол Улсад зохион байгуулагдах энхийг сахиулах хүчний хээрийн сургуульд оролцох гадаад орны томилгоот бүрэлдэхүүний агсамж, нормт хангалтын зүйлс, тээврийн хэрэгсэлд хил, гаалийн хялбарчилсан шалгалт хийх, навигацийн болон бусад үйлчилгээний жүрмыг тогтоох;

4.1.6. энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний агсамж, хангалтын төрөл, тэдгээрийн хэмжээ, олгох жүрмыг тогтоох;

4.1.7. энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд бэлтгэх, оролцох асуудлыг зохицуулах үүрэг бүхий зөвлөлийг мэргэжлийн байгууллагын төлөөлөлтэйгөөр шаардлагатай үед байгуулж, ажиллах жүрмыг тогтоох.

5 дугаар зүйл. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

5.1.Гадаад хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.цэрэг, цагдаагийн албан хаагчийг энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах асуудлыг Засгийн газрын холбогдох гишүүнтэй хамтран Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт хэлэлцүүлж шийдвэрлүүлэх;

5.1.2. цэрэг, цагдаагийн албан хаагчийг энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах асуудлаар НҮБ, холбогдох улс, байгуллагатай харилцаж, шуурхай зохицуулах;

5.1.3. энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцох байгаа цэрэг, цагдаагийн албан хаагч Монгол Улсын болон тухайн улсын хууль тогтоомж, НҮБ-аас тогтоосон дүрэм, журам зөрчсөн буюу эрүүл мэндийн байдал, ар гэрийн шалтгаанаар үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд холбогдох

байгуулагын саналыг үндэслэн эгүүлэн татах асуудлыг шийдвэрлэх.

6 дугаар зүйл. Батлан хамгаалахын болон хууль зүйн асуу дал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

6.1. Батлан хамгаалахын болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

6.1.1.цэргийн мэргэжлийн удирдлагын төв, эсхүл цагдаагийн төв байгууллагын сонгож, санал болгосноор энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг томилох;

6.1.2. энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагааны чиглэлээр сургалт, дадлагад цэрэг, цагдаагийн албан хаагчийг оролцуулах;

6.1.3. цэрэг, цагдаагийн албан хаагч, баг энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцож байгаа байдлыг Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт мэдээлэх;

6.1.4. энхийг сахиулах, олон улсын бусад ажиллагаанд оролцуулах бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэх, сонгох, үүрэг гүйцэтгэх журмыг батлах.

7 дугаар зүйл. Мэргэжлийн удирдлага, бэлтгэл

7.1. Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцож байгаа цэргийн албан хаагч, баг гүйцэтгэж буй үйл ажиллагааны хувьд тухайн ажиллагаагаар удирдаж байгаа олон улсын цэргийн хүчний командлалд, захиргааны хувьд үндэсний цэргийн мэргэжлийн удирдлагын төв байгуулагад захирагдана.

7.2. Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцож байгаа цагдаагийн албан хаагч, баг гүйцэтгэж буй үйл ажиллагааны хувьд тухайн ажиллагаагаар удирдаж байгаа НҮБ-ын бүрэн эрхт төлөөлөгчид, захиргааны хувьд үндэсний цагдаагийн төв байгууллагад захирагдана.

7.3. Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох бие бүрэлдэхүүний мэргэжлийн бэлтгэлийг цэргийн мэргэжлийн удирдлагын төв, цагдаагийн төв байгууллага зохион байгуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

8 дугаар зүйл. Цалин хангамж

8.1. Цэрэг, цагдаагийн албан хаагчийг энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцох хугацаанд ажилаж байсан албан тушаалыг хэвээр хадгалж, өөрөө эвөшөөрсөн тохиолдолд цалин, нэмэгдлийг гэр бүлд нь олгож болно.

8.2. Энхийг сахиулагч үүрэг гүйцэтгэх үедээ амь үрэгдсэн, тахир дутуу болсон, хөдөлмөрийн чадвараа алдсан тохиолдолд тэтгэвэр, тэтгэмжийн асуудлыг Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн[2] 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан шийдвэрлэнэ.

8.3.НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд цэрэг, цагдаагийн албан хаагчийг оролцуулсны нөхөн төлбөрөөс энхийг сахиулагчид олгох хөлсний хэмжээг Засгийн газар тогтооно.

9 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

9.1.Цэрэг, цагдаагийн албан хаагч энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцохдоо хууль, тогтоомж зөрчсөн үйлдэлд олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол дотоодын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр **Улаанбаатар хот**

ГАЛТ ЗЭВСГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Галт зэвсгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд дор дурдсан агуулгатай 4 дэх хэсэг нэмсүгэй:

"4.4. Энхийг сахиулах болон олон улсын ажиллагааны хэрэгийн сургууль, дадлагыг өөрийн оронд зохион байгуулах үед улсын хилээр оруулж буй галт зэвсэгтэй холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй."

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгуулагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

[2] Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль --"Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр — Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтын "байлдааны талбарт..." гэсний дараа "болон энхийг сахиулах"гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр — Улаанбаатар хот

ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Тайван цагт" гэсний өмнө "Энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцож байгаа энхийг сахиулагч," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэрэг, цагдаагийн албан хаагчийг Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг сахиулах болон олон улсын бусад ажиллагаанд оролцуулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭНД НЭГДЭН ОРОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1981 онд Найроби хотноо байгуулсан Олимпийн бэлгэ тэмдгийг хамгаалах тухай гэрээнд Монгол Улс нэгдэн орсныг соёрхон батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 23-ны өдөр — Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуульд дор дурдсан агуулгатай 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт тус тус нэмсүгэй:

1/ 10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6. Цагдаагийн байгууллага нь гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх ажлыг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн туслалцаа, тэдний хамтын ажиллагаанд түшиглэн зохион байгуулна."

2/ 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт:

"5/ офицер цолыг 1 жил хүртэл хугацаагаар хураах, энгийнээр буюу цагдаагаар ажилпуулах ;"

2 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлд "Цагдаагийн байгууллага нь шүүхийн шийтгэх тогтоолоор хорих ял шийтгэгдсэн этгээдийг хорих ял эдлүүлэх байгууллагад хуяглан хүргэнэ" гэсэн 2 дахь хэсэг;

24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "хэрэг бүртгэлт" гэсний дараа " ,мөрдөн байцаалт" ; 31 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн "хориглono." гэсний дараа " Энэ заалтыг зөрчсөн тохиолдолд дүрэмт хувцасыг хураан авна." гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/ 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

" 2. Эрүүлжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон Улсын Ерөнхий прокурортой хамтран батална."

2/ 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 2, 3, 4 –т заасан ажиллагаат Эрүүгийн байцаан шийтгэх хууль[1] болон Захиргааны хариуцлагын тухай хуульд[2] заасан журмаар гүйцэтгэж , тэмдэглэл хөтөлж, түүнд цагдаагийн албаа хаагч, сэрдэгдсэн этгээд, гэрч гарын үсэг зурна."

4 дүгээр зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "баривчлах, албадан саатуулахаар" гэснийг "баривчлахаар"; 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн " сэжиглэгдсэн " гэснийг " сэрдэгдсэн "; 32 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын дугаарыг "6"; 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "цагдан хорих байранд " гэснийг " түр саатуулах байранд " гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн ",албадан саатуулах"; 20 дугаар зүйлийн 9 дэх заалтын ",казино ажиллуулах"гэснийг тус тус хассугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 23-ны өдөр **Улаанбаатар хот**

НОТАРИАТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Нотариатын тухай хуульд дор дурдсан агуулгатай 6[1] дүгээр зүйл, 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 22 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт, 27[1] дүгээр зүйл тус тус нэмсүгэй:

1/ 6[1] дүгээр зүйл:

"6[1] дүгээр зүйл. Нотариатын байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтэц

1.Нотариатын байгууллагын эрх барих дээд байгууллага нь Нотариатчдын танхимын гишүүдийн хурал /цаашид "Гишүүдийн хурал" гэх/ байна.

2. Гишүүдийн хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Нотариатчдын танхимын дүрмийг батлах, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/ Нотариатчдын танхимын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэж батлах;

3/ Нотариатчдын танхимын Ерөнхийлөгчийг /цаашид "Ерөнхийлөгч" гэх/ сонгох, чөлөөлөх, түүнд олгох цалин хөлсний хэмжээг тогтоох;

4/ Ерөнхийлөгчийн ажлын албаны зардлын дээд хязгаарыг тогтоох;

5/ Нотариатчдын танхимын Удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаог тогтоож, гишүүний үүрэгтэй нь холбогдуулан урамшуулал олгох эсэхийг шийдвэрлэх;

6/ Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, тэдгээрийн бүрэн эрхийн хугацаог тогтоож, гишүүний үүрэгтэй нь холбогдуулан урамшуулал олгох эсэхийг шийдвэрлэх;

7/ Нотариатчдын танхимын жилийн төсвийг батлах;

8/ Нотариатчийн ёс зүйн дүрмийг батлах.

3. Гишүүдийн хурлыг жилд нэг удаа Удирдах зөвлөл зарлан хуралдуулна. Гишүүдийн арваас дээш хувь нь санал гаргасан тохиолдолд ээлжит бус хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

4. Гишүүдийн хурал нийт гишүүдийн олонхи оролцсоноор хүчин төгөлдөр болох ба хуралд оролцогсдын олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

[1] Эрүүгийн байцаан шийтгэх хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 6 дугаарт нийтлэгдсэн.
[2] Захиргааны хариуцлагын тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 4-5 дугаарт нийтлэгдсэн.

5. Гишүүдийн хурлын хуралдааны дэгийг Нотариатчдын танхимын дүрэмд заана.

6. Гишүүдийн хурлын чөлөөт цагт Нотариатчдын танхимын эрх барих байгууллага нь есөн гишүүнээс бүрдсэн Удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөлийн эрх хэмжээг Нотариатчдын танхимын дүрмээр тогтооно.

7. Нотариатчдын танхимын ёдөр тутмын үйл ажиллагаог Ерөнхийлөгч удирдах ба Нотариатчдын танхимын дүрэмд өөрөөр заагаагүй бол түүний бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна. Ерөнхийлөгчийг нэг удаа улируулан сонгож болно.

8. Ерөнхийлөгчийн эрх хэмжээг Нотариатчдын танхимын дүрмээр зохицуулна."

2/ 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3. Үл хөдлөх эд хөрөнгийг бусдад шилжүүлэхтэй холбогдсон аливаа хэлцэл болон өвлөх эрхтэй холбогдсон бичиг баримтыг зөвхөн тухайн эд хөрөнгө байгаа тойргийн нотариатч гэрчилнэ."

3/ 19 дүгээр зүйлийн 6 дахь заалт:

"6/ нотариатын үйлдэл хийх эрхээ гагцхүү өөрөө хэрэгжүүлэх."

4/ 22 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

"8. Нотариатын мэргэшлийн шалгаруулалтад тэнцсэн хуульч нь нотариатын хариуцлагын даатгалын гэрчилгээний хувийг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгсний үндэсэн дээр тусгай зөвшөөрөл авна."

5/ 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалт:

"10/ нотариатчийн мэдэгдэх хуудас бичих;"

6/ 27[1] дүгээр зүйл:

"27[1] дүгээр зүйл. Нотариатчийн мэдэгдэх хуудас, түүний агуулга

1.Нотариатч төлбөрийг нотолсон баримт бичгийг үндэслэн өвлөх эрх, тэжээн тэтгэхтэй холбогдсон харилцаанд төлбөр төлөгчөөс мөнгө, эд хөрөнгийг гаргуулахаар талууд харилцан тохиролцож байгуулсан гэрээг гэрчлэн мэдэгдэх хуудас үйлдэнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан мэдэгдэх хуудас үйлдэхдээ дараахь нөхцөлийг харгалзана:

1/ баримт бичиг нь төлбөр төлөгч төлбөр авагчид төлбөр төлөх нь маргаангүй гэдгийг нотолж байгаа;

2/ нэхэмжлэл гаргах эрх үүссэнээс хойш 3 жилийн хугацаанд гаргасан эсэх.

3. Нотариатчийн мэдэгдэх хуудсанд дараахь зүйлийг заана:

1/ мэдэгдэх хуудас олгож буй нотариатчийн овог, эцгийн нэр, нэр, харьяалагдах тойрог;

2/ ямар баримт бичгийг үндэслэж мэдэгдэх хуудас үйлдэж байгаа;

3/ төлбөр авагч, төлбөр төлөгчийн овог, эцгийн нэр, нэр, ажлын болон гэрийн хаяг, аж ахуйн нэгж, байгууллагын оноосон нэр, үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, банкин дахь харилцах дансны дугаар, улсын бүртгэлийн дугаар;

4/ төлбөр гаргуулах хугацаа;

5/ төлбөрийн хэмжээ, шаардлагын зүйл, хэрэв мэдэгдэх хуудас үйлдэхэд үндэс болгосон баримт бичигт заасан бол хүү, торгуулийн хэмжээ;

6/ нотариатын үйлчилгээний хөлс, зардлын хэмжээ;

7/ мэдэгдэх хуудас үйлдсэн огноо, дугаар.

4. Мэдэгдэх хуудсыг хэвлэмэл хуудас дээр бичиж, тамга дарж нотариатч гарын үсэг зурна.

5. Нотариатчийн мэдэгдэх хуудсанд заасан төлбөрийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулья[1] заасан журмын дагуу гаргуулна."

2 дугаар зүйл. Нотариатын тухай хуулийн 13 дугаар зүйл, 14 дүгээр зүйл, 16 дугаар зүйл, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг дор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1/ 13 дугаар зүйл:

"13 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл

1.Нотариатын үйл ажиллагаа нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл /цаашид "тусгай зөвшөөрөл" гэх/ - ийн үндэсэн дээр эрхэлнэ.

2. Хуульд заасны дагуу сонгон шалгаруулалтад орж тэнцсэн хуульч тусгай зөвшөөрөл авахаар мэргэшлийн шалгалт өгөх эрхтэй."

2/ 14 дүгээр зүйл:

"14 дүгээр зүйл. Мэргэшлийн хороо

1.Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон мэргэшлийн шалгаруулалт явуулах Мэргэшлийн хороо /цаашид "Мэргэшлийн хороо" гэх/ нь хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байна.

2. Мэргэшлийн хороо долоон гишүүнтэй байна.

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль- "Төрийн мэдээлэл" эмхтэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

3. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнийг шүүх, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг, Танхимаас таван хүний төлөөлөлтэйгээр, тэдгээр байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

4. Мэргэшлийн хорооны даргыг уг хорооны гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

5. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн мэргэшлийн шалгаруулалт явуулах тухай асуудлыг нотариатын тойрог, нотариатчын орон тоо, хэрэгцээг харгалзан тухай бүр шийдвэрлэнэ.

6. Тусгай зөвшөөрөл олгохтой холбогдсон маргааныг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн шийдвэрлэнэ.

7. Суманд нотариатч ажиллаагүй бол нотариатчийн үүргийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс зөвшөөрөл авсны үндэсэн дээр сумын Засаг даргын Тамгын газрын дарга гүйцэтгэнэ."

3/ 16 дугаар зүйл:

"16 дугаар зүйл. Нотариатын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх

1.Нотариатч эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар нотариатын үйл ажиллагаа зэрэх боломжгүй болсон бол өөрийнх нь хүсэлт болон Нотариатчдын танхимын саналаар тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

2. Нотариатч эрүүгийн хариуцлагад татагдсан тохиолдолд эцсийн шийдвэр гартал эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж болно.

4/ 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7/ нотариатын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойш 6 сарын турш үйл ажиллагаа явуулаагүй."

3 дугаар зүйл. Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн " сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын ажилтан" гэснийг "сумын Засаг даргын Тамгын газрын дарга"; 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 44 дүгээр зүйлийн 3, 4, 5 дахь хэсгийн "Хууль зүйн сайд" гэснийг " хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн"; 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Хууль зүйн яам" гэснийг "хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага; 23 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 10 дахь заалтын дугаарыг "11" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Нотариатын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн "Энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд"; 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд шаардлагатай"; 42 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "Нотариатчдын товчоо," гэснийг тус тус хассугай.

5 дугаар зүйл. Нотариатын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 4, 5 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр **Дугаар 19** **Улаанбаатар хот**

Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай УИХ-ын 1998 оны 56 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Зөвсөгт хүчний тухай хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1. Төрийн цэргийн бодлогын үндсийг батлах тухай Монгол Улсын Их Хурлын 1998 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн 56 дугаар тогтоолын хавсралтын 4 дүгээр бүлгийн Зэвсэгт хүчний тайван цагт хүлээх үүргийн "улсын хил хамгаалах" гэснийг "улсын хил хамгаалахад дэмжлэг үзүүлэх" гэж, "улсын онц чухал объектыг хамгаалах" гэснийг "улсын онц чухал объектыг хамгаалахад дэмжлэг үзүүлэх" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Энэ тогтоолыг Зэвсэгт хүчний тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 16-ны өдөр | **Дугаар 20** | **Улаанбаатар хот**

Төрөөс хилийн талаар баримтлах бодлогыг батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ: /Н.Энхбаяр/-т даалгасугай.

1."Төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг хавсралт ёсоор батална сугай.

2.Энэхүү баримт бичигт тодорхойлсон бодлого, зорилтыг дэс дараатай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, гүйцэтгэлийг жил бүр Улсын Их Хуралд танилцуулж байхыг Засгийн газар

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Ажлын бүлэг, гадаад бодлогын байнгын хороо /Д.Лүндээжанцан/-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 20 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХИЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого /цаашид "Хилийн талаар баримтлах бодлого" гэх/ нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах бодлогын салшгүй хэсэг мөн.

2. Хилийн талаар баримтлах бодлого нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд үндэслэсэн улсын хил, хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын талаархи Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээрийн үндэс болсон залгамж чанартай тулгуур баримт бичиг мөн.

3. Хилийн талаар баримтлах бодлого нь байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэнэ.

4. Хилийн талаар баримтлах бодлого нь бусад улсын түсгаар тогтнолыг хүндэтгэх, нутаг дэвсгэрийнбүрэн бүтэн, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг дээдлэх, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийг хангах, улсын хил дээр хүч хэрэглэхээс аль болох зайлсхийх, аливаа асуудлыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрмэлзэх зарчимд тулгуурлана.

5. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг шинжлэх ухаан, техник, технологийн ололт, мэргэшсэн байгууллагын үйл ажиллагаанд тулгуурлан цогц байдлаар зохион байгуулна.

6. Улсын хил нь хил залгаа улстай байгуулсан олон улсын гэрээгээр тодорхойлогдох бөгөөд Монгол Улсын хуулиар батлагдаагүй байна.

7. Улсын хилийн халдашгүй дархан байдал нь хилийн шугам хууль бусаар өөрчлөгдөөгүй, хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр зөрчигдөхгүй байх явдлаар хангагдана.

8. Хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдал нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, язгуур ашиг сонирхол тухайн нутаг дэвсгэрт хангагдсан байдлаар тодорхойлогдно.

9. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр нэгдмэл тогтолцоог бүрдүүлэх, байгууллага, иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах асуудлыг Засгийн газар хариуцна.

Хоёр. Хилийн талаар баримтлах бодлогын үндсэн чиглэл

1. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар:

1/ улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах талаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, нэгдэн орох, тэдгээрийг хүндэтгэн сахих, холбогдох хууль тогтоомжийг боловсронгуй болгож байх;

2/ бүсчилсэн хөгжлийн үзэл

баримтлалтай уялдуулан хилийн бүс, зурвасын эзэмшлийг сайжруулж, хил орчмын нутаг дэвсгэрийн хөгжлийн талаар нийгэм, эдийн засгийн цогцолбор арга хэмжээ авах;

3/ улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр дэх газар нутгийн уламжлалт монгол нэр, түүх, соёлын дурсгалт зүйлсийг хөвөөр хадгалах;

4/ хил орчмын нутаг дэвсгэрийн стратегийн ач холбогдол бүхий байгалийн нөөц, баялгийг төрийн хяналтад байлгах;

5/ хилийн асуудлаар хил залгаа улсын холбогдох байгууллагуудтай тогтоосон харилцааг хөгжүүлэх;

6/ улсын хил дээр зэвсэгт халдлага, түрэмгийллэл үүсэхээс урьдчилан сэргийлж, хилийн асуудлаар үүссэн зөрчил, будлианыг энхийн аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх;

7/ хил дамнасан гэмт хэрэгтэй тэмцэх, байгалийн гамшиг, хүн малын гоц халдварт өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, хил орчмын нутаг дэвсгэрт хүмүүнлэгийн болон экологийн асуудлыг шийдвэрлэх чиглэлээр хил залгаа болон бусад орнуудтай хамтран ажиллах;

8/ улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлын эсрэг чиглэсэн үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, цаг алдалгүй илрүүлэх, таслан зогсоох, шийдвэрлэх арга хэмжээг цогц байдлаар хэрэгжүүлэх;

9/ хил орчмын нутаг дэвсгэр, хилийн боомт газарт эмх замбараагүй байдал үүсэхээс сэргийлэх;

10/ эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааны зарчимд тулгуурлан, дэд бүтэц, барилга байгууламж бүхий хилийн хяналт шалгалт явуулах нөхцлийг хангасан хилийн боомтуудыг ажилуулах;

11/ улсын хил хамгаалах байгууллагын албан хаагчдыг мэргэшүүлэх;

12/ иргэдийн эх оронч үзэл, улсын хил, хилийн дэглэм, журмыг хүндэтгэн сахих хүмүүжлийг төлөвшүүлэх.

2. Улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах механизмыг боловсронгуй болгох талаар:

1/ улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны зохицуулалт, уялдаа холбоог сайжруулах, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;

2/ хил судлалын шинжлэх ухааныг хөгжүүлж, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг хил хамгаалалтын бодлого, үйл ажиллагааны үндэс болгох;

3/ улсын хилийн бүс, зурвас, боомт газарт орчин үеийн шаардлагад нийцсэн холбоо, хяналт, дохиолол, зам, тээвэр, инженерийн байгууламж бүхий хил хамгаалалтын дэд бүтцийг хөгжүүлэх;

4/ агаарын хилийн хяналтыг боловсронгуй болгоход чиглэсэн дэвшилтэт техник, хэрэгслийг нэвтрүүлэх;

5/ зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг шуурхай болгож, хилийн боомт газарт ажиллах хяналтын албадын үйл ажиллагааг нь уялдуулан, нэгдсэн зохицуулалтад оруулах;

6/ хил орчмын оршин суугчдаас хил хамгаалалтад оролцох явдлыг хөхүүлэн дэмжих, урамшуулах, улсын хилийн бүс, зурвастаа тогтвортой суурьших нөхцлийг бүрдүүлэх;

7/ хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх байгууллагуудыг эх оронч, мэдлэг, чадвартай боловсон хүчнээр хангах, тэдгээрийн нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцлийг сайжруулж, тэдний ар гэрийн нийгмийн баталгааг бодитойгоор дэмжих;

8/ төрөөс аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн Монгол Улсын үндэсний эрх ашигт үл харшлах хилийн харилцааг чөлөөтэй байлгах.

3. Хил хамгаалах албаны бүтэц, үйл ажиллагааны талаар:

1/ хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах чадвар бүхий нэгдмэл бүтэц, зохион байгуулалттай байлгах;

2/ хил хамгаалах албаны үйл ажиллагаанд улс төр, дипломат, тагнуул, инженер-техник, хяналтын болон дэглэм сахиулах зэрэг аргыг оновчтой ашиглах;

3/ хил хамгаалах албыг зохион байгуулж, удирдах байгууллага нь мэргэжлийн байх.

Гурав. Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх чиглэл

1. Хилийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулж удирдах, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүжилт, материал техникийн хангамжийн норм хэмжээг тогтоох, хуулиар олгогдсон эрх хэмжээний дагуу хилийн асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах эзэрэг асуудлыг Засгийн газар хариуцаж хэрэгжүүлэх.

2. Байгууллага, иргэд Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хил орчмын нутаг дэвсгэрт хангах талаар хүлээсэн үүргээ Үндэсэн хууль, бусад хууль тогтоомжийн дагуу биелүүлэх.

3. Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэхэд шаардагдах хүн, хүч, хөрөнгийн тооцоог гаргаж, жил бүрийн төвлөрсөн болон орон нутгийн төсөв бусад эх үүсвэрээс санхүүжүүлж байх.

4. Хилийн талаар баримтлах бодлогод олон улсын харилцааны хөгжил, дэлхий дахины болон бүс нутаг, үил залгаа улс дахь цэрэг-улс төрийн байдал, улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт үүсэж буй болсон бодит нөхцөл байдалтай уялдуулан Улсын Их Хурал тодотгол хийх.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 21 **Улаанбаатар хот**

"Чингис хаан" одон бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Чингис хаан" одон бий болгосугай.

2. "Чингис хаан" одонгийн дүрмийг 1 дүгээр хавсралтаар, тодорхойлолтыг 2 дугаар хавсралтаар тус тус батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 21 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"ЧИНГИС ХААН" ОДОНГИЙН ДҮРЭМ

1. "Чингис хаан" одон бол Монгол Улсын төрийн дээд шагнал бөгөөд төрүүн эзэрийн одон мөн.

2. "Чингис хаан" одонгоор Монгол Улсын Ерөнхийлэгч зарлиг гаргаж шагнана.

3. "Чингис хаан" одонгоор дор дурдсан болзол хангасан хүмүүсийг шагнаж, үнэмлэх олгоно:

1/ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний эв нэгдлийг бататтан бэхжүүлэх, эх орондоо хүмүүнлэг, ардчилсан нийгэм цогцуулан хөгжүүлж, нийгмийн дэвшилийг хангах, төрт ёс, түүх соёлынхоо уламжлалыг гүнзийг судалж, хойч үедээ өвлүүлэх, тэдгээрийг дэлхийн бусад оронд сурталчлан таниулах үйлст жинтэй хувь нэмэр оруулж, төр, нийгэм, үндэстний өмнө онцгой гавьяа байгуулсан Монгол Улсын иргэн;

2/ Улс түмний өв нэгдэл, хөгжил цэцэглэлт, хүн төрөлхтөний амар амгалан байдлыг бэхжүүлэх болон Монгол Улс гадаад орнуудтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, дэлхий дахинд Монгол Улсын нэр хүндийг өргөн сурталчлах, түс улсын эдийн засаг, нийгэм, оюун санааны хөгжилд бодитой хувь нэмэр оруулсан гадаад орны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, иргэн.

4. "Чингис хаан" одонгоор нэхэн шагнахгүй.

5. "Чингис хаан" одонгоор шагнуулах Монгол Улсын иргэнийг Ерөнхийлөгчийн зарлигаар батална "Монгол Улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-д заасанаар, гадаад орны төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, иргэнийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд саналчлан тус тус нэр дэвшүүлнэ.

6. "Чингис хаан" одонг:

а/ Монгол Улсын иргэнд Үндэсний их баяр наадам-Ардын Хувьсгалын ойн баярын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч;

б/ гадаадын иргэнд тухайн өдрийн морин цагт Монгол Улсын Ерөнхийлөгч Төрийн хүндэтгэлийн өргөөнд;

в/ уг шагналыг эх орондоо хүлээн авах гадаадын иргэнд тухайн оронд айлчлах төр, засгийн удирдлага тус тус ёслол төгөлдөр гардуулна.

7. "Чингис хаан" одонгоор шагнагдсан хүнд төрөөс дор дурдсан эрх эдлүүлж, урамшуулал үзүүлнэ:

а/ Үндэсний их баяр наадам-Ардын Хувьсгалын ойн баяр, Үндэсэн хуулийн өдөр, Цагаан сарын баярааг болдог төрийн ёслолын арга хэмжээнд уригдан оролцох;

б/ "Чингис хаан" одонгоор шагнагдсан Монгол Улсын иргэнд тухайн үеийн ханшаар 9 цэн алттай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал, гадаадын иргэнд мөн тухайн үеийн ханшаар 9 цэн алттай тэнцэх хэмжээний мөнгөн шагнал буюу дурсгалын зүйл гардуулах.

8. "Чингис хаан" одонгоор шагнагдсан хүн, эсхүл хууль ёсны өвлөгч нь хүсвэл алдар гавьяаг нь мөнхжүүлэх зорилгоор уг одонг үнэмлэхийн хамт Үндэсний түүхийн төв музейд хүндэтгэлтэйгээр байрлуулна.

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 21 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

"ЧИНГИС ХААН" ОДОНГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. Одон, зүүлтийн хэсэг

"Чингис хаан" одонгийн төвд дугуй хэлбэртэй, сааралт өнгийн паалан дээр Чингис хааны дүрийг цагаан алтаар товойлгон хийнэ.

Түүний гадуурх тойргийн хөх өнгийн паалан дээр баруун хэсэгт "Мөнх тэнгэрийн хүчинд", зүүн хэсэгт "Чингис хаан Тэмүүжин" гэж худам монгол бичгээр товойлгон алтдаж бичнэ.

Түүний гадуур алтадсан эвэр угалзан дугуй хүрээг товойлгож хийнэ.

Дугуй хүрээ нь гадуураа дөрвөн зүг, найман зовхисыг бэлгэдсэн цацрагуудтай байна. Эв нэгдэл, бат бэхийг бэлгэдэж багцалж боосон таван сумны дурстэй урт цацрагыг алтдаж хийнэ. Багцалсан боолт нь цагаан алтан суурь бүхий үнэт эрдэнийн очир алмааз шигтгээ байна.

Цацраг тус бүрийн баруун, зүүн талд түүнтэй ижил урттай, үзүүртэз алтан бөмбөлөгтэй, ховил бүхий цагаан алтан цацраг байна.

Энэхүү цацрагуудын хооронд үзүүртэз үнэт эрдэнийн бадмаараг шигтгээ бүхий богиновтор өргөн алтан цацраг байна. Түүний хоёр талд ховил бүхий цагаан алтан богино цацраг байна.

Бүх хос цацрагуудын хооронд цагаан алтан богино холбоос байна.

Одонгийн дээд хэсэгт одон зүүлт хоёрыг холбох зориулалттай холбоосын хэсэг байна. Холбоос нь Чингис хааны Гэрэгэ дэвсгэртэй цагаан туг байна. Тугийг цагаан алтаар, Гэрэгэ-г алтаар хийнэ.

Одонгийн зүүлт нь алтадсан эвэр угалзан гинжин чимэглэлээр холбогдсон цагаан туг болон бадам цэцгэр хүрээлүүлсэн хөх өнгийн пааландсан суурь бүхий алтан соёмбоос бүрдэнэ. Цагаан тугнууд нь эвэр угалзан хүрээтэй байна. Туг, бадам цэцгийг цагаан алтаар, соёмбыг алтаар хийнэ. Одон, зүүлтийн хэсэгт нийт есөн цагаан туг дүрслэгдэнэ.

Одон, холбоос, зүүлтийн их биеийг мөнгөөр хийх бөгөөд цагирагаар холбогдоно.

Одонгийн ар талд дугаарыг бичнэ.

Хоёр. Одон, зүүлтийн хэмжээ

Одон нь тус бүр 2 мм-ийн зузаантай 3 давхар байна. Одонгийн нийт диаметр 100 мм, Чингис хааны дүрс байрласан дугуйн диаметр 32 мм, худам монгол бичгийн өргөн нь 4 мм, эвэр угалзан хэсний өргөн 4 мм байна. Одонгийн төв хэсгийн дугуйн захаас цацрагуудын үзүүр хүртэл 25 мм; 23 мм; 18 мм; 13 мм; 7 мм байна. Очир алмааз шигтгээ байрласан цагаан алтан суурийн диаметр нь 4 мм, бадмаараг шигтгээний диаметр нь 3 мм байх бөгөөд тэдгээр нь тус бүр 0,1 карат байна.

Гэрэгэ-ийн урт нь 29 мм, өргөн нь 11 мм байна.

Зүүлтний алтан соёмбыг хүрээлсэн бадам цэцгийн диаметр нь 40 мм, зүүлтний цагаан тугны гаднах дугуйн диаметр нь 27 мм байна. Алтан соёмбын өндөр нь 28 мм, өргөн нь 15 мм байна.

Хоёр цагаан тугны хоорон дох эвэр угалзан чимэглэлийн урт нь 48 мм, өргөн нь 19 мм байна.

Гурав. "Чингис хаан" одонгийн бичил хувилбарын тодорхойлолт

"Чингис хаан" одонгийн бичил хувилбар нь уг одонгийн Их эзэн Чингис хааны дүр бүхий цацарсан ирмэгт дугуй дээрх бүх элементийн бүрдэл хэсгүүдийг 4 дахин багасгаж дүрсэлсэн дугуй хэлбэртэй байна.

Бичил хувилбар нь 2 мм-ийн зузаантай, 25 мм-ийн диаметр бүхий нэг хавтгай дээр дүрслэгдэн байх бөгөөд түүний их биеийг мөнгөөр хийж, алт, цагаан алтаар алтадна.

Бичил хувилбарын ар талд энгэрт зүүх зүүлт байх бөгөөд түүний доод талд одонгийн дугаарыг бичнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 2 дугаар сарын 27-ны өдөр Дугаар 32 **Улаанбаатар хот**

Сумдыг төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчдаар хангах талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нарын бүсчилсэн сургалт-семинар дээр гарсан саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин, аймгийн Засаг дарга нарт даалгах нь:

а/сумдад ажиллах төрийн захиргааны мэргэшсэн албан хаагч бэлтгэх зорилгоор 2002-2003 оны хичээлийн жилээс эхлэн Удирдлагын академид төрийн захиргааны удирдлагын дипломын зэрэг олгох сургалт зохион байгуулахаар тогтож, тусгай журмын дагуу авсан элсэлтийн шалгалтад тэнцэж сумын Засаг даргын Тамгын газартайгаа гэрээ байгуулсан элсэгчдийг уг сургалтад хамруулан суралцуулж байсугай;

б/төрийн захиргааны удирдлагын дипломын боловсрол эзэмшээд суманд үр бүтээлтэй ажилласан, цаашид сумандаа тогтвор суурьшилтай ажиллах, өсөх ирээдүйтэй төгсөгчийг тусгай журмын дагуу сонгож сумын Засаг даргын Тамгын газартай байгуулсан гэрээний үндсэн дээр тэднийг бакалаврын болон магистрын зэрэг олгох сургалтад хамруулах замаар сумдын удирдлагын чадавхийг тасралтгүй дээшлүүлэн ажилласугай.

2. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:

а/сум бүрээс 2 хүнд төрийн захиргааны удирдлагын мэргэжил олгох 2002 оны сургалт, дадлагын болон дотуур байрны зардлыг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргаж цаашид энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан элсэгчдийн дээрх зардлыг улсын төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж байхыг үүрэг болгосугай;

б/Удирдлагын академид төрийн захиргааны удирдлагын дипломын зэрэг олгох сургалт зохион байгуулахтай холбогдуулан 336 оюутны дотуур байрыг барьж ашиглалтад оруулах болон шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зардлыг 2003 оны төсөвт тусган санхүүжүүлсүгэй.

3.Удирдлагын академид төрийн захиргааны удирдлагын дипломын, бакалаврын болон магистрын зэрэг олгох сургалтад сумаас ирж суралцаж байгаа оюутны Улаанбаатарт ирэх, буцах тээврийн зардлыг жил бүр захиалагч байгуулагын төсвөөс санхүүжүүлж байхыг аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Төрийн захиргааны удирдлагын дипломын зэрэг олгох сургалтыг эчнээ хэлбэрээр зохион байгуулах, Удирдлагын академийн бүсийн салбар төв ажиллуулах, эдгээр арга хэмжээг гадаад орон, олон улсын байгууллагын бүцалттүй тусламжаар санхүүжүүлэх боломжийг судлан шийдвэрлэх талаар ажиллахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин, Удирдлагын академийн захирал Ш.Тудэв нарт даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргаа, удирдлагын хөгжлийн институтийг Удирдлагын академи болгох, түүний дүрмийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн 197 дугаар тогтоолоор батлагдан дүрмийн 7 дугаар заалтад дор дурдсан нэмэлт оруулсугай:

"е/ Төрийн захиргааны удирдлагын дипломын болон бакалаврын зэрэг олгох сургалт".

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 15 дахь заалт нэмсүгэй.

"15. Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол-Чехийн Засгийн газар хоорондын хамтарсан Хорооны Монголын хэсэг

Дарга -Үйлдвэр, худалдааны дэд сайд"

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

Ой тэмдэглэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 118 дугаар зарлигийг хэрэгжүүлэх зорилгоор "Түүхэн үйл явдал тэмдэглэх, төр, нийгмийн зүтгэлтэн, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь хүндэтгэх ажлыг зохион байгуулах журам"-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Эзэн Чингис хаан (Тэмүүжин)-ы түмэн өлзий гийн мэндэлсний 840 жилийн ойг 2002 оны 5 дугаар сарын 3-ны өдөр улс даяар ёслон тэмдэглэсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот

"Монголд зочлох жил"-ийн бэлтгэл ажлыг хангах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаад оронд Монгол Улсыг сурталчлах ажлыг эрчимжүүлж, жуулчны тоог нэмэгдүүлэх зорилгоор "Монголд зочлох жил"-ийн бэлтгэл ажлыг хангах арга хэмжээг зохион байгуулах үүрэг бүхий Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлсугай.

2. "Монголд зочлох жил"-ийн бэлтгэл ажлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллахыг Дэд бүтцийн сайд бөгөөд Үндэсний хорооны дарга Б.Жигжидэд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Монгол Уясын Их Хурлын 2002 оны
56 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛД ЗОЧЛОХ ЖИЛ"-ИЙН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Дэд бүтцийн сайд Б.Жигжид

Гишүүд:
-Гадаад хэргийн дэд сайд С.Батболд;
-Санхүү, эдийн засгийн дэд сайд Л.Энхтайван;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайд Б.Эрдэнэсүрэн;
-Үйлдвэр, худалдааны дэд сайд О.Эрдэнэ;
-Эрүүл мэндийн дэд сайд Н.Удвал;
-Байгаль орчны дэд сайд А.Болат;
-Улаанбаатар хотын ерөнхий менежер Т.Бадамжунай;
-Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар;
-Цагдаагийн ерөнхий газрын дарга Д.Сандаг-Очир;
-"МОНЦАМЭ" агентлагийн дарга Т.Баасансүрэн;
-Хилийн цэргийн удирдах газрын дарга П.Сүндэв;
-Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Ганзориг;
-Монголын аялал жуулчлалын холбооны дарга Ц.Баярсайхан (тохиролцсоноор);
-Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга С.Дэмбэрэл (тохиролцсоноор);
-Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга М.Дагва;
-Төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга Р.Раш;
-"МИАТ" компанийн ерөнхий захирал Ж.Баярсайхан;
-Шуудан, цахилгаан холбооны газрын дарга Г.Баттөр;
-Аялал, жуулчлалын газрын дарга Г.Шийлэгдамба.

Нарийн бичгийн дарга -Дэд бүтцийн яамны Зам,тээвэр,мэдээлэл, холбоо, аялал жуулчлалын бодлого зохицуулалтын газрын дарга Ж.Сэрээтэр.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр **Дугаар 57** **Улаанбаатар хот**

Ёкохамагийн Тунхаглалыг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хүүхдийг садар самууны зорилгоор ашиглахын эсрэг" Дэлхийн П их хурлаас батлан гаргасан Ёкохамагийн Тунхаглалыг хүлээн зөвшөөрч, түүний үзэл санаат "Монголын хүүхдийн үндэсний хөтөлбөр"-т тусгахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

2. Тунхаглалд дурдсан үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах талаар арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 3.5 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 22 (259)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөө батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Дүрэм батлах тухай*
- *Хөтөлбөр, журам батлах тухай*
- *"Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны зургадугаар сарын 13 №22 (259)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

251. Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөө батлах тухай	Дугаар 22	716
252. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий будуувчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай	Дугаар 24	720
253. Ж. Бямбажавыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 25	720
254. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай	Дугаар 26	720

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

255. Дүрэм батлах тухай	Дугаар 54	721
256. Хөтөлбөр, журам батлах тухай	Дугаар 58	723
257. "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр батлах тухай	Дугаар 59	734
258. Барилга шилжүүлэх тухай	Дугаар 60	744
259. Хөрөнгө гаргах тухай	Дугаар 61	744
260. Ажлын хэсэг байгуулах тухай	Дугаар 65	744
261. Зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ батлах тухай	Дугаар 67	745
262. Хамгаалалтын бүс тогтоох тухай	Дугаар 71	745
263. Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай	Дугаар 72	746

ЗАЛРУУЛГА

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн "батлагдсан" гэснийг "дагаж мөрдсөн" гэж залруулан уншина уу.

УИХ-ын Тамгын газрын хуулийн хэлтэс

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 24-ний өдөр | Дугаар 22 | Улаанбаатар хот

Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Их Хурлын Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх, түүний биелэлтийг зохион байгуулахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /Д.Дэмбэрэл/, Тамгын газар /Д.Батбаатар/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 22 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Монгол Улсын Их Хурлын эрхэм зорилго:

Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцуулан хөгжүүлэх, Монголын ард түмний засаглах эрхийг хангах нь Улсын Их Хурлын эрхэм зорилго мөн.

Улсын Их Хурлын стратеги зорилтууд:

Стратеги зорилт 1. *Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу хууль тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх.*

Стратеги зорилт 2. *Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлэх.*

Стратеги зорилт 3. Улсын Их Хурал нь ардчилсан зарчимд тулгуурлан үйл ажиллаганыхаа ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах.

Стратеги зорилт 4. *Улсын Их Хурлын гадаад харилцаагаа өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх.*

Стратеги зорилт 5. *Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах.*

Монгол Улсын Их Хурлын стратеги зорилтууд нь богино, дунд, урт хугацааны бизнес төлөвлөгөөгөөр зохицуулагдана.

Стратеги зорилт 1

Ардчилсан нийгмийн хөгжлийн чиг хандлага, зарчмын дагуу хууль тогтоох үйл ажиллагааны зохион байгуулалтыг бүх талаар хөгжүүлэх, чанар, үр дүнг дээшлүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

1.1.Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаат Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалын дагуу Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалах, эрх зүйт, ардчилсан төрийг төлөвшүүлэх, ард түмний хүсэл зориг, эрх ашиг, эв нэгдлийг хангах, ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулахад чиглүүлэх.

1.2.Үйл ажиллагаа нь Байнгын болон бусад хорооддоо төвлөрсөн орчин үеийн Парламентыг төлөвшүүлэх, Парламентын дотоод ардчиллыг гүнзгийрүүлэх чиглэлээр судалгаа хийж, Улсын Их Хурлын тухай хууль тогтоомжид зохих нэмэлт, өөрчлөлт оруулах.

1.3.Улсын Их Хурлын Байнгын болон бусад хороодын бүрэн эрхийг цаашид өргөжүүлэх хэрэгцээ, боломжийг судалж, тэдгээрийн үйл ажиллагаанд мөрдөх тусгайлсан дүрэм, дэг бий болгох асуудлыг боловсруулах, Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх.

1.4.Улсын Их Хурлаас болон Байнгын хороодоос байгуулагддаг ажлын хэсгийн эрх зүйн байдлыг нэг мөр болгож, тэдгээрийн үйл ахиллагаат зохицуулах дүрэм, дэгийг боловсруулах, Улсын Их Хурлаар хэлэлцэн шийдвэрлэх.

1.5.Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн бүрэн эрхийг ергөтгөх, үйл ажиллагаат нь зохицуулах тусгайлсан зохицуулалтыг бий болгох.

1.6.Улсын Их Хурлаар хэлэлцэгдэх гол гол хууль, бусад шийдвэрийн төслийн талаар иргэд, төрийн бус байгууллага, олон нийтийн зүгээс саналаа илэрхийлэх, олон нийтээр хэлэлцэх боломжоор өргөтгөх.

1.7.Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэхийн өмнө уг төслийн талаар олон нийтийн санал, дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар урьдчилан сонсох журам нэвтрүүлэхийг судалж, энэ талаархи эрх зүйн зохицуулалт бий болгох.

1.8.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн төслийг боловсруулж батлан гаргах.

1.9.Төрийн байгуулалт, эрх зүй, улс төр судлал, социологи, эдийн засаг, нийгмийн бодлогын асуудлаар судалгаа явуулах, хууль тогтоомжийн төслийн онолын үндэслэлийг боловсруулахад оролцох, үйлчилж буй хууль тогтоомжийн үр нөлөөг судлах, шинжлэх ухааны тайлбар бэлтгэх, дэлхийн улс орнуудын парламентат ёсны чиг хандлагыг судлах үүрэг бүхий эрдэм шинжилгээ, судалгааны төвийг Улсын Их Хурлын дэргэд байгуулах асуудлыг судлан боловсруулах.

1.10. 1990 оноос хойш батлан гаргасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн харилцан уялдаа холбоог ханган, түүний нийгмийн үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор хууль тогтоомжийн нэгдсэн системчлэл, ангиллыг тогтоож нэвтрүүлэх, хууль тогтоомжийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, хууль тогтоомжийн системчилсэн эмхтгэлийг боловсруулан гаргах, тогтмол шинэчилдэг болох.

1.11.Улсын Их Хурлын Байнгын болон бусад хороодын үйл ажиллагааны зохион байгуулалтын өнөөгийн байдалд судалгаа, дүгнэлт хийж, цаашдын ажлын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, тэдгээрийн үйл ажиллагааны зохион байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлэх.

1.12.Улсын Их Хурлын гишүүд тедийгүй олон нийтэд чөлөөтэй үйлчлэх чиглэлээр Парламентын номын сангийн мэдээллийн баазыг өргөтгөх, орчин үеийн техник хэрэгслээр тоноглох, түүнчлэн Парламентын номын сангийн барилга барих асуудлыг судлан шийдвэрлэх.

1.13.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны үйл ажиллагаатай олон нийтийг илүү өргөнөөр танилцуулах зорилгоор Улсын Их Хурлын нэгдсэн хуралдааны танхимыг Төрийн ордны их танхимд шилжүүлэх, уг танхимын тохижилтыг эрүүл ахуйн стандартад нийцүүлж орчин үеийн техник хэрэгслээр иж бүрэн тоноглох, эсхүл Парламентын ордон буюу цогцолбор барих асуудлыг судлан шийдвэрлэх.

1.14.Байнгын хороодын хуралдааны танхимын тоог нэмэгдүүлэх, тэдгээрийг компьютерийн болон телесүлжээнд холбох, санал хураах компьютерийн программтай болгон тоноглох арга хэмжээг авах.

1.15. Улсын Их Хурлаас болон Байнгын хороодоос байгуулагддаг ажлын хэсгийн ажиллах тусгай танхим, өрөөг шаардлагатай техник хэрэгслээр тоноглох, ажиллах бусад нөхцөлөөр хангах.

1.16.Парламентын зочид буудал /албаны орон сууц/ барих асуудлыг судлан боловсруулах.

1.17.Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагаат боловсронгуй болгох, түүнтэй холбоотой мэдээллийг олон нийтэд өргөнөөр түгээх, олон нийтээс мэдээлэл авч байх зорилгоор Улсын Их Хурлын гишүүд, Тамгын газрын болон намын бүлгийн ажилтнуудын ашиглаж буй компьютер, техник хэрэгслийг нэмэгдүүлэх, тогтмол шинэчлэх, компьютерийн сүлжээ болон түүний батлагаат байдлыг сайжруулах, орчин үеийн мэдээллийн технологийн шаардлага хангасан компьютерийн мэдээллийн сангуud үүсгэж, ашиглалтад оруулах.

1.18.Улсын Их Хурлын хэвлэх цехийг орчин үеийн тоног техөөремж, хэрэгслээр хангах арга хэмжээг авч, улмаар хэвлэх үйлдвэр болгон өргөтгөх асуудлыг судлан боловсруулах.

1.19.Орчин үеийн Парламентын чиг үүрэг, агуулгыг нийтэд илтгэн харуулах үүднээс Төрийн ордны дизайн, архитектурын шийдлийг хянан үзэж сайжруулах, Улсын Их Хурлын гишүүдийн албан өрөөний нөхцөлийг сайжруулах, тавилга, хэрэгслийг шинэчлэх арга хэмжээ авах.

1.20.Улсын Их Хурлыг ах ахуй, санхүүгийн хувьд бүрэн бие даалгах асуудлыг шийдвэрлэж, Улсын Их Хурлын гишүүдийн ажиллах нөхцөл, үйлчилгээ, ахуй хангамжийг сайжруулах.

Стратеги зорилт 2

Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож, түүний үр нөлөөг дээшлүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

2.1.Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны өнөөгийн зохион байгуулалтад судалгаа, дүгнэлт хийж, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, цаашид хяналт

шалгалтын үйл ажиллагааны зохион байгуулалтыг хөгжүүлэх тусгай хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх.

2.2. Парламентын хяналтыг Засгийн газрын үйл ажиллагааг төвлөрүүлдэг нийтлэг зарчмыг Улсын Их Хурлын хяналтын гол чиг баримтлал болгох.

2.3.Дэлхийн улс орнуудын Парламентын хяналтын сонгодог гол хэлбэр болох Засгийн газрын гишүүдэд болон Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын эрх баригчдад Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хороод, нам, эвслийн бүлгээс асуулт, асуулга тавьж, албан ёсны хариу авах болон улсын төвлөрсөн тєсвийн хуваарилалт, зарцуулалтад тавих хяналтын чиглэлийг Улсын Их Хурлын хяналтын үйл ажиллагааны үндсэн хэлбэр болгон зохион байгуулах ажлыг өргөжүүлэх.

2.4.Улсын Их Хурлын гишүүдийн асуулт, асуулгын хариуг Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын хуралдаанд сонсох, үүнтэй холбогдуулан шийдвэр гаргах журам, дэгийг тусгайлан боловсруулж, холбогдох хууль тогтоомжид тусгах.

2.5. Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаат эрх зүйн хувьд тусгайлан зохицуулах шаардлагыг судлан шийдвэрлэх.

2.6.Улсын Их Хурлаас болон Байнгын хороодоос байгуулагддаг хяналт шалгалтын ажлын хэсгийн эрх зүйн байдлыг тодорхой болгох, үйл ажиллагаат нь зохицуулах журмыг боловсруулж, холбогдох хууль тогтоомжид тусгах арга хэмжээ авах.

2.7.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Засгийн газрын мэдээллийг сонсдог арга, хэлбэрийг боловсронгуй болгох.

2.8.Монгол Улсын Ерөнхийлөгчийн Улсын Их Хуралд ажлаа хариуцах болон Улсын Их Хуралд ажлаа тайлагнадаг байгууллагын илтгэл, сонсгол, тайланг хэлэлцэх зохистой арга, хэлбэрийг сонгох, боловсронгуй болгох, тэдгээрийг хэлэлцэх журмыг боловсруулах.

2.9.Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээнд Төрийн хянан шалгах хорооны гүйцэтгэх үүргийг Улсын Их Хурлаас бодлого боловсруулахад шаардагдах судалгаа, дүн шинжилгээ, мэдээллийн чиглэлээр өөртөгч, энэ талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.

2.10.Улсын Их Хурал гүйцэтгэх засаглалын байгууллагын дотоодын хяналт шалгалт, захиргааны болон мэргэжлийн хяналтын арга, механизмыг хөгжүүлэхэд түлхүү анхаарч, Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаат төр, засгийн мэргэжлийн хяналтын бусад байгууллагуудын үйл ажиллагаатай уялдуулах арга хэмжээ авах.

2.11.Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийн хүрээнд төр, засгийн байгууллагуудаас Улсын Их Хуралд өгдөг мэдээллийн чанар, ач холбогдлыг өндөржүүлэх, шуурхай болгох техник, зохион байгуулалтын арга хэмжээг авах.

2.12.Улсын Их Хурлаас байгуулагдаж, түүнд ажлаа тайлагнадаг байгууллагууд /Үндэсний статистикийн газар, Төрийн хянан шалгах хороо, Үнэт цаасны хороо, Монголбанк гэх мэт/-ын үйл ажиллагааг чиглүүлэх, харилцан холбоотой ажиллах ажлын туршлагыг бусад орны практикаас судлах, дэвшилттэй зүйлийг авч нэвтрүүлэх.

2.13.Улсын Их Хурлаас улсын төвлөрсөн төсөв, төрийн мөнгөний бодлого, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг хэлэлцэн батлах, тэдгээрийн гүйцэтгэлд хяналт тавих үйл ажиллагааны зохион байгуулалтын орчин үеийн загвар, зарчмыг нэвтрүүлэх, үүх орныхоо төсөв, мөнгөний бодлогыг Парламентаас хэрхэн хянаж, батлагдаг тогтолцоог бусад орны жишээн дээр судалж, эрх зүйн үндсийг боловсронгуй болгох.

2.14.Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагаанд төрийн бүс байгуулага, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хяналтын үйл ажиллагаат илүү ил тод, нээлттэй болгох.

2.15.Улсын Их Хурал дахь цөөнхөөс Засгийн газарт тавих хяналтыг хэрэгжүүлэх нөхцөл, механизмыг бүрдүүлэх, Засгийн газарт тавих асуултын цаг бий болгох.

Стратеги зорилт 3

Улсын Их Хурал нь ардчилсан зарчимд тулгуурлан үйл ажиллагааныхаа ил тод, нээлттэй байдлыг бүх талаар хангах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.Төрийн мэдээллийн нэгдсэн **тогтолцоо**, сүлжээг бүй болгож, орчин үеийн **технологийн** үндсэн дээр найдвартай, шуурхай **байдлыг нь хангах** арга хэмжээ авах.

3.2.Улсын Их Хурлын **мэдээллийн өөөгийн** байдалд судалгаа, дүгнэлт **хийж, цаашдын** хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, **мэдээллийн** тогтолцоог боловсронгуй болгох **хэрэгцээг хангахуйц** хөтөлбөр, төсөл, арга хэмжээг **боловсруулж** хэрэгжүүлэх.

3.3.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төсөл болон Улсын Их Хурлаар батлагдсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн талаар олон нийтэд тогтмол мэдээлж байх механизмыг судлан боловсруулах.

3.4.Улсын Их Хурлын гишүүн сонгогч иргэдтэйгээ байнгын харилцаатай байх нөхцөлийг бүрдүүлж, Улсын Их Хурлын гишүүний орон нутаг дахь бие төлөөлөгч нарт сургалт зохион байгуулах, тэднийг мэдээлэл, төсөв хөрөнгө, ажлын байр, техник хэрэгслээр хангах, Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн сүлжээнд хамруулах арга хэмжээ авах.

3.5.Улсын Их Хурлын мэдээллийн сүлжээг аймаг, орон нутгийн болон төрийн бодлого боловсруулах бүх шатны байгууллагатай холбох асуудлыг шийдвэрлэх.

3.6.Парламентын олон нийтэй харилцах харилцааны өнөөгийн байдал, зохион байгуулалтад үнэлгээ хийж, цаашдын хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, илүү ил тод, нээлттэй байдлыг хангахуйц хөтөлбөр боловсруулж, төсөл хэрэгжүүлэх.

3.7.Монголын Парламентын бие даасан музей байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх, Улсын Их Хурлын үйл ажиллагааг иргэдэд сурталчлах танхим бий болгон тохижуулах.

3.8.Ерөнхий боловсролын болон их, дээд сургуулиудад зориулан Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааны талаар сургалтын программ, гарын авлага боловсруулах, сургалт явуулах.

3.9.Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаан, Байнгын хороодын хуралдааныг телевиз, радиогоор нэвтрүүлэх тусгай суваг бий болгох, улмаар Улсын Их Хуралд радио, телевизийн студи байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх.

Стратеги зорилт 4

Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлэн хөгжүүлэх, парламент хоорондын хамтын ажиллагааны үр дүнг дээшлүүлэх

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

4.1.Монгол Улсын олон тулгуурт нээлттэй, идэвхтэй гадаад бодлогын хүрээнд Парламентын гадаад харилцаа, парламент хоорондын хамтын ажиллагааг шинэ агуулга, хэлбэрээр хөгжүүлэх.

4.2.Парламент хоорондын албан ёсны харилцаа, хамтын ажиллагааны зэрэгцээ Парламентын бүлгэм, байгын хороо, гишүүд хоорондын албан болон хувийн холбоо харилцааг өргөжүүлэх, улмаар парламент, парламентын гишүүдийн хүрээнд улс орны ашиг сонирхолд нийцэх асуудлаар парламентын дипломат ажиллагааг хэрэгжүүлэх.

4.3.Монгол Улсын гадаад бодлогын үзэл баримтлалд заасны дагуу хоёр хөрш болон Америк, Европ, Ази, Номхон далайн бус нутгийн улс орнуудын Парламент хоорондын харилцааг цаашид хөгжүүлэн бэхжүүлэх, тэдгээрийн давтамжийг хадгалах.

4.4.Парламент хоорондын хоёр болон олон талт харилцаа, хамтын ажиллагаа, түүний дотор Олон Улсын Парламентын Холбоо /ОУПХ/, Ази, Номхон далайн бус нутгийн Парламентын байгууллагууд хоорондын харилцааг идэвхжүүлэх.

4.5.Бүс нутгийн зарим хурлуудыг Монгол Улсад явуулах чиг баримталж, улмаар ОУПХ-ны хурлыг ойрын 5 жилд багтаан Монгол Улсад зохион байгуулах бэлтгэл ажлыг эхлүүлэх.

Стратеги зорилт 5

Парламентын ажлын мэргэшсэн алба болох Улсын Их Хурлын Тамгын газрын үйл ажиллагааны зохион байгуулалт, үйлчилгээний арга хэлбэр, чанарыг сайжруулах

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

5.1. Улсын Их Хурлын Тамгын газрын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, бүтэц, зохион байгуулалт, бүрэлдэхүүн хэсгүүдийн чиг үүрэг, удирдах болон гүйцэтгэх ажилтан, мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолтыг боловсронгуй болгох чиглэлээр Улсын Их Хурлын Тамгын газрын бизнес төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх.

5.2.Ардчилсан парламенттай орнуудын Тамгын газрын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт болон боловсон хүчнийг үнэлж дүгнэх, сургах, давтан сургах үйл ажиллагааны чиглэлээр туршлага судлах, танилцах, дэвшилттэй зүйлийг авч нэвтрүүлэх.

5.3.Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, дотоод, гадаадад сургах богино, дунд, урт хугацааны сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх.

5.4.Улсын Их Хурлын Тамгын газарт санхүүжилтийн шинэ журам /механизм/ нэвтрүүлэх асуудлыг судлан боловсруулж хэрэгжүүлэх.

5.5.Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтнуудын ажлаас нөхцөл, бололцоог сайжруулах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 32 дугаар тогтоолын хавсралтын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын эрхлэх ажлын хүрээнд "25[1]. Хүүхдийн төлөө Үндэсний хороо" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 25 | Улаанбаатар хот

Ж.Бямбажавыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Бүрэн эрхийн нь хугацаа дуусгавар болсон тул Жанлавын Бямбажавыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүнээс чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 26 | Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын санал болгосноор Лувсандоржийн Рэнчинг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг 2002 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн дүрэм"-ийг хавсралт ёсоор батлагдсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Санхүү, эдийн засгийн сайд Ч.УЛААН

Засгийн газрын 2002 оны 54 дүгээр тогтоолын хавсралт

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмийн зорилт нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих мэргэжлийн хяналтыг нягтлан бодох бүртгэлийн улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "улсын байцаагч" гэх/ хэрэгжүүлнэ.

3. Санхүү, эдийн засгийн яам, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Монгол банк, Үндэсний татварын ерөнхий газар, Үнэт цаасны хороо, Төрийн өмчийн хороонд нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч ажиллана.

4. Нягтлан бодох бүртгэлийн улсын ерөнхий байцаагчийг Санхүү, эдийн засгийн сайдын санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө. Нягтлан бодох бүртгэлийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн эрхийг Санхүү, эдийн засгийн сайд олгоно.

5. Санхүү, эдийн засгийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, арга зүй болон төсвийн бүртгэл, орлого зарлагын гүйцэтгэлд хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийн дарга, мэргэжилтэн нь нягтлан бодох бүртгэлийн улсын ахлах байцаагч байна.

Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, эдийн засгийн бодлогын хэлтсийн нягтлан бодох бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн, Монгол банк, Үндэсний татварын ерөнхий газар, Үнэт цаасны хороо, Төрийн өмчийн хорооны бүртгэлийн ажлыг хариуцсан мэргэжилтэн нь тус тус улсын байцаагч байна.

6. Улсын ерөнхий байцаагч нь улсын ахлах байцаагч, улсын байцаагчид мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавина. Улсын ахлах байцаагч, улсын байцаагч нь улсын ерөнхий байцаагчид ажлаа тайлагнана.

7. Төсвийн ерөнхийлөн захирагч болон төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагад тавих хяналтыг улсын ахлах байцаагч хэрэгжүүлнэ.

Улсын байцаагч нь төсвийн шууд захирагч, аймаг, нийслэл, дүүргийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгж, байгууллагад тавих хяналтыг хэрэгжүүлнэ.

8. Ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагч Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

9. Улсын байцаагч нь үйл ажиллагаандаа Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт болон энэхүү дүрмийг удирдлага болгоно.

10. Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь батлэх эрх бүхий албан тушаалтнаас олгосон үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэгтэй байна. Улсын байцаагч албан шаардлага, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Нягтлан бодох бүртгэлийн хяналтыг хэрэгжүүлэх чиглэл

11. Нягтлан бодох бүртгэлийн улсын

яналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/Нягтлан бодох бүртгэлийн тухай болон Аудитын тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн талаар гарсан Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилт;

б/нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн гаргасан Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын хэрэгжилт;

в/аудитын олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн гаргасан Монгол Улсын аудитын стандартын хэрэгжилт;

г/улсын хэмжээнд нийтээр дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дүрэм, журам, зааврын хэрэгжилт;

д/санхүү, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, дүрэм, журам, зааварт нийцүүлэн аж ахуйн нэгж, байгууллагаас боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилт;

е/нягтлан бодох бүртгэлийн журнал болон анхан шатны бүртгэлийн маягтын хөтлөлт;

ж/нягтлан бодох бүртгэлийн мэдээ, тайлангийн гаргалт болон байгууллага хоорондын тооцоо нийлэлт, өр авлагын баталгаажуулалт;

з/нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг боловсруулах компьютерийн программ нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, бүртгэл тайлангийн талаар баримталж байгаа арга зүйн шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих;

и/эд хөрөнгийн тооллого хийж, тооцоо бодож байгаа байдал;

к/аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн баримт болон санхүүгийн тайланг хууль, тогтоомж болон дүрэм, журмын дагуу хадгалж байгаа байдал;

л/аж ахуйн нэгж, байгууллага хөрөнгө, өр төлбөрийг үнэлж, бүртгэлд тусгасан байдал;

м/татварын багц хуульд заасны дагуу татварын албанд гаргаж өгдөг мэдээ, тайлангийн гаргалтын байдал;

н/Үнэт цаасны тухай болон Компанийн тухай хуулийн дагуу санхүү, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг олон нийтэд хүргэж байгаа байдал.

Гурав. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагчийн эрх, үүрэг

12. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан улсын байцаагчийн нийтлэг бүрэн эрхийг эдлэхээс гадна дараахь эрхийг эдэлнэ:

а/хяналт шалгалтын ажилд шаардлагатай нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, дэлгэрэнгүй болон өрөнхий данс, санхүүгийн тайлан, нэмэлт тодруулга, мэдээ, судалгаа, лавлагаа болон бусад холбогдох баримтыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

б/хяналт шалгалтын явцад шаардлагатай гэж үзвэл эд хөрөнгийн тооллого хийлгэж, тооцоо бодуулах санал гаргах;

в/анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөхөд гарсан алдаог залруулах санал, дүгнэлт гаргах;

г/шаардлагатай үед холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр мэргэжлийн хүмүүсийг шалгалтад татан оролцуулах;

д/аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шалгах, арга зүйн зөвлөлгөө өгөх;

е/нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага ногдуулах;

ж/энэхүү дүрэмд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ акт, албан шаардлага үйлдэж, дүгнэлт гаргах;

з/биелэгдэхгүй байгаа актын талаар шүүхэд нэхэмжлэл гаргах.

13. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч нь дараахь үүрэг хүлээнэ:

а/хууль тогтоомжийг сахиж хөндлөнгийн нөлөөнд үл автан албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх;

б/аж ахуйн нэгж, байгууллага, албан

тушаалтны хуульгүй ёсны ашиг сонирхол, нэр терийг хүндэтгэх;

в/хийсэн хяналт шалгалт, гаргасан дүгнэлт, бичсэн танилцуулга, акт, тоо баримтын үндэслэл нотлогооны үнэн зөвийг хариуцах;

г/хяналт шалгалтаар гаргасан шийдвэрийнхээ биелэлтэд хяналт тавьж, түүнийг хангуулах арга хэмжээ авах;

д/хяналт шалгалт хийсэн аж ахуйн нэгж, байгууллагын талаархи мэдээллийг нууцыг хадгалах;

е/нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, арга зүйн зөвлөгөө өгөх;

ж/аж ахуйн нэгж, байгууллагын дансны тооллого хийх, нягтлан бодох бүртгэл хөтлөлтийн үзлэг хийх ажлыг зохион байгуулах, оролцох.

14. Улсын байцаагч нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан захиргааны шийтгэлийг ногдуулна.

Дерев. Бусад зүйл

15. Улсын байцаагчийн акт, албан шаардлагыг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан тогтоосон хугацаанд биелүүлж, хариуг албан ёсоор мэдэгдэнэ.

16. Улсын байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл шалгуулагч тал гомдлоо шийдвэр гарснаас хойш 10 хоногийн дотор улсын байцаагчийн шийдвэрт улсын ахлах байцаагчид, улсын ахлах байцаагчийн шийдвэрт улсын ерөнхий байцаагчид тавьж болно. Гомдлыг улсын ахлах байцаагч, улсын ерөнхий байцаагч хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

17. Улсын байцаагчийн актыг үндэслэлгүй гэж үзвэл улсын ахлах байцаагч; улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн актыг үндэслэлгүй гэж үзвэл улсын ерөнхий байцаагч үг актыг өөрчлөх буюу хүчингүй болгоно.

18. Улсын байцаагч үүрэгт ажлаа хуулийн дагуу зохих ёсоор биелүүлээгүй бол түүнд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр **Дугаар 58** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр, журам батлах тухай

Орон сууцны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Орон сууц" үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт, Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах журмыг 3 дугаар хавсралт, Орон сууц хөгжүүлэх сангаас зээл олгох журмыг 4 дүгээр хавсралт ёсоор тус тус батлагдсугай.

2. "Орон сууц" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан түүнд хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт үүрэг болгосугай.

3. Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлж, сангаас зээл олгох, түүнийг зориулалтын дагуу үр ашигтай ашиглах ажлыг зохион байгуулж хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

4. "Орон сууц" үндэсний хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Засгийн газрын 2002 оны 58 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ОРОН СУУЦ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Орон суурны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

Монгол Улсын байгуйн оршин суугч хүн ам 2000 оны 1 дүгээр сарын 5-ны байдлаар 2373.5 мянга болж, сүүлийн 10 жилд дунджаар 1.4 хувиар өсчээ. Сүүлийн 30 жилд Монгол Улсад хотжих үйл явц гүнзгийрч 2000 оны байдлаар нийт хүн амын 57 хувь нь буюу 1345.0 мянган хүн хотод, 43 хувь буюу 1028.5 мянган хүн хөдөөд амьдарч байна. Улаанбаатар хот төдийгүй хүн амын суурьшилт сийрэг, цөөн хүн амтай байсан зүүн бүс хотжилт өндөртэй бүс болж байна.

Хүн ам, орон суурны 2000 оны тооллогын дүнгээр нийт 541.1 мянган өрх тоологдсоноос ам бүлээрээ байгаа өрх 340.6 мянга, ганц бие өрх 35.4 мянга, нийлмэл өрх 150.4 мянга, холимог өрх 14.7 мянга, нэг өрхийн ам бүлийн дундаж тоо 4.3 байна.

Одоо улсын хэмжээнд 6878 мянган ам дөрвөлжин метр суурны талбай бүхий 265.5 гаруй мянган байшин суурьанд нийт хүн амын 49.1 хувь, 275.6 гаруй мянган гэр суурьанд 50.9 хувь нь амьдарч байна. Хотод нийт өрхийн 72 хувь нь, хөдөөд 22 хувь нь байшин суурьанд амьдарч, нэг хүнд ноогдох суурны талбай хотод 6.7 ам дөрвөлжин метр, хөдөөд 5.6 ам дөрвөлжин метр байгаа нь манай улсын жишиг хэмжээнээс 15-38 хувиар доогуур, олон улсын жишиг хэмжээнээс 2 дахин бага байна. Байшинд амьдарч байгаа өрхийн 81.6 хувь нь хувийн өмчлөлийн байшинд, 16.6 хувь нь улсын мэдлийн суурьанд амьдарч байхад гэрт амьдарч байгаа өрхийн 99.5 хувь нь хувийн гэрт амьдардаг байна. Монгол Улсын нийт өрхийн 67.3 хувь нь, үүний дотор хотод 94.6 хувь, хөдөөд 34.1 хувь нь цахилгаан эрчим хүчний эх үүсвэрээр хангагдсан байна.

Байшинд амьдардаг нийт өрхийн 44.4 хувь нь төвлөрсөн халаалттай байгаагийн дотор хотод 54.8 хувь, хөдөөд 2.5 хувь нь нэгдсэн халаалттай байна. Байшинд амьдардаг нийт өрхийн 39.8 хувь нь халуун, хүйтэн устай байранд амьдарч байгаагийн дотор хотод энэ үзүүлэлт 49.3 хувь, хөдөөд 1.8 хувь байна.

Орон сууцыг улсын төвлөрсөн хөрөнгө оруулалтаар голлон барьж, хүн амд үнэ төлбөргүй хуваарилан олгодог байсан тогтолцоог хэвээр үргэлжлүүлэх боломжгүй болсон. Орон сууцны салбарт дорвитой хөрөнгө оруулалт хийгдээгүй, барилгын мэргэжлийн байгууллага болон ажиллах хүч нь тарж бутарсан зэрэг шалтгааны зэрэгцээ иргэдийн амьжиргааны түвшин буурсан, ажилгүйдэл, ядуурал нэмэгдсэн байдал, хот руу чиглэсэн дотоод шилжих хөдөлгөөн ихээхэн өссөн явдал нь хүн амын орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд сөрөг нөлөө үзүүлж байна.

Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгааны дүнгээс үзэхэд хүн амын гуравны нэг орчим нь ядуу амьдарч байгаагийн дээр бодит ажилгүйдлийн түвшин 17.5 хувь болжээ.

"Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний микро түвшний судалгаа"-гаар шилжигчдийн ихэнх хувь нь залуучууд байгаа бөгөөд шилжих хэлбэрийн хувьд гэр бүлийн шилжилт давамгайлж улмаар хот, суурин газрын хүн амын тоог огцом өсгөж байгаагаас орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд мэдэгдэхүйц хүндрэл учирч байгаагийн зэрэгцээ шилжин ирэгчдийн өрхийн ахуйн нөхцөл муу байна. Судалгаагаар шилжих хүсэлтэй байгаа хүн амын олонхи нь нийслэл руу ирэх сонирхолтой байна.

Монгол Улсын нийт хүн амын 38,1 хувь нь 15-34 насны залуучууд, 5,5 хувь нь төрийн албан хаагчид байгаа бөгөөд гэр бүлтэй залуучуудын дийлэнх, төрийн албан хаагчдын 40 хувь өөрийн эзэмшлийн орон сууцгүй байна.

Хүн ам, орон сууцны 2000 оны тооллогын дүнгээс үзвэл 18 мянга шахам өрх орон сууцгүй бусад өрхтэй хамт амьдарч байгаагийн зэрэгцээ жил бүр 10 орчим мянган хос шинээр гэр бүл болж байна. Орон гэргүй орц хонгил, дулааны цооногт амьдардаг хүний тоо улсын хэмжээнд 4300 хүрэзд байна.

Орон сууцгүй дээрх өрх, иргэдийг орон сууцтай болгоход эхний ээлжинд 800 гаруй мянган ам дөрвөлжин метр суурны талбай бүхий орон сууц барих шаардлагатай байгаа бөгөөд хамгийн багаар тооцоход 150-220 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдаж байгаа нь 10 жилийн хугацаанд жил бүр

18.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардагдахаар байна.

Төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, Дундын өмчлөлийн орон сууцны тухай, Орон сууц хувьчлах тухай болон Орон сууцны тухай хуулийг батлагдан явдал эрх зүйн орчин бүрдүүлэхэд томоохон алхам боллоо. Сүүлийн жилүүдэд аж ахуйн нэгж, иргэд, төрийн бус байгууллага өөрсдийн хүч хөрөнгөөр орон сууц барих санаачилга өрнүүлэх, гадаад, дотоодын хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, хүн амын зэрийг улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар орон сууцтай болгох зэрэг ажлыг зохион байгуулж байгаа боловч нийт хүн амын дийлэнх хэсэг, түүний дотор залуу гэр бүл, төрийн албан хаагчид, хүн амын ядуу болон бага орлоготой өрх өөрсдийн хөрөнгө хүчээр орон сууц барих, худалдан авах, сууцныхаа нөхцөлийг сайжруулах боломж хязгаарлагдмал хэвээр байна.

2. Хөтөлбөр боловсруулсан үндэслэл

Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллогын дүнг үндэслэн хийсэн тооцоогоор хүн амын тоо 2010 онд /дунд хувилбараар/ 2715.5 мянгад хүрэхээр байна.

Хүн ам ойрын ирээдүйд энэ хурдцаараа өсч, насны бүтэц идэршихийн зэрэгцээ хотжих үйл явц нэлээд эрчимжих хандлага ажиглагдаж байна. Монгол орны байгаль, цаг уурын эрс тэс нөхцөл байдалд тохирсон бөгөөд хүн амын орон сууцны өсөн нэмэгдэж байгаа эрэлт хэрэгцээнд тулгуурласан, тэдгээрийг хямд төсөр орон сууцтай болоход нь төрөөс дэмжлэг үзүүлэх талаар тогтвортой бодлого явуулах шаардлагатай байна.

Иймд Монгол Улсын төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор "Орон сууц" үндэсний хөтөлбөрийг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн боловсрууллаа.

Хөтөлбөрийг дэлхий нийтийн чиг хандлага, Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулсан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, зарчим

3. Зорилго

Хот, суурин газрын хүн амыг орчин үеийн техник, технологийн болон архитектур, хот байгуулалтын зохих түвшинд инженерийн хангамж болон эдийн засгийн бодит тооцоонд тулгуурласан орчин үеийн шаардлагад нийцсэн тохилог орон сууцтай, нүүдлийн маягаар амьдардаг хүмүүст тэдний уламжлалт ахуйг зохицсон, орчин үеийн материалаар бүтээсэн гэр оронтой болоход нь дэмжлэг үзүүлэх, орлого багатай болон дундаж орлоготой хүн амын хэсэг, залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах, энэ чиглэлээр дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг хөхиүлэн дэмжихэд хөтөлбөрийн зорилго оршино.

4. Хөтөлбөрийн зорилтууд

4.1. Хүн амын орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах эрх зүйн болон эдийн засгийн орчинг бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/орон сууц хөгжүүлэх сан байгуулан, түүний мөнгөн хөрөнгийг бүрдүүлж, зарцуулах журмыг боловсруулан хэрэгжүүлэх;

б/хүн амын орон сууцны хангамжийг сайжруулах чиглэлээр төсөл боловсруулж хэрэгжүүлэх, олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах;

в/дэд бүтэц, бүс нутгийг хөгжүүлэх, ерхийн амьжиргааны чадавхийг дэмжих болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх бусад хөтөлбөрийн хүрээнд хүн амын тодорхой хэсгийг орон сууцаар хангах, орон сууцны нөхцөлийг сайжруулах арга хэмжээг уялдуулан зохицуулах;

г/орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлж, техникийн асуудлыг шийдвэрлэх;

д/гадаадын бүцалтгүй тусламжийн тодорхой хувийг хүн амын эмзэг хэсгийн орон сууцны хангамжийг сайжруулахад зориулах;

е/залуучуудын орон сууцны цогцолбор, оюутны байр,сургуулийн дотуур байр барих санаачилга, хөдөлгөөнийг хөрөнгө оруулалт, зээлийн бодлогоор дэмжих.

4.2. Хүн амын суурьшмал хэсгийн орон сууцны фондыг нэмэгдүүлэх, нүүдлийн маягаар аж төрдөг хүн амыг гэр оронтой болоход нь дэмжлэг үзүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/нийтийн зориулалттай болон цөөн ам бүлтэй өрхэд зориулсан нийтийн орон сууц барьж байгуулах;

б/аж ахуйн нэгж, байгууллагын орон сууц барих үйл ажиллагаат газар олгох, техникийн нөхцөл олгоход дэмжлэг үзүүлэх;

в/орон сууц барих иргэдэд хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээний бэлтгэл ажил хийгдсэн газрыг сонгох нөхцөл бүрдүүлэх;

г/иргэдийн хөдөлмөр, хөрөнгө, хоршин орон сууц барих хөдөлгөөнийг өрнүүлэх;

д/орон сууц, гэр, барилгын материал үйлдвэрлэх, худалдах үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн үүсгэл, санаачилгыг урамшуулах;

е/хүн амын эмзэг хэсгийн идэвх санаачилга, оролцоонд тулгуурлан хямд төсөр орон сууц барих төслийг орон сууц хөгжүүлэх сангаас санхүүжүүлэх;

ж/иргэд өөрийн хөрөнгө, хүчээр хувийн орон сууц барих, сууцныхаа нөхцөлийг сайжруулах, гэр сууцтай болох санаачилгыг дэмжиж эхний ээлжинд газар олгох;

з/дуусаагүй орон сууцны барилгыг ашиглалтад оруулахад зээл олгох;

и/хүн амд орон сууцны зориулалтаар зээл, тусламж авахад нь туслах, зөвлөгөө өгөх үйлчилгээг хөгжүүлэх;

к/аж ахуйн нэгж, байгууллагын санхүүжилтээр тухайн байгууллагын ажилтнууд болон хүн амын эмзэг хэсгийг орон сууцтай болгох үүсгэл санаачилгыг дэмжин газар олгох асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэх.

4.3. Залуу гэр бүл, төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/орон сууц хөгжүүлэх сангаас залуу гэр бүл, төрийн албан хаагчдад хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох;

б/төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагаас залуу гэр бүл, төрийн албан хаагчдын орон сууцны хангамж, нөхцөлийг сайжруулах хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэхэд нь газар олгох, техникийн нөхцөл авахад дэмжлэг үзүүлэх;

в/зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, шүүх зэрэг төрийн тусгай албаны албан хаагчдыг албаны орон сууцаар хангах арга хэмжээг хэрэгжүүлэх;

г/алслагдсан болон говь нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагч, залуучууд, мэргэжилтэй боловсон хүчний амьдралын нөхцөлийг нь сайжруулах зорилгоор орон сууцны зээлийг түлхүү олгох.

4.4. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, орон нутгийн байгаль, цаг уурын онцлог, хүн амын тоо зэргийг харгалзан нийслэл, хот, тосгоны хөгжлийн стратеги, ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хамтын хүч чармайлтыг нэгтгэн зохион байгуулна.

Хэрэгжүүлэх арга хэмжээ:

а/хүн амын худалдан авах чадвар, орон сууцны эрэлт хэрэгцээнд тулгуурлан орон сууц барих шинэ талбайг бэлтгэх, одоо байгаа гэр хорооллын нягтрал, нөхцөлийг сайжруулахад зориулан гэр, орон сууцны хороллын хэсэгчилсэн

төлөвлөгөөг бодит хэрэгцээ, нөөцөд үндэслэн хийх;

б/гудамжны гэрэлтүүлэг бүхий зам болон худаг, ус түгээх цэг рүү явган хүний зам, гүүр тавих, үерийн усны хоолойг сайжруулах зорилгоор гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах;

в/хот суурин газрын барилгажсан хэсгийн нягтрал, дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах замаар шинээр орон сууц барих;

г/гэр хорооолод агаар,ус,хөрсийг бага бохирдуулах халаалтын зуухыг эхний ээлжинд бүрэн нэвтрүүлэх, цаашид дулааны өөрийн эх үүсвэртэй, цахилгаан, ус, ариутгах татуургын нэгдсэн системтэй болгох асуудлыг судлан шийдвэрлэх;

д/шинээр барих орон сууцанд дулаан тусгаарлах өндөр чадвартай материал, хөнгөн бүтээц, эдлэхүүн хэрэглэх, шинэ техник, технологи ашиглах, уян хатан технологиор үйлдвэрлэх бүтээцийн шинэ системийг боловсруулах;

е/орчин үеийн дизайн бүхий амины орон сууцны загвар зураг, төсөл боловсруулах;

ж/хөдөлмөр эрхлэлтийн болон сургалтын байгууллагатай хамтран барилгын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх асуудлыг шийдвэрлэх;

з/хөтөлберийг хэрэгжүүлэхдээ байгаль орчин, экологийн тэнцвэрийг хангах, байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглах асуудлыг иж бүрнээр авч үзэх;

и/орон сууц барьж байгаа иргэд, байгууллагын захиалгаар цахилгаан, дулаан, ус суваг, барилга зэрэг мэргэжлийн явуулын байгууллагыг ажиллуулах асуудлыг судлан шийдвэрлэх.

5.Хөтөлберийн зарчим

Хөтөлберийг дор дурдсан үндсэн зарчмыг баримтлан хэрэгжүүлнэ:

а/Засгийн газар хүн амыг орон сууцтай болоход дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

б/төрөөс орон сууцны талаар баримтлах бодлого, энэ чиглэлээр гарсан хууль тогтоомжтой нийцүүлэх;

в/хүн амыг орон сууцаар хангах ажилд иргэд, өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, тэдгээрийн ажлын уялдаа холбоог сайжруулах;

г/санхүүгийн эх үүсвэр, зээлийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах;

д/улс, орон нутгийн хөгжлийн бодлого, хот төлөвлөлтийн ерөнхий шаардлагатай уялдуулах;

е/орон сууцны архитектурын үндэсний хэв маягийг хөгжүүлэх, барилга барих орчин үеийн техник, технологийг ашиглах;

ж/хүн ам, байгаль орчны зохицол, экологийн тэнцвэртэй байдлыг хангах;

з/ орон сууцны талаар хэрэгжүүлж байгаа төсөл, дэд хөтөлбөрүүдийг энэ хөтөлбертэй уялдуулах.

Гурав. Хөтөлберийн удирдлага, зохион байгуулалт

6. Удирдлага

Орон сууцны хангамжийг сайжруулах хөтөлберийг эдийн засаг, нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих асуудлыг Дэд бүтцийн болон Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын хамтарсан тушаалаар байгуулсан ажлын хэсэг хариуцна. Ажлын хэсэгт төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулна.

Хөтөлберийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаанд орон сууцны болон хүн амын нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын холбогдох нэгж эрхлэн явуулна.

7. Хөтөлберийг орон нутагт хэрэгжүүлэх

Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутгийн хөгжил, иргэдийн аж амьдралын байдалд зохицсон дэд хөтөлбөрийг Орон сууц үндэсний хөтөлбөртэй нийцүүлэн боловсруулж хэрэгжүүлнэ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдан зохицуулах ажлыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хариуцна. Аймаг, нийслэлд хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах орон тооны бус зөвлөлийг тухайн Засаг даргаар ахлуулан холбогдох байгууллагын төлөөлөлтэйгээр байгуулна.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

8. Хугацаа

Хөтөлбөрийг 2002-2006 онд хэрэгжүүлнэ.

9. Санхүүжилт

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараахь санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

-төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс орон сууц хөгжүүлэх санд жил бүр олгох хөрөнгө;

-аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хөрөнгө;

-гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламж, хандивын хөрөнгө;

-төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үүсгэл санаачилгаар бүрдүүлэх хандивын хөрөнгө;

-зээлийн хүү, санхүүгийн үйл ажиллагаанаас олох орлого;

-бусад эх үүсвэр.

Тав. Хөтөлбөрийн үр дүн, үнэлэлт дүгнэлт, хэрэгжилтэд тавих хяналт

10. Хөтөлбөрийн үр дүн

Төрийн захиргааны бүх шатны байгууллага, төрийн бус байгууллагын идэвхи санаачилга, гадаад орон, олон улсын байгууллагын дэмжлэг туслалцаа, иргэд, аж ахуйн нэгжийн оролцоо, хамтын хүчин чармайлтын үр дүнд хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд хүрнэ:

а/хүн амын орон сууцны хүртээмж, нөхцөл, дэд бүтцийн үзүүлэлтүүд сайжирсан байх;

б/шинээр орон сууцтай болсон залуу гэр бүлийн тоо 4500-д хүрсэн байх;

в/шинээр орон сууцтай болсон төрийн албан хаагч ерхийн тоо 2500-д, орон сууцны нөхцөлөө сайжруулсан төрийн албан хаагч ерхийн тоо 5000-д хүрсэн байх;

г/орон гэргүй хүн амын эмзэг хэсгийн 1500 иргэн орон сууцтай болсон байх;

д/Орон сууц үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд улсын төсвөөс жил бүр зохих хэмжээний хөрөнгө төлөвлөсөн байх;

е/бусийн хөгжлийн төв, аймгийн төвүүд бие даан хөгжих нөхцөл бүрдэж, ирээдүйн хот, суурины хөгжлийн үндсэн төрх бүрэлдэнэ.

11. Үр дүнг тооцох шалгуур үзүүлэлтүүд:

Хөтөлбөрийн үр дүнг дараахь шалгуур үзүүлэлтийг ашиглан 2002 оны байдлыг 2006 онтой харьцуулж үнэлж, дүгнэнэ:

а/нийт хүн амд орон сууцтай хүн амын эзлэх хувь;

б/нэг хүнд ногдох сууцны талбайн хэмжээ;

в/орон сууцны үнэ, орлогын харьцаа;

г/нэг хүнд ногдох дэд бүтцийн зардал;

д/орон сууцтай болсон залуу гэр бүлийн тоо;

е/орон сууцтай болсон, орон

сууцныхаа нөхцөлийг сайжруулсан төрийн албан хаагчдын тоо;

ж/орон сууцтай болсон хүн амын эмзэг хэсгийн иргэдийн тоо;

з/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тесвеес олгосон хөрөнгийн улсын төвлөрсөн төсвийн орлогод эзлэх хувь.

12. Хөтөлбөрийн явцад хяналт тавих

Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал, үр дүнд хяналт, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх ажлыг орон сууцны болон нийгмийн хамгаллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал хариуцсан нэгж хийнэ.

Засгийн газрын 2002 оны 58 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОРОН СУУЦ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

1. Орон сууц хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлан мэдээ гаргах журмыг батлуулах, Сангийн яамтай албыг байгуулах

2002 онд ДБЯ

2. Азийн хөгжлийн банкнаас олгож байгаа орон сууцны санхүүжилтийн 15 сая долларыг зээлийг олгож эхлэх

2002 оноос ДБЯ, Оролцогч арилжааны банкууд

3. Орон сууцны зээл, тусламж авах, төсөл хэрэгжүүлэх чиглэлээр олон улсын болон гадаад, дотоодын байгууллагатай хамтран ажиллах асуудлыг судлах

2002 оноос ДБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга

4. Төрийн албан хаагчдад улс, орон нутгийн төсвөөс орон сууцны зориулалтаар бүцалтгүй тусламж олгох асуудлыг судлах

2002 онд ДБЯ, СЭЗЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга

5. Орон сууцны зориулалтаар зээл, тусламж авахад иргэдэд туслах, зөвлөлгөө өгөх үйлчилгээ үзүүлэх

2002 оноос ДБЯ,НХХЯ, ОСХС-гийн ажлын алба

6. Төрийн албан хаагчдын орон сууцны хэрэгцээний судалгааг үндэслэн төрийн байгууллагуудад орон сууцыг зохих журмын дагуу зээлж дараатай олгох

2002 оноос, ДБЯ, НХХЯ, Орон сууц хөгжүүлэх сан(ОСХС)-гийн ажлын алба

7. Өөрийн ажилтан болон хүн амын эмзэг хэсэгт зориулан орон сууц барих санаачилга гаргасан аж ахуйн нэгж, байгууллагад урт хугацааны зээл, газрын зөвшөөрлийг эхний ээлжинд олгох

2002 оноос ДБЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОСХС-гийн ажлын алба

8. БНХАУ-ын бүцалтгүй тусламжийн хөрөнгийг төрийн албан хаагч, ахмад настанд зориулж орон сууц барихад зарцуулах асуудлыг боловсруулах

2002-2003 он ДБЯ

9. БНХАУ-ын 50.0 сая юаний хөнгөлөлттэй зээлээр баригдах 1000 айлын орон сууцыг ашиглалтад оруулах

2000-2008 он ДБЯ, Нийслэлийн Засаг дарга,"Гангаринвест" ХХК

10. Японы Засгийн газрын 1.0 сая долларын бүцалтгүй тусламжийн хөрөнгөөс гэр хорооллын иргэдэд зээл олгож эхлэх

2002 оноос ДБЯ, Төслийн ажлын алба

11. Залуучуудын орон сууцны цогцолбор, оюутны байр, аймаг, сумын төвийн сургуулийн дотуур байрыг засварлах, шинээр барихад улсын төсвөөс зохих хэмжээний хөрөнгийг жил бүр зарцуулах

2002 оноос ДБЯ, СЭЗЯ, НХХЯ, БСШУЯ

12. Цөөн ам бүлтэй өрхөд зориулсан нийтийн орон сууц барих

2003 оноос ДБЯ

13. Орон сууц барихад зориулж хот, суурин газрын ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээг бэлтгэх ажлын санхүүжилтийг судлах, шийдвэрлэх

2002 оноос ДБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга

14. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангаас орон сууц, гэрийн модон болон зөөлөн эдлэл, мөн түүнчлэн орон нутгийн түүхий эдээр барилгын материал үйлдвэрлэх, ажлын байр шинээр бий болгож байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд зээл олгох

2002 оноос ДБЯ, НХХЯ, ҮХЯ

15. Дуусаагүй барилгын хэмжээг улсын хэмжээнд тогтоож, тэдгээрээс орон сууцны зориулалтаар ашиглаж болох барилгыг ашиглалтад оруулах

2002 онд ТӨХ, ДБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга

16. Иргэдийнхээ орон сууцны хангамж түүнд шаардагдах санхүүжилт, техникийн асуудлыг шийдвэрлэж байгаа гадаад орнуудын туршлагатай танилцаж, судлах

2002 онд ДБЯ, СЭЗЯ

17. Төрийн албан хаагчдад орон сууц барихад шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын төсөвт тусгуулах

2002 оноос ДБЯ,НХХЯ,СЭЗЯ

18. Зэвсэгт хүчин, хилийн цэрэг, цагдаа, шүүх зэрэг төрийн тусгай албан хаагчдыг албаны орон сууцаар хангах дэс дараатай арга хэмжээ авах

2002 оноос ДБЯ, НХХЯ, БХЯ, ХЗДХЯ

19. Улаанбаатар, Дархан, Эрдэнэт, Зуунмод, Чойбалсан хотын барилгажсан хэсгийн нягтралыг сайжруулах

2002 оноос аймаг, нийслэлийн Засаг дарга

20. Гэр хорооллыг цэвэр, бохир усны нэгдсэн системтэй болгох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх

2002 оноос ДБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга

21. Орон сууцанд шинэ техник технологи нэвтрүүлэн, дулаан тусгаарлах өндөр чадвартай материал, хөнгөн бүтээц, эдлэхүүн хэрэглэх

2002 оноос Барилга, хот байгуулалт,нийтийн аж ахуйн газар /БХБНААГ/, Барилга архитектур корпораци

22. Амины орон сууцны орчин үеийн дизайн бүхий загвар зураг, төсөл боловсруулах

2002 оноос БХБНААГ

23. Барилгын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх

2002 оноос ДБЯ, НХХЯ

24. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ байгаль орчин, экологийн тэнцвэрийг хангах, байгалийн нөөц, баялгийг зохистой ашиглах асуудлыг иж бүрнээр авч үзэх

2002 оноос ДБЯ, БОЯ, ҮХЯ

25. Орон сууц хөгжүүлэх улсын санд төвлөрсөн төсвөөс жил бүр олгох хөрөнгийг шийдвэрлүүлэх

2002 оноос ДБЯ, СЭЗЯ

26. Орон сууц хөгжүүлэх орон нутгийн санд аймаг, нийслэлийн төсвөөс жил бүр олгох хөрөнгийг шийдвэрлүүлэх

2002 оноос аймаг, нийслэлийн Засаг дарга

27. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж цагаатгагдсан иргэд, түүний ар гэрт орон сууц олгох

2002-2004 СЭЗЯ, ДБЯ, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс

Засгийн газрын 2002 оны 58 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ОРОН СУУЦ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙГ БҮРДҮҮЛЭХ, ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ, ТАЙЛАН МЭДЭЭ ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Улсын болон орон нутгийн орон сууц хөгжүүлэх сан /цаашид "сан" гэх/-гийн зорилго нь орон сууцны санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, нөхцөлийг сайжруулах, түүний дэд бүтцийг хөгжүүлэх, шинэчлэх арга хэмжээг санхүүжүүлэхэд оршино.

2. Улсын болон орон нутгийн сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлан мэдээ гаргах, хяналт тавих үйл ажиллагаанд энэхүү журмыг дагаж мөрдөнө.

3. Сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд улсын болон орон нутгийн сангаас бүрдэнэ. Улсын сан нь орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын, орон нутгийн сан нь аймаг, нийслэлийн Засаг даргын мэдэлд байна.

4. Гадаад орон, олон улсын байгууллагаас тодорхой нөхцөл, болзолтой олгосон зээл, тусламжийн хөрөнгийг сангийн тусгай дансанд байрлуулна.

Хоёр. Сангийн удирдлага

5. Улсын сангийн төвлөрүүлэн захирагч нь орон сууцны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, орон нутгийн сангийн төвлөрүүлэн захирагч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна.

6. Сан нь орон тооны бус удирдах зөвлөлтэй байна. Сангийн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг орон сууцны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. Удирдах зөвлөлийн даргыг гишүүдээс тэдний олонхийн саналаар сонгоно.

7. Сан едөр тутмын үйл ажиллагааг эрхлэх үүрэг бүхий ажлын албатай байна. Сангийн ажлын албаны дүрэм, зардлыг сангийн төвлөрүүлэн захирагч батална.

8. Улсын сангийн ажлын алба нь орон сууцны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд, орон нутгийн сангийн ажлын алба нь тухайн орон нутгийн аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэд ажиллана.

Гурав.Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, төлөвлөлт, санхүүжилт

9. Улсын болон орон нутгийн сан нь дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

а/улсын төвлөрсөн болон аймаг, нийслэлийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

б/олон улсын байгууллага, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, зээл, тусламжийн хөрөнгө;

в/гадаад, дотоодын иргэд, хуулийн этгээдээс санд тодорхой хугацаанд ашиглуулахаар байршуулсан хөрөнгө;

г/зээлийн үйл ажиллагааны орлого;

д/үнэт цаас худалдсанаас олсон орлого;

е/бусад эх үүсвэр.

10. Улсын болон орон нутгийн санд төвлөрсөн төсвөөс тухайн жилд авах хөрөнгийн саналыг улсын сангийн ажлын алба болон аймаг, нийслэлийн Засаг дарга жил бүрийн 7 дугаар сарын 10-ны дотор орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

11. Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага төвлөрсөн төсвөөс тухайн жилд санд олгох хөрөнгийн төсвийн төслийг улсын хэмжээнд нэгтгэж, саналаа жил бүрийн 8 дугаар сарын 1-ний дотор Санхүү, эдийн засгийн яаманд хүргүүлнэ.

12. Төвлөрсөн төсвөөс санд олгох хөрөнгийн төсвийн төслийг Санхүү, эдийн засгийн яам хянаж, жил бүрийн төвлөрсөн төсвийн төлөвлөгөөнд тусгана.

13. Улсын сангийн тухайн жилийн төсвийн төсөл, сангийн хагас жилийн болон жилийн тайланг сангийн удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэн сангийн төлөөрүүлэн захирагч батална.

14. Сангийн хөрөнгийн 35 хүртэл хувийг залуу гэр бүлд, 20 хүртэл хувийг төрийн албан хаагчдад, 10 хүртэл хувийг бага, дунд орлоготой өрх, ахмад настан, хүн амын эмзэг хэсгийн орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд, 1 хүртэл хувийг сангийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхэд тус тус зарцуулахаар төлөвлөнө.

Дөрөв.Сангийн хөрөнгийн зарцуулалт

15. Улсын сангийн хөрөнгийг дор дурдсан зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна:

а/иргэд, улсын болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага орон сууц худалдан авах, шинээр барих, засах, сайжруулахад;

б/нийтийн зориулалттай орон сууцны барилгын дундын өмчлөлийн эд хөрөнгөд томоохон засвар хийх;

в/орон сууцны шинэ хороолол барих, ашиглагдаж байгаа орон сууцны болон гэр хорооллын орчны нөхцөлийг сайжруулах хэсэгчилсэн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд;

г/залуу гэр бүл, төрийн албан хаагч, хүн амын эмзэг хэсгийг хямд, чанартай барилгын материал, зураг төслөөр хангахад;

д/залуу гэр бүл, төрийн албан хаагч, хүн амын эмзэг хэсэгт зориулсан төрийн өмчийн түрээсийн орон сууц барихад.

16. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын төсөл шалгаруулах, орон сууц барих гүйцэтгэгчийг сонгох, худалдан авахтай холбогдсон харилцааг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай хуулиар зохицуулна.

17. Сан нь зохих шалгуурыг хангасан арилжааны банкаар дамжуулан зээл олгоно.

18. Зээлдэгч зээлийн баталгааг дараахь байдлаар гаргана:

а/зээлдэгч хуулийн этгээд нь үл хөдлөх хөрөнгө, баригдсан орон сууцны барилгаар баталгаа гаргах бөгөөд шаардагдах хөрөнгийн 30-аас доошгүй хувийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлэх чадвартай байна;

б/сууц өмчлөгчдийн холбоо нь сууц өмчлөгчдийн сууц өмчлөх эрхийн гэрчилгээг баталгаа болгож зээл авч болох бөгөөд гишүүдийн хүрэлцэн шийдвэрийг үндэслэн засвар үйчилгээний орлогоос тодорхой хувиар тооцож зээлийг сар бүр төлнө;

в/өрхөд олгох зээлийн баталгаа нь өрхийн жилийн орлогын мэдүүлэг, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийн гэрчилгээ байхаас гадна шинээр барих буюу худалдан авах орон сууцны үнийн 30-аас доошгүй хувьтай тэнцэх төлбөрийг тухайн өрх, иргэн төлөх чадвартай нь тогтоогдсон байна;

г/залуу гэр бүл, төрийн албан хаагч, хүн амын эмзэг хэсэгт олгох зээлийн барьцаа нь худалдан авах буюу барих орон сууц байна. Төрийн албан хаагч нь төрийн албанд 3-аас дээш жил үр бүтээлтэй ажилласан талаар тухайн байгууллагын тодорхойлолт, цаашид тогтвортой ажиллахаар уг байгууллагатай гэрээ байгуулсан байна.

19. Зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол баталгаа болгосон орон сууц, орон сууцны барилга, бусад хөрөнгө нь арилжааны банкны мэдэлд шилжинэ.

20. Сангийн хөрөнгийг энэ журмын 16-д зааснаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

Тав. Сангийн тайлан мэдээ гаргах, тавих хяналт

21. Орон нутгийн сангийн ажлын албаны санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг улирал, жилээр гарган улирлын тайланг дараа улирлын эхний сарын 5-ны дотор, жилийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор Улсын сангийн ажлын албанд ирүүлнэ.

22. Улсын сангийн ажлын алба санхүүгийн

болон үйл ажиллагааны тайланг улсын хэмжээнд нэгтгэж улирал, жилээр гарган улирлын тайланг 7 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 5-ны дотор орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

23. Орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тайланг улирал, жилээр гарган улирлын тайланг дараа улирлын эхний сарын 20-ны дотор, жилийн тайланг дараа оны 3 дугаар сарын 1-ний дотор санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

24. Сангийн хөрөнгийн зарцуулалтад санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

25. Сангийн бүртгэл, тайлан, мэдээний маягтын загварыг санхүү, эдийн засгийн болон дэд бүтцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд батална.

Зургаа. Бусад зүйл

26. Зээлийн төлбөрөө хугацаанд нь ямар нэг зөрчилгүйгээр төлж байгаа зээлдэгчийг орон сууцнаас нь албадан гаргахыг хориглоно.

27. Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, ашигласан албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2002 оны 58 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

ОРОН СУУЦ ХӨГЖҮҮЛЭХ САНГААС ЗЭЭЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Шинээр орон сууц барих, орон сууцны нөхцөлөө сайжруулах, худалдан авах, түүний дэд бүтцийг сайжруулах, орон сууцны дундын өмчлөлийн эд хөрөнгийг засварлах зориулалтаар иргэд, аж ахуйн нэгж болон нутгийн захиргааны байгууллага, сууц өмчлөгчдийн холбоодод орон сууц хөгжүүлэх сангаас зээл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Орон сууц хөгжүүлэх сангийн зээлийг арилжааны банкаар дамжуулан олгоно.

3. Зээлийн үйл ажиллагаа эрхлэх арилжааны банк дор дурдсан нөхцөлийг хангасан байна:

а/Монгол банкнаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүд, заавал байлгах нөөцийн шаардлагыг нэг жилийн турш хангасан тухай хөндлөнгийн байгууллагын дүгнэлт гаргуулсан байх;

б/зээлийн үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэлийг сангийн өмнө бүрэн хариуцахаа илэрхийлсэн баталгаа гаргаж, нотариатаар баталгаажуулсан байх;

в/зээлийн үйл ажиллагааг орон нутагт явуулах боломжтой байх.

4. Орон сууц хөгжүүлэх сангаас зээл олгох үйл ажиллагаа гүйцэтгэх арилжааны банкийг сонгох тендерийг орон сууцны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зарлан явуулж, энэ журмын 3 дугаар зүйлд заасан нөхцөлийг хангасан арилжааны банкийг сонгон шалгаруулна.

5. Тендерт шалгарсан арилжааны банктай байгуулах гэрээний загварыг орон сууцны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6. Тухайн үеийн мөнгөний ханш, инфляцын түвшин, зээлийн эргэн төлөлтийн болон хөрөнгө оруулалтын өөрчлөлттэй уялдуулан зээлийн хүүгийн хэмжээг өөрчлөх саналыг орон сууцны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

7. Орон сууц хөгжүүлэх сангийн ажлын алба нь тендерт шалгарсан арилжааны банктай зээлийн үйл ажиллагааг эрхлүүлэх талаар гэрээ байгуулан ажилтан бөгөөд гэрээнд дараахь асуудлыг тусгасан байна:

а/талуудын эрх, үүрэг, хариуцах албан тушаалтан;

б/тухайн арилжааны банкинд байршуулсан зээлийн санд уг банкнаас олгох хүүгийн хэмжээ;

в/эцсийн зээлдэгчид олгох зээлийн хэмжээ, хүү, хугацаа;

г/сангийн хөрөнгөд тавих хяналт;

д/хөрөнгийг эргүүлэн татах нөхцөл;

е/хамтран ажиллах нөхцөл;

ж/гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаа;

з/гэрээг цуцлах нөхцөл.

8. Гэрээг нотариатаар баталгаажуулна.

Хоёр. Зээл олголт ба түүний үндсэн нөхцөл

9. Зээлдэгч арилжааны банкнаас орон сууцны зээл олгоход шаардагдах баримт бичиг бүрдүүлэн зээл авах хүсэлтээ тухайн арилжааны банкинд гаргана.

10. Зээлийн хэмжээ нь шинээр барих, худалдан авах орон сууцны өртгийн 70 хувиас илүүгүй байна.

11. Арилжааны банк зээл хүссэн баримт бичгийг судлан үзэзд шаардлага хангасан зээлдэгчийн хэрэгцээт зээлийн хэмжээг багцлан сангийн ажлын албанд ирүүлнэ. Зээлийн багц 100-500 сая төгрөгийн хооронд байна.

12. Сангийн ажлын алба банкуудаас ирүүлсэн зээлийн багцыг судлан үзэж ажлын 10 хоногийн дотор олгох зээлийн хэмжээг тодорхойлон шийдвэр гаргана.

13. Арилжааны банк ажлын 20 хүртэл хоногийн дотор зээлдэгчийн хүсэлтийг хүлээн авч барагдуулна.

14. Сангаас олгох зээлийн хугацаа залуу гэр бүл, терийн албан хаагчид, хүн амын эмзэг хэсэгт 15 хүртэл жил, иргэд, хуулийн этгээдэд 7 хүртэл жил,нутгийн захиргааны байгууллагад 20 хүртэл жил байна.

15. Зээлийн чөлөөт хугацаа нь 6 хүртэл сар байж болно.

16. Зээлийн санхүүжилтийг баригдаж байгаа орон сууцны барилгын ажлын гүйцэтгэлээр үе шаттайгаар олгоно.

17. Зээлийн хөрөнгийг зориулалтын бус зүйлд зарцуулах, өөр хүний нэр дээр олгох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэн, өрөвд давхардуулж олгохыг хориглоно.

Гурав. Зээл олгох үйл ажиллагаанд тавих хяналт

18. Арилжааны банк, зээлдэгчдийн хооронд байгуулсан гэрээний биелэлтэд сангийн ажлын алба хяналт тавина.

19. Зээлдэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу зээлээ хугацаанд нь төлөөгүйгээс үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Дугаар 59 Улаанбаатар хот

"Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлберийг хавсралт ёсоор батлсугай.

2. Үндэсний хөтөлберийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2003 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөвт тусгаж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд П.Нямдавааа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Үндэсний хөтөлберийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн П улиралд Засгийн газарт мэдээлж байхыг Эрүүл мэндийн сайд П.Нямдавааг даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

Засгийн газрын 2002 оны 59 дүгээр тогтоолын хавсралт

"СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНД" ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Сэтгэцийн эрүүл мэндийн дэлхий дахины чиг хандлага, үндэсний хөтөлбөр боловсруулах шаардлага,үндэслэл

Өнөөгийн байдлаар дэлхийн 5 хүн тутмын 1 нь амьдралынхаа хугацаанд сэтгэцийн ямар нэг эмгэгт нэрвэгдэж байгаагаас гадна хөдөлмөрийн чадвар алдсан 2 тохиолдол бүрийн нэг нь сэтгэцийн эмгэг байна.

Дэлхийн хэмжээнд 1998 онд бүртгэгдсэн нийт өвчлөлийн 11 хувийг сэтгэц, зан үйлийн эмгэг эзэлж байсан бол энэ нь 2020 онд 15 хувь болж нэмэгдэх магадлал байгаа тухай Дэлхийн эрүүл мэндийн байгууллага мэдээлсэн байна.

Манай улсын багтаж байгаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын Номхон далайн бүрүүн бүсийн нийт хүн амын өвчлөлд сэтгэцийн эмгэг өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь бүсийн хөгжингүй орнуудад 27, хөгжиж буй орнуудад 15 хувьтай байна.

Хөгжиж буй орнуудад халдварт болон эх, хүүхдийн өвчин, хоол тэжээлийн асуудал нь өвчлөл, нас баралтын гол шалтгаан болж байгаа хэдий ч сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал, сэтгэцийн эмгэг цаашид улам нэмэгдэх хандлагатай байгаа юм.

Түүнчлэн сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлуудын нэг болох сэтгэл гутрал нь 1998 онд хүн амын эрүүл мэндийн байдалд сөргөөр нөлөөлөгч 4 дэх хүчин зүйл байсан бол 2020 онд 2 дох гол хүчин зүйл болно гэж судлаачид үзжээ.

Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас сэтгэцийн эмгэгтэй нийт хүмүүсийн 60–95 хувь нь ерхийн эмнэлгээр үйлчлүүлж байгааг тогтоосон бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийг ерхийн эмнэлгээр үзүүлэх асуудалд онцгой анхаарч байгаа юм.

Иймээс Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын 2001 оны эзлэхит чуулган сэтгэцийн эрүүл мэндийн асуудлыг онцлон авч үзэж, ойрын жилүүдийн үйл ажиллагааныхаа гол чиглэл болгохыг зөвлөсөн үриалгыг гишүүн орнуудаа хандан гаргаснаас гадна Номхон далайн бүрүүн бүсийн хорооны 52 дугаар чуулганаас тус бүсийн "Сэтгэцийн эрүүл мэндийн стратеги"-ийг батлан байна.

"Нийгмийн эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого", Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт эрүүл мэндийн үйлчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын чанарыг олон улсын стандартын түвшинд хүргэхээр дэвшүүлсэн зорилтыг хангахын тулд сэтгэцийн эрүүл мэндийн дэлхий нийтийн шинэ чиглэл, хандлагад нийцүүлэн манай улсын сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор "Сэтгэцийн эрүүл мэнд" үндэсний хөтөлбөрийг боловсруулав.

Хоёр. Монгол Улсын хүн амын сэтгэцийн эрүүл мэндийн байдал, тулгамдсан асуудал

2.1. Сэтгэцийн эрүүл мэндийн өнөөгийн байдал

Манай улсын нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарсан өөрчлөлт, шинэчлэлтийн явцад хүн амын нэлээд хэсгийн амьжиргааны болон хөдөлмөр эрхлэх боталгаа алдагдсан нь олон жилийн турш нийгмийн зүгээс бүхнийг зохицуулан, тэгшитгэн хуваарилж байснаас хэт бэлэнчлэх сэтгэлгээтэй болсон хүн амын сэтгэл зүйд хүчтэй нөлөө үзүүлсэн юм.

Түүнчлэн эдийн засгийн сул дорой байдал, ядуурал, ажилгүйдэл нэмэгдсэнтэй холбоотойгоор үүссэн зарим хүндрэл, бэрхшээлээс шалтгаалан гэмт хэрэг, архидалт, хүчирхийлэл, хэвл хахууль, биеэ үнэлэх зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд их хэмжээгээр гарах болсон нь хүн амын дундах бухимдал, гутрал, айдас түгшүүрийг нэмэгдүүлж, сэтгэцийн эмгэгийг ихээхэн эрсдэлийг бий болгож, зарим тохиолдолд амиа хорлох, ийм оролдлого хийх хүртэл нөхцөл үр дагаварт хүргэж байна.

Энэ бүхэн нь сэтгэцийн эрүүл мэндийн эмнэлэгт тулгуурлаж байсан тусламж, үйлчилгээг нийгэм-хамт олонд тулгуурласан шинэ тогтолцоонд шилжүүлэх, сэтгэцийн болон зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх ажилд онцгой анхаарах, хүн амын сэтгэцийн эрүүл мэндэд шууд нөлөөлж байгаа нийгэм, орчны сөрөг хүчин зүйлийг багасгах, арилгах, мэргэжлийн байгууллага, мэргэжилтний чадавхийг дээшлүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжихэд олон нийт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, гаднын дэмжлэг, туслалцаа авах зэрэг олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай болсныг харуулж байна.

Улсын Их Хурлаас 2000 онд Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг батлан гаргасан нь

сэтгэцийн эрүүл мэндийн нийтлэг тусламж, үйлчилгээг зохион байгуулах, сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх тусламжийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм.

2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд

2.2.1. Сэтгэцийн эмгэгийн тархалт нэмэгдсээр байна:



Монгол Улсын хүн амын дунд сэтгэцийн өвчний түвшинг тогтоох зорилгоор 1976–1984 онуудад хийсэн тархвар судалгаагаар 1000 хүн амд ногдох сэтгэцийн өвчний тархалт Хангай, Хэнтийн уулархаг мужид 13.1, Дорнодын талархаг их мужид бүюу хээрийн бүсэд 18.3, Алтайн уулархаг их мужид 9.8, Говийн их муж бүюу Говийн бүсэд 23.5, нийслэл Улаанбаатарт 24 байсан байна.

Түүнчлэн 1989–2000 оны хооронд амиа хорлох явдал 5 дахин ихэсч, 100000 хүн амд 17 тохиолдол ногдох болсон нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр үзүүлэлт юм.

2.2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоо боловсронгуй бус байна:

Өнөөгийн байдлаар манай улсад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Сэтгэцийн эмгэг, мансуурал судлалын төв, Сэтгэцийн клиникийн эмнэлэг, Маанытын хөдөлмөр эмчилгээ, асрамжийн газар, Толгойтын наркологийн эмнэлэг зэрэг байгууллагууд үзүүлж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эдгээр мэргэжлийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт боловсронгуй бус сумын болон өрхийн эмч, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн кабинетууд, холбогдох бусад байгууллагатай ажиллах хамтын ажиллагаа хангалттүй байна.

Сэтгэцийн болон архинд донтох өвчний эмчилгээ, нөхөн сэргээлт, нийгмийн халамжийн зориулалтаар төрийн эүгээс жилд зарцуулж буй хөрөнгийн 90 орчим хувь нь зөвхөн ор бүхий эмнэлгийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байна.

Манай улсад 1997-1999 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн "Үндэстнүүд-сэтгэцийн эрүүл мэндийн төлөө" төслийн хүрээнд сум, өрхийн эмнэлгийн түвшинд сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ажил зохиогдон боловч хамралт, эцсийн үр дүн нь хангалттүй байна.

Иймээс нийгэм-хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд жигд, хүртээмжтэй үзүүлэхүйц тогтолцоог бий болгож, үйл ажиллагааг нь тогтворжуулах, чадавхийг нь бэхжүүлэх шаардлага гарч байна.

2.2.3. Мэргэжлийн боловсон хүчний нөөц хангалттүй, тэдний мэдлэг, чадвар сул байна:

Өнөөгийн байдлаар манай улсад сэтгэцийн нарийн мэргэжлийн эмч нар хүрэлцэхгүй байна. Мөн энэ чиглэлээр нийт ажилагсдын 90 гаруй хувийг 1970-1980 онд бэлтгэгдсэн боловсон хүчин эзэлж байгаа бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийн шинэ хандлага болох нийгэм-хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадвар, дадлага дутагдаж байна.

Анагаах ухааны их сургуулийн сэтгэцийн эрүүл мэндийн сургалтын хичээлийн агуулга, хөтөлбөр орчин үеийн шинэ хандлагын жишээр боловсронгуй болж чадаагүй, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах асуудал бүрэн шийдэгдээгүй байна.

2.2.4. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдээгүй байна:

Байгууллага,хамт олон, гэр бүлээс гишүүдийнхээ сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэх талаархи мэдлэг, ойлголт хангалтгүй, ерөнхий боловсролын сургуулиудад хөтөлбөрийн дагуу орж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт эхлэл төдий байна.

Нийгэм, ахуйн орчноос хүн амын сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөгч сөрөг хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, удаан хугацааны давамгайлсан ор бухий эмнэлэгт суурилсан тусламж, үйлчилгээнээс нийгэм, хамт олон, гэр бүл болон хувь хүнд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шилжих, түүнийг дэмжих орчин бүрдүүлэх нь манай улсын хувьд тулгамдсан асуудал болоод байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

3.1. Хөтөлбөрийн зорилго:

Хөтөлбөрийн зорилго нь сэтгэцийн эрүүл мэндийн шинэ хандлага, чиглэлд нийцүүлэн өөрийн орны сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг өөрчлөн сайжруулах замаар одоогийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хүн амын дундах сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн тархалтыг бууруулахад оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилт:

3.2.1. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх.

3.2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг сайжруулах.

3.3. Хэрэгжүүлэх хугацаа:

Уг хөтөлбөрийг 2002–2007 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах стратеги

4.1. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх зорилтод хүрэх стратеги:

4.1.1. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаархи ухуулга, сурталчилгааг бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хүргэж зохион байгуулснаар тухайн асуудалд хандах төр, олон нийтийн анхаарлыг нэмэгдүүлж, салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоог сайжруулах;

4.1.2. Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны нэгдсэн стратеги боловсруулж хэрэгжүүлэх, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах талаар хүн амын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, тэдэнд шинэ хандлага, дадал эзэмшүүлэх;

4.1.3. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд олон нийт, хамт олны оролцоог нэмэгдүүлэх.

4.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг сайжруулах зорилтод хүрэх стратеги:

4.2.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багцад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оруулж сумын болон өрхийн эмчийн түвшинд уг тусламж, үйлчилгээг үзүүлэх тогтолцоонд шилжих;

4.2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

4.2.3. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орчин үеийн чиг хандлагад нийцсэн стандарт боловсруулан мөрдүүлэх;

4.2.4. Ерөнхий мэргэжлийн болон сэтгэцийн нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг орчин үеийн жишиг нийцүүлэн боловсронгуй болгох;

4.2.5. Сэтгэцийн эрүүл мэндийн

үзүүлэлтүүдийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэх;

4.2.6. Хүний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөгч хүчин зүйлийн талаархи судалгааны ажлыг өргөжүүлэх.

Тав. Хөтөлберийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

5.1. Хөтөлберийн удирдлага, зохион байгуулалт

5.1.1. Үндэсний хэмжээнд уг хөтөлберийг эрүүл мэндийн бусад хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх, удирдан зохицуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл хариуцна.

5.1.2. Хөтөлберийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангах, хяналт тавих ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгуллага болон Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн зөвлөл мэргэжлийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

5.1.3. Орон нутагт хөтөлберийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. Хөтөлберийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн салбар зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулан ажиллуулж болно.

5.1.4. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгуллага нь хөтөлберийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл, Засгийн газарт тайлагнаж байна.

5.2. Хөтөлберийн санхүүжилт

Хөтөлберийн санхүүжилт нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн хандив, тусламжийн хөрөнгөөс бүрдэнэ.

Зургаа. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо

6.1. Төрийн захиргааны төв байгуллага

6.1.1. Эрүүл мэндийн яам:

6.1.1.1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

6.1.1.2. Өрхийн болон сумын эмнэлэгт үзүүлэх суурь тусламж, үйлчилгээний багцад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оруулах асуудлыг шийдвэрлэх, үүнтэй холбогдсон сургалтыг зохион байгуулах;

6.1.1.3. Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн талаар мэдлэг, хандлага, дадал төлөвшүүлэхэд чиглэгдсэн албан бус зайны сургалтын хөтөлберийг холбогдох яам, газруудтай хамтран боловсруулж хэрэгжүүлэх;

6.1.1.4. Хөтөлберийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачилга, хамтын ажиллагааг дэмжих;

6.1.1.5. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх;

6.1.1.6. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт боловсруулж, үйлчилгээг боловсронгуй болгох;

6.1.1.7. Хүн амын сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх;

6.1.1.8. Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөлгөө өгөх, сэтгэц, оюуны алжаал тайлах, эмчилгээ, сувилгааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.1.1.9. Хөтөлберийг хэрэгжүүлэх үйл ажиллагаат Засгийн газрын болон олон улсын байгууллага, хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлж байгаа бусад хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан хамтран ажиллах замаар хөтөлберийн үр дүнг дээшлүүлэх.

6.1.2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам:

6.1.2.1. Бүх шатны суралцагсдад сэтгэцийн эрүүл мэнд, амьдрах ур чадварын мэдлэг эзэмшүүлэх асуудлаар эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөр,төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.2.2. Бүх шатны боловсролын байгууллагуудад сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.1.2.3. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр боловсон хүчнийг мэргэшүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээ авах.

6.1.3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам:

6.1.3.1. Сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

6.1.3.2. Ажлын байрны стрессийг багасгах, тахир дутуу болон нийгмийн эмзэг бүлэгт хамрагдаж байгаа ажилтныг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах чиглэлээр ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх.

6.1.4. Санхүү, эдийн засгийн яам:

6.1.4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажилlaгааны зардалд шаардагдах хөрөнгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалга, тооцоог үндэслэн хянан шийдвэрлэж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж байх;

6.1.4.2. Хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын байгууллага, хандивлагчидтай хамтран дэд хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар дэмжлэг үзүүлэх.

6.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

6.2.1. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

6.2.2. Хөтөлбөрийн бодлого, чиглэлд нийцүүлэн өөрийн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн дэд хөтөлбөр боловсруулан батлаж хэрэгжүүлэх;

6.2.3. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжиг байгуулага, хамт олны хөдөлгөөн өрнүүлэх, хамрагдагсдад дэмжлэг үзүүлэх, төдийг сурталчлах, урамшуулах арга хэмжээ авах;

6.2.4. Харьяа байгууллагын үйл ажиллагаагдүгнэхдээ ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар хийсэн ажлыг нэг үзүүлэлт болгон үнэлж байх.

6.3. Хэвлэл, мэдээллийн байгууллага:

Нийтлэл нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөртөө хүн амын эрүүл мэнд, түүний дотор сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн зөв зан үйлийг иргэдэд эзэмшүүлэхэд чиглэсэн мэдээ,мэдээлэл, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

6.4. Аж ахуйн нэгж, байгууллага:

6.4.1. Эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг тооцож жил бүрийн төсөвтөө тусгаж, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашгийг тооцож хэвших;

6.4.2. Ажиллагсдын эрүүл мэндийг бэжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохиох, энэ талаар амжилт олж байгаа нэгж, ажилтанг дэмжих, сурталчлах, тодорхой урамшуулал бий болгох;

6.4.3. Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд хамт олноороо идэвхтэй оролцох;

6.4.4. Ажлын байранд хүний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, бухимдал, сэтгэл гутрал, айдас түгшүүр бий болгох орчин, нөхцөл бүрдүүлж байгаа хүчин зүйлийг арилгаж, байгууллага, хамт олны дотор эерэг уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж ажиллах.


сэтгэцийн эрүүл мэндийн нийтлэг тусламж, үйлчилгээг зохион байгуулах, сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх тусламжийн эрх зүйн үндсийг бүрдүүлсэн юм.

2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлууд

2.2.1. Сэтгэцийн эмгэгийн тархалт нэмэгдсээр байна:

кабинетууд, холбогдох бусад байгууллагатай ажиллах хамтын ажиллагаа хангалттүй байна.

Сэтгэцийн болон архинд донтох өвчний эмчилгээ, нөхөн сэргээлт, нийгмийн халамжийн зориулалтаар төрийн зүгээс жилд зарцуулж буй хөрөнгийн 90 орчим хувь нь зөвхөн ор бүхий эмнэлгийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулагдаж байна.



Монгол Улсын хүн амын дунд сэтгэцийн өвчний түвшинг тогтоох зорилгоор 1976–1984 онуудад хийсэн тархвар судалгаагаар 1000 хүн амд ногдох сэтгэцийн өвчний тархалт Хангай, Хэнтийн уулархаг мужид 13.1, Дорнодын талархаг их мужид бүюу хээрийн бүсэд 18.3, Алтайн уулархаг их мужид 9.8, Говийн их муж буюу Говийн бүсэд 23.5, нийслэл Улаанбаатарт 24 байсан байна.

Түүнчлэн 1989–2000 оны хооронд амиа хорлох явдал 5 дахин ихэсч, 100000 хүн амд 17 тохиолдол ногдох болсон нь дэлхийн дунджаас 2 дахин өндөр үзүүлэлт юм.

2.2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоо боловсронгуй бус байна:

Өнөөгийн байдлаар манай улсад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Сэтгэцийн эмгэг, мансуурал судлалын төв, Сэтгэцийн клиникийн эмнэлэг, Маанытын хөдөлмөр эмчилгээ, асрамжийн газар, Толгойтын наркологийн эмнэлэг зэрэг байгууллагууд үзүүлж байна. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг эдгээр мэргэжлийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт боловсронгуй бус сумын болон өрхийн эмч, аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн мэргэжлийн

Манай улсад 1997-1999 онд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн "Үндэстнүүд-сэтгэцийн эрүүл мэндийн төлөө" төслийн хүрээнд сум, өрхийн эмнэлгийн түвшинд сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ үзүүлэх ажил эхэлсэн боловч хамралт, эцсийн үр дүн нь хангалттүй байна.

Иймээс нийгэм-хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амд жигд, хүртээмжтэй үзүүлэхүйц тогтолцоог бий болгож, үйл ажиллагааг нь тогтворжуулах, чадавхийг нь бэхжүүлэх шаардлага гарч байна.

2.2.3. Мэргэжлийн боловсон хүчний нөөц хангалттүй, тэдний мэдлэг, чадвар сул байна:

Өнөөгийн байдлаар манай улсад сэтгэцийн нарийн мэргэжлийн эмч нар хүрэлцэхгүй байна. Мөн энэ чиглэлээр нийт ажиллагсдын 90 гаруй хувийг 1970-1980 онд бэлтгэгдсэн боловсон хүчин эзэлж байгаа бөгөөд сэтгэцийн эрүүл мэндийн шинэ хандлага болох нийгэм-хамт олонд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх мэдлэг, чадвар, дадлага дутагдаж байна.

Анагаах ухааны их сургуулийн эрүүл мэндийн сургалтын хичээлийн агуулга, хөтөлбөр орчин үеийн шинэ хандлагын жишээр боловсронгуй болж чадаагүй, энэ чиглэлээр мэргэжилтэн бэлтгэх, давтан сургах асуудал бүрэн шийдэгдээгүй байна.

2.2.4. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдээгүй байна:

Байгууллага,хамт олон, гэр бүлээс гишүүдийнхээ сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэц-нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг зохистой шийдвэрлэх талаархи мэдлэг, ойлголт хангалтгүй, ерөнхий боловсролын сургуулиудад хөтөлбөрийн дагуу орж байгаа сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт эхлэл тэдий байна.

Нийгэм, ахуйн орчноос хүн амын сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөгч сөрөг хүчин зүйлсийн нөлөөллийг багасгах, удаан хугацаанд давамгайлсан ор бүхий эмнэлэгт суурилсан тусламж, үйлчилгээнээс нийгэм, хамт олон, гэр бүл болон хувь хүнд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд шилжих, түүнийг дэмжих орчин бүрдүүлэх нь манай улсын хувьд тулгамдсан асуудал болоод байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа

3.1. Хөтөлбөрийн зорилго:

Хөтөлбөрийн зорилго нь сэтгэцийн эрүүл мэндийн шинэ хандлага, чиглэлд нийцүүлэн өөрийн орны сэтгэцийн эрүүл мэндийн тусламжийг өөрчлөн сайжруулах замаар одоогийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, хүн амын дундах сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн тархалтыг бууруулахад оршино.

3.2. Хөтөлбөрийн зорилт:

3.2.1. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх.

3.2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг сайжруулах.

3.3. Хэрэгжүүлэх хугацаа:

Уг хөтөлбөрийг 2002–2007 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхэд баримтлах стратеги

4.1. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх зорилтод хүрэх стратеги:

4.1.1. Сэтгэцийн эрүүл мэндийн асуудлаархи ухуулга, сурталчилгааг бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд хүргэж зохион байгуулснаар тухайн асуудалд хандах төр, олон нийтийн анхаарлыг нэмэгдүүлж, салбар хоорондын хамтын ажиллагаа, оролцоог сайжруулах;

4.1.2. Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааны нэгдсэн стратеги боловсруулж хэрэгжүүлэх, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах талаар хүн амын мэдлэг, чадварыг дээшлүүлэх, тэдэнд шинэ хандлага, дадал эзэмшүүлэх;

4.1.3. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд олон нийт, хамт олны оролцоог нэмэгдүүлэх.

4.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг сайжруулах зорилтод хүрэх стратеги:

4.2.1. Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багцад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оруулж сумын болон өрхийн эмчийн түвшинд уг тусламж, үйлчилгээг үзүүлэх тогтолцоонд шилжих;

4.2.2. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, холбогдох байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах;

4.2.3. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний орчин үеийн чиг хандлагад нийцсэн стандарт боловсруулан мөрдүүлэх;

4.2.4. Ерөнхий мэргэжлийн болон сэтгэцийн нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг орчин үеийн жишиг нийцүүлэн боловсронгуй болгох;

4.2.5. Сэтгэцийн эрүүл мэндийн

үзүүлэлтүүдийн бүртгэл, мэдээллийн тогтолцоог шинэчлэх;

4.2.6. Хүний сэтгэцийн эрүүл мэндэд сергөөр нөлөөлөгч хүчин зүйлийн талаархи судалгааны ажлыг өргөжүүлэх.

Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

5.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1.1. Үндэсний хэмжээнд уг хөтөлбөрийг эрүүл мэндийн бусад хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан хэрэгжүүлэх, удирдан зохицуулах, салбар хоорондын хамтын ажиллагааг хангах үүргийг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл хариуцна.

5.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг мэргэжлийн удирдлага, зохицуулалт, мэдээллээр хангах, хяналт тавих ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн зөвлөл мэргэжлийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

5.1.3. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулах, зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг бүх шатны Засаг дарга, мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, гүйцэтгэлд хяналт тавих үүрэг бүхий орон нутгийн салбар зөвлөлийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулан ажиллуулж болно.

5.1.4. Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь хөтөлбөрийн хүрээнд үндэсний болон орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг Нийгмийн эрүүл мэндийн Үндэсний зөвлөл, Засгийн газарт тайлагнаж байна.

5.2. Хөтөлбөрийн санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт нь улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, олон улсын байгууллага, гадаад, дотоодын төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хамт олон, иргэдийн хандив, тусламжийн хөрөнгөөс бүрдэнэ.

Зургаа. Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо

6.1. Төрийн захиргааны төв байгууллага

6.1.1. Эрүүл мэндийн яам:

6.1.1.1. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ хариуцсан байгууллагуудын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох;

6.1.1.2. Өрхийн болон сумын эмнэлэгт үзүүлэх суурь тусламж, үйлчилгээний багцад сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг оруулах асуудлыг шийдвэрлэх, үүнтэй холбогдсон сургалтыг зохион байгуулах;

6.1.1.3. Хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн талаар мэдлэг, хандлага, дадал төлөвшүүлэхэд чиглэгдсэн албан бус зайны сургалтын хөтөлбөрийг холбогдох яам, газруудтай хамтран боловсруулж хэрэгжүүлэх;

6.1.1.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн оролцоо, идэвх санаачилга, хамтын ажиллагааг дэмжих;

6.1.1.5. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээ, сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг нэмэгдүүлэх;

6.1.1.6. Сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандарт боловсруулж, үйлчилгээг боловсронгуй болгох;

6.1.1.7. Хүн амын сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн судалгаа явуулахад дэмжлэг үзүүлэх;

6.1.1.8. Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөлгөө өгөх, сэтгэц, оюуны алжаал тайлах, эмчилгээ, сувилгааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.1.1.9. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг Засгийн газрын болон олон улсын байгууллага, хамтын ажиллагааны шугамаар хэрэгжүүлж байгаа бусад хөтөлбөр, төслүүдтэй уялдуулан хамтран ажиллах замаар хөтөлбөрийн үр дүнг дээшлүүлэх.

6.1.2. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам:

6.1.2.1. Бүх шатны суралцагсдад сэтгэцийн эрүүл мэнд, амьдрах ур чадварын мэдлэг эзэмшүүлэх асуудлаар эрүүл мэндийн боловсролын сургалтын хөтөлбөр,төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, боловсронгуй болгох арга хэмжээ авч, хэрэгжилтийг зохион байгуулах;

6.1.2.2. Бүх шатны боловсролын байгууллагуудад сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

6.1.2.3. Сэтгэцийн эрүүл мэндийн чиглэлээр боловсон хүчнийг мэргэшүүлэх, мэргэжлийг дээшлүүлэх арга хэмжээ авах.

6.1.3. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам:

6.1.3.1. Сэтгэцийн өвчтэй хүмүүст үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй уялдуулан зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;

6.1.3.2. Ажлын байрны стрессийг багасгах, тахир дутуу болон нийгмийн эмзэг бүлэгт хамрагдаж байгаа ажилтныг ялгаварлан гадуурхах явдлыг арилгах чиглэлээр ажлын байранд сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар дэд хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх.

6.1.4. Санхүү, эдийн засгийн яам:

6.1.4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардалд шаардагдах хөрөнгийг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын захиалга, тооцоог үндэслэн хянан шийдвэрлэж, жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж байх;

6.1.4.2. Хөтөлбөрийн хүрээнд гадаад, дотоодын байгууллага, хандивлагчидтай хамтран дэд хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар дэмжлэг үзүүлэх.

6.2. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

6.2.1. Хөтөлбөрийг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;

6.2.2. Хөтөлбөрийн бодлого, чиглэлд нийцүүлэн өөрийн орон нутгийн онцлог, тулгамдсан асуудалд тулгуурласан сэтгэцийн эрүүл мэндийн дэд хөтөлбөр боловсруулан батлах хэрэгжүүлэх;

6.2.3. Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжигч байгууллага, хамт олны хөдөлгөөн өрнүүлэх, хамрагдагсдад дэмжлэг үзүүлэх, төдийг сурталчлах, урамшуулах арга хэмжээ авах;

6.2.4. Харьяа байгууллагын үйл ажиллагааг дүгнэхдээ ажиллагсдын эрүүл мэндийг хамгаалах, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих талаар хийсэн ажлыг нэг үзүүлэлт болгон үнэлж байх.

6.3. Хэвлэл, мэдээллийн байгууллага:

Нийтлэл нэвтрүүлгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөртөө хүн амын эрүүл мэнд, түүний дотор сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн зөв зан үйлийг иргэдэд эзэмшүүлэхэд чиглэсэн мэдээ,мэдээлэл, сургалт, сурталчилгааг нэмэгдүүлэх арга хэмжээ авах.

6.4. Аж ахуйн нэгж, байгууллага:

6.4.1. Эрүүл мэндийг дэмжих, сэтгэцийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах арга хэмжээнд зарцуулах хөрөнгийг тооцож жил бүрийн төсөвтөө тусгаж, эрүүл мэндийн болон эдийн засгийн үр ашгийг тооцож хэвших;

6.4.2. Ажиллагсдын эрүүл мэндийг бэхжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалт, сурталчилгаа зохиох, энэ талаар амжилт олж байгаа нэгж, ажилтанг дэмжих, сурталчлах, тодорхой урамшуулал бий болгох;

6.4.3. Эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд зохион байгуулагдаж байгаа арга хэмжээнд хамт олнооро идэвхтэй оролцох;

6.4.4. Ажлын байранд хүний сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, бухимдал, сэтгэл гутрал, айдас түгшүүр бий болгох орчин, нөхцөл бүрдүүлж байгаа хүчин зүйлийг арилгаж, байгууллага, хамт олны дотор эерэг уур амьсгал, сэтгэл зүйн таатай орчин бүрдүүлж ажилах.

6.5. Иргэд, олон нийтийн оролцоо:

6.5.1. Гэр бүл, хамт олны дотор харилцан бие биеэ хүндэтгэсэн, харилцан ойлголцсон, хүчирхийлэл, сэтгэлийн дарамтаас ангид орчин бий болгохыг эрмэлзэх;

6.5.2. Хүн бүр эрүүл мэндээ эрхэмлэж, өөрийн болон бусдын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл аж төрөх зан үйлийг өөрийн амьдралын дадал хэвшил болгохын төлөө ажиллаж, амьдрах;

6.5.3. Иргэн бүр сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөөлөх хорт зуршилд автагдах, архи, тамхи, мансууруулах бодис хэрэглэхээс зайлсхийх, бухимдлаас өөрийгөө хамгаалж, тайвшрах арга барилд суралцах.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ,үнэлгээ

7.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих, дүн шинжилгээ хийх, үнэлгээ өгөх ажлыг эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, сэтгэцийн эрүүл мэндийн мэргэжлийн зөвлөл мэргэжлийн бусад байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

7.2. Орон нутагт хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдан зохицуулах ажлыг бүх шатны Засаг дарга, сэтгэцийн эрүүл мэндийн орон нутгийн салбар зөвлөл мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

7.3. Хөтөлбөрийг дараахь шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэнэ:

Шалгуур үзүүлэлт	2000 оны түвшин	2007 онд хүрэх түвшин
1. 10000 хүн амд ногдох сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн тохиолдол /Эрүүл мэндийн статистикийн үзүүлэлтээр/	77.43	70.0
2. Сэтгэцийн эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдсэн байх	Сан байхгүй	Сантай болно
3. Сум, өрхийн эмнэлгээр үйлчлүүлэгчдийн дотор сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж авсан иргэдийн эзлэх хувь	0.13 %	10 %
4. Сэтгэцийн эрүүл мэндийн хөтөлбөртэй сургуулийн тоо /Үүнийг тухайн сургуулийн хэрэгжүүлж буй эрүүл мэндийн хөтөлберт нэмэлт байдлаар оруулна/	0	Жилд 90-ээс доошгүй сургууль
5. Эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр,төслийн хүрээнд сэтгэцийн эрүүл мэндийн дэд хөтөлбөр, төсөл хэрэгжүүлдэг 50-иас дээш ажиллагсадтай аж ахуйн нэгж, байгууллагын тоо	0	1 жилд 40-өөс доошгүй
6. Сэтгэцийн болон зан үйлийн эмгэгийн улмаас эмнэлэгт хэвтсэн хүний тоог нийт өвчлөлд харьцуулсан хувь	1.7 %	1.5 %
7. Сэтгэцийн эмнэлэгт эмчлүүлэгчдийн дундаж ор хоног	27.5	23.0
8. Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг сумын болон өрхийн эмнэлгийн тоо	Одоогоор статистик мэдээ гараагүй	Сум, өрхийн эмнэлэг 100 хувь
9. Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламжийн сургалтад хамрагдсан сумын болон өрхийн эмч, эмнэлгийн ажилтан /хувиар/	30%	70%
10. 100000 хүн амд ногдох амиа хорлосон тохиолдлын тоо	17	12

Найм. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

Зорилт	Гарах үр дүн	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах байгууллага
Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих орчин бүрдүүлэх	Бодлого боловсруулах, шийдвэр гаргах түвшинд сэтгэцийн эрүүл мэндийн талаархи мэдлэг, хандлага сайжирч, тухайн асуудлаархи салбар хоорондын хамтын ажиллагаа сайжирсан байна	- Сэтгэцийн эрүүл мэндийн талаархи мэдээлэл, ухуулга, суурьчилгааны материалыг улирал тутам боловсруулан гаргаж, бодлого, төлөвлөлтийн болон шийдвэр гаргах түвшний хүмүүст хүргэх	2002-2004	ЭМЯ
		- Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийн эрх, нийгмийн хамгааллын талаархи олон улсын хэм хэмжээг суурьчилах үйл ажиллагааг өргөжүүлэх	2002-2003	ЭМЯ, НХХЯ
		- Хүн ам, ялангуяа өсвөр үеийнхний сэтгэцийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх мэдээлэл, нэвтрүүлгийг хязгаарлах, нийтэд үзүүлэх хөтөлбөрийн зохицуулалтын асуудлаар холбогдох байгууллагууд хамтран ажиллаж хэвших	2002-2004	ЭМЯ, ХЗДХЯ, БСШУЯ, РТХЭГ
	Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд олон нийт, хамт олны оролцоо нэмэгдсэн байна	- Сэтгэцийн эрүүл мэндийн зөвлөлгөө өгөх, сэтгэц, оюуны алжаал, стресс тайлах зорилго бүхий сэтгэл засал, эмчилгээ, сувилгааны загвар төвүүдийг нийслэлийн зарим дүүрэг, эмчилгээ, оношилгооны бүсийн төвүүдэд байгуулах асуудлыг судалж, үе шаттайгаар шийдвэрлэх	2003-2006	ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга нар
		- Албан байгууллага, хамт олонд чиглэсэн сэтгэцийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, суурьчилгааг тогтмолжуулах	2002-2005	ЭМЯ, ҮХЯ, НХХЯ
		- Ажлын байранд эрүүл мэндийг дэмжих хөтөлбөр, төсөл, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээг өргөжүүлэх	2002-2005	ЭМЯ, ҮХЯ, НХХЯ
		- Сэтгэл зүйн зөвлөлгөө, эмчилгээний чиглэлээр үр дүнтэй үйл ажиллагаа явуулж буй төрийн ба төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжид мэргэжил, арга зүйн зөвлөлгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах	2002-2007	ЭМЯ, НХХЯ
		- Нийгэм, хамт олонд тулгуурласан нөхөн сэргээх үйл ажиллагаа явуулах аргачлал боловсруулж, бүх шатанд хэрэгжүүлэх арга хэмжээ авах	2003	ЭМЯ

	Сэтгүүлийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, талчилгааны нэгдэн стратегитай болж, сэтгүүлийн эрүүл мэндийн нэмэгдэж, дадал, амьн мэдэгдэл нь зөрчлөгдөн байна хандлага зөрчлөгдөн байна	- Сэтгүүлийн эрүүл мэндийн хандлага, дадлыг тодорхойлох судалгаа явуулах - Нийт хүн амд зориулсан сэтгүүлийн эрүүл мэндийн сургалт, суртачилгааны нэгдэн стратегийг боловсруулж хэрэгжүүлэх - Сэтгүүлийн эрүүл мэндийн сургалт, суртачилгааны материалыг хэвлэж, хуваарилах - Сэтгүүлийн эрүүл мэндийн сургалтыг хөтлөберийг боловсруулан сургалтад нэвтрүүлж, баш нарыг давтан сургах	2003 2003 2003-2005 2003-2004	ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ, БСШУЯ
Сэтгүүлийн эрүүл мэндийн туслалж, үйлчилгээг боловсронгуй болгож, хүртээмжийг сайжруулах	Сэтгүүлийн эрүүл мэндийн туслалж, үйлчилгээг ЭМСТ-ийн түвшинд үзүүлдэг болсон байна	- Сэтгүүлийн эрүүл мэндийн анхан шатны туслалж үйлчилгээг эрүүл мэндийн суурь туслалжийн бүлэд, орчлах, үг туслалжийн стандартыг боловсруулан гаргаж, хэрэгжилтэд хяналт тавих - Сэтгүүлийн эрүүл мэндийн анхан шатны туслалжийн асуудлаар сум, ерхийн зөвлөлийн ажилтны сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах - Сэтгүүлийн эмгэлийг эрт илрүүлж, оношлох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, зөвлөх асуудлаар ерийн орны нөхцөлд тохирсон арга зүй, эргэлтлаар сум, ерх, дүүргэ, аймгийн эмнэлгийн эмч, мэргэжилтэнг хангах - Хүн амд сэтгэл зүйн зөвлөгөө өгдөг "Итгэлтэй үгэс"-ны тоог нэмэгдүүлж, үйл ажиллагаг нь өргөжүүлэх - Сэтгэл зүйн зөвлөгөөнд хамрагдсэн зөрдлыг эрүүл мэндийн даатгалд хамруулах боломжийг судлах	2003-2004 2003-2004 2003-2004 2002-2005 2003	ЭМЯ ЭМЯ ЭМЯ ЭМЯ, ДБЯ ЭМЯ, НХҮЯ
	Сэтгүүлийн эрүүл мэндийн туслалжийн үйлчилгээний стандарт шаардлагад шинэчлэгдсэн байна	- Сэтгүүлийн эрүүл мэндийн туслалжийн стандартыг шинэчлэн боловсруулж, 2 түвшний эмнэлгийн эмгэгийн оношилгоо, эмчилгээний стандартыг шинэчлэн боловсруулах - Сэтгүүлийн эрүүл мэндийн байгууллагуудыг оношилгоо, эмчилгээний орчин үеийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангах - Сэтгүүлийн өвчтэй хүмүүст үзүүлэх нийгэм сэтгүүлийн нөхөн сэргээх туслалжийг ергөжүүлэх - Архинд донтох өвчнийг эмчлэх "АА" эмчилгээг бүх аймаг, хотод нэвтрүүлэх	2003-2004 2002-2007 2004 2003-2007	ЭМЯ ЭМЯ, СЗЯЯ ЭМЯ, НХҮЯ ЭМЯ, НХҮЯ

Ерөнхий мэргэжлийн болон сэтгүүлийн нарийн мэргэжлийн боловсон хүчнийг сургах төлөвлөгөө, үүний жишиг нийцсэн байна	- Ерөнхий мэргэжлийн болон ерхийн эмч нарын сэтгүүлийн эрүүл мэнд, сэтгүүлийн эмгэнэл оношлогоо, эмчилгээ, сэтгэл зүйн зөвлөгөө егөх талаарх мэдлэгийг дээшлүүлэх үе шаттай арга хэмжээ авах - Сэтгүүлийн эрүүл мэндийн төрөлжсөн нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, давтан сургах; зөв байршуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх - Сэтгэл зүйн зөвлөгөө егөх сургалтыг АУИС-ийн сургалтын хөтөлбөрт тусгах - Анагаах ухааны үндсэний сэтгэл зүйн асуудлыг судалж, хэрэгжүүлж эхлэх	2003-2007 2003-2005 2002-2003 2003-2007	ЭМЯ ЭМЯ, БСШУЯ ЭМЯ, БСШУЯ ЭМЯ, БСШУЯ
Сэтгүүлийн эрүүл мэндийн үйлчилгээний удирдлага, зохион байгуулалт боловсронгуй болж, байгууллагын үүл ажилгааны үзүүлэлт, холбоо сайжирсан байна	- Сэтгүүлийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний бодлого, төлөвлөлт, удирдлага, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох арга хэмжээ авах - Сэтгүүлийн эрүүл мэндийн чиглэлээр Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, бусад олон улсын байгууллага, гадаад улстай хамтын ажилгаагаа өргөжүүлэх. - Сэтгүүлийн эрүүл мэндийн талаарх хууль тогтоомж, бодлогын бичиг баримтын хэрэгжилтэд ечч, шаардлагатай бол шинэчлэх арга хэмжээ авч байх	2003 2003-2007	ЭМЯ ЭМЯ
Сэтгүүлийн эрүүл мэндийн эрдэм шинжилгээ, судалгааны ажил сайжирч, үр дүнтэй өтч эхэлсэн байна	- Сэтгүүлийн эмгэнийн тархалтыг шинжлэх ухааны бүсэд байгууллагатай хамтран судалж, тогтоох - Сэтгүүлийн эрүүл мэндэд сөрөгөөр нөлөөлөч хүчин зүйлүүдийг судлан тогтоох, сэтгүүлийн өвчлөлийг илрүүлэх сорилийг нэвтрүүлж, үр дүнг тооцох - Хүн амын архи, тамхи, мансууруулах бодисын хэрэглээний түвшинг тогтоох судалгааг холбогдох байгууллагатай хамтран хийх	2003-2004 2003-2004 2003-2004	ЭМЯ, БСШУЯ ЭМЯ ЭМЯ, ХЗДХЯ, БСШУЯ
Сэтгүүлийн эрүүл мэндийн бүртгэл, мэдээллийн горлоцоо боловсронгуй болсон байна	- Сэтгүүлийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлж, бүртгэх, мэдээлэх горлоцоо бий болгох - Эрүүл мэндийн статистикийн бүртгэлд сэтгүүлийн эрүүл мэндийн асуудлаар нэмэлт, өөрчлөлт оруулах, эрхэлсэн боловсон хүчний мэдлэг, чадавхийг дээшлүүлэх арга хэмжээ авах	2003-2005 2003-2005	ЭМЯ ЭМЯ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Дугаар 72 **Улаанбаатар хот**

Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2002 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын баатар бүрт 500.0(таван зуун) мянган төгрөг, Хөдөлмөрийн баатар бүрт 450.0 (дөрвөн зуун тавин) мянган төгрөг, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн бүрт 250.0 (хоёр зуун тавин) мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж тус тус олгохоор тогтоосугай.

2. "Нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам"-ыг хавсралт ёсоор батлуулсугай.

3. Нэг удаагийн буцалтгүй тусламжийг 2002 онд багтаан олгохыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2002 оны 72 дугаар тогтоолын хавсралт

НЭГ УДААГИЙН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ ЖУРАМ

1. Монгол Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2. Нэг удаагийн буцалтгүй тусламжийг Улсын болон Хөдөлмөрийн баатар, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд олгоно.

3. Нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохдоо дараахь зарчмыг баримтална:

3.1. 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө нас барсан энэ журмын 1 дэх заалтад дурдсан иргэдийн буцалтгүй тусламжийг тэдний ар гэрт нөхөн олгохгүй;

3.2. Буцалтгүй тусламжийг нэг хүнд давхардуулан олгохгүй. Давхардсан тохиолдолд тусламж авагч иргэн буцалтгүй тусламжийн аль илүүг хэмжээтэйг нь сонгож авах эрхтэй;

3.3. 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш нас барсан энэ журмын 1 дэх заалтад дурдсан иргэдийн буцалтгүй тусламжийг ар гэрт нь нөхөн олгоно.

3.4. Нэг удаагийн буцалтгүй тусламжийг олгохдоо Улсын баатар, Хөдөлмөрийн баатар, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтний үнэмлэх, бичиг баримтыг үндэслэл болгоно.

4. 2002 оны 1 дүгээр сарын 1-нээс хойш Улсын болон Хөдөлмөрийн баатар цол авсан хүнд энэ тогтоол хамаарахгүй.

5. Энэ журамд заасан буцалтгүй тусламжийг аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвөөр дамжуулан олгоно.

6. Аймаг, дүүргийн Нийгмийн халамж, үйлчилгээний төв Улсын болон Хөдөлмөрийн баатар, Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэнд энэ журамд заасан нэг удаагийн буцалтгүй тусламж олгосон тухай бүртгэлийг хөтөлж, тэдгээр иргэд нь өөр газар шилжин суурьшсан тохиолдолд буцалтгүй тусламжид хамаргдсан эсэх тухай тодорхойлолтыг шинээр харьяалагдсан байгаа Нийгмийн халамж, үйлчилгээний төвөд гаргаж өгнө.

7. Энэ журмын хэрэгжилтэд бүх шатны Засаг дарга, хөдөлмөр, нийгмийн хамгааллын хяналтын болон нийгмийн халамж, үйлчилгээний улсын байцаагч хяналт тавина.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 4 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (260)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Зар сурталчилгааны тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *"Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем" хөтөлбөр батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай*
- *"Иод дутлын эмгэгтэй тэмцэх" үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны зургадугаар сарын 22 №23 (260)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

264. Зар сурталчилгааны тухай (2002-5-30-ны хууль) 748

265. Гэрээ соёрхон батлах тухай (2002-6-6-ны хууль) 755

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

266. "Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем" хөтөлбөр батлах тухай Дугаар 23 755

267. Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай Дугаар 27 759

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

268. Балдан-Осорын Алтангэрэлд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 79 759

269. Чүлтэмийн Алтан-Өлзийд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 80 759

270. Гомбын Дэлгэрт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай Дугаар 81 760

271. Сэрээнэнгийн Майдаржавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 82 760

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

272. Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай Дугаар 73 760

273. Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай Дугаар 76 760

274. Улсын хилийг шалгах ажилд хөрөнгө нэмж гаргах тухай Дугаар 79 761

275. Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх хөрөнгийн тухай Дугаар 81 761

276. Дүрэм батлах тухай Дугаар 83 762

277. "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай Дугаар 84 764

278. Конвенци хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 86 771

279. Мэргэжил-арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг боловсронгуй болгох тухай Дугаар 90 772

Тав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

280. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн " Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 01 773

281. Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай Дугаар 02 777

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Ерөнхий зүйл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт зар сурталчилгааг бүтээх, байрлуулах, түгээх, түүнд хяналт тавих болон шударга өрсөлдөөнд харшлах, хэрэглэгчийг төөрөгдөлд оруулах, хуурч мэхлэх, тэдний ашиг сонирхолд хохирол учруулахуйц зар сурталчилгааг хориглохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

2.1.Монгол Улсын нутаг дэвсгэрт явагдах аливаа зар сурталчилгаанд энэ хуулийг хэрэглэнэ.

2.2.Энэ хууль улс төр, шашин, сүм хийдийн сурталчилгаа, түүнчлэн худалдаа, арилжаа, аж ахуйн үйл ажиллагаатай холбоогүй мэдээ, мэдээллэл зарлалд хамаарахгүй.

2.3.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."зар сурталчилгаа" гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид "бүтээгдэхүүн" гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг;

3.1.2."зар сурталчилгаа захиалагч" гэж өөрийгээ, эсхүл бүтээгдэхүүнээ сурталчлахаар зар сурталчилгаа хийлгэж буй этгээдийг;

3.1.3."зар сурталчилгаа бүтээгч" гэж захиалагчаас өгсөн захиалгын дагуу зар сурталчилгааг нийтэд түгээхээр бэлтгэсэн этгээдийг;

3.1.4."зар сурталчилгаа түгээгч" гэж мэдээлэх хэрэгслийг ашиглах, эсхүл бусдад ашиглуулах замаар зар сурталчилгааг байрлуулж, нийтэд сурталчилж байгаа этгээдийг;

3.1.5."мэдээлэх хэрэгсэл" гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерын сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгслийг.

4 дүгээр зүйл. Зар сурталчилгааны оюуны үнэт зүйлийг ашиглах

4.1.Зар сурталчилгаанд оюуны үнэт зүйлийг ашиглахдаа Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу ашиглана.

4.2.Зар сурталчилгаа нь Монгол Улсын хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тохиолдолд бүхэлдээ, эсхүл хэсэгчлэн оюуны өмчийн эрхийн тухай хууль тогтоомжоор хамгаалагдана.

5 дугаар зүйл. Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон зар сурталчилгаанаас хамгаалах

5.1.Зар сурталчилгаа нь хүний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон, энэ хуулийн 21.1, 21.2-т заасан жүрмыг зөрчсөн, бусдын бүтээгдэхүүнийг муутган өөрийн бүтээгдэхүүнийг давуутай гэж харьцуулан сурталчилсан, түүнчлэн энэ хуулийн 7.2.1, 7.2.3-т заасан үйлдэл хийсэн бол иргэн, хуулийн этгээд хууль заасан үндэслэлээр, жүрмын дагуу няцаалт хийлгэх, учирсан гэм хорыг арилгахыг шаардах эрхтэй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Зар сурталчилгаа, түүнд тавих ерөнхий шаардлага, хориглох зүйл

6 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд тавих ерөнхий шаардлага

6.1.Зар сурталчилгаа нь үнэн, хэрэглэгдэд хүртээмжтэй байж, агуулга, хэлбэр, түүнийг түгээж байгаа арга хэрэгслээс үл хамааран зар сурталчилгаа гэж ойлгогдохоор байна.

6.2.Тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагаатай холбоотой бичмэл зар сурталчилгаанд тусгай зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын нэр, зөвшөөрлийн дугаарыг тусгасан байна.

6.3.Зар сурталчилгаанд статистик

мэдээ, судалгааны дүн, баримтыг ашиглахдаа тухайн эх сурвалжийг нь заавал тусгасан байна.

6.4.Хортой, галын аюултай барааны зар сурталчилгаанд тухайн барааны эдгээр шинж чанарын талаар заасан байна.

6.5.Зар сурталчилгаа бүтээх, түгээхэд дараах зүйлийг хориглоно:

6.5.1.тусгай зөвшөөрөл авааагүй тохиолдолд тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааны талаар аливаа зар сурталчилгаа явуулах;

6.5.2.Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэх, худалдах, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон бүтээгдэхүүнийг сурталчлах;

6.5.3.тарифын бус хязгаарлалт тогтоосон бараг сурталчлах;

6.5.4.хуульд заасны дагуу чанар, стандарт, эрүүл ахуйн баталгаажуулалтад заавал хамруулах бүтээгдэхүүнийг ийнхүү баталгаажуулаагүй бол сурталчлах;

6.5.5.Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчих үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;

6.5.6.хуульд заасны дагуу байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх төслийг үнэлгээ хийлгэхээс өмнө, эсхүл үнэлгээ хийгдсэн боловч төслийг хэрэгжүүлэх боломжгүй гэсэн дүгнэлт гарсан бол уг төслийг сурталчлах;

6.5.7.айдас төрүүлэх, хүчирхийлэл, садар самуунд уруу татах, түүнчлэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд гэм хор учруулах үйлдэл, үйл ажиллагаанд хүргэж болох зар сурталчилгааг;

6.5.8.хуулиар сурталчлахыг хориглосон бараа, ажил, үйлчилгээг сурталчилах.

7 дугаар зүйл. Хууль бус зар сурталчилгаа

7.1.Хууль бус зар сурталчилгаанд зүй бус, бодит байдалд үл нийцсэн, ёс сурахуунд үл нийцсэн, далд зар сурталчилгаа хамаарна.

7.2.Дараахь зар сурталчилгааг зүй бус зар сурталчилгаанд тооцно:

7.2.1.өөрийн барааг бусдынхтай ижилсгэн сурталчилсан;

7.2.2.бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд харш сурталчилгаа;

7.2.3.хангалттай тодорхой мэдээллийг орхигдуулан, эсхүл мэдлэг, туршлага дутмаг буюу итгэмтгий байдлыг нь ашиглан хэрэглэгчийг төөрөгдөлд оруулсан.

7.3.Дараахь зүйлийн талаар хэрэглэгчийг төөрөгдүүлсэн зар сурталчилгааг бодит байдалд үл нийцсэнд тооцно:

7.3.1.бүтээгдэхүүний зориулалт, бүтэц, найрлага, үйлдвэрлэсэн арга, огноо, шинж чанар, хэрэглүүр арга, хугацаа, чанарын гэрчилгээ, тохирлын тэмдэг, чанарын баталгаажуулалт, тоо, хэмжээ, гарал үүсэл;

7.3.2.зар сурталчилгаанд заасан орон зай, цаг хугацаанд тухайн бүтээгдэхүүний тоо, хэмжээ, олдоц, түүнийг худалдан авах боломж, зах зээл дээрх бодит эрэлт, нийлүүлэлт;

7.3.3.тухайн зар сурталчилгааг түгээх үед мөрдөж байгаа үнэ;

7.3.4.төлбөр тооцооны нэмэлт нөхцөл;

7.3.5.бүтээгдэхүүнийг нийлүүлэх, тээвэрлэх, суурилуулах, үгсрах, тохируулга хийх, ашиглалтын явцад засварлах, үйлчилгээ үзүүлэх, солих нөхцөл;

7.3.6.баталгаат эдэлгээний болон ашиглах хугацаа;

7.3.7.ойуны үнэт зүйлийг ашиглах, захиран зарцуулах эрх;

7.3.8.зар сурталчилгаа захиалагч, түүний бүтээгдэхүүнд олгосон шагнал, үнэмлэх, гэрчилгээ болон бусад хэлбэрээр албан ёсоор хүлээн зөвшөөрсөн байдал;

7.3.9.зар сурталчилгаа захиалагч, түүний бүтээгдэхүүний талаар бусдаас өгсөн үнэлэлт, дүгнэлт, зөвлөмжөөс татсан ишлэл;

7.3.10.судалгаа, шинжилгээ, туршилтын дүн, түүнчлэн шинжлэх ухааны нэр томъёо болон бусад бүтээлээс татсан ишлэл;

7.3.11.зар сурталчилгаа захиалагч, түүний хаяг, үйл ажиллагааны зорилго, чиглэл, туршлага, далдлага.

7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно:

7.4.1.бусдын бүтээгдэхүүнийг гутаан доромжилсон;

7.4.2.Монгол Улсын болон бусад улсын төрийн бэлгэ тэмдэг, түүхэн алдарт хүн, үндэсний мөнгөн тэмдэгт, шашин шүтлэгийг гутаан доромжилсон;

7.4.3.төрийн тусгай алба хаагчийн дүрэмт хувцас, билэгдлийг дүрмийн бус, гаж хэлбэрээр ашиглаасан;

7.4.4.үндэсний болон түүх, соёлын үнэт зүйлсийн бүртгэлд орсон урлагийн бүтээлийг гутаан доромжилсон;

7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашиглаасан;

7.4.6.хүнлэг ёс, ёс суртахуун, Монгол хүний эрхэмлэн дээдэлдэг зан заншлын ёс оримыг зөрчсөн.

7.5.Энэ хуулийн 6.1-д заасныг зөрчсөн, эрэгцлэгчийн ухамсарт шууд бусаар нөлөөлөх зар сурталчилгааг далд зар сурталчилгаа гэж тооцно.

7.6.Шүүх энэ хуулийн агуулга, зарчимд нийцүүлэн энэ хуулийн 7 дугаар зүйлд зааснаас бусад үндэслэлээр зар сурталчилгааг хууль бус гэж тооцож болно.

7.7.Хууль бус зар сурталчилгаа захиалах, бүтээх, түгээхийг хориглоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Зар сурталчилгаанд тавих тусгай шаардлага

8 дугаар зүйл. Тэзврийн хэрэгслээр түгээх зар сурталчилгаа

8.1.Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол тээврийн хэрэгслийн өмчлөгч буюу эсхүл түүний эрийн өмнөөс эрх бүхий этгээдтэй байгуулсан гэрээний үндэсэн дээр автотээврийн хэрэгсэл ашиглан зар сурталчилгааг түгээж болно.

8.2.Нутгийн өөрөө удирдах байгууллага замын хөдөлгөөний аюулгүй байдлын улсын хяналтын албатай тохиролцсоны үндэсэн дээр тээврийн хэрэгслээр зар сурталчилгаа түгээхэд тавих аюулгүйн ажиллагааны болон стандартын шаардлагыг тогтоож болно.

9 дүгээр зүйл. Гадна зар сурталчилгаа

9.1.Нийтийн эзэмшлийн барилга байгууламж, зам, гудамж, талбайд самбар, гэрэл дохио, гэрэлтүүлэг болон хөдөлгөөнгүй бусад хэрэгслийн тусламжтайгаар зар сурталчилгаа байрлуулахад тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын гэрээс зөвшөөрөл авна.

9.2.Нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох улсын хяналтын албаны саналыг үндэслэн гадна зар сурталчилгаа байрлуулахад тавих аюулгүй ажиллагааны болон стандартын шаардлагыг тогтоож болно.

9.3.Гадна зар сурталчилгаа нь замын хөдөлгөөн зохицуулах дохио, тэмдэг, тэмдэглэлтэй тестэй байх, тэдгээрийг халхлах, далдлах болон бусад хэлбэрээр замын хөдөлгөөнд саад учруулахыг хоригдоно.

9.4.Нийтийн эзэмшлийн газар, барилга, байгууламж дээр зар сурталчилгаа байрлуулах зөвшөөрөл олгох нийтлэг журмыг тухайн орон нутгийн өөрөө удирдах байгууллага тогтооно.

9.5.Нийтийн эзэмшлийн газар, барилга, байгууламж дээр байрлуулсан зар сурталчилгааны төлбөрийг тухайн засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн дэд бүтцийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах ажилд зарцуулна.

9.6.Хуулийн этгээдийг татан буулгах ажлыг гүйцэтгэх этгээд тухайн хуулийн этгээдийн гадна зар сурталчилгааг түгээсэн хэрэгслийг хураах ажлыг зохион байгуулна.

10 дугаар зүйл. Харилцуур утасны болон бусад лавлахаар түгээх зар сурталчилгаа

10.1.Харилцуур утасны лавлахаар үйлчлүүлэгчид зориулж мэдээ, лавлагаагаар үйлчилсний дараа зар сурталчилгаа нэвтрүүлж болно.

10.2.Төлбөртэй харилцуур утасны болон бусад лавлахаар зар сурталчилгааг гагцхүү үйлчлүүлэгч өөрөө зөвшөөрсөн тохиолдолд нэвтрүүлж болно.

11 дүгээр зүйл. Радио, телевизээр түгээх зар сурталчилгаа

11.1.Уран сайхны болон бариматат кино, радио жүжгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхдээ зохиогч, эсхүл зохиогчийн эрх эзэмшигчийн зөвшөөрлийг авсан байна.

11.2.Хүүхдэд зориулсан нэвтрүүлгийн дундуур зөвхөн хүүхдэд зориулсан зар сурталчилгаа нэвтрүүлж болно.

11.3.Улс орны болон дэлхий дахины амьдралын цаг үеийн шинжтэй үйл явдлын талаархи тогтмол мэдээллийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хоригдоно.

11.4.Сургалтын нэвтрүүлгийн дундуур зөвхөн сургалттай холбоотой бөгөөд 5 минутаас илүүгүй хугацаанд 30 секүндээс дээшгүй үргэлжлэх зар сурталчилгаа нэвтрүүлж болно.

11.5.Үргэлжлэх хугацаа нь 20 минутаас дээшгүй нэвтрүүлгийн дундуур зар сурталчилгаа нэвтрүүлэхийг хоригдоно.

12 дугаар зүйл. Интернэтээр түгээх зар сурталчилгаа.

12.1.Зар сурталчилгаа түгээгч нь бусдын

эзэмшилд байгаа интернэтийн хуудсанд өөрийн зар сурталчилгаагаа зөвшөөрөлгүй байрлуулахыг хориглоно.

12.2.Интернэтээр түгээж байгаа зар сурталчилгааны зар сурталчилгаа түгээгчийн нэр, хаяг, харилцах утас зэрэг хэрэглэгч холбоо тогтоохоо шаардлагатай бусад мэдээлэл байна.

12.3.Хэрэв тухайн зар сурталчилгааг байрлуулсан хаягаар ороход тусгай төлбөр авдаг бол энэ талаарх санамжийг тухайн хаягаар орохоос өмнө хэрэглэгчид харагдахуйцаар байрлуулсан байна.

13 дугаар зүйл. Эрүүл мэндийн салбар дахь зар сурталчилгаа

13.1.Олон нийтийн мэдээлэх хэрэгслээр зөвхөн жоргүй олгох эмийн тухай болон эмийг зохистой хэрэглэхтэй холбогдсон сурталчилгаа явуулж болно.

13.2.Жороор олгох, мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх эм, эмчилгээний зориулалт бүхий мансууруулах бодис, үргамал, түүнчлэн тусгай мэдлэг, мэргэжил шаардагдах эмнэлгийн хэрэгслийг зөвхөн эрүүл мэндийн салбарын ажилтнуудад зориулсан мэдээлэх хэрэгслээр сурталчилна.

13.3.Эмийг сурталчлахдаа тэдгээрийг хэрэглэх заавартай танилцахыг заавал сануулна.

13.4.Эм, эмийн зүйлс (цаашид "эм" гэх)-ийн зар сурталчилгааны дараахь зүйлийг хориглоно:

13.4.1. улсын бүртгэлд бүртгэгдээгүй эмийг сурталчлах;

13.4.2.зөвхөн эмнэлгийн нөхцөлд хэрэглэх эмийг эмийн сан, бусад нөхцөлд борлуулахаар сурталчлах;

13.4.3.тухайн эмийн гаж үйлчлэл, хориглох заалтыг нуун далдлах зорилгоор сурталчлах;

13.4.4.тухайн эмийн үйлчлэлийн талаар урьдчилсан баталгаа гаргах;

13.4.5.эмийн ерөнхий нэршилгүй, зөвхөн худалдааны нэршлээр сурталчлах;

13.5.Аймаг, нийслэлийн хүн, мал эмнэлгийн удирдах болон мэргэжлийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авааргүй эм хангамжийн байгууллага (эмийн үйлдвэр, эмханган нийлүүлэх байгууллага, эмийн сан)-ыг сурталчлахыг хориглоно.

13.6.Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлгүй эрүүл мэндийн байгууллага, эмчлэх эрхгүй мэргэжилтэн, эрх, зөвшөөрөл авааргүй буюу баталгаажаагүй эмчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг сурталчлахыг хориглоно

13.7.Эмнэлгийн байгууллагын талаархи зар сурталчилгаа нь зөвхөн байршил, үйлчилгээний чиглэл, эмчийн нэр хаягаар хязгаарлагдана.

13.8.Эмнэлгийн үйлчилгээний талаар магтсан, үйлчлүүлэхийг уриалсан сурталчилгаа явуулахыг хориглоно.

14 дүгээр зүйл. Байгаль орчны салбар дахь зар сурталчилгаа

14.1.Нэн ховор, ховор үргамал, амьтны жагсаалтад орсон болон тэдгээрийн үндэс, иш, мөчир, навч, бүгын цусан эвэр, чив, засаа, согооны сүүл, сав, худрийн заар, баавгайн доньд зэрэг эрхтэнийг бэлтгэх, худалдах, худалдан авах тухай зар сурталчилгааг хориглоно.

14.2.Хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд Засгийн газраас гаргасан шийдвэрийн дагуу тодорхой хугацаанд агнах, бэлтгэхийг хориглосон амьтан, үргамлын эд эрхтэн, түүхий эдийг худалдах, худалдан авах тухай зар сурталчилгаа явуулахыг хориглоно.

15 дугаар зүйл. Нийгмийн зар сурталчилгаа

15.1.Иргэн, хуулийн этгээдээс нийтийн болон улсын эрх ашигт нийцсэн ашиг тустай үйлсийг дэмжин тэтгэх зорилгоор зар сурталчилгааг бүтээх, түгээх, эсхүл өөрийн хөрөнгийг энэхүү зар сурталчилгааг бүтээх, түгээхэд зориулан бусдад хариу төлбөргүйгээр шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг нийгмийн зар сурталчилгааны хамаарууллж, хууль тогтоомжид заасны дагуу хөнгөлөлт үзүүлж болно.

16 дугаар зүйл. Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд хүүхдийн эрхийг хамгаалах

16.1.Зар сурталчилгаа бүтээх, байрлуулах, түгээхэд дараахь зүйлийг хориглоно:

16.1.1.эцэг, эх, асран хүмүүжүүлэгчийн нэр хүндийг бууруулах;

16.1.2.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авахыг эцэг, эх болон бусад этгээдээс шаардахыг хүүхдэд шууд зөвлөх, ухуулах, бусад хэлбэрээр нөлөөлөх;

16.1.3.тухайн бүтээгдэхүүнийг худалдан авсан, эсхүл авааргүйгээс бусад хүүхдээс давуутай буюу дор байдалд орно гэсэн ойлголтыг хүүхдэд бий болгох;

16.1.4.хүүхдийг ашуултай орон зай, нөхцөл байдалд дүрсэлсэн дүрс, дуу авиа, эсхүл үг хэллэгийг зар сурталчилгааны ашиглах;

24.7.Энэ хуулийн 24.6-д заасан хяналтын алба, байгууллага нь зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт зар сурталчилгаанд хамаатай этх бүхий байгууллагад шуурхай ирүүлэх үүрэгтэй.

25 дугаар зүйл. Зар сурталчилгаанд тавих олон нийтийн хяналт

25.1.Аж ахуйн нэгж, байгууллага, хувь хүн зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн болон түүнтэй холбоотой мэдээллийг тодорхой үндэслэл, саналын хамт эрх бүхий байгууллагад тавих, шаардлагатай бол мэдээлэх хэрэгслээр нийтийг сэрэмжлүүлж болно.

25.2.Хэрэглэгчийн эрх ашиг, түүнчлэн зар сурталчилгаа бүтээх, түгээх үйл ажиллагаанд оролцогчийн эрх ашгийг хамгаалах зорилго бүхий төрийн бус байгууллага зар сурталчилгаанд хяналт тавих чиглэлээр дараахь эрх эдэлнэ:

25.2.1.хэрэглэгчийн нэрийн өмнөөс зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргах;

25.2.2.тухайн зар сурталчилгаа хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж буй эсэх талаар зөвлөмж гаргах;

25.2.3.зар сурталчилгаа захиалагч, бүтээгч, түгээгчид зар сурталчилгаатай холбогдох санал тавих, зөвлөмж өгөх.

25.3.Зар сурталчилгааны хяналттай холбоотой тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлж, холбогдох зардлыг бүрэн буюу хэсэгчлэн улсын төсвөөс санхүүжүүлж болно.

26 дугаар зүйл. Зар сурталчилгаанд тавих хамтын хяналт

26.1.Оюуны өмчийн улсын хяналтын алба энэ хуулийн 24.6, 25 дугаар зүйлд заасан этгээдтэй харилцан мэдээлэл солилцох, шаардлагатай хяналт, шалгалт, судалгаа хамтран явуулах зэргээр ажиллаж болно.

27 дугаар зүйл. Зар сурталчилгааны хяналтын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргах

27.1.Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагчийн шийдвэр, үйл ажиллагаат зөвшөөрөөгүй этгээд зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллагын даргад гомдол гаргана.

27.2.Оюуны өмчийн улсын хяналтын албаны дарга гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 өдөрт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг эрх бүхий албан тушаалтан 14 хүртэл өдрөөр сунгаж болно.

27.3.Гомдол гаргах, хүлээн авах, хянах, шийдвэрлэхэд Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль[2] заасан журмыг баримтална.

28 дугаар зүйл. Зар сурталчилгааны хяналтын албаны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол, нэхэмжлэл гаргах

28.1.Энэ хуулийн 25.1, 27.1-д заасан этгээд Оюуны өмчийн улсын хяналтын албаны шийдвэр, үйл ажиллагааны талаар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргаж болно.

28.2.Энэ хуулийн 27.1, 28.1-д заасны дагуу нэхэмжлэл, гомдол гаргасан нь хариуцлага хүлээлгэх болон захиргааны шийтгэл биелүүлэхийг хойшлуулах үндэслэл болохгүй.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

29 дүгээр зүйл. Захиргааны хариуцлага

29.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд Оюуны өмчийн улсын хяналтын албаны байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

29.1.1.зар сурталчилгаанд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтны хууль ёсны шийдвэр, шаардлагыг зөрчсөн, эсхүл үндэслэлгүйгээр биелүүлээгүй иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох;

29.1.2.энэ хуулийн 6.1, 6.3, 6.4 дэх хэсэгт, 6.5.1-6.5.8 дахь заалт, 7 дугаар зүйл, 9.3 дахь хэсэг, 10-14, 16, 17 дугаар зүйл, 19.3, 22.1 дэх хэсэг, 23 дугаар зүйлд заасан шаардлагыг зөрчсөн бол гэм буруутай иргэнийг 10000-50000 хүртэл төгрөгөөр, албан тушаалтныг 25000-60000 хүртэл төгрөгөөр, байгууллага, аж ахуйн нэгжийг 50000-250000 хүртэл төгрөгөөр торгох.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан захиргааны хариуцлага нь хууль тогтоомжийн бусад актад заасан хариуцлага, зар сурталчилгааны тухай хууль тогтоомжийг зөрчсөн үйлдэл, үйл ажиллагаат таслан зогсоох шаардлагыг биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

29.3.Оюуны өмчийн улсын хяналтын албаны шийдвэр, үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг Иргэний хуульд[3] заасан журмын дагуу арилгана.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

[2] Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

[3] Иргэний хууль –"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Испанийн Вант Улсын Институто дэ Кредито Официалын хооронд 2002 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр байгуулсан Улаанбаатар хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг сайжруулах төслийн Зээлийн гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр Дугаар 23 Улаанбаатар хот

"Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем" хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн эрчим хүчний бүтцийг бүрдүүлэх, хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийг найдвартай болгох зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

1."Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем" хөтөлбөрийг хавсралт ёсоор батлуулсугай.

2."Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн систем" хөтөлбөрийг хэрэжүүлэхэд олон улсын банк, санхүүгийн байгуллага, хандивлагч орнууд, дотоод, гадаадын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах ажлыг зохион байгуулах, түүнчлэн дотоодын санхүүжилтийн хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төвлөрсөн төсөвт тусгаж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байхыг Засгийн газар / Н.Энхбаяр/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2002 оны 23 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ НЭГДСЭН СИСТЕМ" ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн үндэслэл, хамрах хүрээ, хэрэгжүүлэх хугацаа

1.1.Үндэслэл

Улсын хэмжээнд эрчим хүчний хангамж харилцан адилгүй, бие даасан эх үүсвэрүүд ажиллаж байгаа, өртөг зардал, үнэ тариф янз бүр (эрчим хүчний хангамж илүү хөгжсөн төвийн хэсэгт үйлдвэрлэлийн өртөг хямд) байгаа нь бүс нутгийн эрчим хүчний хөгжилд сөргөөр нөлөөлөхийн зэрэгцээ хүн амд төвийн бус рүү шилжих хөдөлгөөний нэг шалтгаан болоод зогсохгүй ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх, бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, ядуурлыг бууруулах зэрэг асуудлууд орхигдож байна. Нөгөөтэйгүүр эрчим хүчний хангамж, ашиглаж байгаа эх үүсвэрийн хүчин чадлын ашиглалт хангалттүй, өндөр үнэтэй импортын цахилгаан худалдаж авч, дизелийн түлшээр өндөр өртөгтэй цахилгаан үйлдвэрлэж байгаа нь Монгол Улс эрчим хүчний хэрэгцээгээ өөрийн эх үүсвэрээр бүрэн хангах эрчим хүчний үйлдвэрлэл, хангалтын нэгдсэн сүлжээ бий болгохыг шаардаж байна.

Экологийн хувьд эмтэй эрчим хүчний хөгжлийн бодлогыг хэрэжүүлэхэд ус, нар, салхи, атомын зэрэг сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах нь дэлхий нийтийн болон манай орны зүй ёсны шаардлагад нийцэж байна.

1. 2. Хөтөлбөрийн хамрах хүрээ

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ төрийн болон төрийн бус байгуллага, олон улсын банк, санхүүгийн байгуллага, хувийн хэвшил, иргэдийн идэвхитэй хамтын ажиллагаанд тулгуурлана.

1.3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

1.3.1 Хөтөлбөрийг хоёр үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

үзэдүгээр үе шат: ойрын хугацаа (2002-2007 он)-нд бүс нутгийн эрчим хүчний хангамжийг найдваржуулах, эрчим хүчний эх үүсвэр болон дамжуулах шугамуудыг шинэчлэх барих

дөрдүгээр үе шат: дунд хугацаа (2007-2022 он)-нд бүс нутгийг эрчим хүчээр найдвартай хангах зорилгоор эрчим хүчний эх үүсвэр болон цахилгаан дамжуулах шугамуудыг шинээр барьж, баруун, зүүн болон төвийн бүсийн эрчим хүчний системийг өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугамаар холбож, эрчим хүчний нэгдсэн систем байгуулах нөхцөлийг бүрдүүлэх "

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, шийдвэрлэх зорилт

2.1. Хөтөлбөрийн зорилго

2.1.1 Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилтэй уялдуулан эрчим хүчний нөөцийг үр ашигтайгаар ашиглах үүднээс Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийг тодорхой бодлогоор байгуулж Монгол Улсын эрчим хүчний хангамжийг найдвартай, үр ашигтай болгох, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахад оршино.

2.2. Хөтөлбөрийн хүрээнд шийдвэрлэх зорилт

2.2.1 Зах зээлийн нөхцөлд тохирсон хууль, эрх зүй, бүтэц зохион байгуулалт, менежментийг боловсронгуй болгох, цахилгаан станцууд, түгээх сүлжээг үе шаттай хувьчлах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах, ашигталтын бага зардалтай үйлдвэрлэлийн бүтцийг бий болгох, усан цахилгаан станц шинээр барьж өндөр хүчдэлийн шугамаар холбох замаар бүс нутгийн эрчим хүчний систем байгуулж цаашид эдийн засгийн үр ашигтай горим, үйл ажиллагааг бүрдүүлэн Монгол Улсын хэмжээнд эрчим хүчний нэгдсэн систем байгуулж эрхэм зорилгод хүрнэ.

2.2.2 Эрчим хүчний хэмнэлтийн бодлогыг тодорхойлох, үр ашигтай шинэ техник, технологи нэвтрүүлэх, сэргээгдэх эрчим хүчний нөөцийг ашиглах замаар эрчим хүчний эх үүсвэрийн бүтцийн шинэчлэлт хийж төв, орон нутгийн цахилгаан хангамжийг найдвартай болгоно.

2.2.3 Улс орны нийт нутаг дэвсгэр дээр цахилгаан станцуудыг зөв байршуулан, баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системийг бэхжүүлж, цаашид төвийн эрчим хүчний системтэй холбох замаар Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулна.

Гурав. Монгол орны эрчим хүчний нөөц

3.1. Нүүрсний нөөц

3.1.1. Монгол Улс нийт 150 тэрбум тонн нүүрсний нөөцтэй бөгөөд үүнээс 20 гаруй тэрбум тонн нүүрсний нөөцийг урьдчилсан болон нарийвчилсан хайгуулаар тодорхойлоод байна. Нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд 200 гаруй нүүрсний орд газар илрэзд байгаагийн 50 орчим орд газарт эрэл, үнэлгээ, хайгуулын ажил хийсэн, 32 орд газрыг ашиглаж байна. Орд газар бүс нутгаар харилцан адилгүй байршилтай байна.

3.1.2 Баруун бүсэд Нүүрст хотгор, Хар тарвагатай, Хөшөөт зэрэг орон нутгийн чанартай цөөн тооны нүүрсний орд байгаа бөгөөд Завхан аймгийн нутагт нүүрсний орд илрээгүй тул цаашид хайгуул хийх шаардлагатай байна.

3.1.3 Хангайн бүсэд Булганы Сайхан-Овоо, Баянхонгорын Жинст, Хөвсгөлийн Могойн гол зэрэг орон нутгийн чанартай нүүрсний уурхайгаас гадна Өвөрхангай аймагт Баянтөгсийн нүүрсний ордыг ашиглаж байна.

3.1.4. Төвийн бүс нүүрсний харьцангуй их нөөцтэй бөгөөд Тавантолгой, Багануур, Шивээ-Овоо, Тэвшийн говь, Алагтогоо, Хангай зэрэг ордуудыг ашиглаж байна. Төвийн бүсийн хойт хэсэгт нүүрсний нөөц нэмэгдүүлэх эрэл хайгуулын ажил хийнэ.

3.1.5. Зүүн бүсэд Адуунчулууны нүүрсний уурхай, Сухбаатар аймгийн нутагт Талбулаг зэрэг нүүрсний жижиг ордыг ашиглаж байна.

3.1.6. Монгол Улсад газрын тосны хайгуулыг зүүн болон говийн бүсэд хийж нөөцийн хэмжээг одоогоор тогтоогоогүй байна. Шатдаг хийн ордын хайгуул бага хийгдсэн бөгөөд одоогоор нөөц илрээгүй байна.

3.2. Сэргээгдэх эрчим хүчний нөөц

3.2.1. Монгол Улсын усны эрчим хүчний чадлын нөөц нь 6417,7 МВт бөгөөд жилд 56,2 тэрбум кВт.ц цахилгаан эрчим хүчийг усны эрчим хүчээр үйлдвэрлэх боломжтой. Баруун болон хангайн бүсэд ойрын болон дунд хугацаанд 700 гаруй МВт нийлбэр хүч чадалтай усан цахилгаан станцуудыг барьж, ашиглах боломжтой байна.

3.2.2. Монгол орны ихэнх нутгаар жилийн 270-300 өдөр нартай байдаг бөгөөд дунджаар нар гийгүүлэх хугацаа жилд 2250–3300 цаг байна. Жилд тусах нарны эрчим хүчний хэмжээ дунджаар 1400 кВтц/м^2, нарны эрчимшил өдөрт 4,3 – 4,7 кВтц/м^2 байна.

3.2.3. Манай орны салхины эрчим хүчний чадлын нөөц 836,8 тэрбум кВт.ц, түүний ашиглаж болох хугацаа жилдэж 3500 - 4600 цаг байна.

3.3. Атомын эрчим хүчний нөөц

3.3.1. Монгол орон ураны нилээд нөөцтэй боловч цахилгаан станц барих хэмжээнд хүрч хараахан судлагдаагүй байна. Атомын цахилгаан станц барих асуудлыг олон улсын хэмжээнд зөвшөөрч шийдвэрлэдэг тул нарийвчилсан судалгаа явуулж, өндөр хөгжилтэй орнуудын атомын цахилгаан станц ашиглаж ирсэн туршлагыг харгалзан атомын эрчим хүчний нөөцийг цахилгаан хангамжийн нэгэн чухал эх үүсвэр болгох чиглэл баримтална.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1. Нэгдүгээр үе шат буюу ойрын хугацаа (5 жил) -нд:

4.1.1. Говь - Алтай аймгийн нутагт Завхан гол дээр 8 МВт хүчин чадалтай Тайшир (Улаанбоом)–ын усан цахилгаан станц, Хөвд аймгийн нутагт орших Чоно харайх гол дээр 12 МВт хүчин чадалтай Дөргөний усан цахилгаан станц барина. Тайширын усан цахилгаан станцаас Завханы төв Улиастай хүртэл 110 кВ–ын 135 км шугам, Говь–Алтай аймгийн төв Алтай хүртэл 35 кВ–ын 47 км шугам барьж Завхан, Говь–Алтай аймгийг холбосон цахилгаан эрчим хүчний сүлжээ байгуулна. Говь–Алтай, Завхан аймгийн нутаг дэвсгэр дээр салхин станц барих судалгаа хийнэ. Дөргөний усан цахилгаан станцыг Мянгадын дэд станцтай 220 кВ–ын 78 км шугамаар холбож баруун бүсийн эрчим хүчний системийг өөрийн эх үүсвэртэй болгоно.

4.1.2 Өвөрхангай аймгийн Баянтээгийн нүүрсний уурхайг түшиглүүлж 12 МВт-ын хүчин чадалтай дулааны цахилгаан станц барьж, Өвөрхангай аймгийн Арвайхээрийн дэд станцаас Баянтээгийн дулааны цахилгаан станц хүртэл 110 кВ–ын шугам, Баянтээгийн дулааны цахилгаан станцаас Баянхонгор аймгийн төв хүртэл 220 кВ-ын овор хэмжээтэй 110 кВ–ын шугам барина.

4.1.3 Орхон гол дээр 100 МВт хүчин чадалтай усан цахилгаан станц барьж 220 кВ–ын шугамаар төвийн эрчим хүчний системд холбох ажлыг эхлүүлнэ.

4.1.4 Хөвсгөл аймгийн төвийг төвлөрсөн эрчим хүчээр хангахын тулд Эрдэнэтээс Хөвсгөл аймгийн Мөрөн хүртэл 220 кВ–ын хүчдэлтэй 350 км урт шугам барина.

4.1.5. Сайншанд–Замын-Үүдийн 110 кВ–ын 198 км шугам барьж говийн аймгуудад салхины эрчим хүч ашиглан салхин станц барих судалгаа хийх, тэдгээрийг төвийн эрчим хүчний систем, Даланзадгадын дулааны цахилгаан станцтай холбох боломжийг судалж тогтооно.

4.1.6 Улаанбаатарт зарим дулааны цахилгаан станцад шинэчлэлт хийж дулааны цахилгаан станцуудын найдвартай, ашуулгүй ажиллагаа, үр ашгийг дээшлүүлж, өр, авлагагүй, гадаадаас авсан зээлээ төлөх чадвартай болгох иж бүрэн арга хэмжээ авна.

4.1.7 Төвийн бүсэд салхин станцын парк барьж, төвийн эрчим хүчний системд холбоно.

4.2. Хоёрдугаар үе шат буюу дунд шатны хугацаа (15 жил) - нд:

4.2.1 Ховд гол дээр Эрдэнэбүрэн-гийн усан цахилгаан станцыг үе шаттай барина.

4.2.2 Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцаас Ховдын Мянгадын 110 кВ–ын хүчдэлтэй дэд станц хүртэл 220 кВ–ын хүчдэлтэй 62 км шугам татаж, Мянгадын дэд станцыг өргөтгөж холбоно.

4.2.3 Орхон гол дээр 100 МВт хүчин чадалтай усан цахилгаан станц барьж 220 кВ–ын шугамаар төвийн эрчим хүчний системд холбоно. Дэлгэр мөрөн дээр 8-20 МВт хүчин чадалтай Чаргайтын усан цахилгаан станц барина. Энэ станцыг 20 МВт хүртэл өргөтгөж болохоор барьж усан цахилгаан станцаас Хөвсгөл аймгийн төв хүртэл 110 кВ–ын 47 км шугам татна. Баянхонгор аймагт салхин станц болон төвийн бүсэд усан цэнэгт цахилгаан станц барих судалгаа хийж, нэгдсэн системд холбох асуудлыг шийдвэрлэнэ.

4.2.4 Төвийн бүсэд Цагаан суварга, Оюутолгой, Шүтээн–Уул, Ихшанхайн нүрууны эзэсийн ордуудыг ашиглахан тохиолдолд Тавантолгойн коксжих нүүрсний уурхайг түшиглүүлэн дунд чадлын дулааны цахилгаан станц барьж, Мандалговь-Чойрын 220 кВ-ын шугамаар төвийн эрчим хүчний системд холбоно.

4.2.5 Улаанбаатарт Дулааны 3, 4 дугээр цахилгаан станцын техник-эдийн засгийн үзүүлэлтийг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлнэ. Улаанбаатар хотод 100 МВт орчим хүчин чадалтай дулааны цахилгаан станц барьж, хотын дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

4.2.6 Зүүн бүсэд Багануурраас Өндөрхаан-Чойбалсангийн чиглэлд 220 кВ-ын хүчдэлтэй 450 км шугам барина.

4.2.7 Дөргөний усан цахилгаан станц Улиастайн хооронд 360 км урт 220 кВ-ын шугам татаж баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн систем байгуулна. Ингэснээр баруун бүсийн 5 аймгийг холбосон эрчим хүчний нэгдсэн систем байгуулагдана.

4.2.8 Нүүрстхотгорын нөөцийг ашиглаж Ачит нуурын дулааны цахилгаан станц барих асуудлыг судалж шийдвэрлэнэ.

4.2.9 Эрдэнэтийн цахилгаан станцыг сэлбэх зорилгоор 50 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц, дулаан хангамжийн асуудлыг шийдвэрлэнэ.

4.2.10. Дарханы станцыг сэлбэх зорилгоор 60 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц, Багануурын нүүрсний уурхайг

гүшгүүлэн 100 МВт хүчин чадалтай дулааны цахилгаан станц барина.

4.2.11 Атомын цахилгаан станц барих болон говийн аймгуудад нарны эрчим хүчийг ашиглан том хүчин чадлын станц барих боломжийг судлана.

4.3. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем

4.3.1. Улаанбаатар, Улиастайн хооронд 400 кВ–ын хүчдэлтэй томоохон хүчин чадлын транзит шугам татаж, баруун бүсийн эрчим хүчний нэгдсэн системийг төвийн бүсийн эрчим хүчний системтэй холбон Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн системийг байгуулна. Баруун бүсийн цахилгаан хэрэглээ нь 80 МВт хүрэх үед энэхүү транзит шугам нь тус улсын эрчим хүчний нэгдсэн систем үүсгэсэн тэнхлэг шугам болох бөгөөд бүс нутгийн аль нэг талд байгаа илүүдэл эрчим хүчийг нөгөө талд ашиглах горим ажиллагааны зохицуулалт, аваарийн үеийн тэжээл авах бололцоо олгож хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийн найдвартай байдлыг сайжруулна.

4.3.2. Монгол Улсын Эрчим хүчний нэгдсэн систем байгуулахад одоогийн эрчим хүчний эх үүсвэрийн бүтцийг өөрчлөн шинэчилж, зах зээлийн нөхцөлд дэлхийн бусад оронд тогтвортой, үр ашигтай ажиллаж чадах нь нотлогдсон, ашиглалтын хамгийн бага зардалтай, манай орны эдийн засгийн онцлог нөхцөлд тохирсон, хөрөнгө оруулалтаа богино хугацаанд нөхөх хүч чадал бүхий Усан цахилгаан станцыг Эгийн гол, Арцатад барьж байгуулна.

Тав . Сумдын цахилгаан хангамж

5.1. Хөдөөгийн сумдад дизель цахилгаан станц ажиллуулж, жил бүр гадаадаас өндөр үнэтэй түлш худалдан авч, түлшийг тээвэрлэн газар дээр нь хүргэхэд үлэмж зардал гарган байж цөөн цагийн гэрэлтүүлэг тэдий асуудлыг шийдвэрлэж байгаа хөдөөгийн эрчим хүчний үйлдвэрлэлийн бүтцийг өөрчилж шинэчилнэ.

5.2. Одоогийн байдлаар эрчим хүчний төвлөрсөн хангамжид 142 сумыг холбоод байна. 5 жилийн хугацаанд 30 гаруй сумыг төвлөрсөн эрчим хүчний системд холбоно. 5-15 жилийн хугацаанд төвлөрсөн эрчим хүчний системд 80 гаруй сумыг 6, 10, 15, 35 кВ-ын шугамаар холбож цахилгаанжуулна.

5.3. Төвлөрсөн цахилгаан хангамжид холбогдох боломжгүй алслагдсан сумдыг дизель-ус, дизель-салхи г.м эрчим хүчний хосолсон шинэ эх үүсвэрээр ойрын болон дунд хугацаанд хангах бодлогыг баримтална.

5.4. Хэтийн хугацаанд 30 гаруй сумыг төвлөрсөн эрчим хүчний хангамжид холбох боломжтой бөгөөд үлдсэн 40 орчим сумдын цахилгаан хангамжийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангана.

5.5. Эрчим хүчний системд холбох сумдын эрчим хүчний хангамжийн асуудлыг орон нутгийн хэтийн хөгжилтэй уялдуулж, техник эдийн засгийн болон горим ажиллагааны нарийвчилсан тооцоонд үндэсэн дээр нэгдсэн бодлогоор зохицуулах чиглэл баримтална.

5.6. Төвлөрсөн системд холбох нь сумдыг найдвартай цахилгаан хангамжтай болгож, хөдөө орон нутаг хөгжих нөхцлийг бүрдүүлнэ. Сумдад жижиг дунд үйлдвэр болон үйлчилгээний салбар хөгжүүлэх замаар нэг сумын хэрэглэгчдийн цахилгаан ачааллыг доод тал нь 200–250 кВт хэмжээнд хүргэж, шугамын хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх бодлого баримтална.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт

1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

6.1.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох байгууллагуудтай хамтран удирдан зохион байгуулж, хэрэгжилтийг 2 жилд нэг удаа Засгийн газарт тайлагнана. Засгийн газар тайланг Улсын Их Хуралд танилцуулж байна.

2. Хөтөлбөрийн санхүүжилт

6.2.1. Хөтөлбөр хэрэгжүүлэхэд дараахь эх үүсвэрийг ашиглана:

- улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв,
- дотоодын болон гадаадын хөрөнгө оруулалт,
- гадаадын хөнгөлттэй зээл, тусламжийн хөрөнгө,
- эрчим хүчний салбарын компаниудын хөрөнгө,
- дотоодын болон олон улсын төрийн бус байгууллагын хөрөнгө,
- бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

1. Манай орны нийт нутаг дэвсгэр дээрх цахилгаан станцууд харилцан нөхөн ажиллах боломжийг бүрдүүлж, улсын хэмжээнд цахилгаан эрчим хүчний хангамжийн найдвартай, оюутлүй, гадаадаас хамааралгүй ажиллах нөхцөлийг бий болгоно.

2. Монгол Улсын эрчим хүчний нэгдсэн систем байгуулснаар нийт улс орны цахилгаан хангамжийг хамгийн үр ашигтай аргаар удирдах

нөхцөл бүрдэж, улмаар улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг бүхэлд нь түргэтгэж үндэсний эдийн засгийн аюулгүй байдал баталгаатай болох үндэс бүрдэнэ.

3. Эрчим хүчний үйлдвэрүүдийн өрсөлдөх боломж бүрдэн өртөг зардал буурах, нэгдсэн үнэ тариф мөрдөх боломж хангагдсанаар бүс нутгуудад жижиг, дунд үйлдвэр болон үйлчилгээг жигд хөгжүүлэх, улс орны мэдээллийн технологийн нэгдсэн сүлжээг үүсгэх боломж нээгдэн гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад харилцан ашигтай хамтын ажиллагаа өрнүүлэх таатай нөхцөл бүрдэнэ.

4. Эдийн засгийн бүсүүдэд олборлох, боловсруулах, жижиг, дунд үйлдвэрлэл болон үйлчилгээний салбарыг нэмэгдүүлж шинэ ажлын байр бий болж, ядуурлыг бууруулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

5. Хүн амын зохистой нягтрал бий болохуйц хөгжлийн орчин нөхцөлийг бүрдүүлж, хот хөдөөгийн ялгааг багасгаж, төв рүү тэмүүлсэн нүүдлийг зохицуулахад нөлөөлнө.

6. Усан цахилгаан станцыг дулааны цахилгаан станцтай хослон ажиллуулах нь их хэмжээний нүүрсний нөөцийг хэмнэх, байгаль орчныг хамгаалах, дулааны цахилгаан станцуудыг өвлийн их ачаалалд бэлтгэж нүүрс нөөцлөх боломжийг бүрдүүлж, эрчим хүчний үйлдвэрлэлийн ашиглалтын зардлыг бууруулна.

Эрчим хүчний системийн төдийгүй нийт хэрэглэгчдийг эрчим хүчээр хангах үйл ажиллагааг шуурхай удирдах автомат удирдлагатай систем нэвтрүүлэх нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 7-ны өдөр | **Дугаар 27** | **Улаанбаатар хот**

Байнгын хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Б.Баттулгын хүсэлтийг харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооноос чөлөөлж, Байгаль орчин, хөдөөгийн хөгжлийн байнгын хорооны гишүүнээр батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | **Дугаар 79** | **Улаанбаатар хот**

Балдан-Осорын Алтангэрэлд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Аж үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн өндөр ур чадвар эзэмшин бүтээгдэхүүний чанар, үзэмжийг сайжруулах, үйлдвэрлэлийн шинэ багаж, төхөөрөмж санаачлан нэвтрүүлж, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Зоос гоёл" ХК-ийн дархан-токарьчин Балдан-Осорын Алтангэрэлд Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | **Дугаар 80** | **Улаанбаатар хот**

Чүлтэмийн Алтан-Өлзийд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж жүжиг, киноны гол дүр, туслах дүрүүдийг мэргэжлийн өндөр түвшинд бүтээж, тайз, дэлгэцийн урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Үндэсний жүжгийн академик театрын жүжигчин Чүлтэмийн Алтан-Өлзийд Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 81 | Улаанбаатар хот

Гомбын Дэлгэрт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Монгол телевиз, телекино үйлдвэрт санаачилга, үр бүтээлтэй ажиллаж олон арван мэдээ, сурвалжлага, баримтат кино, теле жүжгийн зураг авч, телевизийн нэвтрүүлгийг үзэгч олонд хүргэх, соёлын үнэт өв бий болгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Монгол телевизийн "Монголын мэдээ" агентлагийн зураглаач Гомбын Дэлгэрт Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2002 оны 5 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 82 | Улаанбаатар хот

Сэрээнэнгийн Майдаржавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн сурах таатай орчинг бүрдүүлэх, заах аргын ур чадвараа дээшлүүлэн тэдний авьяас чадварыг хөгжүүлэх, сургуулийн өмнөх боловсрол олгоход оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн Хан-Уул дүүргийн 65 дугаар цэцэрлэгийн багш Сэрээнэнгийн Майдаржавт Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот

Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

хөрөнгөөс гаргаж" гэж нэмсүгэй.

"Хөрөнгө гаргах тухай" Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 16 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "энэ оны П улиралд багтаан" гэсний дараа "Засгийн газрын нөөц

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 76 | Улаанбаатар хот

Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөрт өөрчлөлт оруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2002 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор батлсан "Төрийн өмчийг 2002 онд хувьчлах хөтөлбөр"-ийн 1 дүгээр хавсралтад дор дурдсан агуулгатай 20 дугаар заалт нэмж, мөн хөтөлбөрийн 2 дугаар хавсралтын 8 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байршил (аймаг, хот, сум, дүүрэг)	Үндсэн үйл ажиллагаа	Төрийн эзэмшлийн хувьцаа		Хувьчлах хугацаа /улиралаар/	Хувьчлах арга хэлбэр, нөхцөл
				Нийт хувь	үүнээс: хувьчлах хувь		
20	Хөдөө аж ахуйн банк	Улаанбаатар /аймаг, сумдад салбартай/	Банкны үйлчилгээ	100	100	П-IУ	Гадаад,дотоодын стратегийн хөрөнгө оруулагчдын дунд уралдаант шалгаруулалтын аргаар

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Дугаар 79 **Улаанбаатар хот**

Улсын хилийг шалгах ажилд хөрөнгө нэмж гаргах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улс, БНХАУ-ын хоорондын улсын хилийг шалгах Хамтарсан комиссын Монголын хэсгийн 2002 оны төсөвт нэмж хилийн техөөрөмжийн болон геодези, байр зүйн хэрэгцээ гаргуулах ажлыг гүйцэтгэхэд зориулан 482.4 (дөрвөн зуун наян хоёр сая дөрвөн зуун мянга) сая төгрөгийг улсын төвлөрсөн төсвийн орлогын бүрдүүлэлтийг харгалзан Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

2. Монгол Улс, БНХАУ-ын хоорондын улсын хилийг шалгах, хилийн техөөрөмж, геодези, байр зүйн хэрэгцээ гүйцэлбор ажлыг гүйцэтгэх ажлын хэсэг, салбар комиссын хэрэгцээнд зориулж Батлан хамгаалах яамны нөөцөөс УРАЛ-375 маркийн 17 автомашиныг Хамтарсан комиссын Монголын хэсэгт балансаас балансад шилжүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаад зөвшөөрсүгэй.

3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2000 оны 149 дүгээр зарлигаар батлагдсан "Улсын хил хамгаалалтад иргэдийг оролцуулах журам"-ын "зургаа"-гийн 8 дугаар заалтыг үндэслэн хилийн техөөрөмжийн ажлын хэсэгт ажиллах энгийн хүмүүст олгох хүнсний зардлыг өөрийн төсөвтөө зохицуулан олгож байхыг Хамтарсан комиссын Монголын хэсгийн дарга, тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд Р.Хатанбаатарт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 1-ний өдөр Дугаар 81 **Улаанбаатар хот**

Ойн хөнөөлт шавьжтай тэмцэх хөрөнгийн тухай

Ойн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ойн хөнөөлт хортон шавьжийн судалгаа хийх, тэдгээртэй тэмцэх ажилд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

2. Ойн хөнөөлт хортон шавьжтай тэмцэх ажилд шаардагдах хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, техник, материалаар хангах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэн энэхүү ажлыг хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй арга хэлбэрээр зохион байгуулахыг Байгаль орчны сайд У.Барсболд, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 1-ний өдөр | Дугаар 83 | Улаанбаатар хот

Дүрэм батлах тухай

Захиргааны хариуцлагын тухай хуулийн 4[1] дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Иргэний нисэхийн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралт ёсоор батлуулсугай.

2. "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1999 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн 146 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2002 оны 83 дугаар тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Иргэний нисэхийн улсын хяналтын зорилго нь иргэний нисэхийн үйл ажиллагаанд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр мэргэжлийн хяналт тавьж, Иргэний нисэхийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам, стандартыг мөрдүүлэхэд оршино.

1.2. Иргэний нисэхийн үйл ажиллагаанд тавих улсын хяналтыг Иргэний нисэхийн ерөнхий газрын Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт, зохицуулалтын алба (цаашид "Хяналтын алба" гэх) хэрэгжүүлнэ.

1.3. Хяналтын албаны дарга нь иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч байна.

1.4. Улсын ерөнхий байцаагчийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

1.5. Иргэний нисэхийн хяналтын улсын байцаагч (цаашид улсын байцаагч гэх)-ийн эрхийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

1.6. Улсын байцаагч нь мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан бөгөөд хяналт шалгалтын ажлын дадлага туршлагатай байна.

1.7. Хяналтын алба, улсын байцаагчийн үйл ажиллагаа нь иргэний нисэхийн хууль тогтоомж, Иргэний нисэхийн олон улсын байгууллага (ИКАО)-ын стандарт, зөвлөмжийн хэрэгжилтийн байдалд мэргэжлийн хяналтыг хэрэгжүүлж, нисэхийн аюулгүй ажиллагааны журмыг зөрчсөн, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хохироосон зөрчлийг илрүүлж, түүнийг арилгуулахад чиглэгдэнэ.

1.8. Улсын байцаагч нь Засгийн газраас загварыг нь батлагдсан, уг улсын байцаагчийг томилох эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, түүнчлэн албан шаардлага, дүгнэлт, акт, торгуулийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Иргэний нисэхийн улсын хяналтын чиглэл

2.1. Нисэхийн аюулгүй ажиллагааны улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

2.1.1. иргэний нисэхийн хууль тогтоомж, тэдгээрт нийцүүлж Засгийн газар, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан шийдвэрийн биелэлт;

2.1.2. иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэхэд зөвшөөрөл олгох журмын биелэлт, зөвшөөрөл эзэмшигчийн үүргийн биелэлт;

2.1.3. иргэний нисэхийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, холбогдох стандартын мөрдөлт;

2.1.4 иргэний нисэхийн үйл ажиллагааны талаар эрх бухий байгууллага, албан тушаалтнаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан хэрхэн биелүүлж байгаа байдалд тавих хяналт, үнэлгээ.

Гурав. Улсын байцаагчийн үүрэг, эрх

3.1. Иргэний нисэхийн хяналтын улсын байцаагч нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

3.1.1. хяналт шалгалтыг энэ дүрмийн 2.1-д заасан чиглэлийн дагуу хэрэгжүүлэх;

3.1.2. өмчийн хэлбэр харгалзахгүйгээр иргэний нисэхийн аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх, илэрсэн зөрчлийг арилгуулах, таслан зогсоох арга хэмжээ авах;

3.1.3. хийсэн хяналт, шалгалт, гаргасан дүгнэлт, шийдвэрийнхээ үнэн зөвийг бүрэн хариуцах.

3.2. Иргэний нисэхийн хяналтын улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 9-д заасан нийтлэг бүрэн эрхээс гадна дор дурдсан эрх эдэлнэ:

3.2.1. хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах талаар зөвлөмж, хугацаатай үүрэг албан шаардлага өгөх, биелэлтийг гаргуулж авах;

3.2.2. хяналт шалгалтын ажилд холбогдох мэргэжлийн хүмүүсийг татан оролцуулах;

3.2.3. иргэний нисэхийн үйл ажиллагаанд тавьж байгаа хяналтын явцад бусад салбарын хууль, стандарт, дүрэм, журмаар тогтоосон шаардлагыг хангаагүй зөрчил илэрсэн тохиолдолд энэ талаар холбогдох мэргэжлийн хяналтын байгууллагад мэдэгдэж зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, шаардлагатай тохиолдолд шалгалтын акт, материалыг хууль хяналтын байгууллагад шилжүүлэх.

Дөрөв. Бусад зүйл

4.1. Улсын байцаагч нь иргэний нисэхийн хууль тогтоомж, холбогдох дүрэм, журам зөрчсөн, түүнчлэн илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй этгээдэд Иргэний нисэхийн тухай хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.2. Зөрчил гаргасан этгээд нь түүнд ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийг тогтоосон хугацаанд нь улсын төсвийн орлогод оруулна.

4.3. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл түүнийг хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан нисэхийн аюулгүй ажиллагааны хяналтын Улсын ерөнхий байцаагчид гомдол гаргана.

4.4. Ерөнхий байцаагч гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ. Энэ шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

4.5 Улсын байцаагч нь хууль зөрчсөн үйл ажиллагаа явуулсан бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

:002 оны 5 дугаар
:арын 1-ний өдөр

Дугаар 84

Улаанбаатар
хот

"Иод дутлын эмгэгтэй тэмцэх" үндэсний хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Дэлхий нийтээрээ иод дутлын эмгэгийг устгах зорилт дэвшүүлсэн Ромын 1992 оны Дэлхийн хоол, тэжээлийн тунхаглал, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" үндэсний шинэчилсэн хөтөлбөрийг хавсралт ёсоор батална.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавж биелэлтийг хангуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Үндэсний хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг 2003 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт тусган хэрэгжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт үүрэг болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Иод дутлын эмгэгтэй тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1996 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 6 дугаар тогтоолын 3 дугаар зүйлээс бусад зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

Засгийн газрын 2002 оны 84 дүгээр тогтоолын хавсралт

"ИОД ДУТЛЫН ЭМГЭГТЭЙ ТЭМЦЭХ" ҮНДЭСНИЙ ШИНЭЧИЛСЭН ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Сүүлийн жилүүдэд дэлхийн улс орнуудын устгахаар зорьсон эмгэгийн нэг нь чимээгүй тахал болох иод дутлын эмгэг юм. Хүний ялангуяа хүүхэд, өсвөр насныхны оюун ухааны хөгжилд сөрөг нөлөө үзүүлдэг иод дутлын эмгэгийг устгах хамгийн энгийн, найдвартай арга зам нь давсыг иоджуулан хэрэглэх явдал гэдгийг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрч гадаад орнууд хүнсний давсаа иоджуулан үр дүнд хүрчээ. Монгол Улсын Засгийн газраас 1996 онд батлагдсан "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" Үндэсний хөтөлбөрийн хүрээнд хүн амын дундах иод дутлын эмгэгийн тархалтын байдлыг судлан, хүнсний давсыг иоджуулах техник, технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлж, иоджуулсан давсны чанарт үйлдвэрлэл, худалдаа, хэрэглэгчийн түвшинд хяналт тавих, иод дутлын эмгэгийн хор хохирлоос урьдчилан сэргийлэх талаар суртачилгаа явуулах зэрэг бодлого, үйл ажиллагаа явуулаа.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд иоджуулсан давсны 10 гаруй жижиг, дунд үйлдвэр байгуулагдан ажиллаж байна. 2000 онд дотоодын үйлдвэрлэл болон импортоор 5.0 мянган тонн иоджуулсан давс хүнсний хэрэглээнд нийлүүлсэн нь нийт хүнсний давсны хэрэглээний 57 хувь болж байна. Давс иоджуулах төхөөрөмж болон иодын (кали иодат) баяжмалыг НҮБ-ын Хүүхдийн сан, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (ЖАЙКА)-ын техник, хамтын ажиллагааны тусламжаар хангаж байна. Хөтөлбөрийн үр дүнд сургуулийн насны хүүхдүүдийн дунд бахлуурын тархалт 1992 онд 29.2 хувь байсан бол 1999 онд 21.4 болж бууран айл

өрхийн 46 хувь нь иоджуулсан давс тогтмол хэрэглэж байна.

3. "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" Үндэсний хөтөлбөр хэрэгжсэн 1996-2001 онд дэвшүүлсэн зорилтоо хангахад тодорхой ахиц гарсан боловч цаашид шийдвэрлэвэл зохих олон асуудал байсаар байна. Бахлуурын тархалтыг 2000 он гэхэд 0.5 хувьд хүргэх, иоджуулсан давсаар хүн амын 95 хувийг хангах зорилтдоо хүрсэнгүй. Хүнсний давсны олборлолт хийдэг дотоодын давсны ордыг түшиглэсэн давс иоджуулах үйлдвэр байгуулагдаагүй, жижиг орд, нуураас иргэд өөрсдөө хүнсний давс олборлож хэрэглэсээр байна. Тухайлбал, өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээ төвийн бүсэд 63.6 хувь байхад давсны орд бүхий баруун бүсэд 24.3 хувь байна. Давсанд гүн боловсруулалт хийж цагаан давс үйлдвэрлэх техник, технологи нэвтрээгүйгээс энэ төрлийн импортын давсны хэмжээ өсч байна. Хүүхдийн шээсээр ялгарах иодын хоногийн хэмжээ 100-200 нг/л, нярайн цусан дахь бамбай булчирхай эрчимжүүлэгч дааврын хэмжээ 5 оун/мл-ээс ихгүй байвал иод дутлын эмгэгийн тархалтыг хэвийн гэж үздэг бол дээрх үзүүлэлт судалгаанд хамрагдсан хүүхдийн 75 хувьд нь 100 нг/л-ээс бага, нярай хүүхдийн 10.8 хувьд дааврын хэмжээ 5 оун/мл-ээс их байна.

4. НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын "Дэлхийн хоол тэжээлийн тунхаглал" (1992 оны)-д дэвшүүлсэн дэлхий нийтээрээ иод дутлын эмгэгийг устгах, иоджуулсан давсаар хүн амыг хангах зорилтыг өөрийн оронд хэрэгжүүлэх шаардлагыг үндэслэн; иоджуулсан давсны үйлдвэрлэлийг есгэж, хангамж, хэрэглээг хот, хөдөө, газар зүйн бүсэд жигд, хүртээмжтэй болгох шаардлагыг харгалзан; хүнсний бүтээгдэхүүнд баяжуулалт хийх эрх зүйн орчин бүрдүүлэх, хүн амд иоджуулсан давсны ач холбогдлыг ойлгуулах замаар хэрэглэх хэвшүүлэх, үр дүнг тооцох чиглэлээр цаашид явуулах бодлого, үйл ажиллагаагаа өргөтгөх шаардлагыг бодолцон; малд зориулсан иоджуулсан давс, хужир бэлтгэх хэмжээг нэмэгдүүлэх шаардлагыг харгалзан "Иод дутлын эмгэгтэй тэмцэх" Үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн үндсэн зорилго, зорилтууд

5. Иоджуулсан давсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хангамжийг жигд, хүртээмжтэй болгон, айл өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүн амын дундах иод дутлын эмгэгийн тархалтыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.

6. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараахь зорилтыг хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр зорилт: Иоджуулсан давсны үйлдвэрлэл, хангамж, үйлчилгээг дэмжих эрх зүйн орчинг боловсронгуй болгох;

Хоёрдугаар зорилт: Ордоос олборлох давсыг цэвэршүүлэх, үйлдвэрийн аргаар боловсруулах, иоджуулах чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэн, орон нутгийн хүн амын иоджуулсан давсны хэрэгцээ, хангамжийг сайжруулах;

Гуравдугаар зорилт: Хүн амын дундах иод дутлын эмгэгийг хянах тогтолцоог боловсронгуй болгох;

Дөрөвдүгээр зорилт: Гэр бүл, хувь хүн, олон нийтийн иод дутлын эмгэг, иоджуулсан давсны талаархи мэдлэгийг дээшлүүлж, иоджуулсан давс тогтмол хэрэглэдэг зан үйлийг хэвшүүлэх;

Тавдугаар зорилт: Үндэсний чадавхийг сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээ, тогтолцоо, санг бүрдүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

7. Нэгдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/хүнсний бүтээгдэхүүнийг баяжуулахад баримтлах бодлого, тэргүүлэх чиглэлд давсыг иодоор баяжуулах асуудлыг тодорхойлон тусгаж хэрэгжүүлэх;

б/иоджуулсан давсны үйлдвэрлэл, йлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх эрх зүйн рчинг бүрдүүлэх.

8. Хоёрдугаар зорилтын хүрээнд дараахь рга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/ордоос олборлох давсыг ɔвэршүүлэн, иоджуулах технологийг орон нутгийн ж ахуйн нэгжүүдэд нэвтрүүлж давсны чанарыг айжруулах;

б/давсыг үйлдвэрийн аргаар ɔоловсруулах технологийг нэвтрүүлж, хүнсний цагаан давсны үйлдвэр байгуулах;

в/давсны орд болон түүний ɔйролцоох сум, суурин газруудад иоджуулсан давсны жижиг үйлдвэр, цех байгуулан хөдөөгийн сүн амын иоджуулсан давсны хангамжийг айжруулах;

г/иоджуулсан давсны сан байгуулах ниглэлээр орон нутагт тохирсон төсөл хэрэгжүүлэх;

д/бөөний болон жижиглэн худалдааны сүлжээ, бусад арга замыг ашиглан иоджуулсан давсны хангалт, түгээлтийг айжруулах;

е/малын бахлуурын тархалтыг бүс нутгаар судлан тогтоож эрүүлжүүлэх зорилгоор иоджуулсан тэжээл, бэлдмэлийг шаардлагатай бүс нутгуудад туршин нэвтрүүлэх.

9. Гуравдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/иоджуулсан давсны хэрэглээ, иод дутлын эмгэгийн тархалтыг судлах;

б/сургуулийн өмнөх болон бага ангийн сурагчдын оюуны чадамжийг тодорхойлох судалгаа хийж эхлэх;

в/нярай хүүхдэд төрөлхийн гипотиреоз илрүүлэх скрининг аргыг улсын хэмжээнд нэвтрүүлэх;

г/бүсийн эмчилгээ, оношлогооны төвийн лабораторийг түшиглэн иод дутлын эмгэгийн тархалтыг биохимийн үзүүлэлтээр хянах нөхцөлийг үе шаттайгаар бүрдүүлэх;

д/давсны иоджуулалтын түвшинг үнэлэх шалгуур, үзүүлэлтийг боловсруулж шаардлагатай үед үндэсний стандарт, эрүүл ахуй, аюулгүйн үзүүлэлтийг шинэчлэн тогтоож мөрдүүлж байх;

е/иоджуулсан давсны чанарт тавих хяналтыг тогтмолжуулах, хяналтын үр дүнг сайжруулах;

ж/иоджуулсан давсны болон малын эрдэс тэжээлийн үйлдвэр, цехэд чанарын дотоод хяналтын лаборатори байгуулж, бүтээгдэхүүний чанарыг баталгаажуулах.

10. Деревдүгээр зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/бүх шатны сургууль болон албан бус сургалтын хөтөлбөрт иод дутлын эмгэг, иоджуулсан давсны талаар оруулах;

б/төв, орон нутагт сургалт, сурталчилгааны баг ажиллуулж хэвлэл, мэдээлэл, соёл, урлаг, спорт, биеийн тамирын арга хэмжээг ашиглан иоджуулсан давсны ач холбогдол, иод дутлын эмгэгтэй тэмцэх талаархи сурталчилгааг тогтмолжуулах;

в/сургалт, сурталчилгааны хөтөлбөр боловсруулах, гарын авлага, зөвлөгөө, арга зүй, материалаар хангах.

11. Тавдугаар зорилтын хүрээнд дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/иод дутлын эмгэг, иоджуулсан давсны асуудлаар гадаад болон дотоодын үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагааг өргөжүүлэн, сургалт, семинар, уулзалт зохион байгуулах, гадаадад зохиогдох арга хэмжээнд оролцох;

б/давсны орд, үйлдвэрлэл,

борлуулалт, иод дутлын эмгэгийн тархалт, иоджуулсан давсны хэрэглээний талаар мэдээллийн сан байгуулах, ВЕБ хуудас ажиллуулах;

в/иоджуулсан давсны үйлдвэр, цех болон үйлчилгээний ажилтан, ажилчид, мэргэжлийн эмч нар, лабораторийн шинжээч, судлаач, багш нарын дунд төрөлжсөн сургалт зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, хугацаа

12. Хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнг эрүүл мэнд болон хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн сайд (цаашид "эрхэлсэн сайд" гэнэ), аймаг, нийслэлийн Засаг дарга хариуцна.

13. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд удирдан зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих үүрэг бүхий яам хоорондын болон орон нутгийн (аймаг, сум) орон тооны бус зохицуулах зөвлөл ажиллуулж болно.

14. Яам хоорондын зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах чиглэл, жилийн ажлын төлөвлөгөөг эрхэлсэн сайд нар батлан, хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг авч ажиллана.

15. Орон нутаг дахь салбар зөвлөлийн дарга, бүрэлдэхүүнийг аймаг, нийслэлийн Засаг дарга батална. Орон нутгийн салбар зөвлөл жилийн ажлын төлөвлөгөөтэй байна.

16. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар жил бүрийн 1 дүгээр сард багтаан Эрүүл мэндийн болон Хүнс, хөдөө аж ахуйн яаманд тайлагнана. Хөтөлбөрийн хэрэгжилтийн жилийн тайланг нэгтгэн дүгнэж эрхэлсэн сайд нар жил бүрийн I улиралд Засгийн газарт тайлагнана.

17. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах үйл ажилагаат дор дурдсан эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

а/улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв;

б/хандивлагч орон, НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын байгууллагын тусламж;

в/жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан;

г/иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын хандив, тусламж;

д/гадаадын хөрөнгө оруулалт;

е/арилжааны банкны зээл.

18. Хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

1 дүгээр үе: 2002-2004 он -Хүн амын дунд бахлуурын тархалтыг 15 хувиас бага болгох, айл өрхийн иоджуулсан давсны хэрэглээг 75 хувьд хүргэж, түүнийг хянах, үнэлэх, баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

2 дугаар үе: 2005-2006 он -Эмзэг бүлгийн хүн амын дунд иод дутлын эмгэгийн бууралтыг хянаж, хүн амын дунд бахлуурын тархалтыг 10 хувиас бага болгон, айл өрхийн иоджуулсан давсны хэрэглээг 95 хувьд хүргэн, түвшинг тогтворжуулах бэлтгэлийг хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулах.

Тав. Хамтын ажиллагаа, туншлэл, олон нийтийн оролцоо

19. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд НҮБ-ын төрөлжсөн болон олон улсын бусад байгуулага, хандивлагч орны дэмжлэгийг авч, төрийн болон төрийн бус байгуулага, бусад оролцогч ах ахуйн нэгжийн хамтын ажиллагаат өргөжүүлнэ.

20. Хөтөлбөр хэрэжүүлэх үйл ажиллагааны зарим хэсгийг гэрээний үндсэн дээр төрийн бус байгуулагаар гүйцэтгүүлж болно.

Зургаа. Хөтөлбөрийн хэрэгжилтийн–шинжилгээ үнэлгээ, гарах үр дүнгийн шалгуур, үзүүлэлт

21. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг Эрүүл мэндийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар хэрэгжүүлнэ.

22. Зорилго, зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

Шалгуур үзүүлэлт	Өнөөгийн түвшин	Хүрэх түвшин	Мэдээллийн эх үүсвэр
Хөтөлбөрийн зорилго			
Иоджуулсан давсны хэрэглээний хэмжээг нэмэгдүүлж хүртээмжтэй болгон, аил ерхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх замаар иодын дутагдлаас үүдэлтэй эмгэгийн тархалтыг бууруулахад оршино.	7-11 насны хүүхдүүдийн дундаж бахлуурын тархалтын хувь Шээсэн дэх иодын агуулалж 100 нг/л-ээс бага байх хувь Нярайн цусан дахь БЭД 5 оунлиттэс их байх хувь 7-11 насны хүүхдийн оюуны чадамжийн түвшин ***Зорилтууд***	21,4 62,5% 10,8% 2002 оны судалгааны дүн	2004 онд 15,0% 2006 онд 10,0% <50% 5% сууль түвшингээс сайжирсан байна	Судалгаагаар (НЭМХ, UNICEF) Судалгаагаар (НЭМХ, UNICEF) Судалгаагаар (НЭМХ, UNICEF) скрининг шинжилгээний дүн Судалгаагаар (ЭО төв, НЭМХ)
Иоджуулсан давсны үйлдвэрлэл, хангамжийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Бодлого, тэргүүлэх чиглэл, эрх зүйн баримт бичиг давсыг иоджуулах асуудал тусгагдсан байх.	Хүнсний хуулийн хүнсний бүтээгдэхүүний бүтээгдэхүүнд тухай баяжуулах тухай хуулиудаар бодисуудаар баяжуулах, Нийслэл болон заавал, Нийслэл болон аймгийн Засаг даргын захиралж.	Холбогдох эрх зүйн баримт бичгүүд, тэргүүлэх чиглэл заалт орсон хууль бодлого,
Ордос олборлох давсыг цэвэршүүлэх, иоджуулах, боловсруулах, үйлдвэрлэх, иоджуулах технологийг нэвтрүүлсэн ордын тоо	Иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлээр хангах хувь Хүнсний хэрэглээнд нийлүүлсэн давсны иоджуулсан давсны эзлэх хувь Давс цэвэршүүлэх, иоджуулах технологийг нэвтрүүлсэн ордын тоо	26% 57% 0	50% 100% 2004 онд- 6 2006 онд 4	ХХАА9 ХХАА9 ХХАА9

	Хүнсний цагаан давсны үйлдвэрийн тоо	0	1	ХХААЯ
	Өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээний хувь /бүсээр/	Баруун бүс-24.3 Төвийн бүс-63.6 Зүүн бүс-48.8 Говийн бүс- 37.4	*2004 онд* Баруун бүс- 75 Төвийн бүс-85 Зүүн бүс-75 Говийн бүс-75 *2006 онд* Баруун бүс- 95 Төвийн бүс- 95 Зүүн бүс- 95 Говийн бүс- 95	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
Хүн амын дундах иод дутлын эмгэгийг хянах тогтолцоог боловсронгуй болгох	Иод дутлын эмгэгийг хянах бүсийн лабораторийн тоо	1 (НЭМХ)	2004 онд - 2 2006 онд - 2	ЭМЯ
	Дотоод хяналтын лабораторийн шинээр байгуулах үйлдвэрийн тоо	-	2004 онд – 6 2006 онд - 4	ХХААЯ
	Хурдавчилсан аргаар давсны иоджуулалтыг хянах лабораторийн бүхий хилийн боомтын тоо	(Сүхбаатар, Замын-Үүд)	Байгын ажиллагаа бүхий хилийн боомтын тоогоор	ЭМЯ, ЭМУХА
Гэр бүл, хувь хүн, олон нийтийн иод дутлын эмгэг, иоджуулсан давсны талаархи мэдлэгийг дээшлүүлж, иоджуулсан давсыг тогтмол хэрэглэдэг зан үйлийг хэвшүүлэх	Иод дутлын эмгэг болон иоджуулсан давсны талаархи хүн амын мэдлэгийн түвшин	95%	99%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
	Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь	46%	2004 онд 75% 2006 онд 95%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
Үндэсний чадавхийг сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээ, тогтолцоо, санг бүрдүүлэх	Давсны үйлдвэрлэл, хангамж, сургалт, судалгааны үндэсний чадавхийг сайжирсан нь дээрх шалгууруудаар хэмжигдэнэ			

22. Зорилго, зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

	Шалгуур үзүүлэлт	Өнөөгийн түвшин	Хүрэх түвшин	Мэдээллийн эх үүсвэр
Хөтөлбөрийн зорилго				
Иоджуулсан давсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хангамжийг жигд, хүртээмжтэй болгон, айл өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүн амын дундах иод дутлын эмгэгийн тархалтыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.	7-11 насны хүүхдүүдийн дундах бахлуурын тархалтын хувь	21,4	2004 онд 15,0% 2006 онд 10,0%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
	Шээсэн дэх иодын агууламж 100 нг/л-ээс бага байх хувь	62,5%	<50%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
	Нярайн цусан дахь БЭД 5 оун/мл-ээс их байх хувь	10,8%	5%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF) скринингийн шинжилгээний дүн
	7-11 насны хүүхдийн оюуны чадамжийн түвшин	2002 оны судалгааны дүн	суурь түвшингээс сайжирсан байна	Судалгаагаар (IQ төв, НЭМХ)
Зорилтууд				
Иоджуулсан давсны үйлдвэрлэл, хангамж, үйлчилгээг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Бодлого, тэргүүлэх чиглэл, эрх зүйн баримт бичигт давсыг иоджуулах асуудал тусгагдсан байх.	Хүнсний хуулийн хүнсний бүтээгдэхүүнийг бичил бодисуудаар баяжуулах тухай заалт, Нийслэл болон аймгийн Засаг даргын захирамж		Холбогдох заалт орсон хууль эрх зүйн баримт бичгүүд, бодлого, тэргүүлэх чиглэл
Ордоос олборлох давсыг цэвэршүүлэх, үйлдвэрийн аргаар боловсруулах, иоджуулах чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэн, орон нутгийн хүн амын иоджуулсан давсны хэрэглээ, хангамжийг сайжруулах	Иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлээр хангах хувь	26%	50%	ХХААЯ
	Хүнсний хэрэглээнд нийлүүлсэн нийт давсанд иоджуулсан давсны эзлэх хувь	57%	100%	ХХААЯ
	Давс цэвэршүүлэх, иоджуулах технологийг нэвтрүүлсэн ордын тоо	0	2004 онд- 6 2006 онд 4	ХХААЯ

	Хүнсний цагаан давсны үйлдвэрийн тоо	0	1	ХХААЯ
	Өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээний хувь /бүсээр/	Баруун бүс-24.3 Төвийн бүс-63.6 Зүүн бүс-48.8 Говийн бүс- 37.4	*2004 онд* Баруун бүс- 75 Төвийн бүс-85 Зүүн бүс-75 Говийн бүс-75 *2006 онд* Баруун бүс- 95 Төвийн бүс- 95 Зүүн бүс- 95 Говийн бүс- 95	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
Хүн амын дундах иод дутлын эмгэгийг хянах тогтолцоог боловсронгуй болгох	Иод дутлын эмгэгийг хянах бүсийн лабораторийн тоо	1 (НЭМХ)	2004 онд - 2 2006 онд - 2	ЭМЯ
	Дотоод хяналтын лабораторийн шинээр байгуулах үйлдвэрийн тоо	-	2004 онд – 6 2006 онд - 4	ХХААЯ
	Хурдавчилсан аргаар давсны иоджуулалтыг хянах лабораторийн бүхий хилийн боомтын тоо	(Сүхбаатар, Замын-Үүд)	Байгуулагаа бүхий хилийн боомтын тоогоор	ЭМЯ, ЭМУХА
Гэр бүл, хувь хүн, олон нийтийн иод дутлын эмгэг, иоджуулсан давсны талаархи мэдлэгийг дээшлүүлж, иоджуулсан давсыг тогтмол хэрэглэдэг зан үйлийг хэвшүүлэх	Иод дутлын эмгэг болон иоджуулсан давсны талаархи хүн амын мэдлэгийн түвшин	95%	99%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
	Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь	46%	2004 онд 75% 2006 онд 95%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
Үндэсний чадавхийг сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээ, тогтолцоо, санг бүрдүүлэх	Давсны үйлдвэрлэл, хангамж, сургалт, судалгааны үндэсний чадавхийг сайжирсан нь дээрх шалгууруудаар хэмжигдэнэ			

22. Зорилго, зорилтын шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин

	Шалгуур үзүүлэлт	Өнөөгийн түвшин	Хүрэх түвшин	Мэдээллийн эх үүсвэр
	Хөтөлбөрийн зорилго			
Иоджуулсан давсны үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хангамжийг жигд, хүртээмжтэй болгон, айл өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээг нэмэгдүүлэх замаар хүн амын дундах иод дутлын эмгэгийн тархалтыг бууруулахад хөтөлбөрийн зорилго оршино.	7-11 насны хүүхдүүдийн дундах бахлуурын тархалтын хувь	21,4	2004 онд 15,0% 2006 онд 10,0%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
	Шээсэн дэх иодын агууламж 100 нг/л-ээс бага байх хувь	62,5%	<50%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
	Нярайн цусан дахь БЭД 5 оун/мл-ээс их байх хувь	10,8%	5%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF) скринингийн шинжилгээний дүн
	7-11 насны хүүхдийн оюуны чадамжийн түвшин	2002 оны судалгааны дүн	суурь түвшингээс сайжирсан байна	Судалгаагаар (IQ төв, НЭМХ)
	Зорилтууд			
Иоджуулсан давсны үйлдвэрлэл, хангамж, үйлчилгээг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Бодлого, тэргүүлэх чиглэл, эрх зүйн баримт бичигт давсыг иоджуулах асуудал тусгагдсан байх.	Хүнсний хуулийн хүнсний бүтээгдэхүүнийг бичил бодисуудаар баяжуулах тухай заалт, Нийслэл болон аймгийн Засаг даргын захирамж		Холбогдох заалт орсон хууль эрх зүйн баримт бичгүүд, бодлого, тэргүүлэх чиглэл
Ордоос олборлох давсыг цэвэршүүлэх, үйлдвэрийн аргаар боловсруулах, иоджуулах чиглэлийн үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлэн, орон нутгийн хүн амын иоджуулсан давсны хэрэгцээ, хангамжийг сайжруулах	Иоджуулсан давсны дотоодын үйлдвэрлэлээр хангах хувь	26%	50%	ХХААЯ
	Хүнсний хэрэгцээнд нийлүүлсэн нийт давсанд иоджуулсан давсны эзлэх хувь	57%	100%	ХХААЯ
	Давс цэвэршүүлэх, иоджуулах технологийг нэвтрүүлсэн ордын тоо	0	2004 онд- 6 2006 онд 4	ХХААЯ

	Хүнсний цагаан давсны үйлдвэрийн тоо	0	1	ХХААЯ
	Өрхийн түвшинд иоджуулсан давсны хэрэглээний хувь /бүсээр/	Баруун бүс-24.3 Төвийн бүс-63.6 Зүүн бүс-48.8 Говийн бүс- 37.4	*2004 онд* Баруун бүс- 75 Төвийн бүс-85 Зүүн бүс-75 Говийн бүс-75 *2006 онд* Баруун бүс- 95 Төвийн бүс- 95 Зүүн бүс- 95 Говийн бүс- 95	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
Хүн амын дундах иод дутлын эмгэгийг хянах тогтолцоог боловсронгуй болгох	Иод дутлын эмгэгийг хянах бүсийн лабораторийн тоо	1 (НЭМХ)	2004 онд - 2 2006 онд - 2	ЭМЯ
	Дотоод хяналтын лабораторийн шинээр байгуулах үйлдвэрийн тоо	-	2004 онд – 6 2006 онд - 4	ХХААЯ
	Хурдавчилсан аргаар давсны иоджуулалтыг хянах лабораторийн бүхий хилийн боомтын тоо	(Сүхбаатар, Замын-Үүд)	Байгууллагын ажиллагаа бүхий хилийн боомтын тоогоор	ЭМЯ, ЭМУХА
Гэр бүл, хувь хүн, олон нийтийн иод дутлын эмгэг, иоджуулсан давсны талаархи мэдлэгийг дээшлүүлж, иоджуулсан давсыг тогтмол хэрэглэдэг зан үйлийг хэвшүүлэх	Иод дутлын эмгэг болон иоджуулсан давсны талаархи хүн амын мэдлэгийн түвшин	95%	99%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
	Иоджуулсан давс хэрэглэдэг өрхийн эзлэх хувь	46%	2004 онд 75% 2006 онд 95%	Судалгаагаар (НЭМХ, UNICEF)
Үндэсний чадавхийг сайжруулах, мэдээллийн нэгдсэн сүлжээ, тогтолцоо, санг бүрдүүлэх	Давсны үйлдвэрлэл, хангамж, сургалт, судалгааны үндэсний чадавхийг сайжирсан нь дээрх шалгууруудаар хэмжигдэнэ			

23. Зорилтын шалгуур, хүрэх түвшин /аймаг тус бүрээр/

№	Аймаг, нийслэлийн нэр	Иоджуулсан давсны жижиг, дунд үйлдвэр /тоо/		Давс цэвэршүүлэх арга нэвтрүүлэх орд /тоо/		Иоджуулсан давсны үйлдвэрлэлт /жил/тн/		Бахлуурын тархалтын өнөөгийн байдал %	Бахлуурын тархалтыг бууруулах түвшин /%/		Өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээний өнөөгийн байдал /%/	Өрхийн түвшин дэх иоджуулсан давсны хэрэглээний хүрэх түвшин /%/		Иод дутлын эмгэгийн хянах бүсийн лабораторийн байгууллах /тоо, эх сурвалж/	
		2004	2006	2004	2006	2004	2006	1999	2004	2006	1999	2004	2006		
1	Архангай	1				5	10	22.7	15	10	5.8	75	95		
2	Баян-Өлгий	1				20	40	29.5	20	14	12.0	75	95		
3	Баянхонгор	1	1			40	80	15.5	10	5	15.1	75	95		
4	Булган	1				5	10	24.0	20	14	30.3	75	95		
5	Говь-Алтай	2	1		1	40	150	16.0	10	5	19.5	75	95		
6	Говьсүмбэр		1			-	10	14.5	10	5	93.3	95	95		
7	Дархан-Уул	1				10	20	26.0	20	14	57.5	85	95		
8	Дорноговь		1			-	5	14.5	5	3	91.0	95	95		1 /UNICEF
9	Дорнод	2		1		100	150	17.5	10	5	51.0	75	95	1 /UNICEF	
10	Дундговь		1			-	5	11.0	5	3	76.3	90	95		
11	Завхан	3		1	1	250	300	27.5	20	14	13.9	75	95		
12	Орхон	1				5	10	30.8	20	14	79.7	95	95		
13	Өвөрхангай	7				70	100	25.0	18	14	37.9	75	95		1 /Жайка/
14	Өмнөговь	2		1		40	100	9.1	5	3	35.0	75	95		
15	Сүхбаатар	1		1		20	20	19.5	15	10	29.4	75	95		
16	Сэлэнгэ	1				5	10	25.5	18	14	41.0	75	95		
17	Төв		1			-	5	31.6	20	14	68.4	85	95		
18	Увс	2	1	1	1	150	300	22.0	20	14	16.2	75	95		
19	Ховд	2		1	1	150	300	27.5	20	14	11.0	75	95	1 /АХБ/	
20	Хөвсгөл	3				30	50	28.3	20	14	56.7	75	95		
21	Хэнтий		1			-	5	20.3	15	10	66.0	85	95		
22	Улаанбаатар	7				2810	4000	20.3	14	10	91.8	95	95		
	Улсын хэмжээнд	**38**	**8**	**6**	**4**	**3750**	**5680**	**21.0**	**15.0**	**10.0**	**46.0**	**75**	**95**		

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

Конвенци хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Бараг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай ТИР Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. ТИР Конвенцийн хүрээнд бараг олон улсын хэмжээнд тээвэрлэхэд таслах хуудас бүхий дагалдах дэвтэр (карней)-ийг олгох, Монгол Улсын нутаг дэвсгэрт карнейтай холбогдон үүсэх хариуцлага хүлээх баталгаа гаргах эрхийг Монголын автотээвэр эрхлэгчдийн үндэсний нийгэмлэгт олгосугай.

2. ТИР Конвенцийн шаардлагыг хангаж байгаа тээвийн хэрэгслийг шалгаж баталгаажуулж байхыг Автотээвэрийн газар (Ж.БАТ-ЭРДЭНЭ)-т үүрэг болгосугай.

3. ТИР Конвенцийн хүрээнд бараг олон улсын хэмжээнд тээвэрлэхэд Монгол Улсын нутаг дэвсгэрт гаалийн бүрдүүлэлт хийх, хяналт тавих байгууллагын жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор, Монгол Улсын хилээр нэвтрүүлэх гаалийн байгууллагын жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

4. ТИР Конвенцийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа тээвэрлэгч болон гаалийн, мөн энэ тогтоолоор эрх олгогдсон баталгаа гаргагч үндэсний байгууллагын ажилтнуудад ТИР Конвенцийн болон олон улсын зохих хөтөлбөрийн дагуу сургалт зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2002 оны 86 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ТИР КОНВЕНЦИЙН ХҮРЭЭНД БАРААГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ТЭЭВЭРЛЭХЭД МОНГОЛ УЛСЫН НУТАГ ДЭВСГЭРТ ГААЛИЙН БҮРДҮҮЛЭЛТ ХИЙХ, ХЯНАЛТ ТАВИХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

1. Улаанбаатар хот дахь Гаалийн газар
2. Дархан-Уул аймаг дахь Гаалийн хороо
3. Орхон аймаг дахь Гаалийн хороо
4. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар дахь Гаалийн газар
5. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь Гаалийн салбар
6. Дорноговь аймгийн Замын-Үүд дахь Гаалийн газар
7. Баян-Өлгий аймгийн Өлгий дахь Гаалийн газар
8. Баян-Өлгий аймгийн Цагаannуур дахь Гаалийн салбар
9. Дорнод аймгийн Чойбалсан дахь Гаалийн газар
10. Дорнод аймгийн Эрээнцав дахь Гаалийн салбар
11. Ховд аймгийн Ховд дахь Гаалийн газар
12. Ховд аймгийн Булган дахь Гаалийн салбар (зөвхөн Булган боомтод)
13. Увс аймгийн Улаангом дахь Гаалийн газар
14. Увс аймгийн Боршоо дахь Гаалийн салбар

Засгийн газрын 2002 оны 86 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ТИР КОНВЕНЦИЙН ХҮРЭЭНД БАРААГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ТЭЭВЭРЛЭХЭД МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ ГААЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЖАГСААЛТ

1. Сэлэнгэ аймгийн Алтанбулаг дахь Гаалийн салбар
2. Дорноговь аймгийн Замын-Үүд дахь Гаалийн газар
3. Баян-Өлгий аймгийн Цагаannуур дахь Гаалийн салбар
4. Дорнод аймгийн Эрээнцав дахь Гаалийн салбар
5. Ховд аймгийн Булган дахь Гаалийн салбар (зөвхөн Булган боомтод)
6. Увс аймгийн Боршоо дахь Гаалийн салбар

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 90 | Улаанбаатар хот

Мэргэжил-арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг боловсронгуй болгох тухай

Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 12-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нутгийн өөрөө удирдах байгууллагуудад үзүүлэх мэргэжил-арга зүйн дэмжлэгийг боловсронгуй болгох зорилгоор дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд даалгасугай:

а/аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Тэргүүлэгчдийн тавьсан санал, хүсэлтийн мөрөөр тодорхой арга хэмжээ авч байхын хамт тэдгээрээс тухайн жилд хийсэн ажлын дүнг нэгтгэн Засгийн газрын хуралдаанд танилцуулж байх;

б/санал, хүсэлтээ ирүүлсэн тохиолдолд аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанд Засгийн газрын гишүүдийг оролцуулж Хурал, Тэргүүлэгчдээс тэдэнд тавьсан асуудлыг хэрхэн шийдвэрлэж байгаа байдалд хяналт тавьж ажиллах;

в/Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга, Засаг дарга нарыг оролцуулан Засгийн газрын болон Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, цаг үеийн ажил, тулгамдсан асуудлаар санал солилцох уулзалтыг жилд нэгээс доошгүй удаа зохион байгуулж байх;

г/нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагуудын арга барил, туршлага солилцох ажлыг жил бүр 1-2 аймагт явуулдаг болох;

д/орон нутгийн удирдах ажилтны сургалт, семинар зохион байгуулах, ажлын арга туршлага судлах, сурталчлах, мэдээлэх ажлыг Монголын нутгийн удирдлагын холбоотой хамтран зохион байгуулж байх;

2. Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн дарга нарт дор дурдсан үйл ажиллагаа явуулж байхыг зөвлөсүгэй:

а/Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Тэргүүлэгчдийн хуралдаанаар орон нутгийн тулгамдсан болон нийгэм, эдийн засгийн хэтийн чиглэлийн асуудлуудыг хэлэлцэх, гаргасан шийдвэрийн хүлээгдэж байгаа үр дүнг байнга тооцох хэлбэр, арга барилыг боловсронгуй болгох;

б/гарын авлага, мэдээ, мэдээллээр тасралтгүй хангах, ажлын шинэлэг арга ажиллагаа, харилцан судлуулах зэргээр сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн хурал болон Хурлын Тэргүүлэгчдэд бодитой туслалцаа үзүүлж байх;

в/Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны тов, хэлэлцэх асуудлын жагсаалтыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт урьдчилан мэдэгдэж байх.

3. Энэ тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар жил бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж байхыг Засгийн газрын гишүүн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 5-ны өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Энэ нь улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим
12 цаг 45 мин

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд Ж.Болдбаатар, Д.Чилхаажав, Ж.Амарсанаа, Ч.Дашням /илтгэгч/, В.Удвал, Н.Чинбат, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн дарга Д.Нарантуяа, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Сугар нарыг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд хийв.

Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаанаар "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "шударга шүүхээр шүүлгэх", Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "шүүгч хараат бус байх" заалтыг тус тус зөрчсөн байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн заалтыг Монгол Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзэж 2002 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоол гаргаж ирүүлсэнтэй холбогдуулан уг маргааныг дахин хянан шийдвэрлэв.

Нэг.Дархан-Уул аймгийн Шарын гол сумын Дархан багийн оршин суугч иргэн Нямдоржийн Даваадорж Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн өргөдлөөс:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн заалтыг "Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 1995 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмсэн нь:

а/ Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-ын "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг зөрчин шүүхэд иргэний журмаар хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг шүүхийн доод, дээд шатны хуралдаанаар нь болон шүүгчээр нь ялгаварлан зүйлчилж хуупьчилсан;

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-т "хэрэгээ шударга шүүхээр шүүлгэх, шүүхийн шийдвэрийг давж заалдах" гэсэн иргэний эрхийн байдлыг алдагдуулж, Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үг хэргийг өмнө нь хэлэлцэхэд оролцож байсан Улсын дээд шүүхийн хувийн сонирхол сэдэлттэй шүүгчийг татгалзаах, түүний өмнө нь гаргаж байсан үндэслэлгүй саналаар шийдвэрлэсэн шийдвэрт давж заалдах эрхгүйгээр эцэслэгдэж байгаа;

в/ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1-д "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" гэсэн заалттай зөрчилдөж Улсын Дээд шүүхэд өмнө нь Улсын Дээд шүүхийн шүүгч буюу шүүх бүрэлдэхүүнээр хянан хэлэлцүүлэг шийдсэнээс хойш түүний эсрэг санал гаргаж хууль зүйн дагуу шийдвэрлэх гээд байхын хэрэггүй гэсэн хараат байдалд бусад шүүгчдийг оруулахад хүргэсэн;

г/ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т "Давж заалдах болон хяналтын шатны журмаар доод шатны шүүхийн шийдэрийг хянаж үзэх" гэсэн заалтын агуулгыг алдагдуулсан зөрчлүүд байгаа болно" гэжээ.

Хоёр.Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сугар, Д.Дэмбэрэлцэрэн нар тайлбартаа:

"Нэг.Улсын Их Хурлаар 2002 оны 1 дүгээр сарын 10-нд хэлэлцэн батална Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар Улсын Дээд шүүхийн шүүгч зөвхөн хяналтын шатаар л хэрэг шийдэхээр тогтоож, уг хуулийн 84 дүгээр зүйлд "Иргэний хэргийг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг давж заалдах, хяналтын шат болон дахин анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэж

аасан, прокурор иргэний хэрэгт зөвхөн зохигчийн
увиар оролцох ба Улсын Дээд шүүхийн хяналтын
(ормаар шийдвэрлэсэн хэрэгт хяналтын
сэргүүцэл бичих эрхгүй байхаар хуульчилсан
(өгөөд энэ хууль нь 2002 оны 9 дүгээр сарын 01-
ээс хүчин төгөлдөр үйлчлэх юм.

Иймээс иргэн Н.Даваадоржийн өргөдөлд
ұрдсан асуудлыг Улсын Их хурал өөрийн эрх
эмжээнийхүрээнд нэгэнт шийдвэрлэжээ.

Хоёр. Дээрх хууль 5 сарын дараа үйлчилж
ихлэх үчир энэ хоорондүүсч болох зарим асуудлыг
явч үзвэл:

а/ 5 сарын дараа хүчингүй болох хуульд
эмэлт, өөрчлөлт оруулах нь нийгэмд болон иргэн
Н.Даваадоржид ямар ч ашигтайн дээр тийм хууль
үйн шаардлага байхгүй байна.

б/ Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин
наймдугаар зүйлд "Шүүхийн тогтолцоо нь Улсын
Дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх сум буюу сум
дүнд ын, дүүргийн шүүхээс бүрдэнэ гээд энэ 3
шатны шүүх зэрэг үйл ажиллагаа явуулах нь
эйлгодож байна. Энэ тохиолдолд анхан шатны
болон давж заалдах жүрмаар хэрэг шийдэхэд
эрөлцсон Улсын Дээд шүүхийн 17 гишүүнээс хасаад
байхад Улсын Дээд шүүх хяналтын журмаар хэрэг
шийдэхэд 4 шүүгч оролцох тооцоо гарч байна.
Иймээс Үндсэн хуулийн өөрийнх нь заалтыг
хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагаар оруулсан
нэмэлт юм. Иргэний хэргийг шүүхэд хянан
шийдвэрлэх тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 4 дэх
хэсэгт "Улсын Дээд шүүх нийт шүүгчийн олонхийн
/9-өөс доошгүй/ бүрэлдэхүүнтэйгээр хянан
шийдвэрлэнэ" гэсэн заалтыг ингэж хэрэгжүүлнэ.

в/ Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлд
"Шүүгч харааг бус байж, гагцхүү хуульд
захирагдана" гэж заасны дагуу Улсын Дээд шүүхийн
хяналтын журмаар шийдвэрлэсэн хэрэг шүүхийн
эцсийн шийдвэр, түүнд Ерөнхий прокурор болон
Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2-т заасан
ямар ч албан тушаалтан хөндлөнгөөс оролцож
болохгүй.

Харин прокурор төрийн нэрийн өмнөөс шүүх
хуралдааныг оролцоно гэсэн заалт одоо ч шүүх
хуралдааны мэтгэлцэх зарчимд нийцсэн
хэлбэрээрээ хэрэгжиж байна" гэжээ.

Гурав.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц 2002 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаар маргааныг хянан хэлэлцээд гаргасан 01 дүгээр дүгнэлтдээ:

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт бүй

"Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "шүүгч харааг бус байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна" гэжээ.

Дөрөв.Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоолд:

"Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй" гэсний дараа "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх"; Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "шүүгч харааг бус байх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй" гэжээ.

Тав.Монгол Улсын Дээд шүүхийн ерөнхий шүүгч Ч.Ганбатаас Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн даргын нэр дээр ирүүлсэн, 2002 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 1/1856 тоот, "Цэцийн дүгнэлтийн тухай" гэсэн албан бичигт:

"Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн нэмэлт, өөрчлөлт оруулах болсон шалтгаан нь Улсын Дээд шүүхийн 17 шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанд бүгд оролцон бол уг хэргийг Дээд шүүх давж заалдах шатаар дахин хянах үед бүрэлдэхүүнгүй болох, Дээд шүүхийн давж заалдах шатаар хоёроос дээш удаа орсон эрүү, иргэний хэргийн хувьд Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаан бүрэлдэхүүнгүй болох буюу эсхүл 4-5 шүүгч оролцож эрүүгийн хэргийг иргэний хэргийн танхимын шүүгчид, иргэний хэргийг эрүүгийн хэргийн танхимын шүүгчид шийдвэрлэх зэрэг сөрөг нөлөө бий болж нэг ёсны гацаанд орж байсантай холбоотой юм.

Улсын Дээд шүүхийн давж заалдах болон хяналтын шатаар 2001-2002 оны 3 дугаар сарын байдлаар хянагдсан эрүү, иргэний хэргээс сэдэлгээ хийж үзэхэд Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцсэн хэргээс 14 хэргийг дахин хэлэлцүүлэхээр аймаг, нийслэлийн шүүхэд буцаахад 12-16 шүүгч хяналтын шүүх хуралдаанд оролцжээ. Мөн эрүүгийн 14 хэргийг өөрөөн

байцаалтад болон аймаг, нийслэлийн шүүхэд буцаасан хуралдаанд 12-17 шүүгч оролцон байна. Дээрх хэргүүдийг Дээд шүүх давж заалдах шатаар хэлэлцэх болохоор оролцох шүүгч байхгүй болно гэсэн үг юм.

Судалгаанаас үзэхэд 2000-2002 онд Дээд шүүхийн давж заалдах шатаар хянасан иргэний хэргээс 17 хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан байх бөгөөд үүнээс 3 хэрэг давах шатаар 3 удаа, 8 хэрэг тус бүр 2 удаа хянагдаад Иргэний хэргийн танхимын 6-8 шүүгч оролцон, хэрэв энэ хэргүүд хяналтын шатаар хэлэлцэгдэх бол тус танхимын бүх шүүгчид оролцож чадахгүйд хүрч байна.

Эрүүгийн хэргийн хувьд ч байдал адилхан бөгөөд 2001-2002 онд Дээд шүүхийн давж заалдах шатнаас 61 хэргийг урьдчилсан мөрдөн байцаалт болон шүүхэд буцааснаас нэг хэрэг 4 удаа, 2 хэрэг 3 удаа, 15 хэрэг тус бүр 2 удаа хэлэлцэгдэхэд тус танхимын 6-8 шүүгч, зарим үед иргэний хэргийн танхимын шүүгчдийг оролцуулсан байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх болон Эрүүгийн байцаан шийтгэх шинэ хуулиуд энэ оны 9 дүгээр сарын 1-нээс мөрдөгдөж, давах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн хоорондоо зааг ялгаатай болж байгаа нь зарчмын зөв зүйл боловч, Дээд шүүхийн хувьд Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх" гэж заасны дагуу эрүү, иргэний хэргийн танхим давж заалдах журмаар, Дээд шүүхийн нийт шүүгчид оролцон хуралдаан хяналтын журмаар тодорхой хэрүүдийг хэлэлцсэр ирсэн тул эдгээр хэргээс мөрдөн байцаалт болон шүүхэд дахин хэлэлцэгдэхээр буцсан хэрэг Дээд шүүхээр зцэслэн хянагдаж дуустал одоогийн журмыг шилжилтийн байдлаар хэсэг хугацаанд мөрдөх шаардлага гарахыг үгүйгсэх аргагүй байгаа юм.

Иймд Үндсэн хуулийн цэцийн их суудлаар уг маргааныг хянан шийдвэрлэхдээ дээрх бодит байдлыг харгалзан үзэхийг хүсье. Холбогдох судалгаат хуулбарлан хүргүүлэв" гэжээ.

Дархан-Уул аймгийн Шарын гол сумын иргэн Н.Даваадорж 2002 оны 6 дугаар сарын 01-нд бичиж ирүүлсэн тайлбар-өргөдөлдөө:

"2002 оны 4 дүгээр сарын 03-нд болсон Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд оролцон Улсын Их Хурлын итгэмжлэгдэн төлөөлөгч нар мөрдөгдөж байгаа хуулийн үндэслэлээр бус Улсын Их Хурлаар 2002 оны 1 дүгээр сарын 10-нд хэлэлцэн батлсан, 2002 оны 9 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн талаар тайлбарлаж байгаа нь логикгүй, үндэслэлгүй боллоо.

Улсын Дээд шүүх бол шүүхийн тогтолцооны шүүх биш болж чиг үүргэзрээ гагцхүү шүүхүүдийн гаргасан шийдвэрийг хянаж хэрэг шийддэг шат болсон.

...Миний бичсэн тайлбаруудаас Цэцийн Их суудлын хуралдаанд мэдээлэл магадлуулахтай холбогдох хэргийг магадлуулан дүгнүүлэх нь үндэслэлтэй гэдгээ батлан дэмжин тайлбарлах минь" гэжээ.

Улсын Их хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Д.Сугар Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаан дээр хийсэн тайлбартаа:

"Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өгсөн тайлбараас зарчмын өөр тайлбар байхгүй байна. Харин Улсын Их хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээж аваагүй үндэслэлийн талаар тайлбар хэлье.

1.Улсын Их Хурал Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхдээ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох заалтыг Үндсэн хууль зөрчиж байна гэж хүчингүй болгосноор Дээд шүүхээс шүүн таслах ажлаа хэрэгжүүлэхэд тодорхой бэрхшээл учирч бүй бөгөөд энэ талаар дунд суудлын хуралдаан дээр ярьсан, Улсын Дээд шүүх тодорхой тайлбар өгсөн байгаа.

2.Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлд заасан 3 шатны шүүх тус бүр Үндсэн хууль заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болж болзошгүй байдлыг анхаарна уу.

3.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай шинэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 01-нээс дагаж мөрдсөнөөр зөрчил гарахгүй болох юм" гэв.

ҮНДЭСЛЭЛ:

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Анхан болон давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэхэд оролцон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй" гэсний дараа Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 1995 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн нэмэлт оруулсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "шүүгч

хараат бус байх" гэсэн заалтыг зөрчсөн болох нь дараахи үндэслэлүүд тогтоогдож байна.

1.Хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэж эхлэхээс өмнө хэргийн болон шүүхээс гарах шийдвэрийн талаар шүүгчид урьдчилан тодорхой итгэл үнэмшил төрөөгүй байх нь шүүх шударга шийдвэр гаргах гол үндэслэл хэмээн үзэж тодорхой хэргийг хянан шийдвэрлэхэд шүүгч дахин оролцохыг хуульчлан хориглодог нь олон улсын хэмжээнд нэгэнт хэвшиж тогтсон нийтлэг зарчим болно. Өөрөөр хэлбэл нэг хэрэгт нэг шүүгч нэг удаа оролцох гэсэн нийтлэг зарчим үйлчилж байна.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д урд нь уг хэргийг хянан шийдвэрлэхэд иргэдийн төлөөлөгч, емгөөлөгч, прокурор, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, гэрч, шинжээч, орчуулагч / хэлмэрч/-ийн хувиар, өөрөөр хэлбэл, шийдвэр гаргах үндэсэн үүрэгтэй бусаар оролцсоны дараа уг маргааныг хянан шийдвэрлэхэд шүүгчээр оролцвол урд бий болсон итгэл үнэмшил нь нөлөөлөх гэсэн үндэслэлээр хориглосон байхад шүүхийн шийдвэрийг биечлэн гаргасан шүүгчид түүнийг хамааруулахгүй байх үндэслэл муутай байна.

3.Ийнхүү урд нь анхан шатны журмаар хэргийг хянан шийдвэрлэж өөрөө шийдвэр гарган, хэргийн талаар тодорхой итгэл, үнэмшилтэй болсон шүүгч хяналтын шатны шүүх хуралдаанд дахин оролцсоноор бусад шүүгчдээс шийдвэр гаргахад ямар нэг байдлаар нөлөөлж, шүүгчийн хараат бус байдлын зарчимд харшлах бүрэн үндэслэлтэй байна.

Хэрэг маргааныг шийдвэрлэж байгаа шүүгчдэд нэг ижил зарчим үйлчлэх ёстой атал Улсын Дээд шүүхийн шүүгчдэд давуу эрх хуульчлан тогтоож тэгш байдлын зарчмыг алдагдуулсан байна.

4.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянан шийдвэрлэхэд оролцон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй" гэсэн заалтын дараа "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "...шүүгч хараат бус байх" заалтыг тус тус зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 03-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн холбогдох заалтыг хүлээн авах боломжгүй гэж үзсэн Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дэх заалтын үндэслэл батлагдахгүй байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС:

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй "Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа "Энэ нь Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", Дөчин есдүгээр зүйлийн 1-д заасан "шүүгч хараат бус байх" заалтыг тус тус зөрчсөн байх тул Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн заалтыг хүчингүй болгосугай.

2."Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай "Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 11 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болгосугай.

3.Энэ тогтоол эцсийн шийдвэр бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно.

ДАРГА **Н.ЖАНЦАН**

ГИШҮҮД **Ж.БОЛДБААТАР**

Д.ЧИЛХААЖАВ

Ж.АМАРСАНАА

Ч.ДАШНЯМ

В.УДВАЛ

Н.ЧИНБАТ

Ц.САРАНТУЯА

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 6-ны өдөр **Дугаар 02** **Улаанбаатар хот**

Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн бүрэн бүрэлдэхүүнтэй /их суудлын/ хуралдааныг Цэцийн дарга Н.Жанцан даргалж, гишүүдэд Ж.Болдбаатар, Д.Чилхаажав /илтгэгч/, Ж.Амарсанаа, В.Удвал, Н.Чинбат, Ч.Дашням, Ц.Сарантуяа, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан хийв.

Хуралдаанаар Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн иргэн П.Баттогтохын гомдлоор үүссэн Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн хэлэлцэв.

1.Иргэн П.Баттогтох Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдлөөс:

"...Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн "...хуульд заасан үндэслэл жүрмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчиж бүй Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Эрүүлжүүлэх жүрмыг улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална гэсэн заалт болон Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар 1994 онд батлагдсан "Эрүүлжүүлэх жүрам"-ыг тус тус хүчингүй болгож эрүүлжүүлэх жүрмыг хуульчлан хэлбэршүүлэхийг Улсын Их Хуралд үүрэг болгосон шийдвэр гаргаж өгнө үү" гэжээ.

2.Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Мөрөн Үндсэн хуулийн цэцийн хуралдаанд /дунд суудлын/ оролцож тайлбарлахдаа:

"Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 74 дүгээр тушаалаар "Эрүүлжүүлэх жүрам"-ыг батапсан ба уг жүрмаар эрүүлжүүлэх байрны нөхцөл, түүнд тавигдах шаардлага, эрүүлжүүлэх байранд хүлээн авах, түүнээс гаргах, эрүүлжүүлэх үйл ажилгааанд тавих хяналт зэрэг **зөвхөн** процдурыг зааж өгсөн байна. Иймд Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, түүнийг үндэслэн гаргасан Цагдаагийн ерөнхий газрын даргын 1994 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүлжүүлэх жүрам" нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн заалтыг зөрчөөгүй байна гэж үзэж байна" гэжээ.

3.Иргэн П.Баттогтохын өргөдлийн дагуу Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэж, хянан хэлэлцээд "Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Эрүүлжүүлэх жүрам"-ыг улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн "...хуульд заасан үндэслэл жүрмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна" гэсэн дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд уламжилжээ.

Үндсэн хуулийн цэцийн энэхүү дүгнэлтийг авч хэлэлцээд Улсын Их Хурлаас 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр гаргасан 10 дугаар тогтоолд "Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Эрүүлжүүлэх жүрам"-ыг улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн "...хуульд заасан үндэслэл жүрмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна" гэсэн Үндсэн хуулийн цэцийн 4 дүгээр сарын 10-ны өдрийн 02 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй гэжээ.

4.Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаан дээр нэхэмжлэгч П.Баттогтох Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Долгор нар дараах тайлбарыг гаргав.

П.Баттогтох-Улсын Их Хурлын зарим гишүүд Цэцийн дүгнэлтийг хүлээгээд авчих юм бол эрүүлжүүлэх үйл ажиллагаа зогсчихно гэсэн ойлголттой байх шиг байна. Тиймэ зүйл байхгүй. Жүрмыг хууль болготон хуучин жишгээрээ байж болно. Энэ жүрам бол хуульд заасан жүрам биш. Улсын Их Хурал Цэцийн дүгнэлтийг хүлээж авааргүй гайхаж байна.

Б.Долгор-Дунд суудлын хуралдааныг Д.Мөрөн гишүүний гаргасан тайлбартай санал нэг байна. Одоогийн мөрдөгдөж буй эрүүлжүүлэх жүрам

бол хуулиар тогтоосон журам юм гэж Улсын Их Хурал үзсэн.

-Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь заалт хуульд заасан журам мөн. Харин энэ журмыг л зөрчихгүй байх ёстой. Цагдаагийн хуулийн төсөлд эрүүлжүүлэх журмыг Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайд, Улсын Ерөнхий прокурор зөвшилцөн гаргана гэж томъёологдон батлагдсан. Эрүүлжүүлэх журам боловсрогдож байгаа.

ҮНДЭСЛЭЛ:

"Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Эрүүлжүүлэх журам"-ыг улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэсэн заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн "...хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн болох нь дараах үндэслэлээр тогтоогдож байна.

1.Эрүүлжүүлэх гэдэг бол нэг талаас согтуугийн улмаас өөрийгөө жолоодох чадвараа ямар нэг хэмжээгээр алдсан хүнийг өөрийг нь хамгаалж, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил үйлдэх, бусдад гэм хор учруулах, бусдын амгалан тайван байдлыг алдагдуулан танхайрахаас урьдчилан сэргийлж буй арга хэмжээ боловч нөгөө талаас дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд хүний халдашгүй чөлөөтэй байх тухай Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрхийн хүрээг хөндөж хязгаарлаж буй албадлагын арга хэмжээ юм.

2.Үндсэн хуульд заасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэг хэмжээгээр хязгаарлаж буй эрүүлжүүлэх үйл ажиллагааг хуулиар биш Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн Цагдаагийн төв байгууллагын дарын батална гэж маргаж зохицуулахаар хуульд заасан нь хүний үндсэн эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлах тухай Үндсэн хуулийн үзэл баримтлал, агуулгад нийцэхгүй байна.

3. "Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Эрүүлжүүлэх журам"-ыг улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн "...хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн байна гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 02 тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 10 тоот тогтоолын хууль зүйн үндэслэл батлагдахгүй байна.

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС:

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтуудыг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Цагдаагийн байгууллагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Эрүүлжүүлэх журам"-ыг улсын Ерөнхий прокурортой зөвшилцөн цагдаагийн төв байгууллагын дарга батална" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 13 дахь хэсгийн "...хуульд заасан үндэслэл журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ...баривчлах, ...эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно" гэсэн заалтыг зөрчсөн тул хүчингүй болгосугай.

2.Үндсэн хуулийн цэцийн 2002 оны 02 дугаар дүгнэлтийн тухай Монгол Улсын Их Хурлын 2002 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 10 тоот тогтоолыг хүчингүй болгосугай.

3.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн энэхүү тогтоол нь эцсийн бөгөөд гармагцаа хүчин төгөлдөр болно.

ДАРГА **Н.ЖАНЦАН**

ГИШҮҮД **Ж.БОЛДБААТАР**
Д.ЧИЛХААЖАВ
Ж.АМАРСАНАА
В.УДВАЛ
Ч.ДАШНЯМ
Н.ЧИНБАТ
Ц.САРАНТУЯА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 4 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 24 (261)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай*
- *Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны зургадугаар сарын 26 №24 (26

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

282. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2002-6-6-ны хууль) 779

283. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2002-6-6-ны хууль) 780

284. Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2002-6-13-ны хууль) 780

285. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2002-6-13-ны хууль) 780

286. Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай (2002-6-13-ны хууль) 780

287. Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2002-6-13-ны хууль) 781

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

288. Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрөх тухай Дугаар 29 781

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

289. Уриалга дэмжих тухай Дугаар 91 781

290. Хөтөлбөр батлах тухай Дугаар 92 781

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 6-ны өдөр **Улаанбаатар хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци болон Нордикийн хөгжлийн сантай байгуулсан MOG-3478, NDF-353 тоот гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Тээврийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд импортоор нийлүүлэгдэх авто тээврийн хэрэгслийн оношлогооны тоног төхөөрөмж, авто замын засвар, арчлалтын машин механизм, тоног төхөөрөмжийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 6-ны өдөр Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн ассоциаци болон Нордикийн хөгжлийн сантай байгуулсан MOG-3478, NDF-353 тоот гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Тээврийг хөгжүүлэх төсөл"-ийн хүрээнд импортоор нийлүүлэгдэх авто тээврийн хэрэгслийн оношлогооны тоног төхөөрөмж, авто замын засвар, арчлалтын машин механизм, тоног төхөөрөмжийг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

ЗӨВСӨГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 **дүгээр зүйл**. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тавьсан хориглийг хүлээн зөвшөөрсөнтэй холбогдуулан Зөвсөгт хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны сангийн хооронд байгуулсан "МОН-3, МОН-4" тоот зээлийн хэлэлцээрийн гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Төрийн холбоог өргөтгөн шинэчлэх" болон "Хөдөөгийн цахилгаан холбоо" төслүүдийн хүрээнд нийлүүлэгдэх бараа, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Улаанбаатар хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Солонгос Улсын Эдийн засгийн хөгжил, хамтын ажиллагааны сангийн хооронд байгуулсан "МОН-3, МОН-4" тоот зээлийн хэлэлцээрийн гэрээний дагуу хэрэгжиж байгаа "Төрийн холбоог өргөтгөн шинэчлэх" болон "Хөдөөгийн цахилгаан холбоо" төслүүдийн хүрээнд нийлүүлэгдэх барааг гаалийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, ХБНГУ-ын Засгийн газрын хооронд 1999 оны 9 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан зээлийн хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа "Харилцаа холбоо-2" болон "Харилцаа холбоо-3" төслүүдийн хүрээнд дотоодоос нийлүүлэгдэх бараа, үйлчилгээг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 29** **Улаанбаатар хот**

Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 14.3.-т заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Зөвсөгч хүчний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тавьсан хоригийг хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 91** **Улаанбаатар хот**

Уриалга дэмжих тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын багийн Засаг дарга нарын бүсчилсэн сургалт-ярилцлагыг үгтаж Увс аймгийн Наранбулаг сумын "Алдар" багийн Засаг дарга, иргэдээс улсын хэмжээний нийт багийн Засаг дарга, иргэдийг уриалж авсан үүргийг дэмжсүгэй.

2. Багийн Засаг дарга нарын бүсчилсэн сургалт-ярилцлагыг үгтаж зохиох ажлын хүрээнд "Алдар" багийн Засаг дарга, иргэдээс уриалж авсан үүргийг сурталчилж, багийн ажлыг сайжруулах, тэдэнд дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 92** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт ёсоор, Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих Үндэсний

хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг бүтцийн болон ерөнхө оруулалтын бодлого, бүс нутаг, дэд бүтцийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндэсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусган хэрэгжүүлж байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт, хөтөлбөрийг өөрийн эрхлэх ажлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Энэхүү хөтөлбөр батлагдсантай холбогдуулан "Ажилгүйдлийг бууруулах Үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 219 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Засгийн газрын 2002 оны 92 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хөдөлмөр эрхлэлтийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал

2001 оны байдлаар Монгол Улсын хөдөлмөрийн насны хүн ам 1402.8 мянга байгаагаас эдийн засгийн үйл ажиллагааны салбаруудад 832.3 мянган хүн ажиллаж байна. 2001 оны байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэгдсэн ажилгүйчүүдийн тоо 40.3 мянга, ажилгүйдлийн түвшин 4.6 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 62.2 хувь байна. Нийт ажилгүйчүүдийн 54.0 хувийг эмэгтэйчүүд, 63.3 хувийг 16-35 хүртэлх насны залуучууд, 53.2 хувийг мэргэжлийн боловсролгүй хүмүүс эзэлж байгаа юм. Ажилгүйчүүдийн дунд мэргэжилгүй залуучуудаас гадна мэргэжлийн боловсролгүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа 35 болон түүнээс дээш насны хүмүүсийн тоо өндөр байна.

Ерөнхий боловсролын сургуулийн 8, 10 дугаар анги төгсөөд ажил, сургууль үзлэсэн 10.0 орчим мянган охид, хөвгүүд хөдөлмөрийн зах зээлд жил бүр шилжин ирж байна.

1980-аад онд хүн амын төрөлт өндөр байсантай холбоотойгоор хөдөлмөрийн насны хүн амын жилийн дундаж өсөлт хүн амын өсөлтөөс 1.8 дахин өндөр байна. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тооцооогоор энэхүү өсөлтийн хурдац 2006 он хүртэл хадгалагдах төлөвтэй байна.

Хөдөлмөрийн зах зээлийн байдал ерөнхийдөө ажиллах хүчний урсгал хөдөлгөөн ихтэй, бүтээмж багатай, зах зээлд ажиллах хүчний өрсөлдөх чадвар муу, мэргэжилгүй ажилгүйчүүдийн эзлэх хувь өндөр, ажилгүйдлийн үргэлжлэх хугацаа урт гэсэн гол шинж чанараар тодорхойлогдож байна.

2. Хөтөлбөр боловсруулах шаардлага

Манай улсын хүн амын тоо 2002 онд 2479.9 мянга, 2003 онд 2515.2 мянга, 2004 онд 2549.3 мянга, 2005 онд 2585.0 мянгад хүрэхээр байна. Хүн амын цэвэр өсөлт 2000-2005 онд мянган хүн амд 14.6-13.8 нэгж болох төлөвтэй байна. Энэ тооцооноос үзэхэд хүн амын жилийн дундаж өсөлт тогтворжих хандлагатай байна. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийн тооцоогоор хөдөлмөрийн насны хөдөлмөрийн чадвартай хүн ам 2005 он гэхэд 2000 оныхоос 16.0 хувиар буюу жилд дунджаар 3.2 хувиар өсөх төлөвтэй байна. Энэ хугацаанд албан ёсны хөдөлмөр эрхэлдэг ажилгүйдэл тоо 13.6 хувь буюу жилд дунджаар 2.7 хувиар өсөх тооцоо гарч байна.

Дотоодын нийт бүтээгдэхүүн 2003-2005 онуудад жилд дунджаар 5-аас доошгүй хувиар өсөх бөгөөд энэхүү өсөлт уул уурхай, хөдөө аж ахуй, худалдаа, үйлчилгээ болон боловсруулах аж үйлдвэрийн салбарын өсөлтөөр хангагдах төлөвтэй байна.

Иймд хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, бүтцийн өөрчлөлтийг эрчимжүүлэх, инфляцийн түвшинг бууруулах, банк, санхүүгийн үйлчилгээг сайжруулах, нийгмийн хамгааллын үйлчилгээг боловсронгуй болгох, дэд бүтэц, байгаль орчны зэрэг өргөн хүрээний дэд бүтцийн нэгт уялдуулан Монгол Улсад зээл, түслэмж үзүүлэг гадаадын хандивлагч орон, байгууллагатай тохиролцсон бодлогын баримт бичиг, тухайлбал "Ядуурлыг бууруулах өсөлтийг хангах" бодлогын болон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын "Боломжит хөдөлмөр"-ийн үзэл баримтлалтай нийцүүлж "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний хөтөлбөр" /цаашид "хөтөлбөр" гэх/-ийг боловсруулав.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зарчим

3. Зорилго

Монгол Улсын иргэдийг өөрийн мэргэжил, ур чадварын дагуу хүссэн ажил, мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн зах зээлийн үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдан дэмжлэг авах, өөрсдийн боломж, чадавхийг хөгжүүлэх замаар амьжиргаагаа дээшлүүлэх нөхцөл бололцоогоор хангахад чиглэсэн хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг улс орны эдийн засгийн хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийн бодлого болон бусе нутгийн хөгжлийн онцлогтой уялдуулан хэрэгжүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

4. Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ:

а/хөдөлмөрийг дээдлэх зарчим: Хүүхэд, залуучуудад хөдөлмөрийг үнэлэх, хүндэтгэх, амьжиргааны үндсэн гэж дээдлэх үзлийг төлөвшүүлж, ажлын дадлага, мэргэжил, мэргэшлийн ур чадвар эзэмших нь хүн бүрийн хөдөлмөр эрхлэх үндсэн нөхцөл болохыг ойлгуулах, мэргэжлийн сургалтын бүх хэлбэрийг дэмжин хөгжүүлэх замаар иргэдийн мэргэжлийн ур чадварыг байнга дээшлүүлэх;

б/бодлогын уялдааны зарчим: Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хөрөнгө оруулалт, бүс нутаг, орон нутгийн хөгжлийн онцлогтой уялдуулах;

в/нийгмийн зөвшил, оролцооны зарчим: Хөдөлмөр эрхлэлтэд чиглэсэн өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог идэвхжүүлж, тэдгээрийн үйл ажиллагааг уялдуулах, нийгмийн зөвшлийг хөгжүүлэх;

г/дэмжлэгийн зарчим: Иргэдийн боломжит хөдөлмөр эрхлэлтийг урамшуулах, хөдөлмөр эрхлэх идэвх, саналчилгад бодит дэмжлэг үзүүлэх;

д/мэдээллийн хүртээмжийн зарчим: Үйл ажиллагааны ил тод байдлыг хангах, хөдөлмөрийн зах зээлийн мэдээлэл нээлттэй, хүртээмжтэй байх.

Гурав. Хөтөлбөрийн хамрах хүрээ, зорилт, үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээ

А. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээ

5. Зорилт. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг макро түвшинд эдийн засгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулж өсөлтийг ханган бодлоготой уялдуулах зорилтыг үйл ажиллагааны үндсэн 5 чиглэлээр хэрэгжүүлнэ.

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгох чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/дотоодын үйлдвэрлэгчдэд түүхий эд худалдан авч бэлтгэхэд зориулж хөнгөлөлттэй зээл олгох механизм бүрдүүлэх;

б/хоршооны гишүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад гэнэтийн тохиолдлоос учирсан хохирлыг нөхөх даатгалын систем нэвтрүүлэх;

в/ажлын байр шинээр бий болгох зориулалтаар хөрөнгө оруулалт хийхдээ бус нутгийн эдийн засгийн хөгжлийн онцлог, нөөц боломж, тухайн бүс нутгийн давуу тал зэргийг харгалзан үзэх;

г/хүн амын хэрэгцээг орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангаж иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг багасгасан аймаг, орон нутагт хөрөнгө оруулалтыг түлхүү хийх бодлого баримтлах;

д/ банк бус санхүүгийн байгууллагыг дэмжих замаар жижиг зээл олгох ажиллагаагг өргөжүүлэх.

5.2. Жижиг, дунд, бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/иргэдийг ажлын байраар хангах зорилгоор орон нутгийн байгалийн баялаг, түүхий эдийг ашиглан жижиг, дунд үйлдвэрлэл явуулах санаачилгыг дэмжих;

б/зах зээлд өрсөлдөх экспортын бүтээгдэхүүн, түүхий эдийг хүлээн авч борлуулах бөөний худалдааны сүлжээг сум, суурин газар байгуулах үйл ажиллагааг дэмжиж урамшуулах;

в/сум, багийн төвд халуун ус, үсчин, оёдол, гутал засварын чиглэлээр ахуйн үйлчилгээний цэг, салбар нээн ажиллуулах, явуулын үйлчилгээ бий болгох асуудлыг шийдвэрлэхэд туслах.

5.3. Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хоршоо, нөхөрлөл, ерхийн болон фермийн аж ахуй хөгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх замаар хөдөөгийн хөдөлмөр эрхлэтийн бодлогыг дэмжих чиглэлээр дараахь

рга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/байгалийн гаралтай бордоо йлдвэрлэх, газар тариалангийн чиглэлээр өхөрлөл, хоршооны үйл ажиллагааг өргөжүүлэхэд услах;

б/сайн үүлдрийн болон нутгийн илмэл омгийн мал үржүүлэх фермерийн аж ахуйн йл ажиллагааг дэмжиж цаашид эрдэм шинжилгээ, удалгааны түшиц газар болгох асуудлыг судлах;

в/ажилгүй хүмүүсийг олон малтай ргэдтэй гэрээ байгуулан ажиллуулах, багш авийн барилдлагаа бий болгох хэлбэрийг өргүүлэх;

г/мал аж ахуйн гаралтай түүхий дийн анхан шатны боловсруулалт хийх цэгүүдийг айгуулах замаар иргэдийг түр болон байнгын жлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх;

д/гахай, шувууны махны йлдвэрлэл, загас агнуурын аж ахуй, давс лборлох чиглэлийн аж ахуйн нэгж, хоршоо, өхөрлөлийг дэмжин бүс нутгийн хэрэгцээг хангах одлого баримтлах.

5.4. Хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг айгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх одлоготой уялдуулах чиглэлээр дараахь арга эмжээг хэрэгжүүлнэ:

а/ойн нөөц, усны эх булаг, оворджсон ан, амьтдыг хамгаалах, ой цэвэрлэх, булаг шандыг тохижуулах, ойг нөхөн сэргээхэд орон нутгийн иргэдийг өргөнөөр хамруулж түр болон байнгын ажлын байраар хангах;

б/байгалийн баялгийг ашиглан Байнгын үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж бий болгоход дэмжлэг үзүүлэх;

в/усны эх үүсвэрийг хамгаалах, усан сан байгуулах замаар усалгаатай гариалангийн жижиг аж ахуй бий болгоход нөхөрлөл, хоршооны хэлбэрийг өргөн ашиглах;

г/говь, хээр нутгийг цөлжилтөөс сэргийлэх, ойн зурвас байгуулах замаар газрын хөрс, бэлчээрийг хамгаалах ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг татан оролцуулах;

д/агаар мандлыг хамгаалах зорилгоор утаагүй зуух, утаагүй түлшний үйлдвэрлэлийг дэмжих.

5.5. Аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлоготой уялдуулах чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/түүх, соёлын дурсгалт газруудыг хамгаалах, аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх замаар орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх;

б/хот суурин газрыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд ажилгүй иргэдийг зохион байгуулалттайгаар оролцуулах;

в/аялал жуулчлалын салбарын жижиг үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх;

г/нийтийн зээмшлийн зам, талбай, ногоон байгууламж зэргийг ажилгүй хүмүүст гэрээгээр зээмшүүлэх, энэ чиглэлээр аж ахуйн нэгж байгуулахыг дэмжих;

д/дэд бүтэц, байгаль хамгаллын чиглэлээр нийтийг хамарсан ажил зохион байгуулж, ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамруулан түр ажлын байраар хангах;

е/улс орны баруун, зүүн цэгийг хэвтээ, босоо тэнхлэгээр холбох Мянганы замын төслийн хүрээнд түр болон байнгын ажлын байр бий болгох;

ж/орон нутгийн чанартай зам, өвөл, хаврын улиралд цасанд боогддог бартаа ихтэй даваа, гүвээг засч арчлах зам засварын хэсгүүдийг байгуулж ажлын байр бий болгохыг дэмжих.

Б.Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогын хүрээ

6. Зорилт: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах, хүн амын хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг үйл ажиллагааны 5 чиглэлээр хэрэгжүүлнэ.

6.1. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг дараахь чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан ажилгүй иргэн, ажил хайгчдыг суп чөлөөтэй ажлын байранд зуучлах үйл ажиллагааг хөдөлмөр эрхлэлтийн албадаар дамжуулан зохион байгуулах;

б/ажилгүй иргэдэд ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөлгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн талаархи мэдээллээр хангах үйлчилгээний чанарыг сайжруулах;

в/ажлын байр шинээр бий

болгосон, ажилгүй иргэдэд шинэ мэргэжил олгох, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээр сургалт зохион байгуулсан ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх;

г/иргэдийг ажлын бүтэн бус долоо хоног, богиносгосон цагаар болон гэрээр ажиллуулах хэлбэрийг нэвтрүүлэх, зуучлах үүрэгтэй хөдөлмөр зуучлалын хувийн хэвшлийн байгууллага /түр ажлын бирж/ байгуулах үүсгэн санаачилгыг дэмжих;

д/бичил аж ахуйн нэгжийг албан ёсоор бүртгүүлэх, үйл ажиллагаа явуулахад нь туслалцаа үзүүлэх бизнес инкубаторын төвийг аймгийн төв болон хотын дүүрэг бүрт байгуулах;

е/Монгол Улсын иргэд гадаадад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн дадлага хийх таатай нөхцөл бүрдүүлэх талаар гадаад орнуудтай хоёр талын гэрээ хийх, түүнчлэн байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулах;

ж/гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог дотоодын хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан тогтоож мөрдөх.

6.2. Залуучууд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй бодлого явуулах чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/ажилгүй залуучууд, нийгмийн эмзэг бүлгийн иргэдэд хөдөлмөр эрхлэх чадвар олгох хөдөлмөр зуучлал болон тэдгээр иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны түлхүү анхаарах;

б/оюутны хөдөлмөр зуучлалын алба байгуулахад мэргэжлийн болон материаллаг дэмжлэг үзүүлэх, оюутнууд хичээлийн бус цагаар хагас өдөр, цагаар ажиллах боломж бүрдүүлэх;

в/тахир дутуу, одой иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг судлан тэдэнд зөвлөлгөө өгөх, мэдээллээр хангах, мэргэжлийн сургалтад хамруулах;

г/хүүхдийн хөдөлмөрийг хориглох болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллага, хандивлагч бусад орны туслалцаатайгаар хамтарсан төсөл хэрэгжүүлэх.

6.3. Зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжлийн болон үр чадварын сургалтыг дэмжих чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй, удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэд, ажилгүйдэлд өртөх болзошгүй иргэн болон ажилгүй иргэд, тухайн онц еренхий боловсролын сургуулийн 8, 10 дугаар анги төгссөн, хугацаат цэргийн албанаас халагдсан ажил, сургуульгүй иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцэн мэргэжил олгох болон давтан сургалтад хамруулах;

б/хувиараа болон нөхөрлөл хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэх сонирхолтой иргэдэд бизнес эрхлэх ур чадвар, эзэмшүүлэх сургалт явуулах, гарын авлага бэлтгэх;

в/иргэдийг боломжит хөдөлмөр эрхлэхэд нь туслах, зуучлах, тэдэнд зөвлөлгөө өгөх, амьдрах арга ухаан, хөдөлмөр эрхлэх арга барил, дадалд сургах;

г/ажилтны мэдлэг, боловсролын түвшин, мэргэжлийн ур чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байгаа анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх.

6.4. Боломжит хөдөлмөр эрхлэх арга хэмжээг дэмжихэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын байры нөхцөлийг бүрдүүлэх;

б/хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн оролцоог өргөжүүлж гурван талт зөвшилцлийн үйл ажиллагаат чиглүүлэх;

в/ажиллах хүчний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг гэрээний үндэсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хэлбэрийг ашиглан Засгийн газар, төрийн бус байгууллагуудын түншлэлийг өргөжүүлэх.

6.5. Хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл, суртачилгааны ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ:

а/хөдөлмөр эрхлээгүй иргэд болон албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч хөдөлмөрийн статистикийн тоготолгоог бүрдүүлэх;

б/хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн чанарыг сайжруулах, тоон үзүүлэлтийн хүрээг өргөтгөх замаар ажиллах хүчний болон ажлын байры судалгааг боловсронгуй болгох;

в/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хууль тогтоомжийн талаархи сурталчилгааг тогтмолжуулах;

г/боломжит хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх талаар ажил олгогчдын үүрэг, хариуцлагыг нийгмийн зөвшил, түншлэлийн хүрээнд төлөвшүүлэх сургалт, сурталчилгааг өргөнөөр зохион байгуулах.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаа, удирдлага зохион байгуулалт, санхүүжилт

7.Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2002-2010 онд 2 үе шаттайгаар 9 жилийн хугацаанд хэрэгжүүлнэ. Эхний үе нь 2002-2005 он байх бөгөөд дунд хугацааны үнэлгээгээр хөтөлбөрт тодотгол хийж болно. Хоёрдахь үе нь 2006-2010 оныг хамарна.

8. Удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг эдийн засаг, нийгмийн бусад хөтөлбөрүүдтэй уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүргийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага холбогдох яамдын оролцоотойгоор хэрэгжүүлнэ.

8.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний жил бүрийн төлөвлөгөөг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гарган ажиллана.

8.3. Аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга тухайн нутаг дэвсгэртээ хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг дараахь байдлаар гүйцэтгэнэ:

а/орон нутгийнхаа түвшинд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих дэд хөтөлбөр боловсруулж мөрдүүлэх;

б/хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагааны чиглэл, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавин тайлан гаргах;

в/орон нутагт хуваарилсан хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд зарцуулж, гүйцэтгэлд хяналт тавих;

г/хөтөлбөрийн хэрэгжилт, хөдөлмөр эрхлэлтийн байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг бэлтгэж холбогдох байгууллагад хүргүүлэх.

8.4. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь дараахь үүрэг гүйцэтгэнэ:

а/хөтөлбөрийг хэрэгжүүлэх өдөр тутмын үйл ажиллагаагаа эрхэлж, түүнийг хэрэгжүүлэхэд зориулан олгож байгаа хөрөнгийг үр ашигтай зарцуулах;

б/орон нутгийн түвшинд хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

в/хөтөлбөрийн үр дүнг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор тайлагнаж, цаашид авах арга хэмжээний талаар саналаа тавьж байх;

г/хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд төрийн бус байгууллага, ажил олгогч болон ажилтны төлөөллийн байгууллагын оролцоог өргөжүүлэх.

9. Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилт дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

а/төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

б/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан;

в/хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

г/аж ахуйн нэгж, иргэд, төрийн бус байгууллагын санаачилгаар бүрдүүлсэн тусламж, хандивын хөрөнгө;

д/банкны зээл, хувийн хөрөнгө оруулалт;

е/аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө;

ж/орон нутагт бий болсон зээлийн сангууд.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт, дүгнэх шалгуур үзүүлэлтүүд

10. Хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

а/хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнд үнэлгээ хийх үүргийг аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэдээлэл, хяналт-шинжилгээ,

үнэлгээний нэгж хүлээнэ;

б/хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээнд төрийн бус байгууллага, иргэдийг оролцуулна.

11. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үндсэн болон туслах шалгуур, үзүүлэлтээр дүгнэнэ.

11.1. Үндсэн шалгуур, үзүүлэлт:

а/шинээр бий болгосон ажлын байрны тоо;

б/ажилгүйдлийн түвшний бууралт;

в/бодит ажилгүйдлийн бууралт;

г/ажилд зуучлагдсан хүний тоо;

д/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас дэмжлэг авсан ажил олгогчдын тоо;

е/хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтаар улсын төсвөөс олгосон хөрөнгийн хэмжээ;

ж/нийтийг хамарсан ажилд хамрагдсан хүний тоо;

з/мэргэжлийн болон давтан сургалтаар мэргэжил эзэмшүүлсэн хүний тоо;

и/ жижиг зээлийн төсөлд хамрагдсан хүний тоо.

11.2. Туслах шалгуур, үзүүлэлт:

а/ажиллах хүчний оролцооны түвшин;

б/ажил эрхлэлтийн түвшин;

в/мэргэжлийн болон давтан сургалтад хамрагдсан иргэдийн ажилд зуучлагдсан түвшин;

г/ажлын байрны захиалгын ашиглалтын түвшин.

Зургаа. Хөтөлберийн хүрэх үр дүн

12. Хөтөлберийг хэрэгжүүлснээр дор дурдсан үр дүнд хүрсэн байна:

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	I үе шатанд	II үе шатанд	Дүн
1	Шинээр бий болох ажлын байрны тоо	Мян	155,7	240,1	395,8
2	Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгосон, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангасан хүний тоо	Мян.хүн	142,7	186,9	329,6
3	Ажилд зуучилсан хүний тоо	Мян.хүн	115,0	156,1	271,1
4	Мэргэжлийн болон давтан сургалтад хамруулсан хүний тоо	Мян.хүн	37,3	53,3	90,6
5	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл авсан хүний тоо	Мян.хүн	17,4	24,9	42,4
6	Ажил олгогчдыг дэмжих арга хэмжээнд хамрагдсан хүний тоо	Мян.хүн	18,0	37,6	55,6
7	Нийтийг хамарсан ажилд оролцуулж түр ажлын байраар хангасан хүний тоо	Мян.хүн	41,7	55,2	96,9
8	Ажилгүйдлийн түвшин	Хувиар	4,7	4,5	-
9	Бодит ажилгүйдлийн түвшин	Хувиар	7,8	7,0	-

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагааны чиглэл	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа /он/	Хариуцах байгууллага
Зорилт: Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогыг макро түвшинд эдийн засгийг хөгжүүлэх, ядуурлыг бууруулж өсөлтийг хангах бодлоготой уялдуулах			
А/Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүү, зээлийн бодлогыг боловсронгуй болгох чиглэлээр	1. Дотоодын үйлдвэрлэгчдэд түүхий эд худалдан авч бэлтгэхэд зориулж хөнгөлөлттэй зээл олгох механизм бүрдүүлэх	2002-2005	ҮХЯ,аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	2. Хоршооны гишүүд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, малчдад гэнэтийн тохиолдлоос учирсан хохирлыг нөхөх даатгалын систем нэвтрүүлэх	2002-2005	СЭЗЯ, НХХЯ
	3. Ажлын байр шинээр бий болгох зорилалтаар хөрөнгө оруулалт хийхдээ бүс нутгийн эдийн засгийн хөгжлийн онцлог, нөөц боломж, тухайн бүс нутгийн давуу тал зэргийг харгалзан үзэх	2002-2010	ҮХЯ, СЭЗЯ
	4. Хүн амын хэрэгцээг орон нутгийн аж ахуйн нэгж, байгууллагын бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээгээр хангаж иргэдийн шилжин суурьших хөдөлгөөнийг багасгасан аймаг, орон нутагт хөрөнгө оруулалтыг түлхүү хийх бодлого баримтлах	2002-2010	СЭЗЯ, НХХЯ
	5. Банк бус санхүүгийн байгууллагыг дэмжих замаар жижиг зээл олгох ажиллагааг өргөжүүлэх	2002-2005	СЭЗЯ, НХХЯ
Б/ Жижиг, дунд, бичил үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин хөгжүүлэх чиглэлээр	1. Орон нутгийн байгалийн баялаг, түүхий эдийг ашиглан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх замаар жил бүр 4.0 мянгаас доошгүй ажлын байрыг шинээр бий болгох	2002-2010	ҮХЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга нар

	2. Зах зээл дээр эрсдэлд экспортын бүтээгдэхүүн, түүний эдийн хүлээн авч болгуулах бөөний үйл ажиллагаа сүлжээ сум, суурин газар байгуулах 3. Сум, багийн төвд халуун ус, үсчин, оёдол, гутал засварын чиглэлээр ахуйн үйлчилгээний цэг, салбар нээн ажиллуулах болгох асуудлыг шийдвэрлэхэд туслах	2002-2010	УХЯ	
В/ Мал аж ахуй, газар тариалангийн чиглэлээр хөрөнгө, бодлого, зохицуулалт, мэдээлэл, сургалт, зөвлөгөө	1. Байгалийн гаралтай бордоо үйлдвэрлэх, газар тариалангийн чиглэлээр нөхөрлөл, хоршоолы үйл ажиллагаа эрчимжүүлэхэд туслах 2. Сайн үтлэгийн болон нутгийн шилмэл омгийн мал үржүүлэх фермерийн аж ахуйн үйл ажиллагаг дэмжих ашиг эрлэм шинжилгээ, судалгааны түшиг газар болгох асуудлыг судлах 3. Ажилгүй хүмүүсийг олон малтай иргэдэй гэрээ байгуулан ажлуулах, багш шавийн бариллагаа бий болгох хэлбэрийг хөгжүүлэх 4. Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалт хийх цэгүүдийг байгуулах замаар иргэдийг тус болон байнгын ажлын байраар хангахад дэмлэг үзүүлэх 5. Гахай, шувуугны маяны үйлдвэрлэл, загас агнуурын аж ахуй, давс олборлох чиглэлийн аж ахуйн нэгж, хоршоо, нөхөрлөлийг дэмжин бүс нутгийн хэрэгцээг хангах бодлого барьчтах.	2002-2005 2002-2005 2002-2005 2002-2005	ХХААЯ,НХЯ ХХААЯ,НХЯ Аймгийн Засаг дарга нар ХХААЯ, НХЯ, аймгийн Засаг дарга нар	
Г/Нөхөлмөр бодлогыг орчныг нөхөн бодлоготой	эрхлэлтийн Байгаль хамгаалах, сэргээх уялдуулах	1. Ойн нөөц, усны эх булаг, ховордсон ан, амьтдыг тохижуулах, ой цэвэрлэх, булаг шандыг иргэдийг ергөнөөр ажлын байраар	хамгаалах, ой цэвэрлэх, булаг шандыг сэргээх орон нутгийн хамруулж тус болон байнгын	2002-2010	БОЯ, аймгийн Засаг дарга нар

	2. Байгалийн баялгийг ашиглан байгыгы үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж бий болгоход дэмжлэг үзүүлэх	2002-2005	БОЯ
	3. Усны эх үүсвэрийг хамгаалах, усан сан байгуулах замаар усалгаатай тариалангийн жижиг аж ахуй бий болгоход нөхцөлөл, хөрөөсны хэлбэрийг өөрчлөн ашиглах	2002-2005	БОЯ, ХААЯ
	4. Говь, хээр нутгийг цөлжилтөөс сэргийлэх, ойн зурвас байгуулах замаар газрын хөрс, бэлчээрийг хамгалах ажилд эрхлэгчийг татан оролцуулах	2002-2005	БОЯ, аймгийн Засаг дарга нар
	5. Агаар мандлыг хамгаалах зорилгоор утаагүй зуух, утаагүй тулшний үйлдвэрлэлийг дэмжих	2002-2005	БОЯ
Д/ Аялал жуулчлал, дэд бүтцийн хөгжлийг эрхлэгчийг хөдөлмөр дэмжих бодлогоой уялдуулах чиглэлээр	1. Түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалах, аялал жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэх замаар орон нутагт хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлэх	2002-2010	БСШУЯ, ДБЯ
	2. Хот суурин газрыг тохижуулах, цэцэрлэгжүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд ажилгүй иргэдийг зохион байгуулалттайгаар оролцуулах	2002-2005	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	3. Аялал жуулчлалын салбарын жижиг үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд туслалцаа үзүүлэх	2002-2005	ДБЯ, УХЯ
	4. Нийтийн эзэмшлийн зам, талбай, ногоон байгууламж зэргийг ажилгүй хүмүүст тэрээгээр эзэмшүүлэх	2002-2005	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар
	5. Дэд бүтэц, байгаль хамгаалалын чиглэлээр нийтийг хамарсан ажилд ажилгүй байгаа нийтийн эмээг бүлгийн 10,0 мянгаас доошгүй иргэдийг хамруулан тур ажлын байраар хангах	2002-2005	Аймаг, нийслэлийн Засаг дарга нар

	6. Улс орны баруун, зүүн цэгийг хэвтээ, босоо тэнхлэгээр холбох Мянганы замын төслийн хүрээнд түр болон байнгын ажлын байр бий болгох	2002-2010	ДБЯ, аймгийн Засаг дарга нар
	7. Улс, орон нутгийн чанартай зам, өвөл, хаврын улиралд цасанд боогдодог бартаа ихтэй даваа, гүвээг засч арчлах зам засварын хэсгүүдийг байгуулж ажлын байр бий болгохыг дэмжих	2002-2005	ДБЯ, аймгийн Засаг дарга нар
Зорилт: Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах, хүн амын хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх			
А/ Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлэх чиглэлээр	1. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулан ажилгүй иргэн, ажил хайгчдыг сул чөлөөтэй ажлын байранд зуучлах үйл ажиллагаат хөдөлмөр эрхлэлтийн албадаар дамжуулан зохион байгуулж, жил бүр 23.0 мянгаас доошгүй ажилгүй хүнийг ажилд зуучлах арга хэмжээ авах.	2002-2010	НХХЯ, Хөдөлмөр эрхлэлтийн газар, аймаг нийслэлийн Засаг дарга нар
	2. Ажлын байр шинээр бий болгосон буюу ажилгүй иргэдэд шинэ мэргэжил олгох, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр үйлдвэрлэл дээрх сургалтыг зохион байгуулсан ажил олгогчдод дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд жил бүр 6,0 мянгаас доошгүй иргэнийг хамруулах	2002-2010	НХХЯ, Хөдөлмөр эрхлэлтийн газар,
	3. Иргэдийг ажлын бүтэн бус долоо хоног, богиносгосон цагаар болон гэрээр ажиллуулах хэлбэрийг нэвтрүүлэх, зуучлах үүрэгтэй хөдөлмөр зуучлалын хувийн хэвшлийн байгууллага /түр ажлын бирж/ байгуулах үүсгэл санаачилгыг дэмжих	2002-2005	НХХЯ, Хөдөлмөр эрхлэлтийн газар,

	4. Бичил аж ахуйн нэгжийг албан ёсоор бүртгүүлж, үйл ажиллагаа явуулахад нь туслалцаа үзүүлэх инжүбаторын төвийг аймгийн төв болон хотын дүүрэг байгуулж, хувараа хөдөлмөр эрхлэгч иргэдэд мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх 5. Ажилгүй иргэдэд мэргэжлийн чиг баримжаа олгох, ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх, хөдөлмөрийн зах зээлийн мэдээллээр хангах үйлчилгээнд жил бүр 35,0 мянгаас доошгүй иргэнийг хамруулах 6. Монгол Улсын иргэн гадаадад хөдөлмөр эрхлэх, үйлдвэрлэлийн дадлага хийх таатай нөхцөл бүрдүүлэх талаар гадаад орнуудтай хоёр талын гэрээ хийх, түүнчлэн байгуулсан гэрээний хэрэгжилтийг хангуулах 7. Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний тоог дотоодын хөдөлмөрийн зах зээлтэй уялдуулан тогтоож мөрдөх	2002-2005	НХҮЯ, УХЯ
	1.Ажилгүй залуучууд, нийтийн эмзэг бүлгийн иргэдэд хөдөлмөр зуучлал болон тэдгээр иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд татахуу анхаарах	2002-2010	НХҮЯ
Б/Залуучууд, нийтийн эмзэг бүлгийн иргэдэд зориулсан хөдөлмөр эрхлэлтийн идэвхтэй арга хэмжээг тогтмол чиглэлээр	2. "Оюутны хөдөлмөр зуучлалын алба" байгуулж мэргэжлийн болон материаллаг дэмжлэг үзүүлэх, оюутнууд хичээлийн бус цагаар хаана ядрөөр, цагаар ажиллах боломж бүрдүүлэх	2002 оноос	НХҮЯ, Монголын оюутны холбоо
	3. Тахир дутуу, одой иргэдийн хөдөлмөр эрхлэх боломжийг сурган тэдэнд зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, мэргэжлийн сургалтад хамруулах.	2002-2005	НХҮЯ

	4. Хуухэнийн хөдөлмөрийг хориглох болон түүнээс урьдчилан сэргийлэх талаар Олон улсын хөдөлмөрийн байгууллага, холбогдох бусад орны туслалцаатайгаар хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх.	2002-2005	НХҮЯ
В.Зах зээлийн эдийн засгийн нийцсэн болон сурталтыг дэмжих мэргэжлийн чадварын үр чиглэлээр	1. Ажилгүйдлийн даатгалд хамрагдагчид, удаан хугацаагаар ажилгүй байгаа нийгмийн эмзэг бүлгийн иргэд, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн болон ажилгүй иргэд, тухайн орд ерөнхий боловсролын сургуулийн 8, 10 дугаар анги төгссөн, хүүхдээт цэргийн албанаас халагдсан ажил, сургуульгүй иргэнийг хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжил олгох, давтан сургахад жил бүр 10.0 мянгаас доошгүй хүнийг хамруулах.	2002-2010	НХҮЯ, БСШУЯ
	2. Хүүхдэд амьдрах ухааны дадлага, мэргэжлийн үр чадвар олгох чиглэлээс бусад хэлбэрээр тэдний эрүүл мэнд, аюулгүй хөдөлмөр эрхлүүлэхийг хориглох	2002-2010	НХҮЯ
	3. Иргэдийг боломж хөдөлмөр эрхлэхэд нь туслах, зүүчлах, тэдэнд зөвлөлтөө өгөх, амьдрах арга ухаан, хөдөлмөр эрхлэх арга барилд сургах сургалт зохион байгуулах	2002-2005	НХҮЯ
	4. Ажилтны мэдлэг, боловсролын түвшин, мэргэжлийн үр чадварыг хөдөлмөрийн зах зээлийн шаардлагад нийцүүлэн хөгжүүлэхэд байнга анхаарч, давтан сургах, мэргэшүүлэх, шинэ мэргэжил эзэмшүүлэх.	2002-2005	НХҮЯ, холбогдох яамд
Г/ Боломжит хөдөлмөр эрхлэх арга дэмжихэд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр	1.Ажилтны хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлагыг хангасан ажлын байрны нөхцөлийг бүрдүүлэх	2002-2010	НХҮЯ

2. Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх бодлого боловсруулан хэрэгжүүлэхэд ажил олгогчид, үйлдвэрчний эвлэлийн оролцоог ерөнхийлж гурван талт зөвшилцлийн үйл ажиллагааг чиглүүлэх.	2002-2010	ҮХҮЯ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, МҮӨХ
3. Ажиллах хүчний нөөцийг хөгжүүлэхэд чиглэсэн төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг төрөөний үндсэн дээр төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх хэлбэрийг ашиглан Засгийн газар, төрийн бус байгууллагуудын түншлэлийг ерөнхийлэх	2002-2005	ҮХҮЯ
Д/ Хөдөлмөрийн зах зээлийн талаарх мэдээлэл, сургалчилгааны ажлын үр дүнг дээшлүүлэх чиглэлээр	1. Хөдөлмөр эрхлэгчийг иргэд болон албан бус хөдөлмөр эрхлэгчидтэй хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн сүлжээнд хамруулах арга хэмжээ авч хөдөлмөрийн статистикийн тогтолцоог бүрдүүлэх	2002 оноос	ҮХҮЯ, УСГ
	2. Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн үзүүлэлтийн хүрээ ертөнтөх замаар ажилгүй хүчний болон ажлын байрны судалгааг боловсронгуй болгох	2003 оноос	ҮХҮЯ, УСГ
	3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хүүгийн тогтоомжийн талаарки сурталчилгааг	2002-2010	ҮХҮЯ
	4. Боломжит хөдөлмөр эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх талаар ажил олгогчдын хариуцлагыг төлөвшүүлэх сурталчилгааг зохион байгуулах	2002-2005	ҮХҮЯ, Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, МҮӨХ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

Хэвлэлийн хуудас 2 ☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 25 (262)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай*
- *Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай*
- *Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2002 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2002 оны долдугаар сарын 5 №25 (262

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

291. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай (2002-6-13-ны хууль) 795
292. Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай (2002-6-13-ны хууль) 801
293. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-13-ны хууль) 803
294. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт оруулах тухай (2002-6-13-ны хууль) 804
295. Зарлиг хүчингүй болсонд тооцох тухай (2002-6-13-ны хууль) 804
296. Консулын конвенцийг соёрхон батлах тухай (2002-6-13-ны хууль) 804
297. Зээлийн болон санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай (2002-6-21-ний хууль) 804
298. Зээлийн болон санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай (2002-6-21-ний хууль) 804
299. Хэлэлцээр соёрхон батлах тухай (2002-6-21-ний хууль) 805

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

300. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 30 805
301. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг буцаах тухай Дугаар 32 805

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

302. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 94 805
303. Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Дугаар 95 806
304. Хөрөнгө гаргах тухай Дугаар 96 806
305. Тогтоолын зүйл хүчингүй болгох тухай Дугаар 97 806

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

ХОТ, СУУРИНЫ УС ХАНГАМЖ, АРИУТГАХ ТАТУУРГЫН АШИГЛАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хот, суурины хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулах, цэвэрлэх зориулалттай инженерийн барилга байгууламжийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ус хангамж, ариутгах

Аюургын ашиглалтын хууль тогтоомж

2.1.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Цэвэр усыг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах тухай[1] хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1."төвлөрсөн ус хангамж" гэж ус олборлох, цэвэрлэх, дамжуулах зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг ашиглан хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагаагаг;

3.1.2 "төвлөрсөн бус ус хангамж" гэж ус олборлож, зөвөрлөн түгээж, хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах үйл ажиллагаагаг;

3.1.3."ариутгах татуурга" гэж хэрэглэгчээс гарсан бохир ус цуглуулах, татан зайлуулах, цэвэрлэх зориулалт бүхий шугам сүлжээ, барилга байгууламжийг;

3.1.4."ус хангамжийн эх үүсвэр" гэж гүний худаг, цуглуулах шугам, усан сан, насосны станц, цэвэршүүлэх байгууламжийг;

3.1.5."шугам сүлжээ" гэж цэвэр ус дамжуулах, хуваарилах, хэрэглэгчид хүргэх, хэрэглэгчээс гарсан бохир ус татан зайлуулах байгууламжийг;

3.1.6."ус түгээгүүрийн гол түгээх шугам" гэж усны эх үүсвэрийн барилга байгууламжаас салбар шугам хүртэлх шугам сүлжээг;

3.1.7. "хамгаалалтын бүсэн эрүүл ахуйн бүс" гэж ус хангамжийн эх үүсвэрийг аж ахуйн үйл ажиллагааны улмаас хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор заагласан газрыг;

3.1.8."хэрэглэгч" гэж цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээгээр үйлчлүүлж буй иргэн, хуулийн этгээдийг;

3.1.9."хангагч" гэж хэрэглэгчийг цэвэр усаар хангах, тэдгээрийн хэрэглээнээс гарах бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээдийг;

3.1.10."техникийн нөхцөл" гэж шинээр барих, өргөтгөх барилга байгууламжийг ус хангамжийн болон ариутгах татуургын шугам сүлжээнд холбоход тавигдах шаардлага, нөхцөлийг тусгасан зөвшөөрлийг.

4 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын бүрэн эрх

4.1.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын норм норматив, нийтлэг мөрдөх журам, заавар батлах;

4.1.2. цэвэр усны үнэ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг тогтоох аргачлал батлах;

4.1.3. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5 дугаар зүйл. Төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх

5.1.Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.1.1.улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжийн захиалагчийн үүргийг Барилгын тухай[2] хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэх;

5.1.2.ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг сайжруулах, техник, технологийг шинэчлэх, өргөтгөх хөтөлбөр, төслийг хэрэгжүүлэх ажил зохион байгуулах;

5.1.3.ус хангамж, ариутгах татуургын ашиглалттай холбогдуулан_ төрөөс баримтлах бодлогын талаар санал боловсруулах, эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;

5.1.4.орон нутгийн нийтийн аж ахуйн байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

5.1.5.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын норм, норматив боловсруулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Техникийн нөхцөл,тусгай зөвшөөрөл

6 дугаар зүйл. Техникийн нөхцөл

6.1. Хангагчаас олгох техникийн нөхцөл дараахь шаардлагыг хангана:

6.1.1.хэрэглэгчийг холбох цэгийн шугам хоолойн голчийн хэмжээ, хоолойн сууллын гүн, усны даралтын хэмжээг тодорхой тусгасан;

6.1.2.цэвэр, бохир усны найрлага тэдгээрийг шугам сүлжээнд нийлүүлэх нөхцөлийг заасан;

6.1.3.цэвэр ус хэмнэлттэй зарцуулах, бусад хэрэглэгчийг холбох боломжийг тусгасан.

6.2.Хэрэглэгчийн хүсэлтийг үндэслэн Стандартчилал, чанарын баталгаажуулалтын

[1] Усны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 5-6 дугаарт нийтлэгдсэн.

[2] Барилгын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1998 оны 9 дүгээрт нийтлэгдсэн.

тухай[3] хуулийн 5 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу батлуулсан техникийн нөхцөлийг хангагч олгоно.

6.3.Хэрэглэгчийн техникийн нөхцөл өөрчлөгдвөл хангагч техникийн нөхцөлд өөрчлөлт оруулах буюу шинээр олгоно.

6.4.Энэ хуулийн 6.3-т заасны дагуу техникийн нөхцөл олгосны дараа хангагчийн техникийн үйлчилгээнд өөрчлөлт орсон бол хэрэглэгчид мэдэгдэнэ.

6.5.Хэрэглэгч техникийн нөхцөлд тусгагдсан шаардлагыг зөрчихийг хориглоно.

7 дугаар зүйл. Тусгай зөвшөөрөл

7.1. Үс хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар, үйлчилгээг тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан хуулийн этгээд дараахь үйл ажиллагаог энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлнэ:

7.2.1.ус хангамжийн барим[illegible] байгууламж, технологийн тоног төхөөрөмж, шуг[illegible] сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;

7.2.2.ариутгах татуурга түүний шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжий[illegible] ашиглалт, засвар, үйлчилгээ;

7.2.3.орон сууцны хороолл[illegible] цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалт, засвар, үйлчилгээ;

7.2.4.ус хангамж, ариутга[illegible] татуургын барилга байгууламжид турши[illegible] тохируулга хийх үйлчилгээ;

7.2.5.хот, суурины уст цэг, ус түгээ[illegible] байрны ашиглалт, засвар, үйлчилгээ.

7.3.Тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэ[illegible] хүчингүй болгох, тусгай зөвшөөрлийн талаар[illegible] хууль тогтоомжийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэ[illegible] хариуцлагатай холбогдсон харилцаг Аж ахуйн үй[illegible] ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[4] хуулий[illegible] 12-14,18 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хангагч, хэрэглэгчийн харилцаа

8 дугаар зүйл. Гэрээ

8.1.Хангагч, хэрэглэгчийн хоорондын харилцааг энэ хууль, цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ /цаашид "гэрээ" гэх/ -гээр зохицуулна.

8.2.Хангагч энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан техникийн нөхцөл хангасан хэрэглэгчтэй гэрээ байгуулна.

8.3.Гэрээнд нийлүүлэх цэвэр ус болон татан зайлуулах бохир усны хэмжээ, чанар, найрлага, гэрээг дүгнэх хугацаа, төлбөр тооцооны арга, талуудын эрх, үүрэг, хариуцлага, хохирол тооцох журам болон шаардлагатай гэж үзсэн бусад зүйлийг тусгана.

8.4. Цэвэр усны үнэд орох өөрчлөлтийн талаар түүнийг мөрдөж эхлэхээс 30 хоногийн өмнө, төлөвлөгөөт засвар хийх үед цэвэр усаар хангах үйл ажиллагаог түр зогсоох тухай урьдчилан хэрэглэгчид мэдэгдэх буюу мэдээлэх хэрэгслээр зарлана.

8.5.Үнийн өөрчлөлтийн талаар хэрэглэгчид мэдэгдэхээс хойш 10 хоногийн хугацаанд гэрээнд өөрчлөлт оруулаагүй нь үг өөрчлөлтийг мөрдөхөөс татгалзах үндэслэл болохгүй.

8.6.Хангагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ байгуулахаас татгалзах эрхгүй.

8.7.Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлахтай холбогдсон харилцаг Иргэний хуулийн[5] 178 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

9 дүгээр зүйл. Хангагчийн эрх, үүрэг

9.1. Хангагч дараахь эрх, үүрэгтэй:

9.1.1.гэрээний нөхцөлд тохирсо[illegible] тоо, хэмжээ, стандартын шаардлагад нийцсэ[illegible] цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир у[illegible] татан зайлуулах;

9.1.2.хууль болон гэрээнд өөрөө[illegible] заагаагүй бол цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулахад зориулсан тоног төхөөрөмж суурилуулж, хэрэглэгчийн эзэмшилд шилжүүлэх;

9.1.3.хэрэглэгчийг стандартын шаардлагад нийцсэн цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, технологийн дагуу цэвэрлэх, усны чанар, бохир усны цэвэршилтэд хяналт тавих;

9.1.4.ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын талаарх хууль тогтоомж, дүрэм, заавар, норм, стандартыг үйл ажиллагаандаа мөрдөх;

9.1.5. өөрийн эзэмшилд байгаа инженерийн барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжид технологийн шаардлагын дагуу засвар, үйлчилгээ, шинэчлэлтийг тогтоосо[illegible] хугацаанд нь хийх;

9.1.6.гэнэтийн осол, аваар гарсан болон зайлшгүй урьдчилан сэргийлэх, засвар үйлчилгээ хийх үед энэ тухай хэрэглэгчид мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээ авах;

9.1.7. цэвэр усны үнэ, бохир у[illegible] татан зайлуулах үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоож аймаг, нийслэл, сумын Засаг даргатай зөвшилцөж мөрдөх;

9.1.8.хэрэглэгчийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид үзлэг, шалгалт хийж заавар, зөвлөгөө өгөх;

[3] Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтэлийн 1995 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

[4] Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтэлийн 2001 оны 6 дугаарт нийтлэгдсэн

[5] Иргэний хууль "Төрийн мэдээлэл" эмхтэлийн 1995 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

9.1.9.хэрэглэгч гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцлах, учирсан хохирлоо төлүүлэхийг шаардах.

9.2. Хангагч хууль тогтоомж, гэрээнд заагаагүй нөхцөл, шаардлага тавьж хэрэглэгчийн эрхийг хязгаарлах, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан техникийн нөхцөл олгохоос үндэслэлгүйгээр татгалзахыг хориглоно.

9.3.Хангагч нь хэрэглэгчийн шугамаас дамжуулан шинээр хэрэглэгч холбох техникийн нөхцөлийг шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хүчин чадлыг үндэслэн олгож болно.

10 дугаар зүйл. Хэрэглэгчийн эрх, үүрэг

10.1. Хэрэглэгч дараахь эрх, үүрэгтэй:

10.1.1.энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан гэрээний дагуу цэвэр усаар хангуулах, хэрэглээнээс гарсан бохир усаа хангагчийн шугам сүлжээнд нийлүүлэх;

10.1.2.цэвэр усаар хангуулах болон хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах талаар гэрээнд заасан нөхцөлийг биелүүлэх;

10.1.3.цэвэр ус түгээх, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөх;

10.1.4.хангагч үүргээ зохих ёсоор биелүүлээгүй тохиолдолд үйлчилгээний төлбөрийг бүрэн буюу зарим хэсгийг нь төлөхөөс татгалзах, хохирлоо нөхөн төлүүлэхээр хангагчаас нэхэмжлэх;

10.1.5.техникийн болон ашуулгүй ажиллагааны дүрмийг мөрдөх;

10.1.6.хангагчийн төлөөлөгчийг энэ хуулийн 9.1.8-д заасан үйл ажиллагаагаа явуулах нөхцөлөөр хангах;

10.1.7.хангагчаас цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах техникийн нөхцөл авах;

10.1.8.хэрэглэгч өөрийн эзэмшилд байгаа шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар, үйлчилгээ хийх ажлыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэх;

10.1.9.хэрэглэгч өөрийн эзэмшилд байгаа тоног төхөөрөмж, шугам сүлжээнд гэмтэл учруулсан бол шаардагдах засварыг өөрөө, бололцоогүй бол хангагчаар хийлгэж, гарсан зардлыг төлөх;

10.1.10.хангагчаас олгосон техникийн нөхцөл, зөвшөөрөл, батлагдсан зураг төслийн дагуу өөрийн эзэмшилийн шугамаас бусад хэрэглэгчийг холбуулах;

10.1.11. энэ хуулийн 10.1.10-т заасны дагуу бусдад цэвэр ус түгээх, тэдгээрийн хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах нөхцөл тухайн байгуулагаас үндэсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэлийн төлбөрийг гэрээний дагуу авах;

10.1.12.өөрийн эзэмшлийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжид гарсан болон гарч болох осол, гэмтлийн талаар хангагчид мэдээлэх, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, усны тоолуурын бүрэн бүтэн байдлыг хариуцах.

11 дүгээр зүйл. Цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаат хязгаарлах, зогсоох нөхцөл

11.1.Хангагч дор дурдсан нөхцөлд урьдчилан хэрэглэгчид мэдэгдэхүйгээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагааныг хязгаарлалтыг хийж болно:

11.1.1.ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид эрчим хүчний гэнэтийн тасалдал гарсан;

11.1.2.гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй, онцгой нөхцөл байдал үүссэний улмаас усны хэмжээг нэмэгдүүлэх шаардлагатай болсон;

11.1.3.ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээ, барилга байгууламжид ноцтой гэмтэл гарсан.

11.2.Хангагч дор дурдсан нөхцөлд урьдчилан хэрэглэгчид мэдэгдсэний үндсэн дээр цэвэр усны хэрэглээ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйл ажиллагаат хязгаарлах буюу зогсоох хүртэл арга хэмжээ авна:

11.2.1.эрүүл мэнд, байгаль орчинд аюул учруулахүйц нөхцөл бий болсон;

11.2.2.ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд төлөвлөгөөт урсгал ба их засвар хийх болсон;

11.2.3.цэвэр усны алдагдал, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн гэмтлийг тогтоосон хугацаанд засваралаагүй;

11.2.4.ус хангамжийн байгууламж, ариутгах татуургын шугам сүлжээнд зөвшөөрөлгүй холболт хийсэн;

11.2.5.усны тоолуурын битүүмжлэл, байрлал, холболтыг дур мэдэн өөрчилсөн;

11.2.6.энэ хуулийн 13.1-д заасны дагуу тогтоосон бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг хангаагүй бохир ус нийлүүлсэн.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Ус хангамж, ариутгах татуургын ашиглалт

12 дугаар зүйл. Ус хангамж

12.1.Онц чухал объект болох улсын зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг Дотоодын цэргийн тухай[6] хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтын дагуу

[6] Дотоодын цэргийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1995 оны 12 дугаарт нийтлэгдсэн

хэрэгжүүлнэ. Аймгийн зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна.

12.2.Төвлөрсөн болон төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэр нь хамгаалалтын болон эрүүл ахуйн бүстэй байна. Хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5-д заасны дагуу тогтооно.

12.3.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтэд аймаг, нийслэл, сумын Засаг дарга, мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавина.

12.4.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийг аймаг, нийслэл, сумын Засаг дарга дараахь бөгдлөгар тогтооно:

12.4.1.хот, суурины төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрийн /худаг/ эрүүл ахуйн бүсийг 50 метр, хамгаалалтын бүсийг 200 метрээс багагүй зайд;

12.4.2.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүсийг Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4-т заасны дагуу; хамгаалалтын бүсийг газрын гадаргад ойр байрлалтай буюу хөрсний ус хялбар нэвтрэх уст үеэс ус авч ашиглавал 500 метрээс багагүй, хөрсний уснаас хамгаалагдсан уст үеэс ус авч ашиглавал 100-200 метрээс багагүй зайд;

12.4.3.төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт урсгал уснаас шууд тэжээгдэх худгийн усыг ашиглахдаа хамгаалалтын бүсийг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн 500 метрээс багагүй зайд;

12.4.4.урсгал усыг төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа тохиолдолд тухайн газрын хөрс, чулуулгийн тогтолцоо, голын урсацыг харгалзан мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 5-д заасан хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийн дагуу.

12.5.Улсын болон аймгийн зэрэглэлтэй хотын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын бүсийг тухайн усны эх үүсвэрийн тэжээлийн бүс болон түүнтэй гидравлик холбоотой гол, нуурын ус хуримтлуулах талбайг хамруулан тогтоож болно.

12.6.Төвлөрсөн ус хангамжийн ус түгээгүүрийн гол түгээх шугамын тэнхлэгээс хоёр тийш 5 метрт хамгаалалтын бүс тогтоно.

12.7.Хотын доторхи цэвэр, бохир усны салбар болон түгээх шугам ашиглалтын явцад засвар, үйлчилгээ хийх хамгаалалтын зурвас газартай байна.

12.8.Ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсэд Усны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1-д зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.8.1.газрын тосны бүтээгдэхүүн, химийн бодис болон цацраг идэвхт бодис хадгалах;

12.8.2.орон сууц, үйлдвэр, үйлчилгээний зориулалттай барилга байгуулламж барих;

12.8.3.байгаль орчин, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөөгүй бордоо ашиглан таримал ургамал_тарих, бодис, арга технологи хэрэглэн көнөөлт шавьж, мэрэгчийг устгах.

12.9.Ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд энэ хуулийн 12.8-д зааснаас гадна дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

12.9.1.ұнд, ахуйн бус зориулалтаар ашиглах худаг, цооног өрөмдөх;

12.9.2. хөрсөнд төрөл бүрийн бордоо хэрэглэх.

12.10.Усны чанарын шинжилгээний дээж авах цэг, давтамжийг эрүүл мэндийн хяналтын байгууллагаас тогтоож түүний хэрэгжилтэд хяналт тавина.

12.11.Ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжид хангагч байгууллагын зөвшөөрөлгүйгээр нэвтрэхийг хоригдоно.

12.12. Иргэн хувийн хэрэгцээндээ зориулж гаргасан усны эх үүсвэрээс бусад хэрэглэгчийг усаар хангах нөхцөлд хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөнө.

13 дугаар зүйл. Цэвэрлэх байгууламж

13.1.Хэрэглэгч хэрэглээнээсээ гарсан бохир усыг цэвэрлэх байгууламжид шууд буюу цэвэрлэн нийлүүлэхдээ байгаль орчин, эрүүл мэнд, дэд бүтцийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний хамтран тогтоосон бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээг баримтлана.

13.2.Цэвэрлэх байгууламжийн байршлыг дараахь зүйлийг харгалзан тогтооно:

13.2.1.хот, суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө;

13.2.2.байгалийн гэнэтийн аюул \усны үер, гал түймэр, газар хөдлөлт г.м\-аас урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө;

13.2.3. цэвэрлэх байгууламжийг ергөтгех талбай;

13.2.4. хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоох талбай;

13.2.5.ажиллагчдын эрүүл ахуй, хөдөлмөр хамгаллын болон аюулгүй ажиллагааны нөхцөл.

13.3.Цэвэрлэсэн бохир усны найрлагад эрүүл мэнд, байгаль орчны хяналтын алба, технологийн горимд дэд бүтцийн хяналтын алба тус тус хяналт тавина.

ТАВДУГААР БҮЛЭГ

Үнэ, үйлилгээний төлбөр, цэвэр, бохир усны хэмжээ тогтоох

14 дүгээр зүйл. Үйлчилгээний төлбөр, үнэ тогтоох зарчим

14.1.Цэвэр ус олборлон түгээх үнэ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах, үйлчилгээний төлбөрийг төрийн захиргааны төв байгууллагаас батална аргачлалыг үндэслэн тангарч тогтоно.

14.2.Үнэ, үйлчилгээний төлбөрийг тангарагчийн үйл ажиллагааны бодит зардалд гулгуурлан, хэрэглэгчид ойлгомжтой, энгийн, ил тод байх зарчмыг баримтлан тогтоно.

14.3.Хэрэглээнээс гарсан бохир усны чанарлага зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд төрийн захиргааны төв байгууллагаас батална аргачлалыг үндэслэн үйлчилгээний төлбөрийг өсгөн тооцно.

15 дугаар зүйл. Цэвэр , бохир усны хэмжээ тогтоох

15.1. Хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээг энэ хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу байгууллага гэрээ, эрх бүхий байгууллагаар баталгаажсан усны тоолуурын заалтыг үндэслэн тооцно.

15.2.Усны тоолуургүй хэрэглэгчийн хэрэглэсэн цэвэр усны хэмжээг байгаль орчин, дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэрэглээний жишиг, нормыг үндэслэн тодорхойлно.

15.3.Хэрэглэгчээс нийлүүлэх бохир усны хэмжээг байгаль орчин, дэд бүтцийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хэрэглээний жишиг, нормыг үндэслэн тодорхойлно.

15.4.Усны тоолуургүй хэрэглэгч цэвэр ус хэрэглээний талаар буруу мэдээлэл өгсөн, эсхүл усны тоолуурын заалтаар усны зарцуулалт нь 30%-иас илүү байвал хангагч суулчийн тооцоо хийсэн өдрээс эхлэн цэвэр усны зарцуулалтын хэмжээг шинэчлэн тогтоож болно.

16 дугаар зүйл. Цэвэр ус, хэрэглээнээс гарсан бохир усны төлбөр тооцоо хийх, торгууль ногдуулах

16.1.Хэрэглэгчийн усны тоолуур нь баталгаагүй буюу эвдэрсэн, тоолуурын битүүмжлэлийг задалсан нь тогтоогдсон бол хэрэглэсэн цэвэр ус болон татан зайлуулсан бохир усны хэмжээг өмнөх 3 сарын дундаж хэмжээгээр тооцно.

16.2.Хангагч нь цэвэр ус түгээх болон хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлөөгүй буюу зохих ёсоор төлөөгүй хэрэглэгчид хугацаа хожимдуулсан хоног тутамд төлөгдөөгүй төлбөрийн үнийн дүнгийн 0.5 хүртэл хувьтай тэнцэх алданги ногдуулна.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хяналт, хариуцлага

17 дугаар зүйл. Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомжийн биелэлт, түүнд тавих хяналт

17.1.Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд холбогдох мэргэжлийн хяналтын байгууллага, улсын байцаагч хяналт тавина.

17.2.Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллага ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, цэвэр усны мөрдөж буй үнэ, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах үйлчилгээний төлбөрийн үндэслэлд олон нийтийн хяналт тавина.

18 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

18.1.Хангагч болон хэрэглэгчийн хооронд үүссэн маргааныг эрх бүхий байгууллагад нь тавьж шийдвэрлүүлэх бөгөөд уг шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдлоо гаргаж болно.

19 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээрүй бол ус ашиглалт, ариутгах татуургын улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

19.1.1. ус хангамж, ариутгах татуургын барилга байгууламж, техник тоног төхөөрөмж, шугам сүлжээг зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн, холболт хийсэн, эвдэж гэмтээсэн, техникийн нөхцлийг дур мэдэн өөрчилсөн иргэнийг 5000-50000, албан тушаалтныг 20000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

19.1.2.бохир усны найрлагын зөвшөөрөгдөх хэмжээнд хүртэл урьдчилан цэвэрлээгүй бохир усыг ариутгах татуургын сүлжээнд нийлүүлсэн бол үйл ажиллагааг зогсоож албан тушаалтныг 35000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох;

19.1.3.хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, эрүүл ахуйн бүсийн хязгаарт зөвшөөрөлгүй нэвтэрсэн иргэнийг 10000-50000, албан тушаалтныг 20000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

19.1.4.баталгаагүй хэмжүүр ашигласан, хэмжүүрийн узель өөрчилсөн, битүүмжлэл задалсан гэм буруутай иргэнийг 20000-50000, албан тушаалтныг 35000-60000, аж ахуйн нэгж, байгууллагыг 100000-250000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭД ХӨРӨНГИЙН ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь цэргийн жинхэнэ алба хаагч, дайчилгааны сургууль, цугларалтад оролцож байгаа цэргийн үүрэгтэн болон цэргийн сургуулийн сонсогч /цаашид "цэргийн албан хаагч" гэх/-д эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцаг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль тогтоомж

2.1. Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль тогтоомж нь Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль1, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар албан үүргээ гүйцэтгэж байх үедээ цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

3.2. Энэ хууль цэргийн албан хаагчийн албан үүргээ гүйцэтгээгүй байх үед учруулсан эд хөрөнгийн хохирлыг хариуцан арилгах болон цэргийн анги, байгууллагад хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж буй иргэнд эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхтэй холбогдсон харилцаанд үйлчлэхгүй.

4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёонд тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "цэргийн эд хөрөнгө" гэж цэргийн анги, байгууллагын эзэмшилд байгаа санхүүгийн тайлан бүртгэлд нь тусган бүх төрлийн галт зэвсэг, галт хэрэгсэл, цэргийн техник, тоног төхөөрөмж, хувцас хэрэглэл, барилга байгууламж, шатах-тослох материал, мал, хүнсний бүтээгдэхүүн болон бусад эд хөрөнгийг;

4.1.2. "цэргийн эд хөрөнгөд хохирол учруулах" гэж цэргийн албан хаагч өөрт нь итгэмжлэн хариуцуулсан буюу бусад байдлаар олгосон цэргийн эд хөрөнгийг эзэмших, ашиглах үедээ эвдэж гэмтээх, үрэгдүүлэх, гээгдүүлэх, завших, устгах болон бусад хэлбэрээр эд хөрөнгийн хохирол учруулахыг;

4.1.3 "цэргийн анги, байгууллага" гэж цэргийн бүх шатны удирдлагын байгууллага, нэгттэл, анги, цэргийн сургууль болон батлан хамгаалах салбарт үйл ажиллагаа явуулдаг бусад хуулийн этгээдийг.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлага

5 дугаар зүйл. Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл

5.1. Албан үүргээ гүйцэтгэж байх үедээ цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан гэм буруутай цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлагыг учруулсан бодит хохирлын хэмжээгээр хүлээлгэнэ.

5.2. Цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан цэргийн албан хаагч нь тухайн гэм буруутай үйлдэл /эс үйлдэхүй/-дээ эрүүгийн, захиргааны болон сахилгын хариуцлага хүлээсэн нь эд хөрөнгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.

5.3. Цэргийн албан хаагч дараахь тохиолдолд эд хөрөнгийн хариуцлагаас чөлөөлөгдөнө:

5.3.1. цэргийн анги, байгууллагын зүгээс эд хөрөнгийн бүрэн бүтэн байх шаардалагатай орчин, нөхцөлийг бүрдүүлээгүйгээс учирсан хохирол;

5.3.2. илт хууль бусаас бусад тушаал, захирамж биелүүлснээс учирсан хохирол;

5.3.3. гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй онцгой нөхцөл байдлын улмаас учирсан хохирол;

5.3.4. албан үүргийн дагуу хийсэн үндэслэл бүхий эрсдэл;

5.3.5. хууль тогтоомжийн дагуу хийсэн хууль ёсны үйлдлийн улмаас учирсан хохирол.

5.4. Цэргийн албан хаагчийн бүрутай үйлдэл /эс үйлдэхүй/-ийн улмаас гуравдагч

1 "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 1992 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

эгээдэд учирсан хохирлыг холбогдох хууль оготоожийн дагуу цэргийн анги, байгууллага өлсөн тохиолдолд гарсан зардлыг гэм буруутай цэргийн албан хаагч энэ хуульд заасан журмын дагуу барагдуулна.

6 дугаар зүйл. Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн бүрэн хариуцлага

6.1. Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн бүрэн хариуцлагыг учирсан бодит хохирлын хэмжээгээр дор дурдсан тохиолдолд хүлээлгэнэ:

6.1.1. цэргийн албан хаагчийн хохирол учруулсан үйлдэл эс үйлдэхүй нь гэмт хэрэг болохыг тогтоосон шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон;

6.1.2. гэмт хэргийн шинжтэй эсэхээс үл хамааран цэргийн эд хөрөнгийг санаатай устгасан, гэмтээсэн, муутгасан, ашиглан шамшигдуулсан, хууль бусаар захиран зарцуулсан буюу санаатай бусад үйлдлээр хохирол учруулсан;

6.1.3. соггуурурлах үндаа, мансууруулах бодис хэрэглэсэн үедээ хохирол учруулсан.

7 дугаар зүйл. Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага

7.1. Цэргийн албан хаагч албан үүргээ гүйцэтгэж байхдаа цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан шинжгүй бол цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлага хүлээлгэнэ.

7.2. Эд хөрөнгийн хязгаарлагдмал хариуцлагыг учирсан бодит хохирлын хэмжээг харгалзан цэргийн албан хаагчийн нэг сарын дундаж цалингаас илүүгүй хэмжээгээр ногдуулна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хохирлын хэмжээг тодорхойлох, шалгах, эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх журам

8 дугаар зүйл. Хохирлын хэмжээг тодорхойлох

8.1. Хохирлын хэмжээг цэргийн эд хөрөнгөд учирсан бодит хохирлын хэмжээгээр тодорхойлох бөгөөд үг бодит хохирлын хэмжээг тухайн үеийн зах хээлийн үнээс зохих нормоор бодсон элэгдэл хорогдлыг хасаж жинхэнэ гарсан алдагдлаар тооцно.

8.2. Тусгай зориулалтын болон зах хээлийн үнийг нь тодорхойлох боломжгүй эд хөрөнгийн үнийг батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний батална тусгай зориулалтын цэргийн эд хөрөнгийн үнийн жагсаалтад тусгаагүй, хэрэв үг жагсаалтад тусгагүй бол нягтлан бодох бүртгэлд тусган ертөөр тодорхойлно.

8.3. Хэд хэдэн цэргийн албан хаагч хамтран цэргийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол нэг бүрийн хүлээх эд хөрөнгийн хариуцлагыг учирсан хохирлын хэмжээ, хохирол учруулсан нөхцөл байдал, гэм буруу нь харгалзаж албан хаагч тус бүрээр тогтооно.

9 дүгээр зүйл. Эд хөрөнгөд учирсан хохирлыг шалгах

9.1. Цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ цэргийн эд хөрөнгөд хохирол учирсан тухай мэдмэгц учирсан хохирлын шалтгаан, хэмжээ болон гэм буруутай этгээдийг тогтоохын тулд ажлын хэсэг томилж, захирагааны журмаар шалгалт хийлгэнэ. Шалгалтыг 14 хоногийн дотор хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд хугацаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.

9.2. Шалгалтын явцад гэмт хэргийн шинж бүхий нөхцөл байдал илэрвэл цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ энэ тухай холбогдох байгууллагад нэн даруй мэдэгдэж материалыг шилжүүлнэ.

9.3. Эрх бүхий байгууллагын хийсэн шалгалтын дүнд гэм буруутай цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх үндэслэл, нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзвэл тухайн цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ захирагааны журмаар шалгалт хийхгүй байж болно.

10 дугаар зүйл. Эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх

10.1. Шалгалтаар тогтоосон цэргийн албан хаагчийн учруулсан бодит хохирлын хэмжээ нь хохирол учрах үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээнээс хэтрээгүй бол тухайн цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ шалгалтын дүнг үндэслэн учирсан хохирлыг арилгуулахаар 14 хоногийн дотор эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал гаргана.

Тушаалд төлбөр барагдуулах хугацаа заах ба тушаалыг эд хөрөнгийн хариуцлага хүлээж байгаа цэргийн албан хаагчид биечлэн танилцуулна.

10.2. Шалгалтаар тогтоосон цэргийн албан хаагчийн учруулсан бодит хохирлын хэмжээ нь хохирол учрах үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавь дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс их байвал тухайн цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргана.

10.3. Цэргийн жинхэнэ албаны байлдагч, түрүүч, цэргийн түрээгч, сонсогчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэхдээ сарын цалингийн хэмжээг

нь хохирол учрах үед мөрдөгдөж байсан хууль тогтоомжид заасан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцож тодорхойлно.

10.4. Ногдуулсан төлбөрийг цэргийн албан хаагчийн цалингаас суутгах тохиолдолд сар бүрийн суутгалын хэмжээ нь тухайн цэргийн албан хаагчийн нэг сарын цалингийн 50 хувиас хэтэрч болохгүй.

10.5. Эд хөрөнгийн хариуцлага хүлээсэн цэргийн албан хаагч цэргээс халагдах, чөлөөнд гарах, цугларалт дуусах үед төлбөрөө төлж дуусаагүй бол үлдсэн төлбөрийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль тогтоомжид заасны дагуу төлүүлнэ.

10.6. Эд хөрөнгийн хариуцлага хүлээсэн цэргийн албан хаагчийг хүлээсэн төлбөрөө төлж дуусаагүй байхад өөр цэргийн анги, байгууллагад шилжүүгдэл эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэсэн тушаалыг нь түүний шилжин очих цэргийн анги, байгууллагад нь хүргүүлж төлүүлнэ.

10.7. Шүүх болон цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ хохирол учирсан нөхцөл байдал, гэм буруугийн хэр хэмжээ болон цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн байдлыг харгалзан нөхөн төлөх төлбөрийн хэмжээг багасгаж болно.

10.8. Энэ хуулийн 10.7 дахь хэсэг нь энэ хуулийн 6 дугаар зүйлд хамаарахгүй.

11 дүгээр зүйл. Эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэрт гомдол гаргах

11.1. Цэргийн албан хаагч эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдлоо гаргаж болно.

11.2. Цэргийн албан хаагчид үндэслэлгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэсэн болох нь тогтоогдвол эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэсэн тушаалыг хүчингүй болгож, цэргийн албан хаагчийн төлсөн төлбөрийг түүнд буцаан олгох ба цэргийн албан хаагчид учирсан бусад гэм хорыг иргэний хууль тогтоомжид заасны дагуу арилгуулах асуудлыг тухайн тушаал гаргасан цэргийн анги, байгууллагын захирагч хариуцна.

11.3. Гомдол гаргасан нь түүний цалингаас суутгах суутгалыг зогсоох үндэслэл болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

12 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

12.1. Энэ хуулийн 9.1, 9.2, 10.1, 10.4-10.6-д заасныг зөрчсөн албан тушаалтанд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх зөрчлийн шинж байдлыг харгалзан 30.000-60.000 төгрөгийн торгууль ногдуулна.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

13.1. Энэ хуулийг 2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр **Улаанбаатар хот**

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай[1] хуулийн 183 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "шүүхээр баталгаажуулсан" гэсний дараа , 184 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1 дэх хэсгийн "захиргааны шийтгэвэрийг" гэсний өмнө,184 дүгээр зүйлийн "арбитрын шийдвэр" гэсний өмнө тус тус "цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/-ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай тушаал," гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

[1] Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай[1] хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "шүүхээр баталгаажуулсан" гэсний дараа "цэргийн анги, байгууллагын захирагч /дарга/ийн эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай гэрчилгээ" гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. "Дүрэм батлах тухай" Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 55 дугаар зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр

Улаанбаатар хот

КОНСУЛЫН КОНВЕНЦИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2002 оны 3 дугаар сарын 25-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Монгол Улс, Оросын Холбооны Улсын хооронд Консулын Конвенцийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрын Сэргээн босголтын Зээлийн банк хооронд 2002 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан Эрчим хүчний салбарын хөтөлбөр-1-ийн Зээлийн болон Санхүүжилтийн Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

ЗЭЭЛИЙН БОЛОН САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрын Сэргээн босголтын Зээлийн банк хооронд 2002 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр байгуулсан Жижиг, дунд үйлдвэрийн зээлийн хэлэлцээр /Санхүүгийн салбарыг дэмжих-2/-ийн Зээлийн болон Санхүүжилтийн Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **С.ТӨМӨР-ОЧИР**

[1] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2002 оны 6 дугаар сарын 21-ний өдөр Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Швейцарийн Холбооны Улс хооронд 1999 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр Берн хотод гарын үсэг зурсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх тухай Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 30 Улаанбаатар хот

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг ашиглалтын тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль батлагдсантай холбогдуулан цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах ажлын өртөг, зардлыг хямдруулах, шат дамжлагыг цөөрүүлж, үйлчилгээг хөнгөн шуурхай болгохтой холбогдуулан хангагчаас бүтээгдэхүүнээ хэрэглэгчид шууд нийлүүлж байх боломжийг судлан шийдвэрлэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-даалгасугай.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороо Т.Очирхүү/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2002 оны 6 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 32 Улаанбаатар хот

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн 23.3.4-ийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Ж.Наранцацралтын 2002 оны 6 дугаар сарын 5-ны өдөр өргөн мэдүүлсэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн олонхи нь хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА С.ТӨМӨР-ОЧИР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Дугаар 94 Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 16 дахь заалт нэмсүгэй:

"16. Монгол Улс, Арабын орнуудын хамтын ажиллагааны комиссын Монголын хэсэг:

Дарга -Байгаль орчны сайд"

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 95 | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Засгийн газар хоорондын комиссуудын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 21 дүгээр тогтоолын хавсралтад дор дурдсан агуулга бүхий 17 дахь заалт нэмсүгэй:

"17. Эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны Монгол Улс, БНАСАУ-ын Засгийн газар хоорондын зөвлөлдөх комиссын Монголын хэсэг:

Дарга -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд"

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 96 | Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төрийн ёслолын журмыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Чингис хаан мэндэлсний 840 жилийн ойг Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 81 жилийн ойн баяртай хамтруулан зохион байгуулахыг Улсын баяр наадмын төв комисс /М.ЭНХБОЛД/-т даалгасугай.

2. Чингис хаан мэндэлсний 840 жилийн ойг Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын 81 жилийн ойн баярын арга хэмжээнд зориулж Засгийн газрын нөөц хөрөнгөөс 70.0 (далан) сая төгрөг гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Н.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулж байх үүрэг бүхий төв болон салбар комиссуудын бүрэлдэхүүнийг баталж ажиллуулахыг Улсын баяр наадмын төв комиссын дарга, Нийслэлийн Засаг дарга М.Энхболдод үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2002 оны 5 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 97 | Улаанбаатар хот

Тогтоолын зүйл хүчингүй болгох тухай

Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 15 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн 2 дахь заалт, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн 76 дугаар тогтоолын 2 дугаар зүйл, "Журам батлах тухай" Засгийн газрын 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн 174 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг тус хүчингүй болсонд тооцсугай.

2. Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журмыг холбогдох хуулийн дагуу шинэчлэн боловсруулан батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Хэвлэлийн хуудас 1.5 ☎ 329487